


МОНГОЛЫН ШИЛДЭГ ӨГҮҮЛЛЭГ



МОНГОЛЫН ШИЛДЭГ ӨГҮҮЛЛЭГ

ЖАРГАЛЫН ДУУЛАЛ ЖАРАН БОТЬ

Жаран жилийг нэг эрин гэж монголчууд тоолдог байлаа. Тийм заншил тогтсоноос хойш арван зургаан жаран өнгөрсөн юм. Тэр хооронд арван зургаан үе улиран одоход манай ард түмэн аз жаргал гэгчийг үзсэнгүй, харин түүнийг зөвхөн мөрөөдсөөр, түүний төлөө тэмцээр л байлаа. Гэтэл арван зургадугаар жарны өвлийн улирал хавраар солигдох 1921 оны өлзийт сайхан цагт Монголын ард түмний олон зуун жилийн шаргуу тэмцлийн үр дүн оргилдоо хүрч эрх чөлөөний наран гийсэн билээ. Тийнхүү манай эх орон эрх чөлөө, аз жаргалт түүхийнхээ шинэ тооллыг эхэлснээс хойш анхдугаар жаран жилийнхээ ойтой золгож байна.

Ардын хувьсгалын анхдугаар жаран.

Түүхэн тэмдэглэлтэй энэ ойд монголын ард түмэн амжилт ололтынхоо дээжийг өргөн барьж жаран жилийн жаргал эдэлснээ бахдан дуулж, хувьсгалт төрийн их найрын дэвжээнд ерөөл бүхнийхээ цэцнийг, дуу бүхнийхээ уянгалгийг өргөн цууриатуулж байна. Хувьсгалынхаа сүр хүч, уриа дуудлага, дүр зураг, эрчим чадал, ирээдүй хэтийг шүлэг зохиолдоо мөнхжүүлж ирсэн монголын зохиолчид Ардын хувьсгалынхаа 60 жилийн баярт зохиол бүтээлийнхээ дээжийг нэр төртэй өргөн барьж байна. Ардын хувьсгалын анхдугаар жаран жилд бүтээсэн шилдэг сайн бүхнээ «Жаргалын дуулал жаран боть» гэж үзэх юм бол жар дахь дэвтэр нь уншигч таны мутарт дэлгэгдэж байна гэж үзээд мэргэн оюундаа болгоон соёрхохыг хүсэн уламжлахын ялдамд өгүүлэх нь:

Октябрийн социалист их хувьсгалын төрсөн дүү нь болж Ази их тивийн зулай дээр мандсан монгол ардын хувьсгал манай өргөн тал нутагт бадран цэцэглэхдээ «хуучин байдлыг цөмйг халж гагцхүү нарыг хэвээр үлдээлээ». Эртний тал нутагт зүс царайгаа шинэчлэн өөрчилж, таних аргагүй болтлоо цэцэглэн хөгжөөд цөл байсан газар тариалангийн талбай алаглаж, эзгүй байсан хөндийд хаш цагаан орд харш сүндэрлэж, усан дээгүүр гүүр, уулан дундуур зам зурайж, огторгуйд онгоц нисч, талд трактор хүжигнэж, чулууг зэс болгон хайлж, шороог алт болгон тунгааж байгааг жаран жилийн тэртээх хүнд эргэн харуулбал тэрний амнаас “Туульсад иймэрхүү юм гардагсан” гэсэн үг сонсох нь лавтай.

Тиймээ! Туульсад, монгол ардын баатарлаг туульсад иймэрхүү мөрөөдөл гардаг байлаа. Гэвч бид өнөөдөр хувьсгалт монголын шинэ туульсыг бүтээж байна. Эртний туульсын баатар мөрөөдлөөрөө “үзүүртэй модноос дээгүүр, үүлтэй тэнгэрээс доогуур” жигүүрт мориороо нисдэг байлаа. Манай хувьсгалт шинэ туульсын баатар үзүүртэй модноос дээгүүр биш харин “Хязгааргүй огторгуйн гүнд зугаалагч” Марс одонд хүрэх тухай мөрөөдөж нойрноос сэрсэн юм. Энэ мөрөөдлийг хорь гаруйхан настай Нацагдорж уран шүлэг болгон бичиж, аз жаргалын маань дууллын жаран ботийг сөхөж анхдугаар дэвгрийн анхны хуудсуудыг алтан үсгээр бичсэн билээ. Одоо бид жаргалын жаран боть дууллынхаа энэ жар дахь дэвтэрт монголын анхны сансрын нисэгчийн тухай бичиж байна.

Жаран жилийн өмнө монголчуудыг мөхөж яваа үндэстэн гэж дэлхий дахинд зар тарж байлаа.

Гэтэл ардын хувьсгал монгол хүнийг мөхлөөс аварч дахин залуужуулаад зогссонгүй түүнд хан гарьдийн жигүүр ургуулж, сансарт хүргэж өглөө.

Газраас сансарт хүрч, бойтог анжиснаас трактор комбайнд, модон ээрүүлээс суурь машинд шилжихдээ манай ард түмэн намынхаа мэргэн удирдлагаар тэмцэл хөгжлийн яруу алдарт замыг туулж, хүний нийгмийн бүхэл бүтэн үе шатыг алгасан зуун жилийг арав болгон товчилж нийгмийн идэвхжлийн ховор жишээг үзүүлж чадлаа. “Монголын гайхамшиг” гэж зүй ёсоор үүсэн гарсан нэр томъёо ч үүнтэй холбоотой юм. Хүн нийгмийн түүхэнд гарсан энэхүү ховор мөртөө гайхамшигтай гавьяат үйлсийн уран сайхны он дарааллын бичгийг бүтээх эрхэм үүргийг манай зохиолчид хүлээсэн билээ. Тэр ариун дээд үүргээ яаж биелүүлснийгээ уран бүтээлээрээ нам, ард түмэндээ тайлагнадаг сайхан уламжлал ёсоор ардын хувьсгалын 60 жилийн ойд зохиолчид бидний өргөн барих тайланг уншигт та гардан авч байна.

Энэ ботид манай үргэлжилсэн үгийн 80-аад зохиолч аль л олигтой сайн гэгдсэн өгүүллэгүүдээ шилж оруулсан юм. Гэхдээ ардын хувьсгалын 50 жилийн ойд өргөн барьсан шилдэг бүтээлийнхээ эмхтгэлээс хойших арван жилд бүтээж туурвисан зүйл дотроосоо шилж оруулахыг эрмэлзлээ. Аливаа уран зохиолд үеийн үед улиран хадгалагдах нандин эрдэнэ гэж бас байдаг. Тийм цагийг эзэлсэн эрдэнээсээ ч нэлээдийг энэ ботид орууллаа. Манай аз жаргалын дууллын анхны алтан мөрийг бүтээлцсэн Дашдоржийн Нацагдоржийн өнгө алдахгүй шижир шиг бүтээлээр энэ боть эхэлж байна.

Монголын шинэ үеийн уран зохиолын шилдэг дээжийг арав арван жилээр ботилох юм бол жаран сайхан дэвтэр болох бөгөөд боть бүрд өвөрмөц нэр өгч, боть бүрээс өвөрмөц дуу хөгжим сонсож болно. Дашдоржийн Нацагдоржоор эхэлсэн анхдугаар ботиос бид нойроос сэрсэн тал нутгийн хөвгүүд аз жаргалын шинэ дуугаа аялан: “Улаан тугийг мандуулаад, улсын сүрийг бадруульа” гэж нижигнэтэл дуулж, шинэ амьдралын алтан босгоор алхаж байгааг уншиж мэдэх юм. Хөдөөгийн уул талаар соёлыг түгээж, анхны сургууль, анхны эмнэлэг, анхны улаан булан байгуулж, шарын шашны болон хуучин нийгмийн бурангуй болгонтой тэмцэж яваа шинэ монгол хүний дүрийг дараах ботиос нь бид олж үзнэ. Энэчлэнгээр оюун ухаан, идэвх зүтгэл, ажилсаг гараараа хуучин монголыг өөрчлөн халж социалист шинэ монголыг түүхийн асар богино хугацаанд цогцлон байгуулж байгаа цоо шинэ хүний дүр зураг, сэтгэл санааны баян ертөнцийг манай орчин үеийн уран зохиолын жаран ботиос тов тодорхой харж болно.

Монголын ард түмэн харанхуй бүдүүлэг байдлаасаа чөлөөлөгдөж дэлхийн хөгжлийн өнөөгийн өндөрлөгт хүрэхдээ ертөнцийг үзэх марксист, ленинист онол сургаалиар зэвсэглэсэн Монгол Ардын Хувьсгалт Намын мэргэн удирдлага, дэлхийд социализм, коммунизмын гэгээн бамбарыг анх асаан бадрааж дэлхийн үгээгүй түмний хөгжлийн замыг гэрэлтүүлж өгсөн аугаа их Зөвлөлтийн ард түмний өгөөмөр тусламжинд түшиглэсэн нь түүний бүхийлэн ололт амжилтын гол нууц юм. Энэ нууцыг монголын шинэ уран зохиол өөрийн хуудас болгонд нээн үзүүлсээр ирлээ. Монголын шинэ уран зохиолын гол баатар нь эх орондоо социалист нийгмийг шавхагдашгүй авьяасаараа, ариун цагаан хөдөлмөрөөрөө цогцлон байгуулах цэх шулуун зорилготой, улс түмний найрамдал нөхөрлөл, энхийн үйлсийг эрхэмлэн үздэг эх оронч, интернационалч шинэ хүн юм. Энэхүү шинэ хүний дууриалтай дүр

төрхийг тал бүрээс нь тод томруун үнэн зөвөөр зурж үзүүлэхийн төлөө манай зохиолчид үеэс үе дамжин хөдөлмөрлөж байна. “Хуучин хүү шинэ хүү боллоо!” гэж монголын шинэ уран зохиол хорь, гучаад оны үед тунхагласан шигээ “Хуучин хүү социалист хүү боллоо” гэж тавьжараад оны үед уран үгээрээ зарлан алдаршуулсан билээ. “Социалист хүү коммунист хүү боллоо” гэж яруу сайхнаар уухайлах тэр ариун үйлсэд манай уран зохиол алба хааж байна.

Монгол шинэ уран зохиолын дуу хоолой өдрөөс өдөрт яруу тунгалаг болж өөрийн орны уншигчдын хүрээнээс хальж социалист ах дүү орнууд, дэлхий нийтийн уншлагын их танхимд нэвтрэн орсоор байна.

Манай зохиолчдын бүтээл одоо дэлхийн ихэнх оронд орчуулагдан гараад байна. Зөвлөлт Холбоот Улсад монгол уран зохиолын олон боть цуврал гарч эхэллээ.

Социалист реализмын уран зохиолын үүсгэл суурь тавигчдын нэг Максим Горький монголын шинэ уран зохиолын анхны ботийг бүтээж байх үед манай зохиолчдод “идэвхтэй зарчмыг” номлогтүн гэж сургасан билээ. Тэр цагаас өнөөг хүртэл хагас зуун илүү жилийн туршид манай зохиолчид уран бүтээлээрээ идэвхтэй зарчмыг сурталчилсаар байна. Шинэ нийгмийг идэвхтэй байгуулагч шинэ хүнийг бахархан алдаршуулах манай дуулалд төгсгөл хязгаар байхгүй. Жаргалын дуулал жаран боть номынхоо дээжийг ардын хувьсгалын анхдугаар жаран жилийн өлзийт ойгоор уншигч түмэндээ өргөн барихдаа энэ дэвтэрт байгаа сайн сайхан бүхнийг зохиолын маань гол сэдэв, гол баатар болсон уншигч танаасаа нээж олсон юм гэдгийг монголын зохиолчид талархан тэмдэглэхийг хүсч байна.

Л.Түдэв

ДАШДОРЖИЙН НАЦАГДОРЖ /1906-1937/

Монголын орчин үеийн утга зохиолын үндсийг тавигч, их зохиолч Дашидоржийн Нацагдорж 1906 онд хуучин Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, эдүүгээгийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ.

1921 онд Ардын хувьсгал ялсны дараа нийгэм улс төрийн ажилд идэвхтэй оролцож, хувьсгалт шинэ соёл урлагийн ажилд чармайн зүтгэж байв.

Д.Нацагдорж ЗХУ болон Германд хэдэн жил суралцаж, өрнөдийн соёлын шилдэг өв сантай гүнзгий танилцжээ.

Монголын зохиолчдын байгууллагын анхны нарийн бичгийн дарга нарын нэг Д.Нацагдорж “Уушандар”, “Сандо амбаны харгис явдал” жүжиг “Учиртай гурван толгой” дуурь, “Миний нутаг”, “Од”, “Октябрь” зэрэг олон арван шүлэг, “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс”, “Харанхуй хад” зэрэг өгүүллэгүүдээрээ алдаршжээ.

Д.Нацагдорж оросын болоод дэлхийн сонгомол зохиолуудтай монгол уншигчдыг анх танилцуулж А.С.Пушкиний “Гилберийн хатан”, “Буудалцсан нь”, Эдгар Погийн “Алтан цох” зэрэг зохиолуудыг орос, герман хэлнээс орчуулжээ.

Д.Нацагдоржийн зохиол гадаадын олон хэлнээ орчуулагдсаны гадна түүвэр зохиол нь ЗХУ, Энэтхэг, Герман зэрэг олон оронд хэвлэгджээ.

ХУУЧИН ХҮҮ

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо босоо, элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс угаа суунаглана.

Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна.

Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина.

Хөлд орохоос аваад, үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.

Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном гэж буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж хууль ёс гэж худал үнэн ярихыг сонссоор өдөр сарыг улируулна.

Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй гэж бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр, түмэн хэргээс хоцорж, дэлхийн боловсролоос гээгдэнэ.

Гагцхүү өглөө бурханд залбирч, үдэж тэнгэрт мөргөсөөр нэг нас барна.

Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж хатируулсаар хүрч ирэв. Цагаан даавуу алчуураар толгойгоо ороожээ. Ширэлдсэн хар гэзгийн сэрвийсэн хэдэн үс шанаа руу нь унжина. Урагдаж навгарсан хар ханцуйг сугалдаргалж, хиртэж сайртсан бор тохой гаргажээ.

Тав хийтэл мориноосоо буун, тас хийтэл жолоогоо сойгоод тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрнийхээ хөлсийг арчиж, нусаа хүр хийтэл нийгээд гэрт оров.

“Балдангийнх эсгийгээ хийж байна. Цэндийнх хонио хужирлаж байгаа.

Дамба морь эрэхээр явсан. Гомбо Хангай ороод ирсэн” гэх зэрэг хэв ерийн хэдэн үгийг ах зах хүмүүстээ сонин болгон ярьж, гавж гуай гэж доогуур харан, зайсан гуай гэж дорой дуугарсаар зуухны хажууд сууна.

Авгай хүүхдээс аяга тараг, хэсэг хусам олж идээд, тэндээс гарч, баян Балжирын унага татаж өгч айраг олж уугаад, нэг үдийг өнгөрүүлнэ.

Дэндэв тайжийнд хонь гаргаж өгч, гэдэс олж идэн нэг үдшийг дуусгана.

Хэдийгээр ухаан сэргэлэн боловч, зүүн хушууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор оршин суусан тул юуг үзэж мэдэж, юуг сонсох ажээ.

Нас хэдийгээр залуу боловч үгээгүй ядуу, өнчин балчир тул нутаг сумын хэдэн айлд ээлжлэн зарагдсаар, олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ.

Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх бөгөөд намар ичиж, хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жил нөхцүүлнэ.

Өтгөс, хуучид энэ хоёрын үгнээс бус үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй гэж санаж, хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ.

Юутай гомдолтой зэрлэг амьдрал, юутай хайрлалтай залуу нас, юунд шинэ ертөнцийг үзэхийг үл хүснэ.

Хүмүүжил нь ийм гунихралтай байдлыг хуучин хүү өөрөө бас яахан мэднэ.

Хуучин феодал ба лам нарын гайг мөн хэрхэн танина. Дэмий л дадсан байдалд автагдаж, зовлон нь жаргал, зэрлэг нь цэнгэл болоод, нэг аймаг улсын ихэнх хуучин хүүгийн адил нүдээ аньж, чихээ бөглөн, ертөнц гэгч чухам юу болохыг үзэлгүй, мэдэлгүй хөндий талд хоосоор хоцроход тулжээ.

Хайран, хайран, хөөрхий, хөөрхий,

Гэтэл хуучин хүүгийн нэг нөхөр нь хувьсгалын бууг тавьсан өдрөөс эхлэн, хөмөрсөн тогооны дотор гэрэл тусч, нэг аймаг улс сэргэв.

Тэнгэрийн хаяанаас цааш газар байдгийг мэдэж, таван далай таван тивийг танин шинэ ертөнц дээр хамт явах замыг нээв.

Хөх монгол улаан монгол болов

Хуучин хүү шинж хүү болов

Юутай завшаан, юутай баяр,

1930 он

ХӨДӨӨ ТАЛЫН ҮЗЭСГЭЛЭН

Хөдөө талын зэрэглээ мяралзан жирвэгнэхийн дунд хэдэн өндөр юм сүүмэлзэн үзэгдэх нь харь газрын аяны хүний нүдэнд яахин даруй танигдана. Хурдлан довтлох уурын тэрэгний өмнөөс намрын салхи хүчтэй үлээхэд хоёр нүдэнд нулимс гялтганан холын барааг харж ядна.

Өвгөн жолооч ухасхийх, хийг нэмэхэд дөрвөн хүрд чөлөө завгүй эргэлдэнэ. Бүртэлзэн харагдагч бараа нэг үе далд орж, нэг үе ил гарна. Удалгүй бүртэлзэн цухуйж, алтан ганжрууд нь өглөөний нарны гэрэлд үзэсгэлэнтэй гялалзана.

Тэрхүү хийдийн суврагын тэнд гайхамшигтай манжлага цамхагт өлгөсөн хонхны дуу хангинан жингэнэнэ. Бүрээ, бишгүүрийн дуу үргэлжлэн дүнгэнэнэ. Цам, жахар бүжиглэж байгаа юм байжээ. Хөдөөгийн хүмүүс хэд хэдэн зуугаар хуралдаад, эрээн мярааныг өмсөж, ийш тийш зөрөлдөнө.

Сүлжилдэн давхилдах хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь миний сэтгэлийг даруй бахдуулж, Сан бэйсийн морины сайхан нь миний дурыг хөвөлзүүлэн хөдөлгөнө. Монгол газар минь уужим юмаа. Маш сайхан морьтой юмаа, морио унаад давхихад манай цог заль сэргэнэ.

Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхэд хэдийн миний хоёр нүд гэрэлтэн тусав. Нэг залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэх нь зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэй, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмтэн оюутны боловч хүслийг холбилзуулан татна.

Цагаан саарал морины нуруун дээр ногоон гөлөмтэй боржгин янзын эмээлийг тохсон нь холхи газрын хүлгийн өнгө ялгаран, үзэсгэлэн бүрдээд, түүний дээр залуу охин хормойг цэмцийтэл, гуяыг мөлчийлгөн ороогоод, хөндлөн суужээ. Үзвэл нас арван найм, ес, шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ. Урт хар гэзгийг гурваар даран унжуулж, улбар шар дурдан алчуураар толгойгоо ороон, өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангилан үзүүрийг унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ. Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь улаан туяа тусчээ. Харах нүдний хар цагаан нь хослоод хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам миний нүд эрхгүй дагалдан давхина.

Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмссөн, зүүн ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган, жолоо цулбуурыг хугас барин атгаад баруун ханцуйгаа сул тавин, түүний дотор гараа нуун ташаагаа тулж, буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ. Хоолойн товчийг задгай тавьсны дотуур бас хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж, түүний дотор нимгэн цагаан хөрстэй гуа хүзүү үзэгдэхэд хазаад авмаар.

Шар бажгар дурдан бүсийг шавхийтэл ороогоод, угалзтай шонтгор гутлыг дөрөөний дунд тасхийтэл жийсэн нь талын идэр махбодийг бахархуулжээ. Залуу хүн түүний замыг хөндлөн саатуулж, хэдэн үг асуун хэлэлцэхэд тал газрын бага охин жолоог татаж, дуртайгаар түдгэлзэн хариулан өчиж, бас энэ тэрийг лавлан сонирхоно.

Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурайсан ялгуун саарал морь нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийм тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдах боловч дээр нь унасан үзэсгэлэнт охин ажиггүй сууж үгүүлэлдэх бөгөөд үг хэлэлцэн хичээнгүйлэн аашлах нь бага хүүхэд мэт хөнгөмсөг ээвэрүү, хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээхэд нь үнсэж шимбэл ханашгүй биз ээ.

Хээр талын дунд хөндлөн гулд давхиж, хөдөөгийн саруулд биеэ гайхуулсан ийм нэг үзэсгэлэнт охинтой учраад, хэрхэн сэтгэл хөдлөхгүй байж болох ажээ. Чинээгээр хичээнгүйлэн хэлэлцэж, сонирхолыг тавина. Өндөр хааны өврөөр нутагладаг гэнэ. Өнөөдөр тэнд буусан гэж өмнө хөндийгөөр угалзалсан эрээн майхан бүрэг бараг үзэгдэхийг заагаад, даруй морио ташуурдан харайлгаж, исгэрэн хатируулсаар одов. Хэрэв би морьтой болоод завтай явсансан бол доо.

1931 он

ҮЗЭГДЭЭГҮЙ ЮМ

Хангайн сайхан нуруунаас гарсан Идэрийн сайхан гол өндөр уулнаас буусан тул урсгал түргэн түргэн, бас л хөгжим шиг шуугина. Хажууд нь суун чагнахад үнэхээр тааламжтай. Хүний өнгөрүүлэх зам ямар болохыг юунд урьдаас тайлбарлаж үл өгнө. Энэ тунгалаг ариун мөрөн хичнээн мянган жил хэв хэвээр урссаар байтал, эрэг дагуу оршсон ёс гэтэл хүн амьтны түүх байн байн хувилсаар ирэх нь тэмцээний үр байжээ. Орчин тойрон зэрэглэсэн уулс бэрх өндөр, сэрвэн хад сэхийлцэн сахайлцан сүр жавхлан хэтэрхий, ой шугуй нягт зузаан, ус булаг хоржигнон хуржигнана.

Хавцал хаднаас асгах хархираа хүрхрээ цөмөөр Идэрийн голд цутгах бөгөөд түүний цэнхэр уснаас уухад дотор сэнгэнэн сэргэнэ. Хараахан түмэн бодис дэлгэрэхийн үес, зуны тэрүүн сарын шинэдээр дорнод уулын сэрвээ дээгүүр үүрийн шар туяа гэгээрэн тусмагц, энэтээ уулын орой дээр хөхөө шувуу яруухан донгодоход адуу манасан хүн түүний дууг сонсон баясаж, бас баясан сонсоно. Өглөөний нар оргин гарч ирэхэд голын эхэндэх саруул хөндий гэрэлтэж, ариун агаар татан, үнэхээр зуны амьсгал анхилах бөгөөд дэргэдэх цэцэг өвсөнд нимгэн цагаан хяруу гялтганаад, тэртээ ойд ногооны униар залгалдах нь даруй нүүдэлчин малчин хүний сэтгэлийг хөдөлгөнө.

Ийм нэгэн сайхан өглөө, Идэр голын өмнө этгээд нэг сэргэлэн дэнжийн дээр хэдэн цагаан гэр цэмцийн үзэгдэж, айл бүрийн тоононоос хөх утаа савсан, таван хошуу мал хаяагаар нь үргэлжилнэ.

Удалгүй хотон дотроос нь дөрөв, таван зуун хонь гарч билчин бушуу бушуу алхалж, баруун зүг зүтгэнэ. Гэтэл нэг залуу хүү баруун өмнөд гэрийн хаяанд сойсон нэг үрээгээр мордон, хонины хойноос давхиж ирээд, үүгээр түүгээр нь хашгирч зална.

Үзвэл, нас хорин гурав дөрөв хир, нүүрэндээ цогтой, нүдэндээ галтай, шавхийсэн хархүү байлаа. Хөх даалимбан дээлийг өмсөж, шар ногоон дурдан бүсийг ороосон бөгөөд гээзэггүй, орос эсгий малгайг хэлтгий тавьжээ. Бяцхан хар үрээ нь омголон тул тогтож ядан годгононо. Болд хүү тас тас гуядан, жолоог дугтран, хөндлөн сууж хонины хойноос алхуулна.

Түүнээс баруун ухаа дээр гарвал, хоньд нь тогтож, сая цухуйж байгаа ногоонд шунаж сонирхон, толгойгоо газраас үл салгана. Хажуугийн энгэрт Болд, бууж, халтар үрээгээ тушиж тавиад, хадан дээр сандайлж, ийм тийш харж, эргэх цагийн улирлыг гайхна.

Тэргүүнээ дээш хандвал, дөрвөн зүг тунгалгаар цэлмээд, тэнгэрийн хязгаар асар өв тэгш болжээ. Дөрвөн зүйлийн малууд энд тэнд сүрэглээд, өвсний соргог, усны тунгалгийг даган билчинэ.

Дөрвөн улирлын гайхамшиг, найртай сайхан зуны цаг ирэхэд үнэхээр хүн төрөлхтөн, түмэн бодисын толгой сэргэнэ. Үүнд Болдын сэтгэл бас л тэнийж, цээж дүүрэн ариун агаарыг амьсгалан, газрын байдлыг, уул ус жигдэлснийг ширтэж, хээр талын цэнгэлийн гайхамшигтай сайхныг сайшаан, аяа уудам сайхан хөдөөний газар гэгч нүүдэлчин малчин монгол хүний сэтгэлийг булаана гэж харан байхын хажууд өмнө хоолой руу байн байн ажиглана.

Юун гэвэл, Болд гадаадын сургуульд явж хэдэн жил болоод нийслэл хотоор дамжин гэртээ ирсэн бөгөөд удалгүй Улаанбаатарт буцаж албан хаах учир, өөрийн хуучин нөхөр Балгармаатай энэ өдрийн хонины хишгийг тохиолдуулан хээр тавиун газар тавтай уулзаж, сэтгэл зүрхний үгсийг солилцож, шийдвэрийг хэлэлцэх болзоо тавьсан тул мөрөөдөн хүлээж байгаа нь энэ байжээ. Тэгж, Болд нэг зэрэг уул усны сайхны гайхаж, нэг зэрэг Балгармаагийн ирэхийг санаж баярлан, бас л Балгармааг аваад хот газар явна гэж бодох тутам бахдаж, тэсч ядан суутал, өмнө зүгээс нэг морьтой хүн хатирч чиглэн ирж яваа нь үзэгдэнэ. Нарийвчилбал, морин дээр суусан нь цэмцгэр бөгөөд зайлшгүй Балгармаа мөн. Болдын магнай тэнийж, олон хоньд нь нам гүм болоход түүнийг тосъё гэж яаран ташуурыг тулан босмогц ар талаас гэнэт буун дуу тасхийж дараагаар хоёр удаа дуугарахад сочин гэдрэг харвал, гурван морьтой хүн хойд толгой дээрээс бууж ирэв.

Болд “Хулгайч юмуу, дээрэмчин юмуу, эсвэл гөрөөчин юмуу?” гэж гайхан юу ч болов мордоё гэж тушаатай морь руугаа явж хүрэхийн зуур өнөөх гурван хүн шогшин ирж хөндөлдөөд: “Зогс, гараа өрөг!” гэж зэрэг зэргээр галзуу мэт хашгирна. Болд хирдхийсэн боловч айсан байдал гаргалгүй ”Та нар юун хүн бэ? Юунд буу тавив. Надаар яах гэсэн юм бэ?” гэж асууж, тэднийг нэгд нэгнээр сайтар ажиглавал, нэг хөх царайтай хижээл хүн шар торгон дээлтэй байтлаа, хүүхэн хүний хоргой хамжаарыг өмссөн нь ший янгуунд гарагчид шиг хүзүүндээ өнгө бүрийн хив хадгийг уясан нь хэрж тэнэгч бадарчин шавираачин шиг, хүн рүү харах нь өлссөн чоно шиг бөгөөд хажуудаа нэг улаан хуйтай тахир сэлэм зүүж, бас л нэг буу мөрөвчилсэн нь хэрхэвч ерийн хүн биш. Бас нэг хөх чисчүү дээлтэй хар хүн бөмбөгөр оройтой малгай өмсөж, улаан жинс зүүсэн нь зайлшгүй хуучны түшмэд бөгөөд нэг винтов буу эгэлдэргэлж, энгэр дээрээ түвд үсэг бичсэн цагаа бүс хадсаныг үзвэл, үнэхээр сэжиглэлтэй бөгөөд гайхалтай. Нөгөө нэг хүн нас залуу, толгойг цагаан алчуураар ороожээ. Шинэхэн тав тавьсан нэг замаг буу мөрөвчилж, том ташуур барьсан нь лав шилийн хулгайч хүний шинжтэй, ийм гурван хүн бөгөөд унасан морьд нэлээд хөлөрчээ. Болдын зүг бүгдээр муухай харж лам шиг нь: “Чи маньг байцаана уу! Бид чамайг байцаана уу! Нэр чинь хэн бэ? Гэр чинь хаана вэ?” гэж зандарна. Жинстэй нь: “Аль вэ наадах малгайгаа ав, толгойг чинь харъя, халимаг үстэй юу. Юуны гишүүн бэ? хэл” гэж давшилна. Гуравдугаар нь: “Чи одоо болтол гээг тавихгүй яасан юм бэ. Маньд морь хүнс бэлтгэж байхгүй яасан юм бэ?” гэж загнана.

Үүнд Болд ихэд гайхан ширвэн харж: “Та нарын өмссөн зүүснийг үзвэл, өнөд үзэгдээгүй эдлэл байна. Үг хэлий чинь сонсвол өвчтэй галзуу амьтан шиг, ер нь яаж яваа юун хүмүүс вэ?” гэсэнд тэр гурав даруй буу тулган: “барина, хүлнэ, ална, тална” гэж завдалцан, хүчин хавсарч Болдыг цулбуурын сураар чанга хүлэхэд, залуу хүний царай хөхөрч зүрх догдлон хэрхэхийг нь шүд зуун хүлээнэ. Түүнээс тэр гурав: “Адуу чинь хаана байна? Гэр чинь хаана вэ? Ойр хавь хоршоо байна уу?” гэж хүлгийг чангаруулан байцаахад, Болд тэд хэн болохыг байдлыг нэгэнт мэдсэн бөгөөд залуу хүн зүрхтэй тул нэгийг ч зааж эс өгсөнд тэд морин дээр нь мордуулж, яаманд аваачина гэж хөтөлж, хүнс хийнэ гэж хонин дотроос нэгийг шилэн бөгтрөөд, баруун зүг явах үест хажуунаас Балгармаа хүрч ирж хөндөлдөн зогсож, Болд руу ирэхэд Болд дув дуугүй түүнийг ширтэнэ.

Өнөөх, гурав, хүүхний нэр усыг асууж, мөн л ийм тиймийг сураглахад хүүхэн айсан тул: “Мэдэхгүй, мэдэхгүй” гэхээс өөр хариу үл гаргана. Үүнд тэд нэг зэрэг зандран түрэмгийлсэн боловч дараагаар бяцхан номхорч мантай яв, жанжны хатан бол гэх үг эхлэн, ёсон бусчлах

байдал гаргахад Балгармаа жолоог чангаа барьж холхон зогсоно. Энэ үед Болд сэмхнээр нүд дохисонд Балгармаа даруй учрыг мэдэж морио гуядаж зугтаан одсонд, Болдыг хөтөлж явсан нэг хүнээс бусад хоёр нь хойноос нь хөөсөн боловч Балгармаагийн морь сая барьж унасан тул, цахилгаан мэт гялалзан далд оров. Үд нэгэнт хэлбийж өглөөний цэлмэг тэнгэрт бараан үүл тал талаас хуралдаад бороо орох төлөвтэй болж, жихүүн салхи сэр сэр салхилна. Болд тэр гурвын дунд хөтлөгдөн явах бөгөөд хүлгийн сур нь маханд шигдэж, зүс царай нь улам улам шарлан энэлнэ. Хаана аваачих, юу болохыг мэдэхгүй галиран, хааяа хааяа тэднийг муухай харна. Харилцан ярилцахыг сонсвол, энэ жанжин, тэр жанжин, тийм хувилгаан, ийм дарь эх гэлцэх бөгөөд бас л ингэж албал бахтай, тэгж албал таатай гэж өгүүлэлдэх нь чихэнд сонсогдоход аягүй. Нар баруунтаа хэлбийх үест нэг уулын савыг өгсөн явсаар, удалгүй тэдний үүрлэсэн газар хүрэв.

Нэг бяцхан хийдийн дуган сүмийн алтан ганжир, оройн нарны гэрэлд үзэсгэлэнтэйгээр гялалзаж, мөргөлчин ардууд сэтгэлийг нэвг цацрах боловч түүний дэргэдээс амьтан хүнийг алах бузар яргачин гарна гэж хэн хэрхэн санана.

Тэр хийдийн хажууд үүдэн дээр нь шүхэр тус ба хийморь зэргийг хийсгэсэн хэдэн гэрийн хооронд эр эм, лам хар хэдэн зуун хүн ийш тийш бужигналдах ба энд тэнд хэсэг хэсгээр бүлэглэнэ.

Зүүн гэрийн хажуугаар өнгөрөхөд гав гинж хангинаж, хүн гаслах дуу гаран, бас шаахай тас нясхийж хүний ёолох холоос сонсоно. Болд хүн болсоор ийм юм үзсэнгүй тул үнэхээр нүд халтирч сэтгэл сэржигэн, зүүд зэрэглээ, үлгэр домог мэт болж гайхна.

Өнөөх гурван хүн хамгийн баруун талын гэрийн дэргэд хүрч очсонд өмнөөс нь хоёр гурван хүн угтан морьдыг авав. Болдыг буулгаж урагш хөтлөн нэлээд хол аваачиж хүлээтэй хөгшин залуу арав гаруй хүмүүстэй нийлүүлэн хөлд нь төмөр тушаа торгон орхив.

Болд урьд таниагүй, хэн болохыг мэдээгүй боловч өөрийн шинэ нөхөд болох тэдэнтэй мэндлэн ямар юманд орсон болох учрыг асуувал, олонхи нь дуу гарч чадахгүй, нэг хоёр хүний дорой дуугаар үгүүлэх нь үхэхийг хүлээж байгаа бөгөөд бага тамлуулж алуулбал заяа тэр гэлцэнэ. Болд сочин цааш нарийвчлан асуувал, дөч гаруй настай нэг хар хүн энэ болбол, Бачирбатын яам гэгч юм гэнэ. Үзвэл, Очир там гэж ярилцдаг мөн шиг байна. Миний хүү хотод алба хаадаг тул баригдаж ирэн байцаалгасаар дөрөв хонов.

Эд болбол, саяхан хэд хоногийн дотор гараад ойр хавийн хүн малыг сүйтгэн байна. Их төлөв лам хувраг хүмүүс, алах талахаас өөр юм мэдэхгүй зэрлэг араатан шиг загнах ийм аюултай юмыг ер үзсэнгүй гэнэ. Бас нэг хорин долоо найман насны залууд, эдний жанжин гэгч нэг шийдэм адислан өгч, цэрэгт нь яв гэснийг эс хүлээсэн учир, маргааш шөрмөсий нь сугалж ална гэсэн гэнэ. Зүүн талын хацрын шарх бүхнийг асуудал, өчигдөр ная шаахайдуулсан гэж олон үг хэлэлцэж чадахгүй. Болд эдгээр байдлыг үзэж сонсох тутам мөн хүмүүсийг хайрлан энэрч нийгүүлсэхийн хамт тэдний харгис догшинг гайхаж ядах бөгөөд хоосоор сэтгэл эвдрэн байх үес баруун гэрээс өнөөх гурван хүн бас гурав дөрвөн хүний хамт гарч ирээд, нүдээ бүлтийлгэн, шүдээ ярзайлган, тэдгээр хүлэгтэй хүмүүсийг би үүнийг ингэж ална. Чи түүнийг тэгж ал гэж заан хэлэлцэх нь үнэхээр махчин мангас гэгч шиг. Гэтэл нэг ногоон дээлтэй хив хадаг барьсан хүүхэн тэдний дунд салбаганан явах бөгөөд хооронд дуугарахы нь

сонсвол дарь эх гэнэ. Алцаганан Болдын дэргэд ирж би үүнийг маргааш ална гэж маузер буугаар чичих нь инээдтэй ийм өлөгчин бас явалцана.

Өнөө өглөө гарсан Болд мөн үдэш санамсаргүй буугийн аманд тохиолдоод байгааг хэн олж мэднэ.

Үдийн хонь ирсэнгүй, бас үгүй болоход Болдын гэрийн хүмүүс гайхан ядаж, морио алдав уу, юу болов гэж дэмий эргэцүүлнэ. Гэтэл нар шингэх үед Балгармаа хүрч ирээд, Болд буцаж ирсэн эсэхийг асуухад тэд ихэд сочин, эдүүгээ хүртэл ирээгүй гэх бөгөөд ямар учир болсны төлөвийг Балгармаагаас сонсоод Болдын эцэг эгч хоёр морь эмээллэн даруй эрэхээр явав.

Тэдгээр хүмүүсийг дээрэмчин буюу зандалчин гэж хэлэлцэн хүүрнэж байхад зүүн айлын Гонгор тайж суулцаж байсан билээ.

Энэ хүн бол хуучин цагийн нэг феодал, ноднин өвөл ба мөн хавар Тариатын хүрээ хэд орохдоо ихээхэн лам нартай удаа бүр учирт эсэргүү гаргахын үнэрийг бага мэдсэн боловч баахан айж дув дуугүй чагнаж суусан хүн тул, энэ мэтийг сонсоод тархинд нь гэрэл тусч, хөл дэгдэн тэсэхгүйдээ арга гаргаж, Болдын тул лам нараас төлөг үзүүлж ирье гэж шалтгаалж, хуучин янзын дээлээ өмсөн, жинсээ сэмхнээр өвөртлөн яаран мордож Хүрээний зүг явав.

Гонгор явах зам нэгэнт харанхуй болж, бүдэг бараг одны сүүмэлзэх гэрэлд бодож санаж явах нь хуучин засаг болбол, дээдсийг бялдуучлан, доодсыг дарлана гэж зүрх нь дэлдэх бөгөөд айл аймаг суугаа Болдыг туслах бус, харин тэр үрэгдвэл гэрийн хөгшид бүсгүйчүүдийг мэхэлж дарлаж, хөрөнгөнөөс нь завшина гэж шүлс цувруулж цээж нь урагш тэмүүлэн, бөгцийн шогшино. Гэтэл Болдын гэрт хоцрогсод алмайран байх үес гадна хүн “Нохой хорь!” гэхэд Болдын эх яаран гарвал, Балдан гэгч хүн мориноосоо бууж байна. Түүнийг морь их хөлөрч амьсгаа нь зогсохгүй. Балдан: “Авгай сайн уу!” гэж гэрт орж, мэнд амрын дараа нэг аяга цай уухын зуур хойд хоршоог эсэргүүчүүд ирэн дээрэмдэн түймэрдэв. Эрхлэгч байсан нэг хүн баригдав. Би арай зугтан гарав. Барьсан хүнийг бараг алдаг гэнэ. Алахдаа айхтар тамладаг гэнэ. Баруун хойд сумдаар ийм явдал гараад одоо нэлээд хоног болж байна гэхэд хөгшин залуу бүгдээр дуу алдан сандрах бөгөөд Болдын эх: “Хүү минь!” гэж хашгиран муужран унав. Балгармаа галын хажууд уйлан цухалдана. Болдын өвөг эцэг одоо дүрвэж нүүх буюу хэрхэхийг Балдантай ярилцах ба хүүгийн хойноос бачимдана. Гэрийн дотор уйлаан майлаан, үймээн сандраан болон учраа олж чадахгүй байхад Балдан өгүүлэх нь: “Уйлж сандраад ямар тус ажээ. Харин хотоос ардын цэрэг ирж байгаа тул эртхэн түүнд хэл болон газарчилбал, гагцхүү аврагдах магадгүй. Миний морь эцсэн, нүд бас муу, та ийм настай, хүүхэд багачуул байхгүй юу? Танай айлын Гонгор яасан бэ?” гэж Болдын өвөг эцэгтэй хэлэлцэхийн хамт галын хажууд уйлан суух Балгармаа “Би явья!” гэж даруй босоход тэд зэрэг зэргээр шөнө орой болох гэж байхад газар мэдэхгүй ганц хүүхэд чи яаж чадна гэж хоригловч, Балгармаа үүнд “Би эс явбал, хэн явах вэ” гэж шууд марган гарч явав.

Балгармаа гэрээс гарахад нэгэнт бүрий барай болжээ. Хаяа тойроход замхарч бүхий цагаан гэгээний дунд түүний саарал морины хоёр чих соотгонон хөдөлж байх бөгөөд тушааг тайлан мордоход газар цавчлан явахыг тэмүүлэх нь Балгармаагийн хотоос гармагц даруй хатируулан зүүн өмнө зүг явав. Хөөрхий бяцхан охин гүн шөнө юуны тул хэрхэх, явахыг болзоход бэрх.

Хөмсөг шиг шинэ саран агшин зуураа далд оров. Эсрэг этгээдээс шөнийн салхи сэр сэр хийхэд Балгармаагийн дотор жихүүцнэ. Сэтгэлийн дотор нь уягдаж байсан Болд үе үе үзэгдэж, үе үе үгүй болно. Аяа, учирч уулзахын заяа нэн явцуу болжээ.

Өндөр давааг өгсөн гүн ойн дотор ороход хав харанхуйн дунд энхэл тонхол үргэлж тохиолдож, энд тэнд тас няс чимээ гаран, морь байн байн зог тусах бөгөөд түүнээс зам алдаж шивэр модны дотор дөрвөн зүгийг ялгахгүй, хүн олонд тусыг хүргэнэ гэсэн нь харин эзгүй хээр газар чоно араатны зууш болоход бэлтгэгдэж, цухалдан айх цочих үргэлжлэн байтал гэнэт модон дотроос буун дуу гарч түүний сум толгой дээгүүр сүнгэнэн өнгөрөхөд морь нь бусган тогтож ядан байхын зуур хажуугаас нь хоёр цэргийн хүн тулж ирэн буу сумлан Балгармааг юун хүн вэ? гэж зандрахад Балгармаа, Ардын цэрэг болохыг таниж, нэгэн зэрэг баярлаж бас сүрээс нь айн хирдхийж учир байдлыг тоочин хэлсэнд харуулын цэрэг байлдааны дүрмээр түүнийг барьж штабын газар хүргэв.

Балгармаа тэр шөнө байцаалган хянуулж, үнэн байдлаа мэдэлцсэн хойно маргааш үүрээр цэргийн хамт явах замд сэтгэл яаран, Болдын царай харагдан, амь алдсан болов уу? гэж ямагт бодогдох бөгөөд оронд одохыг орхиж мэдэх газар усны нэрийг цэргийн дарга нарт хэлж өгөн даруй айх эмээхийг мартан байлдааны газар буун дууг сонсохыг хүсэн явна.

Ирээдүйн хэргийг яахан болзоно. Юу болохыг хэн мэднэ. Арван хэдэн хүлээтэй хүн цөм энэхүү дэлхий дээр эцсийн шөнийг гаслантайгаар унтах хатуу зоригийг нэгэнт барьцгаасан бөгөөд гагцхүү хойно бэлбэсрэн өнчирч хоцрох хүүхэд ба эцэг эхийн энэлэхийн тул зовнин урт урт шүүрс алдалцсаар байтлаа өглөөний тунгалаг наран гарч ирээд бас л тэдний дээр гэрлээ тусгана.

Өнөөх жанжин манжин гэгчид нь зуурдын дэвсгэртээ цадтал унтаад өлссөн чоно шиг босож ирэн, нэг хүнийг авчран хоёр гурваараа бөөгнөрөн хонь алах гэж байгаатай адил хутга гаргаж өвчүүг хадахад мэсийн ирэнд мөгөөрс нь ширчигнэж, муухай дуугаран хавьчих бөгөөд зүрхийг сугалан авахад нэг чанга дуун алдан эцэслэв.

Үүнийг хүн төрөлхтөн нүдээрээ үзэж чадашгүй байтугай сэтгэлд бодон түвдэшгүй, хэний ээлж одоо болох бол гэж нүдээ анина.

Тэр зэрлэг араатан шиг хөлхөлдөн тэдний хажууд ирж хүнийг шилэхэд Болд олныг нүдээр үзэж гасалснаас одоо тарчилж үхвэл дээр гэж намайг аваач гэсэнд чиний дураар болдог юмуу гэж өөр нэг хүнийг хөтлөн явахад тэрхүү хүн нүдээ бүлтэлзүүлэн чичрэн дагжин шууд буудан алахыг гуйх бөгөөд үнэхээр төмөр чулуу шиг зүрхтэн боловч, тэсэшгүй байтал, тэгвэл аа бүр тарчлааж ална гэж хоёр гурван хүн дарж арьсы нь яран судас шөрмөсий нь нэг нэгээр сугалсаар гурав дөрвөн цаг гаслуулан бархируулан байж бас хагас амьтайгаар хаясандаа ханаж, энэ өдрийн зугаа энэ хоёроор бага тайтгарчээ.

Аяа зэрлэг тамын орон гэж үгүүлдэг байдаггүй юм, харин энд гардаг байжээ. Эх болсон зургаан зүйлийн амьтны тусын тулд гэсэн лам нараас ийм тиймийг харин өгүүлдэг байжээ. Хэдэн хүлээтэй хүн хэдий тус тусын амыг хорлон үхэхийг эрмэлзэвч хөдөлж чадахгүй тул шөнийн харанхуйд өдрийн аюултай тамлал нүдэнд харагдан, сэтгэлээс нь гарахгүй бас нэг шөнө тарчилна.

Хэрхэн энэлэвч хүн тул аргагүй үүр шөнийн үеэр өчүүхэн нойрт дарагдаж, агшин зуур амгалан болж байтал гэнэт их буун дуу хэдэнтээ дуугарахад бүгдээр сэрж чагнавал, тэртээ уулын хажуугаас ардын цэрийн тавих их буун дуу яруу сайхнаар дүнгэнэх нь чихэнд яруу сайхан бөгөөд бас л сэтгэл сэргэнэ. Тэдгээр хүлээстэй хүмүүс тус тус баярлан, зориг төрж, бид алагдавч яах вэ. Энэ муусайн зандалчингуудын даруй сөнөх цаг ирлээ гэж ярилцана.

Жанжин манжин нь босч сандран гүйлдэв.

Жагсаалын цэргээ бэлтгэх юм болв. Чавганц хөгшид, лам мам нар нийлж навсайж савсайлцан эрэмдэг зэрэмдэг буу сэлэм, эвэг хулсан нум сум, бялуу шийдэм хүртэл барилан, атга шороо тариндуулан өвөртөлсөөр ардын хуягт цэргийг эсэргүүцнэ гэж хэд хэдэн зуун хүмүүс болон хэдэн буутайдаа туулган одох нь инээдэмтэй.

Агаарын онгоц нисэж ирэв. Айж сандравч тархан унана. Хуягт тэрэг хүрээд ирэв. Хуйлран гүйлдэж энд тэнд үхнэ. Хоромхон зуурын дотор өөр ертөнц болов. Хойд даваан дээгүүр улаан туг хийсэн үзэгдэхэд хүлээстэй хүмүүсийн нар гарч, ардын цэргийн ура гэж хашгирахад авилгаач харгисуудын сүнс зайлан, ард түмний сүлд хөгжинө.

Балгармаа хувьсгалт цэргийг дагалдан давхиж, бахдан баярлах боловч Болд яасныг мэдэхгүйдээ бачимдан нүд тавьж, алагдсан хүний хүүр тохиолдвол ажиглаж үзэн явсаар хэдэн цэргийн хамт өнөөх хүлээстэй хүмүүсийн дэргэд ирж хоёр нүднээс нулимсыг гарган, Болдыг тэврэн унав.

Цэргүүд тэдний хүлээсийг тайлж, сувилахад, Балгармаа Болдын хүлгийг тайлж сувилна.

Нэг өглөө, үдшийн гайхамшиг ийнхүү өнгөрч, ардын улаан цэрэг олны дайсныг дарав. Болд, Балгармаа хоёр үзээгүй юмыг үзээд, буцах замдаа тарсан, хоньдыг цуглуулан тууж, баясан ярилцсаар харав.

Энэ үе Идэрийн гол мөн хэвээр урссаар.

1933 он

ЧУЛУУНЫ АЛГАА

Зохиолч Ч.Алгаа 1929 онд Увс аймгийн Цагаанхайрхан сумын нутагт малчны гэрт төржээ.

Бага, дунд, багшийн сургууль 1956-1960 онд Улсын их сургууль төгсжээ.

1955 оноос уран бүтээлээ эхэлж “Ээжий өөр болчихжээ”, “Хөтөлгөө морьтой хүүхэн”, “Хилэн хар морьт”, “Хотгойдын хээр”, “Хөөрхөн халиун”, “Хулгар хээрийн дууль” зэрэг өгүүллэгүүдийн түүвэр хэвлүүлжээ.

ХУЛГАР ХЭЭРИЙН ДУУЛЬ

Баяр гуай та сумын наадамд хулгар хээрийнхээ түрүүлж шуугиан тарьсан намтрыг яриач!
гэхэд Баярын нүд гялалзан, хийморь сэргэж хоолой засаад,

- За байз. Тэр чинь туулай жилийн зунсан билүү дээ. Тэр наадмын дараагаар би баярласан гомдсон хоёртоо болж гурван өдөр шөнө тувт архидаж балрах дөхсөн юм шүү. Хүний амьдралд баярлах гомдох юм алийг тэр гэх вэ! Тэр л миний баярлах гомдох хоёрын туйл болсон болов уу. Наадам яагаа ч үгүй байсан. Би үүрээр босож хулгар хээрээ унаж Нөмрөг Сумын төв ороод буцаад хамж явав. Тэгтэл нэг хүн урдуур зам хөндөлсөн давхиж ирсэн нь Нянгаа байв. Бид ямар мэнд мэдэлцэн бууж тамхилах завсар Нянгаа, миний унаж яваа хулгар хээрийг үл тоосон шинжтэй, ширэв татан тамшааж:

- За би ч энэ жилийн наадмаар “хурдан зээрдийнхээ” тоосыг нэг харна дээ хө. Аав ээж ачит төрийн буян түшиж гүү морь унаж, гүзээ мах идэж явсангүй дээ гэж ирээд л гайхуулах нь тэр.

Миний хор буцлав. Ам руу нь таглачихмаар санагдлаа. Тэгэвч биеэ барьсан юм. Тэгээд:

_ Сайн гүү соёотой байдаг. Сайхан авгай сахалтай байдаг. Гүү биенээс хөлөг төрдөг. Эрийг дагуулахгүй ухаалаг чадалтай хүүхнүүд алийг тэр гэх вэ? Миний энэ хээр ч юун хурдан зээрд битгий хэл, үлгэрт гардаг салхин зээрдээс ч хурдан амьтан даа хөөрхий. Сугандаа гуурстай адгуус л тийм байдаг байх. Би өглөө үүрээр Хустын мухраас мордож давхиад Нөмрөгийн төв ороод одоо буцаж яваа минь энэ. Нэг талдаа гурван өртөө газар шүү дээ гэв.

Нянгаа муу пийсуу гансаараа оролдон,

_ Сайн гүү соёотой ч хурдны цол дуудуулахгүй. Сайхан хүүхэн сахалтай ч эрийн гурван наадамд барилдахгүй дээ ха ха гэж хөхрөв. Тэгээд:

- Чиний энэ муу бөгтөр хээр ч цуутай л унага даа. Одоо ч харьж яваа биз гэж байна, муу нохой чинь. Сархад балгасан явсан бол ч хүзүүн дундуур нь дэлсэхсэн л байх. Даан ч эрүүл явсны тул дотроо хөмхий зууж байв. Тэгээд хулгар хээрийгээ наадмын өмнө яг хоёр хоног сойж хагсаан уралдуулчихсан чинь хол саахалтын дайтай түрүүлж тийм хэрэг болсон юм. Ямар ч гэсэн, тэр зуны наадмаар ягаан Нянгаагийн зээрд түрүүлж чадаагүй нь үнэн. Миний хулгар ч яахав. Хүмүүс цоллоно, цоллохгүй гэж хоёр талцан мэтгэлцсэн боловч аргагүй л цоллуулаагүй. Зөвхөн л Нянгааг чадаж санасандаа хүрсэн хүн дээ би. Тэгэхэд муу хулгар хээрээ мөн ч их өрөвдөж билээ. Эвлэлийн үүрийн дарга тэр хүүг түмний эхийн түрүүлсэн пайзтай хөтлөж явахыг хараад миний хоёр нүдний нулимс асгаад тэсч сууж чадалгүй босож барианыхаа тушаа Нянгаагийн дараа очсон юмаа гэж Баяр өвгөн бахархан ярив.

- Үгүй ээ хараач! Энэ чинь юу вэ? Бараан зүсний морь шиг байх юм. Миний зээрдийн урд ингэж хол түрүүлэх бараан зүстэй хэний, юу байдагсан билээ. Миний энэ муу хоёр ногоон нүд юм танихаа байчихаа юу! гэж Нянгаа өндөлзөн байна.

- Алив, ах аа! Наад дурангаа өгөөч гэж дүү Осор нь хэсэг дурандсанаа:

- Нээрээ тийм байна. Хээр морь байна. Унасан хүүхэд нь ягаан цамцтай юм.

- Ямар хачин юм бэ! гэж царай нь муухай болсон Нянгаа миний зээрдийн өмнө орох дөрвөн хөлтэй адгуус чинь хэнийх байх билээ гэснээ дурангаа шүүрч аваад сайтар харснаа дараачийнх нь миний зээрд байна.

- Та минь ээ, тэр хүүхэд зүүн талынхаа жолоог сул тавиасай гэж адгаж, үгээ залгуулан:

- Хол саахалтын дайтай цахилан түрүүлж яваа тэр хээр чинь арай Доржжүгдэрийн хээр биш биз! гэхэд дүү нь арай ч үгүй байлгүй. Тэр хээр цулбуурдуулбал хэр нь тэр.

- За дөхлөө шүү. Бушуу мордоорой! Барианыхан тэр хөдөллөө гэж хэлээд Нянгаа яаран сандран мордмогц ухасхийв. Өөрөө уралдаад ирсэн юм шиг хөлс нь цувсан Нянгаа, нүд нь орой дээрээ гарч,

- Хүүш та минь ээ! Харав уу? Муу луйварчинг хараач! Тэгэх байхаа чи, өнөөх Баяраагийн хулгар хээр байна. За чамайг даа! Чи бас тэгж олон түмэн наадамчныг мэхлэх үү. Тэгж маллуулахгүй хө гэж ташуураа гозолзуулан давхиж,

- Зогсоорой, зогсоорой! Залуу чи чинь яаж байна. Мал мэддэггүй ямар газрын цагаачин бэ? Чи чинь наадахыгаа хараач! Түрүүлсэн морь биш шүү гэж дуу тавин хурдан морины шүүгч, эвлэлийн үүрийн дарга залуугийн урдаас давхин очиж цулбуурдан авав.

- Яаж байна, Нянгаа гуай Ташуурдах нь уу. Танай зээрд хоёрт орсныг тэр Сэнгээ гуай авч явна шүү дээ.

- Элэнцэгний чинь хоёрт орох наадах чинь морь биш Алдарханы эрмэг хулгар гэдэг гүү байна. Баяраа муу луйварчинг хар! Гүү уралдуулж төрийн наадам үймүүлж олон ардыг доромжилж байна. Төр, наадмын ёс! Гүү уралдуулах цээртэй гэж шүлс үсэргэн: - Бүсгүй хүн бөхийн дэвжээнд барилдаж бөгтөр хээр барианд орж цоллуулах болоо юу. Яасан задарсан улс вэ! Та нар хар! Алдарханыхан хаа байна. Яасан ичгүүргүй улс вэ? хэмээн барьсан залууг эмээлээс нь хуу татах алдан давшлав.

- Нянгаа гуай! Та уураа тат! Наадмын комисст очиж учры нь олъё. Түмэн олон наадамчны нүдэн дээр ганцаараа хол түрүүлж ирэхээр нь би барилаа. Магадгүй. Таны морь ч нэгд орох юм билүү. Та намайг тавь хэмээн эвлэлийн үүрийн дарга залуу учирлав. Баяр давхин очиж:

- За цол дуудсан дуудаагүй нь яамай. Би үүнийхээ хурдан ид шидийг үзүүлэх гэсэн юм. Үүнээс илүү яахав гээд буун харайж хулгар хээрийнхээ хошууг илж цулбуураас нь адис авав.

Төдөлгүй хулгар хээрийн дэргэд наадамчид хуран шавж ирэв. Зарим нь эвий хөөрхий яасан хурдан хөлөг вэ? Хөлсий нь бушуу хусаач! Салхины нь амыг тавиад өгөөч. Хөх мах нь чичрэхийг үзэж байна уу гэхэд нөгөө хэсэг нь - хүлэг морио хат! Гүү л байна шүү дээ, энэ чинь. Одоо байтугай, эзэрхэг засгийн үед ч монгол хүн гүү уралдуулж байгаагүй юм гэлцэнэ. Тэгтэл энэ чинь гарцаагүй хурдан шандаст амьтан байна. Монгол гүүний унага. Хурдан л болсон хойно морь гүү ялгаа юу байсан юм бэ. Цоллох нь зөв! гэхэд зарим нь:

- Ээ бүү үзэгд, муу ёр байгаа даа. Эрийн гурван наадам гэдэг чинь эр хүн зодоглож, агт морины шандас шалгаж, мэргэн эрчүүл харвана гэсэн үг биз дээ, та минь! Баяр зальтай этгээд мөн гэлцэнэ. Ийнхүү дургүйцэх бахархах үгс сумын наадмын гол яриа болов.

Хөлс нь дусалж арьс нь гилтгэнэсэн бөөрөнхий хавиргатай аман хүзүү бүдүүн, бөгтөрдүү хээр морь цулбуураа чирэн, эзнийхээ араас дагаж хэд алхсанаа гайхашран үүрсэв. Дөч эргэм насны зузаан уруултай тагтгар хөх хүн тэнтэр тунтар гишгэлэн өлийн овооны дэргэд очив. Өврөөсөө лонхтой архи гаргаж овоонд нь цавдан цацав. Дараа нь ямар нэг юм амандаа бувтнан тал тал тийш цавдсанаа шүлсээ хүдхийтэл залгин, суун тусав. Архинаасаа ус залгилах адил нэгэн хэсэг залгилаад ханцуйгаараа амаа хайнгадуу шувтрав.

Тэгснээ унасан морио харж: - Эвий хурдан хөлөг минь! Ямар ч гэсэн ягаан Нянгаагаас хариугаа авлаа даа, чи бид хоёр гэж инээх уйлах хоёрын хооронд ярвайснаа гэнэт санаа авав бололтой босов.

- Хан хурмаст тэнгэр минь, даанч яав. Хулгар хээрийн мань хүйсийг ингэж эндүүрэх гэж дээ. Гүү гүү гэнэ. Хэзээ унагалсан юм бэ? Хэрэв морь байсан бол, миний энэ хээрийг саяын наадамд алтан жолоог нь өргөж цолыг нь дуудах байв. Бүгд найрамдах бүх монгол ард улсын Завхан аймгийн Алдархан сумын ард Баярын аргамаг хөлөг хэмээн морины цол дуудах мэт сунжруулан үглэсэндээ Баяр итгэн уярч уйлав.

- Ээ чааваас! Чи бид хоёрт цолоо дуудуулах заяа дутжээ. Түрүүлсэн мөртөө шүү! гэж хэлээд мэнэрсэн согтуу нүдээр хулгар хээрийгээ нэгэн хэсэг гөлрөн ширтэв.

Тэгснээ өлийн овоонд хоёр чулуу нэмж шидээд, хан тэнгэр эцэг минь! Хатан дэлхий ээж минь! Эрмэг хээгчээс минь эр унага гараасай! хэмээн хэдэнтээ шивнээд согтсон баярласан, гомдсондоо алжаасан бололтой, эмээлээ авч, тохмоо үлдээгээд эрмэг хээгчээ сул тавин хэвтмэгц нам унтав.

Эрмэг хээгч эзнээ орхин явж чадахгүй, шаасан гадас шиг дөрвөн хөл дээрээ босоогоороо байж агшин зуур зүүрмэглэснээ хангинатал янцгаан эзнээ сэрээжээ.

ЧИМИДИЙН АЛАГСАЙ

Зохиолч Ч.Алагсай 1933 онд Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага, дунд, багшийн сургууль, Москва хотноо Ломоносовын нэрэмжит Улсын их сургууль төгсч, 1979 онд дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

1950-иад оноос уран зохиол сонирхон оролдож “Ирвэст уул”, “Тахийн ус”, “Суман зээрд”, “Цал мөнгөн алтай”, “Говийн хун” зэрэг тууж, өгүүллэгийн ном бичжээ.

АРГАЛИЙН ДУУЛЬ

I

Өглөөний нарнаар хөх өндрийн царамд сүрэг аргаль идээшлэн гарч ирэв. Уулын жалга, сархиаг, салаа дэвсэг үхэр улаан хадны үе зайвар, нураг дунхад тэд сүрэглэн өглөө оройн сэрүүнд идээшлэн, хадны ус шимж, үдийн наранд хорж, заримдаа харуул харан зогсох нь энэ орчны гоо чимэг байдаг.

Энэ сүрэг хэдэн жилийн өмнө хаанаас ч юм бэ, энэ нутагт дайжин ирсэн хоёр хургатай төлгөн аргалиас өсөж үржин өдий олон болжээ. Тэр сүрэг тод хүрэн бөөртэй, хонго өөхий нь дун цагаан, хошуу буурал, бие томтой байдаг нь эхээ тун дуурайжээ. Бас эндхийн газрын өнгө том том хүрэн асга, уул усны сайхнаас ч тийм өнгөтэй биерхүү байдаг болов уу гэлтэй. Уул усандаа нутагшин дассан болохоор эндээс холдох тун дургүй, үргэж цочсон ч дунх царам зайж хэсэг харайснаа дорхноо номхорч өвс идэж эхэлнэ. Төлгөн аргалийн удам энэ сүрэг том жижиг эвэртэй, эвэргүйгээрээ л ялгагдахаас биш хоорондоо тун адилхан. Андашгүй түүн доторхи даргай хөхөл эвэртэй тод, хүрэн бөөртэй, хамгийн том хижээл аргалийг цөм тэд дуурайжээ. Хүрэн бөөрт, ижил дотроо тун толиотой. Нас гүйцсэн шаазгай алаг, хяруутаас ч өнгөлөг биежүү. Тэгээд бас жил болгон төл өгнө. Одоо ч гэсэн мөн л хоёр хөөрхөн халтар хурга дагуулан явна.

Нар халахын хирд хөх өндрийг арлан тогтож байсан өнөөх сүрэг ногоонд цадаж сурсан заншлаараа нургийн дундах мараан дээрээ ирэв. Хаанаас салхитай байгааг мэдэх гэж хэсэг үнэртсэнээ юмнаас сэргийлдэг заншлаараа тал бүр тийшээ харж хэвтэн хурга төлгүүд нь мөргөлдөн тоглож эхэллээ.

Нураг дунхын ногоо хөхрөн сэрүү татаж, асган доогуур шургасан горхийн хүйтэн ус үе үе хоржигнон тэрхүү сонорч амьтдын чихийг дэлдэнэ.

Хэдий тэд сэргэг сэрэмжтэй ч үүрийн цагаан гэгээнээр бараагүй нь харж мөшгөн дагасан уулын анчин дэргэдээ ирэхийг анзаарсангүй. Хэрэв аль нэгэн зүгээс салхитай байсан бол ингэхгүй байсан болов уу?

Ийм эрт сүрэг тургийн дэргэд ирсэндээ анчин баярлаж “аль нь хэзээ унах бол” гэхээс өөр юм үл бодно. Анчин хэд дахин буудах гэснээ элэгдэн мөлхсөөр хадны сэнжээр буугаа мөрлөн мярааж хартал хүрэн бөөрт хэзээний босчихсон хамраа сартайлган салхилж байв. Тийм том тургийг ийм ойрхноос тэр хэзээ ч ингэж харж байсангүй. Яарахдаа тэр их биеий нь тал хуваасхийн хараалж гохоо дарав.

Уулын цуурайнд хад болгоноос буу дуугарах шиг боллоо. Анчныг босоход гөрөөс байсан нурган дээр цагаан тоос эргэлдэн манарч тэртээ хажуугийн асга хэд шажигнаснаа чимээ алдрав.

- Ээ цус! Хайран жулч! гэж анчин амаа барьж буугаа үүрсээр гэлдрэв.

II

Хоёр уул давж том хүрэн аргаль сульдаж эхэллээ. Энэ сүрэг анх удаа ингэж Хөх өндрөөс ийм хол үргэн холджээ. Том хүрнийг сульдах тусам бусад нь түүний аяыг дагана. Хүрэн бөөртийн үр удам хэдэн шүдлэн угалз ааг омгондоо бусган огло харайж урд нь гарах гэснээ бас түүнээс цойлж түрүүлсэнгүй. Өмнө нь гарч цэгцэлж ч дагуулсангүй. Өдий болтол том хүрний урд нэг нь ч гарч үзээгүй. Цөм л түүний араас дагасаар өсч торнижээ. Гэвч том хүрэн аргалийн хажуу бөөрнөөс хөөс татсан өтгөн хүрэн цус хадан дээр дуслахыг ижил сүрэг нь андсангүй, үнэрийг нь авч зүг бүр тийшээ бутран дүүллээ.

Сүргийн цэгцэнд явдаг том хүрэн анх удаа ижлээсээ сүүлдэж ноднингийнхоо хөхүүл хэнз төлгөө бараадан дагаж хэд харайсан боловч гүйцэгдсэнгүй бараа тасарчээ. Хамгийнхаа сүүлчийн хүчийг гаргаад ч барааг нь харж чадсангүй, дөрвөн мөч нь суларч шогшоор сүүлдээ ганц нэг сажлан газар үнэрлэснээ хад ёроолдон хэвтлээ. Ногоо үнэрлэх гэтэл өвдгөнд наалдсан цусаа харж үнэрийг нь аван огло харайв. Гэвч үргэн давхих тэнхэл байсангүй.

Сүргээсээ ганцаардаж үзээгүй том хүрэн бөөрт, тугал хар нүдээ зүг бүр тийш мэлтэлзүүлэн ижлээ харна. Нэг нь ч ирсэнгүй. Нар хэвийн уулын сүүдэр буужээ. Гэнэт хажууд нь чимээ гарч нэг юм ойртон иржээ. Далгай том эврээ дааж ядан арайхийж эргэж хартал эхэр хоёр хурга нь цувралдан ирж явлаа. Эхээ эргэн харахад хурганууд зог тусан сөөнгө туниа муутай дуугаар майлав. Хурганыхаа дууг сонсон эх нь босох гэтэл хөл нь хөшжээ. Дахин зүтгэсээр бостол тэнцэж чадалгүй унав. Хоёр хурга эхдээ дөхөж ирснээ хэвтсэн газар нь тунан бөшсөн цуснаас жигшин үргэж хэд харайснаа эхдээ хоргодон эргэн зогсов.

Өглөөнөөс орой болтол хоёр хурга эхээ мөн олон хөхдөг билээ. Одоо тэр хэм нь болж, эхийн халуун сүүгээ үргэлж бодох боллоо. Тэр хооронд шинэ ногоо ганц нэгийг тасдан, хүйтэн уснаас шимэвч, эхийн сүүг орлож чадсангүй. Өлсөхийн эрхэнд эхээ хөхөхөөр очсоноо дарь үнэртсэн сумны шарх, шинэ сэвс, халуун цусны хурц үнэрээс бүлтэлзэн айж бусган хулжина.

Хурам хурмаар хоёр хурга эхдээ дасч бараадан хэвтсээр хушууг нь үнэрлэн, хөлөөрөө маажлана. Тэгэхдээ эх нь чадлаа шавхан толгойгоо хөдөлгөж нүдээ анивчихад хурга байн байн майлах ажээ.

Нар жаргахад нялх амьтас бүр ч өлсөн эхийнхээ дэлэнг нудравч хөхөж эс чадна. Шөнө болж, торойх бүхнээс айхдаа хөөрхий хоёр хурга ээжийнхээ гэдсэнд наалдан нам унтаад өгчээ.

Хорт суманд өртсөн эх нь шархандаа шаналан нялх хурганыхаа халуун үнэрийг хааяа нэг мэдрэхээс цаашгүй. Гэнэт хүрэн бөөрт, сүр сархийн хэд тийчилснээ хөлөө тэнийлгэн толгойдоо дийлдсээр хажуулдлаа. Хоёр хурга цочин ухасхийснээ эхийнхээ хөхийг булаацалдан үлгэв. Хөрсөн сүүг нь хэд залгилтал дорхноо татарч жилэм ч үгүй боллоо. Ам дүүрэн байдаг хөх нь ч оромын төдий хоосон арьс болжээ.

Үүр гэгээрэхийн үес эх нь халуун хэвтрээсээ босч хургаа хөхүүлдэг тэр хэм нь болж, хурганууд нэг эхээ үлгэж, нэг ногоо үнэрлэн, хэвтэж босон, хааяа нялх зөөлөн туруугаараа газар малтаж, эхээ сахин торолзоно.

Өглөөний нарнаар хөх өндрийн царам ногоорон дуниартана. Яг өдийд тэнд сүрэг аргаль налайн хөх дунхын гол дахь мараан дээрээ нарлан, төлөг хургууд нь тоос татуулан тоглодогсон.

Жалга сархиаг, салаа дэвсэг, дэл улаан хадны үе зайвар, нураг дунхад сүрэглэн усны тунгалаг, өвсний шим хөөн яваа тэр амьтдыг харж ханадаггүйсэн. Гэвч уулын анчин Хөх өндрийн царманд ирж сүргийн нэгнийг шархдуулан, үр төл нь эхийнхээ цусыг үзэж, үнэрийг нь авснаас хойш тэд энэ ууланд эргэж ирсэнгүй, жигшин зайлжээ.

Одоо тэнд нам гүм, оргиж, асган доогуур шургасан уулын горхины чимээ л тодхон дуулдана.

Төлгөн аргалийн тэр удам одоо хаа явааг бүү мэд! Харин хөх өндрийн царамнаас хоёр уулын цаана хүрэн бөөртийн далгай шаргал эвэр, хоёр хурганы нь мөгөөрсөн эврийн булдруу нэг нэгнээ дэрлэн хэвтдэг юм.

ЛУВСАНДАШИЙН БАДАРЧ /1919-1960/

Зохиолч яруу найрагч агсан Лувсандашийн Бадарч Төв аймгийн Эрдэнэсант сумын нутагт 1919 онд малчны гэр бүлд төржээ.

1937 оноос уран бүтээлээ эхэлж “Октябрийн туяа”, “Баатарлаг явдал”, “Авхайн морь”, “Унага” зэрэг олон өгүүллэг, ёгт үлгэр, шүлэг найраглал бичжээ. 1956 онд анхны нь түүвэр хэвлэгдсэнээс гадна “Хүжийн гал” зохиол нь тусгай ном болон нийтлэгджээ.

Зохиолчийн шилмэл зохиолын түүвэр 1963 онд хэвлэгдсэн байна.

ЧУЛУУН АРСЛАНГИЙН ХЭРЭГ

Урчуудын эвлэлийн... аймгийн салбарт нэг чулуун арслангийн хоншоорыг “эмчилж” байлаа. Хорь гаруй жилийн өмнө нэг “Зоригт” эр, арслангийн хоншоорыг хуга цохиж “номхтгосон” юм байжээ. Тэр зоригтон”арслангийн” хоншоорыг түлээний сүхээр ганцхан далайлтаар хэмх цохисон байхад, одоо түүнийг сэлбэх гэж хоёр сайн барималч хорь хоног оролдож байж хоншоортой болголоо.

Олон зуун нас насалж, олон юм үзэж, хорин хэдэн жил хоншооргүй байхдаа турж үхээгүй тэр арслан одоо ч бүр алзахаа байж, орчлон дээр мөнхжих нь тэр билээ. Ард түмэн түүх соёлынхоо дурсгалт зүйлийг ингэж нандигнаж байдаг. Гэтэл хориод жилийн өмнө түүх дурсгалын зүйлийг сүйтгэж байсан хүмүүс бий. Тэд чухам ямар хүмүүс байсныг өөрийн олж мэдсэний хирээр тодорхойлон бичих гэж оролдъё.

Өөрсдийгөө юм юмны захаас гадарладаг гэж үздэг хоёрын зэрэг хүнийг би мэдэх юм. Энэ хоёр одоо амьд мэнд яваа л байх.

Мань хоёр тэр үед 35-45 насны хүмүүс байсан юм. Тэр хоёр орчин цагийн ном ярьсан ч, бурхан багшийн ном ярьсан ч ярьж л байдаг. хулгай ч ярьдаг, машин ч мэддэг, мал ч мэддэг. Юу ч бол юуг чалчиж чаддаг байжээ.

Чалчихдаа, магтаж ч чаддаг байлаа. Мэдэмгий чадамгай гэгчид маань тоолж болшгүй олон юм гадарладаг боловч тодорхойхон мэддэг нэг ч юмгүй ажээ. Тэр хоёр ам хэлээрээ бол гал ус хоёр шиг нийцдэггүй байсан боловч үнэндээ гал ус хоёр биш хоёул “бохир ус” байсан юм. Тэр хоёрын угийн нэр Тунсаг, Пунцаг боловч нутаг усныхан пийсүү Тунсаг, Пийдаал Пунцаг гэдэг байжээ.

Мань хоёрын аль аль нь бичиг уншдаг ч үгүй байж. Юм юм гадарладаг хүнд тэр илүү зан гэж боддог биз дээ. Бас тэд яриа таниулгад оролцдоггүй, бүхнийг төсөөлдөг хүнд ухуулга таниулга сонсох хэрэг алга гэж санадаг байгаа биз дээ.

Пийсүү-Тунсаг чалчихдаа нэг бол “авай гэгээн” эсхүл “эвий хөөрхий” гэж эхэлдэг зантай. Авай гэгээн гэж эхлэхдээ нүд нь сээтийж, нүүр нь малийж, баярласан муур цээж нь хэрчигнэж байгаа юм шиг талимаарна. Эвий хөөрхий гэж эхлэхдээ нүд нь жартайж нүүр нь үрчийж өлссөн муур шиг гонгинон, сүүрс алдана.

Тэр “авай гэгээ! Урьдын цаг мөн ч сайхан байсан юм” гээд муу юмыг сайн болгож, муухай юмыг сайхан болгож, хар нохойг ч цагаанаар будах гэж хамаг хүчээ шавхдаг байв. Авай гэгээн! Наад захаас нь хэлбэл: “гангар шаазан, гавжийн дугуй, баранзад хадаг, бажгар дурдан, даргар чисчүү, даацай торго, пүүсүү пийсүүгий чинь эдэлж явлаа” гээд түрийнээсээ пийсүү соруултай гаансаа суга татан авч тамхи нэрдэг байсан тул пийсүү Тунсаг нэрийг олсон юм байж.

Пийсүү Тунсаг өөрийгөө хүндлүүлэх дуртай хүн байсан бөгөөд “цагийн сайнд” юм үзэж нүд тайлан урьд цагт торгон дээр хөрвөөж, тосон дээр умбаж, хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи зооглож явсан мундаг эр болох гэж хуучны юм бүхнийг магтдаг байсан ажээ.

Чалчсаар байгаад эрүү нь эцэж хэл нь хатаад аргагүй болж пийсүү Тунсагийг мордоход Пунцаг пижигнэтэл давхиж ирээд,

-Өмхий “пийдаал” өгөр толгой, танайд чалчиж байгаад мордов уу? Өнөөх “пийдаалийн” чинь нэг тэр мөн. Дорж гуай та “пийдаалтай” нөхөрлөөд пийдаал болох нь уу? За ер нь тэгээд та болохтой болбол хэдэн мал гээд гадаа гандаж хөдөө хөхрөөд байгаа биз. Мал хөрөнгө бол “пийдаалын” үлдэгдэл. Та тооноосоо зүүсэн хадгийг устга! Энэ чинь балрын суртал “Пийдаалын” үлдэгдэл ... гэдэг байжээ.

Пунцаг эрүү өвдөг нийлсэн эцэг эх хоёрыгоо мал ахуйгаа янзалж бид хоёроо өргөж тээх хэрэгтэй гэж үглэхэд нь

- Та хоёр “пийдаалын” суртал битгий гарга! Ер нь та хоёр “пийдаалын” үлдэгдэл ... Би, ардын хүүхэд, ангийн хүүхэн байна. Та нарт дарлагдаж мөлжигдөхгүй! Мал хэрэггүй, машин мотор хэрэгтэй. Хазаар ногт барихгүй харандаа цаас барина. Хөх бууц “пийдаалынх”, хөдсөн дээл ч “пийдаалынх” гэж загнадаг байжээ.

Хувьсгалаас өмнөх үеийн юм бүхнийг феодалын юм гэж хэлдэг Пунцагийг нутгийнхан нь “пийдаал” Пунцаг гэж нэрлэсэн учир тэр ажээ.

Хөдөө нутагт жил ирэх тутам өсөж байгаа шинэ хүмүүсийг “пийдаал” Пунцаг огт тоохгүй тэдний хийж байгаа ажлыг сонирхдоггүй, хүмүүжлийн ажилд оролцдоггүй, би мэднэ чадна гэж давхиад “пийдаалын” үлдэгдэл гэж юм бүхнийг чичсээр яваад хамгийн хоцорсон хүн болсноо өөрөө ухаарсангүй.

Тэр, цогтой хувьсгалч хүн дэвшиж дарга болдог. Яаж байж цогтой хувьсгалч болж, том тушаалтай дарга болдог билээ гэж бодохдоо “Аа тийм! Цогтой хувьсгалч бол “пийдаалтай” зад тэмцэгч байх ёстой. Тэгэхээр би “пийдаалтай” зад тэмцье ... Халаг гэм! Манай хушуу ноён байсан Шажинбадрах амьд байсан болоосой, тэгсэн бол би түүний толгойг хага цохих юмсан. Тэгвэл намайг цогтой хувьсгалч гэхгүй яах вэ” гэж боддог байжээ.

“Пийдаал”-Пунцагийн гар загатнаж нэг далим гарлаа. Нутгийн хуучин түшмэд Сундуй хурц гэгч нас барахад түүний гурван мухлаг тэргэнд хадгалж явдаг монгол манж, олон номыг “Пийдаал”-Пунцаг олж үзээд Сундуйн бэлбэсэн эхнэр, ах лам хоёрын нь “Пийдаалын” юм хадгалж байна. Эсэргүү дайсан, өмхий “Пийдаал” гэж хараан зүхэж тэр номуудыг шатааж устгах гэжээ. Тэгэхэд нь сумын захиргаанаас хүн ирж болиулснаар барахгүй сумын дарга, “Пийдаал”-Пунцагийг дуудан аваачиж, учир явдлыг ухуулан, нугалаа завхрал дахиж гаргаж болохгүй гэж хатуу сануулав. Гэвч тэр сумын даргыг бас нэг “Пийдаал” гарах нь гэж хараан, тэр уурандаа нутгийн жижиг хийд дээр давхин очиж дуган сүмд нь ороод бурхан тахилыг нь хэмхчиг гэж бодсоноо арай зүрх хүрсэнгүй тул сүмийн үүдэнд байдаг чулуун арсланг сүхээр балбаж хоншоорыг нь хага цохижээ.

Сумын намын үүрийн нарийн бичгийн даргаас аваад нэлээд гишүүд “Пийдаал”-Пунцагтай уулзаж, хийж байгаа ажлын нь хор холбогдол, жинхэнэ хувьсгалч тэмцэгч хүн ямар байх тухай зүйл бүрээр ухуулан таниулсан боловч Пунцаг сэнхэрсэн юм огт үгүй бөгөөд “эд намайг өөрсдөөсөө илүү хувьсгалч гарах гэж айж дарж байх гэж оролдож байна” гэж буруу

ухаарчээ.

Улс орон түргэн хөгжиж байлаа. Тэр хөгжил юм бүхэн дээр мэдэгдэж байв. Ясны цагаачин, тарвагачин “заяаны буянгүй амьтан” гэж Пийсүү-Тунсагийн доромжлон хараадаг байсан хөх Гэндэнгийнх дүнхэр цагаан гэр барьж, үр хүүхдээр өнөр, үрээ даагаар баян тохитой айл болжээ. Түүнийг үзээд пийсүү-Тунсаг гашуунаар инээмсэглэж, ажил унхиа муутайгаасаа яйжийлгаж жажийлгасан янхир хар гэрээ, буурлын буян гэж бузгайрхаж бардахаас биш арчилж торддоггүйгээс цөөрсөн хэдэн малаа бодож гол нь горойдог байж.

Хөх Гэндэн, хар торгоор гурав эмжсэн сайхан буурал даавуу дээл өмсөж, сайн малчны тэмдэг зүүгээд цог хийморио бадруулан явахыг пийсүү-Тунсаг хараад жөтөөрхөх хор нь буцлахдаа, дал мөрнөөс нь аваад даг хир болсон ганц чисчүү дээл, тамхины бохинд тагжичрсан пийсүү соруулаа бодож, буурлын буян ингээд дуусдаг байжээ гэж санаа алджээ.

Тунсагийг тоодог амьтан ч үгүй, буурлын буян ч үгүй, мэддэг юм юмгүй, чаддаг ч зүйлгүй, үгүйгээр дүүрч гүйцжээ. За ингэхлээр чинь яадаг хэрэг вэ гэхдээ есөн зоос гүйлгэж чаддагаа санаад хүйтэн хөх инээд нь хүрч гэнэ.

“Пийдаал”-Пунцаг ардын хүүхэд, ангийн хүү гэж ханхалзаж, аягүйхэн харсан юмаа пээ-пүү “Пийдаалийн” үлдэгдэл гэж чичээд “мал гэхээр манас гэж, мах гэхээр ухас гэж”, эцэг эх хоёроо зараад эгээ л нэг феодал ёсоор амьдарч байжээ. Тэгж хэдэн жил болоход насан болсон эцэг эх хоёр нь эсгий гэрээ орхиж энгэр гэртээ харьцгаав. Эцэг эхийн хэт хайранд мансуурч өсөхөөсөө өтөлтлөө аж төрөхийг мэдэхгүй тонгочиж явсан Пунцаг, эцэг эхээсээ хойш элдвийг үзэж эхэллээ. Мал маллая чаддаггүй, машин жолоодъё мэддэггүй. Алба хаая амждаггүй: “ардын хүүхэд, ангийн хүү ... пээ пүү “пийдаалийн” үлдэгдэл” гэж хэлж сурсан хэдэн үгнээс өөр мэдэц боловсролгүй, ёстой л “ганц чорт /чөтгөр/ алинд ч хүрдэггүй ээ!”

За тэгээд мань эр эцэг эхийн үлдээсэн хэдэн мал хөрөнгөөр наймаа панз нэлээн үсэргэж, найр хурим баахан хийж, мөрийтэй тоглоом эргүүлж ч үзэж, муу хүнтэй нөхөрлөж ч үзжээ. Ингэж ингэж эцсийн бүлэгт янгиа хар эмээл, яндан цагаан морьтой ягдаж хоцров.

Одоо яаж амьдаръя гэж олон арга бодовч, амьтан хүнээс нэрэлхээд асууж зөвлөн үзсэнгүй. Зайлуул яахав. Ингээд амьдар гээд зааж өгсөн хүнд за яршиг хатуу ажил, хар ажил хийхгүй гэж амар хөнгөн ажил олох гэж арга бааш бясалгаж үзлээ. Зүйл зүйлийн мэх олдсонгүй. Ингэж цөхөхдөө элдэв юм боджээ. Бага залуу байхдаа баруун хүрээнд шавилан сууж бурхны ном заалгаж, бузгай сайн уншигч болж, манз цав зооглож малилзаж явснаа дурсаж, гүзээт дооромбыг дагаж гүрмийн хэнгэрэг балбаж барьц тавьц болж баяжих шахсанаа санажээ.

Чанцал чавганцын зүүд зөн муу гэнэ. Жил нь ороод бие нь бүр базаахгүй гэнэ. Мэрэгч төлөгчөөр үзүүлэлгүй горьгүй, гүрэм засал уншуулалгүй болдоггүй гэнэ. Сэвжид чавганц сэмхэн шивнэж төлөгч гүрэмч хоёрыг төдхөн олжээ. Өнжиж хүлээсэн өдөр болоход өнөөх Чанцал чавганцынх руу мэрэгч, гүрэмч хоёр мэгдэн яаран алхацгаажээ. Гүрэмч түрүү ирээд гүзээгээ баахан дүүргээд арц, рашаан бэлдэж айхтар дүвчигнэж суутал, төдөж удсан ч үгүй төлөгч орж ирлээ. Гүрэмч дүвчнийг үзээд төлөгч мэргэн давхийв. Мэргэч төлөгчийг хараад мэхтэй гүрэмч өндөсхийв.

Хэн билээ энэ чинь гэж хэн хэнээ таньсан чинь нэг нь Пийсүү Тунсаг байж гэнэ. Нөгөө нь “Пийдаал”-Пунцаг мөн гэнэ.

За тэгээд, Чанцал чавганцын өмгөр бор гэрт “гал”, “ус” хоёр ингэж золгожээ.

Мартсан чулуун арслангийн тухай хэлэхэд, малчин ардууд мань хоёрыг шүүмжилж, зүгээр суугаад идэж болдоггүйг зүрхэнд нь ортол сэнхрүүлжээ. Тэгээд мань хоёр урчуудын эвлэлийн аймгийн салбарын хуучин түүх соёлын дурсгалт зүйл сэлбэж байгаа хэсэг урчуудад хар бор ажил хийх болсон байжээ. Тэгэхдээ мань Пунцаг хоншооргүй болгосон чулуун арслангаа сэлбэн засахад чадах хирээрээ туслалцаж “нүглээ наминчилсан” гэнэ билээ.

БАЛДАН ГАЛДАН ХОЁР

Балдан, Галдан гэдэг адилхан хоёр залуу бий. Гэвч ажил төрлөөрөө адилгүй юмсанжээ.

Балдан нь малч, ажилч, бас хичээл дугуйланд идэвхтэй. Ном сонин их уншдаг. Тэгээд нөхөрсөг тусч тул нутгийнхан нь түүнийг магтдаг. Залуу хүүхнүүд ч Балданг л сэмхэн сэмхэн ширтэцгээдэг ажээ.

Галдан нь Балдандаа атаархдаг байжээ. Балдантай уулзсан бүхэн нь түүнийг магтаж, халуун сайхан үг хэлдэг байхад Галдантай уулзахдаа:

- Чи цаг үргэлж айл хэсэж, архи дарс эргүүлж шалмаглаж явахаа боль. Эцэг эх чинь өтөлж, хэдэн малаа хүчрэхгүй болж шүү. Чи тэдэндээ тусалж, малаа өсгөхийг бод гэж л үглэдэг байв.

Нэг өдөр Галдан архи айраг эргүүлж “төмөр тэргээ өгөөч түлээ зөөгөөд өгье” гэж дуулаад давхиж явжээ. Гэтэл түүний зам дээр өвсөө хадаж байгаа Балдан тохиолдов. Галдан дотроо бодов. Энэ Балдан ажилд сайн гэхээр онгирч, улам ажилч хүн болох гэж дэндэж байна. Бас тэгээд надад хүртэл өвс хадахын ашиг тус гэж лекц унших санаатай байна билээ шүү ... Залуу хүн чинь над шиг ингэж, тарган морио унаад торгон дээлээ өмсөөд айраг архи сэнгэнүүлж хэнхдэгээ яраад давхиж явдаг юм биш шүү гэж боджээ. Тэгээд тэр нэг сайн гайхуулна гэж шийдэж мориныхоо гүйхээр Балдангийн дэргэдүүр өнгөрөхдөө:

- Балдаан! Залуу хүн чинь ингэж явдаг юм шүү гэж хашгирав. Гэтэл морь нь хадсан өвснөөс бусгахад Галдан олгойтой ус шиг улхайн ойчив. Балдан хадуураа тавьж,

- Мөн дөө ... залуу хүн чинь ингэж явдаг юм байж дээ гээд инээд алдав. Галдан ойчихдоо өвдсөн боловч ичихдээ ёо гэж хэлсэнгүй. Балдангийн шоолж инээхэд хор нь хөдөлж, өвдсөнөө хайхрахгүй босон харайв. Тэгээд түй мондийн хар өвс! гээд Балдангийн хадсан өвс рүү нулимав. Балдан анхандаа уурламаар завдсан боловч уужирч,

-Толгой чинь эргэж, нүд чинь харанхуйлж байна уу? Хар биш ногоон өвс байна шүү гэв

- Чи юунд дандаа ингэж байдаг юм бэ. Өвлийн бэрхэд хэдэн малын аминд ордог юмны чинь нэг энэ шүү.

- Үхсэн хойноо! Манай мал, хадсан өвсийг идэх байтугай үргэдэг юм чинь дээ. Чи харахгүй юу. Миний морь өвснөөс үргээд намайг хаячихлаа шүү дээ.

- За чи битгий дэмий юм ярь л даа. Энэ чинь адуу шүү дээ. Ер нь ингэж, дэмий тэнэж байхаа болиоч дээ. Жаал өвс хадаж авахыг бод. Хоёул хамжъя, чамд зааж өгье. Над илүү хадуур хэрэглэл зөндөө гэхэд нь Галдан нь хайхарсан ч үгүй ташуураа шүүрч аваад: “Жаахан Дулмаа хаачсан бэ ...” гэж дуулаад, үргэж давхисан мориныхоо хойноос гэлдрэв. Балдан:

- Гайгүй мөд ... мөдхөн болно доо ... гэж хэлээд хадуураа шүүрч авав.

Өвөл болов. Балдан, Галдан хоёрынх ойролцоо өвөлжив. Тэдний адуу оторт гарахад Галдан ганц хайртай морио нүдэндээ харж байя гэж үлдээгээд бусад адуугаа оторт явуулав. Цас байн байн орж билчээр зузаан хадсан их өвс ногоон гүвээ шиг харагдав. Балдангийнхан тэнгэрийг царайчлан харахгүй тайван. Мал нь тавтай хивнэ.

Балдан нэг өдөр сумынхаа төв дээр очиж, сүүлчийн сонин сэтгүүлүүдийг аваад харихаар давхиж явав.

Түүний зээрд морь нь тарган, омголон. Давхихад нь туурайгаар нь цасан манан бужигнана. Гэтэл судгийн хажуугаар өнгөрөхдөө, Балдангийн зээрд морь огло харайн бусгав. Балдан мориныхоо амыг татаж, судаг руу үзвэл, Галдан хөлдөх шахтлаа бээцийгээд цас малтаж өвс зулгааж байв. Түүний бараг “эхнэр шигээ” хайрладаг бор морь нь эвхийчхээд Галдангийн дэргэд зогсож байв. Балдан сандарч,

- Үгүй чи чинь яаж байгаа юм бэ? гэхэд Галдангийн эрүү хавшиж бор морь минь! Харж байна уу, турж үхэх нь гэж арай чарай дуугарав.

- Тэгээд бусад нь ... гэж Балданг яаран асуухад,

- Чи тэгээд манай өвснөөс авахгүй яагаав? Манайханд хэлсэн үү? гэж Балданг асуухад Галдан,

- Үгүй ... хэлээгүй гэв.

- Яагаав хэлэхээ ичээ юу? гэхэд нь Галдан доошоо харж дуугарахгүй зогсов.

- За явья. Одоо очоод манай өвснөөс ав! Орой хоёул явж өвөлжөөндөө зөөж авчирна шүү гэж Балданг хэлэхэд: Галдан,

- За ... гээд, дахин юу ч хэлж чадсангүй, Балданг дагаж одов. Балдан гэртээ ирж буугаад мориндоо өвс тавьж өгөхөд Галдангийн бор морь, өвс рүү нь дайран оров.

- За харж байна уу Галдан! Чиний морь өвснөөс үргэдэг биш билүү гэж инээмсэглэхэд Галдан улам ичиж,

- За та боль л доо гэж Балдангийн мөрийг алгадаад: Би гэмээ мэдлээ. Одоо чамайг дууриаж ажиллана. Чи намайг дагуул гэж хэлэв.

Түүнээс хойш Балдан Галдан хоёр дотно үерхэж ажил төрөл, элдэв нэгээрээ ав адилхан өсөж хөгжиж явдаг боллоо.

БӨХИЙН БААСТ

Зохиолч Б.Бааст 1921 онд Ховд аймаг /одоогийн Баян-Өлгий/ Алтанцөгц сумын нутагт малчны гэр бүлд төржээ. Бага, дунд сургууль, Марксизм-Ленинизмийн оройн Их сургууль, Москвад утга зохиолын дээд курс тус тус төгсжээ.

1936 оноос уран бүтээлээ эхэлж “Алтайн жимээр”, “Алтайн цэцэг”, “Алтайн салхи”, “Алтайн хоёр өнгө”, “Алтайн их дөнөн”, “Хөвчийн Бор”, “Намрын уянга”, “Хаврын салхи” зэрэг өгүүллэгийн туужсийн олон ном бичжээ.

Б.Бааст 1976 онд шилдэг бүтээлүүдээрээ Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртжээ.

ХАШ АЯГА

Дотны найз Гонгорын Хайдавтаа

Баруун уулын даваа нь

Бартаа ихтэй даваа даа хөө

Баруун айлын Гавалмаа бүсгүй нь

Баахан зүрхний тольт уу даа хөө ...

Ардын дуунаас

Оройн саалийн цаг болов. Ууланд хариулганд байсан үхэр жингийн тэмээ шиг жирийгээд гэр лүүгээ цувчихлаа. Ээлжгүй үхэрчин өвгөн Тэрбиш үхрийнхээ сүүлчийг харан гэлдэрсээр гэрийнхээ гадаа ирэн иртэл нь хэн ч түүнийг дуудаж “Манайд орж цай уу” гэсэнгүй. Уг нь фермийн саальчид Тэрбишийг орой бүр ээлжээр гэртээ урьж цайлдаг заншилтай болчихсон юмсанжээ. Тэрбиш гаднаа бууж номхон хул мориныхоо эмээл хазаарыг аваад хондлой дээр нь алгадахад хул морь ухарч цаашлахчаа аядсанаа дороо өвс зулгааж эхлэв. “Намайг бодвол өдөржингөө л эрүү ам нь хөдлөх юм. Тэгсэн хир нь юу ч амсуулаагүй юм шиг мал хүн туйрандсан цулгүй газрын хатаж шарласан өвсийг ум хумгүй зулгаах юм. Яасан ч шинжгүй юм бэ” гэсэн шүү юм бодов. Тэрбиш, гэрийнхээ хаалга түшүүлсэн савааг авч бүсэнд хавчуулав. Саваагаар хаалга түшүүлэх нь “Энэ айл эзэнгүй” гэсэн тэмдэг болно. Гэртээ оров. Газар дээр ганцаар хүний гэр хэдий намрын хайлган сайхан цагаар ч гэсэн өдөржин эзгүй байх юм чинь яаж царайтай байх вэ! Өвгөн хазганасаар намхан орныхоо өмнө очиж адсаган дээр дөнгөж суугаад байтал хэдэн бор жаал гүйлдэн ирэв. Тэдний араас бараг өөрөөсөө том модон домботой халуун цай, тавагтай идээ барьсан хүрэн хацартай охин орж ирэв. Тэрбиш идээ цайг аваад бяцхан хар шургуулгынхаа нүд татан охинд хоёр ширхэг цаастай чихэр авч өгөөд,

- За, өндөөр болоорой гэвэл охин,

- За-аа гээд чихрийг хоёр гардан авлаа. Охины ийнхүү “шагнуулахыг” харсан хэдэн жаал,

- Амаа, төвийн урлагийн бригад одоо манай хажуугийн тохойд ирж буугаад оройдоо тоглох гэнэ ...

-Та концерт гарахыг үзэх бол танд суудал авч байх уу! гэсэнд,

- Өвгөн ах нь яаж ч мэднэ гээд тэдэнд нэг нэг чихэр авч өгсөнд дорноо пижигнээд алга болов.

Тэрбиш шургуулга руугаа гар оруулж нэгэн хаш аяга гаргав. Тэр аяга хоёр бөөрөндөө бариултай юм. Бариулыг нь сайн ажвал дэрээ нэг нь дээшээгээ, нөгөө нь доошоогоо гүйсэн хоёр ижилхэн оготнын сийлбэртэй юм. Тэрбиш, аягаа эргүүлэн тойруулан харж байснаа гүнээр сүүрс алдаад шургуулга дээрээ тавив. Шаазан гаргаж цай аягалав. Цайндаа өрөм хийв. Тавгай цайлаад орон дээрээ хажуулан хэвтэв. Дуг хийгээд сэрвэл гэрт харанхуй. Гадаа гарвал саальчид тугалаа уяж байна. Урлагийн бригад ирээд майхнаа босгоод гаднаа цахилгаан гэрэл тавьж тоглох байраа засаж байна. Баян хуур, шанз хөгжим тоглон хүмүүс дуулах сонсогдоно. Эргэн тойрныг чагнавал, энэ хөндийн бүх айлын хүмүүс морьтой явган, хоёроор гурваар, гагцхүү урлагийн бригад тийш ярин хөөрөн цувж байна. Тэрбиш гэрийнхээ гадаа баахан зогсов. “Урлагийнхны тоглолтыг үзэх үү, байх уу? Хүсэн хүлээдэг хүн маань ирээ бол уу, үгүй бол уу! Нэрийг нь мэддэг, дуулах нь аль язгуурын зүрхэнд танил болон харагдсан тэр нэгэн хүн яагаад манай үүгээр ганц удаа ч гэсэн үл ирнэ вэ! Би чамайг ирнэ байх гэж хол ойрын хичнээн урлагийнхны, хичнээн тоглолтыг үзэв дээ! Гэтэл чи нэг ч удаа ирсэнгүй. Өнөө орой ч бас л ирээгүй бизээ. Ээ дээ чи бид хоёрт уулзахын ерөөл ч оршоогүй дэг ээ” гэхдээ бас нэг удаа гүнээр шүүрс алдав. Тэрбиш гэртээ ороод гэрэл гэгээ ч гаргасангүй. Шууд ор дэрээ засан хэвтэхээр зэхэв. Хэвтэхийнхээ өмнө бас нэг аяга зэхрүүн цай уучих санаатай шургуулга руугаа тэмтэртэл гарт нь хаш аяга нь тааралдах мөртөө амсар нь тисхийн дуугардаг байна. Аяганы амсар сэт үсрэх мэт тисхийхийг анх удаа дуулсан тул Тэрбиш хирдхийн цочив. Гэрэл гарган аяганыхаа амсрыг үзэв. Ер ан цав гарсан юм алга. Алган дээрээ тавиад аяганыхаа амсрыг тог тог хийтэл няслаад үзэхэд диг диг хийдэг урьдын царгиу дуу сонсогдов. Аяга бүтэнд сэтгэл амрав. Урьд нь ингэж тисхийж дуугардаг байсныг огт анзаардаггүй байжээ гэж өөрийгөө зэмлэв. Анчин хүний буу дуугарвал ан гөрөөнд олзтой омогтой явдаг гэдэг. Аяганыхаа тисхийн дуугарахыг анх удаа сонсов. Хүсэн хүлээдэг, нэг бодлын танил, нөгөө бодлын үл таних тэр хүн маань ирээ юм бол уу гэж бас бодов. Тэрбиш өнгийн хангайн юм бодон хэвтсэнээ нам унтжээ.

Өвгөн Тэрбиш давхийн сэрэв. Юунаас цочив оо! Юу ч цочоосонгүй, гагцхүү зүрх сэтгэл нь түүнийг дуудан сэрээжээ. Зүрх сэтгэл харуул манаанд гардаг гэдэг үнэн байна. Тэгээд зүрх сэтгэл минь юуны учир намайг дуудан сэрээв ээ?!

- Ээ тэнгэр минь !!!

Чихэнд минь юу сонсогдоно вэ! Хэн хаана дуулж байна вэ! Юу билээ энэ чинь! Манай энд урлагийн бригад ирсэн билүү? Тэгээд чи минь ирээ юу! Ашгүй нэг ирээ юу! Ингэж ирдэг байжээ. Хаш аяга минь учиргүй ч тисхийн дуугарсангүй шүү! Ээ аяга минь! Тэрбиш аягаа авч алган дотроо барин чагнав.

... Баруун уулын даваа нь

Бартаа ихтэй даваа даа хөө

Баруун айлын Гавалмаа бүсгүй нь

Баахан зүрхний толь уу даа хөө

- Яг чи минь биеэрээ дуулж байна. Аргагүй чи минь хүрээд иржээ. Ингэж чи бид хоёрт

уулзахын ерөөл оршсон байна.

Зүүн уулын даваа нь

Зүгээр ч үгүй даваа юу хө

Зүүн айлын Гавалмаа бүсгүй нь

Зүрх сэтгэлийн минь тольт уу даа хө

Тэрбиш өвгөн хаш аягаа хоёр гараараа яг хавсран бариад мэлмэрүүлэн уйлсаар суув.

... Хад байгаад нурсанд орвол

Хайрга болоод шуурсан нь дээр үү дээ хө

Ханилж суугаад хагацсанд орвол

Харийн танихгүй нь дээр үү дээ хө

Дуучинг ийнхүү дуулан төгссөнөөс хойш Тэрбиш хичнээн уйлсан, хичнээн суусныг хэн мэдэж. Түүнийг гаднаа гарахад өнөөх уудам хөндий дүүрэн, инээн шуугин, морьтой явган ирж байсан үзэгчид эргээд нэг ч үгүй болон таран оджээ. Чагнавал хаа нэгтэй бүсгүй хүний цангинатал дуулах, энд тэнд нохой хуцах, бух урамдах сонсогдоно. Зогссоор байтал урд уулын зоон дээгүүр намар оройн саран мэлтийн гарч ирэв. Сарны гэрэлд уудам хөндий нэлдээ цайран ирэв. Урлагийнхны хоёр майханд гэрэл гэгээ ч алга, анир чимээ ч алга. “Эвий чи минь энэ хоёр майхны алинд нь сэтгэл амранхан унтаж байна даа. Энэ газрын мухарт, зүүдэнд чинь ч үл орох тийм нэгэн хөх өвгөнтэй чи хэзээ нэгэн цагт хүн санамгүй хачин учраатай гэж боддог уу? Яаж ч бодоо аж дээ. Хүний хувь заяа, учрал тохиол гэдэг их хачин шүү...” гэж бодохдоо Тэрбиш мөн гүнээр сүүрс алдав.

Бяцхан бор гэрт гэрэл гэгээ алга. Гэрэл гэгээгүй тусмаа нэг нь дүнгэр ярьж, нөгөө нь юу ч дуугарахгүй гагцхүү хичээнгүйлэн сонсож буй хоёр хүнд аятай байгаа бололтой.

... Тэр минь Цэ-занги гэгддэг байсан нэртэй баян хүний төрсөн ганц охин байсан юм. Аав нь овоо голдоо сүвтэй хүн байсан учир ганц охиндоо бичигтэй хүн олж гэрээрээ ном заалгаж зав чөлөөнд нь охиноо өөрөөр нь уйгагүй оролдуулсаар бичгийн эрдэмд нөр сайн сургасан байгаа юм. Миний мэдэхийнх, тэр цагт тэр бид хоёрын үеийнхэн дотор тэрүүн шиг бичиг үсгийн чадалтай хүн бардах нь биш үнэндээ байгаагүй юм. Хоног цаг өнгөрч өвгөн бие минь өгрөн доройтохуй тусам би түүгээрээ бахархан баясаж, буурал толгойгоо дээр өргөж усарсан хөх нүдээрээ алсыг харж явах бардам сэтгэл төрдөг юм. Би тэдний үхэрчин байв. Би бүх насаараа үхэр хариулах учиртай хүн байж. Мэдээ орсон цагаасаа хойш тэдний үхрийг хариулж байлаа. Сүүлд бид хоёрын хувь заяаг тэнгэр ниргэчихээр нь өөр айлын үхэр хариулж байгаад нутагт маань нэгдэл байгуулагдахад түрүүчийн гишүүн нь болоод анхны дундын хөрөнгө-бяруу тугал, бух шар, сувай саадаг нийлсэн хорин долоон үхэртэй болохоор түүний нь хариулж эхэлснээс хойш одоо бас яг хорин долоон жилийн нүүр үзэж байна. Би тэдний

үхэрчин юм хойно бид хоёрт нэгнийхээ хараа барааг харахгүй юмуу, ярьж хөөрөхгүй цаг гэж ер байсангүй. Би өсөж эрийн цээнд хүрлээ. Тэр маань ч ногоо шиг суга урган өссөөр надаас гурван дүү хир нь уулын арын цэх өндөр хар мод шиг голшиг шулуун хонгор шархан хүүхэн боллоо. Энэ чинь гучаад оны үеийн хэрэг шүү дээ.

Нэг мэдэхэд түүнийг минь энэ тэр эр хүйстэй юмнууд эргүүлж тойруулаад амар заяа ч үзүүлэхээ байжээ. Нэртэй нүүртэй баян хүний өнчин сонгино шиг атлаа өнгөтэй царайтай охинд санаархахгүй эр гэж хаа байх вэ. Түүний минь өөрийнх нь хэлж байснаар бол эцэг нь Данхар гэдэг өөртэй нь адил баяны бас нэг эр ганц хүүтэй суулгах бодолтой байж. Бодолтойсох юу байх вэ. Бараг далдуур зөвшилдөж орхисон байж. Гэтэл тэр минь тэдний далдуур хуйвалдсан санаа ил гараад ирэхийн цагт эцэгтээ уурсаж “Та намайг заяасан гэрт минь амар тайван байлгахгүй хажир адгуус шиг гадуурхахад хүрвэл надад хоёр алд сур, хойт голын хэдэн улиасны нэг олдono” гэснээс хойш энэ хэрэг ингээд ор тас унтарчээ. Тэгж байтал хэдэн жилийн өмнө Улаанбаатар луу яваад сураг нь тасарсан Лутаа гэдэг нэг гайхал эр бурхан минь тостой гараар барьшгүй гоё ганган дарга болчихсон гарч ирэв. Толгойдоо эрдэмтэй, ташаандаа буутай, морин сургууль үзүүлсэн нэг айхтар гайхал болчихсон ирдэг байна. Тэр Лутаа тэднийхээр бууж мордоод байх боллоо. Манайхан ч яах вэ Цэ зангийн охин, цэргийн дарга Лутаа хоёр ч ёстой үүрийн цолмон, үдшийн гялаан хоёр шиг хоёр амьтан нийлэх нь тэр гэлцэв. Удсангүй тэр хоёрын хурим намар болох юм гэнэ гэлцэв. Би яах вэ дээ, яамай тэр хоёрын хэрэг бүтэг, хөөрхий л гэж бодож байна.

... Байж байтал дарга Лутаа маань хүнд тархиа хага цохиулчихаж гэж дуулдав. Тэр мөртөө түүний тархийг хага цохисон хүний хэрэг илэрч яригдахгүй харин дарагдан баларчихав. Сүүлд дуулсан чинь тэр минь цохичихжээ. Яасан бэ? гэвэл Жирэмний хөндий гэдэг битүү улиас, бургаас, хустай хөндий гэтэлж тэр айлд очоод шөнө буцаж явахад нь нөгөө Лутаа гайхал сүүдэр шиг дагаж байгаад харанхуй шөнөөр их модон дотор барьж хүслээ хангах гэсэн байхгүй юу. Тэр минь угаасаа их эрдүүн зоримог хүн юмсан. Тийм болоод ч самбаачлаад Лутаагаас урьтаж орхихгүй юу.

Тэгж байтал соёлын довтолгооны ажил хөдөө нутагт эхлэх нь тэр. Бичиг үсэгтэй хүн манай нутагт тэр үед нэг хүний хоёр гарын арван хуруу хүрэлцэхээр цөөн байв. Тэдний дотор эмэгтэй хүн гэвэл ганцхан тэр минь байв. Тэр минь түр сургуульд багш хийх, бас бичиг сурах дуртай боловч түр сургуульд суух боломжгүй хүнд хол энэ тэр гэхгүй гэр оронд нь очиж ном заах ажилтай болов. Хүнийг ном сургах тэр ажилдаа түүний дуртайг яана. Удсангүй нутгийнхан нь түүнийг өндөр чилгэр сайхан бүсгүй болохоор нь “манай намхан шар багш” гэж энхрийлэн нэрлэв. Тэгж байтал сумын төвд улаан гэр байгуулах ажил үүслээ. Тэр улаан гэрт элдэв уриа лоозон бичиж хадах, зураг үзүүлэнд тайлбар сэлт хавсаргах гоё сайхан бичигтэй хүн хэрэгтэй болсонд бас тэр минь явлаа. Удсангүй тэрнийг минь улаан гэрийн эрхлэгч бөгөөд сумын төв дэх бичиг үсгийн багш болголоо. Дөрвөн жилийн өмнө Улаанбаатарт очиж бичиг үсгийн сургуульд суугаад ном эрдэмтэй болж буцаж ирээд нутгийн олондоо ном сургана гэж явсан нэг гайхал бас хүрч ирэв. Тэгсэн тэр золиг ном ч сурч базаасангүй, хотод жаахан завхарч яваад хүрч иржээ. Ирээд түүнийг минь жаахан оролдож үзээд хэргээ бүтэхгүй олохоор, харин лам болоод хонх дaмap барин лүйжин тавьж зод манаж дувчигнэх нь тэр. Үгүй энэ аавын олон хөвгүүд дотор мөн ч янз бүрийн гайхал байдаг байлаа шүү. Удсангүй тэр минь надад ном заах юм боллоо. Миний ном сургасан охидоос нэг нь

намайг уриалж энэ зун намрын зургаан сард тус бүр тав таван хүнийг түр сургууль, бичиг үсгийн бүлгэмээс гадуур номд сургая гэлээ. Тэгэхээр нь би за гэлээ. Ямар таван хүнд ном сургах вэ гэж бодоод байсан чинь чамд ном заах нь зөв санагдлаа. Чи надаар ном заалгах уу? гэхэд нь би үгүй гэлээ. Тэгвэл чи намайг голж байна уу? гэж тэр минь асуулаа. Энэ нь ухаандаа чи надад хайргүй юм уу? гэсэн далд санаатай үг болон хувираад ирэхээр нь би түүндээ, чамаар ном заалгая гэлээ. Тэр минь их баярлаж байна. Ном дуртай нь аргагүй заалаа. Би ч хичээгээд овоо сураад ирлээ. Тэр минь улам их баярлаж заримдаа надад хүнээр элдэв зурвас ирүүлдэг болов. Тэр зурвас дотор урт сайхан гол гаталгасан, өндөр их уул давуулсан өчнөөн гоё ганган үгс байдаг байв. Яршиг даа нэг голын хоёр талд байж, юун их маягтай юм бэ? гэж заримдаа боддог байв. Гэтлээ үгүй энэ чинь их учиртай хэрэг. Миний л бичиг үсгийн чадлыг сайжруулах гэхдээ мэрийж байгаа нь энэ гэж боддог болов. Энэ захиаг өчнөөн дахин хуулан бич гэж захиж бичсэн байхад нь заавал хуулж тавьдаг байв. Тэр нь одоогийн сурагчдын гэрийн даалгавар гэсэн үг юм даа. Сүүлд ирж, хуулан бич гэсний нь тоогоор хуулсан байхад ихэд баярладаг байв. Заримдаа хүнээр ирүүлсэн захиагаа өөрөө дугтуй хийж жонхуугаар нямбай нааж нүүрэн дээр нь захиа зуун ниссэн шувуу зурсан байдаг боллоо. Тэр нь бас нис нис! гэсэн бичигтэй байхыг яана. Зарим захиандаа давхиулсан морин туурай ч зурсан байна. Харилцан захиа бичилцсээр элдэв юм бичих боллоо. Тэр минь надад нэг л сэтгэлтэй юм шиг санагдаад болохоо байв. Нэг удаа хариу захиа бичихдээ өөрийнхөө сэтгэл зүрхэнд санасныг цөмийг нь бичээд явуулчихав. Тэгэхдээ чи надад хайртай аваас хариу ирүүлэх буй заа. Хайргүй бөгөөс дахин захиа ирүүлэх хэрэггүй гэсэн санаатай юм бичээд явуулчихав. Түүнээс хойш тэр минь гэрээрээ хэд дахин ирэв. Надтай огт урьдынх шигээ уулзаж, баярлаж хөөрсөнгүй. Байдлыг нь харвал нэг бодоход надад гомдсон мэт. Нөгөө бодлын надад бас хайр сэтгэлтэй ч юм шиг. Тэгээд захиаг минь аваад баярлаж хөгжихдөө тэр хайр сэтгэлээ нэг мөсөн илэрхийлж чадахгүй ч байгаа юм шиг халгаж ядсаар байгаад буцаад явлаа. Буцаад явчихаар нь за энэ бид хоёрын хорвоо өнгөрлөө гэж би бодов. Сар шахуу хугацаа өнгөрөөд байтал түүнээс минь нэг томоо дугтуйтай захиа ирэв. Гэнэт захиа ирэхээр гайхаж хоцров. Дугтуйг нь онгойлгоход гар минь чичирч байв. Сэтгэл зүрх минь ч хачин болчихов. Тэр минь учиргүй уран гоё урт гэгчийн тав зургаан захиаг нэг дугтуйд хийжээ. Бичсэн өдрийг нь харвал дөрөв таван хоногийн зайтай бичээд байжээ. Хамгийн сүүлийн захиандаа, бид хоёр нэгэндээ сэтгэлгүй байж чадахгүй. Намайг хүн гэж тоосонд чинь сэтгэл санаа минь сайхан боллоо. Захиаг чинь өдөр бүр л уншиж сууна. Бичгийн чинь хэв улам сайн болж, бичсэн үсэг бүрээс чинь чиний царай зүс, ааш зан харагдаж байна ... гэх мэтээр бичсэн байхыг уншаад магнай хагартлаа баярлав. Ганц бие минь хоёр болов. Тал бие минь бүтэн болов. Удсангүй бид хоёрыг нэг нэгэндээ сайн болжээ гэдгийг тэднийхэн, манайхан цөм мэдэв. Бид хоёрын хувийн нууцыг би алдсангүй. Тэр минь зориуд миний нэг захиаг алдсан болж хүнд өгөөд тэр хүн нь аав эжид минь дуудаж өгчээ. Тэр минь өнөөх, том захиан дотроо манай улаан гэрт Улаанбаатараас Цэрэндулам гэдэг бүсгүй ирж хэдэн дуу зааж өгөв. Тэр дуунаас энэ дуу л надад хамгийн сайхан санагдлаа гээд Гавалмаа бүсгүй гэдэг дууны үгийг бас бичиж хийсэн байв.

Сүүлд тэр минь холын багуудаар явж бичиг үсэг заалгагчдыг шалгах боллоо. Заримдаа бүр хол явахдаа намайг дагуулж явдаг боллоо. Түүнтэйгээ хамт хол явах надад хичнээн жаргалтай байв. Бид хоёр ёстой нэг ярьж хөөрч ном хаялцахыг үзүүлдэг байв.

... Хад байгаад нурсанд орвол

Хайрга болоод шуурсан нь дээр үү дээ хө

Ханилж суугаад хагацсанд орвол

Харийн танихгүй нь дээр үү дээ хө

гэж ирээд л Гавалмаа бүсгүйг тэр минь байсхийн дуулна. Түүний минь хоолой эрдүүн өнгөтэй, дуулах аяс нь өөрийн чинь дуулдагтай яг адилыг яана. Үгээ эхлэх, өнгөө өргөх, нугалах, солих шилжүүлэх, төгсгөхдөө яг л чи шүү дээ ...

Нэг удаа тэр минь өөр тийш бичиг үсгийн шалгалтаар явлаа. Ер нь түүний минь ажил гэж барагдахаа болив. Бид хоёр зуны сүүл, намрын эхээр ханилан суухаар тогтов. Тэгж явахдаа бас намайг дагуулж явах гэсэн юм. Гэтэл тэдний хэдэн сайхан амбан шарыг хулгай хөөгөөд явчихжээ. Би түүнтэй хөөцөлдөх хэрэгтэй боллоо. Намайг дагуулж явж чадаагүйдээ түүний минь сэтгэл нэг л хорогдонгуй, байдал нь тун хачин байв. Би түүнийгээ нэлээн хол хүртэл гаргаж өгөв. Тэр минь наддаа өнөөх л Гавалмаа бүсгүйг дуулж өгөх мөртөө сүүлийн бадгийг нь олон дахин дуулж өгөв. Морин дээр зэрэгцэж яваад намайг өөр лүүгээ татаж духтай минь духаа нийлүүлээд тэгээд дээш нь дүрлийн харж под подхийтэл инээж, за сайн сууж байгаарай! Би хэд хонож ч мэднэ. Заримдаа муухан сурч байгаануудад нь хэд хоног давтан хичээллэх ажил хий гэсэн. Хүнд тус хүргэвэл олигтойхон шуу тусалбал дээр шүү дээ. Чи ч үхрээ сайн л хариулахыг боддог биз дээ. Үхэр сайхан мал шүү дээ. Чи ч үхрээ сайн л хариулахыг боддог биз дээ. Үхэр сайхан мал шүү. Үхрийг сайхан хариулаад байхад ямар ч сайн нэр дуулж болох юм гэж тэр минь яг хэлсэн юм. Ном үзсээр тэр минь их ухаалаг, цовоо, хичнээн сайхан ааш зантай болсон гэж санана даа. За миний үхэрчин нөхөр минь буц даа. Хэдэн шараа олохыг бодоорой! Энэ хүртэл дөхүүлж өгсөнд чинь гялайлаа ... Тэгээд дахин сайн сууж байгаарай! гээд дахин духаа нийлүүлээд нэг удаа уртаар санаа алдах мөртөө мориндоо гэнэтхэн ташуур өгөөд давхин одсон юм. Их бороо орох янзтай арзайсан ам шүдтэй юм шиг хар үүлс түүний минь давхин одсон зүг хөндөлсөн нүүж байв. Би элдэв юм бодсонгүй, буцлаа. Хэдэн шарын хойноос гурав дөрөв хоног яваад олсонгүй буцаж ирэв. Осолдохгүй л буцаж ирснээ мэдэх юм. Ирээд юу болсноо тээр сүүлд мэдэв. Яасан бэ? гэвэл хонгор түүнийг минь тэр өдрийн хар үүл залгижээ. Цахилгаантай бороо ороод нимгэн хувцастай, муухан цувтай болохоороо айлын бараа харах санаатай гэнэн хонгортоод давхиулж явтал аянга цохижээ ... Ёстой л гэнэн хонгор зан гаргажээ. Ингээд л бид хоёрын энэ хорвоогийн жаргал дууссан юм даа ...

Гэрийн дотор бүр харанхуй. Нэг нь ийнхүү ярьж, нөгөө нь тийнхүү сонсож байсан хоёр эр хүн таг чимээгүй болов. Нэг хэсэг энэ гэрт угаасаа хүнгүй юм шиг тийм чимээгүй байлаа.

Чүдэнз шархийн асаж гэрт гэрэл гарав. Тэрбиш өвгөн нүдээ гэрэлд анивчуулан байж бяцхан шургуулгынхаа нүдийг татаж хаш аягаа гаргаж ирэв.

- Энэ хаш аягыг тэр минь надад өгсөн юм. Түүнээс минь надад үлдсэн юм энэ. Тэрнийгээ үрэгдсэнээс хойш энэ аяга бид хоёр өдий хүртэл байж л байгаа нь энэ. Би түүнийхээ хэлснээр үхэр малласаар ёстой сайн нэрнээс салсангүй. Би нэгдлийн дархан аварга үхэрчин, аймгийн есөн удаагийн аварга үхэрчин, улсын нэг удаагийн аварга үхэрчин боллоо. Харин би түүнээсээ хагацсанаас хойш эрдэм номтой болох гэж нэг их тэмүүлээгүй юм. Яагаад вэ гэвэл

түүний минь мэтгэн зүтгэн өчүүхэн хувь нэмэр болж явсан үйлс бүтэж бүгдээрээ ном соёлтой болчихоор миний хийж чадах ажил үхэр маллах юм шиг санагдсан юм. Сэтгэл зүрхнээс тэр минь мартагдаагүй боловч Гавалмаа бүсгүй гэдэг дууг тэрэн шиг минь аяс өнгөтэй дуулдаг хүн ер сонсогддоггүй байтал гэнэтхэн чи минь дуулаад гараад ирэх нь тэр. Өнгөрснийг улирааж, мартсаныг сэргээгээд чи минь энэ дууг дуулах бүрд нэг талаар миний өр зүрх холгогдож хоёр талаар би дандаа түүнийгээ санан дурсаж баярлан бахархдаг болов. Тэгээд энэ дууг дуулдаг хүнтэй уулзахсан, ядахдаа хараа барааг нь харахсан гэж дотроо хүсэж мөрөөдөн хичнээн ч концерт үзэв дээ. Хичнээн ч, сураглав даа. Тэгэхэд нэг ч удаа ирэхгүй байж байж өчигдөр энэ бригадынхантай хаанаас л ирээ аж гээд унтаад өгсөн чинь харин хүрээд ирчихсэн байдаг байгаа. За ингээд өвгөн ахын чинь чамтай уулзах гэсэн хүсэл гүйцлээ.

Чиний дуулахыг сонсох бүрдээ би түүнийгээ дурсан санаж өр зүрх минь баясдаг юм. Ах нь өндөр настай боллоо. Түүний минь надад өгсөн энэ хаш аягыг л чамдаа өгч хадгалуулах, тэгээд чамайгаа нэг харъя. гэж боддог байсан минь ч гүйцлээ. Миний хамаг хүсэл гүйцлээ. Чамдаа урт насалж улам сайхан дуулж явахыг ерөөе гээд Тэрбиш өвгөн хаш аягандаа шинэ сайхан өрөм хийгээд дуучинд барихад дуучийн сэтгэл хөдөлж нүд нь гэрэлд гялалзан харагджээ.

Тэр хоёрыг гадаа гарч ирэхэд тэнгэр цэлмэг, орчин тойрон нам гүм сайхан байв. Урлагийн бригадын хоёр майхан ч гэрэл гэгээгүй аж. Намар оройн саран дахин урд уулын зоон дээгүүр гарч ирэв. Уужим хөндий тэр аяараа мэлтийн цайрав

Тэрбиш өвгөн, дуучийн хоёр хацрыг илэн духан дээр нь духаа хүргээд:

- За хүү минь баяртай, сайн яваарай гэв.

АЛТАЙН ХӨХ ДӨНӨН

Цасан цагаан онгоц маань мөнх цаст домогт Цамбагаравын зүүн сугад хэдэнтээ сүрхий дайвалзав. Төрсөн өссөн нутгийн минь сэтгэлд дулаан, зүрхэнд зөөлөн газар нутаг нүдэн өмнө жирэлзэн өнгөрч эхлэв.

Цагаан түнгэ /үнэндээ цагаан дэрст гэсэн үг/ гэдэг нэгэн сум ард олон хэдэн мянган малтайгаа өлхөн намаржиж, өвөлжиж, хаварждагаар барахгүй хавар нь зөндөө газар тариа тарьдаг, намар нь хаа л бол хадлан авдаг хишигт нутаг минь шаргалтан харагдахаар бие сэтгэл минь нэг л хачин боллоо. Цагаан түнгэ нутаг маань бол Ховд голын нэгэн уужим цүлхгэр, тохой юм л даа.

Би нутгийнхаа халиун намрын ид сайхан цагаар нисэж явжээ. Төдхөн цагаан түнгийн наахантай, олоон жилийн тэртээ хайрт ээжийг минь нутаглуулсан Читгай гэдэг газар онгоцны цонхоор зэрвэсхийн үзэгдээд далд оров.

Ээж минь чухам ямаршуухан хүн байсныг би тодорхой мэдэхгүй ээ. Ээжийгээ нас барахаас нь хэдхэн хоногийн өмнө би нэг удаа хальтхан харсны л өчүүхэн бүдэг бүгээн дүр төрх миний нүдэнд хоногшин үлдсэнээр л би ээжийгээ тиймэрхүү хүн байсан гэж мэддэг. Харин ээжий минь нас барахаас нь өмнөхөн “Энэ муу хүү чинь жаал жуул ном эрдэмтэй явах хувьтай байж мэдэш юм. Юм нүдлэх цээжлэхдээ сайн юм. Үүнийгээ харж яваарай даа ...” гэж аавд минь захисныг, хожим аав минь мөн хүнд өвчтэй байхдаа надад хэлсэн нь энэ үед миний санаанд харван орж ирлээ. Бас би багадаа нэгэн гайхалтай сайхан зүүд зүүдэлсний дотор үүлэн хөх мориороо араас нэхэн хөөсөн олон дайснаас зугадан очиход ээжий минь “Хурдлаарай миний хүү, миний хүү, миний хүү ...” гэж тосон гүйж байсныг дурсан санаав.

Бас “Алтайн хөх дөнөн” гэдэг домгийг Гэцэлжав ах миний багад ярьж өгөхдөө “Эрдэм номтой хүн хүрэхгүй газар, үзэхгүй юм, унахгүй унаа гэж байхгүй болох юм байгаа” гэж хэлсэн нь юутай сайхан холч ухаантай зөн билэгтэй үг байсныг би санаав. Би нисэх онгоцоор тун олон удаа аялжээ. Онгоцонд суух бүрдээ би тэрхүү онгоцоо, багадаа хөлөглөн нисэж явж зүүдэлсэн “Алтайн хөх дөнөнгийн” тухай нэгэн домог дуртгал хавсармал өгүүллэг ярьж өгье гэж бодлоо.

Би багадаа их л дүрсгүй хүүхэд гэгдэж байв. Гэхдээ хүн олонд осолтой халгаатай юм нэг ч удаа үйлдээгүй билээ. Үнэндээ ч хүн айлгаж хүрээ бужигнуулсан юм үүсгэх ухаан санаа, тийм том зүрх, тэр цагийн хүүхдэд яаж ч байх ажээ. Би ах дүү олуулан байж. Одоо ч бид олуулаа л байна. Харин бид багадаа их азгүй ах дүү нар байж. Яагаад вэ? гэвэл бид хайрт ээжээсээ даанч эрт хагацжээ. Би бол ээжийнхээ дүр төрхийг тун муу төсөөлж байгаа юм. Ээжийгээ маш хүнд ёстой л хүний гарт орчихсон үеийнх нь хэдхэн минутын дотор ээжийгээ харсан нэгэн дүр зураг л миний нүдэнд үлджээ. Нэг өдөр би ах дүү нартайгаа түлээнд яваад ирлээ. Бид тэгэхэд манай гэрийн гадаа барьсан илүү гэрт байдаг байсан юм. Ээж минь гэртээ, хажуунаас нь бараг ганц аяга халуун цай аажуухан уучихаад ирэхээр гарах ч эрхгүй болсон ааваар минь түшүүлэн суудаг байсан цаг юм. Би түлээнээс ирээд, яагаад ч юм бэ, ээж дээрээ орох заяа таарч дээ. Тэгээд гэрт ороход зүүн талд намхан модон орон дээр царай гэдэг нь цас шиг цагаан болсон, үс гээг нь ширэлдсэн ээжийн минь хоёр хурц нүд гялалзан намайг

харлаа. Ээж минь жигтэйхэн их амьсгаатай байлаа. Аав минь ээжийг түших гэж бараг тэврэн сууна. Ээж минь намайг өрөвдөн хайрласан харцаар хараад нэг юм өгүүлэв. Ээжийгээ хараад “Хөөрхий ээж минь ийм ч болох гэж дээ” гэж бодохдоо би ухаан гартал айсан байх аа. Тэгээд ээжийнхээ юу хэлснийг лав дуулаагүй байх. Ээжийнхээ хэлсэн үгийг дуулаагүйдээ, би өөрөө гомдсон уу, ээжийгээ гомдоохгүй, уурлуулахгүй гэж бодсон уу, бүү мэд. Ганц хоёр гишгээд дахин ээж рүүгээ хартал “Ээж нь нааш ир гэж байна” гэж аав өгүүлэв. Хайрт ээжийнхээ дэргэд ноорхой царайлаад очсон чинь “Алив хар хүү, ... гээ ...” гээд цааш нь юм хэлж чадсангүй байдал нь хачин болов. “Ээж нь хүүгээ үнсье гэж байна” гэж аав өгүүлэв. Ээж рүүгээ тонгойж духаа өгөв. Ээж үнслээ. Уруул нь цэв хүйтэн боловч бие нь гал цог шиг халуун байв. Тонгойгоод үнсүүлэх хооронд л ээж минь тэр чигээрээ халуун нурам болчихсон юм шиг санагдлаа. Харин ээжийн амьсгаа гэдэг ёстой хачин түргэн байгааг би аль түрүүн нь мэдсэн юм. Ээж намайг дахин дүрлийн ширтээд “Муусайн хүүхдүүд минь яана даа” гэж бодсон байх даа. Тэгээд уйлсан боловч нүднээс нь нулимс гараагүй юм. Хөөрхий ээж минь тэгэхэд лав зүрх сэтгэлээрээ уйлсан байх даа. Ээж сүүлд аавыг тонгойлгоод чихэнд нь хэдэн үг хэлэв. Аав, ээжийн үгийг их л хичээнгүй сонссоноо ээж рүү хараад “”За за” гэх аятай толгой дохиж байв. Би бодохдоо, ээж минь миний тухай л аавд юм хэллээ гэж санасан юм. Аав “Тэр данхыг хөгшин ээжидээ хүргэж өг. Ээжид нь аяга халуун хярам авчраг” гэв. Би тэр данхыг авч гарахдаа ээжийнхээ царайг, зүрх өвдөж, нүд хальтраад дахин олигтой харж чадалгүй газар шагайн гарсан юм. Гэтэл тэр уулзалт ээж бид хоёрын амьд уулзсан сүүлчийн мөч байсан юмсанжээ ...

Түүнээс хойш хөөрхий ээж минь нэг ч их удаагүй нас барсан юм даа... ингээд бид ээжгүй боллоо.

Үүнээс хойш хэдхэн жил өнгөрөөд нэгэн намар аав минь намайг сундалж Танхим гэгчид аваачиж орхиод гэрээрээ Цэнгэл сум руу нүүгээд явчихлаа. Эсэргэн жилийн хавар гэр минь буцаад нүүж ирэв. Танхим завсарлаад гэртээ гүйж харьсан чинь манай гэрт нэг муу морин хуур байлаа. Ер нь тэр үед манай нутгийн айл бүрд муу сайн ч гэсэн ямар нэгэн хуур-хөгжим байдаг байв. Нэг өдөр хуурыг дэмий хөрөөдөөд сууж байтал Гэцэлжав ах орж ирэв. Нутгийн таних мэдэх ах дүү нар намайг урьд нь хаа ч байдаг нусгай борцуулын нэг гэж мэддэг байснаа, танхимд суугаад ирснээс хойш намайг ном эрдэмтэй хүн гэж хачирхаад байдаг болов. Миний хөрөөдөж байсан хуурыг Гэцэлжав ах аваад хөглөж нэгэн морины явдал дарав.

Тэр морины явдал надад сайхан ч юм шиг гунигтай ч юм шиг санагдлаа. Түүнээс хойш Гэцэлжав ахыг би ер бусын ид шидтэй хүн гэж бодох болов. Гэцэлжав ах л ирвэл би хуураа үг дуу ч үгүй авч өгдөг болов. Гэцэлжав ах ч миний хичнээн сонсовч уйддаггүй морины явдлыг дарж өгдөг болов. Аав ч бас заримдаа хуур дардаг байв. Гэвч аавын дардаг морины явдал надад төдий л сайхан санагддаггүй байв. Харин миний аав их л ёс горимтой хүн байсныг би бас мэднэ. Аав минь хуур дарахдаа өвдөглөн суугаад хормой дэвсэж хуураа тавиад дардаг байж билээ. Тэгээд:

- Би яаж хуур сурах вэ, Гэцэлжав ахаа? гэвэл,

- Хуур сурахад амаргүй ээ хүү минь гэлээ.

- Та надад зааж өгөхгүй юу? гэвэл,

- Чи надаар заалгаад олигтой хуурчин болохгүй. Ёстой хуурчин болохыг хүсэж байвал, чи урьдаар сайхан хууртай бол. Тэгээд газар сайн мэддэг хүнээр заалгаж хүн амьтны хөл гүйдэл ихтэй дөрвөн замын бэлчир газар ол! Хасын харанхуй шөнө тэрхүү эл хуль болсон дөрвөн замын бэлчир дээр очиж хуураа бариад суу. Тэгтэл чинь тэр шөнө, дөрвөн замын аль ч талаас нь ямар ч амьтан ирж мэднэ. Ирсэн амьтнаас огтхон ч айж болохгүй. Хуураа хөрөөдөөд л суугаад байх хэрэгтэй. Харанхуй шөнийн амьтад чамд гай түйтгэр тарихгүй. Тэд гүйдэг замаараа гүйгээд л байна. Тэгж байтал нэг мэдэхэд чиний дэргэд тэнгэрийн дагина ч юм уу лусын охин ч юм уу, уртын урт цагаан сахлаа чирсэн уулын өвгөн ирж ч мэднэ. Тэдний аль тэгж ирсэн нь чамаас элдэв шалдав юм асууж шалахгүй, шууд гарыг чинь барьж хуурын эрдэмд сургана. Өглөө эртээр хуурт сургасан хүн явна. Чи тэгээд л хуурчин болчихсон харьж ирнэ гэж ярилаа. Би энэ үгэнд итгэлээ. Ёстой хуурчин больё гэж бодлоо. Гэтэл эзгүй хээрт, эрхийн чинээн бие гав ганцаараа харанхуй шөнө хуур бариад сууна гэхэд хамгийн түрүүнд айх эмээх зүйл л сэтгэл санаанд орж байна. Чоно хүрч ирээд идчихвэл яанаа гэж бодогдлоо. Чөтгөр шулам ирээд аваад явчихвал яанаа гэж ч бодогдож байна. Ер нь айхгүй байх аргагүй санагдлаа. Гэтэл айхгүй байх хамгийн чухал гэж байгаа. Тэр ч байтугай хууранд сургадаг зарим ид шидтэн маань тэнгэрийн дагина, лусын охин байдаггүй, морины хувхай толгой унасан алмас эмгэн байдаг гэх нь тэр. Хэрэв тийм алмас эмгэн нь хүрч ирвэл би айхгүй байх нь бүү хэл ухаантай ч байж чадахгүй шүү дээ. Бас тэр морины хувхай толгойг унаж ирсэн эзэнтэй нь сундалдаж суугаад хуурдвал хуурыг улам ч сайхан сурдаг юм. Хуур гар хоёр чинь өөрөө эвлээд сайхан сайхан ая эгшиг өөрөө л урсаад ирэхийн цагт морины чинь толгойд амь орж хөдлөн хөдөлсөөр нэг мэдэхэд тэр толгой цаст өндөр уулын цалгиа цагаан арслан шиг газар шүүрсэн дэлтэй, ган дөрвөн туурайтай, галгиа халгиа явдалтай гайхамшигт эрдэнийн хөлөг чинь болно. Тэгээд чамайг үзүүртэй модны дээгүүр үүлтэй тэнгэрийн доогуур унуулан давхиад, заяаны чинь ханьтай учрааж ч мэднэ, замба тивээр хэсүүлж ч мэднэ, аль эсвэл аав ээжийн гэрт хүргээд ирж ч мэднэ гэж ярьсныг яах вэ. Гэцэлжав ахын энэ үг, нэг талаар сайхны нь яана, нөгөө талаар аймшигтайг нь яана. Ингээд эцсийн эцэст миний хуурчин болох гэсэн хүсэл бүтэхгүйд хүрэх нь тодорхой боллоо. Гэвч Гэцэлжав ахын энэ үг надад нэг л сайхан санагдаад байдаг байлаа.

Байсаар зун болов. Нутгийн ард олон, уршигт хорт шумуул гарах нь гээд л зуслан өөдөө яаран сандран нүүж эхлэв. Манайхан ч тэмээтэй унаатай айлуудыг хамжин нүүлгэлцэж байж унаа морь, ачлагын тэмээг нь гуйж нүүдгээрээ нүүж Олон-нуур хэмээх дэлгэр сайхан зусланд гарлаа. Зусланд гарахаар ядуу бидний жаргал эхэлж байгаа юм. Хилэн шиг ногоон зүлгэн дээр зунжин хөл нүцгэн наадаж тоглоно. Дуртай цагтаа усанд орно. Тараг хоормогт бүр ходоод маань өнгөршинө. Хүрээний банди нартай нийлж голын жараахайг тагш дүүрэн барьж хийгээд устай нь уралдан ууна... Энэ мэтээр хийдэг адил тун их болно. Шөнө болбол бид гэрт огтхон ч унтахгүй. Муусайн дээл, ширдгээ чирч гараад хотны захад унтана. Шөнө бидэнд айх зүйл бас бий. Бух шар дайрчих гэнэ. Өөдөө сөөргөө давхилдсан согтуу хөлчүү улсуудад гишгүүлчих шахна. Бид орондоо ормогц ярих зүйл бас ихтэй. Тэнгэрийн од, сарны тухай бидэнд ярихгүй зүйл гэж ер байхгүй. Од мичидийг өмчилнө. Нэг нэгэндээ “худалдана”. Заримдаа үлгэр ярина. Найр надам унадаг хурдан мориныхоо тухай ярина. Морио үлгэр домгийн ийм ч морь шиг, тийм ч морь шиг гэж магтана. Бидний багад яасан ч олон үлгэрч туульчин байсан юм бэ? газар сайгүй л үлгэр ярьдаг, өвлийн уртад тууль хайлдаг хүн байж дээ. Бид уван цуван унтана. Нэгэн шөнө би сайхан зүүд зүүдэллээ.

... Манай нутагт л бололтой их олон адуутай таньдаг ч юм шиг танихгүй ч юм шиг баян хүн байх юм. Би тэр баяны адуучин шиг л байх юм. Тэр баян олон адуутай ч надад сайн морь үл унуулна. Гэтэл манай нутагт дайн ч болоод байх шиг, Алтайгаас олон арван сайн эрчүүд ирээд ч байх шиг. Газар дэлхийгээр дүүрэн буун дуу, утаа униар болж өнөөх баяны маань их адууг хөөж туугаад ч байх шиг, хөлгүй их усруу шахаж хиар сүйтгээд ч байх шиг ухаан санаанд багтахгүй хачин юм болж байна. Их адуугаа сүйтгүүлсэн өнөөх баяныг харсан чинь ганцхан муу хамуутай татанхай хөх даага хүзүүдэн тэвэрчихээд л уйлж байх юм. Тэгснээ баян: “Чи энэ даагыг унаад тэрхүү Алтайн сайн эрчүүлийн араас явж адууг минь салгаад ир!” гэх юм. Би баяны хэлснээр түүний татанхай хөх даагыг унаад явах болсонд аав минь “Миний хүү хөх даагаа татанхай гэлгүй гуядаад, хөглөгөр Алтайн замыг хэцүү гэлгүй тэмцээд яваарай! Алтайн сайн эрчүүд алдартай боловч, аян замдаа гурван хоног төөрөх эргүү хар мананг, ахуй нутгийн чинь шидтэнгүүд аргагүй л татууллаа...” гэж хэлсэнд би нум сум ч агсаад буу чум ч үүрээд гарлаа.

Татанхай хөх даага минь татаад тавьсан сум шиг шулуун явдаг юм байна. Ус гол, уул даваанд ер үл саатна. Явсаар сайхан үүлэн цэнхэр морь болон хувилчихлаа. Үүлэн цэнхэр морь болсноо хөрст ногоон дэлхий дээгүүр биш хөх мөнгөн тэнгэр өөд л хөвөн хөөрөн оддог юм байна. Өндөр тэнгэр өөд өгсүүр шатаар явах мэт явсаар байтал өнгийн сайхан солонго татсан үүлэн дунд ороод иржээ. Тэр үүлэн дотор уул ч байна, ой мод ч байна, нуур нуга, шувуу жигүүртэн цөм байна. Гэтэл газрын хаанаас эгшиглэн хангинах нь үл мэдэгдэн гагцхүү сэтгэл баясан зүрх уяраасан өнгийн сайхан хөгжим эгшиглээд тэрхүү хөгжмийн эгшгэнд эргэн тойрны бүх байгаль ертөнц тэр аяараа дуулан бүжин агснаа төдхөн шингэх дөхөж буй нарны туяанд толин цэнхэр нуурхан мэлтэлзээд тэр нуурын дунд алтан шаргал шагшуурга намс намс ганхаж байснаа бадамлянхуан цэцэг дэлбээгээ дэлгэх мэт алтан шаргал шагшуурга хэдэнтээ гадагш налахад дундаас нь олноос олон цасан цагаан хун шувууд хөвөн хөгжин гарч ирэхийг харвал хун шувуу бүрийн нуруун дээр лусын охид эрдэнийн дэвүүр дэлгэн энхрий хонгор дуугаар дуулан явах ажээ.

Ёстой л үзээгүй юмаа үзэж, үлгэрийн ертөнц гэгчид ингээд очдог юм байна. Цасан цагаан хун шувуудыг хөлөглөсөн цэцэг дундаас төрсөн юм шиг цэвэрхэн охид үүлэн цэнхэр морийг минь эргэн тойрон бүжин дуулахад толгой эргэж нүд эрээлжлэв. Охидын хувцас солонгын долоон өнгөтэй. Дэвүүрүүд эрдэнийн олон чулууны гэрэлтэй. Нуур нь толь шиг. Оройн наран, огторгуйн өнгө, хаанаас хангинаад байгаа нь мэдэгдэхгүй эгшиг хөгжим, охидын уянгын уярам дуу, тэр дуу хөгжмийнхөө дагуу яралзан мяралзаж, намилзан намирч байгаа энэ суу жавхлан нэг бодлын ерөөсөө байж боломгүй ч юм шиг санагдана. Нөгөө бодлын яагаад ч ийм сайхан юм энд байдаг байнаа гэж санагдана.

Нэг мэдсэн чинь өнөөх олон цасан цагаан хун шувуудыг хөлөглөсөн лусын охид заавал намайг хөх хөлгөөс минь толин цэнхэр нууран дунд буулгах гэж дайрцгаадаг юм байна. Хун шувууд хөх хөлөг рүү минь ойртох тутмаа өргөн цагаан далавчаа зэрэг зэрэг дэлгэн толин цэнхэр нуураа тас няс алгадаад, лусын охидын дуу ч гэсэн, их хачин өнгө аятай болсонд хөх хөлөг минь гэв гэнэтхэн нуураас тасран хөөрөх нь тэр.

Хөх хөлөг минь ёстой л жийхээрээ жийж гарлаа. Эргээд харсан чинь өнөөх олон цагаан хунгууд цагаан сум шиг амьтад болчихсон лусын дагинууд нь үлгэрийн баатрууд болчихсон

хөөж айсуй явдаг юм байна. Урагшаа тонгойж хөх хөлгийнхөө чихэнд хойноос нь хөөж айсуй амьтдын байдлыг хэлбэл “За чи намайг хавчихаараа хавч би ч сунахаараа сунана. Тэгж байтал учир нь олдох байгаа” гэж хөх хөлөг минь хүний хэлээр хэлдэг юм байна. Тэгээд л хөх хөлөг минь өндөр хөх тэнгэрээс өргөн ногоон дэлхий рүүгээ бууж байгаа аятай л тувт доошоо жирийгээд байх шиг л боллоо. Би ч тэртэй тэргүй юмны учир олохоо байсан хойно, ганцхан хөлгөөсөө л салахгүйг хичээн дэлээс нь зууран явлаа.

Явсаар байгаад нэг харсан чинь номин ногоон дэлхий минь, нутгийн сүрлэг уулс маань бололтой газар орон харагдаж эхэлснээ өндөр шовх оройд нь үүлэн сүрэг хурсан, өргөн цагаан цээжинд нь алтан наран ээсэн нэгэн сайхан цаст цагаан уул харагддаг юм байна. Тэр уулын барааг харангуут хөх хөлөг минь ч чангарав, хөөрхий би ч онгигов. Араас хөөгсөд дөхөөд байна, аюултай сум нь чихний хажуугаар часхийгээд, хацарт ойрхон халуу оргиод л өнгөрөөд байна. Цаст цагаан уул хариугүй ойртлоо. Уулсын мөнгөн цагаан цастай толигор энгэрт тулаад ирснээ “Одоо хаачих байнаа?” гэж бодтол тэрхүү толигор энгэр ямар нэгэн их хүчтэй анир чимээ гарган нижигнэж шижигнэн хага үсрэн ярагдаад хайрт ээжийн минь царай нүдэн өмнө гараад ирэв. Ээжийн минь царай өнөөх хүнд өвчтэй байхад нь миний ороход ямар байлаа, яг тэр янзаараа харагдаж байна. Тэгэхдээ хажууд нь түшсэн аав ч харагдахгүй ээж минь аахилж амьсгалах ч үгүй, харин ч нэг харахад намайг айсуй баярласан мэт, дахин харахад хүү минь хөөж яваанууддаа гүйцэгдэх ч юм уу, шуугин буй суманд нь оногдчих бий гэж байсан зовсон шинжтэй харагдана. “Хурдлаарай миний хүү, миний хүү, миний хайртай хүү” гэж ээжий даллан хашгирсаар наашаа гүйж явна. Би ч ээж ээ ээж ээ, ээж ээ хэмээн морьтойгоо ч юм шиг, явган ч юм шиг тосон гүйж байтал гэнэтхэн уул доргиож, ус цалгиасан сүртэй буун дуун тасхийхэд хөөрхий хөх хөлөг минь ганцхан муухай унгалдаад ойчлоо. Би ч ээжээ хэмээн орилоод сарвалзан ойчлоо. Цочин сэрлээ.

Сайхан зүүд минь халин оджээ. Хөх хөлөг ч алга, хөөсөн дайсан ч алга. Хөөрхий ээж минь бүр ч алга. Хөх хөлөгтэйгөө зугтаж явахад хөөсөн дайсны сум араас онох ёстой атал урдаас ч оноод байх шиг. Тэр мөртөө духан дээр онон, цус урсаад ч байх шиг санагдаад байсан юм. Тэгээд энэ бүхэн маань юу байваа? Духан дээр сум онож хүйтэн цус урсаад байна гэсэн нь бороо орох гэж ганц нэг ширхэг дусал бидний нүүрэн дээр дусаж эхэлсэн нь ажээ. Уул доргиож ус цалгиасан сүртэй буун дуу нь тэнгэрийн дуу байжээ. Үнэндээ газар тэнгэр нийлүүлсэн гал цахилгаан цахиж тэнгэрт гээг даран нижигнэж байв. Шаагин шуугиж айсуй салхитай бороог харвал амьтай голтой юм тэсэж тогтохын эрхгүй юм шиг санагдаж байв. Бид босож дээл хувцас, дэвсгэр хучлагаа чирээд гэр лүүгээ гүйлдэв. Айл гэрийн хүмүүс цув юүдэн болон аргал түлээ, мал хар руугаа гүйлдэв. Хэдхэн хормын хооронд салхи, зүсэрсэн ширүүн бороо, дуу цахилгаан бүгд нэг мөсөн шахам пижигнээд өнгөрөв. Энэ бүхнийг би төдий л тоосон ч үгүй, айсан ч үгүй. Бага балчир наснаасаа зун бүр л үзэж өнгөрүүлдэг зуршил болсон зүйл болоод л тэр байх даа. Би харин өнөөх сайхан зүүдэндээ гашуудаж хэвтэв. Тэр олон лусын охид, цасан цагаан хун, толин цэнхэр нуур, алтарсан шагшуурга, хорвоо ертөнцийг бүхэл бүтэнд нь уяраан хайлаасан дуу эгшиг ямар учиртай зүүдэнд орвоо?

Бодсоор байгаад туульч Бага ахын өнгөрсөн өвөл хайлсан нэгэн гайхамшигт туульд гардаг хэсэг, Гэцэлжав ахын хэлдэг хуур сурахаар дөрвөн замын бэлчирт суухад заримдаа ирдэг гэдэг тэнгэрийн дагина, лусын охидыг хольж хутгал зүүдэлсэн хэрэг байна гэж мэдэв. Үүлтэй тэнгэрийн доогуур, үзүүртэй модны дээгүүр нисээд байсан хөх хөлөг минь ямар

учиртай зүүдэнд ороо юм бэ? гэвэл Гэцэлжав ахын өгүүлдэг нэг үлгэрт гардаг эрдэнийн хөх халзан хөлөг ажээ. Хөх хөлөгтэйгөө зугтсаар ээждээ хүрэхийн даван дээр хөөж явсан дайсан хөх хөлгийг минь буудлаа гэсэн нь гал цахилгаан цахиж тэнгэр ниргэсэн хэрэг байжээ. Эцэст хайртай ээжий чинь яагаад зүүдэнд орсон бэ? гэвэл би нэг ахтайгаа цуг, гол руу тариа услахаар явах улсуудыг дагаж явъя. Тэгэхдээ ээжийгээ нутаглуулсан газар дээр очъё. Би тэр газрыг мэдэхгүй болохоор ах минь мэддэгээрээ надад зааж өгнө гэж хэлсэн юм. Ээжийнхээ газар дээр очно гэсэн нь яагаад ч юм бэ дээ, надад ээжтэйгээ уулзаж учрах юм шиг л сайхан санагдсанаас би ээжийгээ хүсэн хүссээр, эцэст зүүдээрээ хайрт ээжтэйгээ бас дахин нэг удаа халыг учирсан хэрэг байх нь ээ. Би ээжийнхээ гэгээн дүр төрхийг тун бүдэг бадаг мэдэх атал энэ удаа яагаад ийнхүү зүүдэнд ээжийн минь царай зүс тийм содон сайхан харагдсан бэ? гэвэл би сүүлийн үед яагаад ч юм бэ, ээжийгээ нэг л их санаад байх болсноос ийм явдал болсон бололтой.

Зуны хүмүүс гэдэг нойрондоо мөн ч харам юм даа. Тэнгэрийн дуу, цахилгаан, түр зуурын ширүүн борооноос “Түргэн жагсаал” авсан хүмүүс төдхөн ор орондоо хурхираад дугжраад өгөхөд гагцхүү миний нойр ер хүрэхгүй, юу ч бодохгүй унтах гэхэд л хөөрхий ээжийн минь дүр төрх нүдэнд үзэгдэж сэтгэлд урган босож ирээд ер болж өгдөггүй. Маргааш бушуу болоосой, ахтайгаа бушуухан очиж ээжтэйгээ уулзах юм шиг санагдаад тун ч болдоггүй. Амьдралдаа анх удаа ээжийгээ нэг л их санаж, мөн анх удаа нойтон дэртэй хоносон минь тэр шөнө байж билээ. Ээ дээ, энэ дэлхий дээр хүн, юу ч үгүй байж болох боловч ээжгүй байх гэдэг яагаад ч юм бэ ер байж боломгүй зүйл шиг санагдаад тун ч болдоггүй шүү.

Маргааш нь ах бид хоёр гол орж тариа услах хүмүүс дагаад явлаа. “Могой цохиход модны нэмэргүй” гэгчээр очиж очиж тариа услах хүмүүс дагаж энэ хар халуунд үүний явдаг хэрэг нь юу вэ? Очоод бидэнд юугаараа нэмэр болох хүн бэ? энэ бид хоёр ямар элэнцгийнхээ нэмэр болоо билээ. Нэрмээс л болно... Наран харанхуйлтал язганасан хар шумуулд соруулах гэж бөгс нь умалзаа биз гэж тариа услахаар явж буй хүмүүс, замд, надаар зугаа хийж, дамшиглаж явлаа.

Ах минь намайг дагуулж гарсан цаад санаагаа хүмүүст хэлсэнгүй. Харин “Та нар муу дүүгээр минь битгий тоглоом тохуу хий. Та нар уулын оройд унаа морьдоо орхиод, шөнө тариа услахаар явахад дүү бид хоёр л утаа май тавьж унаа морьдоо ялаа шумуулаас хамгаална. Өдөр та нар унтаж амарна. Бид хоёр аргал түүнэ цай чанана хоол хийнэ. Шөнө тавьдгаас бүр ч их утаа май тавина. Бид хоёрын тусыг та нар тэгж юман чинээн бодохгүй байж болохгүй даг шүү...” гэж ах хэлэв.

Тэр өдрийнхөө орой бид Цагаан тунгийн голын наад талын нэгэн намхан уулын орой дээр ирлээ. Ховд гол, Цагаан тунгийн нутаг ёстой л хар ногоорон харагдаж байна. Цагаан түнгэ гэдэг намар, өвөл, хавар цагийн бидний эх орон, яг одоо гэвэл тариа чацарганы эх орон маань тэр аяараа л хөөрхий ээжийн минь дүр төрх шиг харагдахад нүд дүүрэн нулимс бүрхээд ирдэг юм байна. Уулын оройд голын хорт шумуулын зах сэжүүр бас байна. Гэхдээ арай ч унасан морьдыг маань бариад идчихээр биш байлаа.

Бид яаран утаа май тавилаа. Наран шингэх үед хээрийн цай уулаа. Дараа нь жаахан шар будаатай хоол хийж идлээ. Хүмүүс дөнгөж нүдээ ил гарган толгой тархиа зузаан алчуураар боогоод хүрзээ бариад гол руу орлоо. Ах бид хоёр бас нэг хүнтэй гурвуулаа утаа май тавьж

ёстой л ойр зуурын шал дэмий юм хөөрөн суулаа. Шөнө орой болсон хойно салхи үлээв. Салхины үлээлтээр шумуулын хал татрав. Бид ч утаа май уугиулах ажлаас түр суларч тэрүүхэнд байдаг шанд руу явж ус авч ирэв. Тариа услахаар явагсаддаа цай чанаж тавив. Морьдоо бөхлөөд хэвтэв. “Ээжий дээрээ хэзээ очих вэ” гэж ахаас сэмхэн асуувал “Ээжийгээ нутаглуулсан газар дээр гээч миний дүү...” гэх ах залруулан өгүүлснээ “Маргааш хоёулаа мориор очно. Саяын ус авч ирдгээс жаахан цаашаа яваад л хүрчихнэ” гэлээ. Би бас жаахан хэвтсэнээ “ах аа ээжий дээрээ очоод ирвэл болохгүй юу?” гэвэл “Одоо юу ч мэдэгдэхгүй. Бушуухан унт миний дүү...” гэлээ. Дахиад би ахдаа юм хэлсэнгүй. Тэгээд энэ эзгүй хээрт ээжийг минь нутаглуулаад орхичихсон гэдэг ер байж боломгүй юм шиг санагдаад унтаж чадахгүй хэвтээд л байв. Элдэв юм бодон, шөнийн болжморын жиргээ, ууль шувууны гуугачаа, голд төөрч хоцроод ялаа шумуулд үйлээ үзэж яваа нохойн улих тэргүүтнийг чагнан хэвтсээр л байв.

Маргааш болов. Тариа услахаар явсан хүмүүс үүрээр голоос гарч иржээ. Тэдний цөмийн нүүр нүд булуу болтлоо хавдаж тархи толгой нь хэвийнхээсээ том болчихсон юм шиг харагдаж байв. Тэд хорт шумуулд хазуулж хавдсан нүүр нүдэндээ гэрээсээ авч гарсан айргийн өнгөр, шимийн архины охь түрхэнэ. Морьдын маань ч нүд, омруу цээж, цавь, салтаа тэргүүтэн нь хавдах шинж орж зарим газраар нь цус шүүс нэвчин харагдана.

Өдөр ах намайг дагуулан усанд явав. Ус авдаг дэрстэй шанд маань аймшигтай шумуултай байсан учир хоёулаа хэдэн ширэн хөхүүрт усаа хам хум дүүргэж аваад шандын баруун хойт намхан хадан мөрөг дээр гарч урт уужим амьсгаа авав. Гэвч тэнд шумуул бас л байв. Үдийн наран яг сайхан голлож тусдаг хоёр мөргийн хоорондох жалгархуу атлаа өтөг хондтой газар намайг ах дагуулан ирэв. “Муу ээжийг маань нутаглуулсан газар энэ дээ” гэж ах өгүүлэв.

Хоёулаа мориноосоо буув. Хэлэх ч юм олдсонгүй, асуух ч юм санаанд орсонгүй. Нэгэн дөв дөрвөлжин хөх чулуу харагдана. “Яг л энд юм даа...” гээд ах тэр чулуун дээр шилтэй сүүнээсээ дусаагаад тэгээд өтөг хонд дээгүүр цацав. Бас тэр чулуун дээр хонхортой жижиг чулуу олж тавин аргал түлж цог гаргаад арц унгасгав. Мөсөн чихрийн халтар хэлтэрхий бор хиртэй алчуурт нандигнан ороосноо гаргаж тавив. Ааруул хуруудны жоохон хэсэг тавив. “За ингээд ээжийгээ эргэчихэж байгаа юм шүү дээ. Ээж нь миний хоёр хүү овоо л доо гэж бодно шүү дээ. Миний дүү энэ газрыг сайн харж мэдэж ав. Хааяа ингээд ирчих сайхан байдаг юм шүү дээ. Одоо хоёулаа явья. Морьд маань сүйд болох нь...” гэлээ. Хэлэх ч юм олдсонгүй, яах ч учраа мэдэхгүй, дэмий л тэр газар байгаад баймаар санагдав. Ингээд л байгаад байвал эжий минь ахиад саяхны зүүдэнд үзэгддэг шиг нүдэнд нэг харагдах ч бол уу л гэж би горьдсон юм. Гэвч миний горь огтын гэнэн гэгэлгэр горь байжээ. Хичнээн суувч ээж үзэгдэхгүй нь үнэн учир арга буюу ахыгаа даган мордов. Энэхүү хоёр дахь өдөр, тариа услахаар ирсэн хүмүүс дотор над шиг тийм уруу дорой царайтай, ялаа шумуулд ч үхлээ хазуулж, хаван хавдар болж эхэлсэн хүн бараг алга болов. Ээжтэйгээ уулзах юм шиг бодож ирчихээд ийнхүү гол горойсон учир ялаа шумуулд идүүлэхийг даанч юман чинээнд бодсонгүй санжээ.

Орой тийшээ ах маань бас урвайсан харагдана. Бодвол намайг хараад сэтгэл нь өвдөж эхлэв бололтой. Ах бас миний тухай тариа усалж яваа хүмүүст хэлсэн бололтой. Тэд намайг аргадаж, аль зөв үг хэлж, зөөлөн сэтгэлээр хандаж идэж уу, энэ тэр гээд л сүйд...

Энэ орой бидний араас Гэцэлжав ах зэрэг хэдэн хүн хүрч ирэв. Тэд бас тариа услах гэнэ.

Гэцэлжав ахын ирсэн нь миний сэтгэлийг сэргээв. Гэцэлжав ахын оронд ах маань шөнө тарианы ус тавилцахаар явлаа. Би Гэцэлжав ахын дэргэд хэвтээд саяхан зүүдэлсэн зүүдээ хольж хутган өгүүлсэнд, миний ярихыг их л таашаан сонсож хэвтэв. Бодвол тариа услахаар явсан хүмүүс, миний сэтгэлийг сэргээсэн сайхан юм ярьж өгөхийг Гэцэлжав ахад “даалгасан” бололтой.

Миний хэлэх юм дууслаа. Би тэгээд уртаар санаа алдав. Ээжийг яг нутаглуулсан газар бидний байгаа бяцхан уулын оройгоос арай харагдахгүй боловч намхан хадан мөрөг нь гэрэл гэгээтэй бол харагдах тул одоо ингээд санаа алдаад хэвтэж байхдаа би тэр зүг харанхуй ч гэсэн харж л байв. “Миний дүүгийн зүүд их бэлэгтэй сонин сайхан зүүд байна. Чи одоо танхимд сууж ном үзэж байгаа... Ирэх намар дахиад сууна. Чи яваандаа эрдэм номын хүн болох биз. Эрдэм номтой хүн үүнээс хойш энэ улс олонд их хэрэгтэй, их ч хүндтэй хүн болох биз. Эрдэм номтой хүнд хүрэхгүй ч газаргүй үзэхгүй ч юмгүй, унахгүй ч хөлөг морь гэж байхгүй болох биз...” гээд үгээ их л зөөлөн зөөж, сайхан өнгөтэй ярьж байлаа.

...Унахгүй ч хөлөг морь гэж байхгүй болох бизээ гэсэн тэр нэгэн үг нь “Гэцэлжав ахаа, таны надад хуурдаж өгдөг морины явдал ямар учиртай юм бэ?” гэж асуух бодол төрүүллээ. Энэ морины явдлын учрыг мэдэхсэн гэж би дандаа бодох болсон юм. Гэтэл асуух гэхээр нэг ч олигтой аян шалтаг гарч өгдөггүй байв. Заримдаа бас “За за ийм жаахан эрхийн чинээн нусгай хүүхэд ах зах хүнээсээ тийм юм асууж болдоггүй юм” гэх болов уу гэж санагддаг байв. Сүүлийн үед Гэцэлжав ах манайхаар ирэхээ больсон юм. Одоо ингээд тариа услах ажлын үед тааралдсанд миний баярласныг яана. Би бас эрхбиш эрдэм номын захад хүрсэн болохоор хүнээс юм асууж болох байх гэж заримдаа санагдаад байх болсон юм. Би бодсоор тэсэхгүй тэрхүү мориныхоо тухай ярьж өгөхгүй юу гээд гуйчихав. Ингэж гуйчихсан хойноо бас, арай болохгүй бүтэхгүй юм асуучихсан юм биш байгаа гэж хулмалзтал Гэцэлжав ах “Харин ах нь чамд тэр мориныхоо тухай яг ярьж өгөх гэж байлаа шүү дээ” гэдэг юм байна. Ингэж хэлэхээр нь би ёстой магнай хагартлаа баярлав. Хоёулаа явж аргамжаатай морьдынхоо дөрөв биш найман талд нь тавьсан утаа майгаа сэргээлээ. Гал дээрээ буцаж ирлээ. Зөөгширсөн хар цайнаас уулаа. “Ах нь үлгэрээ ярьж өгөөд цай чанав. Би унтана шүү дээ” гэлээ.

“...Урьд манай Алтайд Жанибек гэж өнчин ядуу нэг хүүхэд байжээ. Тэр хүү ядуу хоосон ч гэлээ ухаантай, их зориг зүрхтэй хүү байж гэнээ...” гээд Гэцэлжав ах яриагаа эхлэв. Ер нь энэ хүүгийн тухай түүх сударт ч их бичсэн бололтой байдаг юм билээ. Ард олны дунд түгсэн яриа ч их байдаг юм. Түүнээс би чамд хоёр л юм ярьж өгье дөө. Нэгд хүүгийн зоригтойн тухай, хоёрт, тэр хүүгийн хайртай нэгэн морины тухай гэлээ.

“...За тэгээд Жанибек хүү чам шиг бага байхдаа нэгэн намар цаг, анчид дагаж гахайн гөрөөнд явж гэнэ. Анчид гөрөөлөх газраа хүрээд халууцаж, цөм хувцас хунараа тайлаад энд тэнд шалдан цээж гарган, их өвсөн дунд хэвтэцгээж гэнэ. Нэг харсан чинь Жанибекийн хөлийн ул өөд өгсөн хуруун дээгүүр нь нэгэн могойн толгой өндийн даваад хөл өөд нь гонжийгоод л өгсөж байхыг хүмүүс харжээ. Их ч том, мөн урт гэдэг нь ч аймаар эрээн могой ажээ. Айж сандарсан хүмүүс яаж ч чадахгүй дэмий л бүлх залгичихсан юм шиг гөлийлдөн байтал нөгөө могой Жанибекийн нүцгэн цээж өөд л өгсөж харагдаж гэнэ. Жанибек биен дээгүүрээ могой хүйт оргилуун өгсөж явааг мэдсэн боловч огтхон ч чацав татав гэлгүй, тайван гэгч нь амаа ангайчхаад л хэвтээд байх юм гэнэ. Айсан хүмүүс гайхаад л байж. Жанибек амаа ангайчхаад

л хэвтгээд байж. Могой өгссөөр хоолойнд нь хүрчээ. Цаашаа эрүү өөд нь өгсөөд Жанибекийн ангайсан ам руу гулсан ортол нь Жанибек ганц хавхийсэн чинь могойн толгойг тас хазан нулимчихаад босоод ирсэнд айхын эрхэнд анир чимээгүй атиралдан хэвтсэн хүмүүс, цөм санаа амарсан янзтай аль л сайн сайхан үгээ хэлэн босоод ирж гэнэ. Эр хүн зоригтой бол чоно яана гэдэг билээ? Миний дүү тийм үг мэдэх ч үгүй биз ээ. Эр хүн зоригтой явах гэдэг энэ Жанибек хүү шиг явахыг л хэлнэ шүү дээ гэлээ. Гэцэлжав ах энэ домгийг ярихдаа, яг л одоо өөр өөд нь өгсөн ирсэн могойн толгойг тас хазаж байгаа юм шиг ярьсан болохоор би ч бүр жигтэйхэн айж хар хөлс минь чийхарчихсан байлаа. Ингээд Гэцэлжав ах яриагаа завсарлаж утаа майгаа засав. “Энэ хүү мөн ч зоригтойёо доо?” гэхэд нь би “Ёстой аймаар байна” гэв. Гэцэлжав ах дахин ирж, миний хажууд хэвтэв. Жанибек хүү мөн чам шиг байхдаа нэгэн баян хүнээс морь гуйжээ. Тэр баян “Мянган адуу цаана чинь бэлчиж байна. Морины сайн мууг мэддэг л бол шилж байгаад нэгийг нь барьж ав” гэжээ. Жанибек их адуун дотор ороод энэ ч унага даага, тэр ч агт морийг хараад шинжээд яваад л байж гэнэ. За бараг баяны мянган адууны эр хүйстэй бүгдийн шандас шөрмөсийг барьж үзэх шиг болж гэнэ. Тийнхүү явж явж, шар үсэндээ хатсан нэг муу хөх даагыг хөтлөн ирээд “Үүнийг чинь авъя” гэж гэнэ. Тэгэхэд нь баян, “За яах вэ, юу сайхан бэ, дур сайхан, ав ав. Чи нэг бол наадахаа сайн морь болохыг нь мэдээд авсан байх. Үгүй бол шал усан тэнэгтээ авч байгаа хэрэг байх” гэж өгүүлжээ. Жанибек усан тэнэг хүү байсангүй. Хөх даага өссөөр үнэхээр гайхамшигтай сайхан морь болжээ. Олон удаагийн дайн тулалдаанд Жанибек хөх морио унан орж гэнэ. Орох бүрд дайснаа дарж, дархан цолоо мандуулж явжээ. Жанибек сайхан хөх морьтойгоо цуг өсөж Алтай даяар алдар цуутай эр болж гэнэ. Сүүлд хөх морь өгсөн хөгшин баяны орь ганц охинд хайр сэтгэлтэй болж гэнэ. Баян, ядуу хүнд яалаа гэж арилгасан сонгино шиг цэвэрхэн ганц охиноо өгөх билээ. Тэгэхээр баян охиныг босгуулж авахаар шийджээ. Хугацаа болзоо тогтоож хурдан хөх морио уяж сойж байгаад нэгэн шөнө, хонгор бүсгүйгээ аваад зугтсан чинь баяныхан мэдэж, нэхэн хөөгөөд хурдан хөх морийг нь буудан алж охиноо салган авчээ. Жанибек өөрөө Алтайн ууланд амь тэмцэн гарчээ. Жанибек удалгүй хурдан хөх мориныхоо толгойг хулгайгаар авч Алтайн нэгэн уулын оройд залж гэнэ. Ийн хөх морийг буудсан хүн бол баяны ганц охиныг олон зуун гүүгээр худалдаж авахаар хэлэлцэж тогтсон бас нэг баяны омог дээрэнгүй хүү байсан юм байжээ. Баяны охин тэрхүү омог бардам эрд богтлогдон одсон боловч төдхөн амиа хорлож хорвоогоос хальсан юм гэнэ.

Харин Жанибек хүүгийн амьдрал яаж төгссөнийг нэг ч хүн мэддэггүй юм .Ихэнх хүмүүс тэр хүүг үхдэггүй мөнх хорин таван настай рашааныг Алтайгаас олж хүртсэн учраас одоо ч бий гэдэг юм .Ард олны тэгж ярьсан юм худлаа байдаггүй юм . Жанибек ард олныхоо дотор яваа бий ...» гэж өгүүллээ . «Тэгвэл таны хууранд дардаг тэр морины явдал Жанибекийн хөх морины тухай юм уу?» гэж асуусанд «Тийм ээ ,тэгэхдээ Жанибекийн хөх морины тухай гэдэггүй, «Алтайн хөх дөнөн ...» гэж нэрлэдэг юм гэж Гэцэлжав ах өгүүллээ.«Алтайн хөх дөнөн ...» ямар сайхан нэр вэ! Тэр орой тэр нэрийг би аман дотроо лав зуу дахин өгүүлсэн байх .Мартчих байх гэхдээ юу ,хайр хүрсэндээ юу ,юу ч болтугай дахин дахин «Алтайн хөх дөнөн » гэж өгүүлэхүй бүрд тэр нэр миний хайрыг улмаар булаав . Гэцэлжав ах тарианы ус тавиад ирэх хүмүүст цай чанах ажилдаа оров . Алтайн хөх дөнөнгийн ,хорон санаантанд алагдсан байдал ,миний зүүдэнд орсон үүлэн хөх морьтой адилаар барахгүй , хоёулангийнх нь хувь заяа буудуулж үхэж төгсдөг нь бүр ч адил байхаар нь би тэрхүү зүүдийнхээ тухай Гэцэлжав ахад дахин өгүүлсэнд:

«Миний дүү бэлэгтэй сайхан зүүд зүүдэлжээ » гэж би түрүүн хэлсэн шүү дээ. Тэгэхээр миний дүү том болохоор Алтайн хөх дөнөн шиг

САМБУУГИЙН БАДРАА

Зохиолч С. Бадраа 1923 онд Булган аймгийн нутагт малчны гэрт төржээ.

1950 оноос уран бүтээлээ эхэлж «Амьдрал», «Нисгэгч», « Хөрст алтан дэлхий» зэрэг өгүүллэг, туужийн ном бичжээ.

Мөн Горький, Фурманов, Шолохов, Айтматов зэрэг зөвлөлт зохиолчдын олон шилдэг бүтээлийг орчуулжээ.

ШОНХРЫН МАГТААЛ

Би Намсрайтай уулзав . Энэ хүн бол нисэх онгоцны газар он удсан хашир догь нисэгч юм.

Би түүнийг нэлээн дээр үеэс таних болно . Энэ хүн идэр залуудаа нарийхан гулжгар биетэй атал цул шандас шөрмөсөөр бүрдсэн мэт жавхалзсан чийрэг залуу байв. Харин одоо насжиж таргалаад эв хавгүй бүдүүн эр болсон мэт санагдана . Дөчин хэдэн оны үед байлдааны сөнөөгч онгоцыг онц чадамгай эзэмшсэн хүн гэж ихэд нэрд гарч байсныг би мэдэх юм . Хожим иргэний агаарын тээвэр бий болсноос хойш анхандаа «Царцаа ногоон » дараа « ИЛ 14 » онгоц барьж монгол нутгийнхаа ямагт мишилзэн байдаг хөх огторгуйгаар хөндлөн гулд хичнээн ч нисэв дээ,бүү мэд !

Зан байдал гэвэл үргэлж инээмсэглэн явдаг сайхан зантай хүн атал инээхээс цаашгүй дуу цөөтэй , бүрэг ичимтгий юм шиг хачин залуу билээ . Хүнтэй төдийлөн үг ярих нь үгүй . Нөхөд нь бөөгнөж олон таван үг дэлгэвэл манай хүн бусдаас дайжиж онцгойхон суугаад ямар нэг юм бичиж тэмдэглэн байна . Түүнийгээ өөр бусдад үзүүлэх нь үгүй . Энэ байдлыг олонтаа харсан нөхөд нь « Мань эр хэлээ хөштөл дуугай сууж уйдагдаа янаг амрагийн нялуун үгт захиа юмуу , шүлэг бичиж суудаг биз » гэж тааварлан ярилцдаг билээ . Энэ бол өнийн хэрэг. Түүнээс хойш бид олон жил уулзсангүй . Хааяа уулзавч « Сайн байна уу ? »

Сайн Сонин юу байна ? юмгүй » гэхчлэн хэдэн хуурай үг зөрүүлэхээс цаашгүй байв .

Гэтэл сая би Намсрайтай уулзав . Уулзахаар барахгүй , гэрт нь « уригдаж » очив . Яагаад очих болсон бэ ? гэвэл би түүнтэй уулзаад :

-Нисэхийн 50 жилийн ойд нэг бяцхан өгүүллэг бичих гэсэн юмсан . Чи нисэхэд олон жил болсон хүн . Надад өөрийн буюу өрөөл бусдын амьдралаас ямар нэг сонин явдал түүх ярьж өгөхгүй юу? гэж би гуйсан юм . Миний гуйсны учир бол нэгд Намсрай дөчин хэдэн оноос хойш нисэхээс огт ховхроогүй тул тэндхийн аж байдлыг сайн мэдэхийн дээр хоёрт хүний зан төрх үргэлж нэг янзаар байхгүй, ондоо болж хувирдаг ёсон бий болохоор энэ хүн насжаад яриа хөөрөөтэй ч болсон байж юуны магад гэж горьдсоных юм . Намсрай идэр залуугийнх шигээ яралзтал инээмсэглэж :

- Намайг дуу цөөтэй хүн гэж чи мэднэ . Би юугаа ярих вэ ? Гэвч чи манайд оч л доо . Хэрэг байна гэв .

« Юун хэрэг байх билээ ? Миний горьдлого , бодвол хоосон өнгөрөхгүй нь болов уу » гэж би дотроо баярлав ...

Намсрай нисэгчийнх хотын нэгэн шинэ микрорайонд гурван тасалгаатай том саруул байранд суудаг юм байна . Гэрийн дотор тавьц юмс цөм шинэ, үнэтэй эд хогшил дүүрэн их сайхан айл байв .

« Энэ хүн монголын хөх мөнгөн тэнгэрт хэдэн мянган цаг нисч хэдэн сая километр урт агаарын чухал тээвэр хийсэн хүн , олз омогтой ч байлгүй яахав , энэ зэрэгтэй ч суулгүй ч яахав » гэж би дотроо өмөгшин суув .

Учрыг мэдвэл тэр маань намайг гэртээ урьж юм ярих гэсэн биш , харин юм үзүүлэх гэсэн байлаа . Бага шиг хүрэн шүүгээг түлхүүрээр нээж дотроос гурван зузаан дэвтэр гаргаж ирээд :

- Энэ миний тэмдэглэл . Гучин жилийн тэмдэглэл дээ ! Дөчин таван оноос хойш зав гарсан цагтаа өөрийн тухай , чиний хэлснээр өрөөл бусдад тохиолдсон сонин явдлыг тэмдэглэн бичсээр байтал өдий болов . Үүнийг ном болгож болдог юм уу ? гэж чамаас асуух гэсэн юм гэв.

-Уухай! Мань эр Жуков жанжин шиг том зузаан дурсгал бичиг гаргах нь уу ? Мөн дөө! гэж би санамсаргүй хэлжээ . Намсрай ихэд ичингүйрэн царайгаа улайлгаад ,

- Тэгсэн ч юмгүй ... гэж бүдэг тасархай дуу гарав . Би ч санаа зовчлоо ... Үүнийг үл үгүүлэн өгүүлэх нь :

Би Намсрай нисэгчийн «Өдрийн тэмдэглэлийг » үзэв. Бүгд гурван зузаан дэвтэр байв . Эхний хоёр нь гадаад байдлаараа үзэмжгүй , ердөө шугамгүй парвагар цаас дамбийтал үджээ . Харин гурав дахь нь « Международная книга » гэсэн онц гоёмсог зузаан дэвтэр байв . Дэвтэр бүрийн хавтсан дээр уран тууз зураад « Өдрийн тэмдэглэл » гэж дармалджээ. Уг дэвтрийн хуудсыг санамсаргүй эргүүлж үзээд би ихэд гайхав . Осолгүй гараар бичсэн атал ердөө л нэг хэвлэмэл ном! Мөр бүрийн адгийг жигд тасалж , дөрвөн захад нь ив ижил цагаан зах үлджээ . Хуучин монголоор бичсэн нь гаргацтайгий нь яана ! Би эхний хуудсыг сөхөж :

« ...Аргын нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн он. Арван хоёр сарын гучин нэгэн . Бөмбөрцөг даяар олны сэтгэл түгшүүлсэн дөчин дөрвөн оны эцэс болж , эергэн жил дуусах орой би цэргийн нисэх анги дээр байвай . Энэ үеэс хүн бүрд нижгээд нас нэмэгдэж, ертөнц дахины амьдралыг тус бүр нэгэн шат дэвшин харах баясгалангийн сайхан бүхэн эхлэх гэж байхад юм бүхэн хэвээр үлдсэн юм шиг санагдана . Энэ нутагт урьд хоёр жил нутагласны хувьд сайн мэдэх болсон « Доод хадан хошуу » хэмээх Туул голын ариун урсгалыг баруун хойш нугалсан эгц хадан ирмэгийн чанадад оройн наран жаргаж , түүнийг дагалдан , ганц нэг од түгж эхлэхэд үдшийн жавар хацар шүүрэм салхилж байв . Тавхан цагийн дараа төгсгөл нь болох энэ жилийг би чөлөөт амьдралын дэлгэр хүрээнд бүрэн багтаж өнгөрөсөн явдал бол надад дуусгаваргүй сэтгэгдэл үлдээв .

Үүнээс өмнө өдрийн тэмдэглэл хэмээн бичсэн зүйлгүй учраас сүүлийн үед болж өнгөрсөн явдлыг цухас дурдвал :

Үүнээс хоёрхон жилийн өмнө Булган аймгийн шинэ цэргүүдийг дайчлах цугларалтын газар очсоноо санана . Энэ өдрийг би өөрийн амьдралын гадаад хүрээг бүрмөсөн өөрчилсөн өдөр гэж үзэх ёстой юм . Тэр цаг тун саяхан мэт санагдана . Гэвч энэ саяхан мэт санагдах удаан хугацааны дотор нэлээд явдал болж , ихэд юм үзэх хол ойр сууж бусад улсад ч очиж үзэв. Тэр цагаас эхлэн эдүгээ хүртэл хугацаанд болж өнгөрсөн явдлуудын төлөв нь цэргийн байдалтай бөгөөд хоосон ба зугаат амьдрал холилдсон байв .

Би дөчин хоёр оны зун цэргийн албанаа татагдаж , Улаанбаатар хотноо хүрэлцэн ирээд нисэх ангид цэргээр очиж , улмаар Зөвлөлт Холбоот Улсад одоо , нисэх онгоцны мэргэжлийн дунд

дарга нарыг бэлтгэх сургуульд өөрийн сайн дураар явав .

Хүн төрөлхтний тайван байдал арилж, дайн байлдааны хүнд шуурганд дайрагдсан энэ үед Зөвлөлт улсын Воронеж мужийн харьяа Борисглебск хэмээх хотноо өөрийн ирээдүйн хувь заяа лугаа гүнээ уялдсан цэргийн эрдэмд суралцаж, агаарын онгоц жолоодох сургууль үйлдвэй. Хүчирхэг орны хана болсон улаан армийн цохилт дайсны хар сүнсийг хайргүй тонилгож байсан дөчин хэдэн онуудыг санахад аймшигтай боловч их гүрний нүсэр ажиллагаа жигдэрч фронтын ар талд тайван цагийн хөгжилт байдал хэвээр үргэлжилж байсан явдал бол аварга хөгжилт нийгэм журмын орны хүчирхэг байдал ямар болохыг чухам мэдэж болно . Ялагч гүрний армийн журмаар хоёр жил хүмүүжсэн бидний монгол нисэгчид дөчин дөрвөн оны адгаар өөрийн орон нутагтаа хүрэлцэн ирэв. Шинэ үеийн хамгийн боловсон техник болох агаарын хөлгийг хөх огторгуйд дураар эргэлдүүлэх чадварыг олсон миний бие хувьсгалт цэргийн дунд тушаалын дарга болж , дэслэгч цол хүртвэй. Ийнхүү цэргийн хүний зугаат амьдралд дасаж ядан, эх орныг хамгаалах үүргээ дутагдалгүй гүйцэтгэн явсаар энэ шинэ жилтэй золгодог байжээ ...» гэж унштал миний дотор нэг жигтэй итгэл бадрав. Цаашид уншсаар байтал уг тэмдэглэлийн дэвтэр миний хамаг сонирхлыг соронзон төмөр адил өөрийн эрхгүй татав . Унших тусам улам амт шимт орно. Заримдаа би хэн нэгний өдрийн тэмдэглэлийг уншиж байгаа биш ямар нэг уран зохиол уншиж байсан шиг санагдав. Гурван дэвтрийг дуусан дуустал уншжээ . Миний ингэж шүлтэн уншсаны учир бол энэхүү нисэгчийн тэмдэглэлийн дэвтрийн дотроос нэг гоц сонин зүйл олж уншигч та нартаа хүргэх гэж улайрсных юм. Гэтэл мянган хонин дотроос алж идэх хонь эс олддог гэдэг үнэн байна . Тэрхүү өдрийн тэмдэглэл дотор бичигдсэн бүхэн сайхан санагдаж байв. Сүүлдээ алийг шилэхээ мэдэхийг болив. Уншиж уншиж хамгийн сонирхолтой бөгөөд сайшаалтай санагдсан нэг бяцхан үйл явдлыг шилж авснаа уншигч та нартаа толилуулья .

Тэр хэсэгт бичсэн нь : « 1945 оны 7 дугаар сарын 28 Одоо бид гурвуул сууж байна . Нэг маань манай хэсгийн дарга, нөгөө нь ахлах нисгэгч , би бол бага нисгэгч болно. Бид гурав нийлээд нэг эскадрилийн хэсэг болох бөгөөд энэ өдөр Улаанбаатар хотыг агаараас сэргийлэн хамгаалах байлдааны тушаал аваад жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа. Бид онгоцонд суухдаа сандайлдаг шүхрээ биеэс тайлж дэргэдээ тавиад нэгнийхээ онгоцны хажууд сууцгааж байв .

Өглөө хэдий эрт боловч дорноос ургасан улаан наран хөөрөх тусам илч чангарч жигтэй халуун өдөр болох шинж илэрнэ . Тийм өдөр, цагийг нөхцөөх гэдэг хэцүү! Бид хэдий ээлжээр боловч ингэж жижүүрлэн суусан тул ярих юмаа баржээ . Надад бол үнэндээ ярьж гэвэл үг олохгүй болсон байлаа. Байлдааны шинэ онгоцоор сургууль хийх гэж Өндөрхаан явсан нөхдөө бараг нэр дараалан ярилцаж үгээ барж залхуу хүрээд хэсэг дуугуй сууж байтал манай хэсгийн дарга болох жигтэй том гэдэстэй бөөрөнхий гуятай, ахмад цолтой навтгар нуруутай буриад хүн :

- Чус ! Бүтэн сайн өдөр ямар чөтгөр ирэв гэж ! Би жаахан амрах минь! Намайг дуудаарай гээд онгоцныхоо далавчин доогуур багтан ядан шургав. Хэсгийн дарга ахмад Очирбат бол их гудиггүй эр болохыг бид мэднэ. Миний адил дуу цөөтэй авч нэг дуугарвал их өмхий гашуун үг хэлдгээс ондоо илүү зангүй шударга хүн амуй . Бас биднийг бодвол байлдаан гэж юу байдгийг биеэр үзсэн догь эр .

- Байлдах айхтар уу ? гэхэд

- Гайгүй дээ . Ер нь ирээгүй байгаа аюул , бэрх хоёрыг урьдаас таах хэрэггүй . Гагцхүү ирсэн цагт нь шалдан хүүхэн юм уу гахайн торой шиг хоосон чарлалдахгүй эр хүн шиг байх ёстой гэж бидэнд ямагт сурган ярьдаг нь дэмий үг бус гэж би боддог билээ .

Харин манай хэсгийн ахлах нисэгч Дорж бол тийм биш, их яриа наргиа залуу юм . Тэр бол хүн инээлгэхийг бодохоос цаашгүй хөнгөн хүн билээ . Гэвч би энэ цэргийн даргын хувцастай, гурван настай хүүхдийн ааштай гоолиг залуутай нэг хэсэгт багтсандаа баясан явдгийн учир нь Дорж бол хэзээ нэгэн цагт хүнд тус болж чадах хүн гэж миний итгэн явдгийнх юм . Бид хоёр үлдээд шатар тавьж нэлээд суусны сүүлд энгүүн ярилцсаар байтал Дорж улайсан нүүрний хөлсийг арчаад

- Дайн байлдаан гэдэг утгагүй юм. Ер нь юунд байлддаг вэ ? Залуу хүүхнүүдийн хөлийг тайрах гэж үү? Шал балай юм гэж гэнэт яриад , тоос татсан халуун тэнгэр өөд ширтэж ,

-Чи хойно байхдаа харсан биз дээ ? Хичнээн сайхан залуу , ёстой цэцэг шиг хүүхнүүд хоёр хөлгүй болсон байгаа биз дээ ? Хөөрхий зайлуул ! гэж амандаа гаслав .

Үргэлж цог шиг гэрэлтэн явдаг энэ залуу наргиа хүний амнаас тийм өрөвдөнгүй дуу гарахад би ч өрөвдөж байв. «Энүүний маань санаанд гэнэт яагаад мина оров ? Яагаад заавал хүүхнүүд гэж ярив? Газар булсан мина дэлбэрэх болбол хүүхэн эргүй сүйтгэнэ .Ер нь дайны зэвсэг бүхэн муухай! » Би Доржийн саналыг дотроо зөвшөөрч байв. Гэвч энэ саналаа би ил гаргаж хэлсэнгүй . Энэхэн үес дарга нарын байрны урдуур нэг хүүхэн банзлаа намируулаад тогос адил алхан явахыг Дорж хэдийн харж ,

-Хэн бэ ? гэж надаас асуув . Би нэрийг заасанд ,

-Эндхийн хүүхнүүд нэг л сайхан харагдахгүй юм гэв .

- Хаанахынх сайхан харагддаг вэ ?

-Иш! Манай нутгийн хүүхнүүд согоо, уулын согоо гэсэн үг !

- Чи аль нутгийнх вэ ?

- «Тэсийн голын унага , Тэрхийн голын хүүхэн » гэж дуулсан уу ?

- Дуулах ч дуулсан . Гэхдээ чи алиных нь юм? Хүлэг сайн морьтой газрынх нь юм уу ?

- Тэрхийн цагаан нуурынх байлгүй яахав . Манай тэндхийн хүүхнүүдийг санахаас... гэж нэг гараа атгаж нөгөө гараар тасхийтэл алгадахад би инээд алджээ .

Гэнэт буу тасхийв . Агаарт ногоон пуужин харваж байна. Бид ч ухасхийн босч , шүхрээ эгэлдрэглээд онгоцондоо үсрэн сууж агшин зуур асаав. Энэхэн үес нэг жигтэй том ногоон онгоц уулын дээгүүр жирэлзэн харагдав . Хэсгийн дарга маань хэдийн рулидэж *Онгоцыг газраар явуулах гэсэн үг*

улаан шугамнаас шууд зүүн урагшаа жирийлгэж гарав . Тэр чигээрээ тасрах нь бололтой. Бид хоёр ч хойноос нь жагсаалын эрэмбэ алдалгүй жирийлгэв. Газраас тасармагц харвал сайхь том ногоон онгоц хойт уулын дээгүүр баруун тийш шуухайтал дарж явна . Ердөө үзээгүй, жигтэй хурдан онгоц бололтой . Биднийг дөнгөж өндөр аваад гүнзгий эргэхэд нөгөө онгоц тэртээ баруун уулын дээгүүр эргэж байв. Тэр янзаараа бол гүйцэгдэх шинж алга. Манай хэсгийн дарга бол зоригтой ч хүн, хэнэггүй ч хүн. Далавчаа нэгэнтээ хөдөлгөж бидэнд дохио өгөөд маш гүнзгий эргэж эгц урдаас нь тосон янзтай чиг авав . Би гайхаж хоцров . Тийм үл мэдэгдэх онгоцны өөдөөс тосч болдог юм уу? Энэ бол агаарын байлдааны хамгийн хориотой зүйл .

Энэхэн үес мөнөөхөн том онгоц манай аэродромын зүүнээс бултан орж гулгаж эхлэв. Бид ч хойноос нь

«туусаар» байв. Биднийг мөн бууж ирэхэд том онгоцныхон онгоцноос бууцгааж байв. Лав долоо найман хүн бууж харагдана. Бид онгоцоо тавиад хүрч очив. Тэд биднийг тосоод зогсоно . Жигтэй өндөр нуруутай , овор том биетэй , зөвлөлтийн нисэхийн таних тэмдэг бүхий хурандаа цолтой хүн өмнө нь зогсож байв. Биднийг ёслоход тэр хурандаа бидэнтэй гар барьж ,

- Та нар биднийг хөөсөн үү? гэв

- Тиймээ . Нөхөр хурандаа !

- Хэрэв дайсны онгоц байсан бол яахав ?

- Яахав , тулалдах байсан даа !

- « И- 15 » -аар уу ? Бид нарыг харсан. Гурван хайрцаг чүдэнз шиг харагдсан. Хэрэв дайсны онгоц байсан бол асааж орхиход амархан байсан даа ...

- Та нарын энэ онгоцыг бид харсан. Том торхтой дарь шиг санагдсан . Нөхөр хурандаа, үнэнийг хэлбэл дарийг чүдэнзээр дэлбэлдэг шүү !

Бидний яриаг чагнан зогсож байсан орос цэргийн дарга нар үзтэл шивэр авир ярилцан ,

- «Молодцы!» гэж сайшаах дуун сонсогдов. Зөвлөлтийн хурандаа инээмсэглэн ,

- Энэ чинь «Бостон » гэдэг онгоц ! Харахгүй юу ? Урагшаа хойшоо , дээшээ доошоо харсан арван хэдэн буутай байлдааны том онгоц шүү дээ . Та нар тэгэхэд ...

- Хорин хэдэн буутай ч байсан ялгаагүй , нөхөр хурандаа. Бидэнд байлдааны тушаал өгөхдөө олон буутай онгоцны өөдөөс битгий нисээрэй гээгүй . Эх орны тушаал бол тушаал ! Мөнөөхөн «Молодцы» гэсэн үг дахин сонсогдов . Зөвлөлтийн хурандаа дахин инээж, бидний дал мөрийг алгадаж ,

- Зөв ! Ёстой шонхрууд байна ! Та нар шиг хатан зоригтой эрс одоо цагт их хэрэгтэй байгаа юм . Цэрэг эрийн хатан зориг ялалтыг авчирдаг. Та нар ёстой шонхрууд мөн байна ! гэж үнэн

сэтгэлийн угаас хэлэв . Энэ өдөр бид ингэж « шонхор » цол авсан билээ гэжээ .

Нисэгчийн «өдрийн тэмдэглэлээс» энэ өчүүхэн явдлыг уншаад би бодлоо . Цэргийн эрчүүл гэдэг ёстой юунаас ч буцдаггүй эрс шулуун улс юм ! Энэ удаа энэхүү тэмдэглэл хөтлөгч зоригт нисэгчийн хувьд мартагдашгүй сонин учрал тохиолдсон байна. Ялангуяа шонхор нь шонхрыгоо магтсан нь сайхан санагдана. Тэгэхдээ бүр бүргэд шонхор нь начин шонхрыгоо магтаж буй хэрэг шүү !

НАМСРАЙН БАНЗРАГЧ

Зохиолч Н. Банзрагч 1925 онд Завхан аймгийн Алдархаан сумын нутагт малчны гэр бүлд төржээ .

Бага дунд сургууль , Улсын их сургуулийн дэргэдэх утга зохиолын оройн дээд сургууль, Москва хот дахь

М . Горькийн нэрэмжит утга зохиолын институтийн дэргэдэх дээд курсийг тус тус төгсжээ . 1940 оноос уран зохиол сонирхон оролдож « Жирийн хүүхнүүд », « Тал нутгийн хавар », « Мөнх зул », « Аадрын дараа » ,«Цэрэг эрийн дууль », « Замбага ягаан цэцэг », «Өглөө », « Нэг голынхон » ,«Намрын хонгор салхи» ,«Шинэ жилийн өмнөх үдэш » өгүүллэг , туужууд «Зам » , « Хошуу цагаан нутаг » роман бичжээ . Зохиолчийн « Зам » роман ЗХУ–д орос , белорус хэлнээ хэвлэгджээ .

ЦЭДЭВДОРЖИЙН БАЗАРРАГЧАА

Зохиолч Ц. Базаррагчаа 1937 онд Ар-хангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага дунд сургууль, 1962 онд Улсын их сургууль төгсжээ. 1960 оноос уран зохиол оролдож «Цаст уулын цас», «Тамирын чулуун», «Галын илч», «Цэцэгт нуурын цэцэг» зэрэг өгүүллэг туужийн түүвэр хэвлүүлжээ.

ЭНГЭРИЙН ГУРВАН ХАЙЛААС

Уужимхан урт хөндийн эхэн тушаа , хадтай өндөр толгойн энгэрт гурван өвгөн хайлаас холоос сүр бараатай харагдана. Хайлаасны ногоон навчис нь дөрвөн зүгтээ шүхэрлэн тэлж зэлүүд хээрийн салхины аясаар сэржигнэн шуугих нь улирч одсон он жилүүдээ тоолж, болж өнгөрсөн үйл явдлаа хүүрнэн өгүүлэх мэт . Хав ойр ой модгүй тал хөндийд гурван лүглэгэр хайлаас хэдийд ургасныг хэн ч үл мэдэх бөгөөд олон жилийн турш ширүүн бороо цасан шуурганд савчин ганхаж урт үндсээ газрын гүн руу бат шигтгэн улам улам бүдүүрэн ургаж өдий хүрчээ. Нутгийнхан дээр үеэс гурван хайлаасыг лус савдагтай онгон догшин гэж шүтэж , навч нахианд нь ч гар үл хүрэх учир ганц ширхэг навч хүний гараар тасран салсангүй . Намар намарт алтан шаргал навчаа гөвөх учир орчны газар нь шаргал өнгөтэй хөвсгөр болжээ. Хайлаасны мөчир болгонд талын болжмор үй олноор цуглаж цаг ямагт шулганан жиргэнэ .

Гурван хайлаасны яг өлмий доороос нь маш тунгалаг устай гурван булаг ундрэн гарч саахалт хиртэй урсаад гурвуулаа нийлж зэгсэн элбэг устай горхи болон жирэлзэн урссаар хөндийн адагт буй элсэнд шурган шингэнэ. Урсгал ус ой модгүй говь талд хүний хүслээр бий болсон юм шиг үзэсгэлэн төгөлдөр хайлаас цэнгэг устай булгийг байгаль заяажээ . Хүйтэн тунгалаг ус нь жирийн ч биш гэдэс дотрын өвчнийг анагаах чадалтай рашаан болохыг мөн л олон жилийн тэртээгээс мэдэж хавь ойрынхон нь шидэт рашаанаас хүртэж өвчин эмгэгээ анагаахаар ирсэн бөлгөө . Хөндий дундуур жирэлзэн урсах горхи ямар ч гантай жил хатаж ширгэж байсангүй. Газрын хөрс нь шимтэй ус чийгтэй болохоор өвс ногоо ч өтгөн сахлаг ургана. Зун намрын дэлгэр цагт Гурванбулагийн хөндий гэж нэршсэн энэ сайхан нутаг ёстой л хүн малын жаргалын орон болдог байв . Горхины хоёр хөвөөгөөр ойр ойрхон олон хот айл бууж хөндий дүүрэн мал багширна . Нутгийн айлууд булгийн эхээс нэлээд доогуур зусна. Тэд булгийн эхийг догшин гэхээс гадна түүний ундаргыг бохирдуулалгүй цэвэр байлгах , тал нутгийн чимэг болсон гурван хайлаасаа гэмтээхгүй гэсэн сайхан сэтгэл өвөрлөн олон үеийг өнгөрөөжээ .

Намрын хонгор салхи сэв сэв үлээж газар дэлхий шаргалтан гандах үес хайлаасны навчис алтан шаргал болж улам ч сүртэй сайхан болно .

Энгэрийн гурван хайлаас

Эрдэнээс илүү гялалзана

Энгийн хүн байтлаа

Ээжээс илүү санагдана .

гэж энэ нутгийнхан дуулах дуртай . Магадгүй нутгийн авьяас билэгт ард түмэн эрдэнийн өнгөөр алтран гялалзах хайлаасаа магтаж энэ дууг зохиосон бизээ.

Хөндийхөн өвсний сөл тасарч анхны хяруу унахад говийн дулаан өвөлжөө өөдөө нүүцгээдэг бөгөөд хавар ногоо цухуйхтай зэрэг л мөн аянчин шувууд шиг буцан нүүж ирнэ. Өнгөрсөн зун

намар идэж бараагүй сахлаг борог дотроос нялх ногоо алаглан цухуйх үес хөндийд ирсэн мал сүрэг тодхон тэвээрч дэлгэр зунтай золгоно . Энэ хөндийд нэгдлийн хонины гол сууриуд зусах бөгөөд өвөл эзэнгүй болно. Цас ихтэй хатуухан өвөл болбол нэгдлийн адуун сүрэг оторлон ирдэг юм. Сүүлийн хоёр гурван жил хөндийн эх орчмоос хадлан хадах болжээ. Ноднингоос энэ хөндийд малын тэжээлийн ургамал тарьж хадлангийн талбай болгоно. Айл амьтан нутаглуулахгүй хамгаалж тордоно гэсэн яриа гарсан боловч чимээгүй болжээ. Харин булгийн эхний хадан хясааг нурааж зам засах гэнэ гэсэн цуу үг гарсан нь нутгийнхныг зэгсэн түгшээжээ. Гурван хайлаасны архан талаар хадан хясааны ёроолоор эртний балархан жим байжээ. Арав гаруй жилийн тэртээ хөндийн зүүн урд биед сум нэгдлийн төв суурьшсанаас хойш тэрхүү балархай жим нь аймаг сумын төвийг холбосон гол зам болжээ. Гэвч хясааны энгэрээр том том үхэр чулуутай хадан хясаа түрж орсон тул машин явахад нэн бэрхтэй. Хааяа нэг нутгийн сайн жолооч л үхэр чулуун дундуур сүлжиж булгийн эхний эрэг рүү уначих дөхөн явдаг байлаа. Толгойн араар шинэ зам гарсан боловч гуу жалга олонтой өвөл бол цас боож зун шавар шалбааг ихтэйн гадна уг зам нь хөндийн баруун биеэр дугуйран тойрч хөндийн адагт очоод зүүн хойшоо эргэх тул сумын төвөөс лав хоёр гурван өртөө хол тойруу болгоно. Хөндий дундуур огтлон гарья гэхэд намаг шавар их , гүүр байхгүй тул жолооч нар зүрхлэдэггүй ажээ. Хадагт толгойн зүүн биеэр бол овон товон хад чулуу арвин, бартаатай болохоор машин зүглэх арга байхгүй . Хамгийн ойр дөт зам бол урагшаа түрж орсон хадан хясааг нурааж зам засах нь ашигтай болохыг аймаг сумын удирдлага мэдэж байсан боловч зам засахаар хөрөнгө гаргаж зүрхлээгүй л байв. Тэгтэл сумын төвийн ойролцоо чулуун нүүрсний уурхай нээгдэж ашиглаж эхэлсэн тул тойруу замаар өдөр, шөнө, өвөл зунгүй машин дүнгэнэн явах болжээ . Ингээд үржил шимтэй энэ хөндий нэг бол хадлан тариалан тарьж айл амьтан нутаглахгүй болох, үгүй бол хясааг нурааж зам засах их ажил эхлэх болж хөндийд идээшиж дассан олон айл баахан түгшиж байлаа .

Хөндий дүүрэн ногооны хөөнгө суунаглан цэнхэртсэн хаврын сүүл сарын нэгэн дулаахан сайхан өдөр алс говьд өвөлжсөн айлуудын түрүүч хөндийд зусахаар ирлээ .

Өвгөн Дамбий олон жилийн турш зуссан тунгалаг горхины зүүн хөвөөнд гэрээ барих зуур ийш тийш харвал тэднийхээс өөр айл нүүж ирээгүй юм шиг байв . « Энэ жил манайх хамгийн түрүүн ирээ шив дээ . Энд бууж болохгүй гэж нэгдлээс хэл сураг ирээгүй болохоор энэ жилдээ л лав тариа ногоо тарихгүй нь шиг байна » гэж бодлоо. Гэрээ барьж цай чанаж уучихаад хонио Гурванбулагийн эх өөд аажуухан туув. Хөндийн өвс урьдын адил өтгөн сахлаг бөгөөд борог дундаас энд тэндгүй шинэ ногоо цухуйсан үзэгдэнэ. Дамбий хонио туусаар гурван хайлаасанд нэлээд дөхлөө. Хөндийн эх өөд өвс нь бүр ч өндөр сахлаг байдгийг малчин өвгөн сайн мэдэх тул бусад айл нүүж ирэхээс хэд хоногийн өмнө ч гэсэн өвлийн тарчиг цагт зүдэн ядан онд орсон хоньдоо цатгах гэж ийнхүү өвсний соргог усны тунгалгийг сонгон яваа ажээ. Хонь ч борог өвс шинэ ногоо холилдсон нэгэн нугад ороод сайхан тогтлоо. Дамбий мориноос бууж юуны өмнө гурван хайлаас өөд дурандлаа. Хайлаас ид навчилж байгаа бололтой мөчир гишүү нь хар ногоон өнгөтэй болжээ. Хайлаасны ард машин тэрэг, хүмүүс нааш цааш явж байгаа харагдахаар аян замын улс юм болов уу гэж бодоод хараад байсан чинь машинаас юм буулгаж төдөлгүй том хөх майхан босгож эхлэхээр нь зам засахаар ирсэн хүмүүс байх нь гэж гэнэт бодоод зүрх нь лүг лүг цохилон мориндоо мордон тийшээ шогшуулав. Хашин морио давчин шогшсоор булгийн тархиар тойрон гарч очвол хоёр гурван машин, бас трактор ч харагдав . Нэлээд олон хүн ачаа бараагаа буулгаж зарим нь бас нэг

майхан босгох гэж байв. Нутгийнхны хэн нь ч хавьтдаггүй булгийн эхний ундаргаас хоёр хүн том саванд ус хийж байгааг хараад « Хай дамшгууд булгийн эх рүү бохир сав дүрж бузар оруулчихлаа» гэж амандаа үглэн ус авч байгаа хоёр хүний дэргэд очоод амар мэндээ ч асуулцсангүй .

- Та нар чинь яаж байгаа нь энэ вэ ? Бохир саваа булгийн эх рүү дүрээд гэж чангахан хэлбэл тонгойгоод ус утгаж байсан залуу эргэж харснаа

- Юу гэнээ өвгөн гуай гэв .

- Эндээс ус авч болохгүй .

- Яагаад ?

- Наадах чинь рашаан булгийн эх ундарга . Манай нутгийнхан тээр дор харагдаж байгаа чулуун овооны тэндээс ус авдаг юм гэж өвгөн гараараа заав . Хоёр залуу ер тоосон шинжгүй .

- Бид хаанаас ус авахаа мэднээ гэвэл Дамбийн зэвүү хүрч :

- Монголоо алдсан дамшгууд . Булгийн эхэнд бохир юм оруулж болохгүй гэж дуулаагүй юу ? гэвэл

- Бидний энэ шанага хөдөөний та нарын халтар шанагатай адилгүй цэвэрхэн юм. Харин та бүхэн сав суулгаа сайн угааж байж энэ рашаанаас авч байгаарай . Хэд хоноод энэ хадан хясааг нураахаар рашаан чинь улам цэвэр тунгалаг болно доо гэж өндөр залуу тавлах мэт хэлэхэд Дамбийн бие зарсхийж дэмий л шогшров . Хоёр залуу саваа дүүргэж аваад майхан өөдөө дамжлан явахад нь Дамбий даган явж байснаа

- Та нар энд зам засахаар ирээ юу ? гэлээ .

- Тиймээ зам засна. Явах замын саад, улсын хөгжлийн тээг болсон энэ хадан хясааг агаарт хийсгэж зайлуулна гэлээ. Өвгөн гарцаагүй болсон энэ явдалд балмагдан дахин ч юм асуусангүй. Замынхан өвгөнийг сонирхсон янзтай харна. Тэгтэл хэдэн хүн газар ухаж эхлэв. Дамбий тэсэж чадсангүй

- Бид олон үеийн турш энэ хавийн газар орныг хөндөж үзээгүй өдий хүрсэн юмсан. Та нар ч шийдсэн улс юмаа гэвэл махлаг залуу , хүнд төмөр царил далайн газар тас хийтэл цохиод

- Өвгөн гуай лус савдагтай газар уу ? гэв .

- Лус савдаг ч юу байх вэ . Элэнц хуланцаасаа л хайрлан шүтэж ирсэн газар орон шүү дээ гэж өвгөн хэлбэл

- Газар оронд сохроор биширч шүтэж байдаг шашны л хор гай шүү дээ. Энэ шашин ард түмний тархинд мөн ч гүнзгий шингэсэн юм шүү. Одоо болтол бурхан шашиндаа хайртай хүн байгаа нь мөн тоогүй хэрэг гэж тарган залуу хэлбэл Дамбий сэртхийж бурхан шашин

шүтдэг гэж ороогдох бий гэж айгаад дэмий л санаа алдав .

- Та айж сандрах хэрэггүй . Тэр догшин сүрхий газрыг бид номхтгоод өгнөө гэж бас нэг залуу хэлээд газар тун тан хийтэл нүдэхэд хайлаасанд үүрлэж байсан олон шувууд сандралдан нислээ. Өвгөн тэр шувуудыг харж « Хөөрхий энэ амьтад олон жилийн турш ажин түжин амьдрахдаа ийм түгшүүр ер үзээгүй юмсан » гэж бодлоо .

Дамбий өвгөн маргааш өглөө нь зам засахаар ирсэн хүмүүсийн даргатай нь уулзаж өөр газраар зам засаж болдоггүй юм болов уу гэж бодож санаж явдгаа хэлэх санаатай ирлээ. Өчигдөр нүх ухаж байсан хүмүүс газар ухаж хийсэн зуухандаа гал түлж хоол цайгаа хийж байгаа бололтой байв . Хэдэн хүн булгийн эхэнд хувцас хунараа угааж байгаа харагдахаар өвгөний дотор харанхуйлан зүрх нь пал хийж, өөрийн мэдэлгүй морио ороолгон тэдэн дээр давхин ирж

- Эрээ цээрээ алдсан зулбасгууд эндээс зайлцгаа гэж байдаг тэнхээгээрээ хашгирав . Юм угааж байсан хүмүүс толгой өндийн гайхан харлаа .

- Наадах чинь рашаан гэж та нарт хэлээгүй билүү? Та нар даанч яав ? Ариун булаг минь бузартаж одоохон ширгэж алга болно гэж өвгөн мөн л хашхирав .

- Та эндэхийн лус савдаг нь арай биш биз дээ гэж нэг залуу өвгөнөөр даапаалав. Дамбий тэр доогтой залууг ташуураар ороолгож

- Яана гэнээ. Настай хүнээр тоглож байхдаа ичихгүй байна уу? Чи над шиг эцэгтэй байх гээд дахин ороолгох гэтэл өнөө залуу навтасхийн зайлж бусад нь үймэн шуугилдав .

- Юу болоод байнаа ? гэх захирангуй дуу гарахаар Дамбий эргэн харвал гозгор цагаан залуу гайхсан янзтай харж байв .

- Инженерээ энэ өвгөн өчигдрөөс хойш биднийг омогдож байгаа юм . Сая намайг ташуурдаж байхгүй юу гэж халыг цохиулсан залуу гомдол мэдүүлэв. Инженер залуу инээмсэглэн ойртож ирснээ

- Дамбий гуай та амархан сайн байна уу? гэж мэндлэв . Дамбий нгдээ арчин дахин дахин харснаа

- Үгүй энэ чинь ... Балдангийн хүү юү дээ гэснээ мориноосоо шалавхан бууж инженер залууд ойртоход үймж байсан улс гайхан харцгаалаа. Дамбий инженер залуутай золгож хацрыг нь үнэрлэн үнсээд

- За Чулуун хүү хэзээ ирээ вэ ? гэлээ .

- Би өчигдөр орой ирсэн. Танайх хөндийд нүүж ирээ юу?

- Тиймээ хүүхээ

- Манайх хаана байгаа вэ ?

- Өнөө маргаашгүй л нүүж ирнэ .

- Таны бие тэнхээ сайн биз дээ Танайхан бүгд сайн уу ?

- Сайн сайн . Хүү минь чи Гурванбулагийнхаа хясааг нурааж зам засах гэж ирээ юу ?

- Тиймээ , Дамбий гуай .

Дамбий нутаг усны нэг дорын хүүтэй уулзсандаа нэг талаар баярлаж нөгөө талаар гомдож байлаа. Чулууны эцэг Балдан, Дамбий хоёр нэг хонхорт төрж хар багаас үерхэн өссөн бөгөөд дандаа айл саахалт явдаг байлаа. Балдангийн дунд хүү хотод дээд сургуульд суралцаад инженер болсон юм гэсэн яриа хоёр жилийн өмнөөс дуулдаж байжээ. Чулуун дээд сургуульд байхдаа жил бүр зуныхаа амралтаар ирдэг байсан, харин сургуулиа төгсөөд ажил алба нь болж өгөлгүй хоёр жил гэртээ ирээгүйг Дамбий сайн мэдэж байв. Дамбий нэг дорын хүүхэдтэй уулзаад баярласны учир бол үүнийг зад загнаж байгаад өөр газар зам засуулна гэж бодсоных. Хэрэв тэр нь бүтэхгүй бол гомдох байлаа. Тэгээд санаж бодсоноо хүн амьтнаас далдлан ярих нь зүй гэж бодоод

- Хүүхээ хоёулаа уулзья гэв .

Чулуун инженер өвгөнийг дагуулан нөхдөөсөө холдлоо. Тэр хоёр , гурван хайлаасны баруунтай очиж суув. Дамбий түрийнээсээ богинохон цагаан соруултай гаанс гаргаж тамхи нэрж асааснаа

- Хүү минь чи төрсөн газар орноо эвдэж нураах гэж ирээ юу? гэвэл Чулуун инээмсэглэн

- Эвдэх ч юу байх вэ . Зам засах гэж байна гэлээ .

- Энэ хясааг нурааж болохгүй л юмсан. Бид өвөг дээдсийн үеэс энэ сайхан булаг шанд , хайлаас , хадан хясааг шүтэн биширч өдий хүрэхдээ ширхэг чулууг нь ч хөндөж үзээгүй юм шүү гэж гомдонгуй өгүүлэв. Чулуун ч гэсэн мэдээ орсон цагаасаа эхлэн тал нутгийнхаа гоо үзэсгэлэн болсон булгийн хөвөөнд бишгүйдээ л тоглож явахдаа аав ээжийнхээ үгэнд орж хайлаасанд үүрлэсэн олон шувуудыг ч үргээж байсангүй , навч нахиаг нь ч тасалж үзээгүй юм .Энэ нутгийнхан булгийн эх гурван хайлаасыг догшин онгон гээд хавьтахгүй бөгөөд хэрэв чулуу шороог нь хөндөж цэцэг навчий нь тасалбал лусын хорлол болно . Бас рашаан булаг нь хатаж ширгэнэ гэж дээр үеэс сүсэглэн ирсэн билээ. Тийм үзэл бодол хатуу баримтлах нутгийн нэр хүндтэй настай хүнийг гомдоохгүйг хичээн аль болох эвтэйхнээр аргалахыг бодсон инженер залуу юу гэж хэлье хэмээн бодож байгаад

- Дамбий гуай ... Улс орны хөгжлийн шаардлагын дагуу газар орноо өөрчлөн сайжруулж ашиглах нь ... гээд учирлах гэтэл өвгөн үгийг нь таслан

- Тэр ч тэгэлгүй яах вэ. Гэхдээ заавал хясааг нурааж зам засахын оронд өөр газраар засаж болохгүй гэж үү дээ. Алтан дэлхий алгын чинээн биш гэв .

- Аймаг сумын хооронд үүнээс өөр дөт зам байхгүйг та мэднэ. Хөндийн баруун талаар явдаг

зам чинь ... гээд тайлбарлах гэтэл Дамбий бас үгийг нь таслан

- Хясааны зүүн сугаар хөндийн зүүн биеэр зам засаж болохгүй гэж үү? гэв.

-Түүнийг чинь бодож үзсэн юмаа. Түүгээр зам засна гэхэд бартаа ихтэй .

- Бартаа саадаас айх гэж үү? Ийм мундаг машин трактортой улс чинь тэр том том үхэр чулуу, сондуул довонг дор нь хамж түрээд зайлуулдаг юм биш үү?

-Нарийн учир бий. Тэнд зам засахад наад зах нь хагас өртөө хирийн газрыг янзлах болохоор хөрөнгө мөнгө их орно. Харин хясааг бол жараадхан метр газар нураачихвал болох нь тэр.

-Хясааг нураатал энэ рашаан маань хатаж ширгэнэ шүү дээ.

-Хаанаас даа. Та дэмий юманд санаа зовж байх юм.

Өвгөн дуугарсангүй бодол болон тамхиа баагиулж сууснаа гаансаа чулуун дээр тогшиж үнсийг нь унагааж түрийлээд

-Бид мэтийн мунхаг өвгөчүүл бол орчлон дэлхийг бурхан бүтээсэн, түүнийг хэн ч өөрчилж болохгүй гэж боддог. Харин эрдэм номтой та нар бол байгаль

өөрөө бүтээсэн гэдэг шүү дээ. За бурхан ч бүтээсэн бай, байгаль нь ч бүтээсэн ялгаа алга. Нэгэнт л бүрэлдэж тогтсон газар орныг эвдэж сүйтгэж орхиод дахин бүтээж чадахгүй. Чи богино бодолтой байна. Энэ булгийг хайлаасны ёроолоос ундарч байна гэж санадаг бизээ. Тэр тийм биш . Жинхэнэ ундарга нь хадан хясааны дор байгаа юм . Газрын зөөлнийг дагаж хайлаасны хөлөөр ил гарч байгаа юм. Ерөөс төрсөн нутаг усаа хайрлаж хамгаалж байдаг манай ардын заншил бол ганцхан уул усны лус савдгаас айж болгоомжилсон юм биш шүү. Чи хар л даа. Тэр зүггүй хүүхдүүд булгийн эхэнд хиртэй хувцсаа угааж байна. Дуртай дуртай газар бие засаж бохирлож байна .Энэ хөндийгөөр дүүрэн хүн мал олон жилийн турш амьдарч ирснийг чи мэднэ . Тэд одоо та нарын хир зунгаг шингэсэн усыг уух болж байна шүү дээ. Монгол хүн булаг шандын усыг цэвэр тунгалаг байлгах гэж хэзээнээс эрхэмлэж ирсэн түүхтэй юм. Урсгал усгүй энэ нутагт ус гэдэг чандмань эрдэнээс ч үнэтэй. Энэ булаг горхи ширгэж орхивол бид яах болж байна ? Хатаж үхэх хэрэг үү? Энэ хайлаас , энэ булаг шанд чинь амьтай эд. Та нар амьд байгаль гэдэг биз дээ . Амийг нь тасалбал үхнэ биз дээ . Хүү минь чи эрдэм номтой хүн сайн тунгааж бодоорой гэжээ. Чулуун түүний ярихыг чих тавин чагнаж суухдаа хөдөөний жирийн нэгэн малчин өвгөнөөс ийм ухаантай үг сонсоно гэж үнэндээ бодоогүй байсан юм . Дамбий өвгөн аав шиг нь хэзээний малын хойноос хөөцөлдсөн бичиг үсэг ч тааруухан мэддэг, үг яриа ч цөөн томоотой төлөв хүн болохыг Чулуун мэдэх боловч амьдралын нарийн ухаан, бодож цэгнэх талаар хэнийг ч дагуулахгүй хэрсүү гүнзгий бодолтой болохыг сая л мэдэв . Тэгээд хариулан хэлэх ч үг олдсонгүй . Тэр хоёр хэсэг зуур бие биеэ харан дуугуй сууцгаав .

- Чи тэгээд яая гэж бодож байна гэж өвгөн асуув . Чулуун өвгөнийг зүрхшингүй харснаа

- Дамбий гуай минь би ингэж шийдсэн юм биш шүү дээ . Энэ зүгийн мэргэжлийн улс газар

орныг нь шинжилж зураг төслийг нь гаргасан юм. Түүнийг өөрчлөх эрх мэдэл надад алга даа гэвэл Дамбий санаа алдаж

- Тийм нь ч тийм л дээ . Чи ганцаар хаанаас шийдэв гэж. Гэхдээ тэр зураг төслийг нь зохиохдоо миний түрүүний хэлсэн зүүн талаар зам засна гэж зүтгэсэн бол ч учир байх байсан даа гэлээ .

- Тэр тухай яриад дийлээгүй юмаа . Түүгээр зам тавихад хясааг нурааснаас арав дахин их зардал орно гээд зөвшөөрөөгүй юм гэж Чулуун хэлэв. Дамбий дуугарсангүй , сүүмийсэн нүдээр харж байснаа аажуухан босож мориндоо мордоод

- За тийм байдаг байжээ . Хүү минь төрсөн үүрээ нурааж эвддэг ангаахай хэзээ ч байгаагүй юм шүү гэххээд морио давиран бөг бөг шогшлоо. « Төрсөн үүрээ нурааж эвддэг ангаахай хэзээ ч байдаггүй юм гэнэ үү? Энэ чинь юу гэсэн үг вэ? Нээрэн би чинь энэ нутагт төрсөн өчүүхэн муу ангаахай нь шүү дээ. Ангаахай үүрээ орхиод нисдэг болохоос биш түүнийгээ эвддэггүй билээ. Би төрж бойжсон үүрээ эвдэх гэж үү? » гэхээс түүний зүрх гэнэт хүчтэй дэлсэж чимчигнэн өвдөх шиг боллоо .

Гүн шөнө болов. Нөхөд нь унтаж чимээ шуугиан намдлаа. Чулууны нойр мөд хүрэх шинжгүй сэрвэлзэн дэмий л нааш цааш хөрвөөнө . Түүний санаанд «Төрсөн үүрээ эвддэг ангаахай» гэсэн зэвүүн үг байн байн орж шаналгана . «Манай нутгийнхан Балдангийн онгиороо хүү л төрсөн үүрээ эвдэж нутаг усаа бузарлав гэнэ дээ. Дамбий гуай яасан ухаантай хүн бэ ? Хөдөөний өвгөд чинь гаднаас нь харахад юу ч мэдэхгүй, бүдүүлэг хачин юм шиг байдаг нь зөвхөн гаднах өнгө байх нь . Манай нутгийн буурлууд их ухаантай , амьдралын агуу их туршлагатай юм байна . Тэд нутаг усандаа хайртай болоод л түүнд гар хүрдэггүй байжээ. Харин үүнийг нь шашин овжин ашиглаж лус савдагтай гэж айлган сүрдүүлж мунхруулж байсан хэрэг . Одоо дэлхий дахинаараа байгаль хамгаалах гэж бөөн шуугиан болж байна . Манай нутаг харин төдий л хүний гар хүрээгүй юм шүү. Булгийн ундарга нь үнэхээр хясаан дор байдаг бол хясааг нураахад ундарга нь дарагдаж ширгэнэ . Тэгвэл ч энэ сайхан уужим хөндий амьдралгүй болно гэсэн үг. Манай суманд үүн шиг задгай устай сахлаг өвстэй газар байхгүй. Зөвхөн манай сумаар ч барахгүй зэргэлдээ хэдэн суманд ч байхгүй л дээ. Рашаанаас уух гэж бүр алс хол нутгаас ч ирдэг шүү дээ. Булаг ширгэхгүй юмаа гэхэд рашааны чанар нь өөрчлөгдвөл яана. Би яах ёстой вэ ? ... Дээд сургууль төгсөж зам гүүрийн инженер болчихоод төрсөн үүрээ л эвдэх болж дээ ... Улсынхаа төлөө гэсэн чин санааг минь манай нутгийнхан ойлгох бизээ . Би ямар дураараа хийж байгаа биш . Аймгийн төв цаашилбал улсын хэрэгцээг хангах уурхайн үр ашгийг өндөр байлгахад энэ зам маш чухал үүрэгтэй. Дамбий гуайн хэлдэгээр хясаанаас зүүн талаар зам засахад ч болно л доо. Даанч их зардал гарч олон хоногийн ажил болно. Яавч түүнийг зөвшөөрөхгүй . Юутай ч гэсэн маргааш тэр хавийн газрыг нарийвчлан үзье .

Үнэндээ би энэ замын зураг төсөл хийхэд хөндлөнгийн хүн шиг байсан минь тоогүй юм боллоо. Хясааны зүүн талаар зам засья гэж нэг удаа санал гаргахад хэн ч дэмжээгүй. Тэгээд л өнгөрсөн. Хэрэв яагаад түүгээр зам засах шаардлагатай байна вэ гээд л зүтгэсэн бол арга байсан ч байж мэднэ . Одоо газар дээр нь нягтлан үзэж тооцоо гаргаад хөөцөлдвөл дэмжиж ч мэднэ. Хүрээлэн байгаа орчин , байгалиа хамгаалах тухай хууль ч гарсан. Миний саналыг хар муйхраар дайрч няцаахгүй бизээ» ийн бодоод түүний санаа түр ч гэсэн амрав . Эргэн тойрон

нам гүм гагцхүү хээрийн чөлөөтэй салхи л үл мэдэгхэн сэвэлзэн үлээнэ. Чулуун баахан хэвтэж байгаад нойр нь бүр хулжсан тул сэмхэн босож майхнаасаа гарлаа. Дамбий өвгөний зэмлэсэнд сэтгэл зовнин майхнаа булгийн эхээс нэлээд доогуур авчран барьж булагт хамаагүй юм угааж бохирдуулж болохгүй гэж нөхөддөө захижээ. Нялх ногооны содон үнэр ханхалж ойролцоохон луглийн харлах хайлаасанд олон шувууд шулганан жиргэсээр л байв. Чулуун шувуудын жиргээнийг сэтгэл догдлон чагнаж байснаа горхи өөд явлаа. Оройтож гарсан сар яг л гурван хайлаасны цаанаас гэрэл гэгээ цацруулна. Горхины хөвөөнд ирвэл сарны гэрэл усанд тусаж мөнгөн утас мэт цайран жирэлзэнэ. Чулуун горхины хөвөөнд сууж жирвэгнэн мяралзах усыг сонирхон харав. Ус хол хол хийн бургилж тал саран урсгал саран давхих мэт мэлтэгнэнэ .

Чулуун багадаа энэ горхины хөвөөнд хурга хариулж явснаа дурсан санав. Бас сарны саруулд саах нийлүүлэх гээд богинохон шилбүүр барьж айлынхаа хүүхдүүдтэй хургаа туугаад инээж шуугиж явсан нь, хурдны морь, унаад хөндийн зүүн биеэр уралдаж байсан нь саяхан мэт санагдана . Үүр цайх дөхсөн бололтой хайлаасны тэндэх шувууд жиргэх нь улам олшров. « Би гэмгүй энэ олон шувуудын үүрийг эвдэх нь дээ. Хясааг нураахаар л бүгдээр үргэж алга болно бизээ » гэж бодохоос их л гэм хийж буй мэт бодогдов . Сумын бага сургууль төгсөөд аймгийн дунд сургуульд ааваараа хүргүүлэн энэ хясааны өмнүүр явахад мөн л олон шувууд жиргэж байсан билээ. Аав нь шувуудын жиргээнийг чагнаж явснаа

- Буянтай сайхан нутаг шүү. Манай энэ тал нутагт үүн шиг сайхан газар хаана ч байхгүй . Миний хүү эрдэм ном их сураад төрсөн нутагтаа буцаж ирэхэд хамгийн түрүүн л энэ шувуудын жиргээ тосно шүү дээ гэж хэлсэн юм. Түүнээс хойш Чулуун хүү аймгийн дунд сургуульд цаашаа нийслэл Улаанбаатар хотод дээд сургуульд суралцаж байхдаа намар нь эдгээр шувуудын жиргээнээр үдүүлж хаварт нь угтуулан олон жилийг ардаа орхисон билээ. Өчигдөр орой энд ирэхдээ хамгийн түрүүн танил шувуудынхаа хөгжилдөн жиргэхийг сонсож сэтгэл нь ихэд догдлон хөдөлж байсан юм .

Төрсөн нутгийн нь цэнгэг сайхан агаарт бие сэтгэл нь хөнгөрөн унтаж хэвтэхийг хүссэнгүй, дорно тэнгэрийн хаяа цайвартаж сарны гэрэл бүдгэрэн байгааг Чулуун инженер сая л анзаараад майхан өөдөө аажимхан алхахдаа Дамбий өвгөний үг үе үе санаанд нь орж зовоосоор байлаа.

Зам засах хүмүүс ирээд хориод хонов. Гэсэн ч хясааг нурааж эхэлсэнгүйд Гурванбулагийн хөндийд нүүж ирсэн малчид эргэлзэн гайхаж байлаа. Олон үеийн турш малчны сэтгэл тэнэгэр, малын зоо тарган байдаг хөндийхөн энэ зуныг сэтгэл түгшүүртэй угтсан билээ. Гурванбулагийн хадан хясааг нурааж зам засахаар хотоос хүмүүс ирсэн тухай мэдээ хоромхон зуур тарж айлууд яаран сандран нүүж ирцгээсэн юм. Тэд нүүж ирсэн даруйдаа зам засахаар ирсэн хүмүүсийн байраар ганц хоёроороо хэд гурваараа үзэгдэх болж Чулуун инженерийн сэтгэлийг улам ч зовоох болжээ. Чулуун нутгийнхаа ах дүү танил хүмүүстэй өдөр бүр уулзаж зам засах тухай учирлан ярьж заримаас нь хатуу ширүүн үг ч бишгүй сонсов. Тэгээд ямар ч гэсэн хясааны зүүн талаар зам засаж болох эсэхийг мэдэх гэж хэдэн өдөр газар орны байдлыг нарийн судалж нягт сайн тооцоо судалгаа гаргаж шинэ төсөл зохиогоод, түүнтэйгээ хамт нутгийн ард олны хүсэлтийг хавсарган явуулжээ. Чулуун шинэ төлийг нь хүээж авах эсэхийг мэдэхгүй боловч ямар ч гэсэн хариу иртэл ажилдаа орсонгүй. Замынхан хийх ажилгү тул

ихэнх нь хөдийн айлаар хэсэх болов . Энэ хооронд Чулууны гэр говиос нүүж ирсэн тул өдөр бүр гэртээ очно . Харин эцэг нь огт зэмлэсэнгүй . « Улсын чухал болохоос биш миний хүү ямар дураараа загнаж байгаа биш . Олон санаа санаж эргэлзэж байхаар ажилдаа орсон нь дээр» гэж эцэг нь хэлсэн юм. Айл саахалтын амьтан ах дүү нар нь түүний хүүг зэмлэж төрж өссөн нутаг орноо эвдэн нурааж рашаан булгыг бузарлах гэж байна хэмээн ил далд шуугиад байхаар Балдан өвгөний сэтгэл хэнээс ч илүү зовж шаналж байлаа. Гэлээ ч гэсэн нэгэнт зам засахаар дээд газар шийдэж хөрөнгө мөнгө зарж хүн хүч ирүүлсэн болохоор яавч түүнийг өөрчилж болохгүй гэдгийг Чулууны эцэг сайн мэдэж байв. Тийм учраас хүүдээ хатуу ширүүн үг хэлээгүй юм. Хэрэв нутгийнхны адил эвгүй үг хэлбэл зам засах ажилд саад учруулж мэднэ гэж санаж байжээ. Балдан өвгөн угаас бурхан шашин шүтэж яваагүй тул хүүгээ хадан хясааг нураахад лусын хорлол энэ тэр болно гэж айсангүй, гагцхүү Дамбийн хэлсэнчлэн ариун булгийн ундарга дарагдаж хатаж ширгэх бий гэхээс л сэтгэл зовнино .

Чулуун төвөөс ирэх хариуг хүлээж өдөр шөнийг зовиуртай өнгөрөөж байлаа . Хааяа арын замаар өнгөрөх машины дуунаар дэмий горьдон гарч хардаг байсан ч төвөөс хариу шийд ирэхгүй л байв .

Чулуун майхандаа хэвтэж байтал ойролцоохон машин дуугарав. Замын машинд олон удаа хууртсан болохоор гарч харсан ч үгүй хэвтэж байтал машины дуу ойртон ойртсоор гадаа нь хүрээд ирэх шиг болохоор ухасхийн гарвал суудлын тэрэг тоос хадаан айсуй . Чулуун сэтгэл догдлон харж байтал машин хурдлан явсаар хүрч ирлээ . Хэн ирээ бол гэж сонирхон харав . Машин майхны дэргэд ирээд зогсоход зам гүүрийн туршлагатай инженер Дүвжир машинаас гараад ирэв. Дүвжир бол Чулууныг бодоход насаар нилээд ах, олон ч зам гүүр удирдан барьсан дадлага туршлага их шилдэг инженерийн нэг ажээ.

Дүвжир замын тоосоо гүвж

- За дүү хүү сайн уу? Ажлаа эхлэхгүй юугаа хүлээж байгаа юм бэ гэв . Чулуун юм ч хэлсэнгүй түүний гарыг чанга атган мэндлээд майхандаа дагуулан орлоо . Дүвжир цуваа тайлж орны толгойд тохоод явган сандалд сууж

- Яасан халуун өдөр вэ гээд хөлсөө арчив . Чулуун түүнийг ангаж цангаж ирснийг мэдээд данхтай цайнаас том шаазанд хийж өгвөл Дүвжир авч зөөг цайг гүд гүд залгиснаа

- Чиний төсөлтэй танилцсан гэлээ .

- Тэгээд ? гэж Чулуун яаран асуув .

- Чи дэмий юм санаж байх юм . Мэдээжийн хэрэг хэн ч зөвшөөрөхгүй шүү дээ .

- Миний шинэ төслийг яагаад батлаагүй юм бол ? Би учир шалтгааныг тодорхой бичсэн шүү дээ .

- Залуу минь бид нэг шийдсэн зүйлээ хэн хүний үгээр өөрчилж байвал ажил яаж бүтэх юм бэ? Хэрэв чиний төслөөр зам засах юм бол хоёр зуун мянган төгрөг нэмж

зарцуулах нь байна . Болж бүтэх юмыг өөрчлөөд хоёр зуун мянган төгрөгийг агаарт цацах хэрэг үү?

- Түүнээс ч илүү үргүй зардал гаргадгийг аль тэр гэх вэ ?

- Түүнийг л мэдсэн юм бол дэмий үргүй зардал гаргахын хэрэггүй биз дээ. Чиний төсөл ёстой үргүй зардал .

- Та нарийн учрыг нь мэдэхгүй байна. Ард түмний бахархал болсон энэ сайхан байгаль орчныг үнсэн товрог болгохыг би хүсэхгүй байна .

Дүвжир ийм үг сонсоод гайхахдаа нүд нь том болж гараа алдлан өндөлзсөнөө

- Тэр үнэтэй сайхан байгаль, ард түмний бахархал чинь аль вэ? өвгөрч унах дөхсөн гурван өвгөн хайлаас уу ? өчүүхэн жижиг булаг шанд уу? Манай оронд үүнээс ч илүү үзэсгэлэнтэй сайхан газар бишгүйдээ бий. Хэрэгцээ шаардлага байхад энэ байтугай үүнээс ч сайхан байгалийг устгаж хувиргадаг юм гэж ширүүлэв . Чулууны ч дургүй хүрч

- Хэрэгцээ шаардлагаар түрээ барьж болохгүй . Одоо дэлхийн олон улс гүрэн учир мэдэхгүй мунхаг үйлээсээ болж эвдэлж сүйтгэсэн газар орон, бохирлож бузарласан гол мөрнөө дахин буй болгох гэж махаа идэж байна. Нэгэнт сүйтгэсэн байгалийг ёстой буян амлаж бурхан бүтээсэн ч дахин уг байснаар нь бий болгож чадахгүй. Одоо хоёр зуун мянган төгрөгийг зарахдаа харамлаж байж хожим хойно хоёр сая төгрөгөөр ч тал нутгийн чимэг болсон энэ сайхан газрыг бий болгоно гэж үү гэхэд Дүвжир ширүүхэн үзэлцэхээр шийдсэн бололтой дөхөн сууж

- Битгий номчирхоод бай. Хүн төрөлхтөн байгалийг өөрийн эрхшээл өөрийн амьдралын сайн сайхны төлөө ашигласаар ирсэн юм. Байгаль орчныг бохирдуулж сүйтгэнэ гэдэг чинь үүн шиг юм биш . Ихээ том зүйл гэж тайлбарлав .

- Энэ хадан хясааг нураах нь хэдий жижиг зүйл ч гэсэн ийм сайхан мод рашаан устай газар хавийн хэдэн суманд л байхгүй. Энд нэгдлийн олон суурийн хэдэн мянган мал хэдэн зуун хүн амьдран аж төрж байна . Говьд ус гэдэг чандмань эрдэнэ гэж Чулуун бас тайлбарлав . Дүвжир дэмий маргахыг хүссэнгүй бололтой босоод

- Тэр хэдэн мянган мал , хэдэн зуун хүнээ бодох уу гэдгийг улс мэдэж байгаа юм . Олон таван үггүй ажилдаа ор гэлээ .

- Аль алийг нь бодоод шинэ төсөл зохиосон юм гэж Чулуун хэлээд бас бослоо .

- Тэгвэл улс орноо илүүд бодох нь бидний зорилго гээд Дүвжир майхнаас гарлаа. Чулуун ч хоцорсонгүй даган гарч ирэв . Дүвжир ийш тийш харснаа

- Ажилчид чинь хайчсан бэ ? гэв .

- Ойрын айлуудаар орсон гэвэл

- Чи ер нь энд амарч зугаалах гэж ирсэн юм уу ? үгүй бол ... гээд Дүвжирийн дуу өндөрсөхөд
- Та сэтгэл зоволтгүй одоохон цуглана гэж Чулуун хэлэв .
- Би та нарыг ажилд нь оруулаад буцна . маргааш өглөөнөөс хясааг нурааж эхлэх хэрэгтэй гэж Дүвжир тушаав .
- Би тэр хясааг нураахгүй шүү гэж Чулуун эрс хэлэхэд Дүвжирийн нүд мөн том болж
- Яагаад ? гэлээ .

Түрүүн хэлсэн шүү дээ гэж Чулуун хариулбал

- А чи чинь энэ нутгийнх гэлүү? Хоцрогдсон бүдүүлэг хөгшид л энэ хайлаас булгийн эхийг лус савдагтай гэдэг юм . Чи тэдний үгэнд ороод айж хулчийж байх шивдээ. Ийм ч сэхээтэн байх гэж? Наашаа гарахаасаа өмнө Гандан хийдэд очиж амь насаа даатгах нь яасан юм бэ ? гээд Дүвжир тачигнатал инээхэд Чулууны хилэн гэнэт бадарч түүнийг заамдан аваад алгадах гэтэл Дүвжир гарыг нь чанга атгаж

- Зодох нь уу гэлээ . Чулуун ганц ч үг хэлсэнгүй түүнийг аяархан түлхчихээд горхи руу гүйчихэв .

Зуны тунгалаг наран мэлтэсхийн мандлаа. Замын ажилчид өглөөнийхөө цайг уучхаад хясааг нураахаар явцгаав .

Чулуун Дүвжир хоёр хэд дахин ширүүн маргалдсан боловч тусыг олсонгүй. Үнэндээ Дүвжир, Чулууны саналаар шинэ зам засах эрх мэдэл ч байгаагүй билээ .

Чулуун Дүвжир хоёр хясааг дэлбэлэх бодис үүрсэн хэдэн хүний хойноос хурдан хурдан алхаж явахдаа юм ч ярилцсангүй. Чулуун их л баргар царайлан явж буйг Дүвжир нүдний булангаар харснаа

- Улсынхаа хөгжлийн төлөө ямар ч гарз хохирлоос айлгүй ажиллах ёстой. Сэтгэл санаагаа үймүүлж болохгүй гэлээ. Чулуун дуугарсангүй газар шагайн алхана. Хайлаасны хойно ирснээ Чулуун зог тусаж

- Би хясааг нурааж чадахгүй гэчихэв . Дүвжир мөн л нүдээ том болгож

- За за битгий тунирхаад бай гэвэл

- Чадахгүй гэдгээ танд олон дахин хэлсэн шүү гээд Чулуун хайлаасны сүүдэрт суучихав . Дүвжир анхандаа түүнийг тоглож байна гэж санасан боловч царай нь баргар нүд нь ууртай гялалзаж байхаар нь

- Чи ямар эцэгтээ туньж байгаа биш . Үүрэгт ажлаа хийнэ үү? байна уу, өөрөө мэд гэлээ. Чулуун дуугарсангүй. Хясаа тэслэх бодис авч явсан ажилчид очих газраа оччихоод инженерээ хүлээсэн бололтой холхиж харагдана.

- Нөхөр минь бос. Ажилчид хүлээж байна гэж Дүвжир ширүүн хэлбэл Чулуун хяламхийж

- Би танд хэлдгээ хэлсэн шүү дээ гэв. Дүвжирийн зэвүү туйлгүй хүрсэн боловч биеэ барьсхийж

-Чи намайг тэсэлж чадахгүй гэж арай бодсон юм биш биз . Чиний амиа тавиад байгаа энэ өгөр хайлаасыг унагааж шалбааг чинь булаад өгье гайгүй гэгчхээд хясаа өөд бараг гүйх шахам явлаа. Нар дээш хөөрлөө. Хясааны ёроолд хэлэн хүн Дүвжирийн заавраар тэсрэх бодисоо булж байгаа бололтой тонголзоно. Хясаа тэслэхийг сонирхсон ажилчид нэлээд холхноос харж байв. Дүвжир ажлаа дууссан бололтой хүмүүсээ дагуулаад буцлаа. Дүвжир тэсрэх бодистой холбосон утсаа хөврүүлэн барьж эргэн эргэн харсаар хайлаасны хойно ирээд утасныхаа үзүүрийг тавьж чүдэнз зураад асаав. Утаа манасхийн өчүүхэн хөх гал улалзав. Дүвжир ойролцоо байсан хүмүүсээ зугтаа гэж гараараа зангачихаад Чулууны хажуугаар гүйж өнгөрөхдөө

- Нөхөөр ! Аминдаа хайртай бол холд гэж хашгирав . Чулуун хорондоо суугаад баймаар санагдсан боловч мунхаг явдлаас болж амиа гээхийг хүссэнгүй түүний хойноос харайлгав. Дүвжир ч эргэн хараад гүйнэ . Чулуун ч эргэн эргэн харж хол хол харайв. Гэнэт нижигнэсэн сүрт дуу гарч газар доргив . Чулуун эргэж харвал бөөн утаа тоос манарч бараг дэргэд нь том жижиг олон чулуу пижигнэн уналаа . Тэр чулуутай хамт амгалан байсан олон шувууд үргэн нисэж толгой дээгүүр нь нар халхлан өнгөрөв . Дараагийн тэсрэлт боллоо . Чулуун амьсгаадан гүйх зуур амандаа тэсрэлтийг тоолов. Эхний ээлжинд таван удаа тэслэлт хийхээр төлөвлөсөн юм. Тав дахин тэсрэлт болж дуусахад Чулуун зугтаахаа больж эргэн харвал шороо тоосонд хясаа ч харагдсангүй , хайлаас нь ч үзэгдсэнгүй . Дүвжир амьсгаадан гүйж ирээд

- Тэсэлгээ амжилттай боллоо шүү гэв. Чулуун түүний хөлөрч мэнчийсэн хүрэн нүүрийг хараад «Энэ хүн надад ямар гэм хийлээ. Бид хоёр адилхан л мэргэжлийн улс. Нэгэнт л дээд газар зөвшөөрөхгүй болохоор бидний хэн нь ч гэсэн түүнийг өөрчилж зөрчиж болохгүй шүү дээ » гэж бодлоо . Чулуун үл мэдэгхэн санаа алдсанаа

- Таван газар л тэсрэх бодисоо булаа биз дээ . Хир нураасан бол очиж үзье . Дахин тэслэх шаардлага байна уу үгүй юу гэж хэлэхэд Дүвжир ч юм хэлсэнгүй, түүнтэй зэрэгцэн явлаа . Толгой дээгүүр нь бөөн шороо хуйларна . Тэр хоёр явсаар хайлаасны дэргэд ирэхэд мөчир гишүү нь энд тэндгүй хөглөрөн унасан байв . Булгийн эх рүү том жижиг чулуу зөндөөн унаж булингартай улаан ус уурласан юм шиг тэдгээр чулууны завсраар сад тавьж байлаа . Чулуун хайлаас өөд нүдний булангаар сэм харвал салхины аясаар намиран байдаг ногоон мөчир нь хуга хуга үсрэн холтос нь ч ховхрон унасныг хараад дэмий л шогшров .

Зуны адаг сар гарангуут Гурванбулагийн хөндийхөн өөр тийшээ амь тэмцэн нүүцгээв. Хясааг дэлбэлж зам зассаны дараахан булгийн ус багадсаар ойрмогхон бүр ширгэжээ. Айлууд нүүсээр зөвхөн Дамбий Балдан хоёрынх үлдэв . Хоёр өвгөн горхины эрэг буланд тасарч үлдсэн балга усаар хэд хоног аргацааж бас нэг худаг ухсан авч тэр нь ширгэсэн тул нэгэн зэрэг ачаалав .

Дамбий ачаалчихаад булгийн эх өөд явлаа . Энэ жил хөндийд олигтой ч өвс ургасангүй . Аль

хавраас олон малд идүүлсээр бүр улаан шалдан газар болжээ .Ямар ч гантай жил Хөндий ийм өвс ногоогүй байхыг Дамбий далан хэдэн жил амьдрахдаа үзээгүй билээ. Тэр бөг бөг шогшсоор булгийн эхэнд ирж мориноосоо бууж харав. Ариун тунгалаг рашаан булаг мэлтэлзэн ундарч байдаг газар нь нүдийг нь ухаад хаясан аварга том амьтны ухархай шиг харлан хүнхийх нь нэн аймшигтай. Зам засаж байхдаа Чулуун инженер булгийн эхийг дарсан зөндөөн их чулууг зөөлгөж цэвэрлэсэн боловч нэмэр болоогүй юм .

Ундарга хавьд усны дусал ч үзэгдсэнгүй, зөвхөн хуурай хар шороо л өчүүхэн төдий хөдлөх салхинд бужигнана. Гурван хайлаас нь мөчир шилмүүсээ тэсрэлтэд тас тайруулсан учир бараа сүр нь ч алга болж мэнд үлдсэн цөөн мөчир нь хатаж хүрэн өнгөтэй болжээ . Дамбий цөхрөнгөө барж булгийн ундаргын шороог гараараа аяархан малтав .

- Дамбий минь наадхаараа оролдоод ер нэмэргүй гэх дуу гарахаар ихэд цочин эргэж харвал Балдан өвгөн зогсож байв . Балдан мориноосоо буусан ч үгүй

- Явья даа . Ачаа холдчихлоо гэв .

Хадан хясааг нурааж зассан дардан замаар ачааны машин тоос хадаан давхиж өнгөрлөө. Дамбий түүний хойноос харснаа

- Сайхан зам болжээ гээд мориндоо мордлоо .

- Гэсэн ч энэ сайхан өгөөмөр нутаг минь эзгүйрч орхигдлоо доо .

Миний л хүүгийн хийсэн нүгэл дээ гэж Балдан гүнзгий санаа алдан өгүүлэв . Дамбий морио давирч

- Хаанаас даа Балдан минь . Чулуун хүү ч зүүн талаар зам засах гэж их мэрийсэн. Улсын ажил чухал болохоор энэ хэсэг газар өгөрч гандах нь юу ч биш гэлээ .

- Ирэх зун хаана зусна даа гэж Балдан асуувал Дамбий дуугүй явж байснаа

- Харин ээ хөө. Хөшөөтийн худгийг л бараадахаас өөр замгүй боллоо гэв .

Хоёр өвгөн хайлаасны дэрэгдүүр өнгөрөхдөө зүрх өвдөн харав .

- Хайлаас минь өвгөрчээ. Одоо ус чийггүй болохоор мөдхөн хатаж унана бизээ гэж Балдан хэлэв .

- Тэгж л таарна . Өдийд цэл ногооноороо байдаг навч нахиа нь хүрэн болж хатаж байна . Ирэх жил ч лав цэцэглэхгүй бизээ гэж Дамбий маш гунигтай өгүүлэв .

Тэр хоёр нүүдлийнхээ хойноос шогшуулав. Хөлөөр хөглөрч байдаг өвс ногоотой хөндийд морьдын туурайгаар улбар тоос босно . Хатаж ширгэсэн горхины сайр хөндий уруудан цайран харагдах нь нүдэнд хүйтэн ажээ . Хоёр өвгөн явсаар нэгэн хөтөл дээр гарч ирээд эргэн харвал эрдэнийн өнгөөр гялалзан байдаг гурван хайлаас нь сүр сүлдгүй харлан ёрдойж , ногоорон хөхөрч байдаг уужимхан хөндий нь цайвар цагаан болж өнгө алдаад улаан шороо

тоос бужигнан хийсэж байсанд хоёр өвгөн гүнзгий санаа алдан цааш гэлдрэв.

УЛААН ХАДНЫ ӨВӨЛЖӨӨ

Хургандаа цадтал хөхөөгүй бол

Төлгөндөө майлдаг

(Хоньчдын хууч яриа)

Эл өгүүллэгт уул нь «Хамхуул халзан» ч юм уу, «Төлгөн суурь» гэж нэр өгч болох байлаа.

Чингэтэл, Хөх чулуут хэмээх хаа холоос бараа нь дүнхийсэн, майхан хэлбэртэй аварга цагаан уулын нэгэн ам болох Улаан хадны өвөлжөөг үзсэнээс хойш, мал дагасан хүн ийм уулын нөмрийг түших нь түмэн зөв өө гэх бодол эзэмдэх болж билээ.

Зэлүүдширсэн тэр нутаг ус одоо ч гэсэн буйд хэвээрэн л байна шүү дээ, гэхдээ тэр нутаг усны нэрээр өгүүллэгээ нэрлэв.

Хоньчин Сандагийг ямар ч юмны сүүлийг л мушгихаас биш, авсаар хүнээс урьдаж хөдөлнө гэж байхгүй, дотуур ухаантай амьтан хэмээлцэх нь бий.

Гэтэл халуун намраараа шахам байхад тэднийх сөл хөөн, нутгийн зах гарч буйд нутгийн бэлчээр уснаа хүрсэн байлаа.

Тийн оторлон одох тухайгаа Сандаг эхнэр хүүхэддээ л дуулгасан уу гэхээс биш, хэнтэй ч зөвшин хэлэлцсэн нь үгүй. Энэ нь аанайхан түүний дотуур ухаан ч байж болно.

Намрын хуучаар тэнгэр хангай ч олон хоног бургаж бударч Сандагийн сэтгэл ч олон хоног дэнсэлжээ.

Эргэх дөрвөн улиралд мөнх бургилж байдаг асан булаг, шанд болгоны ус, намар зуны заагаар газрынхаа гүн рүү хаван шургаж, намар эрт гэгч нь хэд хэд дахин цас дарж, хүйтний эрч чангарчээ. Өглөө оройд хээр гадаа явахад нь усны шувууд дуу нь дуулдахаас биш, бие харагдахааргүй дээгүүр нисэн буцаж буйг ажихад хүртэл нэг л биш. Эл бүхнийг анзаарах бүр Сандагийн сэтгэл дэнсэлнэ.

- Энэ тэнгэрийн байж байгааг ээ! Нэг л бишдэнэ дээ! Тэгтэл би гэдэг хүн нийгэмийн энэ олон зуун төлөг толгойгоороо хариуцаад авчихсан байдаг хэмээн ганцаар шогшрон, бударч бурганан буй уулсын зулай ширтэн зогсдог байлаа.

Чингээд нэг л өглөө суурь төлгөө туун, хоёр нохойгоо дагуулан өвсний сөл, усны тунгалгийг зорин одсон хэрэг.

Ар талаараа шивэр их ой хөвч үргэлжилсэн Хөх чулуут хэмээх дагшин уул наран ээвэр талдаа

олон ам сугатай . Хөх чулуутын ам суга бүхнийг дамжин явсаар зул сарын эхээр Улаан хадны өвөлжөө хэмээх гэр хадны нөмөрдөх хуучин өвөлжөөнд суурьшжээ. Нэгэн үдэш, хониныхоо захад хэвтэж байсан хоёр нохой нь бууцны хөл рүү чимээрхэн хуцсанаа шур шурхийн алга болов. Удаж төдөлгүй ноход боргоосоор , бараан морьтой хүн айсуй . Уржигдархан ирээд явсан малын бага эмч байлаа . Бага эмч мориноосоо буунгуутаа :

- Танай энэ « Асар » « Усар » хоёр чинь ер нь амьдаар минь идэх нь ээ ! гэснээ :

- Би энэ нэгдлийн « тахар » юм болсон хойно , таньд л хэл залгуулах гэж газрын мухарт хүрч явна .

- Ээ халаг гэж ! Ямар ч хол газар вэ ? Танай энэ өөд ч ёстой « бурхны » орон юм аа . Бэл рүүгээ цас ямар их гээ ! Уулынхаа эх өөд өгсөх бүр цас нь нимгэрсээр энд ирэхэд бараан шахуу юм гээч ! Хар цаснаас мултруут морины хөл хүртэл хөнгөрөөд явчих юм , энэ ээ тэрээ гэж ярьсаар бага эмч , отрын шовгорын өмнө ирээд , хоёр өвдгөн дээрээ хоёр гараараа тулан , шовгорын үүдээр мөлхөх шахам ороход , хуурай гишүүний оч чад пад дуугаран халуу дүүгнэ. Гэр хадны нөмөр дэх талын чинээн хашааны үүгээр түүгээр бие биенээ үнэрлэн шөргөөцөлдөж, хоорондоо мөргөлдөж байсан төлөгнүүд хүн ирснийг сониучирхах мэт эмчийн хүүрэг хөлс болсон морины зүг хошуурна .

Хөх чулуутын оройн шивэр их ой хөвч, зул сарын оройн жаварт салхинаа хүүгэн шуугисаар байхад , Улаан хадны өвөлжөөнөө бараг нь оготоны сахал хөдөлгөх салхигүй агаад , хагд өвс, шар навчис, хонины шар бууцны шивэр шивгэр ханхална .

- Төвөөс яваа хүн гэв үү дээ ! Мартчихаад байна .

- Уухай ! Очиж очиж надаар яах нь юм бол оо !

- Хэн мэдэхэв , дарга нар л таны нэрийг хэлээ биз .

- Арай ч дээ .

- Чухал хүн гэсэн шүү. Тэр хүнд таныг өөрийнхөө ажил бодол хоёрыг нэгд нэгэнгүй ярьж өгөөрэй гэж хэлүүлж байна билээ .

- Уухай , Буруу хойшоо ! Би юугаа ярих болж байна даа ?

- Юугаа ярихаа өөрөө л мэдэхээс биш ! Би л хэл гэсний нь хэлэв ээ барж. Отрын шовгорт ийн ярилцаж байгаад , бага эмчийг мордохоор босоход , Сандаг ч нохойгоо хорихоор гарав .

Тэр хоёрыг гадагш гарахад отрын шовгор дахь бөөр нь час улаан болсон зуухны хоёр этгээдэд сая халуун цай уугаад тавьсан аяганаас уур савсан хоцров .

Сандаг эмчийг мордсоноос хойхно , хонио хотлуулж явахдаа :

- Заа байз , тэр ирэх хүнд чинь юу ярьдаг билээ ! Надаас ер юу асуудаг юм бол ? Арай л нэгдэлд хэзээ орсон бэ ? гэж асуухгүй байгаа даа ? Тэгвэл нэгдэлд болбол орохгүй юмсан гэж

нутаг гулсан нүүж явснаа ярих болно шүү дээ . За арай ч тийм юм асуухгүй байлгүй. Зүгээр л отор хийдэг тухайгаа л ярих юм байгаа биз . Уул нь би чинь , энэ хангай нутагтаа отор хийнэ гэдэг үгийг дуулаад дургүйцэж байлаа шүү дээ. Хүн ер нь ямар ч юмыг биеэрээн үзэж байж л ухаарах юм . Хангай ч бай , говь ч бай , нэгэнт л малыг олон зуугаар нь суурилдаг болоод байгаа хойно , оторлохгүй л юм бол байдгий нь барна гэсэн үг гэдгийг би өнгөрдөг жил л мэдлээ гээд л эхлэх үү! Тэр нь л зөв байх! Нэн ялангуяа энэ бага малыг олон зуугаар нь суурилсан газар уу? Заавал л отор хийж таарна . Оторлохыг оторлов , нутаг усаа олж чадвал л үр нь гарна . Манай энэ Хөх чулуутын өврийн ам сугууд аргагүй л малтай хүний нутаг шүү . Хар л даа . Энэ уулын нөмөр нөөлөг , ус бэлчээрийг! Энэ уулын нөмөр манай хэдэн төлийг битгий хэл , нэгдлийн суурь малыг цас жавраас хаахдаа л хаана гэж ярих уу ? Ингэж ч болох юм шүү .

Манай энэ хангайхан дэндүү улс л даа . Гурван өртө хүрэхгүй шахам газар , ийм өгөөмөр нутаг байхад , энэ рүү оторлоод ирэхгүй л байгаа юм . Зарим нь оторлоно гэдгийг бууц арилжих төдийхнөөр ам хаагаад өнгөрдөг бололтой . Уул нь оторлоно гэдэг чинь малд бол яалтгүй сайн юм. Харин эзэн хүний тухайд бол тийм ч амархан ажил биш дэг ээ .

Хөхөө өвлийн хүйтэн, хар цасны жаварт эзгүй хээр тав тохь муутай бол зутарч гүйцэх бололтой юм гэж ирээд л яривал өөрийгөө дөвийлгөсөн болох болов уу? Сандаг ингэж бодсоор хонион хотлуулж, орой төлөгнүүд нь баралгүй үлдээсэн шүүг хамж бөөгнүүлэв. Чингээд аяга хоол идэхээр шовгортоо ортол , хотонд нь нэгэн төлөг хурган дуугаар цангинан майлав . Үдшээр хүн ирж , бас ч бага зэрэг сатаараад авснаа сая санав. Тэрхүү хурган дуугаар цангинагч бол « хамхуул » халзан мөнийг дуугаар нь танив . Хамхуул халзан оройнхоо үмхүүшийг ацаг алдалгүй нэхэж байгаа нь тэр .

Хургандаа, өргөхөд хамхуул шиг хөнгөн байсан тэр халзан төлөг , орой хотлох, өглөө бэлчээрлэхийнхээ үес хадны атга хөөө , тарваганы зүсэм ходоод идэж сурчээ . Сандаг гадагш гарч , жаал тэжээл хормойлон хотруугаа алхлав . Хамхуул халзанд өглөө оройных нь үмхүүшийг өгөхөд , орилоо хар хүзүүт , гувшаа хундан гээд хажуугаас нь шомбодож сурсан хэд хэдэн ч амьтан бий . Тэдэнд бас хувийг нь авчээ . Төлөг гэдэг хүүхэд шиг горьдомтгой , бас тунирхуу амьтан болохыг Сандаг хэдийн сайн мэдэх ажээ . Хамхуул халзанд үмхүүшийг нь өгөхдөө өнөөх хишиг хүртэж сурсан хэдэд хувь хүртээхгүй бол , бэлчээрт гарсан хойноо, өдөржин майлан гүйж мэднэ . Ер нь нялх амьтан болгоны хүнээс юм горьдохын агаар нэг гэдгийг Сандаг, төлгөн суурь авснаасаа хойш бүр ч сайн ухаарах болсон хэрэг. Түүнийг төлөгнүүддээ тэжээлийг нь өгөөд эргэхэд үдшийн жавар тас няс хайрч ,дээд тэнгэрт өвлийн шөнийн одод жирэв журавхийн байлаа . Хоттой хонь нь зөөлөн яраглаж , Хөх чулуутын орой хүүгэн шуугихаас өөр чимээ имээгүйхэн байтал , хойт шил хадны чигтэй , үнэг гаагалах мэт дуугаруут хоёр нохой нь яаж дуугүй байхав гэсэн шиг дурамжхан хөв хөв хуцав .

Нэг муу анчин гавар үдэш бүхэн тийн дуугардгийг хоёр нохой нь бас эзэн шигээ сайн мэдэх болсон ажээ .

Сандаг өдрийнхөө утаж алсан ганц мануулыг эд бад хийх, энээ тэрээ гэсээр мичид марал дээр хөөрсөн хойно хэвтсэн авч , нойр нь сэрвэлзэн , дэг дуг гэсээр нэлээн уджээ .

- Очиж очиж надаар яах нь вэ ?

- Бурхангүй газар бумба галзуурна гэгчийн үлгэр болж байна уу ?

- Тийм л болж байна .

- Зовмоор юм .

- Одоо яая гэхэв . Нутгийнхаа нэрийг бодохоос биш .

- Зун ч бай, өвөл ч бай . Нэгэнт л малыг олноор нь суурилдаг болсноос хойш , отор хийхгүй юм бол нэг л цагт муугаа үзэж таарна . Би энэ л бодлын учир энд ингэж явна шүү дээ . Тэр ирэх хүнд өөрийнхөө энэ бодлыг гайгүй сайн яриад орхих уу ? Энэчлэнгээр эргэцүүлсээр хэвтсэнээ , ашгүй нэг мэдэхэд , овоо дуг хийгээд авсан байв .

Галын захад орхисон хувинтай ус час часхийн хага хөлдөж буй чимээ тов тодхон дуулдах нь үүрийн жавар чангарч буйн тэмдэг гэдгийг хоньчин сайн мэднэ . Төдөлгүй бууцны хөл рүү үхэр оготно дуу дуугаа авалцан шивших мэт дуугарч эхлэх нь ч мөнөөхөн үүр тэмдгэрч байгаагийн дохио болой .

Сандаг азарган нэхий дээл нөмрөн гадаа гарч , од сар , тэнгэр хангайн байц ажиглан сэм сэм алхлан явсаар « морь хараад » эргэхдээ хэд ахин хий хий ханиалгав . Чингэхэд нь өвсний хашаан дахь морь нь аяархан шилгээж , морины нь хөлд хөлдүү хомоол тор тор торжигнож дуулдав .

Өмнө тэнгэрийн хаяа гал улаанаар хярхаглаж , шөнийнхөө дүнд анир чимээгүйхэн болсон Хөх чулуутын оройн мод хүүгэн шуугиж эхлэх нь өөрийн жавар салхин , их хөвчийг нойрноос нь сэргээв бололтой .

Бага үдийн алдад , бэлчээрт хөнгөн тэрэг давхин ирэв . Орлогч дарга нь , зураг авдаг юм энгэртээ санжгануулсан , шарангуй залуу эрийн хамт явна . Залуу эр , Сандагаас :

- Хэдийд оторт гарсан , хэд нүүгээд байна . Хэдэн хоньтой вэ ? Хэдэн тонн өвс тэжээлтэй вэ ? гэж баахан тоо тэмдэглэж аваад , харандаа цаасаа далд хийнгээ , цаг руугаа хараад :

- За , Та одоо морин дээрээ морддоо . Зургийг чинь дарна . Сонинд тавина гэж богино богино өгүүлбэртэй үгийг хойно хойноос давхцуулав .

Сандагийг мордон , хониныхоо цаад захаар орж явахад, залуу эр , хониных нь нөгөө талаар чөрөг чөрөг шогшин , байн байн явган сууж , үе үе урагшаа хойшоо эрэгцэн , зогтусам явснаа , Сандагийг хүрээд ир ! гэж даллав . Сандагийг дэргэдээ очтол :

- Ахаа таны наад уурга яасан сүргүй юм бэ ? Иш-ш , хангай газар байна даа ! хэмээн илт голонгуй аясаар үглээд , мөрөө хавчгасхийлгэхэд , Сандаг :

- Энэ шилбүүр үү? гэж амандаа сулхан гүнгэнэхэд , залуу эр:

- Тийм ээ ! Уртхан шиг...! гэж хэлээд, мөнөөхөн хоёр гараа сарвагасхийлгэн , дал мөрөө хавчгасхийлгэхэд , мөнөөх зураг авдаг юм нь тархийн , энгэрийнх нь товчийг хавиран

санжигнахад , Сандагийн хонины хээрийн чих хулмагасхийн биеэ хураан үргэхчээ аядав. Сандаг морио хөтлөн явсаар, нэгэн сахлаг довны өвөрхөнд очин., морио амгайвчлан тавиад, бараа нь улам улам жижгэрсээр буй хөнгөн тэрэгний хойноос ширтэн :

- Уул нь. Ах аа ! Ах аа- гэж гүйж ниссэн хөөрхөн аашгай хүү юмсанж. Харсаар байтал царай нь хөөхөр оргин цонхийгоод лав орон суурин газар өсч өндийсөн байж таарна хэмээн болгоож суув . Тийн суутал , дэлхэн идээшилж байсан сүргийн нь тэндээс хурган дуу цангинан, бодлыг нь таслав. Тэр бол өнөөх хургандаа цадтал хөхөөгүй хамхуул халзан мөн болохыг хоньчин дуугаар нь андахгүй танина.

СОРГОГ ХҮМҮҮС

7-р сарын сүүлчээр юмсанжээ. Үдшийн орсон ширүүн бороо зүсэрч , гудамжинд хүний хөл татарчээ .

Цагдаа Түмэн бүтэн гурван цагийн турш хувиарт газраа эргээд Ерөөгийн 1-р гудамжны зүүн үзүүрийн сүүдэртсэн догол дахь нэг хашааны үүдэнд амсхийхээр ахархан жижиг сандал дээр суулаа .

« Ерөөгийн 9 тоотыг анхааралдаа ав !» гэсэн нэмэлт үүргээ бодож суугаа цагдаа Түмэн өврөөсөө тамхи гаргаж нуусхийж асаагаад галыг нь ханцуйдаа далдлан хаа нэг сорж , эргэн тойрноо ажиг анир чагнав .

Зүсэрсэн борооны усан дуслууд хэлхээ татан бууж, хурын дусал тунаруулсан газар л мэлгэр хөх усан дүрс дээгүүрээ агриа мяралзуулах нь балар харанхуй шөнийг арай ядан гийгүүлсэн чийдэнгийн сүүмгэр гэрэлд тунаран харагдаад Түмэнд балчир багынх нь явдлыг өөрийн эрхгүй санагдуулжээ .

Тэр жил би сургуулийнхаа зуны амралтаар хөдөө гэртээ хариад нэгдлийн адуучин эцэгтэйгээ яг ийм шөнийн зүсэрсэн бороонд шавшуулж Дэрстийн хөндийд адуу маналцаж билээ .

Аав бид хоёр тэр дүнсгэр шөнийн гүн харанхуй дундуур адуугаа зогсоо зайгүй эрэгсээр үүр гэгээрмэгц би адуугаа зүүн жигүүрээс нь хумьж эхлэв .

Хатирт борлог минь ёстой л дөмөлзтөл хатирдагсандаа. Идэр залуу наснаасаа өвгөн буурал болтлоо малын дэргэд байсан аав минь адуугаа баруун талаас нь исгэрэнхэн эргүүлэхэд аавы минь тэр исгэрэлттэй ижил дасал болсон адуун сүрэг маань эзнийхээ санасан бодсоны нь мэдсэн юм шиг үүрсэн янцгааж хариулах нь ээрэм талын гүн харанхуй шөнийг чухам л амьдруулах шиг санагддагсан гэж Түмэн хөдөөх газар өнгөрүүлсэн балчир багынхаа амьдралыг янз янзаар дурсан бодож суулаа .

Гудамжны баруун үзүүрээс мотоциклийн гэрэл сүүмэлзэн ойртсоор түүний хурц цайвар гэрэл нь нэгэн юм эрэх хайх шиг Түмэнгийн дэргэдүүр чичигнэн тэнүүчилж эхэллээ .

Түмэн цувныхаа юүдэнг духруугаа дарж малгайныхаа саравчийг далдлаад мотоцикльтэй хүний хажуугаар өнгөрөх маягтай жирийн хүний байдлаар алхлав .

Шөнийн 1 цаг хагасын яндан дуугарч , гүн харанхуй шөнө, шуугисан цасан шуурга, шаагисан ширүүн бороо, исгэрсэн догшин салхинд ч тордоггүй энэ хүнгэнэсэн цовоо дууг сонсоод сэтгэл нь хөдөлдөггүй тийм хүн ч байдаггүй биз !

Яндангийн цээлхэн дуудлагаар сэтгэл нь хөдөлсөн Түмэнд юм бүхэн шөнийн харанхуй дундаас цэлсхийн харагдах шиг болжээ .

Нөгөө хүн Түмэнгийн өөдөөс ирж явснаа мотоциклио хүд... хүд ... хийлгэн эвгүйхэн дуугаргаад хашааны сүүдэрт зогсчихов .

- Аа золиг доо чамайг , бас л унтарчихлаа гэж нөгөө хүний хараах нь Түмэнд сонсогдлоо .

Хожим хэрэг болж юу магад , зөрөнгүүт номерыг нь хараад өнгөрье байз гэж санаад нэлээд ойрттол нөгөө хүн багажныхаа хайрцагнаас даавуун ууттай түлхүүрүүдээ гаргаж урд номер дээгүүрээ бөгрөөд мотор руугаа тонголзож Түмэнг зэрэгцэж ирмэгц ,

- Уучлаарай хүн гуай ! Та шүдэнзтэй бол өгөөч , би энэ рүү нэг юм хараад орхиё гэхэд Түмэн аргагүй л дэргэд нь ирж ,

- Чүдэнз бий л юмсан гээд өвөр дэх чүдэнзээ эрэнгүүт мотоциклийн номерыг сэм ажиглалаа .

Урд номер дээгүүрээ багажныхаа уутыг тохож , арынх нь номер шавар будагдсан учраас чухам хэдэн номертой мотоцикль вэ ? гэдэг нь Түмэнд мэдэгдсэнгүй .

Аа ... « М - 72 » байна шүү! Тэгээд хажуугийнхаа суудлыг авчихаад явж байгаа хэрэг үү. Тэгнээ даанч дуу нь нэг л зөөлөн байсан юм гэж бодсон Түмэн ,

- Яаж орхио вэ ? гэж дэмий л асуугаад нүдэндээ салхины том гэгчийн шил зүүсэн тэр хүнийг ажиглалаа .

Бороотой бүрхэг шөнийн чийдэнгийн бүдэг гэрэлд тэр нь ямар шүү царайтай хүн болох нь Түмэнд бас л танигдсангүй .

- « Гамтай эдэлбэл зүгээр болохоос ондоон , уг нь гамгүй эдэлчихсэн юм чинь байсхийгээд л таг болчих юм . « Та чүдэнзээ зураад гэрлийг нь энэ рүү тусгаад өгнө үү!» гээд нөгөө хүн мотор руугаа заагаад байз уу! надад чинь зүлгүүр ... гээд энгэрийнхээ жижиг савыг уудлав .

Түмэн чүдэнзээ зурлаа . Мотоциклийн арынх нь суудлын дугуй бариулыг хагас ороосон гялтганасан хөх өнгөтэй эд нүдэнд гялс хийж харагдаад тэр нь нэг үзүүрээсээ салбайн урагдсан юм шиг харагджээ .

Нөгөө үл танигч хүн чүдэнзний гэнэт бадарсан гялбам хурц гэрлийг завдан ашиглаж Түмэнгийн нүүр өөд гэнэдүүлэн цохилоо .

Түмэнгийн нүднээс гал бутрах шиг болж , хөл дээрээ арайхийж тэнцтэл нөгөө хүн хутгаа гялс хийтэл далайлаа .

Түмэн хутгатай гарын тохой руу алгадлаа , хутга нь тор ... гээд газарт унажээ .

Нөгөө хүн хутгаа алдмагц Түмэнг шууд зууран барьж хүчээр гэдрэг нь түрлээ. Ямар нэг мөлгөр бөөрөнхий юм гутлынх нь өсгийд тээглэж тэнцүүрээ алдмагц Түмэн дотроо сэхээ авч гэдэргээ унангуутаа дайснаа өөр рүүгээ хүчтэй дугтран эргэж дороо хийлээ .

Гэвч хүчээр давуу нөгөө хүн Түмэнгийн зүүн мөр рүү нь ёврон эргүүлээд дороо хийж багалзуудаж авлаа .

... Мотоцикль ... Мотоцикль ... бариарай , тэр арынх нь бариулыг гялгар хөх эдээр бүрчихсэн мотоцикльтэй хүнийг ... Аа ! цус ... тэр суудлаа авчихсан М-72 - той хүнийг ...

Түмэн халуундаа дэврээд урд шөнийхөө болсон явдлыг ярьж байгаа бололтой гэж өвөр дээрээ бичгийн хавтас тавиад Түмэнгийн дэргэд суугаа сэргийлэхийн ахмад Гарьд Түмэнгийн тас аньсан нүд , чинэрсэн нүүр рүү нь ширтжээ .

Сувилагч Жаргал хараагаа Гарьд өөд аажимхан шилжүүлж , тийм байна , Шархныхаа халуунд дэмийрч байна .

Эгэмний нь дор сүрхий гүн хутгалсан юм билээ гээд Түмэнгийн суганаас халууны хэмжүүр авлаа .

- Аль вэ ? халуун нь ...

- 40 байна , түрүүнд 41 байсан юм . Тарианууд хийлгээд халуун нь буурч байх шив гэж сувилагч Жаргал хэлэв .

Өвчтөнүүд дэмий л бие бие рүүгээ харан Түмэнгийн огцом хүнд амьсгалыг чагнан дув дуугүй хэвтэцгээж , зарим хөнгөн өвчтөн нь орон дээрээ босоод суужээ .

Түмэн амь тэмцэн зууралдаж байсан илий балай бодлоосоо хагацаж ядсаар бараг хориод минут боллоо .

Сувилагч хүүхэн Түмэнгийн хөлийнх нь уланд тавьсан халуун жинг заслаа.

- Цус их алдсан , халуун ихтэй байна . Гэвч гайгүй удахгүй тэнхэрнэ гэж эмч Гэпэлмаа хэлж байна билээ гэв. Гарьд толгой дохиод өөр үг хэлсэнгүй , гараа элгэндээ зөрүүлж суудлаа засасхийж суугаад Түмэнгийн үе үе өмөлзөж байгаа уруулы нь , байн байн татвалзан хөдөлж байгаа өтгөн хар хөмсгий нь ширтлээ .

Хүмүүс Түмэнг ширтсээр , тасалгаанд удтал нам гүм байв .

Түмэн хоолойгоо хэржигнүүлэн их л зовиуртайгаар санаа алдаад гар нь чичигэнэн хөдөлж уруулаараа ямар нэгэн юмны амтыг үзэж байгаа юм шиг тамшаална .

- Одоо халуун нь улам саарч байх шиг байна . Удахгүй ухаан орно гээд Жаргал, барьж байсан халбагаараа жимсний шүүс хутган ам руу нь цутгав .

- Уг нь золбоотой л хүнсэн , харин урд шөнө л сүрхий гэнэджээ гээд ахмад санаа алдав .

Түмэн, эдний яриаг там тум сонсож эхлэв. Нүдээ нээх гэж оролдлоо. Дээрээс нь ямар нэг бөөн цагаан юм дараад байгаа ч юм шиг , тэр нь давчдан манарсан бодлоос нь нэг л салж өгөхгүй , харин уруулы нь ямар нэгэн хүйтэн юмаар жигнэн , хоолой руу нь сэрүү татаж ,

дотор нь нилээд уужрах шиг болж , ам руу маань уух юм орж байна даа гэж мэдлээ .

Түмэн нүдээ үл мэдэг нээмэглэснээ дахин анилаа .

- Та намайг харж байна уу ? гэж Жаргал асуув . Түмэн дахин харах гэж оролдоод чадсангүй , харин Жаргалын зөөлөн хонгор дууг сонсож , миний дэргэд ээжийн минь дуу л сонсдож байна уу даа гэж бодно .

Түмэн хөдлөх гэж үзлээ . Чадсангүй , би чинь хаа байна даа ! эрүүл байна уу ? үгүй юу ? гэж бодлоо .

- Одоохон сэргэнэ гэсэн түрүүчийн зөөлөн элбэрхүү дуу Түмэнд дахин сонсдож нүдээ тогтуухан нээлээ .

Жаргал Гарьд хоёр өөд өөдөөсөө харж , хоёулангийн нь нүүрэнд баярласны шинж тодорлоо . Өвчтөнүүд ч бие бие өөдөө харж шивэр авир ярилцав .

Хилэн шиг зөөлөн хар үсээ цагаан алчуураар эвтэйхэн даруулж зангидсан усгал намуухан харцтай Жаргал өөд Түмэн хэсэг гөлөрч байснаа ,

- Би чинь ... хаа ... байна ... даа гэж чичигэнэсэн тасалдангуй дуугаар шивнэх шахам асуув .

Жаргал халбагаар жимснийхээ шүүснээс дахин өгөөд ,

- Та эмнэлэгт хэвтэж байна! Бие чинь ямар байна гэв . Түмэн хараагаа Гарьд дээр арайхийн шилжүүлээд

- Ахмад аа ! гээд өндийх гэж оролдов .

- Хүүе болохгүй ! гэж Жаргал тэвдэнгүй хэлээд хучлагаар нь дарлаа .

- Битгий хөдөл , түргэн шиг эдгэрээд гарахыг бод ! гэж Гарьд хэлэв .

Түмэн эмнэлэгт хэвтэж байна гэдгийгээ мэдэж, зүүд зэрэглээ шиг бүүр түүр байсан өнгөрсөн шөнийн нь явдал дээр дээрээсээ замбараагүй давхцан санагдаж ,

- Танд илтгэх зүйл гээд дахин өндийхөд ахмад Гарьд ,

- Битгий хөдөл ! Тогтуухан ярина уу ! Гэвч бие чинь ...

- Ярьж чадна , бүүр сайн ярина гээд Түмэн амьсгалаа уртаар авлаа .

- Гэмт этгээд мотоциклийнхоо хажуугийн суудлыг хийлгүй унаж , урд хойт номероо Түмэнгээс нууж амжжээ . Харин « Гамтай эдэлбэл зүгээр болохоос ондоон уг нь гамгүй эдэлчихсэн юм чинь байсхийгээд л таг болчих юм » гэж Түмэнд ярьсны нь нээрээ ч Өвөрхангайн хүн болох нь гээд ахмад Гарьд Түмэнгийн тодорхойлолтыг уншуулангуутаа өврөөсөө чүдэнз гаргаж таамгаар зураад аман дахь тамхиа их л дадамгай асаалаа .

- Ахмад Гарьдын илтгэлийг сонсож , тэмдэглэл хийж суугаа хошууч Сүх ,

- Анхаарууштай ноцтой сэжиглэлүүд байна даа , тэгээд ...

- Тэгээд Түмэн гэмт этгээдийн мотоциклийн арын суудлын дугуй бариулыг зөөллөж , гялтганасан хөх өнгийн эдээр ороосны нь чүдэнзнийхээ анхны гэрэлд харж амжжээ. Тэгэхдээ тэр ороосон эд нь нэг үзүүрээсээ салбарлан урагдсан юм шиг санагдсан гэж Түмэн ярилаа гэж Гарьдыг үргэлжлүүлэн ярихад Сүх ,

- Түмэн , гэмт этгээдэд гэнэдэж цохиулсан ч гэсэн үнэн хэрэг дээрээ хэргийн талаар бараг хүрэлцэхүйц баримттай хоцорч алдсан алдаагаа нөхжээ. Тэгэхээр хэрэг нэхэмжлэгч Дорлигийн үлэмжхэн эд хөрөнгийг хулгайлсан хэргийн сэжиг Оргийнхоос илэрч болох юм гэж бидний тааварлаж байгаа сэжиглэл , Түмэнгийн тодорхойлолтоор дахин батлагдлаа .

Учир нь « М 72 » -ын тодорхой биш мөр ... гээд хошууч шүүгээнээсээ хавгастай хэрэг гарган ,

- Эзэн нь энэ дээ гээд хавгсаа нээв .

-Эршүүд шийдмэг зантай хошууч Сүхийн давхраагүй уужим нүд , гонзгойвгор хөх нүүр рүү нь ширсэн суусан ахмад Гарьд ,

- Үгүй энэ чинь юун бүч вэ ? гээд ногоон даалимбийг их л нямбай тасамдан имхэрдсэн бүчийг ажив .

- Энэ бүч угзарсан ч гэсэн тасарчихамгүй сонин баримт шүү, бид таныг Түмэнтэй цуг явуулчихаад уг хэргийг үүдсэн газар дээрээс нь олсон юм гээд хошууч инээмсэглээд манай анхааралд байгаа Оргийн суудаг гудамжинд энэ хэрэг үүджээ .

Шөнийн ээлжинд явсан Оргийн ажлаасаа буусан цаг , уул хэргийн үйлдсэн цагтай нэлээд ойролцоо байгаа нь бүүр ч сэжигтэй хэрэг .

Энэ бүх сэжиглэлүүдийг баталж өгөх гол баримт маань энэ бүч дээ гэж үргэлжлэн ярив .

- Тэгээд ч гэмт этгээд Түмэнд өөрийнхөө байрыг сэжиглүүлэхгүйн тулд шийдсэн аргаа хийжээ. Ингээд Орги 2 дахь удаагийнхаа хэргийг үүсгэжээ . Гэвч Орги мотоцикльтой гэдэг нь мэдэгдсэн хэрэг болохоор ... гэхэд хошууч ахмадын үгийг тасалж ,

- Мотоцикльгүй ч гэсэн Орги өнгөрсөн шөнө мотоцикльтой явсан байж болох юм . Харин Оргийн мотоцикль унаж чаддаг эсэхийг нь шалгана . Ер нь Орги энэ хэрэгт шууд холбогдохгүй ч гэсэн шууд бусаар эрх биш хамаарагдах нь зайлшгүй . Учир нь манайд авагдсан мэдээгээр Оргийнд мотоцикльтой хүмүүс орж гардаг боллоо гэснийг санах хэрэгтэй .

Тэгээд Оргийн эхнэрийг ажилдаа очих замд нь тосч сэм авчруулахаар нарийн бичгийнхээ даргыг жолоочтойгоо явуулчихсан. Энэ зөв үү? гээд хошууч Сүх , төв даруу зантай ахмад Гарьдын нүд дүүрэн дугуй цагаан нүүр өөд нь эгцлэн харахад ахмад Гарьд :

- Зүйтэй та тэр хүүхний зургийг өгч явуулан биз дээ гэв .

- өгсөн , өгсөн .

- Хаалга тогшлоо . Нарийн бичгийн дарга эмэгтэй , Оргийн эхнэрийг оруулж ирээд гарав .

Ахмад Гарьд Жаргалд сандал тавьж өгөөд ,

- Нэр чинь хэн билээ , хаа ажилтай вэ ? гэж асуулаа .

- Миний нэр Жаргал, Төв больнизад сувилагчийн ажилтай гээд нүдээ бүлтэгнүүлэн ахмад Гарьд руу ширтэв. Жаргал бусдад хутгалуулж хэвтсэн цагдаа Түмэнтэй очиж уулзсан ахмад маань байна гэж Гарьдыг харуут таньжээ .

Хошууч Сүх суудлаа засасхийж суугаад Жаргал өөд хараагаа намуухан тусгаж ,

- Би танаас өөрийн чинь мэддэг хамгийн ойрын зүйлүүдийг лавлаж мэдье гэсэн юм. Тэгээд ч таны нөхөр Оргийг сайн таньдгийн хувьд найдварлаж , таныг манай ажилд эрхбиш тус хүргэх болов уу ? гэж санасан юм гэж хошуучийг хэлэхэд Жаргал ,

- Бололгүй яахав харин ажлынхаа газарт ...

- Зүгээр, зүгээр зовох хэрэггүй, даргад чинь албан ёсоор жич мэдэгдэнэ гэж ахмадыг хэлэхэд Жаргал ,

- За тэгвэл яахав гэлээ .

Сувилагч Жаргалын үргэлж инээмсэглэж байгаа юм шиг шармагдуу нүүр , давхраагүй бүлцэн нүд рүү нь ширтэж суусан Сүх ,

- За тэгээд Оргийн бие нь сайн , ажил нь амжилттай биз дээ ! гэж асуулаа .

- сайн сайн гээд «хамгийн ойрын мэддэг зүйлээс чинь гэнэ шүү» юуны тухай юм болдоо гэж Жаргал гайхан бодож суув .

- Орги маань шөнийн ээлжинд явж байгаа юу ? аль өдөр үү?

- Шөнийн ээлжинд .

- Би Өвөрхангайд ажлаар явах замдаа Оргитой тээр жил танилцсан юм . Аль сумынх гэлээ байз !

- Өндөр - Өнц сумынх

- Нээрэн тийм л дээ . За тэр ч яахав . Орги уржигдар надтай энүүхэн урд дайралдсан юм , ажлын ногоон хувцастай л явж байна билээ гээд хошууч унтарсан тамхиа дахин асаав .

Эд чинь Оргийг ямар нэг хэрэгт хардаж байгаа юм биш биз гэсэн сэжигтэй сэтгэгдэл Жаргалын санаанд аяндаа орж , за байз ... уржигдар Орги гэрээсээ гараагүй шөнөжин архидаад, өдөржин унтаж өнжсөн шүү дээ . Тэгээд ажлын ногоон хувцастай ч гэх шиг гэж бодсон Жаргал ,

- Орги уржигдар гадагшаа гараагүй , та андуурч байна . Ер нь Оргид тийм хувцас байхгүй гэж уцаарлан хэлэв .

- Та битгий уцаарла яах ч аргагүй ногоон хувцастай л явсан даа гэж хошуучийг мэтгэнгүй хэлэхэд Жаргал царайгаа улайлган ,

- Хашаанаасаа ч гараагүй хүн тантай дайралддаг нь сонин юм даа гэж хэлэв .

- Тэгж яривал бас гэрч баримттай шүү. Оргийг мотоцикльтой хүний ард суугаад явж байсан байвал та яах вэ ?

- Тэгвэл тэр чинь уржигдрын хэрэг биш , хэдийд ч юм бэ ? Гомбо Цоодол хоёрын нэгтэй явж байсны нь уржигдрынх болгож та андуурч байгаа байлгүй .

- Андуурсан ч байж болно . Би уржигдар л дайралдсан шиг санаж байна . Тэгээд Орги яах ч аргагүй ногоон хувцастай явсан юм . Тэгвэл Гомбо Цоодол хоёр мотоцикльтой юм шив дээ .

- Тиймээ .

- Тэгээд танай нөхөр , тэр хоёртой ижилхэн ногоон хувцастай юм гэж үү? гэж Гарьдыг асуухад :

- Тийм ижилхэн , надаар оёулсан юм чинь тэрнийгээ даанч мэддэг байгаа даа гээд Жаргал ахмад Гарьдыг зэрэвсхэн хараад ширэв татлаа .

- Гомбо , Цоодол хоёр хаа ажилтай юм бэ ? гэж ахмадыг асуухад Жаргал ,

Цоодол нь лав Хотын худалдаанд ажилладаг юм . Харин Гомбыг нь сайн танихгүй , их л боловсон , зан ааш сайтай хүн харагддаг юм гэв .

Хошууч Сүх ахмад Гарьд руу нуусхийн нүдээ ирмээд Оргид холбогдсон хэргийн хавтсыг өмнөө тавиад ,

- Бодвол та Цоодол Гомбо хоёрын ажлын хувцсыг хийхдээ ижилхэн өнгийн утсаар оёсон юм байгаа биз дээ ?

- Би санахгүй байна . Ер нь юу болоод намайг хоргоогоод байна даа ойлгохгүй байна .

- Гэрчлэх, тодорхойлох эрхтэйн чинь хувьд таны мэдэж байгаа асуудлыг тодруулах гэсэн юм , хэрэгтэй бол та өөрийгөө өмгөөлж ч болно шүү дээ .

- Гомбо Цоодол хоёрын хэн нь билээ мотоциклийнхоо бариулыг цувны хөх эдээр ороосон

чинь ?

- Аа мэдэхгүй ажиглаагүй .

- Энэ удаа асуултаа завсарлая гээд Гарьд , Жаргалын тодорхойлолтын хойно ямар нэгэн юм нэмэн бичиж эхлэв . Эхлээд л Оргийн тухай асуугаад сүүлд нь Гомбо Цоодол хоёрын талаар ... үгүй энэ чинь юу болох нь энэ вэ ? Би тэдэнд хуцас оёод өгчихсөн маань хуульд ямар буруу үүсгэдэг билээ .

Энэ ахмад чинь , хүнд хутгалуулж шархадсан Түмэнг эргэж очсон , тэгэхэд Түмэн гялгар хөх эдээр бариулыг нь бүрсэн ч гэх шиг ... их л юм яриад байсан. Би Түмэнг халуундаа бас л дэмийрч байна даа гэж бодсон маань асуудал шал өөрөөр эргэчих шивдээ. Гэсэн ч би муу юм хийгээгүй. Түмэн хэнд ч хутгалуулсан юм , би яаж мэдэхэв дээ гэж Жаргал гайхан боджээ .

- Танд асуулт байна уу ? гэж хошуучийг шийдэмгий хэлэхэд Жаргал нэлээд бодож байснаа ,

- Алга шив дээ гэв .

- Харин та манайд тодорхойлолт өгснөө хэнд ч мэдэгдэж болохгүй. Наадхаа сайн уншаарай гээд өөрийнх нь тодорхойлолтыг өгөв . Жаргал уншиж үзээд гарын үсэг зурлаа .

- Баярлалаа бүсгүй минь гэж хошууч , Жаргалд тал өгөөд Жаргалыг нарийн бичгийнхээ даргын өрөө хүртэл үдэж, энэ бүсгүйг ажил дээр нь хүргэж өг гэж жолоочид хэл гэв .

Оргийнх өглөөнөөс хойш их л наргиан шуугиантай гэвч хөл үймээн багатай байлаа. Гэрийн хоймор , жижигхэн явган ширээний гурван талд Орги , Цоодол , Гомбо гурав тухлан суугаад жүнзтэй архиа их амтархан шимцгээж , ямар нэг шалиг дууны аяар эвгүйхэн гиншицгээнэ .

Жаргал жижүүрээсээ бууж ирээд гал зуухныхаа ажилтай зууралдаж өдөржин архичдад хоол цай чанаж аягалсаар ядарсандаа нүд нь нуухтан, зуухныхаа аман тушаа суужээ .

- Ай Гомбоо манай эхнэр муу найзыг чинь дүүгүүрдчих гээд байгаа шүү дээ. Өчигдөр ... гээд Оргийг зогисуулахад Гомбо , Цоодол хоёр,

- За тэгээд , тэгээд гэцгээв .

- Цагдан сэргийлэхэд дуудагдаж үл ойлгогдох зүйлүүдэд асуугдахдаа харсан, далдын ид шидээр бий болсон юм шиг ер бусаар гарч ирсэн тэр бүчний тухай, Орги, Цоодол, Гомбо нарын талаар олныг бодож суусан Жаргал Орги руу харж , надад дөвгүүрдүүлэхээсээ саар нөхдийнхөө далдын мэхэнд автагдаад амьдралдаа дөвгүүрдүүлэв дээ гэж хэлэх гэснээ ,

- Битгий дэмийрээд байгаарай гэж хүйтнээр хэлэв .

- Аа тийм үү? Өчигдөр үдэд шинэхэн ногоон портод суучихаад хажуугаар минь сүнгэнэдэг чинь та мөн биз гэж Орги уурсангуй хэлэв .

- Чи өөрийгөө л хичээ ! наадхи гашуун уснаасаа ангижрахгүй бол чамтай амьдарна гэхэд бэрх

л байна гээд Жаргал, хошууч Сүхийн тэргээр хүргүүлж явсны минь , мань хүн харжээ .
Намайг хэнд ч хэлж болохгүй гэж хэлсэн , за байз яаж аргалья даа гэж боджээ .

- За тэр ! ингэж ярьдаг хүн дээ . Үгүй тэгээд очиж очиж тостой хар жолооч шүү тэр нь , болсон зохисон амьтантай нөхөрлөж дээ .

- Тэгээд чи Оргиос салах нь уу ? Аль яах нь вэ ? Энэ хүүхнүүд ийм л илүү харж , билүү долоох улс шүү гэж Гомбо өлгөн авч хэлэв .

- Оргио оо ! чи андуураагүй биз ! Жаргал ч тийм ч хүн биш дээ гэж Цоодолыг хэлэхэд Орги ,

- Очиж очиж эхнэрээ андуурав гэж дээ . За яамай өөрөө л мэддэг гэв .

- Аа мэдэхгүй залуу бүсгүй багынхаа авьяасыг сэргээгээ биз гэж агсрах өө эрсэн Гомбо шүлсээ үсчүүлэн хэллээ .

... Орги минь аяга тагш юм уухаараа ингэж илүү үг ярьдаг аа больж үз . Бас тэгээд хүн гөрддөг нь юу вэ гэж Жаргалыг хэлэхэд Орги ,

- Гөрдөө ч үгүй хө ! Харин чи л намайгаа сэгсэрчих нь дугаад байгаа байх гэв .

- За битгий дэмийр ! Чи архинаас болж аашаа эвдэж байгаагаа мэдэж байна уу ? нийлсэн нөхөд чинь энэ . Ээ дээ чиний ингэж байдаг чинь эз үү? аз уу ?

- Наадх илүү үг, илүүрэн хушуугаа тат , эрчүүд олсноо идэж ууж байна . Бидний энэ чамд ер хүртээлгүй « эрийн муу нь цагдаа , эмийн муу нь сувилагч » гэгчээр чи зүгээр Оргийн олсныг идчихээд л хөнжлийнхөө хирээр хөлөө жийж хэвг гэж Гомбо хөндлөнгөөс нь хамар амаа татвалзуулан агсрав .

- За яршиг Гомбо минь эр эмийн хооронд чи бид хоёр шиг нь жороолдоггүй юм . Ам хэлээ тат гэж Цоодолыг хэлэхэд

- За чи нэг их саваагүй хүүхнийг өмөөрч... гээд Гомбо хэхэрч түүнээсээ болж зогьсуулав .

« Эрийн муу нь цагдаа , эмийн муу нь сувилагч » гэж зарим хүмүүс юунд хөдөлмөрийг ингэж хар цагаан гэж ялгадаг юм бол! гэж бодож суусан Жаргал

- Гомбоо! чамайг ухаан алдталаа архи уугаад гудамжинд хөндлөн хэвтэж байхад чинь хэн чамайг машины замаас зайлуулж амийг чинь хамгаалдаг билээ .

Чамайг ингэж ногоортлоо уугаад хээр уначихаад хөл гараа хөлдөөчихвөл чинь хэн чамайг сувилах билээ. Энэ ч наад захын хэрэг шүү гэж цухалдан хэлэхэд Гомбо ,

- Цагдаа та хоёроор энхрийлүүлтэл хаа ч юм бэ ? зай ч бий , лай ч бий гэв .

- Муу хүнд үг бүү хэл ! Мухар үхэрт худаг бүү үзүүл ! гэгч л болох нь ээ гээд Жаргал зуухандаа түлээ нэмэв .

- Эхнэр минь , Гомбо минь маргалдахаа больцгоо , эхнээр! энд суу! ганц хундага юм балгачих гээд Орги , хундагатай архиа цалгиулан Жаргал өөд сарвайхад ,

- Чи л өөрөө эвдэрч байгаа аашаа архиар хужирлаж суу ! гэж Жаргал тачаадан хэлэв .

- Үгүй ер , мэргэн түргэн , цэцэн чамин үгтэй хонгор минь ! Дахиад хэлээд орхи , за хэл гээд Гомбо шүдээ хяхнуулан хавирч хөмхийгөө зуув .

Жаргал , Гомбод дахин үг хэлсэнгүй гарч түлээ хормойлж суухдаа мотоцикль дээрээ бөгтөрсөн Цоодолын тос болчихсон ажлын хувцсыг харж , аа тийм Цоодолынхыг ижил өнгийн утсаар , Гомбынхыг хар утсаар оёсон юм.

Хэргийн баримт болж олдсон хошуучийн хавтсан доторхи тэр бүчийн учир утга ... цагдаа сувилагч хоёрыг үзэн яддаг Гомбын маань далдалсан хэргийн гогцоо гараад ирэх шив гэж бодоод Жаргал, түлээгээ хормойлоод мотоциклиудын дэргэд очлоо .

Цувны хальслаг хөх эдээр бүрсэн Гомбын мотоциклийн арынх нь дугуй бариул нүдэнд нь туслаа .

Цагдаа Түмэнтэй холбогдсон хэргийн этгээд Жаргалд бүр ч тодорхой боллоо . Урагдаж тасарсан үзүүрий нь эвтэйхэн даруулж бөхөлсөн энэ хөх эд ... « Сайхан дээл өмсөөд савласан эрдэмгүй бол зураг шиг » гэгчээр Гомбо Өдрийн ганган, шөнийн дээрэмчин байжээ . Ээ дээ хуурмаг бялдууч зан , ховдог зальхай сэтгэлийг бий болгогч өнгө, мөнгө хоёрын ерийн өнгөцхөн байдалд гэнэхэн хууртагдах бий гэдгийг хүн үргэлж санаж явууштай юм гэж бодсоор Жаргал гэртээ оронгуут хормойлсон модоо хайрцагт хийгээд , ширээнийхээ цагийг сэм гүйлгэж 5 цаг хагас болгоод хувцаслаж эхлэв .

- За энэ чинь хаачих гээд хувцаслаж гарав даа гэж Оргийг асуухад Гомбо ,

- За хонгор минь тогтож хайрла ! Энэ айлаас, Оргий минь орхиод явчих гэж байгаа юм биш биз гэж хөндлөнгөөс нь дооглонгуй асуув .

- Хүүхдээ цэцэрлэгээс нь авчирдаг байгаа даа .

- Уучлаарай хатагтай минь гээд Гомбо шүднийхээ зайгаар шүлсээ год хийтэл хаялаа .

Орги ширээнийхээ цаг руу харснаа :

Баларч хоцор гэж дээ өнөө ажлын цаг аль хэдийн өнгөрөөд орхижээ , за байз яадаг билээ . Яах вэ эхнээр !

- Эрээлжилсэн нүд , өмхий ам хоёроороо гайхуулах гээгүй бол чи ажилдаа очоод юу бүтээх вэ ? гэж Жаргал Оргийг зэмлэв .

- За дүүрсэн хэрэг , ганц өдрийн ажил таслахаас биш , чи минь хүү рүүгээ явж үз , харин замдаа ганц хоёр шил юм аваад ирээрэй гэж Оргийг хэлэхэд Цоодол , Гомбо хоёр ,

- Уугаад байя гэцгээв ,
 - Та нар ууж байснаас дэвтэж байсан нь дээр ! наадхи лонхтой архин дотроо орчих гээд , Жаргал гарч одов .
 - Цагдаа Түмэнгийн тодорхойлолт ингэж батлагдлаа гэж ахмад Гарьдыг хэлэхэд хошууч Сүх :
 - Гомбын мотоциклийн арын дугуй бариулын бүрээс бас Өвөрхангайн хүн болох нь батлагджээ . За тэгээд цааш нь гэв .
 - Гомбо жил тойрон ажилгүй байж , сүүлийн нэг жилд ер бусаар хөрөнгөжжээ гэдэг нь түүний хэргийн далдалсан гогцоог тайлж өглөө гэж Гарьдыг хэлэхэд .
 - Нөхөр ахмад та үүргээ сайн биелүүлжээ. Харин хошууч хавгаснаасаа нэг бичиг гарган инээмсэглэж ,
 - Хөөцөлдсөн хэргийн маань гэмтэн бараг тогтоогджээ . Тэгээд та энийг сонирхооч гээд ахмадад нөгөө бичгээ өглөө.
 - « Гэмт хэрэг үүсгэсэн тэр шөнө Гомбо , хотын худалдааны ажилтан Цоодол , түүний гэр бүлийнхэнтэй хамт кино үзээд 24 цагт киноноос тарж , Цоодлынхныг хүргэлцэхээр хөдлөхдөө би танайхаас Оргийнд очно. Харин чи маргааш эртхэн очоорой» гэжээ гэсэн мэдээг ахмад уншаад , асуудал улам тодорхой болжээ. Тэгэхээр Гомбо , Оргийнд очих замдаа Түмэнтэй гудамжинд тулгарч уг хэргийг үүсгэжээ гэв .
 - Тиймээ! Гэвч хамгийн гол нь бүчний эзэн Гомбо мөн үү, биш үү гэдэг л ...
 - Орох уу дарга нараа ! гээд Жаргал хаалгаар шагайв .
- Ахмад , Жаргалыг таньж ор ор гээд мэндлэнгүүт түүнд сандал тавьж өглөө.
- Та бүхэнд бүчний учрыг хэлэх гэж ирлээ гээд Жаргал амьсгал дарж ядан шавдангуй хэлэв .
 - Битгий сандар, тогтуухан яриач гэж хошуучийг хэлэхэд ахмад цаас авч бичихэд бэлтгэв .
 - Гомбо, одоо манайд бий ! Тэд архи ууцгааж байгаа ! Гомбын ажлын хувцсыг би хар өнгийн утсаар оёсноо өнөөдөр бодож оллоо. Та бүхний үзүүлсэн бүчний эзэн нь Гомбо юм. Тэгээд та бүгдийн асуугаад байсан нөгөө мотоциклийн арын дугуй бариул яг тохирлоо гэв .
 - Эрхэм бүсгүй минь та , манай ажилд их тус хүргэж, манай цагдаа Түмэн, ер нь өвчтөнийг чин сэтгэлээсээ хичээнгүйлэн сувилдагт чинь , тэгээд Түмэн та хоёрын эгэл сайхан ажил үйлсээс чинь төрж гарсан соргог сонор , хурц сэрэмжинд чинь баярлалаа. Энэ талархалыг минь та Түмэнд уламжлаарай гэж хошуучийг хэлэхэд Жаргал :
 - Баярлалаа та бүхэнд! Ажилд чинь ингэж тус хүргээд нинжин сэтгэлгүй гэмтнүүдийн нөлөөнөөс нөхрөө балрахын нь даваан дээр татаж авсандаа баярлаж байна гэжээ .

ЗО -БАЙ- ЖИНГИЙН БАТТУЛГА

Зохиолч З. Баттулга 1919 онд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт төржээ.

1965 - 1967 онд Москвад утга зохиолын дээд дурс төгсжээ. 1950 иад оноос уран бүтээлээ эхэлж «Төвшин төгс», «Ерөөлт учрал», «Шийнэн дуулж байна», «Уяхан замбуутив», « 785 дээр» өгүүллэг, туужийн ном «Хөх тэнгэр» роман бичжээ.

ДАРМААГИЙН БАТБАЯР

Залуу зохиолч Дармаагийн Батбаяр 1941 онд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт төржээ.

1966 онд Монгол улсын их сургууль , 1979 онд ЗХУ ын М . Горькийн нэрэмжит утга зохиолын сургуулийн дээд курсийг тус тус төгсжээ.

Д.Батбаяр нь бага наснаасаа уран зохиол оролдсон бөгөөд « Гар » « Жаргалын найман морь » « Өгүүллэгийн түүвэр», « Дөшин жирэмийнхэн», « Шувуу бүхэн жаргалтай », « Нэг Ваанжил , нөгөө Ваанжил » , « Цөөрөм » жүжгүүд бичжээ .

МЭЛМИЙ

Хаалга онгойн гаднаас хүүхэд гүйн орж ирэх хөлийн чимээнээр өвгөн Нэрэн :

- Өө миний хүү юу ? Гадаа халуун байна уу ?

- Үгүй ээ , Нээнээ та гадаа гараагүй юу ?

- Өглөгүүртээ мөн нэг жаахан гарч суусан . Халуун өдөр болох аятай байна лээ..

Миний хүү хүйтэн юм залгичихаад дээшээ гүйж гараад Ваанчиг билүү, нөгөө рашаан шинжээч залуу чинь, тэднийд очоод « өвөө танд рашаан захисан юмсан, Авчраа болов уу » гэж асуугаад ир гэхэд жаал хүү Жавхлан « За » гээд годхийн гарав . Жавхлан хүү шатаар нисэх мэт гүйн хоромхон зуур дээд давхрынхаа айлын үүдэнд очин, өлмий дээрээ өндийн байж цахилгаан хонхны нь товчийг нэгэнтээ үргэлжлүүлэн дараад хаалга руу цэжлэн зогсов. Хаалга онгойсонгүй . Жавхлан хүү хором тээнэгэлзсэн янзтай зогссоноо хаалга нь мөн байгаа гэсэн мэт өлийн харахдаа хүлээн авагчийн чийдэн шиг юм хаалганд байхыг ажин , лав хаалга онгойхоор ногоон гэрэл асдаг юм байх гэж бодон хонхыг дахин дарав. Төдхөн хаалганы цаана цоож түлхүүр тожигнон хаалга аажимхан онгойсон боловч ямар ч гэрэл ассангүй. Харин Ваанчигийн эхнэр болох туранхай хөх хүүхэн үүдээ таглан зогсоод:

-Юув ?

-Нээнээ Ваанчиг гуайгаас рашаан авчирсан болов уу гэж асуугаад ир гэж байна гэхэд нь «Хэний хүүхэд билээ энэ чинь » гэсэн шиг Жавхлан руу лавлан харснаа:

-За би асуугаатхая гээд цаашаа өрөө рүүгээ орон:

-Доод айлын муу жаал л байна. Нөгөө сохор өвгөн чинь бас л рашаан авчирсан уу гэж асуулгаж гэх нь Жавхланд утсаар сонсогдох хүний яриа мэт алс бөглүүд дуулдав. «Нээнээ ямар сохор юм уу, Нээнээгийн нүд нь гартаа байдаг юм чинь гэж Жавхлан хүү бодлоо.

Онгорхой цонхоор орж ирэх нэвт салхи битүү хаалттай хаалганы завсраар сэнгэнэх нь намрын хүйтэн салхи эднийд л хорогдож байдаг юм уу гэлтэй.

Ваанчигийн эхнэр ирэн :

-Жаахан рашаан авчирсаан. Одоохондоо завгүй байна. Азнаж байгаад ирж аваарай» гэж хэл гээд хаалгаа хаахад Жавхлан хүүгийн өөдөөс сэнгэнэж байсан салхи хаалганд цохигдон тасарсан дээс мэт эрчлэн ирж , нүүр руу нь цохих шиг болжээ . Ваанчигийн эхнэр юу ч болоогүй юм шиг хаалгаа түгжээд эргэж ирэхдээ :

-Манай байшингийн хэдэн хүүхдийн дэггүй гэдэг үү. Жигтэйхэн заримдаа чинь хаалганы хонхыг учир зүггүй орилуулаад л байх нь тэр. Юу болов , наана цаана гэж бодоод онгойлгоход

юу ч байхгүй шүү. За тэгээд шуугина гэж ... Бид хоёр өсөхөөсөө аваад чимээ шуугиангүй газар дасчихсан болоод хүүхэд нажигнахаар л амь тэмцэх шиг болох юм гэхэд Ваанчиг :

- Хаалганы хонхыг ч ... нэг л ... хүүхэд дарчихаад зугтаачихаад ... байгаа юм ... Гайгүй ээ .
Чамайг нэг ... дуранджээ ... байгаад ... бариад авнаа ... гэж үг нэг бүрээ аман дотроо эвлүүлэн, хэлээрээ нэг нэгээр нь тэмтэрч үзсэний хойно сая гаргах мэтээр удаанаар тасалдуулан хэлээд, хүж адил уугих янжуурынхаа үлдэгдлийг ширээн дээрх гуулин бойпорт бясаа алах мэт эрхий хуруугаараа няцлан унтраав. Түүний өөдөөс харж суусан дэлдэн шар залуу :

- Хэний яанаагүй хаалгандаа ийм нэг дуран олж хийе байз .

Энийг чинь юу гэдэг юм дээ ?

- Оросоор « глазок » гэдэг юм . Монголоороо одоо « нүдхэн » гэлтэй биш дээ . Шагайвар гэдэг юм уу даа гадна талаасаа дотогшоо юу ч харагдахгүй хирнээ дотроосоо бол ч дураан дуран. Үүдэн дээр зогсож байгаа хүнийг амьсгаа хүрэм ойрхноос хараад байхад чинь ер ажиг ч үгүй ангайгаад л зогсож байгаа нь ёстой, овоо хараанд орчихоод зогсож байгаа согоо гээд хажуудах хүндээ харагдах төдий болохоос сонсогдохооргүй инээх нь өөрөө өөрийнхөө нүүрэнд тодорсон инээдээ гадагш нь цацраалгүй буцаан биедээ хураан авч байх шиг харагдана .

- Би ч түрүүн ёстой ангайгаад зогсож байсан байх даа гэж дэлдэн шар залуу инээн:

- Чи найздаа нэгийг олоод өгөхийг бодоорой . Ваанчиг царайгаа төв болгон түүн рүү нээрэн үү гэсэн мэт хэсэг ширтсэнээ

- Нандин юмтай хүнд олдож цөхөх юу байхав, дороо. Аятайхан хийцтэй зурмал ч юмуу , шумал ч юм уу нэг юм олоод ир л дээ .Би чамд олоод өгөмц . Харин чи нөгөө ахтайгаа танилцуулаатахна гэсэн чинь яасан бэ ? Даруйхан шиг танилцвал над мөн их хэрэг байна санж .

Би нэг сайн монгол цоожныхоо өргөсийг гээчихсэн юм . Түүндээ л нэг өргөс хийлгэх гэсэн юм . Уг нь их сайн цоож . Энэ нэг олон түлхүүртэй далд цоожнууд уу , монгол цоож шиг манайх эзгүй гэсэн шиг данхайтал харагдахгүй нь бараг цөмөөрөө хоорондоо таарах нь холгүй юм гээд цонх түшүүлэн тавьсан ширээн дээрээс баруун гараа могой мэт чимээгүй гулгуулан авч халаасандаа хийгээд саяны хэлсэн үгээ амтлах мэт тамшаалав .

- Нэрэн гуайгаар хийлгэхгүй юу . Залуудаа их сайн дархан байсан юм гэх чинь билээ .

Би хэлсэн л дэг . Ойрын жил цоож түлхүүр хийсэнгүй . Төсөөрчихөө болов уу даа , гэсэн ч яахав хэмжээ дамжаагийг нь өгвөл болох байлгүй яав гэж л байна л ээ шүү дээ гэж ноосон цамц нэхэж суусан эхнэр тосон авч хэлэхэд :

- Хн ! Тийм хүнээр цоожны өргөс хийлгэх гэж ... Дэмий юм ярьж байдаг юм гэхэд эхнэр нь дуугүй болон юмаа хурдан хурдан нэхэж эхлэв . Дэлдэн шар залуу :

- Тэр бололгүй яахав . Хэзээ л бол хэзээ , өнөөдөр ч гэсэн болно .

- Хаана юм дээ .

- Долоон буудлын тэрээд шү.

- Хн ! үгүй мөн холоо . Тэгээд хоёулаа хэзээ тийшээ явах вэ ?

- Би нөгөөдрөөс хөдөө явчих байх . Завтай бол маргааш өглөө явья л даа .

- За байз маргааш өглөө ... болох юмаа . Чи өглөө дайраад ирнэ үү.

- Тэгье л дээ .

- За ашгүй тэгвэл гээд Ваанчигийг суудлаасаа босоход , дэлдэн шар залуу « яв » гэсэн мэт даган босч үүд рүү зүглэхэд , Ваанчигийн эхнэр :

- Хүүе хоол идээд яваач .

- Зүгээр зүгээр . Би бас ажлын далимаар нутгаар орох санаатай . Мэр сэр юм төхөөрмөөр байдаг. Хоёр нүдний дуран ч олддоггүй байх даа гэхэд Ваанчиг :

- Тэр чинь ёстой нэг хөдөө явах хүний гарын бэл гэнэ лээ шүү.

Дор хаяад л нас гүйцсэн шар ...

- Миний нэг нагац ах байдаг юм. Тэр маань хэрээстэй дуран гэж үглээд байдаг юм . Олоод очвол зүгээрсэн .

- Тэр ч ховор эд байх шүү гэв . Дэлдэн шар залуу өрөөсөн нүдээ анин , хаалганы шагайвчаар гадагш харснаа :

- Догь эдээ бас . Энэний чинь оронд зүгээр шил хийчихвэл гаднаас хүн шагайгаад байх нь байна шүү.

- Хаалганд байх ч бас хүн үзчихээд дэмий байгаа юм . За баяртай .

- Баяртай .

Ваанчиг хаалгаа түгжин үүднийхээ өрөөнд орж ирэхэд ширээн дээрх аяга , тавагтай чихэр сэлтээ хурааж байсан эхнэр нь

- Чи ус цасанд ороод амарч бай . Би дэлгүүрт очоод идэх уух юм цуглуулаад ирье. Тавгийн чихэр ч дуусч байх шиг байна . Ямар чихэр авах вэ өвгөөн !

- Таваганд тавих юм бол ямар ч чихэр яадаг юм .

- Арвын чихэр авах уу .

- За, хэн мэддэг юм. өөрөө л мэдэхгүй ю . Одоо байтлаасаа таваганд ямар чихэр тавихаа хүртэл асуух нь шив дээ .

- Асуухгүй яадаг юм . Мэдээд авчихаар чи сүүлд нь ийм тийм гээд салдаггүй шүү дээ .

- За ... За ... больж үз, зүгээр , гэрийн босго алхахаар л хэрүүл .

- Хэлэхгүй яадаг юм . Тэгж яривал ч чамаас л дандаа хэрүүл гарч байдаг шүү гээд галынхаа өрөөнд орон хувин сав , аяга тавгаа хангинуулах нь тэндээс харааж загнасаар л байх мэт Ваанчигт санагджээ . Гэвч хэдэн хормын дараа эхнэр нь галын өрөөнөөс хоолны том цүнх барин гарч ирэхдээ :

- Чи маргааш ажилдаа очих уу ? гэж аргадсан янзтай асуув .

- Маргааш очиж чадахгүй байхаа. Өглөө өнөө дархны руу явна барина гэсээр байтал өдөр өнгөрчихнө биз дээ. Одоо хүн олдсон дээр хийлгэхгүй бол ингэсээр байтал хүн олдохоо больчихно гэхэд эхнэр нь юу ч хэлсэнгүй гараад явчихав . Ваанчиг ядарсан янзтай хоёр гараараа нүүрээ илснээ хувцсаа солихоор унтлагынхаа өрөөнд орж , тасалгаан доторхийг бүртгэх мэт нүд гүйлгэн харав .

Босоо хүний дайтай том толь, зэрэгцүүлж тавьсан хоёр шүүгээ , модон ор нь хэдхэн хоног хөдөө яваад ирэх хооронд нь цоо шинэ болчихсон юм шиг харагджээ .

Тэр шүүгээ уудлан хар даавуунд нандигнан босон юм гаргаж ирэн задлав.

Өргөсгүй цоож , түлхүүр хоёр байлаа .

Үүнийг анх говийн нэг айлын хүүхдийн тоглоомон дээрээс олсон ажээ . « өргөсгүй цоож гэдэг замаггүй буу шиг хэрэгцээгүй золиг байдаг юм шив дээ » , гэж бодон зогстол хаалганы хонх дуугарлаа . Ваанчиг цоож түлхүүрээ боон шүүгэндээ хийж хаагаад , муур мэт чимээгүй гэтэн очиж , хаалганыхаа шагайвраар харав . Доод давхарын нь айлын жаал хүү яг өөдөөс нь ширтэн зогсож байлаа. Ваанчиг хаалгаа онгойлгон :

- Аа чи юү . За ор , саваа авчирсан уу гэхэд Жавхлан хүү ардаа барьж байсан жижиг бидоноо гаргаж өгөхөд :

- Өө хөө! Энийг чинь дүүргэх юм байхгүй шүү. За яахав наанаа хүлээж бай гэж хэлээд галынхаа өрөө рүү орчихов .

Тэрбээр хэсэг чимээ тасарснаа архины шилтэй юм барин хүрч ирээд :

- Өглөө орой хоёр нүдээ арчвал сайн юм гэнэ лээ . Уугаад ч хэрэггүй биз дээ гэж хэлээрэй гээд жаал хүүг гаргав .

Жавхлан хүү шилтэй рашаан бидон хоёроо элгэндээ тэврэн нэг ч шат алгасалгүй аяархан бууж гэртээ орж ирэв . Жавхлан анх удаа шат алгасалгүй явсан нь энэ ажээ .

- Нээнээ! Өглөө орой хоёр нүдээ арчвал зүгээр байх . Уугаад хэрэггүй биз гэж байна гээд авдран доор ургасан ногоо шиг цонхигор цагаан гарт нь бариулахад өвгөн шилтэй рашааныг авч өвөр дээрээ тавиад тэмтэрч үзсэнээ .

- Ээ төрийн минь сүлд гэж! Яасан сайхан хүйтэн рашаан бэ. Тэр газраас намайг гэж бодоод явдаг ямар ачтай хүүхэд вэ , зуу насал гэж хөөрхий минь хэмээн дуу алдахад галын өрөөнд хоол хийж байсан бэр нь хүрч ирэн :

- Нээнээ минь ингэж хоёрын хооронд юм болгоод яахав . Найман сард бид хоёр амралтаа аваатахая. Тэгээд цөмөөрөө майхан зайхантай тухтайхан явцгаая .

- Би явна даа. Би явна даа .

- Иш ! хүүхдүүд минь юу юуны туханд хүрээгүй байж нэг их сүр бадруулаад яахав . Нээнээ нь хэд хоног нүдээ арчиж үзье . Тэгээд юу болох нь вэ ? Байдлыг нь харья. Улсын ярих нь өчнөөн төчнөөн халуун хүйтэн рашаан хэсээд хараа ороогүй хүн хараа орж гэлцэх юм. Юмыг яаж мэдэх вэ гэж бодоод Нээнээгий нь итгэл тасрахгүй юм даа .

Нээнээ нь уг нь мунгинасаар байгаад чадаагүй юм . Түүнээс биш манай сумын эмч хот руу явж эмчлүүл гэж бичиг хүртэл үйлдүүлж хийж өгч билээ . Гээд яах вэ яахав . Гэгээн төрийн буянд харанхуй ч гэхнээн нүдтэй юм шиг жаргаж л байна . Заримдаа ингэж зүгээр сууж тэтгэвэр авч байгаадаа дотор цухалдах юм . Уг нь хадан гэртээ харихаас өмнө бондгор бандиа харах юмсан гэж санах юмдаа . Миний хүү ч хөөрхөн хүү байгаа бий вий .

- Миний түнжгэр хүү шиг хөөрхөн хүү хаа байна .

- Одоогийн багачууд сайхан юм даа . Хар багаасаа сургууль номын мөр хөөдөг болоод ухаан нь эрт задарч томоо суух юм . Намайг чинь үүдээр гарав уу , үгүй юү. Нээнээ та гадаа суух гэж байгаа юм уу . Би шатаар буулгаад өгье гээд л шавчих нь тэр. Арай л өргөөд явчихгүй юмаа . За тэгээд л гадаа сууж байхад чинь энд ийм юм явж байна . Тэнд тийм юм байна гээд л шулганалдаад байх нь тэр дээ .

- Танаас бор ааруул , чихэр авч амташчихаад Нээнээ гадаа гарах нь уу гээд л үүдэн дээр шуугилдацгааж байдаг юм .

- Ерөө ер . Эдэнд чихэр жимс өгч муу зан сургачихаад Нээнээ нь тавгийн чихэр байлгахгүй нь ээ дээ . Улс амьтан орж ирэхэд тавгийн чихэргүй болгочихоод хүүхдийнхээ нүүрийг түлчих гээд байх юм даа .

- Яах вэ яахав . Нээнээ минь , байвал өгч л бай . Бид байгаа юм байх гээд заримдаа авахаа мартчихаад байх юм ... Нээнээ та наад рашаанаа ингэж барьж суугаад асгачихав даа .

-Ерөө хэлээд яахав гээд шилтэй рашааныхаа бөглөөг авч үнэрлэн :

- Элдвийн үнэр танаргүй сайхан рашаан байна, хөөрхий . Нээнээ нь хоолоо идчихээд нүдээ арчъя .

Алив миний хүү энийг нэг шилэнд юүлчихээд шилийг нь аваачаад өг гэхэд Жавхлан хүү:

- Ам нь эмтэрхий ийм шилийг чинь дэлгүүр авдаггүй юм . Тиймээ ээжээ !

- Дэлгүүр авдаг авдаггүй нь хамаа байхав , өг хүү минь над шиг олон амьтанд рашаан тараадаг байлгүй дээ ... миний хүү савыг нь хоосон битгий буцаагаарай. Рашаан гэгч ус өнгөгүй ч чандмань эрдэнэ юм хойно будаа ч болохноо хийгээрэй гээд яриандаа болоод өдий болтол барьж сууснаас хурууны өндгийг нь чим чим хайран байгаа шилтэй рашаанаа жаал хүүгийн гарт бариулав .

- Эхнэр нь нэг цоожны өргөс хийлгэх юмсан гээд байсан юмсан . Одоо юу болж байдаг юм бол доо .

Уг нь ч түлхүүрийг нь өгвөл болох л ажил хуна даа .

- Хаалгандаа монгол цоож хийх гэж байгаа юм байх даа .

- Үгүй дэгээ . Хаалгандаа хүлээн авагчийн чийдэн шиг юм хийчихсэн байна . Онгойхоороо ногоон гэрэл асдаг юм байх гэсэн чинь ассангүй гэж манай банди л хөөрч ирсэн шүү дээ . Бодвол нөгөө цахилгаан цоож моож нь юм байлгүй .

- Намайг хэн бэ гэж асуулгүй үүдээ тайлаад өгсөн .

- Аа шагайвартай болж л дээ. Үүдэн дээр ирсэн хүнээ дотроос нь харж байгаад үүдээ тайлж өгдөг жижигхэн дуран шиг юм байдаг юм билээ . Тэр байх л даа . Эхнэр нь орой үдэш айгаад байх юм гээд байдаг юм . Тэгээд тийм юм хийлгэж л дээ ...

- Тийм байж л дээ . Хүүг гайхан шагшиж ирэхээр нь цоож л юм байх гэж бодоод л доо ... Одоогийн улс цоож хэрэглэхээ болиод сайхан болж дээ . Урьд цоож , хийж өгөөч гэсэн улс амар заяа үзүүлдэггүй сэн .

- Нээнээ таныг цоожиндоо өргөс хийлгэвэл хийлгэ гэж байна гэх үү.

- Одоохондоо юу хийхэв дээ . Хожим аажуу уужуу болно биз .

Цоожинд улс ямар яарах биш дээ . Миний хүү зүгээр л савыг нь аваачаад өгчихөөд ир гэхэд Жавхлан хүү гүйн гарч одов .

- Май Нээнээ ! Шөл . Хоолоо идчихээд эртхэн хажуулаа аав минь гээд бэр нь халуун шөл гарт нь бариулав .

Удсан ч үгүй жаал хүү « үүдээ тайлж өгөхгөй юмаа » Хонхыг нь зөндөө дарлаа гэсээр орж ирлээ .

- Эзгүй юм байж л дээ. Цөөхөн дарахгүй дээ миний хүү эзгүй айлын хонх орилуулаад гэж Нэрэн өвгөн хэлээд хөлсөө арчин сууснаа нөгөө шилтэй рашаанаа авчруулан алган дээрээ хэд дусаан ширгэсэн булаг шиг хоёр нүдээ ээлжлэн шавшаад дээш харан хэвтлээ . Нэрэн өвгөнийг

ингэж хэвтэхэд хүү нь ажлаасаа ирж эхнэр хүүхэдтэйгээ шуугилдан, өнөөдрийн рашааны тухай ярилцацгаах нь мухрын өрөөнд там тум сонсогдоно .

Өвгөний нойр хулжжээ. Хоёр нүдий нь нулимс бүрхэн юм харж болохгүй арган зовоож байсан гангийн тэр халуун зун эргэн бодогдож хорвоогийн хамаг юмс нулимсанд живчих шиг болсон тэр өдрийг эргэн санав. Төмөр толгой гэж нэрлэдэг нэгэн бор толгой дээр очиж хэсэг төмрийн хүдэр цуглуулаад газар ухаж хийсэн бухан зуухандаа хайлж байтал нь мэлтэлзэн хайлсан улаан төмөр хоёр нүдийг нь тэсэхүйеэ бэрх хорсгон нулимс асгаруулж байсан тэр мөч . Тэр гал улаан төмөр дурсагдав .

Нэрэн өвгөн энэ шөнө нойргүй хононо гэдгээ лавтай мэдэж байлаа. Тэр ямар нэгэн шинэ эмчилгээ хийж эхэлсэн шөнөө унтдаггүй ажээ. Хэвтсэн даруйдаа нэг хэсэг урьд өмнө өнгөрсөн амьдралаа дурсана .

Дараа нь гэнэт таг харанхуй болсон шигээ гэв гэнэтхэн хараа орох юм шиг бодон, тэр мөчийг унтаж байгаа зүүд шиг алдчихуузай гэсэн мэт өөрийгөө чагнана . Бас гэнэт хараа орчихвол өглөө хамгийн түрүүн хэн харагдах бол гэж бодно . Ингэж тэгсээр шөнөжин нойргүй хөрвөөж өглөөгүүр өөрийн эрхгүй нүдний хор гаргах төдий дуг хийгээд сэрнэ .

Сэрэнгүүтээ мөн л бахь байдаг таг харанхуй хэвээрээ байхаар нь зүүрмэглэсэн тэр мөчид л хараа ороод түүнээ мэдэлгүй , нүд аниатай байж байгаад алдчихсан юм шиг унтчихсандаа гутардаг байлаа . Энэ шөнө ч гэсэн мөн л хуучнаараа шөнөжин нойр хулжин, сэрвэгнэж байгаад өглөөгүүр хором зуур дугхийжээ .

Өвгөнийг сэрэхэд ,

- Аав та цайгаа авчруулах уу гэж хүү нь асуув .

- Үгүй ээ хүү минь хэвтэрт орчихсон биш аав нь босч байгаад өөрөө аваад уучихья . Та нар ажилдаа л явцгаахыг бод . Хождов хүү минь

- Хождохгүй ээ. Таны нүд яаж хонов доо. Юм мэдэгдэж байна уу?

- Яаж ганц өдөр мэдэгдэх вэ дээ, хүү минь. Хэд хоногоос тар нь танигдах байхаа.

- Ааваа, гал дээр халуун хоол бий шүү.

- Яах нь вэ. Хар өглөөгүүр ажил удаж хоол хийгээд.

- Яах вэ яахав. Та хамаагүй гам алдаж болохгүй.

Жавхлан сүүнд явсан гээд хүү нь ажилдаа явлаа. Нэрэн өвгөн цайгаа ууж, рашаанаасаа хөвөнд шингээн нүдэндээ дусаав. Савтай рашаан нь халуун байшинд бүлээссэн хэрнээ нүдний аяга руу нь сэрүү татан дотор нь онгойжээ. Өвгөн ач хүүгээ хүлээлгүй гадаа гарав. Хүүхдүүд өвгөнийг тосон «Нээнээ таны нүд хараа орсон уу» гэж шалгаан өвгөнийг хөтлөн вандан сандал дээр суулгав. Энэ үес байшингийн хаалгаар цагаан цамц өмсөж, тольтой шил зүүсэн Ваанчиг дэлдэн шар залуугийн хамт гарч ирэн Нэрэн өвгөнийг хармагц «ус, рашаан

хоёрыг ялгахгүй байж, яаж цоожны өргөс хийх юм бол доо» гэж бодож явахад нь түүний
тольтой шилэнд туссан нар дальдрах мэт ойв.

ЖИГЖИДИЙН БЯМБАА

Зохиолч Ж. Бямбаа 1934 онд Завхан аймгийн Ургамал сумын нутагт төржээ.

1956 оноос уран бүтээлээ эхэлж, «Талын цэцэг», «Хүний хүүгийн хүслэн», «Улаалзай», «Бүлээн чулуу», «Ийм нэгэн хайр», «Хөлсний үнэ» зэрэг тууж, өгүүллэгийн ном «Хорвоогийн өнгө», «Их аяныхан», «Энэрэлгүй хорвоо» роман бичжээ.

МӨНГӨНИЙ БИЗЬЯА

Зохиолч М. Бизьяа 1907 онд Увс аймгийн Хяргас сумын нутагт малчны гэрт төржээ. 1942 оноос уран бүтээлээ эхэлж, «Бэлэг», « Үнэн домог», «Ганц гархи» зэрэг өгүүллэг, найрууллын ном хэвлүүлжээ.

ГАЗАР ЭХ

Писхийсэн чимээ гараад тэрэг зогслоо.

- Ойн цагдаагийнх тэр дээ гээд жолооч голын захын мөнгөлөг цагаан хусан дундуур цухуйж байгаа гэрийг заахад түүнтэй хамт яваа нүдэндээ шилтэй эцэнгэр залуу.

- Та намайг хүргээд өгөхгүй юу. Би том хайрцагтай яваа юмсан гэв.

- Эндээс очих зам байхгүй. Замгүй газраар давхиад хүрвэл Данхар өвгөн тархи хага цохино... Хангай дэлхий хавчсан юм шиг алга дарам газрыг ч бэрд шиг харамлаж байдаг тэр яхир өвгөнтэй мар мар хийж байх гэж хар яршиг. Нэг ам мурийвал амар салдаг хүн биш гэж жолооч тун ч түвэгшээнгүй хэлээд түлхүүрээ хариулж гэдийн суугаад тамхи ороов. Түүний царайд хөдлөх янз огтхон ч үгүйг ажсан залуу тэрэгнээс дуугүйхэн гарч ачаан дээр бөхөлсөн хоёр том хайрцгаа буулгав. Тэгээд ёсыг бодон жолоочид тал өгөөд ойн цагдаа-

гийнх руу хоёр хайрцгаа өргөн гэлдрэв. Түүнийг байн байн амарсаар гэрт дөхөж очих үеэс нохой хөв хөв хуцав. Гэрээс нэгэн бүсгүй гарч ирээд харан зогссоноо түүний хайрцгандаа түүртэн арайхийн явааг ажсан бололтой тосон хүрч ирлээ. Залуу мэндийн хариу өчөөд бүсгүйг ширтсэнээ гэнэт санаа зовон харцаа доошлуулж:

- Танайх ойн цагдаа Данхар гуайнх мөн үү? гэж асуулаа.

- Мөн мөн... Та манайд ирэх гэж яваа хүн үү гэж хэлэхэд түүний дуу жигтэйхэн уянгалаг сонсдов.

- Тиймээ гээд залуу хоёр хайрцгаа өргөтөл бүсгүй:

- Би нэгийг нь хүргээд өгье гээд үг хэлэхийн завдалгүй шүүрч авлаа. Тэгээд бүсгүй түүртсэн янзгүй өмнө нь орж алхлаа. «Ийм сайхан амьтан энэ аглаг ойн мухарт юугаа хийж сууна вэ?» гэж залуу бодон хариу эрж, түүний наранд борлосон нарийхан шилбийг нь ширтэн хойноос нь дагав. Тэр хоёрыг гэрт ороход үсээ хусуулсан, мөлжсөн тойг шиг жижигхэн толгойтой намхан өвгөн нохой шиг хэлбэртэй үндэс янзлан хойморт сууна. Том толгойтой болохоор нь Данхар гэсэн юм байхдаа гэж залуугийн санаж байснаас тэс өмнөө хүн байлаа. Өвгөн залууг хааяа нэг ажин, нөгөө л үндсээ оролдон байснаа:

- Залуугийн нэр хэн билээ? гээд

- Уртнасан гэсэнд:

- Ямар хэргээр хаа хүрэх гэж явна даа? гэж асуув.

- Танай энэ хавьд эрдэм шинжилгээний ажил хийх санаатай ирлээ. Өвгөн үндсээ тавьж:

- Заавал манай энд үү? гэж лавлах дуунд нь дурамжхан өнгө илрэв.

- Тиймээ... Энэ хавийн ууланд гэж хэлээд залуу жолоочийн хэлснийг санаж яхир өвгөн гээд байсан нь үнэн байх нь гэж бодлоо.

- Уухай... гэхдээ өвгөний нүүр үрчисхийгээд явчихав. «Эрдэм шинжилгээний ажил гэнэ үү? Нөгөө гайхлын өрөөсөн дугуй байх нь. Энд нэг мунгинасан өвгөн бий гэж зааж өгч нааш нь явуулж дээ.

Мануухай шиг хааш нь ч харуулж тавьсан болно гэж хэлсэн байх даа» гэж санахаас өвгөн хий бухимдаж эхлэв.

- Эрдэм шинжилгээний ажил ий?... Шинжлэх ухаанд хэрэгтэй юм хийх гэж яваа юм биз дээ? гэж өвгөн тохуурхсан янзтай хэлэхэд нүүрэнд нь ёжтойхон инээмсэглэл тодров. Уртнасан өвгөний даажин тохуутай үгэнд битүүхэндээ дургүй байлаа ч гэсэн хариу юу ч хэлсэнгүй халааснаасаа албан бичгээ гаргаж өгсөнд өвгөн авч тамгыг нь нэг харснаа унших дургүйдээ ч тэрүү:

- Ийм юм авчирдаг л юм гэж тоомжиргүй дуугараад эгүүлэн өгөхөд бүсгүй замаас нь авч үзэх гэсэнд:

- За чамд ямар хэрэгтэй юм! гэж өвгөн зандрав. Эмгэн өвгөнөө шинэ гийчиндээ юунд ёозгүй зан гаргана вэ гэсэн бодолтой хөмсөг зангидан муухай харснаа залууд: Хүү минь, холоос ядарч ирсэн байлгүй. Цай уу, өрөм ид.

Алив, миний охин гэр дээрх дэлгэцнээс шинэ ааруул авчирч тавь гэж хэлэв.

- Та нарыг би мэднээ, мэднэ гэж өвгөн дуугарахад Уртнасан чухам хэнийг хэлж байгаа, яагаад ингэж байгааг ойлгохгүй гайхахдаа өвгөний царай. руу харлаа.

- За тэгээд чи чинь эрдэмтэн л болох гэж яваа хүн үү дээ гэж өвгөн асуув. Эвий нь олж аятайхан ярихгүй бол өвгөний гэдэн нь хөдлөөд ажилд саад болж магадгүй гэж Уртнасан болгоомжлон аяыг нь дагуулсан нь дээр гэж бодоод:

- Одоохондоо судалгааны юм нэлээд хийнэ. Болж өгвөл алсдаа ч цол хамгаалах санаа бий л юмсан гэв.

- Тэгж л таарна. Цалингаа нэмэх гэсэн хүний нэг юм биз дээ гэж өвгөн хэлэхдээ нүд нь сөрвөлзөж нэг л ууртай шиг байхаар нь Уртнасан гайхахын ихээр гайхжээ.

- Өвгөн, та чинь хүнтэй төрхтэйхэн ярьж чадахгүй зөнөж байгаа чинь энэ үү? гэж эмгэнээ тэссэнгүй хэлсэнд:

- Хн... гэж өвгөн эмгэнийхээ үгийг тоосон шинжгүй хамраа дуу гаргаад:

- Хичнээн буга, аргаль, янгир алах вэ? Шилүүс ирвэсний арьс бас л хэрэгтэй биз дээ? ...Танай эрдэмийн ажлын гол юм энэ л байдаг даа. Манай энд ч энэ элбэг... гэв. Бүсгүй, эцгийнхээ үгэнд баахан санаа зовсон бололтой эцэг, эх, залуу гурвыг ингэж ингэж юу л болдог бол гэсэн эмээнгүй харцаар ээлжлэн харна.

- Надад тийм ан хэрэггүй. Би эмийн ургамал судалдаг хүн гэж Уртнасан түс тас хэлээд ан амьтандаа хайртайдаа л тэгж эртнээс дэмий муу зангаа гаргаж байсан бол одоо санаа нь амрах биз гэж бодлоо.

- Цэцэг ногоо гэхээр яаж ч байсан хамаагүй юм шиг бодож ч болохгүй дээ... Мэдээжээр вансэмбэрүү авч таарна гэж өвгөн нухацтай дуугараад тийм үү гэсэн харцаар ширтэхэд нь залуу.

- Миний! сонирхож байгаа гол эмийн ургамлын нэг дээ гэсэнд өвгөнний нүд илэрхий томроод ирлээ.

- Хот газар вансэмбэрүү их үнэ хүрдэг гэсэн байх аа? гэж өвгөн хүйтэн гөлгөр харцаар ширтэн асуусанд Уртнасангийн уур нь дүрсхийж царай нь улайв. Өвгөн ч залуугийн царай хувьсхийгээд явчихыг ажсан бололтой дахин юм дуугарсангүй. Тэр дөрөв бие биеэ хулгай нүдээр харан нэлээд дуугүй суув. Уртнасан хот суурин газар нүдний гэм болсон сарлагийн даргар өрөм хөвүүлсэн цай амтархан ууж, эцэг, охин, эх гурвыг ажина. Эмгэн өвгөн өөдөө хялам хийх атал Уртнасан дээр зан сайт хүний урьхан харцаа тусгаж ид, уу гэж уриалгахан гэгч нь шална. Бүсгүй санаа зовонгуй, хийх юмаа олж ядсан байртай харагдана. Өвгөн хүрлийчихээд дуугаа хураажээ. «Энэ бас хачин өвгөн юм даа. Жолооч яах аргагүй үнэн хэлжээ. Нэг насаар амьтан хүний бараа харахгүй уулын мухар сахисаар зожиг болчихсон юм болов уу? Ийм зан муутай хүн дээр ирж таарах гэж. Эмийн ургамал элбэг гэхээр нь наашаа зүтгэчихсэн минь гай болов байна. Одоо яана?... Үгүй тэгээд энэ өвгөний үгэнд эрдэм шинжилгээний хүнд дургүй янз цухалзаад байх шиг. Энд өмнө нь ямар нэгэн хүн ирж байсан юм бол» гэж Уртнасан бодоод асуух гэснээ өвгөний эгдүүг хүргэвэл дуугүй сууснаас дор болох биз гэж гэнэт санав. Уртнасан цай ууж ханаад тэдний хэн нэгийг дуугарах болов уу гэж жаахан хүлээзнээд бүтэхгүй болохоор нь хайрцгаа нээж янз янзын чихэр, нэг лонх архины хамт эмгэнд хоёр гардан барьж

- Хотын боов идэцгээ гэвэл эмгэн баяртай тосон авч:

- Буян чинь дэлгэрч яваг хүү минь гэж ерөөлөө. Эмгэн чихэр тарааж архинаас галд өргөөд өвгөндөө жижигхэн мөнгөн хундганд хийж өглөө. Өвгөн архийг уугаад эмгэнээ дахин хийж өгөх гэхэд нь:

- Балагтай хар усаар яах юм гэж ундууцав. Гашуун л юм үзвэл сайхан загнаад нааш нь гэж байдаг өвгөнийхээ амнаас ийм хачин үг гарахад чихэндээ үл итгэсэн эмгэн:

- Өвгөн минь, чи чинь уухгүй гэв үү, үгүй юу?... Эсвэл би буруу дуулав уу? гэж асуусанд.

- Хэд хэлүүлэх гэсэн юм гэж өвгөн уцаарлав.

- Үнэхээр тийм бол ч нар ургах зүг солигдож дээ гээд эмгэн жуумалзан архиа хойш тавилаа. Эмгэний үгнээс өвгөний архинд дуртайг гадарласан Уртнасан энэ өвгөний санаанд нийцүүлэх арга ухаанаа олохгүй мухардахдаа гэрээс гарлаа.

Уртнасан ойн цагдаагийн ирснээс хойш хэд хоног өнгөрөв. Өвгөний орчны нутгийн Эмийн

ургамлын тархалт, нөөцийг судлах гэж мэрийжээ. Тэр залуу өглөө эртлэн босоод дасгал хийж буй бололтой жаахан сарвалзаж байгаад цай уусны дараа ургамал хавчдаг том хавтас үүрээд уул руу одно. Эмгэн, охин хоёр түүнд идэх өрөм, ааруул, боож, ширэн дашмагт цийдмэг хийж өгнө. Энэ хэд хоногт тэдний ойр орчны уулсыг бараг гүйцээв. Ажилдаа улайрахдаа хаа хүрснээ ядарснаа ч мэддэггүй бололтой. Зарим өдөр Уртнасан хэдэн уул давж бүр шөнө болсон хойно хоёр хөлөө арай ядан солбиулсаар ирнэ. Тэгэхэд Данхар өвгөн, түүнийг хаврын ногоо хөөсөн мал шиг ингэж шургаж унатлаа тэнэж яана даа гэж бодоод дуугүйхэн байхад эмгэн нь:

- Хүү минь, битгий ингэж оройтож бай. Манай энэ хавь чинь зэрлэг амьтан ихтэй зэлүүд газар шүү дээ. Осолтой шүү, хүү минь хүнддэнэ гэхгүй бол өвгөний буу үүрээд явж байгаач гэж үглэнэ. Дуугүй мөртөө нэг яривал их яриа байрын энэ төлөвхөн залууг хэзээ, хаанаас гараад ирэх бол гэж бүсгүй битүүхэндээ харуулдана. Хүн цөөн үзэгддэг болохоор хань ижил эрсэндээ ч бус, Уртнасан бүсгүйд цаанаа л дотно санагдаад байх болжээ. Түүний хүслээр болдогсон бол Уртнасан юманд явахгүй гэрт л байж байвал тун таатай санагдана. Гэтэл Уртнасан гэрийн бараа харалгүй эзгүй хээрт тэнэсээр өдрийг барна. Бүсгүй түүнтэй ганц ч атугай явахсан гэж санавч эцгээсээ айх учир хэлж үл зүрхэлнэ.

Бүсгүйн аз болоход Уртнасан нэг өдөр гэрт өнжлөө. Хайрцагнаасаа янз бүрийн шилтэй шингэн бодис гарган ирж, хуруун шилэнд цэцэг, үндэснээс хийж спиртэн дэн дээр буцалган өөр шингэн бодистой холих мэтээр үзнэ. Зарим цэцэг, навчийг өсгөдөг шилээр харна. Энэ бүхэн гэрийнхэнд их сонин байлаа. Уртнасан өсгөдөг шилээ эмгэн, охин хоёрт өгч харуулахад өөрсдийнх нь мэдэх цэцэг энгийн нүдээр харснаас хичнээн ондоо байдгийг үзлээ. Хэнэггүй царайлж залуугийн юу хийж байгааг эс тоосон янзтай суусан өвгөн ч эмгэн, охин хоёрынхоо шагшин яриад байхаар нь тэссэнгүй очиж харлаа. Өвгөн нэг насаар үзээгүй юмаа үзэх нь тэр.

- Үгүй ерөө, мөн санаанд оромгүй юм хийж суудаг хүнээ чи! гэж өвгөн гайхан дуугарчээ. Уртнасан тийнхүү гэрт өнжсөнд бүсгүй яагаад ч юм их баяртай байлаа. Дуу аялан орж гарна. Залууг юу ч эс анзааран өнөөх цэцэг навчаа оролдон суухад нь бүсгүй тэлмэгэр хар нүдээрээ баясан харж үе үе мишээнэ. Тэгээд залууг өчүүхэн хөдөлмөгц харцаа буруулна.

Өвгөн залууг цэцэг түүдэг хүн гэдгээс өөрөөр бодсонгүй. Учрыг мэдэхийг ч хүссэнгүй. Гэтэл залуу энэ өдөр түүний хэрэгт дурлах овыг нь хөдөлгөж орхив. Залуугийн юу хийж байгааг үдийн хугас дуугүй харж суусан өвгөн тэсгэлгүй.

- Энэ цэцэг навчаар чи юу хийдэг хүн байна даа. Энэ том хавтсанд хатаагаад байгааг хичээл дээр хүүхдэд үзүүлэх гэж байгаа юм уу?... Ингэхэд чи ер нь ургамал ногоо заадаг багш хүн болж таарав аа? гэж асуулаа.

Уртнасан хийж байгаа юмаа түр орхин ийм сэжүүр гарсан дээр нь тухтайхан ярьж өвгөний санааг мэдэж авья гэж бодоод түүн рүү эгцлэн харж суулаа.

-Миний энэ түүгээд байгаа чинь дандаа эмийн ургамал. Би эм хийдэг үйлдвэрт ажилладаг хүн.

- Пээ, ямар буянтай үйл бүтээдэг хүү вэ гэж эмгэн дуу алдав.

- Бид чинь тэгвэл уудаг эмэн дээгүүрээ л туучиж байдаг улс байх нь ээ гэж өвгөн толгойгоо тунжигнуулэн халаглан шогшроход

Уртнасан:

- Хараахан тэр чигээрээ ч эм биш л дээ. Нарийн аргаар боловсруулж байж сая хүн хэрэглэх эм болдог юм гэв. Сөөм газрыг ч хайрлаж, үүгээр түүгээр давхисан жолоочийг тархидаж байдаг нь энэ өвгөний яхир муу зангаас бус, байгалиа хамгаалах гэсэн сайхан сэтгэлийн үр болохыг Уртнасан гадарлах болсон учир өвгөнтэй ний нуугүй ярих хүсэл төрлөө.

- Данхар гуай, газар дэлхий гэдэг чинь хүний төрж өссөн өлгий нь. Эрт цагаас эх мэт ивээлээрээ хүнийг хооллож, хувцаслаж иржээ. Өвчин эмгэг хүрвэл анагаах эмээ ч ургуулаад өгч байна. Газар шороо баймааж ус ургамал байна. Ус ургамал баймааж амьтан байна. Амьтан баймааж хүн идэх хоол, өмсөх хувцастай байна. Хүн баймааж дэлхий маань улам өгөөмөр баян болж, дэгжин цэцэглэж байна. Энэ дөрөв амин судасны холбоотой юм даа. Тэгэхээр байгаль маань хүний төрсөн эх юм. Хүн байгалиас төрөөд байгальдаа шингэж байгаа юм гэж Уртнасан яриад баахан номчирхчихов уу даа гэж санаа зовсхийв. Гэтэл өвгөн харин ч шаггүй ухаарсан бололтой.

- Нээрээ л үнэн дээ, хүү минь. Бид чинь эргээд л хөрс шороо болж байгаа юм чинь гэж хэлэв.

- Тэгэхээр хүн эхийгээ яаж хайрладаг вэ, түүн шигээ нинжин сэтгэлээр газар эхээ хайрлах учиртай юм даа.

- Хэлээд яах вэ хүү минь гэж өвгөн уриалган хэлээд: «Энэ чинь их ухаантай хүү юм. Хэд хоног дүлий годил шиг сууж байхаар ийм хүүхэдтэй ярьж хөөрч байх минь яалаа! Намайг муухай ааштай өвгөн гэж бодсон байх даа. Яалаа ч өнгөрсөн хэрэг. Тэнэг өвгөнд гомдоогүй бололтой. Одоо ингээд надтай цаанаа юм санасан шинжгүй ярихыг бодоход сэтгэл цайлган, санаа сайтай хүүхэд байх гэж өөрийгөө ихэд зэмлэжээ. Бүсгүй, эцэг, залуу хоёрынхоо ийнхүү санаа нийлэн ярилцахыг үзээд илтэд баясан тэр хоёрыг мишээнгүй харна. Тэдний хамаг санаа бодол өөр дээр нь тусаж, ихэд сонирхож байгааг Уртнасан мэдээд нэгэнт эхэлснийх жаахан ярихад ч яах вэ гэж боджээ.

- Хүн ухаант амьтан мөртөө эрт цагаас юм бүхэн төгс бүрдмэл газар эхдээ даанч халамжгүй хүйтэн сэтгэл гаргасны уршгаар маш олон төрлийн амьтан ургамал үгүйрч алга болж дээ. Европ тивд байсан үхрийн өвөг эцэг түүр гэдэг зэрлэг үхрийн сүүлчийг гурван зуун тавин жилийн өмнө устгаснаар удам нь тасарсан байна. Яриад байвал ийм жишээ олон л доо. Байгаль дээр байгаа бүх юм хоорондоо шүтэлцээтэй байдаг. Энэ муу ялаа хэрэггүй гэж болохгүй. Америкийн Калифорни гэдэг мужийн нэг үзэсгэлэнтэй сайхан нуурын дэлэнчийг устгасан чинь загас нь үгүйрч дуусаад шувуу нь нүүж алга болжээ. Яагаад гэвэл, тэр загас, шувуу дэлэнчээр хооллодог байж л дээ.

Шоргоолжийг үгүй хийчихвэл модгүй болох жишээтэй юм. Тэгэхэд манай өвөг дээдэс хорхой

шавьжийг битгий ал, шувууны өндгөн дээр сүүдрээ тусгавал эх нь голчихдог юм гэж сургасаар ирсэн маань их нарийн учиртай юм байна шүү дээ гэж Уртнасанг ярихад,

- Тэгэлгүй яах вэ гэж өвгөн өгүүлэв. «Энэ бас сайхан ярьдаг хүү юм даа. Бид гурвыг голохгүй байна шүү. Гэтэл нөгөө нэг эрдэмтэн...? Ямар учиртай юм хийгээд байгаа залуу вэ гэж асуухаар энэ тун нарийн ухааны ажил даа. Цэвэр эрдмийн ажил гэдэг энэ. Яриад яриад та учрыг нь олохгүй байх даа гэхэд нь, дүү минь тэгээд миний хялбархан ухаж мэдэхээр бол юунд тус болох юм хийж байгаа хэрэг вэ гэж шалгаахад, шинжлэх ухаанд л чухал хэрэгтэй юм гэж хэлж билээ. Мангуу толгой би ч түүнд итгэчхээд өөрт хэрэггүй ч, шинжлэх ухаанд хэрэгтэй юм гэж бодчихоод тус болох гэж хөлөө хугалах шахглаа харайсны нь яана! Хар моньд чинь миний гараар хүртэл могой бариулсан шүү. Гашуун усанд дуртайдаа л тэгж хүний зууш болсон юм» гэж Данхар бодоод «Бузар золиг» гэж амандаа хараав. Ийн бодол болж суухдаа өвгөний хацар байн байн үрчилээж байлаа.

- Манай монголчууд олон зуун жилийн тэртээгээс байгалиа хамгаалж ирсэн түүхтэй улс. Богд хан уул, Отгонтэнгэр, Хан хэнтий чинь өнө эртний дархалсан уулууд. Монгол улс таван зуугаад жилийн өмнө гарсан «Халх журам» гэдэг хуулиндаа байгаль хамгаалах тухай нарийвчлан заасан байдаг билээ.

- Мөн ч өнийн юм даа. Хичнээн ч үе улираа вэ дээ.

- Манай ард түмэн усанд бохир юм угааж, асгах нь байтугай сүүний савыг зайлдаггүй, нүүхдээ бууриа заавал цэвэрлэдэг, онцын хэрэггүй бол мод огтлох, газар ухаж сэндийлэхийг цээрлэдэг нь эртний сайхан уламжлал юм. Би энэ ойн цагдаагийн ажлыг олон жил хийсэндээ ч тэр үү, ан гөрөөс, мод ургамал гээд л нүдэнд үзэгдсэн бүхнээ харамлахыг яана. Заримтай нь ч галд хийх ганц мод огтолсноос болж тангараг тасрах шахсан удаа бий гээд өвгөн эрүүгээ тулан ширдэг рүү гөлрөх нь энэ насандаа сайдаж муудалцаж явснаа нэхэн санаж байна уу гэлтэй. Бүсгүй эцгээ энэ залуутай ийм элгэмсүү ярилцаж байгаад туйлаас баярлана.

- Сайн юмны төлөө сайдаж муудалцах ч бага хэрэг. Юмаа хамгаалах нь түмэн зөв. Хойч үедээ л элбэг дэлбэг, байсан юмыг байснаар нь үлдээх гэсэндээ л энэ шүүдээ. Манайхны зарим нь арай дэндүү байгаа юм гэж Уртнасанг хэлэхэд өвгөн сэргэж:

- Ёстой тийм. Чи бүр нэг голоор нь хэллээ. Ан амьтныг чинь зарим нь зугаа гаргаж байх ёстой амьд бай шиг л санадаг бололтой. Эр охин, том жижиг үр төл гэж бодох юмгүй үзэгдсэнээ л буудахыг нь яана! Даанч дэндүү. Гэгээн цагаан өдрөөр амьтан хулгайгаар алчихаад хүний бараанаар ум хумгүй зугтаад алга болно гээч. Энэ насанд есөн жорын амьтантай учирч аль хөглөж явсныг тэр гэх вэ. Хүү минь! гээд Данхар залууд гэртээ ирснээс хойш анх удаагаа нүүр өөд нь харж инээв. Энэ өвгөнийг ерөөс инээдэггүй, баргар царайлчихаад л явдаг юм байх гэж санаж байсан Уртнасан ч инээмсэглэжээ. Өвгөн өдрийн од шиг зуудаг гаансаа гарган тамхи нэрж завилан тухлав.

-Би нэг эрдэмтэнтэй ах дүү шиг байваа, чи минь. Тэр хүн манай энд эрдэм шинжилгээний ажил хийж ирсэн юм. Ан амьтан л судалдаг гэж ярьсан даа. Манай энд хоёр удаа ирсэн. Улаанбаатараас захиа зангаа бичиж ийм ч арьс, тийм ч эвэр явуулаач гэнэ. Би ч хүний итгэл, ажлын чухлыг бодоод явуулдаг байв аа, чи минь. Цол хамгааллаа л гэж дуулдсан. Тэгээд сураг

тасрах нь тэр. Гурван жилийн дараа ч байна уу, би нэг хот орчихоод явж байтал өнөөх эрдэмтэнтэйгээ гудамжинд дайралддаг юм байна. Таргалсан гэж ч жигтэйхэн. Нүдэндээ шил зүүчихэж. Томоо гэгчийн цүнх барьчихсан. Лувсан маань яах аргагүй мөөн. Маагайд заавал оч гээд салдаг юм биш. Гял цал болсон байшин руу ороод л явчихдаг юм байна. Тэгсэн чинь хүүе, эндээс ч бугын эвэр нүд сохолчих гээд тэндээс ч янгирын эвэр сүлбэчих гээд гишгэх газар олддог юм биш. Айлд орлоо гэсэн чинь нэг л бөөн эврэн дунд орчих нь тэр. Арай гэж нэг газар сууж аваад ажсан чинь өнөөх сэрийж сарайсан эвэрүүд чинь дандаа манай эндээс л эрдмийн ажилд хэрэгтэй гээд бодийг нь хөтөлж авч байсан эвэр дүрээрээ байдаг байгаа даа. Гэтэл бас энэгүй л бол миний ажил бүтэхгүй сүйд болно гэж гувшиж, гувшиж байгаад цааш нь харуулсан ирвэс, шилүүсний арьсыг дөрвөн мөчий нь тэлээд ханандаа хадаж орхиж. Цөмөөрөө л миний гараар орсон юм чинь. Би танилгүй яах вэ. Шинжлэх ухаанд хэрэгтэй юм хийх гэж байгаа хүнд тус хүргэх гэсэн сайхан сэтгэл минь ийм болох гэж дээ, тэнэг толгой яасан муухай гэнэдэж хууртав даа гэж санахаас дотор харанхуйлаад явчихлаа. Тэглээ гээд яах вэ, айлд ирсэн хүн чинь дуугүй л суухаас. Эхнэр нь гэж чиний энэ бичээд байгаа хөх бэх шиг юмаар нүдээ тойруулаад будчихсан, зовхи сормос нь хүн хүнийхээс ондоо босож сэргийсэн жигтэй янзын, гэхдээ харин аюулгүй хөөрхөн ааштай хүүхэн байсан шүү. Эрдэмтэн эхнэр хоёр ч намайг байдгаараа дайллаа. Үзээгүй сонин шилтэй архи ч гаргалаа. Би ч сүрхий халлаа шүү.

- За тэгээд эрдэмтэн боллоо гэсэн, юу бүтээ вэ дээ гэж асуусан чинь эрдэмтэн маань.

- Миний цол хамгаалсан ажил энэ дээ гээд машиндсан тэвхэгэр цаас үзүүлж байна. Тэр нь надад яагаад ч юм бэ нэг л чамлалттай санагдсанд

- Ердөө л энэ үү? гэсэнд

- Үүнийг бичнэ гэдэг амар биш. Хуудасных нь тоогоор өвгөний минь толгойд цагаан үс гарсан байх гээд эхнэр нь алиалан инээж байна.

- Эрдэмтэн болохын ашиг юу байна даа? гэж асуусан чинь бас л эхнэр нь урьтаж.

- Өвгөн маань цол хамгаалаад цалин нь овоо нэмэгдсэн гэлээ. Миний дургүй хүрч,

- Цол хамгаална гэдэг чинь цалин л нэмүүлэхийн нэр юм шив гэж хэллээ. Яалаа гэж тэгж хэлж болох вэ, Данхар гуай минь. Шинжлэх ухаанд их нэмэр хандив оруулж байгаа юм гэж эрдэмтэн маань надад дандаа хэлдэг нөгөө үгээ хэлээд,

- Таны хувь нэмэр ч бас оролцсон. Би танд баярлаж, үргэлж дурсаж явдаг юм гэж ярилаа. Би ч шинжлэх ухаанд нэмэр болохоосоо өөртөө гомдож

- Эрдэмтэн болсноосоо хойш их юм бүтээгээ биздээ гэвэл, Эрдэмтэн:

-Баахан ном уншлаа. Энэ хэдийг сонин сэтгүүлд бичлээ гээд босож хавтсанд үдсэн дөрөв таван хайчилбар үзүүллээ.

Аа! гэдгээс өөр би юу хэлэх билээ. Миний дурамжхан байгааг гадарласан бололтой,

- Аргагүй ээ, аргагүй. Данхар гуай эрдэм шинжилгээний нарийн түвэгтэй ажлыг яаж ойлгох вэ гээд эрдэмтэн маань надад уурлах бус, харин ч сэтгэл тайван инээж байлаа. Нөгөө агнаж цуглуулсан юмаараа гэртээ музей байгуулаа шив дээ, эрдэмтэн маань олны төлөө биш амиа л бодож явдаг байх нь ээ гэж санаад баахан урам хугарч билээ. Тэр бүхнийг айлын гэрт биш, эрдмийнхээ кабинетад л байх юм гэж бодсон хэрэг шүү дээ.

- Түүнээс хойш л элдэв сайхан нэрээр бичиг сачиг өвөртөлж ирдэг хүнд яснаасаа дургүй хүрдэг болчихсон юм даа. Чиний шинжилгээ судалгаа хийнэ гэж хэлэхийг чинь сонсуут л өнөөх эрдэмтэн санаанд бугаад явчихсан хэрэг. Тэгээд л уурлаж хохилзаж байгаа нь тэр. Ийм л учиртай юм даа, хүү минь гээд өвгөн мушилзаж, залуугийн өөдөөс хүлцэл өчсөн харцаар харлаа. Түүний яриаг сонсоход үнэндээ ч өвгөн буруутай биш байлаа. Газар дэлхийнхээ юм юманд хайртай хүн харамлаж халаглахдаа тэгж бодох ч аргагүй ээ. Цол авсан эрдэмгүй хүн жинхэнэ эрдэмтэн хоёрын хооронд алганы ар өвөр хоёр шиг зөрөө байдгийг мэдэхгүй ийм настай хүнийг зэмлээд ч яах билээ.

- Эрдэмтэн бүрийг тэр хүн шиг бодож яаж болох вэ. Тэгэхдээ олон дотор ганц нэг тийм хүн байгаа л даа... Улс орныхоо тархи нь болсон лут лут эрдэмтэн зөндөө бий гэж Уртнасанг хэлэхэд өвгөн:

- Би ямар эрдэмтэн мэргэдтэй уулзаж явсан биш. Сохор үзсэнээ мутар атгаснаа гэгчээр өөрийнхөө учирсан ганцаар л жишиж байгаа нь тэр... Тэнэг ч амьтан бол доо гээд өөрийгөө голонгуй инээмсэглэв.

Оройн хоолны дараа өвгөн, Уртнасан хоёр бас хөгжөөнтэй юм ярилцаж суутал бүсгүй шүд шүд гэж ярвайн хацраа дарлаа.

- Өнөө шүд чинь өвдөөд унав уу гэж эхийнхээ асуухад бүсгүй тунирхуу янзтай толгой дохиод орон дээр очиж хэвтэв.

- Одоо яана аа. Өвгөөн? гэж эмгэнийхээ хэлэхэд би яах вэ дээ гэсэн харцаар өвгөн хариулав.

- Хавирганы бураа халааж жигнэх юм бил үү гээд эмгэн мах гаргасан түмпэн дотроос хавирганы яс авлаа. Уртнасан хоромхон зуур хайрцгаа нээж цаасан хүүдийнээс нэг (жижигхэн бор эм авч бүсгүйн дэргэд очоод биед нь хүрэх шалтаг олдсонд дотроо олзуурхан, шүд өвдсөн талын хацарт нь алгаа нааж: Аль шүд чинь вэ? гэж асуув. Бүсгүй «Аа» гэж аяархан дуугараад өөдөөс нь харахад сайхан дүрлэгэр нүдэнд нь шаналангуй байдал илэрхийг Уртнасан ажаад «өвдөх сургаар л ингэж байдаг юун ч янгууч юм билээ дээ. Хоёр хөгшиндөө эрхэлсээр энэ байх даа» гэж бодоод цоорхой араан дээр нь эмээ тавиад:

- Хөдөлгөлгүй зуугаарай гээд гар хүрч амжсаных гэсэн шиг булбарай харцыг нь энхрийхнээр нэг илбэжээ. Гэтэл хэдэн минутын дараа бүсгүй инээд алдсаар босоод ирлээ.

- Зүгээр болчихов уу охин минь? гэж эмгэн энхрий зөөлөн дуугарав.

- Өвдөхөө больчихлоо гээд бүсгүй чи ийм ачтай хүн байсан юм уу гэсэн харц, баясгалантай мишээл хоёроор залууг зэрэг шагнав.

- Сайн эм юм даа... Одооны залууст шүд шүд гэж арзайхгүй амьтан бараг байх биш. Хичнээн хүнийг амрааж байгаа бол доо. Түмний тусыг бодсон нэг буянтан нь л гаргаа байх даа, хөөрхий гэж эмгэн үнэн санаанаасаа сүжиглэнгүй хэлэхэд Уртнасан дуугүйхэн инээмсэглэв.

Урьд нь өвгөний дүнсгэр царайнаас эмээж дуугаа хурааж суудаг байсан Уртнасан оройжингоо сонин юм ярьж тэр гурвыг баясгав. Өвгөн нэгэн насаар ой сахиж суухдаа учирсан хүнтэй паянгаасаа хааяа ярьж инээлгэнэ. Өвгөнийг ийм яриа хөөрөөтэй, сайхан зантай гэж зүүдлээ ч үгүй байсан залуу түүний инээж хөхрөхийг харахдаа сэтгэл тэнүүн баяртай байлаа. Данхар, түүний анхлан бодсон шиг тийм яхир өвгөн биш байжээ. Хэн хэндээ муу санах юмгүй сэтгэл цэлмэсэн хүмүүс үе үе нир хийтэл инээлдэн бие биенээ урьхан харцаар харж хөгжөөнтэй байлаа. Хүн хүнээ ойлгоно гэдэг ийнхүү хүн хүндээ инээд баяр хайрладаг ажээ. Нарлаг сайхан өдөр. Ойн цагдаагийн гадаа бэрзээнтэн дээгүүр өнгө өнгийн цэцэг дэлгэн хатаажээ. Уртнасан цээжээ нүцэглээд наранд шарангаа цэцгээ эргүүлж тойруулна. Сэржмядаг бүсгүй энэ тэр цэцгийг шохоорхон үзэнгээ хатсан цэцгээ савлахад нь тусална. Залуу тун ч нямбай хүн ажээ. Цэцгээ багц болгон боож хүүдийд хийж оёод, цэцгийн нэр, хаанаас хэзээ түүсэн цэцгийг нэгд нэггүй бичсэн пайз зүүнэ. Бүсгүй багцалсан цэцэгнээс авахдаа үүнд чинь энэ хүний гар хүрсэн юм шүү дээ гэж бодно. Тийн бодох тусам үнэр ялдам энэ сайхан цэцгэнд залуугийн үнэр бас шингэсэн юм шиг санагдаж сэтгэл уярна. Тэгээд залууг дөлгөөхөн харцаар сэмхэн харж санааширна. Бүсгүй ягаавтар өнгийн цэцэг багсайтал атган өргөж:

- Та энэ цэцгийн домгийг мэдэх үү? гэж асуув.

- Согоо суман уу?... үгүй шүү, дулаагүй юм байна.

- Эрт л цагт юм байх. Нэг анчин согоо буудаад шархтуулчихаж гэнэ ээ. Тэгсэн чинь хаанаас ч юм янзага нь гүйгээд очиж дээ. Анчин ихэд гэмшин буцжээ. Тэгэвч санаа нь зовж өнөө газраа өдөрт заавал ч үгүй нэг эргэж очдог байж. Шархтай согоо энэ цэцгийг л идэж харагдах юм гэнэ. Хэд хоносны дараа согоо эдгэрээд янзагаа дагуулаад явчихжээ. Тэгээд согоо суман гэж нэршсэн гэж ярьдаг юм билээ гээд бүсгүй яриандаа өөрөө уярч залууг мэлмэрсэн тогтуун нүдээр харав. Хайр гэрэлтсэн тэр сайхан нүд, та надад ямар их янаг дотно харагдана вэ гэж хэлэх байлаа, Залуугийн харц бүсгүйн хайр хүссэн харцтай тулгарав. Бүсгүйг тийм бодолтой байдгийг Уртнасан гадарлаагүй учир далдуур шаналж явжээ. Данхар өвгөнийд ирээд сар шахам болохдоо сүүлийн арваад хоногт эмийн ургамал бодсон сэтгэлийг нь энхрий хонгор бүсгүй эзэлж өдрийн бодол шөнийн зүүд болж байгаа билээ. Гэтэл өнөөдөр бүсгүйнхээ нүднээс бодлыг нь олж харсандаа хязгааргүй баярлахдаа чи минь бас над шиг байсан юм уу гээд ухасхийн тэвэрч авмаар бодогдоод иржээ. Тэглээ ч уулын зэрлэг согоог ухаангүй нэгэн хөдөлгөөн үргээхийн адил болуужин гээд сэтгэлийнхээ хөвчийг чандлан барьж алсад дүнхийх цаст цагаан уулсын толгой харан санаа алдав. Тэгээд жаахан сэхээ орон бүсгүйн, тэрхүү уулсын цагаан тэргүүн гантиг ариухан сэтгэл дээр нэгээхэн ширхэг ч хөө унагаахгүйг хичээхийн учир:

- Чи цэцэг ногоо сүрхий таних юмаа гэж тэс өмнөө юм хэллээ. Залуугийн харцтай мөргөлдмөгц яах ч учраа олохгүй байсан бүсгүйн дотор овоо уужирч:

- Тэгэлгүй яах вэ. Ойн цагдаагийн охин ойгоо сонирхолгүй яах вэ. Тиймдээ ч би ойн сургуульд орсон. Танаас ургамал цэцгийн тухай хичээл дээр сонсоогүй сонин сайхан юм их

дуулж авлаа гэж өгүүлэв.

- Аав шигээ ойн эзэн болох юм биз дээ.

-Эндэхийн зарим хүмүүс аавын хэлдгээр ойн бэрд ч бас болох байх гэвэл бүсгүй нүдээ эрвэлзүүлэн инээлээ. Залууд энэ инээд урьд өмнө огтхон ч сонсогдоогүй тийм л уярсан хайлам уран эгшигтэй сонсогджээ.

Тэр хоёрыг ийн суухад өвгөн эмгэн хоёр мөн л хүүгийн тухай ярилцаж байлаа.

- Энэ эрдэмтэн залуу юмаа. Таван салааны шүүс гэнэ үү, нэг хүрэн эм өгснөөс хойш миний элгэн дээр данхайж хоолны шингэц муу байдаг чинь гайгүй болчихлоо. Үгүй тэгээд охин бид хоёрт өгсөн эмийг өөрөө хийсэн юм гэнэ үү дээ. Охинд ярьсан байна.

-Энэ тийм амар хүн биш. Эрдэмтэн болоогүй байхдаа ингэж байгаа хүн чинь болохоороо аягүй бол үрэгдсэнийг сэхээх бэрх хүн гарах ч юм билүү яаж мэдэх вэ.

- Манай өвгөн ч юмыг нэг магтахаараа тэнгэрт тулгаад л нэг муулахаараа газарт булаад л гээд эмгэн үүдэн шүд нь онгойсон улаан буйлаа гарган инээв.

- Ишц, эмгэн минь, чиний наад ам чинь ч хүний өөдөөс харж мөн инээмээр байна даа гэж өвгөн тохуурхав.

- Өвгөөн, энэ хүү вансэмбэрүү л гэж хааяа дурсаад байх юм. Уушгинд сайн эм хийх санаатай юм байх. Чи бэрдлэлгүй зааж өгөөрэй.

- Тэгнэ ээ, тэгнэ. Ашиг хонжоо эрэгч биш, олонд тусгай юм хийе гэж нэгэн үзүүрт сэтгэл барьсан хүн юм. Харваас андашгүй. Ургамал цэцэг авахдаа ч үрэлгэн сэтгэлээр хүрэхгүй. Би өөрөө газарчилж явна.

- Овоо доо, өвгөн минь...

Уртнасан наранд байсаар нэлээд халууцсан бололтой хөлсөө арчсаар орж ирэхэд эмгэн аяга дөхүүлж:

- Хүү минь, халуун цай уувал энэ шар данханд байна. Хүйтэн юм залгилбал тэр домбонд хярам бий гэв.

- Хүү минь, чи хуучин монгол бичиг, төвд ном мэдэх үү? гэж өвгөнийг гэнэт асуухад Уртнасан ухаангүй залгилж байсан ундаагаа амнаасаа салгаж гайхасхийн харснаа:

- Аль алий нь бага зэрэг гадарлана аа гэж аяархан хэлэв. Өвгөн дуу шуу ч үгүй хоймрынхоо авдрыг уудалж ёроолоос нь хуучирсан хүрэн баринтагтай хэдэн ном гаргаж ирлээ. Тэгээд залууд:

- Манай эмгэний эх эм барьдаг оточ хүн байсан юм. Зөндөө л ном байлаа. Он жилийн уртад увуу цувуу үрэгдсээр энэ хэд үлдсэн юм. Чи үз дээ. Чиний мэдэх юм байна уу, үгүй юу? гэв.

Уртнасан номнуудыг нэг нэгээр нь өвдөг дэрээ тавин баринтагийг нь нямбайлан задалж уруул хөдөлгөн үзэж байхад өвгөн нүд салгалгүй ширтэж байснаа.

- Ямар ямар ном байна? гэж асуугаад:

- «Эрдэнийн увидас гарахын орон», «Хиргүй болор толь», «Эндүүрэлгүй танигч», «Эмийн дөрвөн үндэс» гэхчилэн зарим нь төвд хэлээр, зарим нь хуучин монгол үсгээр бичсэн эм зүйн талын ном байна даа гэвэл:

- Ийм хуучин ном чамд хэрэг болох уу? гэхэд нь:

- Манай хуучин эм судлалыг одооныхтой харшуулан үзэхэд хэрэгтэй байлгүй яах вэ. Энэ чинь чухаг ховор ном шүү дээ гэж залуу учирлав.

- Эд эзнээ хүлээж байдаг гэж үнэн юм даа... Хүүдээ өгөлгүй яахав гээд өвгөн өнөө номнуудаа давхарлан барихад Уртнасан хичээнгүйлэн авч:

-Гялайлаа. Эх орныхоо эмийн ургамлыг хичээн судалж ариглан хайрлаж, хүн арддаа тус болох сэтгэлийг үүрд өвөрлөж явьяа гэв. Сар дээр хөөрчээ. Тэргэн дээр зэрэгцэн суусан Уртнасан, Сэржмядаг хоёрын царай сарны тунамал гэрэлд бодлогошронгуй харагдана. Ойр саахалтын дайтай урсаж байгаа уулын голын чимээг чагнасан юм шиг хоёул дув дуугүйхэн. Уртнасан бүсгүйн мөрөн дээр гараа аяархан тавьж:

- Сэржмядаг минь, эмийн үнэрээс хол, балын амтанд ойрхон байсан хэд хоног өнгөрч, буцах маань хаяанд ирж дээ гээд шүүрс алдахад бүсгүй:

- Та тэгээд хотоо санаад бушуухан харихсан гэж яараад л байна уу? гэж хэлэхдээ хоолой нь чичигэнэв.

- Болдогсон бол... гээд залуу хөгжмийн утас гэнэт тасарсан мэт таг дуугүй боллоо.

Сарны сүүн цагаан гэрэлд улиаснууд мөнгөөр цутгачихсан юм шиг цайрна. Салхины хөдлөхөд улиасны навчис сэрчигнэх нь ЖИНГЭНЭСЭН чимээ л гарахгүй байгаагаас биш, мөнгөн зоос хэлхээд зүүчихсэн юм шиг гялалзана.

- Эндээс буцахад ганцхан л юманд сэтгэл хоргодоод байна даа гэж залуу зүрхшээсээр хэлэхэд бүсгүй ойлгоогүйдээ ч тэр үү, зориуд дүйвүүлэх гэсэндээ ч тэр үү,

- Вансэмбэрүү юу?... Маргааш очоод авахын хооронд санаа зовоод яах вэ дээ гэв.

- Вансэмбэрүү ч биш л дээ.

- Тэгээд юу юм бол доо гэж бүсгүй хайнгадуу хэлээд залуугийн өөдөөс дүрлийтэл харлаа.

- Сэржмядаг цэцэг... гэж хэлэхдээ залуугийн харц бүсгүйн харцтай эсрэг ширтэлцэв. Бүсгүй түүний үг цэцэгний тухай бус гэдгийг юу эс андах вэ.

- Та чинь өвс ногооноос өөр юм боддог хүн байсан юм уу?

- Бодолгүй яах вэ дээ. Сэржмядаг минь гээд залуу бүсгүйн бэлхүүсээр тэвэрсэнд:

- Би таныг боддоггүй юм байх л гэж санасан, гэж бүсгүй гэрийн хаяагаар урсаж байгаа бяцхан горхины шивнээ шиг дуулдах төдийхөн хэлээд тэрэгнээс үсрэн бууж гэр рүүгээ алхав.

- Сэржмядаг гэсэн энэ сайхан нэр шигээ аглаг ойд ургасан анхилуун цэцэг шиг танхилхан хонгор юм даа, чи минь гэж Уртнасан бодон түүний араас харна...

Дөнгөж үүр хаяарч байхад Данхар өвгөн Уртнасан, охин хоёртойгоо хөдөллөө. Сэржмядаг хамт явж газар үзнэ гэсэн учир түүнийг хорьсонгүй. Түүнтэй холын замд дөрөө нийлүүлж явах нь хэзээ хэзээгүй буцах болсон Уртнасанд олддошгүй завшаан байлаа. Уртнасан ингэж яваадаа хязгааргүй баярлаж бүсгүйг байн байн уриханаар ширтэхэд Сэржмядаг баяр хөөр нь багтаж ядан байгаа хирнээ ичингүйрэн эмээлийнхээ бүүргийг гөлөрнө. Олон уул, олон гол өнгөрөв. Их уулсын биед дөхөх тусам ургамал ногоо сийрэгшин хад асга элбэгшин, наран холдоод байгаа мэт сэрүү татна. Уул эгц цавчим болж, хад асга ааглаад морьд явж чадахгүй боллоо. Зарим газар морио хөтлөөд ч явж үзэв. Морьд усан хулгана болтол хөлөрч амьсгаагаа багтааж ядан гаргах мэт хамар нь сарталзана. Тэд мацуулсаар байж өвгөний заасан онь дээр гарлаа. Уулын цаана уул дүнхийнэ. Уулын дээгүүр онгоцны хошуу шиг шомбогор цагаан орой цухуйх нь Отгонтэнгэр уул .

- Хүүхдүүд минь, энэ хоёр таширласан уулыг давахад Отгон тэнгэрийнхээ наахан, бага Отгоныхоо ар тушаа нэг уул бий. Тэнд л вансэмбэрүү байгаа даа... Тун мэдээтэй яваарай. Асга нурж сүйд болов гэж өвгөн захилаа.

Тэр хоёр хөтөлцөн уруу буулаа. Эхний уулны дээр гарахад өвгөн гурван морьдоо бариад суусан чигтээ харагдана. Салхи сэнгэнэж бөөн бөөн үүл уулсын толгой шүргэх шахам нүүнэ. Уртнасан зүрх сэтгэлийнхээ нууцхан дэнлүү болон гэрэлтэж байгаа энхрий бүсгүйн жижигхэн булбарай гараас хөтлөн уулнаас уул дамжин яваагаа нэгэн насныхаа аз жаргалыг эдэлж байгаа мэт санана. Тэр хоёрын явсан газар бүхэнд ус жүржигнэн урсах сонсдоно. Энэ гол хаана байна гээд ийш тийш харахад ус үл үзэгдэнэ. Тэгээд хэвтэн чагнавал, яг доогуур ус шуугин урсах нь усан дээр яваа юм шиг санагдана. Анхны хайрын жолоо алдан тэмүүлж байгаа залуугаа дагаж хүний хөл ховорхон хүрсэн байгалийн сүр жавхланг бишрэн бахдаж яваа бүсгүй хүний хөхөж хөөрсөн сэтгэл далай мэт долгиулж энэ чигтээ ертөнцийн хязгаар хүрэхээс эс буцна. Тэгэвч сэтгэлийнхээ угт «Энэ хүн вансэмбэрүүгээ аваад хот руугаа буцахаар өчүүхэн намайг мартчих байх даа» гэсэн бодол зурсхийж зүрх нь эмзэглэнэ. Хорвоод өнөөдөр шиг жаргалтай өдөр үзээгүй юм шиг санаж яваа бүсгүйн баяр хөөр бялхсан сэтгэлд муу бодол орогнох зайгүй болохоор түүнээ доржноо мартаж дандаа цэнгэлийн сайхныг мөрөөдөнө.

- Сэржмядагаа чи айж байна уу?

- Бороо зогсохгүй шөнө болчихвол яана!

- Эндээ л унтахгүй юу.

- Аав минь санаа зовж сүйд болно доо. Морьдоо орхиод тэсэхгүй бид хоёрын хойноос явна шүү.

- Нээрээ л тэгнэ дээ... Тэгсэн чинь би охины нь хулгайлаад явчихсан байвал яах бол? гээд тонгойхдоо Уртнасангийн уруул бүсгүйн хацарт хүрчихсэнд Сэржмядаг цочин навтгасхийж:

- Арай ч дээ гэв. Тэр хоёрыг уул өөд хүч шавхан авирч алхам алхамаар ахиж байхад үүл нүүдэллэн ирж замыг нь байн байн харанхуйлна. Тэр хоёр үүлний нүүдэл харан амран суутал нэгэн хэсэг үүл бөөгнөрөхөд авирч байгаа уулынх нь оройд наран туслаа. Тэнд гурав дөрвөн настай бүсгүй хүүхэд зогсож байна уу даа гэмээр сагсайсан бөндгөр толгойтой юмнууд харагдахад Уртнасан:

- Вансэмбэрүү! гэж дуу алдлаа.

- Ер гээч! Тэр!... гээд бүсгүй ч олж харснаа баярлан босон харайлаа. Тэгээд мацсаар вансэмбэрүүнд хүрэв. Хос хосоороо ургасан тэрхүү ховор нандин ургамлыг сонирхон үзэж хайрлахдаа гараа хүргэж ядна.

- Бид хоёр шиг хослон ургадаг юмаа гэж Уртнасанг хэлэхэд бүсгүй ялдамхан инээмсэглэв. Залуу вансэмбэрүүний толгойг зөөлөн илбэхэд түүний хөвсгөр цагаан сэвлэг нь бүсгүйн намирсан хар үс шиг уян налархай санагдсан учир «Хүний гараас даажих гэж ийнхүү хэн ч хүрэмгүй аглаг дайд уулын тагтад ургасан юм байх даа» гэж, бодлоо. Тэгээд сэтгэл ихэд хөдөлсөндөө:

- Хангайн сүрлэг уулсын дундаас хүний бяцхан үр Сэржмядаг,

үлэмжийн сайхан вансэмбэрүү хоёрыг ингэж л олох учиртай бодож дээ гэж хэлээд бүсгүйг цээжиндээ наан тэврэхэд Сэржмядаг талимаарсан дүрлэгэр нүдээр өөдөөс нь харлаа. Түүний тэлмэгэр хархан нүднээс янагийн халуун оч бадарна.

- Тэр хоёрын зүүн өмнө Отгонтэнгэрийн зүрхэн цагаан оргил 'гялалзаж, хэсэг хэсэг үүлс түүнийг тойрон салхин хөгжмийн аясаар бүжин наадна. Орчны их их уулсын орой цайран үзэгдэх нь бишрэм

сүрлэг агаад гайхам үзэсгэлэнтэй ажээ.

- Вансэмбэрүү... үү!

- Сэржмядагааг... ааг! гэж Уртнасан хашгирахад уулын цууриа давтан түгээнэ. «Вансэмбэрүү» гэхэд «үү, үү» гэж, «Сэржмядаг» гэ-хэд «Аа, аа» гэж цуурианы төгсгөлд удтал хүнгэнэнэ. Уулнаас уулсад дамжин холын холд жингэнэн одож байгаа цууриаг дахин сонсоход сонин байхаар нь Уртнасан хоёр нэрээ давтан хашгирч улам улам цууриатуулна. Газар эх энэчлэнгээр хүний сэтгэлийг хөвсөлзүүлэх түмэн гайхамшгийн увидас төгөлдөр буюу.

ЖУРМЫН НӨХӨД

Өглөөгүүр нэг залуу Улаанбаатарын төв цэцэрлэгт дээгүүр харан дэмий холхиж байв. Цэцэрлэгийн баруун хаалгаар бачимдсан байдалтай нэг залуу орж ирэв. Хоёр залуу мөргөлдөх шахам тулгаран зогслоо. Түрүүчийн залуу шазруун дээрэнгүй зангаар Та хүн үү гэхэд нөгөө залуу,

- Нүд чинь зүгээр үү. Би Далантай. Чи Наянтай биш үү гээд хирдхийсэн янзтай алхам ухрав.

- Тийм байна. үнэнч нөхөр Далантай огт хувирсангүй гээд Наянтай инээмсэглэх төдий болж гар сунган ердөө ёс төдий сулхан атгав.

Гайхуулж болмоор хоёр залуу цэцэрлэг дундуур сэлгүүцэнхэн хэн алиндаа өчиг алдахгүй ам зөрөн ярилцана. Түшлэгт сандал налан сууцгаав. Наянтай ам нээж,

-Миний атаархдаг галбир хэлбэр, дүрс «сүгээ» нандигнан авч яваад чинь бахархмаар. Бие царай чинь эв эрүүл, сав саруулыг илтгэнэ. Аргагүй шүү. Сайн эхнэртэй хүн ийм байдаг. Сайн нөхөртэй эхнэр ялгаагүй. Харин миний биширдэг ялдам эелдэг, бат буурьтай зан чанарт чинь согог суусан бололтой. Тэгсэн бол тэвчээр хатуужил алдан бэртэгчин «аялгуугаар» дуулахад хүрдэг. Галбир хэлбэр гаднах үзэгдэл, хүнлэг чанар дотоод чухам чухаг ухагдахуун шүү. Эрээ цээргүй хэлэхэд нандин чухал юмнаасаа хэмхчин хэсэглэн гээж байгаад чинь харамсана.

Далантай түшлэгээс нуруу хөндийрүүлэн Наянтайн нүүр өөд өрөмдөх мэт ширтээд,

-Хянуур мэдэмхий дүр гарган хэлбэрддэг заншил эрхэмлэдэг оппортунист авьяас нэрвэгдэж хөрөнгөтний дипломат шиг битүү бүрхэг, үгээр егөөтэй, ихэмсэг ярих гэж зүдэрдэг болчихоогүй бол ойлгомжгүй ярихаа орхиж үз гэхэд Наянтай илэрхий сайхан мишилзэн бодолхийлэв.

Тоолбол нас, төөлбөл нуруу чацуу энэ хоёр залуу өөр нэг итгэлт нөхрийн хамт наймаас арван найм насалтал нэгэн сургуульд нэг эгнээ сандалд сууж, адил сайн дүнтэй аравдугаар анги төгсөөд дотоод гадаадын сургуульд давшин суралцжээ. Далантай улсын их сургууль дөнгөж төгсөөд байгаа, Наянтай анагаах ухааны талаар Москвад дээд боловсрол олж, өчигдөр ирээд найзаа утсаар дуудан цэцэрлэгт хүн цөөн байдаг өглөөний цагийг ашиглан ийнхүү ярилцаж байгаа ажээ.

Наянтай бодож байснаа танайд гэнэтхэн очъё гэж түргэн алхалж явлаа. Санамсаргүй Өнөртэй уулзсан. Тэгээд чамтай урьдчилан ярьж гомдлоо баръя гэсэн юм гэв. Энэ чинь эхнэртэй минь уулзаж эхнэр зарга мэдүүлсэн байж таарах шүү гэхээс зүрх эмзэглэсэн боловч Далантай уужуухан эр хойно,

-Найзаа чухам хэнд юуны учир тэгтэл гомдож орхив. Өнөр бид хоёрт гомдсон юм бол тайтгарч тайвшир! Хэдэн үг хэлэлцэе.

Ингэхэд урьд адил цааш гарахаа товлосон цахилгаан илгээхгүй яагаа вэ?

Наянтай малгайгаа хажуугийн зайд тавиад хичээлийн цагт баригдахаа больсон болохоор Москвад номын сав барилгүй хэд хонохыг хүссэнсэн. Гэтэл түргэн тусламж аятай нааш гарч өчигдөр 14 цагт онгоцны буудлаас шууд төв больницод очоод хорин цаг хүртэл ажилласан. Үүрэг гүйцэтгэж, үг захичихаад гэртээ ороод ирсэн чинь санаандгүй байсан Баяр минь барс баавгай довтолсон юм шиг цочин «юу болж байна» гэж хашгирав. Харин «муу зулзага» Оргил минь «ааваа» гээд гүйж ирснийг яана. Ингэхлээр цахилгаан илгээх цаг олдох уу. Давхар асуултыг чинь хариулахад ганц чамд гомдсон. Өнөр нүүр нүдээ таглан боосон учрыг тодорхой хэлсэнгүй. Эмчийн нүдэнд Өнөрийн нүүрийг бяртай эр хүчтэй дэлссэн шинж харагдсан. Ингээд андын минь араншин эвдэрч байгаа юм болов уу гэхээс тэсэн ядан чамайг хүлээж байлаа. Ингэхэд эхнэрээ яагаад зодсон юм бэ? Далантай цуурайтуулан инээгээд,

- Энэ төдийд гомдсон гэж үү

- Энэхэн гэнэ үү! Хэрцгий балмад хүний үг... '

- Өнөр дэмий ааш адгүй мөртлөө тэнэг зан гаргахад нэг «буулгасан» юм. Өнөрийн тэнэг, миний тэвчээр алдсан тухай одоохондоо нууц байг гэж Далантай хатуухан хэлэв.

Хоёулаа бодлогошров. Өнөр өглөө явахдаа, битгий зов. Санамсаргүй юм мөргөсөн гэнэ биз. Энэ бол бид хоёрт анхны, бас сүүлийн ганц тохиолдол гэж би үзнэ. Өөрийгөө шүүмжлээд Ерэнтэйг өөд татах хүний нэг байтал хувиа хичээгчийн авир гаргасныгаа гэмшиж байна гэсэнсэн. Өнөр хэлсэндээ хүрч зохиомол үгээр намайг хаацайлж яваа юм байна. Алин боловч анддаа үнэнийг тоочих ёстой гэж Далантай бодов.

Наянтай юу бодож бэ гэвэл, нууц байг гэсэн. Тэгэг. Эмч нар сэхэхгүй өвчтөнийг тэсэхгүй гэж; хэнд ч хэлдэггүйн адил нууц байг. Тайлагдашгүй уяа, танигдашгүй өвчин ховордсон орчин үед найзуудын нууц мөдхөн тайлагдах бий гэж боджээ.

Тэнгэр цэлмэг, агаар ариун, цэцэрлэгт сэлүүхэн байлаа. Далантай цочмоор чанга «чи» гэж хашгираад Наянтай эргэж харахтай зэрэг нам дуугаар,

- Ерэнтэйг мартаагүй биз.

- Юу гэнээ яалаа гэж мартах вэ. Түүний тухай бушуухан дуулгаач.

- Тэгвэл хүн шиг сонс. Ерэнтэйг үл бүтэх үхээнц дорой амьтан гэх иш үндэс надад олддоггүй юм...

- Миний тэвдүүг мэдэхгүй биш юунд ийм тийм:...

- Хуучин өмд цамц, арай хазгай гишгээгүй нэг шаахай цэвэрлэж арчихад, Өнөр сайн, тун сайн гэж байлаа.

- Наянтай зүггүй хүүхэд шиг тавгир алдан гэр зуурын юмыг хойш тавьж Ерэнтэйн тухай хэлээд өг.

- Давгаад хэлчихье. Тэвчээртэй сонс. Цэвэрлэсэн хувцсыг цаасанд ороогоод, ширээн дээр байсан мөнгөнөөс 25-тын ганц дэвсгэр авч Ерэнтэйдээ очилгүй горьгүй гэхэд Өнөр тэнэгтэж «Аль болгон архичин тэжээх юм бэ» гээд гараас зууран мөнгө, хуучин хувцсыг булаацалдав. Уур бадарсан боловч гар далайсангүй тохойгоор хүчтэй нударсан юм. Гай дайрч өрөөсөн нүдийг оночихсон юм билээ гэж Далантай нууцаа дэлгэв.

Уяа тайлагдаж уур номхорсон боловч Наянтай учраа ололцож болох амархан хэрэг байж шүү гэв.

Хоёр залуу дахин сандал налж суугаад Ерэнтэйн тухай яриа үүсгэжээ. Ингэхэд цаадах чинь ямар амьтан» байна даа гэж Наянтай асуугаад чих тавин чагнав. Яггүй зөрчил гаргаснаасаа бантаж дөрөвдүгээр ангид дэвшилгүй сургуулиа орхисныг чи сонссон. Тэгээд архичин болсон гэх үү дээ. Ер нь замарчихсан юм. Энүүхэндээ хэлэхэд бид хоёр соёлч хөдөлмөрч, эцэг эхийн гал голомт өвлөн үлдэж, галын хайч, гарын алчуур гаднаас авалгүй дээд боловсрол оллоо. Ерэнтэй маань багадаа эцгээс өнчрөөд эхийн хүчинд ядуу дутууг хайхралгүй суралцаж байсан боловч сэтгэл дундуур байсан байлгүй. Яахав, үүн дээр ийм гай нэмэрлээд бүр гутарчихсан хэрэг. Ерэнтэйг яавал таарах вэ? гэхэд Өнөр Баяр хоёр «Архинаас гаргах эмчилгээ хийлгэнэ биз» гэдэг. Хишиг хэлэхдээ: «Засардаггүй хүн, залагддаггүй яргай байх уу! Хань нөхдийн үлгэр жишээ, хамжаа дэмжлэгээр аргалах тал байвал сайнсан» гэдэг. Ингээд чамайг хүлээсэн хэрэг. Наянтай дуу тавин,

- Нөхөр минь би Хишигийг шинэ нөхөртэй болж жаргалд умбаж байгаагаар муу санаж явсансан. Хулчганадаггүй, хувирдаггүй сайн хүүхэн байж билээ...

- Хишиг яг хэвээрээ байгаа. Ерэнтэйг засарна гэж итгэдэг ганц хүн Хишиг. Наад захыг хэлэхэд бүтэн гурван жилийн ням гариг бараг алгасалгүй очиж Өлзий гуайнд тав арван төгрөг хайр гамгүй өгдөг юм билээ гэж Далантай хэлэв. Наянтай гүн шүүрс алдан

- Хүний чанар... Би Ерэнтэйтэй гурван жил гаруй уулзаагүй, сүүлийн хоёр жил амралтаар ирэхдээ Баяртай цуг олон очсон. Гиюүрч ганьхарсан Өлзий ээжтэй уулзаад гардаг байв. Ерэнтэй зугтаад байсан байх. Одоо даруйхан уулзаж биеийн эрүүл мэнд ямар байгаа үзэл санааны зөрчил бий эсэхийг ажиж арга саам эрнэ. Дундаас дээш боловсролтой таван хүн ганц найзаа шавар балчгаас суга татан гаргаж болох байлгүй гэв. Далантай үгээс үг өлгөж,

- Ерэнтэйг үзэл санал огт хувираагүй. Биеэ гэмтэн гэдэг ганц гай бий гэжээ. Хоёр залуу хурамхан хугацаанд зөвлөөд, энэ орой Далантайнд цуглах, Өлзий ээж Ерэнтэй Хишиг нарыг заавал байлгах, Ерэнтэйг давын өмнө бүрэн хувцаслаж эгнээндээ эгүүлэн авах эхлэлт хийхээр таг яг шийдэв. Өлзий ээж Ерэнтэй хоёрыг урьж ирэхээр Далантай явж очлоо. Ерэнтэй өмгөр бор гэрийнхээ шал элэгдэн хэвтэнэ. Хажууд нь аяга шөлнөөс уур савсана. Хүүгийн үнгэлэгдэж өрвийсөн үсийг илбэн суусан Өлзий гуай Далантайг танимагц,

- Энэ төрийн минь сүлд. Одоо яана аа гэж яаран босоод доголлон нулимсаа арчиж Далантайг тэврэн үнсэв.

- Ээж ээ! Наянтай сургуулиа төгсөөд Москвагаас өчигдөр ирсэн. Өнөөдөр манайд бүгд уулзаж цай уух гэсэн юм. Тэгээд та хоёрыг залж аваачихаар ирлээ гэж Далантай хэллээ.

Өлзий гуай уулга алдан, Ээ! Төрийн минь сүлд... Ерэнтэй огцомхон өндийгөөд, Далантайтай тулгарсан харцаа үл шилжүүлэн зовууртайхан инээмсэглэж, та нар намайг эгнээнээсээ хасаад огт мартацгаа.

Өөрийгөө үрж байгаа намайг алийн болгон энэрэх билээ. Мартаж үзэцгээ. Харин Хишигийг минь... тун сайн хүүхэн шүү гэжээ.

Ерэнтэйн шанааг ширүүн юм шүргэсэн бололтой. Гэвч тоос тортоглож нэгэнтэй эвэрсэн шалбархай Ерэнтэйг ичээхээр биш ажээ. Цовоолог эрвэлздэг нүдийг ажихад ялигүй бүлцийсэн аньсгаа үгүйсгэсэн гэрэл бадрангуй цөцгий гялалзана. Далантай эх үр хоёрт хардаа ээлжлэн хандуулж, бид хэдийн сэтгэлийг бодоцгоо. Ерэнтэй чи босоорой. Хөлсний унаа одоохон ирнэ. Хүлээлгэж юу хийх вэ гэж тэвдүүлэв. Гадаа хөнгөн машин ирж зогслоо. Хүлээгсэд, хүрэлцэн ирэгсдийг үүдэнд угтан, Өнөр Баяр нар Өлзий гуайг өргөн баахан сугадаж шатаар өгсөв. Гурван жил гаруй уулзаагүй Наянтай, Ерэнтэй хоёр хараа хальтралгүй халз ширтэлцэн тэврэлдэхэд чийрэг эрсийн үе мөч нужигнах ажээ. Найз хоёр залуу Ерэнтэйг угаалгын өрөө рүү шууд аваачив. Тэр гурвын инээлдэн хөгжих дуу бүдэг бөглүү дуулдаж байв.

Хагас цагийн дараа цоо шинэ өвч бүрэн хувцас өмссөн, өтгөн хар үсээ гялалзтал тослоод сайтар самнасан Ерэнтэйг ээжий нь хараад зүүд байлгүй гэж нойрноос сэрэхийг хүсэн залуугаараа байгаа үүдэн шүдээр хэлээ өвдтөл хазаж үзэв. Зүүд биш бололтой. Уулын цэвэрч Өлзий гуай өврөөсөө цав цагаан алчуур гарган хөлсөө биш нулимсаа арчив.

Айраг амсаж, цай уун, энэ тэрхнийг ярилцах зуур хүн бүрийн өмнө аяга тавагтай хоол, архи дарстай хундага бэлэн болов. Өлзий ээжий, охид минь эндүүрээгүй биз. Нэг илүү хувь байх чинь... Өнөр Баяр хоёр ам өрсөлдөн, эзэн нь ирнэ гэлээ.

Ерэнтэйг орхиж чаддаггүй Хишиг хүүхнийг Өнөр Баяр нар эгзэгтэй ийм үед ямархан овжин аргаар яаж даллан дуудсаныг Өлзий гуай юунаа мэдэх вэ.

Хундага өргөж Далантай үг хэлэхийн даваан дээр хонх жингэнэв. Хаалга нээгдэж хавь ойрынхонд монгол бүсгүйн хичээнгүй цэмцгэр дүр, авьяаслаг ажилч чанар, сонин сайхан төрхөөрөө гайхагддаг Хишиг хүүхэн босго алхангуут алмайран зогсчихов. Ухарч гараад зугтчих янзтай харагдана. Хишиг тийм хүүхэн биш, шууд урагшилж ирээд нэгэнт өргөсөн хундагыг дэвшүүлсний дараа мэнд усаа асуулцъя гэж Баяр бодсон бололтой дүүрэн хундага авч өргөв. Далантай даваатай эр учраас давчидсангүй. Хоймор суугаа Өлзий ээжий, хол ойроос уулзаж байгаа найз нарын сайн сайхны төлөө гэхэд хундага харшиж хавиралдах чимээ сонсдов.

Хишиг Наянтайд хандаж, энэ аальгүй хүүхнүүдийн худалч хуурамчийг эрчүүл та нар тэвчиж тэсвэрлэдэг гэм биз. Сайн ирэв үү? Хэзээ ирэв гээд мэндлэх гэтэл Хишигийн сунгасан гарыг Наянтай хумин барьж духан дээр нь шовхийтэл үнсэв. Хишигээс өөр хүүхэн бол «ямар ичдэггүй эр вэ, пэ па» гэх байсан. Хишиг тийм хүүхэн биш. Харин ч хариу болгон Наянтайн хоёр хацрыг ээлжлэн үнсэв. Энэ хэдийн бат нягт ханилгааг «бурхан, чөтгөр» хэмээгчээс илүү мэдэх Өлзий ээжий тэрхэн хоромд арай эвгүй юм. Баяр Ерэнтэй бусад хэн боловч муу юм санаж болох биш үү гэж бодтол, залуус нэн баясгалантай хөхрөлдөн, алга ташиж дэвхцэв.

Өлзий ээжийг хайран хүүхэд минь «бузардах» бий. Хар муу санаагаа хаана «булах» билээ гэж бодов. Тэгснээ ийм учрал байж болохгүй. Энэ чинь зүүд. Нойрноос сэрэмгүй сайхан зүүд... Хүн бүр үг хэлж хундага дэвшүүлсээр хоёр лонх архи чилээв. Элдэв юм бодож суусан Ерэнтэй хундага өргөхдөө,

- Тэвчээр хатуужил гэх мэт үгсийг би хэлдэг боловч өөртөө тусган хэрэглэж чаддаггүй юм байна. Одоо надаас «айх»-аа больцгоо. За юу гэв. Үүний дараа бага наснаас үерхсэн энэ хэдийн хооронд хөгжөөнтэй яриа удтал үргэлжлээ. Наянтай гэдэг сайхан нэрээ! Би Далантай больё гэж Ядамсүрэнг хэлэхэд тийм шүү Өнөр, Баяр, Хишиг гэдэг монгол үгээр өгсөн нэр мөн ч аятайхнаа гэж Чойжилсүрэн хэлээд би Ерэнтэй больё гэжээ. Хоёр найзтайгаа ижилдүү монгол. нэртэй болохын төлөө эцэг эхийн эргэлзсэн татгалзсаныг ил далд зөрчсөөр 16 нас хүрч иргэний паспорт авахдаа шинэ нэрээ бичүүлж «Ялалт» хийсэн тухай ярив. Нэг сургуулийн анд гурав, зэргэлдээ сургуулийн найз гурван охин анхандаа хичээл давтах, цана тэшүүрээр гулгаж зугаалахад хамтран нэгдэж харилцан туслалцдаг байснаа сүүлд ижил дасал, янаг амраг болсон тухай инээдэмтэй хууч ярьж амжина. Хундагуудыг коньякаар дүүргэв. Дуулж наргицгаах боловч архийг цөм амсах төдий болж байв. Халуун цай уусны дараа, Хишиг, уяралтай зөөлөн дуугаар:

- Ерэнтэй минь, би чамайг орхих цэвдэг санааг хаанаас олох вэ. Намайг март, орхи, залуу нас, ирээдүйгээ бод, чамд залуус захаас аван дурлана. Сайн ханьтай болж үз. Өөрийгөө гаргуунд гаргасан намайгаа мартаж чад гэдгээ чи одоо орхивол таарна. Ээжийн өмнө, энэ нөхдийн өмнө хуучнаа сэргээнэ гэж хоёул амлая. Чамайг гурав дахь жилдээ одоо хүртэл эдгэршгүй өвчтэй, засаршгүй зантай хүн гэсэн санаа надад төрөөгүй юм. Хүсэл дурлал, хайр сэтгэл хүмүүст хичнээн их үнэ цэнэтэй байдгийг би ойлгосон. Хүн хийгээд биет ямар нэг зүйлээр чамайг орлуулж чадахгүйгээ дахин хэлбэ. Зүүдэндээ чамтай жаргаж байгаад сэрэхэд ямар их гашуун гаслантай, ямар сүрхий аюул заналтай мэт санагддагийг чи мэдэж байгаа. Чамд бас ийм явдал тохиолдож байдаг байхаа. Чиний хэлдгээр цэвэр, гуалиг, соёл боловсролтой залуус намайг хараандаа хадгалж халдаж яддаг юм. Тэдний аль нэгээр чамайг орлуулж чадах чулуун зүрх надад бий болохгүй байна. Үүнээс болоод энэ ертөнцийн хүүхнүүд дундаас гав ганцаар «усан тэнэг» гэж хэлэгдэхээс намайгаа зовно гэж битгий сана. Учир юу вэ гэвэл: «Чи намайг чин үнэн хайрын сэтгэлээр шинэ ханьтай болж жаргалтай амьдраг гэж бодсоноос биш үзэн ядаж зайлуулахын мөн болоогүйг би «залуу нас, зандан цогцос» оороо мэдэрч байдаг. Ийм гүн хайртай чамайгаа хаяж мартвал намайг хүмүүс юутай зүйрлэх вэ гэдгийг ухаантай амраг минь бодохгүй байгаа гэж үү! Намайг адгийн муу амьтан аалз могой мэттэй адилтгасан үг дуулбал чи алалдах хүн. Ингэтэл намайг хайрладаг чамайгаа хоёр бие амьд ахуй цагтаа хаях чадал над бий болохгүй. Хэвлийд хүүхэд оршсоныг өвчин гэж бодоод чамаас айдаг байсан. Ээж, хаанаас даа бэр минь гээд анхаарал тавьдаг байсан. Амьд хуулбар чинь одоо баацганаад гүйж байгааг чи бид хоёрын ээж чамд бишгүй дуулгасан байхгүй яав гэж, Чи саяхан хундага өргөөд юу хэлэв ээ. Би дахин сонсох юмсан гээд тэргүүнээ өргөхөд нөхөд нь уярч олонхийн нүдэнд нулимс гүйлгэнэж байхыг хармагц Хишиг огло харайн тагт дээр гарав. Цэлийсэн гудамжны цахилгаан гэрэл, цэлмэг шөнийн тэргэл сар бүдэг бүрхэг мэт санагдахад нүдээ тас анин хайс түшиж зогсов.

Гэнэт араас хүн тэврээд Хишгээ гэхэд Ерэнтэй минь мөн. Өөр хэн байх вэ хэмээн ханхар эрийн тэвэр дунд шалмаг эргэх агшинд хамаг бие халуу оргих шиг болсныг Хишиг мэдрэв.

Ерэнтэй Хишиг хоёр орж ирэхэд Наянтай ам нээж бүгдээр Ерэнтэйд ажил эрнэ. Улмаар сургуулиа төгсөх арга зам нээнэ. Анагаах ухааны нэг чухал номыг орос хэлнээс орчуулах хүн эрж байгаа. Түүнийг гурвуул орчуулна. Хүүхнүүд давын өмнө оройн сургууль буюу биеэ даах дээд боловсрол эгээрнэ. Ерэнтэй хэсэг хугацаанд монгол үнээний сүү ууна, Согтууруулах ундааны хордлого байж магадгүй учраас тэр шүү! Сүү юунд ч гэсэн сайныг бид мэдэхгүй биш гэв.

Салхивч тас няс хааж, шороо манарган өнгөрсөн ширүүн салхины залгалдаа намираа бороо шиврэн орж эхэллээ. Далантай Өнөр хоёр хоноцуудад ор засаж эхлэв. Ерэнтэй, Хишигийг тас тэврэн, бид хоёр зүт чиггүй арилаад өгнө. Та нар мартаж үзэцгээ гэж сэтгэл хөдөлснөө битүү илтгэхэд залуус хөгжиж нүдэнд бүү үзэгдцэгээ гэв. Өлзий гуай нэлээд хөлчүүрсэн учир тас тас инээв. Харин Хишиг бараг анх удаа нүүр улайн, нүд халиран ичингүйрэв.

Өлзий ээж уртаар шүүр-с алдан, журмын нөхдийн үнэн сэтгэл үйл хэрэг үнэхээр сайхнаа. Журмын нөхөд гэдэг сайхан үг. Зоригт хүмүүсийн мэргэн уриа. Хамт олон гэдэгтэй харьцангуй утгатай, анд найз гэдэгтэй адил санаатай гэж Далантай Өлзий гуайг дэмжин хошигнов. Ерэнтэй ингэж амархан саруул замдаа эргэж орлоо гэж үү, үгүй шүү! Зуун өдрийн нөр их хөдөлмөр түүний бузар булай хандлага бүхнийг мартуулсан юм байжээ. Залуус анхандаа ямар нэг чухал ажил нэрлэж Ерэнтэйг таван тийш татлан зав зай өгөхгүй байв. Сүүлдээ Далантай, Наянтай хоёр албан ажил их, шинэ ажилд дадаж дамшаагүй гэдэг шалтгаанаар орчуулж байгаа номын үлдсэн хэсгийг Ерэнтэйд албан мэт шахан шилжүүлэв. Ерэнтэй хэлний шинжилгээ судалгаа монгол, орос хэлний зүйд маш шуналтай, үр шим нь уулын булаг шиг ундарч байлаа.

Хос залуус наймдугаар сарын 2 дахь бямба гаригт Хишигийнх гэхээ болиод Ерэнтэйнх гэдэг болсон айлд цуглаж эхлэв. Гурван хүүхэн өндөр нам дуугаар ярилцаж байснаа инээлдэхэд Өлзий ээж, төрийн минь сүлд гээд хамт хөгжинө. Гал тогооны өрөөнөөс хүүхнүүд ээ! Тун сайхан цувдай дайралдаж шүү! Та нарын бэлтгэсэн тахиа, гахайн «тааруухан» зуушийг таван цулын шөлөөр даруулна гэж Ерэнтэй даажигнаж Тулга цууриа шиг давтах сацуу баярласан байдалтай өрсөлдөн ярьсаар шат өгсөн айсуу Наянтай Далантай нарын дууг таницгаав.

Тэр хоёр, та нар баярлаж магадгүй мэдээ бий гэснээ угаалгын өрөө рүү уралдан оров. Удаж төдөлгүй ширээ тойрон суумагц,

- Өвгөн эрдэмтэн номыг хянан засаад сайдад барьжээ. Яг долоо хоноод сайд өвгөн докторт баяр хүргэж уг номыг хэвлэлд шилжүүлсэн. Орчуулагчид дам баяр хүргээрэй гэсэн гэнэ гэж Наянтай хэлэхэд бүгд хөгжилдөв.

Би анагаах ухааны дээд сургуулийн захирлын өрөөнд орлоо. Захирал хичээлийн эрхлэгчтэй зөвлөж суув. Нүүр үзсэн сайхан зантай ахмад хүмүүс байлаа. Хулчийсан маягтайгаар Ерэнтэй гэдэг залууг эрхэм багш нар таних болов уу гэсэн чинь бараг нэг амаар хэлэх шиг танилгүй яахав. Сайн хүү, сурлагатай оюутан байсан гэцгээв.

Ахмадтай яриа дүйж Ерэнтэйг зохих ангидаа дэвшин суралцахыг тэд зөвшөөрөв. Далимд хэлэхэд тэнд нэг жижүүр түр хэрэгтэй гэнэ. Ерэнтэй голно биз гэнэ. Ажил намайг голно. Ажлыг би голохгүй гэж Ерэнтэй эрсхэн хэлээд сэтгэл хөдөлснийгөө нуух далим гаргаж өнөө

таван цулын шөл гэх шиг дуугараад гал тогооны өрөө рүү гүйхэд, Тулга аавынхаа үгийг дууриах мэт давтан гүйв. Ерэнтэй, Хишиг хоёр янаг амрагийн үйлсэд хөвж байсан тэр дээр цагт хүүхэдтэй болохоо зөгнөн анхных нь хүү бол Тулга, охин бол Хана гэдэг нэр өгнө гэлцдэг байсан юмсанжээ. Тулга одоо аавынхаа ааш зан аялгуу дууг дууриан дагаж яваа хэрэг. Хоолоо идэцгээж байтал Хишиг, тэр нэг оройных шиг огло харайн угаалгын өрөө рүү оров. Түүний огиж байхыг түгшүүртэй сонсож суусан залуусад зориулж Өлзий ээж төрийн минь сүлд битгий зовцгоо. Бэр жирэмсэн юм шүү! Охин заяасан байх аа! Тулга, бүсгүй дүүтэй болно гэдэг тун сайхнаа. Хана гэж нэрлэх юм гэдэг шүү гэв. Долоон жил өнгөрөх зуур Ерэнтэйн зориг хатуужил, ухаан бодол ерөөж, журмын нөхдийн сэтгэл зүйн ур, оюун ухааны чадал, хайр халамжийн илч хамаг бүхнийг журам горимын дагуу нийцтэй сайхан болголоо гэсэн үгийг салхи биш, шаазгай биш. санаа бодол шивнэлээ.

ШАГЖИЙН ВАНЧААРАЙ

Зохиолч Ш. Ванчаарай 1932 онд Завхан аймгийн Яруу сумын нутагт малчны гэрт төржээ. Бага, дунд сургууль, УИСургуулийн анагаах ухааны ангийг 1959 онд төгсөж хүний их эмчийн мэргэжилтэй болжээ.

Ш. Ванчаарай 1957 оноос уран бүтээлээ эхэлж «Хун», «Амьдрал», «Гал улаан цэцэг», «Яруугийн хавар», «Буурал хангайн даваа», «Сэтгэлд гийсэн гэгээ» зэрэг тууж, өгүүллэгийн ном бичжээ.

ХИЛСДЭХГҮЙ

Залуу эмч Пүрэвдорж гэрлээд удаагүй байжээ. Пүрэвдоржийн

хүүхэн Мишгээ бас залуу, нөхөртөө тун хайртайгаас гадна нэлээн эмзэг юмсанжээ. Ялангуяа сүүлийн энэ сард хоол унданд дургүй болсноос хойш нөхөртөө бага зэрэг тунирхуу байх болжээ.

Намрын улцгар шар нартай Ням гаригийн амралтын өдөр 12 цагийн үед Пүрэвдорж Мишгээ хоёр сугадалцан хөл нийлүүлж Сүхбаатарын талбайг жншүү огтлон яаруу алхахын учрыг тааж мэдэхэд амархан байлаа. Тэр хоёр гартаа нэг нэг жижиг чемодан барьсан нь халуун усанд орохоор зорьсон нь тодорхой. Яаруу яваагийн шалтгаан нь Мишигээ усанд орж ирээд гэртээ бага сага ажил амжуулах, ядаж цонхоо элбээд наагаад авах, орой Элдэв-очир кино театрт «Ардын эмч» гэдэг киног нөхөртэйгээ хамт үзээд авахаар дотроо төлөвлөсөн юмсанжээ. Пүрэвдорж өнөөдөр усанд орох гарцаагүй шаардлагатай болсон боловч амралтын өдөр усны газар хүн ихтэй байгаа даа гэж бэрхшээх бодол түүний зоригийг байн байн мохооно. Гэвч Мишгээгийн зоримог алхаа Пүрэвдоржийн эргэлзээг арчин устгах боловч бэрхшээх бодол дахин дахин төрсөөр байгаад өөрийн эрхгүй ам нээж:

- Уг нь такси аваад Амгаланбаатар юм уу, өөр нэг зайдуухан газрын халуун ус руу явсан бол оочер багатай, сийрэг байгаа даа гэхэд Мишгээ мөн түүний саналыг дэмжиж:

- Уг нь тэгдэг л байж, би аравхан төгрөгтэй гарсан маань бурууджээ гээд талбай дүүрэн хангинах радиогоор нэвтрүүлж байгаа цовоо хөгжмийн эгшигтэй сэтгэл нийлүүлэн алхалсаар халуун усны газар хүрчээ. Халуун усны хүлээх танхимд Пүрэвдоржийн тааж бодсоноос үнэхээр илүү олон улстай байжээ. Пүрэвдорж үзүүр нь мэдэгдэхгүй өлзий утас шиг тахирлан, сүлжилдсэн олон улсын цувааг хараад дэмий л Мишгээ өөд арга нь барагдсан царай гаргаж харав. Мишгээ үүдэн хавийн хүмүүст хандаж:

- Сүүлийн хүн хэн бэ? гэж зөөлөн дуугаар асуухад, зузаан гэгчийн ном руу хоёр нүдээ хамартайгаа шаачихсан нүдний шилтэй туранхай хөх залуу, би гэж хэлээд дахин ном руугаа шигдэв.

Тэр хоёр зэрэгцэн» сууж, хүлээгчдийг тойруулан ажиглалал энд тэнд ганц хоёр зүс таних хүн байхыг хараад холоос толгой дохин мэндэлцгээв. Хүлээгчдийн дунд уйдаж арга нь барагдсан хүмүүс ихэнх нь байвч ашигтайгаар хүлээж ном сонин уншиж байгаа хүмүүс ч мэр сэр харагдана. Тэр хоёрын эгц урдаас харж суугаа бүдүүн ягаан авгай ногоон ноосон утсаар жижиг хүүхдийн оймс нэхэж харагдана. Тэр авгайгаас зайтайхан хуучин хар савхин дээлтэй, хууз хар хүн яндан шуумагтай саарал өмдтэй хоёр урт хөлөө зөрүүлэн ачиж сунган жийгээд сандлын налуурган дээр толгойгоо гэдрэг хаян унтаж хурхирна. Зарим хүмүүс байн байн энгэнэтэл эвшээж нулимсаа арчина.

Энэ хоёр унших ном ч үгүй, нэхэх юм ч үгүй ирсэн учир чухам цагийг яаж өнгөрүүлэх билээ гэсэн байдалтай дэмий л байшингийн хана, дээврийг гөлрөн суухад байшингийн хананд

хадаастай, яарах «сэтгэл» нь элэгдчихсэн тэвчээртэй шар модон цаг 1 цагт 12 минут дутуу түг таг, түг таг гэлдэрсээр байна. Энэ үед гаднаас орж ирээд сүрдэн зогсож байгаа хэсэг хүмүүсийн дунд Пүрэвдоржийн ажлын газрын жижүүрийн жолооч Лхагва хүлээгчдийг нэг нэгээр нь шүүрдэн харж, хуруундаа нарийн сэнжтэй түлхүүр эргүүлж нүд нь тэр хоёрын дээгүүр өнгөрөн давхина. Пүрэвдорж Лхагвааг машинтай явж байна гэж мэдээд сийрэг чөлөөтэй халуун усны газар бодогдож:

- Лхагваа! гэж дуудав. Лхагваа Пүрэвдоржийг харж олзуурхан ирээд сандруу ярьсан нь:

- Дарга таныг олоод ир гээд би танайхаар орж энд байгаа гэж дуулаад ирлээ. За явья, за явья гэж шаардангуй хэлэхэд Пүрэвдорж Мишгээ рүү нүдээ шилжүүлэн! Хараад:

- Юу болоо юм бол. Дарга хаа байна? гэв. Лхагва гарахыг завдан эргэж:

- Контортоо, контортоо гээд улсын дундуур займран зүтгэв. Пүрэвдорж Мишгээг шинжсэн нүдээр харж:

~ Одоо яадаг билээ гэхэд Мишгээ огт дургүйцсэн шинжгүй уриалгахнаар:

- Чи яваад ир л дээ. Энд лав их удах байх, би байраа хадгалаад байж байя гээд юм суудал урагшаа ахив.

Лхагва Пүрэвдорж эмч хоёр давхисаар үүдэнд хүрвэл дарга нь тэднийг гадаа шатан дээр хүлээн зогсож байгаад угтан ирж:

- Май энэ утас нь, энэ онгоцны ирэх-очихын билет нь, за шалавхан яваарай. Булганы онгоцны буудал дээр машин хүлээж байгаа гэтэл Лхагва асаастай байсан тэргээ дор нь хөдөлгөж ОНГОЦНЫ буудлыг чиглэн давхив. Машин Туулын гүүрээр гарах үед нэг цагаас 15 минут өнгөрч байжээ. Пүрэвдорж газраас 2000 гаруй өндөрт хөвөрч онгоцны цонхоор доошоо элдвийг ажиглан явтал нугачин тахирлан урсах Орхон гол харагдаж халуун усны газрыг хүлээгчдийн цувааг санагдуулж цагаа харахад 2 цагт 15 минут дутуу байжээ. Удалгүй онгоц алгуурхан доошилж Булган аймгийн төв ярайн харагдаж гурилын тээрмийн өндөр барилга, олон хонины дунд ганц цагаан тэмээ зогсох мэт ноёрхуу харагдан өнгөрч, онгоцны дуу зөөлрөн шуугисаар хоёр гурав дэгдэж газардаж гүйсээр буудал дээр ирж зогслоо. Пүрэвдорж бууж аймгийн эмнэлгийн ГАЗ- 69 машиныг чиглэн гүйх шахаж явтал араас нь «Залуу! Залуу та ачаагаа аваач, ачаагаа аваач!» гэж дуудахыг сонсоод эргэж харвал Пүрэвдоржийн дотуур хувцас, алчуур, саван хийсэн жижиг чемоданыг нэг хүн барьж харуулна. Буцаж гүйн чемоданаа авч машинд хүртэл урьд их сургуульд хамт байсан танил залуу эмч угтаж машинд суулган яаруу дуудлагын учрыг ярьж давхисаар аймгийн больниц дээр ирж мэс засал хийхээр бэлтгэж хувцаслан бугуйныхаа цагийг тайлж байх үед 2 цаг 15 минут өнгөрч байжээ. Мэс засал хийхээр урьдаас бэлтгэсэн тул аймгийн эмч нартай товч бөгөөд тодорхой түргэн ярилцаад, өвдөн шаналж байгаа хүний амийг үхэлтэй булаацалдах хариуцлагатай шаргуу тэмцэлд оржээ. Уг мэс заслын ажиллагаа бага боловч осолтой нарийн эрхтэн болох учраас яаруу бөгөөд маш нямбай төвлөрсөн анхаарлыг шаардсан билээ. Дуудлагаар ирсэн үүргээ амжилттай дууссан эмч Пүрэвдорж сэтгэл нь тайвшран уужирч, гараа угааж бугуйндаа цагаа зүүж байхад 3 цагт 15 минут дутуу байхыг хараад манай улсын маань хөгжил ч сайхан болж

дээ. Би яг хоёр цагийн өмнө хүүхэнтэйгээ халуун усны газар хүлээн суусан хүн, тэгэхэд одоо 370-аад километрийн хол газар чулуудагдчихаад өдий төдий газар ус үзээд, нэг хүний амь аварчихаад байж байдаг гэж бодохоос бараг өөрөө ч итгэмээргүй юм шиг санагдав. Харин манай Мишгээ халуун усны кассанд ойртож байгаа болуу гэж бодоод хажуудаа байгаа сувилагчаас:

- Онгоц хэдийд буцах билээ? гэж асуухад, хонин шар нүдтэй хавтгай улаан бүсгүй инээмсэглэн хятад ёотонгийн чинээ дөрвөн том цагаан шүд гаргаж:

- Болоогүй ээ, 3 цаг 50 минутанд хөдөлдөг юм гээд годгор салаа

гээгнийхээ үзүүрийг сүлжин цэнхэр туузаар бөхлөөд мөрөн дээгүүрээ чулуудан:

- Эмч гуай таны чемодан үүдний жижүүр дээр бий шүү гэхтэй зэрэг Пүрэвдоржид санаа төрж:

Танай эндхийн халуун ус ойр уу гэж асуув. сувилагч:

- Ойрхон, ойрхон энэ харагдаж байна гээд өрөөний урд цагаан даавуу хөшгийг ярж:

- Тэр өндөр яндантай цагаан байшин гэж заасныг хараад бараг цаг шахуу зай байгаа тул түргэхэн усанд орохоор зориглон гарчээ.

Пүрэвдорж 30 минут хиртэй тавтай сайхан биеэ угааж аваад больниц дээр ирж машинд сууж нөгөө танил залуу эмчтэйгээ ярилцан захих, хэдэн юмаа ярьсны дараа тэр эмч:

-Энд ирчихээд манайхаар оролгүй буцах гэж дээ, халуун ус руу явчихсан байх юм гэхэд, манай хотод халуун усны газар тийм ийм ч гэж хэлэлтэй биш дээ, дэмий л нэрэлхэж би ажлынхаа дараа тэгдэг дасгалтай болчихсон юм гэжээ.

Онгоцны буудал дээр ирэхэд онгоц дөнгөж Хөвсгөлөөс ирээд бууж байлаа. Энд ирээд бүртгүүлэх гэж бараг нэг хуудас шахуу биеийн байцаалт, овог нэр, нас, албан ажил, яваа ажил хэргээс эхлүүлээд бичүүлж жижиг чемоданаа жигнүүлэх хүртэл бүх ёсыг нь гүйцэтгээд онгоцоор явдаг улс гараа барилцаж, даллах бүх ёс номоор нь журамлаж газраас тасран хөөрч нисээд Улаанбаатарын буудал дээр буухад Пүрэвдоржид гомдмоор юм нэг байдаг билээ. Эдний дарга явуулахыгаа мэдэхээс биш хэрэг нь бүтсэн бол буцааж авахаа мартчихдаг заншилтай юмсанжээ.

Пүрэвдорж онгоцноос бууж сайн өдөр ХЭНТЭЙГЭЭ утсаар ярих билээ, ядаж өвөрт нь улаан МӨНГӨ Ч байхгүй дэмий л гайхаж онгоцны буудлын хойт засмал зам дээр очоод цагаа харж зогсоход 4 цагаас 30 минут өнгөрч байжээ. Ашгүй танилтай хүн талын чинээ гэгчээр засмал замаар баруун талаасаа «ЯВА» маркийн улаан мотоцикльтэй загасны уурга гозолзуулсан залуу давхиж ирээд таньж зогслоо. Тэр найзынхаа араар суун <Булган орсон тухайгаа ярьж, тэр найз нь тохойноос том загас барьсан ба алдсан тухайгаа ярьсаар нисэх мэт давхисаар 5 цагт Пүрэвдорж гэртээ ирээд хоол ундаа идэж уун чемоданаа нээж нойтон алчуураа хатаахаар тээж, хуучин дотуур хувцсаа гаргаж, тавтай сайхан хэвтэж радио чагнаж байтал

хаалга дуугарч Мишгээ орж иржээ, Мишгээ усанд орж амжсан байдалтай нэлээн хүрэн ягаан болжээ. Гэвч арай илүү хүрэн болсон нь Пүрэвдоржийг ирээгүй тэр чигээрээ алга болсонд уур нь хүрч нэмэгдсэн биз ээ. Орж ирээд үг дуу ч үгүй чөмоданаа уудлан нойтон алчуурыг харж мөн хуучин дотуур хувцсаа сольсон болохыг мэдээд энэ хүн ингэж надаас зугтааж амиа борлуулж явдаг вий. Даанч унаа машин олоод хүн цөөтэй халуун усанд орёе гээд байсан юм гэх мэтчилэнгийн, элдэв хартай баримтууд бөөгнөрөн бодогдож энэ гэнэн хонгор бүсгүйн хоёр нүднээс нь нулимс өөрийн эрхгүй цайлан, хоёр чих, хүзүү нь хүртэл час улаан болон хувирч шууд Пүрэвдорж орж ирээд эхэр татан уйлж:

-За Пүрэвдорж минь намайг ингэж дарлаад яахав. Би чам шиг хөлдүү мөс шиг сэтгэлтэй хүнтэй амьдрах гэж бодсон алдаагаа эртхэн засч авья гээд нүүрээрээ зузаан өдөн дэр рүү шааж орон дээрээ очив.

Пүрэвдорж энэ бүх учрыг ойлгон тайлбарлан тайтгаруулах санаатай өндийж Мишгээг аргадан:

- Мишгээ чи ойлгооч, би чухал яаруу ажилтай яваад ирлээ шүү дээ гэхэд МИШГЭЭ бүр ч чанга дүүгарч:

- Юуны чинь ажил! Надаас зугтааж өөр усанд орсон чинь чухал байна уу ! гээд урьдаас нь түлхэв. Пүрэвдорж тэсгэлгүй инээд алдан:

- Үгүй ээ, би Булган аймгийн төв дээр усанд орчоод ирсэн юм мэдээ үү гэж чухалчлан үнэмшүүлэхийг оролдсон боловч Улаанбаатарт орж дээд сургуульд сураад, дөрвөн жил эм найруулагчийн ажил хотод хийж зүүн тал Налайх, баруун тал нь Сонгинын амралт, хойд тал нь Сэлбийн амралт урьд тал нь наадам, яармагийн байр хүрснээс хэтрээгүй энэ бүсгүй яаж ч үнэмших билээ. Харин улам уурлаж:

- Чи намайг доромжлох доромжлохдоо дэндүү тэнэг мунхагт үзэж байгаа юм биш үү. Ядаж хүн үнэмшмээр юм олж хэлж болсонгүй юу гэж уйлахыг нөгөө өрөөнөөс сонссон Пүрэвдоржийн эх Мажиг гуай орж ирээд:

- Хүүхдүүд минь та хоёр яаж байна? Усанд орохоор цуг яваад цуварч ирээд хэрэлдээд унах чинь больцгоо, больцгоо ямар шившгийн юм бэ гээд гарах гэтэл Мишгээ өндийж:

- Ижий, энэ чинь нэг жолоочтой нийлээд намайг халуун усны газар орхичоод өөрөө амиа бодоод, надаас зугтаад... гэж үргэлжлүүлэхийг

Пүрэвдорж таслан:

- Үгүй ээ, ээжээ! Би Булган аймаг нисэх онгоцоор ороод тэнд халуун усанд орсон юм байхгүй юу гэхэд Мажиг авгай уурлаж:

- Хүү минь чи бага шиг л солиороорой! Энэ чинь согтож л дээ. Чи одоо бүр архи уудаг болсон бий. Онгоцоор явж халуун усанд орлоо гэж юугаа донгосч байгаа амьтан бэ? Чи энэ муу бэрийг минь битгий зовоо! Би маргааш танай байгууллагын даргад очиж ярина вий

гайгүй гээд хаалга шилбүүрдэн гарав. Сандарсандаа тулгамдаж нэг инээд нь хүрч, нэг уур нь хүрэх шиг болоод ээрч зогссон Пүрэвдорж юу ч нотолж чадсангүй хоцорчээ. Гэнэт онгоцныхоо билетийг үзүүлж нотлох юм байна гэж санаанд нь орж нэг ухасхийгээд бас л дэмий оролдлого болно гэж бодоод таг чимээгүй болжээ.

Залуу эмч орон дээрээ бодод болон хэвтэж өнгөрсөн өдрийн явдлыг эргэцүүлэн бодоод хотод нэг хүн усанд ороод гарах завсар өөр нэг газар бас нэг хүн хичнээн их юм амжуулж болдог байна вэ гэж баярлан бас харамсаад инээд нь хүрэх боловч Мишгээгийн уурыг улам шатаахаасаа болгоомжлон инээдээ барин тэвчиж хэвтсээр үргэлжлүүлэн бодвол ер нь түргэн шиг, сайхан усанд оръё гэвэл Булган, Архангай, Өвөрхангай орчихвол амар юм даа, даанч үнэ ихтэй л болох юм гэж бодоод бас инээд нь хүрч хэлээ хазав.

Мишгээ Пүрэвдорж хоёрын маргаан ч яахав, маргааш нь тайлагдаж эв намдаа орох юм. Харин зарим талаараа манай хөгжил үнэмшигдэх аргагүй шуурхай давшиж байхад зарим талаараа тэр халуун усны газар шиг байх нь урамгүй юм гэж бодсоор залуу эмч зүүрмэглэжээ.

НУТГИЙН МИНЬ ХУН НУУРАНДАА БИЙ

Долдугаар сарын нэгэн цэлмэг сайхан өдөр бид хоёр зуслангийнхаа дэргэдэх ой руу явлаа. Шинэ орсон шиврээ борооны чийг ханхлан, газраас бүлээн уур савсаж, нарсан ойн шулуухан модод улам ч урт гоолигхон болчихсон харагдана. Нар хөөрөх тутам ойн доторх гялалзсан сахдаг ногооны өнгө бүдгэрч моддын завсар зангаар хөх суунаг татна.

Удаж өжсөн хөвд өвсний үнэрийг нялх ногооны сэнгэнэсэн үнэр, цэцэгсийн хурц анхилам үнэр даран ханхална. Бид хоёр ойн чөлөөнд гарч, бүлээхэн чийглэг ногоон дээр суулаа. Ойн тунгалаг агаарт шувуудын шулганан жиргэх нь сэтгэлд жигтэй зохицох бөгөөд алс тэнгэрийн хана хувиршгүй бүдэгхэн саарал өнгөтэй болжээ. Зулзаган нарс-ны үл мэдэгдэм хөдлөх торгон үзүүрийн дээгүүр хөх тэнгэр мэлтийж, үдийн нар бид хоёрын чанх орой дээр гарчээ,

- Тэгэхэд би хорин дөрөвтэй байлаа гээд Буян аль эртннхээ нэг явдлаа ярьж эхэллээ.

Зун амралтаа аваад нутагтаа очивоо. Тэгэхэд би татлаа түтлээ огт байхгүй, нэг үгээр хэлбэл дэгжин цэцэглэж явсан үе маань байжээ. Хорвоо дэлхий шиг мянга мянган хавар хүнд заяа үгүйг мэдэхгүй явжээ. Гэхдээ холын бодолтой байх гэж өөрийгөө зовоодог байжээ. Харин эмэгтэй хүнийг сонжин мэдэх гэдэг тун адтай сүрхий дон шүтэлсэн байсан. Манайх тэгэхэд Бага нуурын хөвөөнд Банди гуайнхтай зусаж байв.

...Гэртээ очсон шөнөө би жигтэйхэн бөх унтаж хоносон байв. Бие хөнгөрч, сэтгэл уужирсан гэдэг ч жигтэйхэн, ханатал нойрсоод аяндаа сэрсэн хүүхэд адил цовоо сэргэлэн болчихжээ.

Нар ханын элэгрүү бууж, зуухан дээр ээжийн буцалган буй ээзгийнээс хар бага наснаас минь ижил дасал болсон халуун сүүний гайхам үнэр ханхалж, гэрт жигтэйхэн талбиун чөлөөтэй юм шиг. Гадаа чимээ анир огтгүй. Харин хаяанд буй Бага нуурын усанд нисэн буун байгаа шувуудын ганганалдан шуугилдах нь урьд өмнө огт сонсоогүй хэдэн мянган хөгжмийн эгшиг алс холын уулсын чанадаас уянгалах мэт сонсогдоно. Зуны нимгэн өмд цамцтай чигээрээ гадаа гарвал ээж үхрийн зэлнээс тугалаа аажуухан гэлж байх бөгөөд алсын уул нурууд дуниартан, хөлийн дор зулсан ноос мэт зөөлхөн ногоо чийг дааж, хот суурин агаарын урьд хождын ялигүй бухимдуу бодлууд үгүй болсон байв. Тээр доор цэлмэг тэнгэрийн доорх Бага нуурын мандал өглөөний "Наран дор" мяралзан гялалзаж, энүүхэн дээхэн нүүгэлтэн ногоорох шинэс модон ой униартан байв. Бага нуурын жижигхэн Агбушанд хуран цугласан галуу, нугас, цахлай тэргүүтэн нисэн буун ганганан шуугилдах бөгөөд тэдгээрийн олон янзын жигүүр даль өнгө өнгөөр солонгорон харагдах нь зүйрлэшгүй үзэсгэлэн төгөлдөр байхын сацуу хонь шиг хоёр том цагаан хун нуурын усыг зүсэн нарийхан цагаан зам гарган аажуухан хөвөх нь үлгэрийн юм шиг байв. Би баруун монголын жирийн нэгэн ийм эрхүү тансаг байгалийн дунд өсөж өндийн өдий хүрсэн атал орчлон дэлхийн энэхүү гайхалтай сайхныг ингэтлээ сүрхий мэдэрч, сүйд майд болж байсан удаа урьд өмнө үгүй байсан мэт санагдлаа. Гэвч миний нүд болон сэтгэл сайхан юманд хэтэрхий дасчихсаныг байсан биз. Би хөл нүцгэн чигээрээ тэрүүхэн баруунтаа горхи руу явав. Уулын чулуудын завсар чөлөөгөөр ойж буун урсах горхины ус нь Тэр үе жигтэй харигаатан цуурайтаж байснаа гэнэт нам жим болж ахиад чагнавал сулхнаа пол пол хийн байв. Огторгуй гүйлгэнэн толигноод, агаарт тогтуухан хөх

суунаг татжээ. Хаашаа ч харсан нэн тавиун амгалан болчихсон ч юм шиг... хамраараа шуугитал цэнгэг агаар амьсгалан зогсоод ч баймаар... Би тэрхэн зуур чийг даасан зөөлөн ширгэн дээр толгойгоороо хэд годройтон биеийн чилээ гаргаад горхи уу гүйн очвол Банди гуайн Байгалмаа ингэн гуулин шанагаар ус хутган савхтай зэс хавчигт хийж байв. Тэр өнгөлөг бүдүүн ширхэгтэй шингэвтэр үсээ задгай тавин ямар нэгэн юмаар угаар нь чанга боосон тул өглөөний нарны гэрэлд үзэсгэлэнтэй толигор магнай нь онц гэрэлтэн байлаа. Байгалмаа үнэ хямд цоохор даавуун богинохон даашинзныхаа хормойгоор харах боловч тэрүүхэндээ зовхио анисхийн үгээр илэрхийлэх хэлэх аргагүй элэгсэг дотно болоод

- Та хөл нүцгэн явж байгаа юмуу хэмээн ихэд шохоорхон асуухад нь би шоглонгүй аяс оруулахыг хичээн

- Бага насаа бодоод... гэж хэлбэл Байгалмаа хөмсгөө өргөн, хар нүдээ хөгжилтэй анивчин инээмсэглэснээ хоромхон ичгүүрэн урт сормуусаа буулган нүүрээ буруулаад хувинтай усаа аван явав. Сугсалзсан ногоон дундуур цэлмэг тэнгэрийн доор нарийхан шулуун хөлөө яльгүй гадагш тавин, эрдүүхэн алхалж яваа тэр юутай бишрэм харагдаж байсан гээч. Би нүүр гар, цээжээ горхины хүйтэн усаар булхан угааж, цэнгэг анхилам агаар шуналтан амьсгалан, мөнөөх хивс мэт ногоон дээгүүр явж байхдаа цаглашгүй их юм хүсэн хүлээсэн хүний хангалуун таатай сэтгэлд бүрнээ умбасан байв. Чухам юундаа ингэж байгаагаа би хэлж мэдэхгүй байв. Тэр агаар, ус, байгалийн тансаг сайхандуу? эсвэл...? Тэгсэн атлаа би юу ч хүсэхгүй, юу ч бодохгүй байлаа. Би юу болчихлоо гэж ингээд байнаа гэж өөрөө өөрөөсөө асуугаад ч үүний хариуг тэрхэн үедээ оноон хэлэх аргагүй болжээ. Гэртээ ирээд гутал, хувцсаа өмсөн байтал тугалаа бэлчээрт гарган ирсэн ээж намайг харангуутаа нүүр царай нь улам бүр ялдамхан зөөлөн болж:

- Ээж нь хүүдээ... хэмээн үгсэн гал өрдөж, тогоотой эзгийг шалмаг түргэн хэд хутгаад аавын том шаазанд хэдэн хусуур хутган хийж, дээрээс нь зөөхий нь унжилдсан зөөлхөн цагаан өрөм овоолон хоёр гардан барьж:

- Миний хүү! Нухаш ид! Хот, суурин газрын улсад эзгийний ханд сайн юм гэдэг шүү! хэмээн хэлэхэд нь өргөн тавиун санчигт нь буурал орж буй ээжийгээ хараад өрөвдөх шиг ч, хайрлах шиг ч... нэгэн хачин сэрэл зүрх рүү харван ирсэн тул би ээжийн өгсөн аягатайг түргэн авч идэх гэсэн боловч цатгалдаад болсонгүй. Гэтэл аав, Банди гуай хоёр энэ тэрхнийг ярьсаар орж ирэв. Овор бие том, гүдэсхэн шулуун зантай Банди гуайгаас хэзээний цэрвэн эмээж явдаг би одоо харин түүнийг ихэд хүндлэн дээдэлж, үг яриагий нь сонсмоор, эс бөгөөс амьдрал ахуйг нь сонирхмоор. Тэр орж ирээд үүдний хавьцаа зогсосхийн азнахад би ээжээс урьгаж:

- Та өөдөө сууна уу? хэмээн явган жижигхэн сандал авч өгөхөд Банди гуай түүнийг хажуудаа сул тавиад сурсан зангаараа зүүн өвдгөө нугалан суунгаа хуучирч илсэн булигаарин ууттай тамхиа өврөөсөө гарган богинохон суман модтой урт цагаан гаансаа түрүүнээсээ сугалан тамхи нэрж, надад тамхиллаа. Аав ч бас жижигхэн улаан шүрэн толгойтой, халтар хавчиг манан хөөргөөрөө тамхилав. Банди гуай нас 60 гарсан гэхэд тун тэнхлүүн ануухан байв. Аав дөнгөж 50 хүрч яваа гэхэд онц ялгарах юмгүй. Банди гуай тамхиа шуналтайхан сорж миний нүүр өөд харан:

- Муу хөгшнийг минь дуулаа биз дээ. Уржнан намар өөд боллоо. Цаг улирал нь харин сайхан байсан шүү! Байгалмаа бид хоёр яахав болж байнаа. Охин маань ноднин наймаа төгсгөөд мал дээрээ саналаараа гараад ирсэн. Нэгдлийнхээ хэдэн үнээнд үнэндээ шаагдахгүй байна. Уг нь онц сурдаг шүү байсан юм. Одоо бас номноос салдаггүй хэвээрээ, Зан ааш нь хүртэл маньтай адилгүй юм даа! гээд дуугүй болоход нь ээж ярианд оролцон

- Тэгэлгүй яахав Банди гуай минь! Цагаа дагаж одооны багачууд аргагүй шүү дээ гэлээ. Гадаа Байгалмаа гитар цохин, түүний

«Нуураа чи хөлдөх гээд байна уу даа хө хө хө хө

Нугас гэдэг амьтан чинь хөөрхий боллоо доо хө

Ай хөөрхий амьтандаа хө хө» гэж эвлэгхэнээр дуулах дуулдана. Банди гуай бодлогошрон дуугүй сууна. Би ам нээж:

- Байгалмаа чинь аятайхан дуулдаг юм байна шүү гэхэд Банди гуай дуртай нь аргагүй

- Тиймээ! Ер нь маньд байхгүй нэг чухаг юм та нарт байх юм.

Үүнийг бол бид мэдэхээс цаашгүй юм даа. Харин дориухан мэдэлтэйхэн, дээгүүр зиндааны улс нь үүнийг ойлгодог биз дээ! Одооны залуучуудын хэн нь ч гэсэн аливаа юмыг ухаарахдаа сүрхий, ажилд ч гэсэн муугүй болцгоожээ. Харин нэг гэдийлэгчихвэл горигүй улс шүү гээд гаансныхаа толгойгоор модон хашилт тог тог цохин надруу нухацтайхан тайван харж байгаа нь егөөтэй сүртэй хөгшдийн нэг аргагүй мөндөө! Тэгтэл аав:

- Аав морийг чинь эмээлчихсэн. Миний хүү энүүхэн хойт ойгоор явахгүй юу! Энэ жил орой зун болсон ч одоо цэцэг, жимс жигдрээд аа бас сайхан болжээ. Даа ялангуяа цаашихнаа явбал ч базарваань хэлэлцэх аргагүй гоё, гоё! Ан амьтан ч дайралдаж магадгүй, аавынхаа муу оготор шар (карвин бууг хэлжээ)-ыг үүрээд яв! Гэхэд Банди гуай илт ундууцан:

- Өдийд ямар элэнцгийн ан байдаг юм гэхэд аав оочин сахлаа оролдон:

- Одоо тураг ан ч сайхан болж байна шүү Банди гуай! Энүүхэн энгэрт хэдэн аргал угалз уяатай юм шиг зуслаа гээд тооноор тэнгэр өөд харан шүүрс алдахад нь утас ээрэн суусан ээж:

-Чи юунд ингэж өчигнөж байдаг юм гэлээ. Гэтэл Байгалмаа «аргал угалз нуурт орж байна хараач» хэмээн хашгиран гүйн орж ирэв. Аав «за, тэршүү» хэмээн ухасхийн гарав. Ээж «хангайн амьтан тэгж л байг л дээ» гэлээ. Банди гуай ийм л хүн шүү дээ гэж хэлэх лугаа адилхан Байгалмаа руу хяламхийн харж «тэгээд яагаав» хэмээн зандрах завдан хэлээд босов. Би гэрэл зургийн хуучин муу аппаратаа шүүрэн авч гарав. Хорь, гучаад хирийн аргаль угалзын сүрэг манайхны үхрээс зүүнтэйгүүр нуурын уснаас ууцгаан, сүрлэг үзсгэлэнтэй толгойгоо өргөн сүүхэлзэн алсыг харах нь тун сүр жавхлантай байв. Тэгснээ усны шувуудын сүүдрээс үргэв бололтой толгойлогч данхар эвэртэй жавхлантай нэгэн угалз сүргээс цойлон одоход бусад нь түүний хойноос жооргонон гүйлээ. Тэдний ууц нуруу усны мандал шиг

мяралзан цайлалзсаар толгодын цаагуур далд оров.

Тэгээд би аавын эмээллэж зэхсэн борлог морийг унан ойрхон саахалтын газар буй ой руу явав. Нар өглөөнийхгэйгөө адил амгалан тайвнаар хөөрсөөр... тэнгэрт зурвас зурвасхан цагаан судал гарч, лүгхийм халуун өдөр болох шинжтэй. Ойруу дөхөх тутам чийг татам давирхай үнэртэж, хаа нэгтээ тоншуул мод тонших нь дамар цохих мэт цуурайтан дуулдана. Ойн дотор ямар нэгэн амьтан часхийн дуугарснаа цааш гүйх нь цэнгэг тогтуухан агаараар дамжин надад бүдэг бадагхан мэдэгдэв. Тэгтэл хар модны шилмүүс, давирхайн үнэр жигтэй гаргууд хадаж, бие хөтлөн хөнгөрөн, сэтгэл гайхалтай энгүүн чөлөөтэй болов. Иймэрхүү үед юм бүхний өнгө аяс зөөлөрч, тун жавхаатай сайхан харагдахыг хэлэх юун. Ойн захруу ороход өмнөөс сэрүү татаад бал бурмын үнэр ханхалж, шилмүүс, давирхайн үнэр дарагдан, нойрмоглон хөглийх сүрлэг моддын урт урт сүүдэр, мөлхөх мэт улам бүр богиносож байв. Моддын дээгүүр мэлтэгнэн цэлийх тэнгэрт ганц нэг элээ эргэлдэн, тэр алс дээгүүр хос ангир нутаглан дуугарсаар нуур тийш нисэн өнгөрөв. Би мориноос буун сахлаг ногоон дундуур туучин морио хөтлөн чанагш дөтөлбөөс үхрийн нүдний үнэр хамар цоргин, нар гийсэн ойн цоорхойд түүний багсайсан бут гялалзан гялтаганан харагдав. Би морио тушиж бөхлөөд очвол тэнгэр тольдсон тунгалаг хүрэн үхрийн нүд, хэлхсэн сувд мэт бөнжийлцэн, урт залаа нь газар шүргэн алдан байлаа. Түүнээс таслан авч баахныг идээд хөх тэнгэр ширтэн ая тааваараа хэвтэх аваас бие, сэтгэл урьд өмнөхөөс нэг л ондоо болсон байв. Ой доторх агаар үнэнхүү цэнгэг тул шувуудын шулганан жиргэх нь хүртэл тод агаад сэтгэлийг ер бус тайтгаруулан аргадах мэт.

Моддын мөчир аяархан хөдөлж, түүний бүдэгхэн халуун сүүдэр миний нүүрэн дээгүүр нааш цааш хөдөлнө. Би гэдэргээ харж хэвтээд алсын цэнхэр тэнгэрийн наагуур үймцэн хөдлөх нарийхан ногоон шилмүүсний намилзан хөдлөхийг ширтэн байлаа. Ойн дунд дээш харан ингэж хэвтэх юутай сайхан бэ! Тээр дээр цэлийн байх ёроолгүй гүн далайгаас тонгойх модод долгилох мэт агаад модны мөчир бага үдийн нарны гэрэл дээр ногоон сувд шиг нэг харагдаад агшнаа тогтнуухан балар ногоон өнгөөр гялалзан байв. Хөгшин шинэсний торгон үзүүрийн нарийхан мөчрийн зүү шиг шилмүүс хөх тэнгэрийн, наагуур усанд хөвөх мэт гүйлгэнэн байхад түүний наадах мөчир тунгалаг усны ёроолд хөвөх загас мэт ганцаар хөдөлнө. Тэнгэрийн мандалд хөвөлзөх хурган цагаан үүлс алгуур алгуурхан хөвөх бөгөөд нэг харахад хөлгийн дарвуул мэт цайран байснаа ахиад харахад ачаатай тэмээ шиг болно. Энэхэн үес үгээр илэрхийлж хэлэх аргагүй баяр баясгалан миний сэтгэлд хуран тунарчээ. Тэгээд миний уруулд сэтгэл ханаж баяссан хүний инээмсэглэл хоромхноо тодрон байгаа бололтой. Тэгснээ тэнгэрт ганцаар хөвөлзөх цагаан үүлсийг даган бие минь бас хөөрөн хөвөх шиг ч...

Би ингэж хэсэг амраад морио хөтлөн ойгоос бууж явтал Байгалмаа хувин дүүрэн жимс түүчихсэн, зүггүйрхэн найгасаар надруу дөхөж ирэв. Түүний байдлыг өдрөөр зүйрлэн хэлэх аваас хаврын нарлаг тэнүүн өдрийн өглөө шиг намуун ээлтэй, бас жавхаатай байв. Өглөөнийхөө цоохор даавуун даашинзтайгаа явна. Тэр ичгүүрэн, урт сормосоо буулган миний дэргэд ирэн даруухан суув. Түүний үсэнд наалдсан ногоон навчнаас үхрийн нүдний үнэр, бас өөр юу ч юм бэ эрүүл саруул сайхан үнэр сэнгэнэн нүүр царай нь туяаран, нүд нь үнэнхүү жавартай цоглог байна. Гагцхүү түүнд л байж чадах золбоолог сэргэлэн, хээ шаагүй байдал нь олон жил хот газар сууж, эрдэм номын мөр хөөсөөр үлбэгэр дорой мэт харагдах миний байдалтай огт нийцэхгүй байгаа бололтой. Тэгтэл Байгалмаа зүггүй ч гэмээр, доог тохуутай ч

юм шиг бяцхан маяг гарган инээмсэглэж:

-Та ингэж их удчихаад жимс түүдэггүй! гэж үгүүлээд хариу хэлэх завдалгүй

-Манай эндхийн байгаль сайхан шүү! танд ямар санагдаж байна? хэмээн тэнгэр өөд харан санаа алдав.

- Сайхнаар барахуудаа... миний бие бүр нялхарчихаад байна хэмээн хэлвээс Байгалмаа ой цуурайтгал хөхөрч

- Нялх болно гэнээ! хэмээн зүггүйтэн хэлээд

- Нээрээ сайхан-шүү! гээд эргэн тойрноо харан

- Өглөө эртхэн Бага нуурын эрэг дээр очвол... зогсоод баймаар ч байдаг юм гэснээ,

- Та жимс идэх үү? гээд төмөр хувинтай жимсээ надруу дөхүүлэн тавиад

- Манайхан дотор танай аав л жимсэнд их дуртай. Бусад нь хэтээсээ идэж чаддаггүй юм гээд өөрөө хэдийг авч амруугаа хийгээд газар ширтэн инээвхийлэн байснаа хоромхноо амгалан дөлгөөн» болж

Бага нуурын зүг ширтэн

- Миний хоёр цагаан алга! гэлээ. Би энэхэн зуур бүгчим халуунд нозоорсондоо чухам юуны тухай хэлснийг үл ухааран байтал Байгалмаа ахиад энэ үгээ давтан хэлэхэд нь би

- Үхэр үү? хэмээн асуухад Байгалмаа тас тас хөхрөн:

- Үгүй ч биш. Манайхны үхэр энэ харагдаж байна. Манайханд ерөөсөө цагаан үхэр байхгүй шүү дээ гээд надруу доогтойхон; харж:

- Багануурын хунг би хэлсэн юм. Тэр хоёр хун үхэр малаас хүртэл үргэдэггүй юм. Надаас бол бүр ч айхгүй. Халуун өдөр ойруу нисээд явчихдаг юм гээд дуугүй болсноо ялигүй гуниглангуй аястай

- Би тэр хоёр хунг харахаараа уйтгарладаг! хэмээн үнэнээ хэлээд

-Та уран зохиолын ном их уншдаг уу? гэж надаас зүгээр энгүүн сонирхон асуугаад

- Пушкины Евгений Онегинаас уншиж өгөхгүй юу? гэхэд нь би сүүлийн үес уран зохиолын ном уншихаа бараг больсондоо бантаж орхиод:

- Евгений Онегиныг би оюутан байхдаа орос дээр нь жаахан харж байсан. Одоо мартчихжээ хэмээн эв дүйгүй хэлчихээд ингэж хэлэхдээ нүүр улайн, нүд маналзаж аминдаа их л тэвдэж байтал ашгүй зүй-

тэй нэгэн бодол сэтгэлд зурсхийн орж ирсэн тул:

- Чи надад харин уншиж өгөөч! Би сонсьё гэлээ. Байгалмаа тоосрон хөхрөх тэртээ хөтөл тийш харан байснаа ийнхүү уншив.

<Татьяна юугаараа буруутан юм?

Залуу халуун гэнэндээ

Зартай тэр хүүхнүүд шиг

Залилж үймүүлж чадахгүй

Бодол хүсэлдээ хөтлөгдөн

Болгоомжгүй яваа нь буруу юу!

Гал халуун сэтгэлийг

Гялалзуур түргэн ухааныг

Зоримог шулуухан зантай нь

Зориуд бурхан заяажээ

Илүү дугуу ямар ч юмгүй

Ингэж дурласан тэр охины

Учир начиртай уянгатай сайхныг нь

Уучилж болохгүй гэж үү!»

Түүний цэвэрхэн цохолттой тод үгс тунгалаг агаарт цацагдан миний сэтгэлд бууж байв. Тэгээд Байгалмаа бугуйн дахь жижигхэн цагаа харж:

- Үнээ саах цаг болох нь... хэмээн үгүүлээд хувинтай жимсээ барин босов. Тэгтэл хунгийн аргил намуухан дуу алсаас дуулдлаа. Байгалмаа амьсгаа даран чагнаад:

- Эр нь дуугарч байна гэж хэлэнгүүтээ ийш тийш харан байснаа

- Тэр гараад ирлээ! хэмээн дуу алдан гараараа заав. Тэр зүг харвал ногоорон буй ойн дээгүүр хоёр хун хойно урьдаа орон, алгуурхан нисэх бөгөөд цас шиг цагаан өехийтэй томхон биетэй нь арай чанга дуугарч байв. Бие багатай орог саарал цээжтэй нь хойноос нь гүйцэн ирж хэдэнтээ зөөлхөн дуугараад далавчаа хумисхийн ойртоход нөгөөх нь огцомхон эргэн баруун тийш ниссэнээ ахиад л түүнийхээ өмнө орон уянгалаг зөөлөн ганганаж байлаа. Хоёр хун энэ мэт хойно урьдаа, дээр дороо орон ниссээр нуурын уснаа алгуурхан буув. Байгалмаа ихэд

хөхөн баясаж:

- Миний түрүүний яриад байсан хун даа! ямар байна хэмээн нүдээрээ инээмсэглэн үгүүлээд

- Хүн далавчтай бол ямар байх бол! гэснээ

-- Та бид хоёр далавчтай бол яаж нисэх бол! Хөх тэнгэрт алга болчихоод л... гэж хэлэхдээ Байгалмаа хачин уян намуун болов.

- Хүнд ерөөсөө жигүүр ургадаг шүү дээ гэж намайг хэлэхэд

- Яагаад! хэмээн инээв.

- Чи яваандаа мэдэх болно. Чамд нэг л мэдэхэд жигүүр ургана даа. Евгений Онегины Татъяанагийн байсан газрыг ч очиж үзнэ мэдэв үү? гэхэд тэр ихэд хөхөн баясаж хувинтай жимсээ барин явав. Би морио услахаар нуур луу очив. Халуун бөгчим агаарт нуурын ус хачин жигтэй тогтуухан болсон байв. Усны мандал дээгүүр үе үехэн жижиг жижигхэн атираа үүсэн: тэр дорхноо алга болж байх бөгөөд усны шувууд жижигхэн Агбушнаа цугларан шуугилдан ганганалдаж «Байгалмаагийн хоёр хун» мөн Агбушны сахлаг ногоотой эрэгт гарчихсан үзэсгэлэнт гоолиг хүзүүгээ сунган бие биенийхээ өд сөдөөр оролдон наадаж байв. Тэгснээ арай бага шиг нь хөлд орсон хүүхэд шиг явгалан гүйхэд нөгөөх нь суналзсан үзэсгэлэнтэй далавчаа дэлгэн хойноос нь дэгдэн хөөсөөр нуурын Апбушны шаргал зэгс рүү орон харагдахгүй болов. Би морио ханатал услаад гэртээ ирвэл аав, Банди гуай хоёр манай гадаа ногоон дээр ая тааваараа сууцгаан нуурын хойтох хөх уулын энгэр рүү дурандан байв. Байгалмаа горхины цаатах нугаас тугалаа ойртуулж явна. Ээж үхрээ хураахаар морджээ. Эрж хайж явсан чухаг юмаа арайхийж олсон хүн шиг аав дурангаасаа нүдээ үл салгана. Банди гуай угийн тайван хүлээцтэй зангаараа таг дуугүй дурандаж байв. Аав «ганц нүдний» дурангаа надад өгч

- Өнөөх хэдэн гөрөөс чинь тэр энгэрт идээшилж байна. Манийг бүр тоохоо больсон шиг байна шүү, цусаар урс, хүн амьтнаас зайдуухан бол нэгийг унагаад авах юмсан. Одоо ч цул өөх байгаа хэмээн үглэж байна. Би аавын өгсөн дурангаар харвал дөрвөлжин улаан цохионы хажуугийн ногоорон буй нугад хорь гучаад аргаль угалз хэвтэх нь хэвтэж, идээшлэх нь идээшлэн их л тогтуун байв. Харин сүргийн толгойлогч бололтой нэгэн үзэсгэлэнтэй том угалз цохионы дээдэх үхэр чулуун дээр данхайтал зогсон ийш тийш сортогон харх бөгөөд явдал дундаа ногоо ганц хоёр зулгаан өөдөхнөө очин алсын харуултай ногоон товгор дээр гаран, жавхлантай мөнгөлө хушуугаа агаарт сэлэх мэт ийш тийш хөдөлгөн анирдан байв. Энэ бүхнийг дурандан суусан Банди гуай:

- Сэргэлэн, цогтой амьтан шүү! өвсний сэргэг, усны тунгалгийг шилж явах амьтад хойно сайхан байлгүй яахав. Ер нь хангай шиг баян юм ч гэж хаа байхав дээ гэж бахдан үгүүлэхэд

- Естой доо! хэмээн би зөвшөөрөв

- Аав юунд ч юм бэ бухимдан хараал тавьж, гэрт орж гаран байхдаа

- Ээж чинь номхон морь унаад явчаагүй бол цаадуулыг чинь одоо л нэг оролдоод үзэх юмсан гэхэд Банди гуай надад ойртосхийн

- Цаадах чинь эднээс хороох дон шүгэлчихжээ. Ногооны цагаар юу хийхэв гэж аавдаа хэл! гэж арга мухардан шивэгнэв. Би урьд хожид ер тэгж байгаагүйгээр дур гутан, аавын хойноос гэрт гүйн орж:

- Та яах гээд байгаа юм. Танд угалз алахыг хэн зөвшөөрсөн юм бэ! ийм сайхан амьтдыг бас... гэж хэлээд сэтгэл арайхийж амарч билээ. Үүнээс хойш аав угалз буудаж эврийн нь хүүдээ өгнө гэж ер ярихаа байсныг бодвол СЭТГЭЛ бухимдсан залуу хүний хурц үзүүртэй үг хөгшдийг их айлгадаг бололтой. Чухамдаа аав, Банди гуай хоёр тэс ондоо улс юм. Банди гуай бол хүмүүстэй ихэд ойр дотно байх төдийгүй. АЛИВААГ ШУУН ТУНГААЖ байж хөдөлдөг сортоотой хянуур хүн юм. Аав бол уул ус мод чулуу, ургамал өвсөнд ойр дөт, түүнийг өөрийн тулд ашиглахыг бодохоос цаашгүй. Манайх хэзээний таргийн үнээ, шөлний хэдэн богоос цааш хэтрээгүй айл. Тэгвэл Банди гуайнх угийн мал хөрөнгөтэй, одоо ч бас бийлэгжүү тохь тавгай хэвээрээ байв.

Гагцхүү нийлсэн тонгорог шиг хурц зантай, гар сул, бүдүүн шар авгай нь хэн хүнд үгүйлэгдэж байлаа. Харин багадаа Байгалмаа шиг гал цогтой, номхон доройг үл тэвчих годгоносон охин явсан ч юм билүү хэн мэдэх вэ! Би яваандаа Байгалмаагийн хөдөлж барих, нүдний харц аяг ааш зэргээр нь юу бодон, яах гэж байгааг нь хүртэл тааж мэддэг болов. Энэхүү бяцхан охины юу нь л зөөлөн уян атлаа ил цагаан занд би ухаангүй татагдсан байв. Харин түүний гоолиг сайхан биед гар хүрч зүрхэлсэнгүй. Тэр миний дэргэд санаашрангуй ирээд зүрх түгшин ойрхон ойрхон амьсгалан, ямар нэгэн юмыг гөлрөн ширтэж байх нь хүртэл үл мартагдах бөгөөд задгай тавьсан гялалзсан хар үс, нүдэнд дулаахан улаа бутарсан ялдамхан бор царай, үргэлж инээвхийлэн байдаг жирэвгэр хархан нүд нь миний сэтгэлээс ер гардаггүй юм. Ямар ч байсан би тэр зун шиг жаргалтай байгаагүй. Энэ бол хүний амьдралд тун ховор тохиолдох зурсгээд өнгөрдөг чухаг учрал байсан биз.

Тэг тэгсээр миний амралтын хугацаа дуусаж буцах дөхөж байлаа. Би юунд ч юм бэ энд хоргодож байв. Өглөө үдшийн үнэгчлэн сэвэлзэх салхи нэгэн хэмээр пол полхийн урсах хажуугийн горхины чимээ, хагдран буй өвс ногооны өнгө зэрэгт хамрын аяс барин тавин мэдэгдэж, сэтгэл аяндаа гэгэлзэн байх боллоо. Харин Байгалмаа чухам энэ бүхнийг анзаарахгүй байсан биз. Түүний жаргалтай цоглог байдал насан туршийн юм шиг хэв янзаараа! Нэг өдөр Байгалмаатай уулзмаар болоод болдоггүй. Тэгээд тэдний гэрлүү явж байхдаа «Би Байгалмаад дурлалчхлаа гэжүү» гэж өөрөөсөө асуумаар боллоо. Тээр доор шувууд нь яваад эзгүйрсэн Бага нуур цайран харагдана. Харин Байгалмаагийн хоёр цагаан хун усны мандалд тун тайвнаар хөвж байв.

Намайг ороход Байгалмаа ном уншиж сууснаа царай нь уласхийгээд явчихлаа. Ус шиг цэнхэр, одтой торгон тэрлэг өмсжээ. Харин нүүр царай нь шинэ дээлтэйгээ тохироогүй мэт гунигтай байлаа.

- Банди гуай хаачсан бэ гэж намайг асуухад

- Сумын төв рүү явсан гэж товчхон хариулаад яаралгүйхэн гэзгээ гүйцээн сүлжиж цаашаа

эргэн надад үзүүлээд:

- Надад зохиж байна уу? гэхэд нь гол шиг сайхан биед нь дүйсэн нарийхан урт гэзгий нь гөлрөн ширтэж

- Зүгээр шүү! зохиж байна хэмээн дуу алдахаас наагуурхан хэлэв. Байгалмаа арай хөгжилтэй болж:

- Надад элдвийн юм бодогдох юм. Би бүр бага... ээжтэйгээ байгаа юм шиг болчихжээ... гэснээ гитараа аван тун түвэггүй түргэн хөглөөд хүсэл мөрөөдлийн нэгэн дууг намуухан тэгэхдээ бүр жигтэйхэн цэвэрхэн дарлаа. Энэ дууны үг, нь миний сэтгэлд бүр хоногшчихсон байв. Байгалмаа гитараа дарах завсар чөлөөгөөрөө над руу байн байн ШИРТЭЖ:

- Танд энэ дуу сайхан санагдахгүй байх шиг байна гээд хөгжмөө орныхоо толгойд өлгөөд

- Би эмэгтэй хүн мөртөө заримдаа хачин юм бодох юм. Аавыгаа дагуулаад ч юмуу хаашаа ч хамаагүй явчихмаар... нээрээ үнэн шүү! ном их унших тусгүй гэж үнэн үү? гэхэд нь

- Үнэний хувь бас бий. Харин сонгож унших хэрэгтэй гэхэд

- Би ямар ном унших вэ? та хэлж өгөөч! гэж үнэнээсээ асуув.

- Сонирхол... сонгож авах... хааяа завсарлах... гэхэд Байгалмаа

- Та надтай ярилцах дургүй байна уу? гэв.

-- Яалаа гэж дээ гэхэд тэр над руу ширтэн:

- Та намайг хөнгөн хийсгэлэн хүн гэж битгий бодоорой! Харин та жаахан муу санаатай байхаа! гэхэд нь миний инээд хүрэв.

- Та дандаа инээх юм гээд дуугүй болсноо

- Та намайг далавчтай болж ниснэ гэсэн. Би Улаанбаатарт очвол тантай заавал уулзана. Аа бас Пушкины Евгений Онегин дуурь үзнэ гэхэд нь

- Чиний өмнө зам бүхэн нээлттэй гэж би хэлэв. Байгалмаа тэгээд бас надруу гөлрөн ширтэж байв. Тэгтэл гадаа буун дуу тасхийв. Байгалмаа пондгосхийн цочоод, ухасхийн гарлаа. Би ч хойноос нь гарчээ. Нуурын захад суудлын ногоон «69» машин байх бөгөөд буу барьсан олийсон өндөр хүн- машинаасаа гаран! зүүн тийш гүйж харагдав. Байгалмаа

- Шувуу буудаж байна. Болиоч! хэмээн хашгираад Морь байхгүй яанаа! гэснээ манай гэрийн хаяанд байгаа миний унаж байгаа борлог морь руу гүйн очиж, тушааг тайлан мордон давхив. Тэр мориныхоо дэлд наалдан, бөхийж, салхи мэт хийсгэн машин руу дөхөн очив. Тэгтэл тэр хүн буудсан- хунгаа газраас шүүрэн авч машиндаа хийгээд тоос босгон хурдлав. Үлдсэн нөгөөх хун нь машин даган цахилан эргэлдэж зүрх шимшрэм орилж байв. Тэгээд Байгалмаа борлог морьтойгоо машинтай зэрэгцэн давхисаар бараа тасрав. Сэтгэл машид зовиурлан,

хойноос нь яаравчлан явах гэсэн боловч надад унаа олдсонгүй. Сумын төв рүү ноосны мөнгө авч, хоршоо худалдаагаар орох гээд манайхан цөм явсан тул үнэндээ хөл дүүжлэх юм надад яахин олох билээ.

Оройн үнээ саахаас өмнөхөн манайхан ирцгээлээ. Байгалмаа тэдэнтэй хамт ирэв. Тэр гунигтай байх авч хотоос яваа ангийн хууль зөрчсөн улсыг сум нэгдлийн захиргаанд хүргэж өгсөн тухайгаа их л сэргэлэн цогтойгоор ярьж байлаа. Тэдний буу, анг хурааж, 100 төгрөгөөр торгосон нь Байгалмаагийн хувьд их л багадсан арга хэмжээ болжээ. Тэр тэднийг хүний үнэргүй амьтад хэмээн нэрлэн дахин дахин ярьж, санаа алдан байв.

Үүнээс хойш нууранд ганцхан хун байдаг болов. Бага шиг биетэй эм хун нь үлджээ. Тэр хун тэрүүхэндээ сулхан ганганан нуурын хуйлрах долгионыг сөрөн ганцаар хөвсөөр байдаг болов. Нэг өдөр түүнийг харан нуурын захад зогсож байгаа Байгалмаагийн дэргэд би очив. Тэр толгой дээрээ том эрээн алчуур тавьж, айсан шувуу шиг бээвийн зогсол нь өрөвдмөөр байв. Намайг ойртон очиход нууранд ганцаар хөвөх хунг дуу шуугүй ширтсээр байлаа.

- Байгалмаа! Чи юу хийж байгаа юм бэ? гэхэд надруу дурамжхан хараад цаашихнаа ганц нэг алхав. Би очиж гарыг нь баривал цэл хүйтэн байлаа.

- Усны шувууд явчихаад байхад энэ маань ганцаараа... гээд түүний жижигхэн уруул нь арай ядан хөдлөн хэлэв. Түүний сэтгэлийг би засах санаатай

- Ганцаараа явж чадахгүй байгаа юм болов уу даа! гэхэд

- Тийм байх! гээд толгой дохилоо. Хойно хойноосоо эрчлэх долгионд нааш цааш шидэгдэн, хөвөх ганц хунг харваас нэг л уйтгартай.

- Байгалмаа! гэж намайг ахин дуудахад тэр итгэж ядан хүсэж хүлээсэн харцаар надруу тогтуухан гэгч харлаа. Тэгснээ тэр баруун гараараа миний гарыг атган, амьсгаа нь дээр, огцомхон болж намрын

навч шиг ч чичрэн буй зүүн гараа мөрөн дээр минь тавилаа. Би нүүрлүү нь харвал түүний хоёр нүд цог орчихсон мэт хурц болсон байх бөгөөд гоолигхон бие нь аандаа намуухан зөөлөн аястай балж хамар нь хавчийн үс нь нойтон юм шиг ар тийшээ налаад намайг түшихэд алчуур нь мөрнөөс нь мултран газар унав. Тэгээд Байгалмаа ямар нэгэн юмнаас айсан юм шиг надруу шуугатнан зүтгэж, суганд наалдахад нар салхины үнэр шингэсэн түүний гялалзсан үсэнд миний уруул аяндаа хүрлээ. Байгалмаа:

- Та намайг... гэж сонсогдох төдий шивэгнэхэд нь

-Юу хэлэх гэсэн юм бэ! хэл л дээ! гэхэд

- Та хэзээ явах вэ? гэж асуулаа

- Маргааш! гэхэд

- Аа тийм үү! гээд надаас хөндийрөхөд нь

- Хоёулаа ийшхэнээ очиж өвсөн дээр жаахан сууж юм ярья! гэж би гуйлаа. Байгалмаа нуурын мандалд цайран харагдах ганц хунг ширтэн байснаа

- Яах юм бэ! Би харилаа! гээд гэрийн зүг гүйн одов. Эзгүй хээр гэнэт мориноосоо салсан хүн шиг сэтгэл хачин эвгүй оргиод би ганцаар үлдлээ.

Тэгтэл хээр морио унасан Банди гуай надруу ирж явна. Би саяын явдлаа нуух гэж бодсондоо додигорхон алхлан урьдаас нь тосон очвол мориноосоо буун, цулбуурыг надад өгөөд:

- Миий хүү! морь услаад ир! гээд өөрөө тамхиа нэрэн дороо суув. Морийг нь услаад ирвэл Бандк гуай шөрөвгөр хэдэн буурал хөмсгөө хөдөлгөн

- Миний хүү зовох юм байхгүй. Манай Байгалмаа надад бас үнэнээ ярьсан. Ээжээсээ хойш намайг бүр ч зовоох болсон юм. Цаадах чинь хар модны хуурай шилмүүсний асаж байгаа гал гэсэн үг. Харин одоо болтол тэгээгүйгээс биш, хүнд

нэг сайн болчихвол хэцүү юм болно байх шүү. Ах нь заримдаа яахаа ч мэдэхгүй болчихдог юм гэлээ. Ингэж ичгэвтэр бөгөөд аймшигтай юм болов. Банди гуай тамхины үнстэй гаансныхаа соруулаас амаа үл салган, нуурын дунд ганцаар цайран харагдах хунг өндийн харж:

- Энэ хун ч энэ жилдээ Бага нуурын энүүхэн урьдах харзанд өвөлжих байлгүй. Тээр жил манай нутгийн онгиороо хар бас нэг хун буудчихсан юм. Нөгөөдөх нь эндээ өвөлжчихсөн шүү! гээд алс дээгүүр харж:

- Миний хүү зовоод байхын хэрэггүй. Ажил ахуйдаа буцалгүй яахав! Бид алзахгүй ээ! гээд бослоо.

Маргааш нь би явав. Өглөө эртлэн босож, юм хумаа жин тан болгоод, Байгалмааг орж ирэхийг хүлээв. Гэтэл тэр ой руу ганцаараа явчихсан байлаа. Ээж тэрүүхэндээ сандран арга нь барагдан дуу шуугүй болжээ. Банди гуай яах ч учраа олохгүй гаднаа тайван энгүүн байхыг хичээж байв. Аав «өвчтэй юм, тэрүүнтэй уулзсан уулзаагүй яадаг юм бэ» хэмээн үглэн бухимдаж байлаа. Би аавд битүүхэндээ уур хүрч байсан хэдий боловч дуугарсангүй. Тэгээд арга буюу аймгийн онгоц буухаас урьдаж сумын төврүү аав бид хоёр мордлоо гээд Буян яриагаа төгсгөн халсан газар тас гэдэргээ харан хэвтэж, гоолиг нарсны оройн гялтганах мөчрийг нүд онийн харж:

- Ингээд бас өнгөрөөгүй шүү! Улаанбаатарт ирээд ажилдаа дөнгөж орж байтал анхны захиа нь шуугиж ирвээ гээд Буян Байгалмаагийн захиануудыг уншив.

Нэгдүгээр захидал

Ховорхон тохиолдох танд хэлэх гээд хэлж чадаагүй үг минь дэлбэрэн гадагшаа гарахад би ямар янзтай болдгийг та төсөөлөн бодохгүй яваа биз. Надад ямар ч юм тохиолдлоо гэсэн

амьд явахын бахдал, түүний баяр баясгаланг амсахын төлөө тэмцэх ёстой биз дээ. Би гагцхүү өнгөрсөн зун таны дэргэд байхдаа хүнд заяаж болох бүх жаргал баясгаланг эдэлсэн. Усны шувууд хуран цугладаг Бага нуур минь, анхилам үнэрт хар модон ой минь таны сэтгэлийг хэрхэн хөдөлгөж байсныг эргэн санана уу! Тээр тэнд та бид хоёрын жимс түүсэн ой харагдаж байна. Тэр ойн цаадах хөхрөх уулын орой дээр гараад эргэн тойрноо харвал юутай сайхан байх бол. Өнөөдөр Бага нуур маань шуугин долгиж байна. Захад нь очихоос ч айдас хүрэм эвгүй байна. Миний сэтгэлийн ганц зугаа болсон хун минь үзэгдэхгүй байна. Бодвол халуун орон луугаа явсан биз. *9-р сарын 15.*

Хоёрдугаар захидал

Өнөөдөр хун маань нуурандаа эргэж ирсэн шүү. Түүний тасралтгүй орилох нь харин гайгүй болжээ. Гэхдээ хөөрхий минь хөлдөх гэж байгаа нуурын хүйтэн усанд ганцаархнаа хөвсөөр л байна. Бага нуур маань хунгийн зовлонг мэдэж байгаа юм шиг долиглон шуугихгүй байна. Би гунигтай бөгөөд баяртай байна. Ойн гүнээс эх авсан горхины маань зуны нөгөөх омголон шуугиан нь намдан, ус нь татран, өвс нь хагдарчээ. Гэсэн ч дахин хавар болж, мод нахиалан, цэцэг, жимс цэцэглэнэ. Тэгээд зун болоо. Харин та амралтаараа нутагтаа ирэх үү? Би их тэнэг шүү! Та надад битгий уурлаарай! Нуурын захад таны суганд толгойгоо наалдуулан, нүүр лүү чинь харж байсан тэр, газар очих дуртай болчихжээ. Энэ тухай бүхэл бүтэн найраглал бичсэн ч болмоор байна. Магадгүй шүү! Харин танай аав эндхийнхээ хэдэн аргал угалзыг оролдохоо бүр байсан. Энэ бол таны авсан чухал арга хэмжээний ач юм. Хангайн энэ үзэсгэлэнтэй онгон догшин амьтад үргээж цочоохгүй бол хүнд амархан дасдаг юм байна. Тэд манайхны үхэр мал шиг хаяанд байдаг болсон. Би бүр дэргэдээс нь харж, баясаж байна. Би ёстой л хүүхэд юм даа! *9-р сарын 30.*

Гуравдугаар захидал

Захидал бичилгүй удсаныг минь уучлаарай! Таны явуулсан захидлыг олон дахин уншлаа. Та зун нутагтаа ирэхгүй юм шив дээ. «Яаж ч мэднэ гэсэн таны үгний утгыг арав хорь дахин уншиж байж миний тэнэг толгой арайхийж ойлголоо. Харин та өнгөрснийг хэзээ ч битгий мартаарай! Өчигдөр би, та бид хоёрыг уулзсан хэдэн дэрсний түүгээр явахад надад хичнээн сайхан байсан гэж санана. Та бид хоёрын анх уулзсан горхины тэнд би бас очлоо. Миний хун харзандаа тавтай өвөлжиж байгаа шүү. Би таныг бодохоороо гитартаа хэдэн дуу дардаг. Дахин уулзталаа баяртай. Шөнийн нэг цаг болж байна. Сайхан нойрсоорой! Баяртай! Буян минь баяртай. Чамайгаа би үүрд мартахгүй. *12-р сарын 31. Б...*

Энэ бүхнийг сонсож хэвтсэн би

- Тэгээд... нутгийн чинь хун одоо ямар янзтай байгаа вэ? гэж тоглоом шоглоомын аяс оруулан асуувал Буян тохойн дээрээ өндийн ийн үгүүлэв.

- Чамд үнэнээ хэлэхэд би хэд хэдэн хүүхэнтэй танилцаа биз дээ. Гагцхүү Байгалмаа миний сэтгэлд үлджээ. Харин би түүнд олон дахин захиа бичээгүй. Түүнтэй суусан бол балрах ч байсан байж магадгүй. Тэр ер нь гоц сэтгэлийн хөдөлгөөнтэй, онцгой хүүхэн байсан байдаг шүү. Түүний энэ захиануудыг хадгалж баймаар санагдаад байдаг юм. Биед наалдан, нүүрлүү харж байсныг нь хүртэл мартаж арга байхгүй. Сэтгэл гижигдсэн урьхан инээмсэглэл, хүүхдэрхүү яриа, цовоо сэргэлэн хөдөлгөөн, гитар хөгжмөө цохиж байгаа нь хүртэл хэлэхийн арга байхгүй ээ. Тэр зуны үнэр танар, ой мод, жимс ногоо, усны шувуудын ганганаан, хунгийн дуу сүр жавхлантай аргаль угалзын сүрэг цөм л дотор зураад, толгойд яг л биччихсэн юм шиг л байна. Байгалийн энэ бүхэн хүний зовлон, жаргалыг хуваалцан мөнх байх зүйлс бололтой. Харин би түүнээс хойш чухам ямар болсон билээ гээд бодохоор... Байгалмаагийн сэтгэл хөдлөм тэр сайхан юмнаас чухам юу нь үлдсэн бол. Тэр маань чухам хаахна яваа бол! Хатуухан хорвоогийн хууль хааш нь аваачсан бол гээд Буян босож, явахаар завдав. Би ч бослоо. Бни хоёрыг буцахад нар баруунаа ташин, сэвэлзэх салхин, үд дундын жин халууныг элдэн хөөж сэрүү татан байв.

ГАГНААС

Ажилд анх орсон залуу мэргэжилтэнд амьдрал, дээр аль хачин юм тааралдахыг тэр гэх вэ.

Сургууль сая төгсгөсөн залуу инженер Ойдов Хүнүй голын баруун эрэг дээр суурилсан хангай нутгийн нэгэн нэгдэлд орлогч даргаар томилогджээ. Дарга инженер хоёр бие биеэ их л өөрөөр төсөөлөн бодож байжээ. Дарга нь инженерээ нийслэл хотын эрдэм сурлагатай залуугийн нэг гэж дуулаад дэгжин илгэн хүрэм юм уу нийлэг эдээр хийсэн пальто өмссөн, сахлаа юм уу үс хуузаа ургуулсан, өндөр цагаан залуу санаанд нь бууж байжээ. Гэтэл түүний оронд техникумын ямар ч ангийн охин огт хачирхалгүй «найзаа» гэж үерхэм насны нялдгар царайтай, усгал харцтай шувтан мөртэй намхан бор залуу монгол дээлтэй хүрээд иржээ. Ажиглавал энэ залуу морин дэл дээгүүр дарцаглан давхиж өсөөд аймгийн арван жилийн хайсан хашаа дүнзэн байшин дотор эрдэм боловсролын навч нахиагаа дэлгэсэн хөдөөний залуу сэхээтнээс гойд ялгарах юмгүй шиг. Харин оюутан нөхдийнхөө дунд «мэдлэг Ойдов» гэдэг содон хочтой байсныг нь даргын нүд хичнээн гярхай ч гэсэн энэ даруухан бор залуугаас яахин олж харах билээ.

Инженер бус энэ нэгдлийн даргыг «Бүхэл бүтэн шинжлэх ухаантай тэнцэх их дадлага туршлагатай сүрхий овжин хүн бий» гэж аймгийн намын хороон дээр хэлэлцэхийг дуулаад даргыгаа тухтай удаан хөдөлгөөнтэй, хүнгэнэсэн дуутай, догь бүдүүн эр угтах биз гэж төсөөлж байжээ. Тэгтэл төсөөлөн бодсон хүний нь оронд дэгдэгнүүр хурдан хөдөлгөөнтэй, арын ширэнгэнд ургасан чилгэр улиас шиг өндөр хар хүн ширээний ард сууж байжээ.

Тэр дарга инженерийн дипломын хавсралтыг сонирхон үзвэл цөөхөн дундтай, сайн онц голдуу дүнтэй суралцсан залуу болохыг сая мэдэж:

- Чи чинь тэгэхлээр сургуульдаа дан онц дүнтэй суралцаж амжаагүй хүн юмаа? Чамайг чинь сүрхий сурлагатай хүн гэж танилцуулж байсан шиг санагдах юм гээд «Энэ маань миний захисан хүн мөн үү биш үү?» гэж эргэлзэн тэнсэх мэт орлогчоор томилогдож ирсэн хүнээ сүрхий ажиглажээ.

Энэ алдартай даргын амнаас санаандгүй байтал төмөрлөг өнгийн жингэнэсэн дуу гарна гэж огт бодоогүй байсан Ойдов баахан ичингүйрхэх мэт инээмсэглээд:

- Тийм ээ, би алаг булаг л дүнтэй сурч байсан даа гэж аяархан дуугарвал дарга нь:

- За тэр ч яахав. Танилцъя! Намайг Ядамжав гэдэг гээд тэмээлзгэний хөл шиг урт нарийхан хуруутай гараа сарвайхад Ойдов нэрээ хэлж хүүхдийн гар шиг үе болгонд нь хонхор гардаг богинохон мөгдгөр хуруутай гараа хариу сунгажээ. Дарга,

- Би энэ нэгдлийг толгойлж суугаа хүн. Гэтэл толгой минь мэддэг юмаар дульхан. Тэр дундаас техник механизмын талаар бол бүр ч паг суучихаад сүрхий доголдож талдаж байлаа. Ашгүй чи мэдлэг мэргэжилтэй хүн хүрээд ирлээ. Одоо би мэдэхгүй чадахгүй бүхэндээ чамайгаа л түшнэ дээ. Би өөрөө бол үнэндээ хөдөө хөхөрч гадаа гандаж практикаар л тэмтэрч зүтгэж яваа хүн гэж хэлэхэд нэрмэлийн аарцны хурууд шиг чилдэн хөх царай «хөдөө хөхөрсөн» гэдгийг нь батлах мэт санагдвал инженер золтой л инээд алдсангүй.

- За тэгэхлээр миний мэдэхгүй мухарддаг юман дээр чи сурсан эрдмээрээ тусална. Чиний тулгамдсан зүйл дээр би хар практикаасаа хавьтах юм байвал нэмэхийг бодно. Ингээд хоёулаа энэ айлын ажилд зүтгэнэ дээ! гэж аминчлан захиж аргадах мэт хэлжээ.

Ингэж танилцаад хэлэлцсэн ёсоор ажиллаж байтал зул сарын хуучдаар ийм нэгэн явдал болов.

Ядамжав дарга унтаж байгаад шөнө гэнэт сэржээ. Бөөр нь цухуйсан бөөрөнхий босоо пийшингийн ачаар үргэлж дулаахан байдаг өрөө тасалгаа нь мөлүүхэн хүйтэн болсон байна. Дарга даараад сэрсэн бололтой. Хурган дотортой дээлээр давхар тумлайдан хучлаа. Угийн хөнгөн нойр нь үргэж дэрхийсэн ятуу шиг гэнэт сэрж замхарсан тул хэсэг зуур эргэж хөрвөж хэвтгэл голын зүгээс тас няс хийх бүдэгхэн чимээ гараад байх шиг. «Юу вэ? Мөс үү? Гол хадаалж, гадаа ер нь тачигнан хүйтэн хонолоо доо. Очиж очиж өнөө шөнө ингэж хүйтрэх гэж! Өглөө модонд гарна гэж байдаг. Үгүй ээ мөн хясаантайя!» гэж сэтгэл зовнин боджээ.

Тэд өглөө эрт хүн амьтан ажилдаа цуглах гэж яарч байхад Ядамжав дарга харин албан тасалгаанаас гадагшаа гарахаар яарч адгуу гараар ширээ шургуулгаа түгжиж цоожилж байжээ. «Еэ дээ, гайтай хүйтэн хонолоо доо. Гадуур юу болоо бол?» гэсэн түгшүүрт асуулт өгзөгнөөс нь шивээд авсан мэт ухасхийн бостон инженер орж ирэв. Түүний араас уур цан маналзан орж ирэхийг үзвэл орлогч даргын хойноос бөөн гай үүд хаалгаар шургалах мэт тавгүй харагджээ. Орлогчийн нь гялтгар бор царайд урам хугарч, гайхаш тасарсан шинж ил байв.

- За тавтай юу? Цаагуур чинь юу болж байна! Одоо ингээд гарахад бэлхэн биз? гэж давхцуулан асуусны цаад утга нь «Юу болоо вэ?» гэсэн түгшүүрт ганцхан асуулт байжээ.

- Дарга минь балраад байнаа. Модонд гардаг өнгөрлөө гэж эхэлтэл,

- Үгүй ээ одоо тэр чинь яаж байгаа нь тэр вэ? гэж дарга адган гайхсанд:

- Яах юу байх вэ? Тракторын маань мотоор хага хөлдөж орхижээ гэсэнд даргын онигор нүд моторын тэр хагархайг инженерийн магнай дээрээс олж үзэх гэсэн мэт бүлтийн ширтээд:

- Үгүй ээ тэр чинь одоо яахлаараа тэгдэг байна? гэхэд

- Баларсан Дамбаас л болоод тэр! Маргааш модонд гарахаар бэлтгэж янзал гэсэн чинь маанаг гайхал чинь устай нь хонуулаад зад хөлдөөчихөж... гэж учирлавал...

- Үгүй ээ мөн золиг оо! Тэр зузаан ширэм чинь тэгээд хагарчихдаг хэрэг байжээ. Яаж хагарах вэ? Арай тас няс гэж дуугарахгүй биз? гэж дарга нь сонирхсон ажээ.

Энэ тэнэг ч юм шиг хачин асуулт залуу инженерт доромжлолт даажин, хорсолтой тавлалт санагдан эгдүүт хүргэсэнд:

- Яаж, ямар дуу гарч хагарсныг нь би мэдэхгүй. Хагарах нь яах аргагүй л хагарчихсан байна лээ. Та үнэмшихгүй байгаа бол өөрөө очоод шалгаад үз л дээ! гэж хэгжүүрхсэнд тэр хэгжүүн

нь даргад бас халдсан мэт

- Үгүй ээ чи юу яриад байна. Мотор хагарчихжээ гэдгийг чинь итгэхийн цаагуур итгээд байна. Урьд шөнө гадаа даанч тас няс хийгээд байсан юм. Би мөс хадаалж байна гэж бодож байсан юм. Тэгэхнээ нь мотор чинь хагарч байсан юм байж л дээ гэж дооглож шоглож байгааг ч бүү мэд, үнэн голоосоо хэлж байгааг ч бүү мэд, янзтай хачин юм хэлжээ.

Ядамжав дарга дараа нь буруу гарын долоовор хуруугаа тохийн чичилж:

- За тэр ч яахав. Нэгэнт хагарчихсан хойно одоо яая гэх вэ! Төлөвлөсөн ажлаа нураалтай биш, чи инженер хүн байна, тэднийгээ нэг аргалаад ууланд аваад гарч үз дээ! гэж тулгасанд залуу орлогч талийгаачийг босгож тулалдаанд оруулах тушаал авсан эмч мэт гайхаж:

- Дарга минь хагарчихсан моторыг чинь би одоо яаж аргалах болж байна? гэж эргүүлж асуун татгалзсанд инженерийн аргагүйдсан байдлыг дарга нь бас гайхсан янзтай:

- Чи тэгээд арга чарга нээрээ мэдэхгүй юу? Сургуульд чинь заадаггүй юм уу? Гүй ээ мөн хачинаа? Тэгвэл одоо яах вэ, цусаар гагнаад л үз дээ гэж зөвлөсөнд залуу инженер «дарга маань солиорчив уу?» гэсэн янзтай хэдэн хором дуугүй ширтэн байснаа гэнэт: «Мэдлэг чадварыг минь басаж их доромжлох нь шив дээ?» гэж уур нь хүрсэн бололтой царай нь хувьсхийж:

- Дарга аа, та одоо юу ярьж байна? Хага хөлдчихсөн тракторын моторыг цусаар гагнана гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж илтэд эгдүүцсэн аялгаар асуужээ.

- Үгүй ээ чи чинь одоо цусаар гагнахыг мэддэггүй юм уу? Ном дэвтэрт чинь юм байдаггүй юм уу? Үгүй ээ мөн хачинаа? гэж үнэн голоосоо гайхан сонирхсон бололтой хэлжээ. Үүнд инженерийн өтгөн зэгсэн дотроос мэлтэлзэх харз адил сормууслал хар нүдэнд уур уцаар туналзан:

- За мэдэхгүй юм даа! Би хувьдаа хагарсан ширмийг цусаар гагнаж болдог гэдгийг чинь дуулаа ч үгүй, заалгаач ч үгүй, олж уншаа ч үгүй юм байна гэсэнд Дарга,

- Үгүй ээ бас хачин юм даа. Мэдмээр л юм даа! За за маргаад яах вэ. Ажил болохоо байлаа! Одоо гарцгаая! гээд год харайн яаран гарахад инженер хойноос нь урамгүйхэн» дагалдав.

Гадаа явган шуурга маналзан тэнгэр цэлмэж, балчир есийн үзэгдээгүй хүйтэн тачигнаж байлаа. Адгаж гүйн гарсан даргатай конторын үүдэнд бичээч хүүхэн, золтой л халз мөргөлдсөнгүй, дуу алдан зог тусжээ. Түүний араас ерөнхий нягтлан бодох тэргүүтэй ууланд гарч мод хийлцэх хүмүүс цугларч айсуу харагдана.

Хар даавуу дээлтэй өндөр хөх дарга тэгш мөртэй, хаалганы гуя хийхээр харуулдаж зассан банз шиг хавтгай цээжээ цэх болгож:

- Үгүй ээ та минь, өнөөх модонд гарах тракторын маань мотор хага хөлдчихсэн гэнэ. Үгүй мөн солиг оо! Одоо яая гэх вэ цусаар гагнаж үзэхээс... гэж цугларсан хүмүүст хэлээд бичээч

тийш эргэж:

- Аль вэ Хандаа чи гүйгээч! Айлаас ч юм уу гэрээсээ ч юм уу хэдэн яс олоод ир! Шатаах юм чинь ямар ч яс хамаа байжуу! Мэдэв үү? гэж урт долоовор хуруугаар занган хэлэв. Дараа нь өнөөх хуруугаараа орлогчийн зүг дохиж:

- За инженер ээ! Чи яваад малын бүлээн цус нэг жаахан олоод ир! гэсэнд

- Даргаа би энэ хүйтэн өдөр тэр бүлээн цусыг чинь хаанаас олох вэ гэсэнд

- Хаанаас ч хамаа байж уу! Цаад айл амьтнаар сураглахгүй юу? Малаас шприцээр соруулсан ч болно. Ганцхан бушуулж үз гэж дарга шаардлаа.

Цүдгэр их харвинтай, майга хөлтэй, намхан бүдүүн ерөнхий нягтлан бодох хажуунаас нь:

-- Инженер ээ чи нярвынхаар ор. Эхнэр нь сая хөнгөрсөн юм. Урд шөнө байна уу шөлний юм гарсан даа. Түүхий цус үлдсэн байх ч магадгүй гэж зөвлөв.

Инженер илбийн юм олох даалгавар авсан жаал хүү шиг яаран нярвынх руу гүйлээ. Тэр зуур: «Зугаатай юм болох нь. Намайг доромжилжээ гэхэд эднийг арай ингэмгүй юм даа... Тракторын моторыг цусаар гагнана гэнэ? Моторын тэр их халуун... бас даралт... мөн завхарчихсан юм боддог өвчтэй эр юм даа. Бас тэгээд энэ хар хүйтнээр халуун цус ол гэнэ шүү! Хярамцагны хөлдүү цус л олдож магадгүй» гэж сэтгэл дотроо даргатайгаа марган бодоход инээд ч хүрмээр юм шиг, нэг бодоход уур ч хүрмээр юм шиг хачин санагдаж байлаа.

Ерөнхий нягтлан бодохын инженерт үг зөвлөхийг сонсоод дарга «ашгүй чи энд байна уу» гэсэн шиг түүн тийш эргэж илбийн очроор дохих мэт аанай л долоовор хуруугаа гозойлгон зангаж:

-- Гэлэг ээ, чи яваад хэдэн хагадас залтас олоод ирж үз! Цаагуур чинь аж ахуйн хашаагаар хагалсан юм байна уу? үгүй юу? хуурайхан шиг л юм бодож үзээрэй! гэж даалгасанд нягтлан бодох «За!» гэж яаран зөвшөөрсөн боловч хөл нь хэл шигээ шалмаг хөдөлж өгөхгүй байгаа бололтой зараа шиг хайвга хайвга хийсээр түлээний хашаа руу алгуурхан бөмбөрөв.

Инженерийн аз болоход нярвын авгай нярайлахад гаргасан хонины цуснаас жаахан түүхий цус саванд үлдсэн байв. Түүнийг сэнжтэй төмөр аяганд хийн авч ирвэл гараашийн дэргэд хэдийн түүдэг гал өрдөж бичээчийн авчирсан ясыг шатааж байжээ.

Хэргийн эзэн Дамба тракторч ч ирчихсэн байв. Энэ хонин шар нүдтэй, унжуу хамартай урвагар залуу азарган нөхий дээл, том хар эсгий гутал, үнэгэн лоовуузтай лүглийн зогсох нь тракторын гэм зэмтэй жолооч даргадаа зэмлүүлж байгаа биш, харин саяхан ойгоос баригдаж ирсэн зэрлэг баавгай өндөр хөх шонгоос уяатай зогсож байгаа мэт харагдаж байжээ. Ядамжав илбэт долоовроороо чичлэн:

- Гүй ээ Дамбаа чи чинь одоо яахлаараа тракторынхоо моторыг хага хөлдөөчихдөг билээ? гэсэнд

- Өглөө бэлхэн байлгана гэхлээр нь устай нь хонуулчихсан чинь хага хөлдчихөдөг новш байж л дээ гэж тэр тракторчин ер юм болоогүй юм шиг гудиггүй хэлжээ.

- Үгүй мөн хариуцлагагүй хүнээ! Яг эгзэгтэй ажил дээр ингэж хяссанд орвол чи миний толгойг хага цохисон бол шулуун байсан юм. Даанч яачихсан хүн бэ чи гэхчлэн зэмлэхэд цаадах нь даргын нүүр өөд мэлрээ шар нүдээр дув дуугүй ширтэх нь «Даргын энэ цомбон толгой нээрэн мотороос бөх болов уу?» гэж гайхан бясалгах мэт.

Ядамжав дарга нь нярвын төмөр уурыг авчруулж шатаасан ясаа нунтаг болгон нүдүүлж бор саарал өнгөтэй гурил шиг юм болгов. Түүнийг инженерийн олж ирсэн цусаар зууруулж моторын хагархайг шавуулж ан цавыг чигжүүлжээ. Тэгснээ гэнэт мартсан юмаа санаж, - Пээ та минь! Гагнуур бий билүү? гэж сэтгэл түгшин дуу алдсанд тракторчин Дамба гэмээ наминчилж унжуу хамраараа газар онгилох гэсэн мэт дуугүй хоёр гурав дохисхийгээд гагнуур олж ирэв. Ямар азаар түүнд энэ багаж байнаа гэж дор бүрнээ гайхан ярилцав. Тэгээд мөнөөхөн цус ясны чигжээс шаваасаа халуун гагнуураар сайтар шарж ширээн хиншүү ханхлуулав.

Ингэж цусаар гагнасан мотортой трактороо асаагаад үзвэл дажгүй хүрчигнэж байхыг үзэж гайхан шагшсаар модонд гарцгаажээ. Ганцхан Ойдов инженер л итгэж ядан «Одоо эс гэхэд хэдэн цагийн дараа, өнөө эс гэхэд маргааш энэ гагнаас магад ханзарна даа» гэж санаж энэ хүйтэн өдөр ууланд яаж хөглөх бол гэж битүүдээ их л санаа зовж байжээ.

Тэгтэл сайн бороолсон бэртэнгэ шиг цус ясны зуурмагаар шавж гагнасан тэр трактор дажгүй хөдөлсөөр өдөр сар улирааж байхыг нүдээр үзэж инженер гайхаж барахгүй байжээ. Тэгээд «өнөөх бүхэл бүтэн шинжлэх ухаантай тэнцүү дадлага туршлага гэгчийн нь нэг энэ байж дээ» гэж даргыгаа ойшоон хүндэтгэх болсон ажээ. Энэ гайхалтай гагнаасны учрыг шинжлэх ухааны үүднээс сонирхож нэг удаа даргаасаа асууруун:

- Даргаа та цус ясны зуурмагаар ган ширэм гагнаж болно гэж хаанаас яаж мэдээ вэ? гэсэнд цаадах нь

- Гүй ээ тэрний чинь би мэдсэн юм биш. Ардууд мэддэг юм. Ер нь тэгээд чи бид нар ардуудтайгаа мах цусны холбоотой байвал олон юм мэдэж авч, их юм бүтээж чадна шүү гэжээ.

Түүнээс хойш Ядамжав даргын чилдэн хөх царай залуу инженерийн сэтгэлд хөдөлмөр тэмцэлд хатаагдсан эрхэм коммунист хүний гянт болдоор бүтээсэн хөрөг дүр шиг санагдах болж билээ. Ойдов инженер энэ олби оготно шиг овжин даргынхаа сэдэж гаргасан санааг эрдэм номоороо зураг төсөл болгож, хоёул хэд хэдэн механик төхөөрмжийн зүйл хаягдал төмрөөр амжилттай хийж босгоод ажилдаа хэрэглэсэн ажээ. Дарга нь инженерээ бас алаг булаг дүнтэй ч аргагүй толгойтой аавын хүү» гэж магтах болсон ажээ.

Ийнхүү дарга орлогч хоёр гар нийлэн зүтгэдэг байсныг сонсвол өнөөх цус ясны гайхамшигт гагнаас олныг үзсэн овжин даргын их дадлага туршлага, залуу инженерийн эрдэм мэдлэг хоёрыг бат гагнаж туурвин бүтээх их хүч болгосон мэт сэтгэгднэм билээ.

ЖИНГЭЛЭЙН ДАМДИНДОРЖ

Зохиолч Ж.Дамдиндорж 1928 онд Төв аймгийн Баянзүрх сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Намын дээд сургууль, Москвад Ломоносовын нэрэмжит их сургуулийг тус тус төгсчээ.

1950-иад оноос уран зохиол сонирхон оролдож “Ёстой сайн хүн”, “Хаминдаагийн авгай”, “Нэгэн амьдралын мартагдашгүй өдрүүд”, “Дууриалт үйлстэн” зэрэг найруулал, өгүүллэгийн ном, “Хотоос ирсэн бүсгүй”, “Суварганы нууц”, “Мартагдашгүй баясгалант өдрүүд” зэрэг тууж бичжээ.

ХАЛАГДСАН ЦЭРЭГ

Дамба, Норжмоо хоёр наадам тарсан өдөр сумын төвөөс нар шингэхийн өмнөхөн гарлаа. Тэд өндөр уулын сүүдэр буусан тал дундуур шинэхэн улаан “Ява”-гаар тийрэлтэт онгоц шиг цэнхэр утаан зам үлдээн дээд зэргийн хурдтай давхилаа. Норжмоогийн улаан алчуур салхинд дэрвэлзэн хийсэж, дотроо ялимгүй зүрхшин айсан тул Дамбын бэлхүүсээр чанга тэвэрч, махлаг зөөлөн хацраа түүний даланд наалдуулан халуу дүүгүүлж сэтгэлийн дотор хэмжээгүй баяр жаргалд автагдан явжээ. Зарим хотгор, жижигхэн судаг газар мотоцикль нисэх мэт дүүлэхэд тэр хоёр нүдээ тас анина. Нэлээд давхисны дараа Дамбыг эрүүгээрээ аяархан ёворсонд цаадах нь мотоциклынхоо хурдыг хасан бараг зогсох дөхөөд:

- Юу гэв? хэмээн асуулаа.

- Яасан хамаагүй давхих юм бэ. Миний толгой эргэж, дотор муухай болж байна гэж Норжмоо худал хэлж аяар явуулахыг оролдсонд Дамба тийнхүү хурдан давхихыг больж зөөлөн явах зуур:

- Энэ чинь барагдахгүй арвин тал байгаа юм. Би цэрэгт явахдаа аавын хонины хээр мориор өглөөнөөс орой хүртэл шогшуулсан юм даа ... гэж хууч хөөрч эхлэв.

Энэ явдал гурван жилийн өмнө болжээ. Хоньчин Лхагвын ганц хүү цэргийн албанд мордоход сумын төв орох унааны тухай гэрийн дотор бөөн маргаан дэгдэв. Эх Долгор:

- Хүүгээ хөнгөн хөлтэй мориор сум руу явуулна. Урьд хатуу хэцүү ажлы нь хийж, хойно урьд нь гүйдэг байсны хэрэг юу билээ. Халтарынх сум орох хөнгөн хөлтэй унаа өгөлгүй яахав гэж зүтгэхэд

- Ямар хүнээс юм гуйхын дон шүглэсэн биш, тэгж царай алддаг цаг өнгөрсөн. Чи Халтарын занг мартаа юу, тэр чинь хясаж л байвал ганц болдог хүн гэж Лхагва эсэргүүцжээ. Эцэг эх хоёрыг маргалдахад Дамба хөмсөг буулган дуугүй суулаа.

- Нүүрэндээ илэг наасан юм шиг хүнтэй уулзахаас айдаг жигтэйхэн хүн шүү. Халтаринд очоод унаа гуйхад юунд нь хойш сууна даа. Амнаас нь ам уначих юм биш. Өгвөл өгнө л биз, өгөхгүй бол байна л биз. Ямар гарзтай юм уу... гэж Долгорын яншихад Лхагва ундууцаж түүн рүү муухай харснаа Дамбад хандан:

- Миний хүү аавынхаа хээр морийг унаад яв. Муу ч гэсэн өөрт байгаа юмыг хүнээс гуйгаад яах вэ. Аавын нь хээр морь хаа ч хүрчихнэ гэж итгэлтэй өгүүлжээ. Лхагвын зөрүүд зан хөдлөхөөр юу ч хэлээд нэмэргүй тул Долгор түүний чихнээс хонох уяхыг болив. Харин үгэнд нь оролгүй өөрийнхөөрөө зүтгэсэнд хяхуурхан аашилж загнах өө сэвийг сайн олж байв.

Хэрэв Дамба “Хээр мориороо явна” гэж зүтгээгүй бол бас л Долгор санасандаа хүрэхээс нааш санаа амрахгүй байж билээ. Маргааш нь өглөө эрт Дамбыг хээр мориндоо мордоход эх Долгор дөрөөн дээр нь суу дусааж баруун хацры нь үнсэхдээ нулимсаа барьж ядан хоолой нь зангиран биеэ хайрлаж явахыг захин эх адаггүй юм урсгахад:

- Залуу насандаа юм л сурахыг бодоорой. Хүний хойгуур сууж юм сурахаас хоцорвол хожим өөрөө гэмшихэд хүрнэ. Хүнтэй л адилхан хүн юм чинь хүнээс хоцрох хэрэггүй хэмээн эцэг Лхагва өгүүлжээ.

Дамба аавынхаа хонины хээр морийг унаж, айл амьтнаас холуур дөлж дөрвөн мөчөөрөө зай завсаргүй далавчлан балбавч яг, яг шогшихоос үл хэтэрнэ. Намрын халуун өдөр ингэж явах нь яршигтай санагдавч бас ухаа толгой даван явсандаа тайвширч, заримдаа хашин хээр мориныхоо тааваар сажлуулж байв. Намайг ингэж явахад нутгийн залуус л битгий тааралдаасай гэж Дамбыг бодоход хоёр чих нь улайн духнаас нь хөлс чийхарав. Аз болоход тэр өдөр Дамбатай замд хэн уулзалдсангүй.

Тэгэхэд харамч хочтой Халтарын охин Норжмоо ишигний сүүл шиг годгор хоёр салаа гэзэгтэй, залуу эрийн анхаарал татмааргүй байсан. Халтарын ялимгүй юм харамлаж боож үхэх дөхөн бачимдахыг Дамба дотроо жигших тул болж л өгвөл Халтарынхаас холхон явахыг хичээнэ. Харин Халтар бол “Хар Лхагва заяа муутай учраас манай хаяа түшихгүй, тошсон бух шиг ганц гэр явна” гэж боддог байв.

Эцгийн хашин хээр мориор сумын төв орж, оройдоо түүнийг таних хүнд хөтлүүлэн буцаасны дараа Дамбын санаа амарчээ. Тэр цэрэгт ирээд барилгын ангид орж ажилласан нь өнгөрсөн гурван жилд барилгын олон төрлийн ажил хийж чаддаг болсноор барахгүй хаана ч толгой, өвдөхгүй өрлөгчин болжээ.

Норжмоо түүнийг дахин эрүүгээрээ зөөлөн ёвров. Дамба мотоциклоо алгуурхан зогсоолоо. Талд холбоо нуур, хужир марз дундуур урссан нарийхан гол гайхалтай сайхнаар шингэх нарны эцсийн туяанд гялалзан өдрийн халууныг давж оройн сэрүүнийг угтан буй хот айл үнэхээр жаргалтай харагдаж байлаа. Дамба, Норжмоо хоёрын зогссон ухааг бараан сүүдэр бүрхжээ. Гэвч өдрийн наранд улайсах мэт халсан газрын хөрс хөрч амжаагүй ажээ.

- Дамба нэгдлийн дарга та хоёрын яриа юу болж тарсан бэ? гэж Норжмоо анх суман дээрээс хөдлөхөөс эхэлж сэтгэлийн нь зовоосон нөгөө зүйлээ асуулаа.

- Хэд хоногоос сумын төвд ирж, барилга дээр ажил хий л гэж байна. Яадаг шүү юм байгаа юм бэ, мэдэхгүй. Нэгэнт мэргэжлий нь эзэмшсэн болохоор очиж ажилладаг л хэрэг байх даа хэмээн тээнэгэлзсэн байртай ярьсанд Норжмоо түүний яриаг тасалж,

- Очсон нь дээр. Хөдөө байхлаар хайран сайхан мэргэжил нэг л мэдэхэд зэврээд хэнд ч хэрэггүй болчихно шүү дээ гээд:

- Чи суман дээр суух дуртай байна уу? гэхэд:

- Мэдэхгүй гэж хэлээд баясангуй инээжээ.

Тугалын зэлний хажууд нойтон аргалаар май тавиад, үнээ саалгах хүн юусан билээ хэмээн гэрийн үүдэнд нүцгэн хүрэн хэнхдэгээ ил гарган өмд цамцтай зогсож байсан Халтар хажуухнаар нь шурдхийн өнгөрсөн мотоциклоос цочин ухасхийхдээ тотго мөргөж аман дотроо хараал тавив. Гэвч Норжмоог түргэн ирсэнд баярлан:

- Ашгүй та хоёр хүрээд ирэв үү? Би ч өнөөдөр амжиж ирэхгүй, хэдэн үнээгээ хэнээр саалгадаг юм билээ гэж л бодож байлаа шүү хэмээн албаар инээмэр болжээ. Тэгээд тулганы хажуу дахь мөнгөн бүслүүртэй зэс домбо тийш зааж:

- Хүйтэн юм залгилцгаа. Мөн ч халуун өдөр байлаа шүү гээд,

- Замд ам цангах зав ч болсонгүй. Бид суман дээрээс тун саяхан гарсан гэж Норжмоогийн хэлэхэд Халтар зовхи нь унжсан ногоон нүдээ бүлтийлгэн:

- Их хурдан явжээ. Энэ “мулцагсэлээдий” гэдэг чинь хөдөөний хүнд л ганц тохирох сайхан унаа юм даа. Ийм хурдан юм чинь дээр нь явахад халуун өдөр салхи татуулаад мөн сайхан байдаг бий гэж гайхав.

- Сум орох ажил гарвал та надтай хамт яваарай гэж Дамбын өгүүлэхэд Халтар их олзуурхан:

- Тэгье байз. Сум орох ажил байлгүй яахав гэж хэлэхдээ “ойр зуурын юманд бэлэн сайхан унаатай боллоо. За байз энэ унаагаар чинь л өнөө хэдэн морины хойноос эрэлд явдаг хэрэг. Хар Лхагвын хүү манайхаар эргэлддэг чинь тийм ч муугүй юм болох бий. Хүнээсээ унаа нь илүү хэрэг болно” гэж бодож байв.

Дамбыг явсны дараа Халтарын жөтөөрхөл гэнэт хөдөлж хэлэх муу үг олж ядахдаа хамар дороо доогтой дуугарч:

- Юм гэдэг хачин байх юм. Бүх л амьдралдаа хөнгөн хөлтэй морины нуруун дээр гарч үзээгүй хар Лхагва гэнэт далавчит унаатай болчих гэж. Дамба ч хүн харахад нурмайсан томоотой юм шиг хир нь дотуур тамиртай муу санаатай золиг байгаа юм гэхэд Норжмоогийн дотор сэрдхийн:

- Аав та юунд дандаа хүнийг элдвээр муу хэлж байдаг юм бэ. Тэд биднийг яагаа ч үгүй шүү гэж хэлээд:

- Чи тэднийг надаас өмөөрч хамгаалахдаа юу болдог юм бэ. Ээ чааваас, таарсан ч амьтан бол доо. Цаадуул чинь тэгж хүний хайр, халамж эдлэх заяатай улс биш гэхэд:

- Хүн шиг л хүмүүс гэж Норжмоо шийдэмгий хэлжээ.

Эцэг, охин хоёр нэлээд маргалдсан боловч өөр өөрийнхөөрөө зүтгэжээ. Халтар яаран Дамбыг үргээчихгүй, хурдан унаагий нь элдэв юманд хэрэглэхийг нэг талаар хичээх тул охиноо тайвшруулж:

- Аав нь Лхавгынхныг муу хэлэх гэсэн юм биш. Зүгээр санаснаа л хэлж орхилоо. Үүнийг цааш нь хүнд ярих хэрэггүй шүү хэмээн ятгав. Энэ үед Лхагвын бор гэрт бөөн баяр болж хүүгээ гэрийн босго алхмагц эцэг нь гоц халуунаар угтаж:

- Хүү минь наадамд түрүүлээд ирэв үү? Хийморьтой сайхан хэрэг байна. Аав нь чамайг наадамд түрүүлсэн гэж дуулаад арай л хөгшин хээр мориороо сум руу шогшуулалгүй сууж байна гээд:

- Аав та хэнээс дуулаа вэ? гэхэд нь:

- Дуулалгүй яахав. Нударга Дэндэв хөөрхий гэмгүй байдаг юм гэж хаа байгаа газраас ирж хэл хүргээд саяхан явлаа. Баярласан гэж жигтэйхэн явна билээ гэлээ.

Лхагва түрүүлсэн бөхийн байг эцэгтээ, сумын хоршооноос худалдаж авсан боов чихрээ ээждээ өгсөнд хоёр хөгшин баярласандаа арай л уйлсангүй, нэн их догдолсон сэтгэлийн эрхээр дуу алдан баярлав. Сумын төвийн сонин ярьж нэгдлийн дарга түүнийг яаралтай ирж барилга дээр ажиллахыг тушаасан тухай Дамбын өгүүлэхэд Лхагва шулуухан л:

- Очиж амжилгүй яахав хүү минь. Ямар унаагаар хүний царай харах биш, дуртай цагтаа л давхиад ирэх газар хойно гэж хэлэв. Долгор шулуухан дургүйцэж Лхагва тийш эгдүүцэнгүй харж.

- Хүүхэд шиг юман түрүүнд л долдгонож байх юм. Цэргээс халагдаж ирсэн хүн ганц зун гэр орондоо байж хэдэн хониныхоо сүүгээр гэдсээ цайлгахад яадаг юм бэ. Дамбыг үзээд л нэгдлийн барилга болохгүй болчихоо юу. тэр ч харин яршиг байна даа, гайгүй гэж омогдов.

Лхагва юмны учир ойлгож мэдэхийн оронд өөрийнхөөрөө зүтгэх дуртай эхнэрийнхээ баруун солгойгүй яншихаас түвэгшээж таг дуугүй болов. Дамба эцгээ өрөвдөх, эхийгээ хайрлах сэтгэлд автагдан сууснаа эд хоёулаа л миний төлөө санаа тавьж байгаа нь энэ гэж бодлоо.

- Ээж минь аав их зөв хэлж байна. Би цэрэгт зөвхөн л мотоцикль авах мөнгөтэй болох гэж барилга дээр ажилласан юм биш. Гол нь барилгын мэргэжилтэй болж нэгдэл, бригадаа тохижуулах л гэсэн юм. Би өөрөө барилга дээр ажиллая гэж бодож явсан, гэтэл өнөөдөр нэгдлийн дарга тушаал өглөө.

- Дамба минь ээж нь юу мэдэх вэ дээ. Чи өөрөө тэгж бодож байгаа бол над хэлэх юм алга.

Хэд хоногийн дараа Дамба сумын барилга дээр ажиллахаар явах боллоо. Явахынхаа өмнөхөн Норжмоотой уулзаж:

- Чи яая гэж бодож байна вэ? гэхэд хүүхний нүүр улайснаа тэр дорхноо больж:

- Намар хойноос чинь очно. Харин чи ажлаа сайн хийж бай гэжээ.

- Аав чинь надад дурамжхан юмаа?

- Тийм ч байж мэднэ. Тэгээд юу гэж?

- Ул нь бие биедээ сайн байвал улам л сайхан байх шүү дээ.

- Аав над хайртай, би чамд ... Ингээд болох биш үү.

Дамба мотоцикльдоо мордож тал дундуур салхи татуулан давхилаа. Бас сэтгэлийн их баяр хөөрөөс ундарсан уртын дуу аялах сонсодно. Тэр дууны аяыг Норжмоо гэрийн үүдэнд уяран чагнасаар л байв.

АЮУРЗАНЫН ДАНДИЙЯДАМ

Зохиолч А.Дандийядам 1928 онд Ховд аймгийн Манхан сумын нутагт төржээ.

Бага дунд сургуульд суралцаж багшийн дээд сургууль төгсчээ.

1958 оноос уран зохиол сонирхон оролдож “Эрхэм зам”, “Хилийн чулуу”, “Учиртай авдар”, “Хангайн сайхан Долгор”, “Ган хөлгийн намтар” зэрэг тууж, өгүүллэг найрууллын ном хэвлүүлжээ.

ХОРИН ЕСӨН ХОНГОР

Ган тулганаа дүрэлзэн асах аргалын гал дээр ширмэн тогоо дүүрэн, сүүтэй цай даргилна. Бадамханд гуай цайгаа самран уудлах зуур уншиж буй захидлыг чих тавин чагнана.

“...Хэдэн цагийн турш газар доргиулан нижигнэж байсан их бууны дуу намдмагц бид морин атакт оров. Бидэнд удаан цагаар бүслэгдэж ар талаасаа таслагдсан Германы цэргүүд хирдээ яггүй эсэргүүцэв. Гэвч манай морин анги фашистын зандалчдыг ёстой л үүрэнд нь бут цохисон! Тэр тулалдаанд би Германы хоёр зандалчинг устгаад “СС-ийн бололтой нэгэн офицерыг дайран чавчих гэтэл тэр маш зальтайгаар бултан миний морийг...” гээд таг болоход Чимэдийн царай хувисхийв. Гэтэл нөгөө хуудаснаас эхлэн “энд цас ихтэй хүйтэн байгаа боловч монгол морьдоо унаад давхихаар тэр дорхноо дулаацдаг... Дохио! За баяртай” гэж уншихад Чимэд ихэд гайхан:

- Үгүй хүү минь тэгээд морь нь яасан хэрэг вэ? гэхэд эхнэр Бадамханд тэндээс:

- Харин ээ! Тэр нэг л олигтой юм болоогүй дог! хэмээн санаа алдав. Захидал уншиж байсан залуу бас л гайхшран хоёр жижиг хуудсыг эргүүлж тойруулж харснаа:

- Нэг, гурав. Арай дундах хуудас нь орхигдох гэж баймааргүйсэн гэхэд Чимэд гуай:

- Тэр муу нохой хүүгийн минь морийг яачихаа бол доо гэснээ гаансныхаа унтарсан галыг гутлынхаа хошуун дээр цохив. Нөгөө залуу:

- Дундах нэг хуудас нь л алга байх юм! гэхэд Чимэд нэгэн санаа авсан бололтой:

- Үгүй яаж мэдэхэв дээ! Ямар бидэнтэй адил аргал, хонины хойноос хөөцөлдөж яваа биш, амь өрсөн ширүүн дайнд яваа хүнд самгардах тал тохиолддог ч байж мэднэ! гэтэл Бадамханд гуай:

- Иш хөөрхийс минь дайтаж яваа улсад тийм юм байлгүй яахав. Харин хэдий завандаа захиа бичиж амждаг байна гээд толгой сэгсрэв.

- Би урьд хятадын хар цэрэгтэй байлдаж явахад ялимгүй юманд самгардаж Хатанбаатар багшид сүрхий зэмлүүлж билээ! гэхэд Бадамханд гуай “Чимэд минь бид хоёрын үг олдож, үхэр холдох нь! Энэ тэнгэрийн гийхэн дээр адуугаа эртхэн цуглуулчихаад суурин дээрхи байшинд байгаа хэдэн элдсэн нэхий ганзгалаад ир. Би орой үдшийн заваараа хэдэн сайн дулаан дэгтий хийж тэр хүүхдүүдэд явуулах минь гэхэд:

- Хөгшин минь тэр зөв шүү. Би хурдхан шиг яваад ирэхийг бодъё гээд Чимэд өвгөн хойморийн авдар дээрээс том үнэгэн лоовууз шүүрэн авав. Гадаа тэнгэр, цэлмэг, шинэхэн цасны өмнө нүд гялбуулна.

Чимэд цас нимгэн өвс сахлаг, хулангийн зоо мэт шаргалтан буй дүгнэгэр ухаагийн ар царам өгсөн давхиж явав. Унасан морь хазаар даран духалзаж хусан уурганы үзүүр, хуйв атираан туялзах нь адуучин эрийн сэтгэлийг хөдөлгөнө. Тэртээ зүүн энгэрт идээшлэн буй адуун

сүргийн урд хэсэгт цавидар хонгор азарганы адуу байгааг ажив. Чимэд адуугаа бөөгнүүлэн цуглуулангаа сэлгэн буух нутаг, өвсний сэрмүүн, цасны нимгэнийг ажиглан явгал шинэ цасан дээр саявтархан явсан чонын мөр байхыг хараад:

- Үгүй ер хээрийн боохой адууны бэлчээрт ирнэ гэдэг ч муу хэрэг дээ гэж шивнэн алсыг ширтсэнээ энэ боохойн мөр тэр зүүн хойт Өлгийн сархианаас хэтрээгүй хэвтсэн байлтай санж. Тэгвэл ч хонгор морь бид хоёроос мултрахгүй дээ гэж бодон мөрийг дагаж хатируулав. Хашир эрийн таамаглал зөв онож зальт саарал бартаа бараадан харайхыг үзээд чанга хашгиран ташуур далайтал хонгор морь ч ухасхийв. Хөлгийн туурай тачигнан хурдлах тутам чонын тэнхэл барагдаж хоёр хажуугаараа эргэн эргэн харна. Шүдээ ярзайн ахирах чонын сарьсан хоншооры нь уурганы бөгсөөр цохиж амжив. Дөрвөн мөч нь татганан үхэж буй чонын дэргэд тамхи татан суух зуур хонгор морь, Иван Петровский хоёрын тухай мөн л бодов. Зөвхөн малын дайсан чоно л ийм санаа агуулж бйагаа юм чинь хүний дайсан, тэгээд бүр аюултай яргачин болохоор тэр герман, Петровский хүүгийн минь моринд муу юм хийхээс буцахгүй. Тэгээд л түүний нь бичсэнгүй. Эр хүн унасан мориноосоо хагацна гэдэг үү! Дайны талбарт эмээлт хүлэг, барьсан зэвсгээсээ салахад мөсний ангалд унасан лугаа адил гэж судар бичигт гардаг сан! гэж бодоход зүс царайг нь үзээгүй ч Петровский хэмээх тэрхүү орос цэргийг өрөвдөн хайрлах сэтгэл төрнө. Одоогийн энэ дайн миний Хатанбаатарын цэрэгт байхдаа хятадын хар цэрэгтэй дайтаж явсантай адилгүй. Тэгэхэд бидний хамгийн сүрхий зэвсэг усан ваамлий, хурдан цэнэгтэй цахиур буу, сэлэм байлаа. Одоо бол их буу, нисэх онгоц, хуягт танк...үгүй ер нь тэр олон бууны амнаас гарсан өчнөөн мянган суманд яаж өртөхгүй гардаг юм бол доо! гэх мэт элдвийг бодон чоноо өвчиж дуусав. Эмээлийн хойгуур бөгтөрсөн чонын арьснаас жигшиж үргэсэн хонгор морь хамар дуугарган ухасхийхэд Чимэд дөрөөн дээрээ ялимгүй өндийж суугаад тэртээд бэлчээрлэн байгаа адууны зүг давхин одов. Нар баруунаа тонгойж уулын сүүдэр харлан буугаад хацар хайран үлээх оройн жаварт сахал цантан нүүр нь хүрэн өнгөөр туяарч сэтгэлий нь эзэмдэх нь нөгөө бодол үргэлжлэх бүр хорин есөн хонгор морины туурай тачигнаж түүнийг унасан хорин есөн орос эрийн уухайн дуу хангинаж хорин есөн сэлэм наранд гялалзаж байх шиг санагдана. Дайн! Дайн гэдэг тун ч аюултай хар гамшиг. Үг хэл үсний өнгө ялгаатай ч миний хорин есөн хүү тэр дайнд яваа. Энэ хорин есөөр зогсохгүй бас олон хүүхэд минь тулалдаж байгаа. Тэд нартаа хөлд нь дэгтий, гарт нь дулаан бээлий бушуу хийж явуулах нь зөв. Би хорин есөн хурдан хонгороо бэлэглэсэн нь зөв болсон юм...

Ирмэглэсэн хадтай толгодын дундуур баруунаас зүүн тийш орсон нарийн булгийн урд дэнж дээр асар майхан босч олсон хээтэй хар модон уяа олныг зоожээ. Өглөөний наран ургахаас эхлэн үдшийн бүрэнхий болтол тал бүхнээс хангал морьд хөтөлсөн хүмүүс хуран цугларах ажээ. Энэ бол улаан армид агт бэлэглэх ажиллагааг олон багийн нутаг дундажлан задгай устай энэхүү булаг дээр явуулахаар товлосон төв нь байв. Таанын толгой цавцайж байгаа талиун дэнж дээр хураасан олон адууг тойрон урт уурга суналзуулсан эрчүүд нэгнээсээ урьтаж уургалахыг хичээн байхад агт уясан уяаны энд тэнд бөөгнөрөн суусан хүмүүс дайн дажны гамшиг, алдагдсан малын эрэл сурал зэрэг элдвийг хүүрнэнэ. Хэсэгхнээр сууж байгаа хүмүүс дээр чөрчгөр туранхай биетэй нэгэн эр ирснээ гутлын түрийнээс гаансаа гаргаж бөөгнөрүүлэн хурааж байгаа адууг харснаа:

- Энэ Чимэд ер нь онгиргон золиг шүү. Адуугаа цөмий нь хөөж ирчихээд байгааг нь харав уу?

гэхэд бас нэг нь:

- Харин тиймээ! Тэгээд бүүр хонгор азарганыхаа адуунаас шилж байж гучаад морь, хэн ч гэнэв нэг орос даргад бэлэглэх гэнэ гэснээр Чимэдийн тухай яриа үүсэв.

Чимэд дэлий нь зассан хонгор морин дээр хөндөлсхийн сууж уургачин эрчүүдэд барих морьдыг зааж өгнө. Төдөлгүй ижил зүсмийн хонгор морь эгнүүлж уясан уяаны дэргэд хүмүүс цугларан их наадамд сойсон хүлгүүдийг шинжих мэт морь бүрийн сонин содон шинжийг гайхацгаан:

- Энэ хорин есөн хонгор ч Чимэдийн адууны туг сор нь шүү!

- Аргагүй шүү дээ. Хатирт хулын удам юм чинь гэхэд Баян Нэмэх том нударгатай ханцуй хаялан олны дэргэдүүр явж хорин есөн хонгорыг атаархан сонжсон харцаар ширтэснээ:

- Муу онгиргон золигоос энэ хонгорыг даага байхад нь уях санаатай, “хоёр мянга” амлахад өгөөгүй юм шүү хэмээн хондлой дээгүүрээ ховилтой хонгор морийг заахад хүмүүс “эд нар тэр нь энэ нь гэх юмгүй хурдан бол бүгд л хурдан, мөнгөөр бодоход жараад мянган төгрөг. Бидний наймааны ханшаар бол гурван азарга адуу гэсэн үг. Манай Чимэд ч энэ Боргиогийн дэнж дээр ханхалзаж байх шив” гэлцэнэ. Гэтэл албаны бололтой, том ширэн цүнх зүүсэн хижээлдүү насны хүн “Нөхөөд! Наашаа цуглараарай” гэж зарласнаар бүх хүн тэрхүү уяаны дэргэд цуглав.

Чимэд хүрэн тэрмэн дээл дээр шар бажгар дурдам өргөн ороож эсгий оройвч хэвгийдүү тавиад сэтгэл нь хөдөлсөн бололтой зогсоно. Нөгөө хүн олонд хандаж “Нөхөөд! Германы фашистуудыг бут ниргэх Зөвлөлтийн улаан армийн ялалтыг түргэтгэхийн тулд манай сумын ард түмнээс бэлтгэн буй агтны ажил амжилттай явагдаж дуусах дөхөж байна. Одоо манай сумын гуравдугаар багийн ард Должингийн Чимэд баатарлаг улаан армид бэлэглэх зүйлээ гардуулна гэв. Чимэд нударгаа эргүүлэн том мөнгөн аяганд дүүрэн сүү хийж алд цэнхэр хадаг дэлгэн суран ноттой хонгор морь хөтлөн ирж агт хүлээн авах комиссын дарга зөөлөн шаргал үстэй өндөр нуруутай нэгэн орос хүний өмнө барьснаа

- За хүү минь! Ах чинь эзэрхэг засгийн үед үхэхээс бусад зовлонг эдэлж явсан хүн. Эрх чөлөө сайн сайхны төлөө харийн дайсантай тулалдаж ч явлаа. Одоо эрхт гэгээн засгийнхаа ач ивээлээр амар жаргал эдэлж явна. Жуков жанжны цэрэгт өөрийн адуун сүргийн манлай хорин есөн хонгор морио сайны дээж цагаан сүү, цэнхэр хадгийн хамт барья гэв. Орос дарга баярын мишээлтээр сүү хадгийг хүлээн авснаа хариу баяр хүргэхэд хүмүүс алга нижигнүүлэн ташив. Чимэд сэтгэл хөдлөн тал бүр тийшээ харав. Баруунаа тонгойсон нарны туяанд мөнгөн тууз мэт мушгиран гялалзах зөөлөн урсгалт булгийн ус, барсгар хадан цохио бүхий ирмэглэсэн сүрлэг хар толгод, таана найган сугсалзах талбиун тал тэр аяараа баяр хөөрөөр бялхаж байх шиг санагдав.

Чингэснээ Чимэд уяаны дэргэд тамхиа татаж суух зуур өнгөрсөн одоог эрэгцүүлэн “хүний амьдрал гэгч мөн ч сонин байх юм. Би энэ дэнж дээр муу нэртэй, хүний адаг болж хэвтсэн удаа бий. Тэгэхэд одоо...” гэж бодтол гэнэт “хүн зовлонг дааж чадвал жаргалыг заавал үздэг учиртай юм гэнэ билээ. Ах минь тэсч үзээрэй. Би чадлаараа туслахыг бодъё” гэж дүүгийн нь

хэлж байсан үг сэтгэлд нь буув. Тэр үгийг би яг л энэ дэнж дээр сонсож байсан. Гэтэл үнэхээрийн жаргал хөөр баяр өнөөдөр миний цээжнээс халин энэ дэнжийг бүхэлд нь бялхааж байна гэж бодов. Учир нь агт авч байгаа энэхүү дэнжийн зүүн урд хонхорт нурсан байшингийн овгор догшин, ухагдсан нүхний балархай сорви, сайн эрийн цус маханд хатаагдаж гүйцсэн наян жингийн суунаг зэврэн хэвтэнэ. Энэ бол дүрвэд далай хааны хошуу тамгын шоронгийн ул буурь нь билээ. Чимэд хорин нэгэн насандаа Цээбумба гэгчийн азарга адуу хулгайлсан хэрэгт хилс гүтгэгдэн Цэвэгням захирагчаар хэргээ шүүлгэн олон сар хоригджээ. Тэр жилийн өвөл нь зуд, зун нь ган болсны улмаас хотол хошуугаараа нутаг сэлгэн нүүдэл хийхэд гар хөл нь гавтай Чимэдийг энэхүү дэнж дээр орхижээ. Гангийн наранд шатталаа шарагдан хатуу шүүлтэнд нурууны нь яс гарч мах нь идээлж өтөөд тэсхүйеэ бэрх байсан ажээ. Шээсэн дээр ургасан хөмүүл зулгааж идэн арай гэж амьтай голтой байтал дүү Жамъян нь нүүдлээс эргэн амьтан хүнээс нуугдаж ирээд гав дөнгий нь салгаж унаа хоол залгуулахдаа дээрхи үгийг хэлсэн нь тэр байжээ. Ийнхүү хээрээр гэр хийж, хэцээр дэр хийж нэг хэсэг зовсноо Хатанбаатарын удирдлаганд хятадын хар цэрэгтэй тулалдан эх орноосоо урвасан Мэ ноёныг барилцаж гарамгай үйл бүтээсний учир хөх шилэн жинс, залан зэргээр шагнагдсан Чимэд баатар хэмээн дуудагдах сайн нэртэй нутагтаа иржээ. Гэвч аятай амрах тух болсонгүй, дайсан нутаг орны нь түйвээн сүйтгэж байсан учир хошууны нэг мянган цэргийн даамлаар томилогдон “бунхант” хэмээх газар цэргийн сургууль хийлгэв. Гэтэл Хатанбаатарын цэрэг нэгэн жасын дэргэд хуарагнан буугаад Чимэдийг дуудуулжээ. Чимэд ёсыг барин баатарт бараалхвал:

- За залан баатар минь сайн уу, гэж эелдгээр мэндлээд чамайг энд байгааг мэдсэн бол би өөр тийшээ урагшилдаг байжээ! гэснээ

- За яахав ардын журамт цэрэгт хөөгдсөн дайснууд өс өвөрлөхдөө дайралдсан айл амьтныг түйвээж гай тарьж явна. Үүнийг хүчин хамтран дарах болно доо гэв.

Тэгээд Наран Зоногийн өвөрт нутаглаж байсан Түдэв, Дармаа нарын арав гаруй хот айлуудыг сүйтгэж олон хүний амь хороосон хэсэг цагаантныг мөрдөн “Ганжуурын хярд” гүйцэн устгаж “хүйтэн булгийн” өртөөгөөр дамжин тэр хавьд хоргодож уналга хөсгөө сэлбэх гэж байсан гамингуудыг хөөн устгалцжээ.

Чимэд гуай дагуулж явсан нөхдөө зоригжуулан өөрөө заавал түрүүлэн уухайлж ордог болохоор Чимэд баатрыг бууны сум даадаггүй юм гэсэн яриа ч дэлгэрсэн ажээ. Ийнхүү зориглон тулалдаж явсан Чимэд гэгээн төрийнхөө наран доор бие сэтгэлийн зовлонгүй жарган яваа нь энэ бөлгөө...

Агт бэлэглэл дууссанаас хойших хэдэн сарын дараа Увс аймаг Хяргас сумын гуравдугаар багийн ард Должин овогтой Чимэдэд гэсэн захидал иржээ. Түүнд Чимэдийн бэлэглэсэн хорин есөн хурдан хонгор морийг хүлээн авсан тухайгаа дурьдаад тэдгээр морьдын чадлыг бахдан магтсан нэгэн ангийн хамт олны талархал бичигджээ. Тэр захидлыг авсан Чимэдийн сэтгэлд хорин есөн хонгор морьтой хорин есөн цэрэг эрийн дүр тодордог болжээ.

Чимэд үдшийн бүрэнхий болж мал хотолсон хойно гэртээ ирэв. Гэрийн гадаа бууцанд хөлс нь цантаж бууралтсан хүрэн морь тушаатай байв. Чонын арьсаа бараан дээрээ тавиад элдсэн нэхийнүүдээ тэвэрсээр ортол сумын нарийн бичгийн дарга залуу баяртайгаар инээмсэглэн

мэндлээд:

- За Чимэд гуай таны орос хүүхдүүдээс чинь бас л захиа иржээ. Түүнийг чинь хүргэж ирэх гэж яараад... гэхэд Чимэд

- Яасан сайн юм бэ? аль вэ хүү минь орос хэл мэддэгээрээ уншаадах! Хөгшин! галаасаа олигтойхон түл! гэв.

“Хайрт монгол аав ээж нар минь ээ! Та нарын төрүүлж өсгөсөн хүүхдүүдээс чинь өөрцгүй Антанов, Смирнов, Черпов, Алексей, Петровский нар чинь фронтоос мэндчилж байна! гээд өөрсдийнхөө ялалтын мэдээг бичиж мөн л монгол морьдын тухай магтжээ. Харин эцэст нь та нар минь уучлаарай. Би үүний түрүүн бичсэн захидлынхаа нэгэн хуудсыг дайралтад орохын дохио өгмөгц яарсандаа дутуу орхижээ гээд “2” гэсэн дугаартай хуудас хавчуулсныг үзээд Чимэд тэсгэлгүй дуу алдан:

- Тэгнээ тэр! Аль вэ хүү минь одоохон уншаадах гэв

“...Гар буугаараа буудах гэтэл би урьтаж амжлаа” гэснийг сонсоод сэтгэл нь хөдөлж:

- Зөв. Муу золигийг гэж чанга хэлснээ өнөөдөр нэг л совин татаад байсан юм гээд инээмсэглэв. Үхрийн хөх аргалын гал дүрэлзэн асаж түүний гэрэлд Чимэд гуай эхнэр Бадамханд хоёр элдсэн нэхийгээр дэгтий, хурганы арьсаар бээлий эсгэж эхлэв.

Одод түгсэн шөнийн тэнгэр доор гэрийн тооноор тулган дахь галын туяа цойлох нь сайхан сэтгэлийн илч хүчийг тэртээ хол, түмэн бээрийн цаана байлдаж буй улаан армийн дайчдад хүргэх гэж гэрэлтэн байгаа мэт.

ЛУВСАНДАМБЫН ДАШНЯМ

Зохиолч Л. Дашням 1943 онд Архангай аймгийн Төвширүүлэх сумын нутагт төржээ.

1967 онд Москва хотноо олон улсын харилцааны дээд сургуулийг төгсчээ.

1970 оноос уран бүтээл сонирхон оролдож “Нялх ногоо”, “Бурхантын цэцэг”, “Хайрын нууц” өгүүллэг шүлгийн номууд хэвлүүлжээ.

ТАЙГЫН БОЛЗОО

Тарвагат уулын оройгоор хэсэг цаа бэлчээрлэн явна. Яргуй хөөн сүрэг тэргүүлж явсан шар халиун мянджаг уулын сэрвээнд гарч ирэнгүүт дүрлэгэр хар нүдээ тормолзуулан, хэсэг зуур ийш тийшээ ажиглан зогсов. Гэтэл тавьтаргүй тасбан хажуугаар нь гүйдэн өнгөрч, Тарвагат уулын хилэн хивнэг гэлтэй үй зайгүй ургасан шар яргуйн дунд ийш тийш баярлан хөлхөлдөх боловч шүдгүй тул амандаа цэцэг, ногоо тасдан хийх нь төдий л үгүй нь ажиглахуйяа өрөвдөм хөөрхөн бүлгээ.

Чулуунжий жаарайжаг хэмээх өндөр цагаан зариа унасаар сүргийнхээ баруун захаас шоволзон гарч ирэв. Зарь нь өгсүүр газар амьсгаадан, амаа аль байдгаараа ангайж, хэлээ унжуулаад, могоцгор сүүлээ өргөн нуруу гонойжээ.

Ганц нэг донгор, аальгүй дунгуй сүргээс тасран гүйчих гээд болохгүй, цуглуулж араас нь хөөцөлдсөөр дөнгөж сая уулан дээр гарч ирсэндээ Чулуунжий дотроо ялимгүй харамсан явна. Юу гэвэл “Рэгсэлийг Мөнхшилийн үзүүр ороон далд орон ортол араас нь ширтэх юмсан” хэмээн тэсгэлгүй яарч явсан юмсанжээ.

Тэртээ урд Их, Бага Тайжийн нуур мэлтийн, тэнгэр лүгээ өнгө булаалдаад, мяралзах зэрэглээн чанад Гунын эх Арсганадагийн даваа үл мэдэг сүүмэлзэн харагдана.

Рэгсэл, Чулуунжийн гарч ирэхийг хүлээсэн мэт Мөнхшилийн үзүүрт буучихсан, хөсгөө амрааж буй боллолтой сууж байлаа. Түүнийг Чулуунжийн сэргэлэн хар нүд дор нь олж үзжээ.

“Эй гялай минь ! Рэгсэл тэнд сууж байна...” хэмээн хүүхдийн ааль хөөрхөн сэтгэлээр хөөрөн баярлав. Түүний царайг ажвал нар салхинд онгосон хөрслөг бор нүүр, аглаг тайгын ороо зэрлэг байдлыг илтгэх ширүүн догшин хөдөлгөөн, омголон хар нүд, хүүхэмсүү энхрий байдлын үлгэр-жигд цагаан шүд, нарийн саран хөмсөг... ер Рэгсэлд таалагддаг, сэтгэлий нь дуудан далладаг бүхэн хамгийн сайхан болсон харагдана. Учир нь Рэгсэл тийнхүү өөрий нь хүлээсэн мэт сууж байсанд Чулуунжий туйлгүй баярлан, сэтгэл зүрхний нь хамаг нандин бүхнийг чандлан хадгалагч нууц оньс нээгдэх шиг болжээ.

Чулуунжий, Рэгсэлд тийм их хайртай байснаа ч мэдсэнгүй. Багаас урцын хооронд тоглон гүйдэж, “Хамгийн олон цаатай болно, хамгийн өндөр ууланд гарна” гэж мөрөөсөн ярилцаж суухдаа, хоёул цаагаа хариулан, нүцгэн сарьдаг, балар тайгын уулс хэдрэн, аюулт чоно, адат шилүүснээс хирдхийн, хангинуур сүхээр урц босгох мод тасар цавчин, анхны ан олзоо билэгтэйд бодон, уйгар омгийн буянт өтгөс Аг-оол өвөөдөө барьж байхдаа, хожим нь сургуульд орж, Улаан-уулын хүрэн дүнзэн байшингууд, сургуулийн шилэн цонх, дэлгүүрийн голио чихэр тэргүүтэн, энэ тэрийг сонирхон, нүд хужирлаж, сургуулиасаа оргон, Эмгэний даваанд хөлдөж үхэх шахан, модны хонгилд хоноглож явахдаа Рэгсэлийн хойноос ийн сэтгэл догдлон, өгөөмөр тэнүүн бодол өвөрлөж, санаашран зогсох юм гэж өчүүхэн ч бодсонгүй. Гэтэл амьдрал жамаараа өнгөрөн, урсах одох он жилийн аварга далин дор “Хайр” хэмээх анхилуун содон цэцэг дэлбээлэн ургасан байв. Чулуунжий түүнийг сэтгэлийнхээ билэгт увидсаар танин мэдээд тангад ойртон ирсэн наран адил мишээн баярлажээ.

Рэгсэл цаандаа мордон, намаг шалбааг, хад чулуу тойрон яаралгүй гэлдэрсээр Мөнхшилийн

үзүүр ороон далд оров.

Ногоон уулс, тогтуун мэлтийх Тайжийн хос нуур, үл мэдэг жирвэлзэх зэрэглээн дор үлгэрийн орон мэт хүсэл дуудан, тийш жаарайжагийн хурдан хөлөөр дүүлэн очмоор санагдана. Юу гэвэл: тэр зүг Чулуунжийн сэтгэлтэй хүн явж, тэндээс амьдрал өөрчлөх өгөөмөр халуун бодол, итгэл өвөрлөн эргэн ирэх байлаа.

Хэдэн цаа тэртээ баруун хажуу руу тасран алга болжээ. Сахилгагүй бидэг-донгор, адат хавагтаг. Алагчих хэмээх их сүүт хар, халиун мянджаг цөм тийш явсан бололтой.

Чулуунжий зариныхаа эвэр рүү савааны үзүүрээр аяархан доргион цохиж, тасарсан сүргийн хойноос гэлдрэв.

Рэгсэлийн тухай бодол, түүний яриа санаанаас нь үл гарна. Рэгсэл тайгын хүний чийрэг сайхан цээжиндээ Чулуунжийг тэврэн үнсэж, түүнийг урьд хожид хэзээ ч үзээгүй энхрий зөөлнөөр таалан янаглахад аглаг тайгын онгон салхин хүртэл саатан гайхшрах шиг болжээ.

Чулуунжий хүнд үнсүүлж үзсэнгүй, бас хот газрын эгдүүтэй юм шиг мөртлөө дасвал саламгүй сайхан байм сонин үнэр, хүнд хэлж болдог гэж бодомгүй ухаалаг дотно үг, аль алиныг биеэр эдэлж, сэтгэлээр хүртэж үзсэнгүй. Тэгэх тусмаан тэр бүхнийг багын найз Рэгсэлээсээ танин ойлгох юм ч гэж санасангүй. Чулуунжийг сургуулиасаа гарч, тайгадаа ирэхэд Рэгсэл эрдэм номын мөр хөөн хот газар оджээ. Тэгээд арван жил үзэгдсэнгүй.

Чулуунжий ямар ч тохиолдлоор юм бэ, айл аймаг олон жил ханьсан явсан багын нөхрөө сэтгэлдээ дурсан, бөглүү тайгадаа амьдралын аяс даган, хол ирээдүй, хожим хойнын тухай өчүүхэн ч бодолгүй хэдэн жил од үдэж, төдөн жил нар угтжээ.

Саяхнаас сургууль соёлын багачууд “Эвлэлийн илгээлт” өвөрлөн ирж, тайгын амьдралд өөр аяс, өөр өнгө нэмэв. Чулуунжий ч бас тэр гавшгай охид хөвгүүдтэй “Ажлаараа уралдьюу” гэж цаагаа хол бэлчээж, урцаа өндөрт хатгах болжээ. Тэглээ ч сэтгэлд нь нэг л юм дутуу амьдрал гэгч юунд ч юм бэ дэмий л хар хөлсөө урсгахыг хэлдэггүй, ямар нэгэн зорилго, чиг зүгтэй бөгөөд тийш тэмүүлэн тэмүүлэвч хүсэл ханамгүй мэт. Гэтэл бас тэр бүхнийг ухааран ойлгож сэтгэлчлэн бүтээхэд хэн нэгэн хүний өгөөмөр гар, тууш сайхан бодол үгүйлэгдээд ч байх шиг санагддаг байлаа. Гэтэл тэр бүхэн Рэгсэлийг хүлээсэн нууц сэтгэл, түүний дагуулж ирсэн хаврын урь, бүтэшгүй юм шиг санагдах зоригт үгэнд нь нуугдан байснаа гэв гэнэтхэн нүдэнд үл харагдагч далд хөрснөөсөө соёолон ургах шиг болов. Тайгын наран хүртэл урьд байгаагүй ээвэр дулаан, уулсын өвөр нүнжигт хүрэн хөрсөө дэлгэн, “Май охин минь! Шинэ амьдралаа энэ л хөрсөндөө цэцэглүүл!” гэх шиг дотно сайхан.

Нутаг орноо олон жил хаяж явсан Рэгсэл нэгэн өглөө мягмансанжийн шүүдэр адил нүд булаан буцаж ирэхдээ хамаг л юмыг сэтгэл гомдом үгүйсгэсэн, өөлсөн хагуу “ташуур” барьж иржээ. Түүнд утаат урц нь ч таалагдсангүй, уух идэх юм, унтах газар нь ч таарсангүй.

- Хуучин амьдралаа гагцхүү бид л өөрчлөх ёстой юм. Хүн төрөлхтөн өнөө өөр гариг ертөнцөд хүрсэн байхад та нар бөглүү зэрлэг амьдралдаа хоргодож, хорвоод юу болж буйг үл мэдэн, нүдэн балай чихэн дүлий өдөр шөнө өнгөрөөн, насыг барж байна. Хүнийг хэдийгээр

Байгаль-эх төрүүлсэн ч бид ухаантай учир эх-байгалиа, ахуй амьдралаа өөрчлөх ёстой.

Рэгсэлийн энэ үгнээс “Амьдралаа гагцхүү бид л өөрчлөх ёстой” гэдгээс бусад нь Чулуунжийд харь хэлээр ярьсан юм шиг ойлгомжгүй байв.

“Тиймээ өөрчлөх ёстой. Бид отор нүүдэл хийн, уул нуруу хэсэж, алс бөглүү суугаа ч тохилог сууж яагаад болдоггүй юм бэ? Гэвч... гэвч өвөг дээдэс минь хүнээс дутсан юм гэж үү? Хүнтэй л адилхан болоод, амьдраад ирсэн шүү дээ. Нүүдлийн улсад ер нь илүү ажлын хэрэг байна уу даа? Рэгсэл биднийгээ мартсан даа л тэр. Нүүдлийн амьдралаа умартан, хот газрын хүн болсон доо л тэр” хэмээн бодсоноо Чулуунжий өөрийн эрхгүй Рэгсэлийн яван зүг мөрөөсөнгүй зөөлөн харцаар ширтэв.

Нүдэнд нь Рэгсэлийн цэвэр, үзэсгэлэнт царай, дахиад л нөгөө... нөгөө хот газрын анхилуун сайхан үнэр, болохгүй бүхэн рүү зүтгэх тавилантай төрсөн юм шиг зөрүүддүү шийдэмгий төрх, янзаганы нүд шиг цогтой, ухаалаг нүд... нэгд нэгэнгүй харагдах шиг болов.

- Бид хөгшдийнхөө сэтгэлийг эвдэх хэрэггүй ээ. Тэгэхдээ амьдрал байдлаа заавал өөд татах ёстой. Соёлт хүн яаж л амьдарч байна, тэгж л амьдрал хэрэгтэй. “Нүүхэд бэрхтэй авдар саваар яахав. Нүүдлийн улсад орон байшингаар яахав, тайгын эрүүл нөхцөлд гар нүүрээ угаасны ч хэрэггүй, хашаа, бэлчээрийн хуваарь ч хэрэггүй” гэж та нар маргаж байна. Цөм хэрэгтэй! Үүнийг чинь бид бий болгох ёстой юм. Байгаагүй, санаагүй бүхнийг бид л чухам үүдэн байгуулах учиртай! гэж Рэгсэл бараг уурлан, чанга чанга ярьж байсан нь бодогдоно. Гэхдээ Рэгсэл энэ үгээ ойлгоно, өөртэй нь гар нийлүүлэн ажиллаж, шинэ амьдрал буй болгоно гэж итгэн, санаа бодлоо гагцхүү өөрт нь хэлсэнд Чулуунжий тэсгэлгүй баярлаж явав.

“Тиймээ! Чиний хэлснээр мод огтлон, нүүдлийн зам засаж болно, зассан замаараа цастай өвөл чаргаар явж болно. Гол гол бэлчээртээ байшин бариад, нүүдэллэх бүр түүндээ суурьшаад, тэндээсээ ойрын оторт явж ч болно. Гэрэл тавьж шөнийн цагаар ном уншиж ч болно. Сайхан дуу сонсон, улс орныхоо хөгжлийг мэдэж болно. Чи ер нь хичнээн сайхан юм ярьсан юм бэ? Бодохоос сайхан байна. Харин чи минь сайхан юм ярьж сэтгэл хөөргөчихөөд, урьдынх шигээ ор сураггүй алга болчихов доо! Сэтгэл чинь үнэнч байсан шигээ хэлсэн үгэндээ үнэнч байж үзээрэй!”.

Чулуунжий бодсон бодолдоо сэтгэл таацан, заринаасаа буун, даалимбан дээлийнхээ хормойг ялигүй өөдлүүлэн, бүсээ чангалаад, Рэгсэлийн авчирч өгсөн торгон алчуурыг тайлж үзэв.

“Ийм гоё алчуураар ч би яахав дээ! Тайгын хүн надад үүнд орвол цоохор даавуу дээр...Ингэхэд би ер нь тэгээд гоё юм эдлэх, гоё гоё үзэх эрхгүй болж байна уу? Үгүй ээ! Рэгсэл ёстой үнэн хэлсэн. Би ч гэсэн ялгаа байхгүй хүн шүү дээ. Юу гэлээ? Аа тийм социализм байгуулж байгаа хүн! гээ биз дээ...”

- Би одоо Улаанбаатар руу эргэж очоод, ажлаа өгнө. Тэгээд илгээлтээр буцаад ирье. Хоёул нутгийнхандаа сайхан амьдрал үлгэрлэн үзүүлнэ. Ердөө удахгүй, сайндаа л сар болоод ирнэ гэж Рэгсэл аяархан, бодолтой өгүүлж билээ. Тэгэхэд нь Чулуунжий,

- Чи худлаа хэлээд алга болчихгүй бол яахав... гэж арайхийж нэг юм ам нээжээ.

Чулуунжий цаагаа цуглуулаад, сүрэг уруу татагч Алагчих хэмээх өндөр мянджаг, Мэнгэт гэдэг данхар хөх халиун этэр хоёрыг нэг нэг сайн шавхуурдав.

Өмнө нь нэгэн хэсэг сайхан хөх цэцэг, өндөр ишт шаргал улаан цэцэг, навч нь салбарлан, мөчир шиг үелэн өндөрссөн сонин ягаан цэцэг, зүйл бүрийн цэцэг ногоо ургасан тэгш өвөр тааралдсанд өөрийн эрхгүй нүд баясан, хөх шар яргуйнаас өөр цэцгийн нэр мэддэггүйдээ харамсав.

“Рэгсэл бол магадгүй цэцгийн нэр хүртэл мэдэх биз. Намайг ядаж өдөр бүр хариулдаг цаагаа ямар өвсөнд илүү дуртайг, хэдийд ямар бэлчээрт хэр удаан байвал дээр байдгийг нарийн мэдсэнгүй” гэж зэмлэсэн. Тэр ч бас үнэн шүү. Ингэхэд Рэгсэл минь ирээд арав гаруйхан хонохдоо намайг л загнаж, зэмлэж байгаад буцсан юм уу даа? Бас ч үгүй шүү! Надад хот газрын тухай үлгэр шиг сонин юм ярьсан. “Зоригт анчин бүсгүй” гэдэг сонин баатарлаг номноос ярьсан. Рийтхүү билүү Рэтхүү гэлүү нэг хүний бидний адил цаатан улс мөртлөө атаархмаар сайхан амьдарч байгаа, нэг нь нөгөөдөө сэтгэлээ өгч хайрлаж байгаа гоё ном уншиж өгсөн. Хоног гэдэг ингээд бодохоор ямар урт юм бэ? их юм үзнэ гэдэг сайхан юм даа. Би бол ярих юмаа хагас өдөр ярьчихаад, тэгээд л таг суух байлгүй”.

Энэ өдөр Чулуунжий урьд бодоогүй явсан бүхнээ бодов. Ийм юм бодож чадах байсан гэж итгэхэд бэрх санагдана.

Ирээдүйн юм бодон, Рэгсэлтэйгээ хоёулаа эвлэлийн илгээлтээр ирсэн залуусыг дагуулан сайхан амьдрал, цоо шинэ зүйл үүдэн цогцлооно. Явж нийслэл хотоо үзнэ. Ажил хөдөлмөр бялхсан, шинийг бүтээн буй газар нутаг, хүн ардтай нүүр учирна, бас Рэгсэл шиг хөөрхөн хүүтэй болно гэж бодоход хачин урамтай, өөрийн эрхгүй “Рэгсэл минь, чи арай эртхэн ирэхэд яав даа!” гэж харамсан санааширахад хүрэв.

Тийм бодол төрж суухад, өвлийн жин хүйтэнд элгэнээс ил гал төөнөн байтал нуруунаас хага жинддэг хаяа онгорхой урц хэмээх муу утаат оромж, дүүжлээстэй байдаг том хар даавуун уут, цай давсны ширэн сав, үүд хойморгүй дэвссэн үст адсага, хаяанд овоолсон пөөнөгөр дээл, ер нүдэнд харагдсан бүхнээ цөмий нь урж тасдан, ийш тийш нь зайлуулж хаямаар санагдав.

“Орой харихад нөгөө л хуучин амьдрал, хуучин ахуй минь угтан, ээж хэдэн халтар аягандаа хүрэн цайгаа аягалж, олсоор боож дүүжилсэн хэдэн хурууднаас эмтлэн өгнө дөө” гэж бодохоос гомдмоор. Анхилуун сайхан үнэрт цэцэг өвөртөө тэр чиг нь байлган хономоор санагдана.

Гэвч “Рэгсэл одоохон буцаад ирнэ. Удахгүй хоёулаа Шармайн даваа, Шар уул, Уданжул, Тасрай, Барлангийн ам, газар сайгүй шинэ зам, шинэ амьдрал үүсгэнэ” гэж бодохоос сэтгэл өегшинэ.

Тайжийн хоёр нуур ертөнцийн мэлмий адил мэлтийн, ташин буй наран дор Рэгсэлийн ирэх зам тов тодхон харагдах нь Чулуунжид дөнгөж сая нүд нээн, өөрөө, гагцхүү өөрийн биеэр хорвоогийн жаргал амсаж буй мэт зүйрлэшгүй нандин бүлгээ.

ДОЖООГИЙН ДОРЖ

Зохиолч Дожоодорж 1930 онд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага, дунд сургууль, мөн Дотоод явдлын яамны цэргийн нэгдсэн төв сургуулийг 1951 онд, Москвагийн Бүх Холбоотын киноны дээд сургуулийн зохиолчийн ангийг 1961 онд тус тус төгсчээ.

1949 оноос уран зохиол сонирхон оролдож “Ямаан дах нөмөрсөн хүн”, “Замын хүзүү урт”, “Шинэ үеийн баатрууд”, “Зүүний сүвэгч” зэрэг тууж өгүүллэгийн ном, “Үүрээр”, “Улаанбаатарт байгаа миний аав”, “Амар хуур”, “Амьдралын цуурай”, зохиолч С.Удвалтай хамтарч “Үер”, “Балга ус”, “Хүргэн хүү” зэрэг уран сайхны кино зохиолууд бичсэнээс гадна “Хөрш”, “Ёроолгүй авдар”, “Нэг ширээний хоёр”, “Хаанахын хүн бэ” зэрэг жүжгийн зохиолууд бичжээ.

ХАЧИН ХҮН

Нэг

- Тунсаа минь өнөөдөр яасан халуун өдөр гэгч вэ?
- Намрын шар нар гэдэг чинь энэ дээ. Чи костюмаа тайлаад сэрүүцэж үз. Наваан минь.
- Баярлалаа хө. Аймгийн гудамжаар хэд алхсан чинь халуунд шатаад жихтэйхэн, гол дээр очиж усанд орчихоод эргээд ирлээ. Танай энд чинь ийм эрт намар болдоггүй юм байгаа биз дээ?
- Царцаахай дуугараад намрын шинж орж байна. Наваан манай аймгийн төв ямар шүү санагдаж байна?
- Энд, тэндгүй шинэ хороолол, шинэ гуанз, ресторан баригдсан сайхан хот байна. Нэг онцлог нь гудамж талбай, эргэн тойронгүй ой модоор бүрхсэн аргагүй сайхан хангай газар юмаа.
- Тэгэхдээ манай Улаанбаатарыг яаж гүйцэх вэ дээ?
- Хэмжээгээрээ бага ч гэсэн орчин үеийн томоохон хотын шинжтэй болсон газар байна. Тунсаг аа танайхаас энэ зүүн тийшээ айл амьтан байна уу, үгүй юу?
- Байхгүй. Манай байшингийн энэ үзүүрээс эхлээд цаашаа туж ой. Зүүн тийшээ нэг километр хиртэй явахаар “Баавгайтын хар нуур” гэдэг том нуур бий. Тэнд очвол ямар сайхан гэж санана? Тэр нуур луу Бургастын гол, Хайлаастын гол цутгадаг, бас Хүрэмтийн гол гэдэг чинь эндээс эх авдаг юм. Наваан чи загас барьдаг уу?
- Үгүй, загас барихаар өрөвдөөд байдаг юм.
- Чи их өрөвчхөн сэтгэлтэй хүн байх нээ? ...
- Би багаасаа тарвага, зурам, нохой шувуу алах дургүй хүн.
- Тийм улс тааралддаг юм, Баавгайтын хар нуур гэдэг чинь загасаараа алдартай нуур даа. Эргэн дээр нь очихоор загас гэж шоргоолж шиг язганаж байдаг юм.
- Сэрээнэн та нар эргэн тойрон хуш, нарсан ой дотор нуурынхаа дэргэд, голынхоо эргэн дээр мөн ч жаргалтай суудаг улс юм аа.
- Зүгээр шүү. Мартсанаас чи яагаад Хоролжаваасаа салсан юм бэ?
- Нэг л мэдэхэд өөр хүнтэй болсон байсан. Тэр надаас болоогүй байх аа.
- Аа тийм үү?... Тэгээд чи л хайр халамжгүй байсан хэрэг.
- Хүүхнүүдийн ухааныг дотор нь орсон биш гадарлахгүй юм даа. “Чамтай тохирохоо

болилоо, одоо саллаа” л гэсэн,

- Та хоёроос хүүхэд гараагүй юу?

- Гараагүй, түүнээсээ ч болсон юм уу, сүүлийн үед дургүй л болсон дог... Мэдэхгүй юм аа...

- Эмэгтэй хүн дургүй болноо гэдэг чинь эр нөхөр нь хайрлаж, энхрийлэхээ больсны тэмдэг байж мэдэх юм шүү. За тэр тийм байдаг байж. Наваан минь захиалсан умбарсан улаан шаргал цайгий чинь чаналаа. Уугаарай.

- Их баярлалаа найз минь.

- Наадах өрөм ааруулаасаа ид, энэ бяслаг байна. Аягандаа боорцог хийлгэнэ үү?

- Одоо хэрэггүй, дараа авья.

- Наваан чи амралтаа дуусаад буцах уу?

- Буцахгүй ч байж мэднэ, сайн шийдээгүй...

- Хотынхоо тэр сайхан байр байшинг орхичихоод энэ бөглүү хөдөө газар сууна гэж үү?

- Танай энд хотоос ялгаа юу байх вэ? нэг л гэм нь хотоос хол юм. Бодон байж болно доо.

- Чи байраа эхнэртээ өгөөгүй биз дээ?

- Үгүй, Хоролжав шинэ хар хүнтэйгээ Толгойтын хороололд орсон гэнэлээ. Манай нэг дүү хүүхнийх хоёр өрөөнд нь би нэг том өрөөндөө сууж байгаа ухаантай.

- Та нар тэгээд нэлээн хэдийн салсан болж байна уу?

- Өнгөрсөн жилийн намар. Тунсаг чинь цай чанахын мастер хүүхэн юм аа.

- Нэг зүйл ч гэсэн санаанд чинь тохирсон нь яамай даа. Цай хийлгэ хийлгэ, ахиж хоёр гурван литр уусан ч байна.

- Зүгээр, зүгээр байзнаж байгаад нэг аяга уумз. Чи тэр жилээс хойш хот ороогүй биз?

- Үгүй, нийслэлийн бараа хараагүй болсоор 12 жил өнгөрлөө. Айдаа цаг хугацаа гэдэг чинь мөн ч амархан юм даа. Тэгэхэд ч би Сэрээнэнтэй дөнгөж суугаад залуухан байжээ.

- Одоо ч гэсэн залуугаараа л байна шүү дээ.

- Нээрээ би хөгширсөн байгаа биз?

- Яалаа гэж, хорин хэдэт шиг л гялалзаж байна...

- Тэр ч арай юу юм бэ? харин танай хуучин эхнэр чинь л царай зүс, нуруу туруу сайтай хот

газрын хээнцэр хүүхэн харагдана лээ. Гучин хоёр, гурваас хэтрээгүй биз?

- Энэ жил гучин гуравгай

- Тэгж таарнаа, надаас ганц хоёр дүү байх учиртай.

- Сэрээнэн ирэх болоогүй юм бол уу?

- Цаадах чинь бас нэг ажлын хэнхэгтэй амьтан аягүй бол долоо наймаас өмнө ч ирэхгүй байж мэднэ.

- Тэр баавгайтын нуурыг чинь очиж үзэх юмсан.

- Чи одоо явья гэж үү?

- Харин нь...

- Олохгүй байж мэднэ, би газарчилж өгье.

- Сэрээнэн ирнэ, чи хоолоо хийж байна биз.

- Ээ дээ мэдэхгүй, цаадах чинь юу гэж бодох юм билээ?

- Сэрээнэн чамтай яваа болохоор элдэв өнгийн юм санахгүй.

- Айлчилж ирж нэг хоноод эхнэрий нь дагуулаад хүн амьтангүй шивэр ой дотуур зугаална гэдэг чинь нөгөө талаар нь бодсон хүн эвгүй сэтгэгдэл төрүүлж мэдэх юм шүү.

- Наваан минь битгий зов, харин тийшээ жимстэй байдаг юм. Жижиг цагаан сав аваад явья.

- Эмэгтэй хүн зориглоод байхад эр хүн хулчийгаад ч яахав. За хө Тунсаг минь хөдлөө дөө.

- Үнэн үг, шар тос

- Наадах цагаан савыг чинь би барья,

- Тэг тэг баярлалаа.

Хоёр

- За Наваан минь барь, барь

- Одоо нэг юмны төлөө ууя, яаж хоосон уух вэ?

- Тэр үнэн үг шүү. Бид чинь юу юуны төлөө уулаа?

- Их л олон юмны төлөө уусан юмсан. Тунсагийнхаа төлөө хундага өргөөгүй байхаа.

- Мартаж орхиж, хөөш Тунсаг аа? Чиний төлөө уух гээд байна, нааш ир?
- Юу гэнээ?
- Нааш ир, Наваан чиний төлөө хундага өргөх гээд байна, энэ хундагыг барьж үз.
- Миний төлөө бараг эхлээд шахуу бас нэг хундага өргөсөн шүү дээ.
- Зүгээр, зүгээр. Эмэгтэй хүний төлөө хэдэн удаа ч өргөж болно. За Тунсаг минь чиний эрүүл мэндийн төлөө.
- Их баярлалаа. Наваан.
- Эхнэрийнхээ төлөө хоёр дахь хундагаа өргөө.
- Их баярлалаа.
- Наваан чамд нэг сонин зураг үзүүлье... Чи энэ зургийг санаж байна уу? Хонгор минь.
- Аль вэ хө... Энэ чинь бид дөрвийн амралт дээр хамт авахуулсан зураг байх чинь вэ, ёстой түүхийн баримт гэгч мөн байна даа.
- Мөн аягүй залуухан байгаа хэрэг шүү... Сэрээнэн бид хоёр суугаад дөнгөж жил болж байсан, Хоролжав та нар нийлээд удаагүй байсан байх.
- Тийм ээ, удаагүй байсан цаг...
- Уучлаарай, би явж хэдэн буузаа чимхэе,
- Бид туслалцаж өгөх үү?
- Хэрэггүй, хэрэггүй сууж л бай.
- Наваан чи чинь одоо Хоролжавыг хаясан юм уу, хаягдсан юм уу. Яагаад салсан хэрэг вэ?
- Хаяад залуу хар хүнтэй суусан...
- Чамайг яалаа гэж голж байгаа юм бэ?
- Манай Хоролжав чинь гуч хүрээд л маяг орчихсон хүүхэн дээ. Түүнээс өмнө зүгээр л байсан юм...
- Өвгөөн энэ хүүхнүүд чинь гуч дөхөөд ирэхээрээ л явдалтай болдог гэж ортой шүү... Тэр үед нь л чангахан шиг атгаж байхгүй бол тавиад туучиж мэдэх юм шүү дээ.
- Магадгүй л юм...
- Чи амгалан амьтан болохоороо тэр үед нь Хоролжавыг сулхан барьж байгаад сураггүй

алдчихсан хэрэг...

- Нэгэнт сэтгэлгүй болсон хүнийг албадаж суугаад ч яахав дээ, тэгээд л явуулчихсан.
- Мартсанаас өнөөдөр би трестийн даргатай чиний талаар ярьсан.
- Юу гэж байна?
- Чамайг мэргэжлийн чинь дагуу үйлдвэрийн хэлтсийн даргаар авах саналаа би ярьсан, дарга маргааш уулзъя гэж байдаг шүү, надтай хамт очоорой.
- Үгүй, үгүй би угаасаа барилгачин хүн, тоосгочин юмуу, шаварчин, будагчин л хийнэ.
- Үгүй чи чинь хотод мөн энэ мэргэжлээр үйлдвэр, санхүүгийн хэлтсийн дарга, төлөвлөгөөний хэлтсийн даргаар удсан дээд мэргэжилтэй эдийн засагч хүн шүү дээ.
- Арав гаруй жил бичиг цаасны ажил хийлээ, одоо биеийн хөдөлмөр хийнэ, ер нь танай эндэх шиг хангай газар барилга дээр ажиллах юм бол бүр сайхан.
- Чи тэгээд ажилчин больё гэж үү?
- Ажилчнаас илүү алдар хүндтэй хүн хаана байна? Би багаасаа хар ажилд дуртай.
- Ээ дээ мэдэхгүй хар ажилчин болно гэдэг чинь бүх талаараа хүндхэн шүү дээ Наваан минь?
- Зүгээр, алийн болгон зөөлөн, хөнгөн ажил хийх вэ? Хүндхэн тусмаа сайн.
- Чи одоо эхнэр хүүхэдгүй ганцаараа, бас ажилчин болно... Амь зуухад хялбаргүй дээ.
- Өө санаа зоволтгүй, би зургаан жил барилгачин байсан болоод байдаг юм зүгээр.

Гурав

- Орж болох уу?
- Наваан орооч дээ. Надтай уулзах гэж явна уу?
- Тийм ээ, уулзах хэрэг байна.
- Суугаад ярь л даа, юун тухай тэр вэ?
- Өөрөө өчигдрийн хурал дээд мастер Батсуурийн талаар нэлээд хатуу ярьсан шүү дээ, тэр чинь...
- Хатуу ярих байтугай халах ёстой байсан юм...
- Сэрээнэн минь тийм бишээ, өнгөрсөн сар ажлын зохион байгуулалт, удирдаж байсан

Батсуурийн муугаас төлөвлөгөө тасалсан гэж чи шүүмжилсэн. Тэр чинь үнэнээ хэлэхэд зуурмагийн материалаар тасраад бүтэн долоо хоног ажилгүй сууцгаасан, Батсуурийн буруу биш, харин трестийн удирдлага тухайлбал чиний ажлын хариуцлагагүйгээс болсон хэрэг шүү дээ.

- Трестийн хэмжээгээр тасарсан юм чинь...

- Тэгээд Батсуурийн буруу байдаг юм уу, хамгийн гол нь Трестийн үйлдвэр санхүү, материал хангамжийг хариуцаж байгаагийн хувьд чиний л буруу. Би иймэрхүү ажлыг удирдаж явсан болохоор хаана доголдол, алдагдал байна гэдгийг сайн мэдэж байна.

- Чи намайг шүүмжлэх гэж орж ирээ юу?

- Шүүмжлэх ч юу байх вэ? ер нь трестийн ажилчид өөрийн чинь трестийн дарга, ерөнхий инженертэйгээ адил хүндэлдэггүй л юм шиг байна. Энэ талаар бодох хэрэгтэй. Бид олон жил бие биенээ сайн мэдэх, хамт суралцаж байсны хувьд хэлмээр санагдсан юм.

- Над тал муутай улс ч бий. Шаардлага тавихаар хэл ам гаргадаг, угаасаа салан задгай байдалд дассан улс манайд нэлээн бий. Тэд нартай би олон жил тэмцэл хийж байгаа хүн, чи шинэ ирсэн болоод сайн мэдэхгүй байна.

- Тийм ч байж магадгүй. Гэхдээ шаардлага, улсын эрх ашгийн үүднээс л байх ёстой.

- Тэр зүйтэй.

- Сэрээнэн минь удирдах ажил хийж байгаа та нар ажилчдыг хайрлаж ахуй амьдралы нь харж хандаж байх хэрэгтэй юм шүү. Жишээлбэл манай бригадын Жамбалсүрэн, Доной, Намшир гээд л хэд хэдэн ажилчид нүүрс, түлээгүй, гэрийн давхарлага муутай юм ярьж байна лээ.

- Нүүрс түлээний гэрээ албан газартай хийсэн, харин өнөөдөр санасан дэрээ ярилцая байз уу?

- Эвгүй юм хэлсэн байвал уучлаарай.

- Зүгээр зүгээр.

Дөрөв

- Сэрээнэн чи мах хөшиглөх үү, гурил зуурах уу?

- Би аль алийг нь хийж амжихгүй, гүйцэтгэх захиргаан дээр хуралтай одоо явлаа.

- Тэгвэл би хоолоо бэлтгэж байя.

- Тунсаг удахгүй ирнэ, эхнэрүүдийн хийдэг гал тогооны ажилд эр улс хутгалдаад ямар хэрэг байна! Өнөөдөр чамтай дарга уулзав уу?

- Дуудлаа гэсэн, очсон чинь алга байна лээ.
- Маргааш заавал уулзаарай, чухал асуудалтай.
- Ямар асуудал?
- Чиний талаар би саналаа хэлсэн, дарга бүрэн дүүрэн дэмжиж байгаа...
- Батсуурийн аманд итгэх юм биш, тэр чинь нэг суурин дээр хэд дахин эргэж хургадаг ихээхэн зальтай эр байхгүй юу? Тэгэхээр Наваан минь дотночилж ярих зүйл байна, чи наашаа суугаад тамхиа тат. Ашгүй эхнэрийг ирээгүй дээр ярьж авья.
- Тийм нууц яриа юм уу?
- Нууц ч юу байх вэ? гэхдээ чи бид нарын хувийн хоорондын чухал яриа... Чиний ажиллаж байсан албан газрын ажлын тодорхойлолтыг манай дарга, аймгийн намын хороонд танилцуулсан байна лээ. Тэгээд ер нь дарга бид хоёр өөрий чинь одоогоор үйлдвэрийн хэлтсийн даргаар тавина гэж шийдсэн. Дарга маань ирэх намар намын дээд сургуульд явахаар болж байгаа...
- Тэгээд?
- Тэгээд дарга, намайг орондоо тавиад чамайг миний ширээн дээр залах төлөвлөгөөтэй байна. Чамаас нуух юм алга, чи бид хоёр хамт нэг ангид оюутан байлаа, түүнээс хойш хийгүй сайхан нөхөрлөж дотно танилцлаа. Зан, зангаа сайн мэдэхийн хувьд хоёулаа энэ трестийг гартаа авья.
- Үйлдвэрийн хэлтсийн дарга Лувсандэндэвийг ямар ажилд өгөх гэж байгаа юм бэ?
- Ажил унагаасан учир тушаал бууруулж, мастер болгохоор тохиролцсон.
- Батсуурийн оронд уу?
- Тиймээ, Батсуурийн оронд, Батсуурийг хүсэлтээр нь хална.
- Нөхөр минь энэ чинь буруу асуудал.
- Яагаад буруу гэж?
- Батсуурь шиг тийм сайн ажиллагаатай, шударга мэргэжлийн ажилчныг халаад оронд нь намайг дэвшүүлнэ гэдэг чинь таарахгүй, дэмий ажил...
- Чамайг Батсуурийн оронд тавих гээгүй байна шүү дээ.
- Шууд түүний оронд биш ч гэсэн, намайг хэлтсийн дарга болгохын далимаар Батсуурийг зайлуулж байгаа хэрэг...

- Ээ дээ Наваан минь, Наваан минь зургаа, долоохон сар ажиллачихаад манай трестийнхний нарийн явдлыг гадарлах болоогүй байна. Ажилчдын дотор удирдлагын нэр хүндийг бууруулахыг оролддог, хэл ам гаргадаг, хоосон шүүмжилж сүржигнэдэг мастер Батсуурь барилгын техник Жамбалжамц нараар толгойлуулсан бүлэг байгаа юм. Хэрвээ чи бид нар шиг санаа нийлсэн улс хамтын удирдлагатайгаар ажиллавал бусдыг уруу татагч тэр бүлгийг тас цохиход төлөөгүй амархан.

- Тэр хамтын удирдлага гэдэгт чинь би орж чадахгүй.

- Хүн учры нь хэлээд байхад чи ямар хачин хүн бэ?

- Хачин юу байх вэ? Энэ баримталж байгаа шугам чинь буруу байна...

- Жишээлбэл: юу нь буруу байна гэж?

- Тэр Батсуурь, Жамбалжамц нарын хэсэг ажилчид өнгөрсөн жилийн тайлангийн хурал дээр, бас үйлдвэрчний хорооны хурал дээр ч гэсэн трестийн хэмжээгээр оршиж байгаа дутагдлыг хэлээд чамайг зохион байгуулж чадахгүй байна, биеийн жаргалыг бодохоос биш ажил хийхгүй байна гээд л шүүмжилсэн. Ажлын эрх ашгийн төлөө зөв шүүмжилсэн хүмүүсээ халаад “бүлэг” гэж тас цохиод байвал эцэстээ юу болох вэ?

- Чи ийм хандлагатай байгаа бол над хэлэх юм алга...

- Сэрээнэн минь бухимдсаны хэрэггүй. Үнэн байдал ийм л байна.

- За за больё, явах цаг ч болчихлоо.

- Их бага удирдах ажил хийж байгаа улс, хүнийг гомдоож л болдоггүй юм. Би ч бас энэ гашуун туршлагыг биеэрээ үзсэн хүн...

- Нэг үгээр хэлбэл чи миний саналыг дэмжихгүй л байгаа биз дээ.

- Би бол ажилчин хүн, өөрийнхөө саналыг л хэлж байна. Магадгүй манай трестийн бүх ажилчид ч ийм бодолтой байж мэднэ. Чи сая үйлдвэрийн хэлтсийн дарга Лувсандэндэвийг тушаал бууруулна гэж байна. Тэр чинь бүх талаараа ажилчдын дотор их нэр хүндтэй дарга шүү.

- Ямар ч болсон маргааш даргатай уулзаарай.

- Уулзаад ч нэмэргүй байх аа даа...

- Тунсаг ч ирлээ. Би явъя.

- Цай чинь халлаа, уухгүй юм уу?

- Уухгүй, уухгүй...

- За манай Наваанаар сонин юу байна?
- Юмгүй хө. Чи хоршоогоор ороо юу?
- Тарган мах байна, гурван кило авлаа. Сэрээнэн ууртай гарч явах чинь, та хоёр түнжин хагараагүй биз?
- Яалаа гэж. Олон жилийн найз нар гэдэг чинь ам зөрнө гэж байдаггүй юм шүү дээ. Би гурил зуурах уу?
- Тэг тэг чи хоол хийхдээ надаас дээр юм гээч.
- Дээр нь ч юу юм бэ, ойр зуурын юм хийгээд л байдаг юм. Найз минь цайнаасаа уу, халуун байгаа. Дараа нь би махаа хөшиглөж орхиё.
- Гэртээ өөрөө хоолоо хийдэг биз?
- Бараг л тийм, заримдаа Хоролжав ч хийдэг л байсан.
- Чи Хоролжавыг их эрхлүүлж байж толгой дээрээ гаргачихсан хүн юм аа даа.
- Яаж байна?
- Хоол, унд гэр орныхоо бүх ажлыг өөрөө хийсээр байгаад дэндүү эрхлүүлчихсэн байх... Эхнэртээ их бууж өгвөл эцэстээ ганцаараа үлдэнэ гэгч энэ дээ Наваан минь.
- Үнэний хувь бий дэг шүү... Танай Сэрээнэн гэрийн ажилд хир вэ?
- Зуун хувь нооль. Чи нэг удаа хоол хийж байхы нь харсан уу?
- Хараагүй.
- Манай Сэрээнэн ч ажил төрөл байхгүй, ааш зан сайнгүй ер нь тиймхэн л хүн. Нэгэнтээ ханилчихсан юм, одоо болсон хойно салалтай биш.. Хөөш Наваан чамаас нэг зүйл асууя байз, болох уу?
- Асуу, юу асуух гэв?
- Чи ер нь яах гэж манай энд ирсэн хүн бэ?
- Аж төрөх гэж...
- Худлаа, чамайг нэг л юм сэтгэлийг чинь зовоогоод байх шиг байна. Өөр хүүхэнд хайртай болсон юм уу? Нэг л шалтгаан байна...
- Чи хаанаас мэдээ вэ, Тунсаг аа?
- Чамайг энэ хугацаанд ажиглаад л байгаа юм... Муу Тунсаа чинь тийм ч их мулгуу хүүхэн

биш шүү... Чи хэлээч дээ...

- Тэр их нарийн учиртай, чи мэдэхгүй...

- Нарийн учры нь гадарлаад байна, найздаа хэлчих...

- Манай ажлын газар Цэвээнсүрэн гэдэг нэг хүүхэн байдаг юм, бид олон жил хамт ажилласан улс.

- Хар хүнтэй юм уу?

- Гэр бүлтэй, нэг охинтой.

- Насаар залуухан хүүхэн үү?

- Энэ жил 29 настай.

- Тэгээд та нар суухаар ян тан тохиролцсон хэрэг үү? Цаадах чинь хар хүнээсээ салж байгаа юм уу?

- Үгүй, үгүй би салгах гэж байгаа юм биш, харин намайг хотод байвал Цэвээнсүрэн хар хүнээсээ салчиж магадгүй болоод байгаа юм... Тэгээд би бусдын гэр бүлийг үймүүлснийхээ оронд өөрөө холдож байгаа минь энэ.

- Худлаа, худлаа. Чамайг байхгүй хойгуур цаадах хүүхэн чинь салдаг, жилийн дараа ч юм уу чи эргэж очоод суудаг, ийм л хэлэлцээртэй нууц янагууд байна.

- Чин үнэнээсээ ярихад ийм учиртай юм, чи итгэвэл итгэ байвал бай, бусдын гэр бүл үймүүлэх шиг эвгүй юм байхгүй.

- Ээ дээ мэдэхгүй, нууц янаг гэдэг чинь их л хүчтэй байдаг юм гэнэ лээ дээ...

Тав

- Наваан минь чи явахаар шийдээд байна уу?

- Явна. Танайд чинь бүтэн найман сар суулаа, над их тус боллоо, та хоёртоо их баярлалаа.

- Манайхаас гараад хаана суух болж байна, байр олсон уу?

- Барилгын ажилчдын байранд нэг өрөө өгсөн.

- Сэрээнэн та нарын хооронд юм болоогүй биз, Цаанаа нэг л биш..

- Найз улсын хооронд юу болов гэж...За миний чемодан бэлэн болчихлоо.

- Чамайг ийм түргэн явна гэж санасангүй. Наваан минь чамд би дасчихжээ... Өнөөх

Цэвээнсүрэнгээс чинь сурагтай юу?

- Сураггүй, би хаашаа явахаа хэлээгүй юм чинь яаж сураг гарах вэ дээ.

- Энэ хооронд захиа бичээгүй юм уу?

- Хоёрын хооронд бичиж сэтгэлий нь үймүүлэх ямар ашиг байна.

- Та хоёр хоорондоо их сайн байхаа. Тийм үү?

- Нэг дор хамт ажиллаж бие биендээ дассан л улс...

- Наваан чи ер нь жинхэнэ дурлаж үзсэн үү?

- Хэлэхэд хэцүү л байна. Хоролжавт бол дурлаж л байсан... Тунсаг минь хайр дурлалгүйгээр хүн гэдэг чинь амьдарч болох ч үгүй чадах ч үгүй.

- Би ч бас тэгж л санадаг. Миний сэтгэлийг чи даанч ойлгохгүй байна. Сэрээнэн ирж байх шиг байна.

- Сэрээнэн хуралтай байсан юм болов уу? Юун их удах юм.

- Тийм ээ, хуралтай байсан юм. Дараа нь дарга нар ажилтай гэнэ лээ. Тарсан юм байж л дээ. За баяртай Тунсаг минь.

- Наваан минь ингээд яваад өглөө гэж үү?

- Танай ам өрхөнд багтаагүй болохоор явахаас биш яахав.

- Сэрээнэнтэй уулзаж яв, би яриад өгье... Өө Сэрээнэн ч ороод ирлээ. Чи яагаад оройтоо вэ?

- Ажилтай.

- Наваан маань явах гэнэ.

- За бүгдээрээ баяртай. Их баярлалаа. Би эртхэн дөхье.

- Баяртай.

- Сэрээнэн! Чи чинь Навааныг яасан царай өгөлгүй гаргаж орхив оо? Ядаж нэг манж үг ч гэсэн хэлдэг байгаа даа.

- Ямар ч үг хэлэлтгүй өөрөө сайн мэднэ...

- Хувцас хунар, царай зүс чинь яачихаа вэ? Бие чинь өвдөө юу?

- Өнөөдөр ажлаасаа авахуулчихлаа...

- Юу? Орлогч даргаасаа авахуулчихлаа гэж үү?
- Тийм ээ, бүтэн найман жил хийгээд өнөөдөр халагдлаа. Тунсагаа цаадах хундаганаас аваад ирээч хө.
- Архи ууж явах нь вэ?
- Дуугүй л аваад ир. Өнөөдөр мөн их цухалдаж уур хүрлээ гэм...
- Юунд цухалдаа вэ? Хэн чамайг халаа вэ?
- Манай дээр ардын хяналт шалгалтынхан хэд хоног ажиллаж байгаад өнөөдөр хуралдуулсан юм. Олон хүн шүүмжилсэн хамгийн голы нь Наваан л хийчихлээ.
- Наваан уу даа? Хүнд гэм хиймгүй л хүнсэн дээ.
- Ёстой найзгүй эр юм, нэг сайхан дөнгүүллээ.
- Наваан ер нь зөв л үг хэлдэг хүн, чиний л буруу байгаа байх.
- Чи ханилсан нөхрөө уначихаад байхад юунд шар Навааныг өмөөрч сүйд болоод байгаа юм бэ?
- Өмөөрсөн юм алга, санаснаа л ярьж байна. Наадах чинь ус биш архи шүү дээ, битгий залгилж орхи.
- Зүгээр, сэтгэлээ засч байна.
- Чиний оронд ямар хүн томилогдсон бэ?
- Уг нь Навааныг томилох гэсэн нь өөрөө татгалзсан юм билээ. Тэгэхээр нь үйлдвэрийн хэлтсийн Лувсандэндэв гэдэг дүйнгэ толгойтой нэг юмыг тавихаар болсон. Тэр бид хоёр ч таваглахгүй ажил байхаа.
- Чи ямар ажил хийхээр болов оо?
- Бүү мэд... Нэг ажил шүү юм өгнө л биз.
- Танайхан тэгвэл Навааныг үнэлж байгаа юм биз дээ.
- Наваан үнэд орж би сохор зоосны өртөггүй болж байгаа юм байхаа. Чи ер нь юу гэж Навааныг магтаад байгаа юм бэ?
- Хэн магтсан юм бэ? Чи өөрөө л Навааныг дэвшүүлэх гэсэн татгалзаа гээ биз дээ.
- Өөрөө дэвшихгүй мөртлөө өрөөл бусдыгаа ингэдэг мөн хачин хүн шүү...
- Хачин биш ээ. Харин ухаантай хүн байна. Миний өвгөн нөхдөдөө битгий муу юм сана.

Цаадах чинь чамайг сайн яваасай гэсэндээ л шүүмжилсэн байх.

- Хоол хийвэл идлээ, хийхгүй бол унтлаа.

- Өвгөн минь согтож орхиж. Түр амарч бай. Хоол болохоор сэрээе.

- Тунсагаа!

- Юу вэ?

- Чи одоо надаас сална биз дээ?

- Яалаа гэж салдаг юм бэ. Дуугүй унтаж үз.

- Ажил ч үгүй, цалин ч үгүй ядарсан амьтантай суугаад яахав. Чамайг зовоохын нэмэр. Явбал явж болно...

- Сэрээнэн минь, өвгөн минь чамайг хичнээн ядрах тусам муу Тунсаа чинь салах байтугай улам хайртай болно.

- Ай даа ийм сайн эхнэртэй байсан цагт би юунаас ч айх вэ дээ.

- Үнэн үг шар тос.

- Хайр сэтгэлтэй л бол хамаг хэрэг бүтнэ.

- Залуу халуун насандаа ханилсан улс чинь хайртай байлгүй яахав дээ. Миний өвгөн сэтгэлээ тайвширч үз!

ЦЭНДИЙН ДОРЖСҮРЭН

Зохиолч Ц.Доржготов 1940 онд Архангай аймгийн Хашаат сумын нутагт төржээ.

Бага, дунд сургууль, 1969 онд Москва хотноо хэвлэлийн дээд сургууль төгсжээ.

1970 оноос уран зохиол сонирхон оролдож “Дусал инээд”, “Мөнхийн ус”, “Бор морь” зэрэг хошин шог зохиолын ном бичжээ.

ГАЛЫН БУРХНЫ ХАЙЛСАН ҮГ

Галаа түлүүлж хоолоо хийлгэдэг болохоор нөхөр маань намайг галын бурхан гэж дээдэлсэн юм. Эрхэм хүүхнүүд ээ!... Хэрэв нөхөр тань гаднаас орж ирээд угаасан шалан дээгүүр шороотой гутлаараа туучдаг бол, орон дээрээ гадуур хувцастайгаа хэвгдэг бол, тамхиныхаа үнсийг дуртай газраа хаядаг бол, гоожуурын ус хэрэглээд хаалгүй орхидог бол, мартын найманд бөх үздэг бол, өөр юм бодоод авгайнхаа яриаг тоож анхаардаггүй хирнээ дахин давтан эцтэл нь яриулдаг бол энэ өгүүллэгийг уншаарай!

Сургаж болдоггүй хүн гэж байхгүй гэдэг. Гэхдээ өрхийн тэргүүлэгчдийг гэр орны яль бусын дэг журам сахиулахад тийм ч амаргүйг миний мэт галын бурхад сайн мэдэх учиртай. Нөхрийгөө гэр орны дэг журам дагахгүй зөрчихөд би, үүний буруу миний нөхөрт биш гагцхүү энэ гайны дэг журам л сулдаж хэмээгээд улам чангалдаг байлаа.

Урьд манай нөхөр нэг хүүхэнд сээмэгнэсэн удаатай. Сээмэгнээгүй ч байж болно. Ямар ч атугай надад тэгж санагдсан хойно сээмэгнэсэн л болж таарна. Би энэ талаар хуулиа чангалахаар шийдэж нөхөртөө “Хэрэв чи дахиад эмс рүү зөвхөн нүд ирмэвээс би үг дуугүй сална. Энэ бол манай гэрийн заавал биелүүлэх дотоод хууль” гэж тунхаглав.

Хэд хоногийн дараа бид хоёр дэлгүүрт орлоо. Тэгтэл нөхөр маань махны худалдагч шомбогор цагаан хүүхэнд талоноо өгөхдөө нүд ирмээд надад баригдлаа. Би нөхөртөө “Энэ талаар манайх ямар хуультайг чи мэдэх үү?” гэвэл тэр арга буюу толгой дохиод ямар нэг тайлбар тавих гэж байна. “Хуулиа л мэдэж байсан бол ямар ч тайлбарыг авч хэлэлцэхгүй” гээд би гэртээ оруут өөрийн гэсэн хамаг юмаа ялгаж богц саванд ян тан болгож аваад, толгой салаавчлан орон дээрээ гадуур хувцастайгаа хэвтсэн нөхрийнхөө дэргэд /зүрхээр нь хатгуулахаар/ зориуд авчирч тавилаа. “Би чинь ийм хөөрхөн хүүхэнтэй байсан юм уу?” гэсэн харамсалдаа түүнийг багтарч үхвэл үхэг! гэж бодоод дэргэдүүр нь хойш урагшаа хувцасны маяг үзүүлэх мэт холхиж гарав. Уг нь надад шууд гарах л үлдсэн юм. Гэвч нөхрийгөө ямар нэг үг дуугарах магадгүй гэж сэтгэл минь хоргодно. Хөөрхий, эмэгтэй хүний сэтгэл болсон хойно ямар нэг юманд горьдоод байна. Юунд горьдоо вэ?... Мэдэхгүй. Бухимдсандаа би царсан шалан дээгүүр гутлынхаа өсгийгөөр тас тас товшлон гулалзав. Энэ нь нөхөрт маань бол, царсан шалан дээр өндөр өсгийгөөр товших биш, харин өөрийн нь халзарч яваа зулай дээр төмөр гадсаар тогшиж буй мэт өвдөж байгаа вий. Гэвч яая гэх вэ өөрийн хийсэн хэрэг гэж би бодоод “гомдолгүй биз?” гэж амыг нь асуулаа. Тэр дээш харж хэвтсэн чигтээ

- Одоо яах вэ дээ. Манайх нэгэнт тийм хуультай хойно гээд миний зүрхийг чичигнэтэл санаа алдав.

- Би хэсэг чимээгүй зогсож салах ёс гүйцэтгээд амьсгаагаа урт авч “За баяртай” гэж жүжигчний намба аясаар хоолой чичрүүлээд, нөхрийнхөө дэргэд /зүрхийг нь шархлуулахаар/ аль түрүүн тавьсан богц саваа авч хаалга руу явах гэтэл хоёр хөл зүүдэнд мэт хөдөлсөнгүй. Сэтгэл нэг юманд горьдсондоо нүд юу ч харахгүй боллоо. “За одоо мань эр тэсэхгүй,.. ухасхийн шалан дээр сөхрөн суугаад хөлнөөс минь тэврэн, айл аймгийн хүмүүсийн дотрыг сэрхийтэл орилно” гэж бодуут хүчтэй төсөөлөлдөө толгой эргэж хөл дайвалзав. Гэвч тэр хөлд сөхрөх байтугай, нүд анилдуулж байна. Би арчаагүй байдал гаргаснаа хар авахуулахгүйг

хичээн хаалга руу алхлаа. Тэгэхдээ түүнийг араас гэнэт тэврэн орилоход нь цочихгүй гэж хамаг биеэ түүнд бэлдэн сугаа хавчин явсаар нэг мэдэхнээ хаалганд хамраараа тулав. Түлхүүрээ зориуд шажигнуулан эргүүллээ. Хаалга дуугарсан ч үгүй “явсугай” хэмээн өөрөө онгойв. Хэсэг зогслоо. Чимээ ч алга, намайг явуулахын мөрөөс болжээ гэж бодоод шар хөдлөв. Босго алхуут зэвүү хүргэсэн хаалгыг чадлаараа хаялаа. Тэгтэл эхнэргүй эрийн харанхуй орцонд аймаар ганцаардаж байна. Хаасан хаалгаа нуруугаараа налж хэсэг уужрахдаа “бүх болсон ба болох” явдлаа төсөөлөн бодож үзлээ. “Энэ муугаас салахад би харамсаж байна гэж үү?... Ёстой гайгүй байлгүй” гэж бодогдмогц доош шатаар гүйв. “Энэ зэргийн хар юмнаас салахдаа харамсвал ёстой гутамшиг”. Шатны хашлага сандайлан суугаад багын зангаар гулгамаар санагдав. Гулгалаа. Болж байна... “Надаас хорж холторсон юм ердөө ч алга. Би одоо эхнэр биш бүсгүй”. Бие хөнгөрөөд нэг л “сул” хүн мэт санагдлаа. “Байз, ингээд харьчихад нэг л юм дутаад байна. Юу дутаа вэ?... Аа тийм. Түүнийг ядаж ганц сайн чадахсан. Яасан гэж түүнийг чадах гэж байгаа билээ?... Шалиг зан гаргаж махны худалдагч бүсгүйд нүд ирмэсэн гэж үү? Үгүй ээ! Одоо бол нүд ирмэсэнд гомдох юм өчүүхэн ч алга. Ичгүүргүй харчуудыг шалиглахад би ч гэсэн хааяа зөвхөн гадна талдаа тас намжирдаж байсан. Миний гомдол өөр зүйлд байна. Тэр намайг үүрд явахад яагаад хорьсонгүй вэ? Би түүнд ийм хямдхан амьтан байжээ. Хамаг гомдол минь үүнд л байна. Ерөөсөө буцаж орё”.

... Намайг ороход тэр ухасхийн босож инээмсэглээд гараас богц сав авах гэлээ.

- Үгүй шүү! хэмээн би гар дахь юмаа угз татан авч

- Та буруу ойлгож байх шиг байна. Би танаар хүргүүлэх гэж буцаж ирлээ. Та намайг анх авчирсан болохоор хүргэж өгөх байлгүй гэлээ. Тэр хөмсөг зангидан нэлээд бодсоноо

- Миний буруу! Намайгаа уучил гэж байна.

Шууд буулт хийх нь арай ичгэвтэр тул би

- Тэр ярихгүй ээ. Хууль бол хууль! Аль вэ, одоохон хар гэрт минь хүргэж өг гэв.

Түүний царай үерийн үүл адил баралзсанаа

- За... хүргэж өгье дөө гэж сулхан дуугараад хувцаслав.

Хүн бууж өгөх гэж байхад мэдэхгүй, тэнэг амьтан гэж би дотроо түүнийг хараагаад гаднаа их л ууртайгаар “Чи намайг зайлахгүй байх гэж айсандаа гэрт аваачиж өгөх нь үү? Би ганцаараа далд орж чадна” гээд гарлаа.

... Эхлээд шууд харихаар автобусанд суув. Тэгтэл таньдаг хүн таарах вий гэсэн айдас намайг эзлэв. Нөхрөөсөө салсныг яваандаа бүгд мэдэх атал ийм айдас төрсөн нь хачирхалтай санагдаж, нэгэнт шийдсэндээ хүрэхийн тулд өөрийн оюун мэдрэлд ямар л эрэг шураг байна бүгдийг чангаллаа. “Эртхэн мэдэж авцгааг! Нуугаад хэрэггүй” гэж өөртөө зарлиг буулгав. Гэвч таньдаг хүн таарах вий гэхээс бэргэж жийрхээд нэг л болдоггүй ээ.

Тогшуут хаалга аяндаа онгойж эвгүй чихрав. Би хувцсаа өлгөөд галын өрөөнд орлоо. Тэр

нойрмоглосоор орж ирээд хажуу дахь сандал дээр лагхийн сууснаа

- Чи сая ирэв үү?... Би таг унтчихаж гээд эвшээлгэв.

Би түүний нүүр өөд харж чадсангүй, дэмий л

- Чи чинь хаалгаа түгжихгүй унтчихсан хүн үү гэх зуураа “гэр орон хулгайч ухчихвал яах юм бэ?” гэсэн ихээхэн өөриймсөг харц шидвэл мань эр

- Чи өөрөө түгж гэж хэлээгүй явчихсан хойно би яаж мэдэх вэ гэж уцаарлав.

Нөхрийн маань юу ч болоогүй мэт хэнэггүй, тэр ч байтугай увайгүй тунирхуу энэ байдал миний ичиж нэрэлхсэн бүх л зовлонг нимгэлж, баярласандаа би түүндээ хариу тунимаар санагдав. Гэвч биеэ барилаа. Барихаа ч алд. Саяхан би нөхрийнхөө тухай бодохдоо, тэр авгайгаа явуулчихаад хоолоо хийх гэж циркийн баавгай зүү сүвлэх гэж буй мэт овойж суугаа даа гэж хор шарын инээдэмдээ ялимгүй баясаж, аминдаа хариугаа авч явлаа. Гэтэл тэр намайг ичүүртэйеэ буцаж ирэхэд юу ч болоогүй мэт хоолоо хүлээж, гэдсээ илэн сууж байсанд, надад ч гэсэн тэр дороо юу ч болоогүй мэт болж нэг мэдэхнээ ханцуй шамлан тогоо тулга золгуулан гялбалзаж байх юм. Үүгээр ч үл барам таг дуугүй суух нь энэ айлыг хөмөрсөн тогоо лүгээ адил болгоод сэтгэл давчдан нөхрийнхөө амыг чагнана. Нөхөр маань эвшээлгэх зуураа харвингаа шохоорхон баахан илснээ

- Би сая хонжворт сугалаагаар эмэгтэй хүний нэхий дээл хожлоо гэж зүүдэллээ. Хэмжээ нь яг дөчин зургаа, урт нь гурав байдаг шүү гэнэ. Эхлээд миний ой гутах шиг болов. Дараа нь “Еэ зайлуул даа, аргадах ухаан нь энэ!” гэж бодоод хоолой зангирлаа. Эцэст нь “Мөн мэргэн юм бодож олов оо” гэж бодмогц хоолой дээрх тээглээ зөөлрөн инээд болж хувирах дөхлөө. Гэхдээ манай нөхөр тэнэг хүн биш ээ. Тэр хүнтэй ярихдаа маш ухаалаг. Ухаалаг байдгийн нууц нь анхаарлаа дайчилсных л даа. Харин тэр надтай ярихдаа оюун ухааны өчүүхэн ч зардал гаргадаггүй учир ийм тэнэг байдалд байн байн ордог юм. Энэ нь надад итгэсэндээ ч тэр үү, дээрэлхсэндээ ч тэр үү, бүү мэд! Хамгийн гол нь миний сэтгэл түүнийг үг хэлэхэд хариу дуугарахгүй байж ерөөс тэвчдэггүй юм. Тэр зүүдээ ярьсан хойно гэргий хүн би хариу дуугарах ёстой. Тэгээд

- Орчин үеийн маягаар бол би рост дөрвийг өмсдөг болсон шүү гэж хэллээ. Тэр мангардуухан инээгээд

- Мэдэхгүй мэдэхгүй золиг! Тэгвэл рост дөрөв байсан байх ээ. Их л тод зүүдэлсэн юмдаг гэв. Бид дахин таг дуугүй болов. Энэ ёозгүй аниргүй байдал бид хоёрын сэтгэлд оройны эвгүй явдлыг авчрах тул би сэтгэлээ дүйвээлэх санаатай учир утга мөхөс, тэнэгдүү яриандаа эргэн орохоор шийдэж

- Цэвэрлэгээнээс чиний хувцсыг аваад замдаа үсээ янзлуулах юм билүү гэсэн нь хүн зөндөөн байна. Яараад чадсангүй гэж гүвтнэв.

Тэр дахин “ах-ах-ай” хэмээн эрүүнийхээ углуургыг нуд нудхийтэл эвшээлгээд хайрцагтай янжуур авч үзсэнээ

- Чи тамхи авчраагүй биз. Тамхи дуусчихаж гэнэ.

Түүний татах дуртай янжуурыг замдаа авахаа мартаагүйдээ өөрийгөө би овоо хүүхэн шүү гэж бодлоо. Хүүхнүүд минь нөхрийнхөө арганд би ингэж орсон хүн дээ.

Энэ явдлаас хойш би гэр орондоо хичнээн дэг тогтоож, хууль гаргаад нөхөр маань биелүүлэхээ цэглэлээ. Мунгинасаар байтал нэг мэдэхнээ манайх олон хүүхэдтэй өнөр өтгөн айл боллоо. Аавыгаа дагалдаад хүүхдүүд маань миний шаардлагыг дагахгүй янзтай. Ээ дээ хүүхнүүд минь, орон гэр өөдрөг байх нь өрхийн тэргүүлэгчийн хүмүүжлээс шалтгаална шүү. Яагаад гэвэл тэдний занг үр хүүхэд нь дууриадаг байна. Нөхрийгөө гэр бүлийн аливаад сургахад ёс журам сулдахгүй ээ. Гагцхүү тэр ёс журмыг биелүүлж байна уу гэдгийг мөрдөх л сулдана. Биелүүлэхгүй бол дэг журам хичнээн чанга байгаад ашиггүй. Одоо би эвдэрсэн нөхрөө засаж авахын тулд өөрийнхөө шаардлагыг зөөлрүүлж, харин биелэлтийг нь чангаруулж байна. Жишээ нь: “Тамхины үнсийг бэлтгэсэн саванд хийж бай” гэж байсан бол одоо тамхиныхаа үнсийг ойчихыг дөхүүлээд авгайгаа дуудаж авахуулж байх ёстой гэж зөөлрүүлсэн юм. Гэхдээ энэ журмыг заавал биелүүлэхийг хатуу шаардсаны дүнд нөхөр маань байн байн “Хүүе! Янжуурын үнс уналаа” гэж хашгирах буюу эсвэл “Уналаа уналаа, гүйгээрэй гүйгээрэй” гэж сандаргана. Би ч үнсний сав барин түүний янжуурын үзүүрийг ээрүүлдэн амар заяаг нь үзүүлэхгүй нүдний нь өмнө бүртэлзэн гүйдэг боллоо. Тэр ч байтугай мань хүн заримдаа надаас түвэгшээгээд гарынхаа дор байгаа үнсний саванд янжуураа тоншдог явдал ч сүүлийн үед харагдлаа. Бас “гар нүүрээ угаагаад гоожуураа хааж бай” гэхийн оронд “гар нүүрээ угаагаад намайг дуудаж гоожуураа хаалгаж бай” гэсэн зүйл оруулсан юм. Ер нь өрхийн тэргүүлэгчид “энийг ингээч, тэрийг тэгээч” гэж эхнэрээ захирахдаа онцгой дуртай хүмүүс. Манай нөхөр гоожуурын ус хэрэглэхчээд явахдаа “Хөөе чи, тэр гоожуураа хаахаа мартаж улсын байр сүйд хийчих вэ. ус ч гэсэн алт гэдгийг чи мэдэх үү” гэж надад сургааа ерөөс мартдаггүй юм. Эрчүүлийн иймэрхүү “зааварлах” авьяасыг нь дагуулан хөөргөөд өгвөл цаадуул чинь уг нь ханилж болох хүмүүс шүү. Тэдний дуг нойрон дундаа хурхирахаас бусад дутагдлыг засаж болно гэдэгт эрхэм хүүхнүүд минь итгээрэй.

1978 он

ДУГАРЫН ДОРЖ

Зохиолч Д.Дорж 1931 онд Дорнод аймгийн Баяндун сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага дунд сургууль, 1956 онд Улсын их сургууль төгсжээ.

1953 оноос уран зохиол сонирхон оролдож “Барилдаж явсан минь”, “Мандах нарнаар”, “Ялимгүй будлиан”, “Давааны цаана даваа”, “Нууц хурим” шүлэг өгүүллэг туужийн ном хэвлүүлжээ.

МЯЛААЛГА

- Шинэ байрны мялаалганд урья гэсэн бичигтэй хуруу дарам хуудас аваад гайхшран сууж байтал, нягтлан бодогч Төмөрхүү, бас нэг тийм хуудас барьсаар орж ирэв.
- Чогдог тун чамбай эр шүү. Юм бүгд дээр нямбай загнана. Энэнийг хараач гэж Төмөрхүү, урилгын хуудсыг эргүүлж тойруулан үзэж байна. Чогдог гэдэг маань манай аж ахуйн дарга билээ.
- Тиймээ, үнэхээр чамбай гэдгээ баталж байна. Ганцхан хуруу дарам цаасан дээр л бүхэл бүтэн урилгыг багтаасан байна. Мөн ч хичээнгүй, тун ч жижигхэн бичсэн байна шүү.
- Мань эр цаас хэмнэхийн хажуугаар бас бэхээ арвилахыг бодолцсон байна шүү.
- Тэр ч мэдээжийн хэрэг. Газар хэвтэж байгаа ширхэг хадаасыг хүртэл түүж борлуулан хөлжиж байгаа хүн шүү дээ. Тэр ч байтугай ... гэтэл утас дуугарч яриа саатуулав.
- Олдох ярьж байнаа гэсэн манай даргын дуу утсанд хүнгэнэж байна.
- Би Мандах байнаа. Сайн байна уу даргаа? Мэндийн хариуд дарга маань:
- Бүх хүмүүсийг над дээр таван минутын дотор оруул гэж зандрав.

Тавин долоон хүнийг ийм богино хугацаанд цуглуулж хараахан амжмааргүй мэт санагдавч болчимгүй үг дуугарахаас би болгоомжлон уруулаа жимийв. Манай дарга ч бас чамбай хүн шүү дээ. Үүрэг даалгавры нь биелүүлэхгүй өөдөөс нь цор-цор гэсэн хүнийг араандаа зууна. Удахгүй болох хурал дээр муугийн жишээнд орвол муухай шүү дээ таминь. Би тэр дороо гүйн гарч

- Цааш цааш нь дамжуулаарай, та минь. Даргын өрөөнд ... гэж хашгиран багтарч унатлаа харайлгав.

Ярианаас хожимдож орсон хүнийг нэг нүдээрээ үздэггүй, цагийн секунд бүрийг тооцдог даргынхаа занг анддаггүй, манайхан ч сүр сархийн гүйлдэж байв. Дарга маань цагаа харж мушилзаад

- За нөхөд минь, нэг чухал ажил гарлаа гээд ялдамхан мишээж байна. Бүрхэг өдрийн тэнгэр шиг дүнсгэрхэн байдаг даргын маань энэ эвлэгхэн ааш, түнэр харанхуйд, тэргэл саран мандах мэт биднийг баясгав.

- Нөхөр Чогдогийн шинэ байрны мялаалганд хүн бүгд заавал оролцох хэрэгтэй. Тэгэхдээ гуч гучин төгрөг нийлүүлж, зурагт радио авч очно. Мөнгө илүү гарвал таван хошуутаас хэдийг нэмнэ гэж яриад дарга маань уруулаа шилэмдэж тамшаалж байна. Цугларагсад даргын яриаг дуугүй чагнаж, дор бүрнээ нэгийг бясалган бодол болов.

- За нөхөд минь яриа дууслаа гээд дарга маань хөмсөг зангидав.

Тэгээд манайхны дунд, мөнгө цуглуулах, дэлгүүрээр явах энэ тэр гээд хэдэн өдөр ажил ундрал.

Урьсан өдөр, найрын гол ширээнд манай дарга сууж, шинэ байрны мялаалгын ёслол яг цагтаа эхлэв. Өрхийн тэргүүлэгч Чогдог өөрөө найрын сөн түшиж, сархадын савыг хоосортол юүлж байлаа. Хоосортол юүлнэ гэдэг тун учиртай ажээ. Энэ тухай өгүүлэх нь:

Чогдог өөрөө хоёр дугарааны дараа халамцаж эхлэв. Тэгээд бараг илбэ гэмээр хачин юм үзүүлж, биднийг хөгжөөх гэж оролдов.

- Би нэг юм хэлье. Уул ухаандаа энэ маань аливаа зүйлийг арвилан хэмнэх тухай юм гээд Чогдог, нэг шил архи авахад гар нь салгалж байлаа.

- За та нар харж бай гээд архийг хундагалж эхлэв. Та нар сайн тоолоорой, нэг хоёр...гэсээр гучин гурав дахь жүнзийг дүүргээд шилнийхээ ёроолыг харуулав.

- За энэ шил хоосорч уу?

- Шавхруу ч үгүй болсон байна.

- Аа тийм үү? Тэгвэл дараачийнхыг гээд түрүүчийн үйлдлээ давтан үзүүлэв. Тэгээд эхний суларсан шилийг жаран долоо дахь жүнз рүү тонгойлгоход хэдэн дусал, дараачийнхаас нь бас хэдэн дусал, хоёуланг ээлжлэн арваад минут сэгсэрсний эцэст нэг хундага дүүрэв.

- За ийм л байна дээ. Ингэж юмыг дусал, ширхэгээр нь хямгадах хэрэгтэй гээд Чогдог пар пар инээв. Энэ “үзэгдлийн” дараа хүмүүсийн дунд “орон нутгийн” яриа үүсэв.

Миний хажууд суусан хэдэн хүн, энүүхэндээ аминчхан яриа эхлэв. Энэ хүмүүсийг, аагтай цайнаас хатуу ундаан хэрэглэдэггүйг манайхан мэднэ. Эд нар маань нэг дусал ч хороож зүрхлэхгүй, анхны тулгасан нь мэлтэлзэж байна. Хэдийгээр аминчхан ярилцавч үг бүхэн нь тодхон сонсогдоно.

- Манай Чогдог ийм л чамбай даа. Ямар нямбайгүй байтлаа халимгаа самнаад, мөрөн дээгүүрээ унасан үсээ түүж хадгалж байх вэ дээ. Тэгж цуглуулсан үсээ нийлүүлж томон түлхүүрийн оосор хийгээд зээл дээр барьж явахы нь би үзсэн.

Харин тийм ээ. Дэлгүүрээс авсан барааныхаа боодлын цаасыг хүртэл индүүдээд зүсэж байхы нь би харсан. Тэгээд илүү гарсан өөдсий нь гэртээ авч ирж гэл асаадаг гэсэн... гээд тэрүүхэндээ шивнэлдэж байна.

Ширээний нөгөө буланд бас, сэтгэл нийлсэн хэдэн хүн сууж байна. Тэд дөрөө чангалахдаа ганзага нийлдгийг манайхан цөмөөрөө мэднэ. Тэдний дунд, Төмөрхүү хамраа гудчин, хоолойгоо засаж сууна. Хашир хандгайнууд, дэргэдэх бүсгүйчүүдийнхээ хувийг сэмхэн хүртээд царайгаа улайлган хөгжилдөцгөөнө. Тэд уухаасаа сонсоод хэл нь ороолддогийг бид бас мэднэ. Тэр дундаас Төмөрхүү сонсохоосоо өмнө архины тухай сануугаа нүд нь талимаарч эхэлдэг билээ. Тэд нар, түс түс ярьж тас тас хөхрөлдөж байна.

Энэ үес мань Чогдог үг хэлэхээр босов.

- Ай юутай сайхан бэ. Би ийм хамт олны дунд ажиллаж байгаадаа туйлын их баярлаж явдаг. Та бүхнийхээ дэмжлэгийн хүчинд л би энэ зэрэгтэй сайн явж байна шүү дээ гэж Чогдогийн яриа ид дундаа өрнөж байтал

- Ёстой үнэн дээ. Бидний хүчинд л шинэ байртай... гэж Төмөрхүү түсхийтэл дуугарч үгий нь таслав. Чогдогийн царай баралзаж, урдаа байсан том аягыг шүүрэн авуут, таван хошуут хүрэн архинаас мэлтэлзүүлэн хийгээд Төмөрхүүд хоёр гардаг өгөв. Төмөрхүү аягатай сархад руу уруулаа цорвойлгож, нүдээ жаатайлган хэсэг зуур ажсанаа, толгойгоо далжийлган зогсоод

- Зээ

- Сайн нөхөр Чогдогийнгоо

- Сайхан байртай болголоо бид

- Сайхан энэ байр бол...гэж урсгаж эхэлтэл, Чогдогийн царай бүр хувхай цайж

- Үгүй ээ, үгүй ээ ерөөл хэрэггүй. Наадахаа зүгээр тогтоочих. Чамайг шагнаж байгаа юм гэж уруулаа өмөлзүүлэн хэлэв. Төмөрхүүгийн урам хугарав бололтой, шалавхан суугаад, аягатайгаа амсалгүй тавив.

-Төмөрхүү минь наадахаа тогтоочих. Чамайг шагнаж байгаа юм гэсэн шүү дээ. Шагналаа хүртчих гэж нэг нь чанга хэлэв.

- Үхсэний чинь шагнал. Сохор улаан зоос төлөлгүй бусдын хүчээр шил, тоосго хамаг юмаа олчихоод,

- Төмөрхүү минь жаахан тавьтартайхан шиг байж үзээрэй гэж манай дарга зандран хуруугаа чичлэв.

- Тавьтаргүйдээ яагаав. Таван өрөө, үнэгүй байшинтай болсон хүн.

- Төмөрхүү минь өөр сайхан юм ярья гэж Чогдог аргадан хэлээд, аадрын ус шиг асгарч байгаа духныхаа хөлсийг шувтрав.

- Муухай юм ярихдаа би яагаа вэ. Манаачийг цай уух хоорондуур барилгын талбайгаас банз,дүнз ачуулж байсныг чинь би ярих гээгүй. Сайхан байшинтай болсон гэж л магтах гэсэн юм. Энэ үгийг сонсоод хүмүүс харилцан нудралцаж, нэгэн зэрэг босоцгоов.

ШАРАВЖАМЦЫН ДОЛГОРЛХАМ

Зохиолч Ш.Долгорлхам 1938 онд Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага дунд сургууль, БНАСАУ-ын Урлагийн дээд сургуулийн дуулаачийн ангийг 1962 онд төгсжээ.

1962 оноос уран зохиол сонирхон оролдож “Хос мөр” гэдэг өгүүллэгийн түүвэр хэвлүүлжээ.

НҮҮДЛИЙН ШУВУУ

Эх орныхоо ирээдүйн хөгжил цэцэглэлд хандивлах гэж харийн орноос эрдэм өвөрлөн ирж яваа хайрт ханьтайгаа маргааш учирна гэхээс сэтгэл байж ядан догдолно. Ийнхүү сэтгэлийн хөдлөлөөсөө болж гэртээ тогтож чадалгүй гадаа гарч сайн сайхны хязгааргүй бодолд умбан оюун сэтгэлээрээ баяр жаргалыг амсан сайхан хотынхоо саруул гудамжаар алхаж явлаа. Гэтэл нүүдлийн шувуудын уянгат ганганаа миний бодлыг сарниахад тэр зүг харвал нэгэнт харанхуй болсныг би саруул гэрэлд бодолд автан явсан тул анзаарсангүй. Харин тэр харанхуй тэнгэрт од мичид анивалзан гялалзахаас өөр юу ч харагдсангүй. Тийнхүү харанхуйн дунд нүүдлийн шувууд байн байн ганганалдах нь тэр одод дуу хоолойтой болчихоод холын тэр орчноос хүний орчлонгийн зүг тэмүүлэн дуулалдаж байх шиг санагдав. Тэгтэл төд л удалгүй шувууд маань “зэрэгц” команд авсан цэргийн жагсаал шиг ярайсан гэрлийн цараанд зэллэн орж ирлээ. Тэгээд дуу нь ганганан холдон холдсоор гүн цэнхэр нуурандаа ороод шингэчихэв үү гэлтэй алга болсноо дахин толгой дээр минь ганганалдан “Хунгийн нуур” бүжгэн жүжгийн хунгуудын бүжгийг санагдуулж дэвж харагдсанд Дархан хотын минь гэрлийг нуураа гэж эндүүрээд эргэлдэн байна уу даа гэж бодогдлоо. Тэгснээ бас л дуу нь холдсоор шөнийн тэнгэрт шингэн уусав уу гэлтэй үгүй болоход одод миний дээгүүр зэл татан ганганалдаж байснаа хөх тэнгэртээ очоод хадагдчихсан ирмэж байх шиг саяхан дэргэд минь элдвийг бодогдуулан дэвж байсан шувууд маань хаа холын тэнгэрт очоод од болон шигтгэгдчихсэн юм шиг санагдана. Ингэж агаарт явсан бодол маань газарт бууж их хотынхоо гэрлийг ажиглаж ахуй сар санагдахад хэдэн арван мөнх сар гэж бахдах сэтгэл төрж сарыг байтугай нарыг ч хажуудаа байрлуулж чадах хүний оюун ухаанд бишрэн амьдарч байгаа эриндээ өөрийн эрхгүй баясан бахархаж байлаа.

...Өглөө босон харвал нөгөө чийдэнгүүд маань бас л элч гэрэл түгээн эгнээ эгнээгээрээ ийш тийшээ салаалан ярайж хараа сунгавч гүйцэхээргүй даваа даван хөврөх нь эрин үеийн минь сүр хүчийг сэтгэлд бахдуулна.

Одоогоос арваадхан жилийн тэртээ шүү дээ. Тэгэхэд би өнөөдрийн шигээ эрийн цээнд хүрсэн ажилчин биш айлын ууган хүү гэж аавдаа тус хүргэх гэж адуу малаа нааш цааш нь болгодог хүүхэд байлаа. Тэгж явахдаа шөнийн харанхуйд мэлрэх талдаа хавирган сарыг хүртэл ханьд бодож эрт орой гарах сарыг хүсэж явсан билээ. Гэтэл өдөр шөнийн ээлжинд явж байхдаа сүүмгэр сарыг байтугай сүү шиг цагааран гийгүүлэх чийдэнгийн гэрлийг хүртэл онц анзааралгүй явсан байж ээ. Тэгээд бас хавар намрын цагт хөгжим мэт уянгалах дуунд нь уяран бараагүй болтол нь харцаараа үддэг байсан ирэх буцах шувуудын ганганааг ч сонсолгүй удсан нь их хотын шуугианы буруу биш цогцлон байгаа орчин ахуйдаа дорхноо дасал болсон миний буруу биз ! Тэр ч бүү хэл хавирган сарын төдийхөн байсан хүсэлд минь ханийн заяат бүсгүй алс ирээдүй, алаг үртэйгээ, айл гэрийн амжирлагатайгаа хүртэл багтаж ухаан бодол минь тэлэгдсэн байлаа. Тэгээд хань минь миний зүрхэнд Эрдэнэтуяа хэмээх нэр шигээ “эрдэнийн” туяа цацлахад над өөр гэрлийн хэрэггүй болсон байжээ.

Ай даа! Юм гэдэг үнэхээр сонин! Хөгжил гэдэг гайхмаар сайхан! Тэр үед тоотойхон бэлчих малын хөлд эмзэглэн, дурайсан зам татдаг байсан, Бурхантын хөндий өнөөдөр хүнд үйлдвэр, хүчит моторын хүнгэнэсэн дуунд баясан сэргэж үлгэрийн ордыг өвчүүн дээрээ сүндэрлүүлэн хол ойрын айлчин гийчдийн сэтгэлийн соронзон, хүчит эрсийн чадлыг сорьсон, хөөрхөн

охидын мэлмийг булаасан “Дагина” болчихоод тэр олон хүн, машины хөлд хотойх байтугай хүчит бөхийн цээж шиг тэвхийн байнам... Бас тэгээд өдөр шөнөгүй сүндэрлэн тэлэгдэж байгаа нь харчуулын хайрыг булаах тавилантай төрсөн гоо үзэсгэлэнтэй бүсгүйчүүд улам хөөрхөн харагдах гэж оо энгэсэг тавьж, үс гэзгээ янзлах лугаа адил билээ.

Энхийн хавар эргээд ирэхэд их хот минь улам өргөжин тэлэгдэж хөгжин цэцэглэсэн байна. Тэр хөгжлийнх нь хурдад Эрдэнэтуяагийн минь эрдэм нэмэрлэсэн байна шүү дээ гэж бодож зогстол алсад галт тэрэгний дохио нүүдлийн шувуудын дуу шиг уянгалан сонсогдоход нүдэнд тусах, сэтгэлд харагдах бүхнээс зол жаргал гийж байв.

ГОНДИЙН ДҮЙНХЭРЖАВ

Зохиолч Г.Дүйнхэржав 1930 онд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага, дунд сургууль, Улсын их сургуулийг 1956 онд төгсжээ.

1965 оноос уран зохиол сонирхон оролдож нэлээд өгүүллэг, найруулал “Арилшгүй мөр” зэрэг тууж бичжээ.

ФРОНТЫН ТАНИЛ

Огторгуйн уудамд анивалзах түм буман оддын дунд саран авхай их хотын хөл хөдөлгөөнийг сонирхон ажих мэт мэлтийнэ. Уужимхан тасалгаанд сүүмгэр хөх гэрэл тусч, цэнхэр дэлгэцнээ цэг төдий сүүмэлзэх дүрс тодрон тодорсоор нисэх онгоц гялсхийн өнгөрөхөд бөмбөг тэсрэн, байшин барилга нурж, агаарын их буу таг таг хийн дуугарч утаа манас манас гэхэд дайн тулааны гамшиг зовлонг биеэрээ туулсан настангууд шүүрс алдаж, юмыг сайнаар бодох балчир үрс хүн хүндээ юунд ингэж аюул тарина вэ гэж гайхан бүлтэгнэнэ.

Дайсны онгоц хар утаа суунаглуулан дүүгүүрийн чулуу шиг унахад настайвтар нэг нь “Болж хуна” гэж өөрийн мэдэлгүй амандаа үглэхэд хүүхдүүд ура хашгиран алга ташиж өндөлзөнө. Жижигхэн биетэй, шалмаг түргэн хөдөлгөөнтэй мөнгөн буурал тэргүүнтэй Даш гуай амралтын хувцсаа өмсч диван дээрээ тухлан суугаад сайн муу үггүй цэнхэр дэлгэц ширтэнэ.

Санаа сэтгэл нь өрөөнөөсөө хэдийн хальж орчлон ертөнцийн хязгааргүй орон зайд хүрсэн байлаа. Хомхой сэтгэлдээ дийлдсэн энэ хөрөнгөтнүүд үү! Дандаа л дайн дажин дэгдээж, энгийн номхон ардын цус нулимсыг урсгаж явдаг яасан өлзий бусын амьтад вэ. Ёстой л буруу номтон гэдэг ийм байдаг байх даа. Бидний амьдарч байгаа газар дэлхийд сайн санаа газар авч хорон муу санаатанд хоргодох газар улам бүр ховордож байгаа нь сайхан ч эднийг гаргуунд нь орхиж болохгүй. Уугуул ус, суугуул нутгаа хамгаалан дайтаж буй Вьетнам түмэнд туслах ажил өнөөдөрхөн явагдсан.

Олны олон таван цэн гэхлээр болоод л явчихна. Монгол түмэн та нарыг дэмжиж байна гэдэг сэтгэл санааг шингээсэнд л хамаг учир байгаа юм шүү дээ. Бөмбөгний тэсрэлтэнд хот суурин бөөн бөөнөөрөө нурж өрвөлзсөн улаан гал түүнийг хоромхноо улаан хэлээрээ ороон залгиж үнсэн товрог болгон жирийн өтгөс хөгшид, хүүхэд эмэгтэйчүүд үхэтхийн ойчиж байгааг харахад Дашийн бүх бие зарсхийж толгойны үс босох шиг болов. Духны нь үрчлээ улам гүн болж 1939 онд болсон Халхын голын дайны хар сүүдэр биеийг нь жихүүцүүлж, үхэл хагацлаар алхам бүрт заналхийлж байсан аймшигт өдрүүдийн тухай гүн бодолд автжээ.

Зургадугаар сарын аагим халуун нар дээрээс төөнөж, улайссан элс элгэн дороос өрөвдөх шинжгүй хайрахад хөлс дааварлан тэсэхүйеэ бэрх болсон ч цэрэг эрс түүнийг юман чинээн бодолгүй хориглолтын байрандаа хориглосоор. Дайсны хөдөлгөөнийг нүд цавчилгүй ширтэн хэвтэж, сэрвийх торойх бүхнийг ажиглан сум гарздахгүйг хичээн бууддаг байж билээ. Тэгэхэд би жирийн цэрэг. Дайны олон өдрийг өнгөрөөсөн мэргэн буудагч, хашир туршлагатай хүн болсон байлаа. Газрын хөрсийг нэвт дэвтээсэн хур буугаасай гэж хүсэмжлэн гангийн улаан нар шарсан униарт талыг ширтэвч нэмэргүй ээ. Тэр нэг өдөр хоромхон зуур санаанд оромгүй ширүүн байлдаан болж билээ. Энэ өдрийн тулалдаан миний санаанаас ер гардаггүй. Дандаа л нүдэнд үзэгдэж сэтгэлд дурсагдаж явдаг юм.

Зүүдэнд ором ёнгиносон муухай дуутай олон саарал онгоц бидний ар тал, нуувчны ойролцоо бөмбөгдөж газрын хөрсийг урвуулах сар том зуухны амаар үнс утаа тургин байх шиг сүртэй юм болж билээ. Манай зоригт шонхрууд түүний эсрэг элэн халин дайрч, дээр дороо орж бие биен дээрээ суман мөндөр буулган онгоцнуудын зарим нь утаа суунаглуулан газар унаж, зарим нь сүүл хавчин мөр буруулан зугтаж хааяа нэг шүхэрчид буух нь харагдана.

Агаарын байлдаан арай дуусаагүй байтал их бууны сум газар сайгүй дэлбэрэн, газрын хөрсийг онгилон шидэлж чих дүлийрүүлээ. Энэ ч нэлээд юм болох бололтой гэж бодоод утаа, шороон манан дундуур нүдээ нухлан, хахаж цацан байж харвал дайсны танкууд элсэн дунд цатгалан могой шиг мөлхөж араас нь зэвхий хувцастай япон цэргүүд даган давшиж харагдав. Манайхны винтов пулемёт, бөмбөг буудагч, миномет, их буунууд тэдний эсрэг зэрэг зэрэг гал нээлээ. Газар тэнгэр нийлэх шиг болж чих дүлийрэн утаа шороон манан тунгалаг хөх тэнгэрийн өнгийг бүүдийлгэн гутааж дарийн эхүүн үнэр дотор муухайрам ханхалж байсансан. Бууны сум шив шув тусч шороо пор пор хийлгэнэ. Манайхны хэн нэг нь нэгийг албал солио, хоёрыг албал хожоо гэж хэлтэл:

- Тийм биш нөхдөө! Бид үхэхийн төлөө байлдаж байгаа юм биш. Амьд байж төрөлх эх орноо хамгаалан, харийн хар санаатан дайсныг өлгий нутгаасаа зайлуулахаар байлдаж байгаа болохоор хийморьтой үзэлцэж дандаа хожих ёстой гэсэн салаан даргынх нь баргил бүдүүн хоолой чихэнд нь сонсогдох шиг болоход бид хожихыг бодон бууддагсан.

Бидний хамт хориглож байсан зөвлөлтийн туслан хамгаалах ангийн цэргүүд мөн л цог золбоотой гялалзаж ялахын төлөө мэрийн буудаж байгаа нь илхэн харагддагсан. Миний хажуухан талд хэвтгээд буудаж байсан сэргэлэн цэнхэр нүдтэй орос цэрэг “Сайн бууд” гэж байгаа бололтой дохиод сэтгэл хангалуун инээмсэглэхэд улам ч зориг орох шиг болж билээ. Дайсан давшихаа болиод хориглолтонд орлоо. Бидний зорилго зөвхөн хориглоход биш дайсны эзэлсэн газрыг булаан авахад байсан юм. Манай их буунууд зэрэг зэрэг галлаж “Давшаад” гэсэн командаар монгол, орос цэргүүд нуувчнаасаа үсрэн гарч ура хашгиран дайрч билээ. Дайсан байдаг чадлаараа галлаж биднийг урагш ахиулахгүйг хичээнэ. Миний дэргэд байсан тасгийн дарга:

- Онц буудагч Даш хоёрдугаар тэмдэгтээс баруун тийш хоёр хуруу зайтай байгаа дайсны хөнгөн пулемётын галын точкийг сөнөө гэлээ.

- Би тушаал ёсоор гүйцэтгэе! гээд овоо хараагаа нийлүүлэн гохоо дарлаа. Пулемёт ч чимээгүй боллоо.

- Нөхөр түрүүчид, тушаал ёсоор дайсны хөнгөн пулемётын галыг устгалаа.

- Сайн байна.

Манайхан дайсны эсрэг ёстой л суман мөндөр буулгаж дахиад дайрлаа. Би ч хамт дайрлаа. Тэгтэл миний хажуу талаас дайсны хөнгөн пулемёт дахин тачигналаа. Би хэвтэнгүүт түүн рүү давшилтын гранатаа шидлээ. Гранатын дэлбэрэлтэнд пулемёт онхолдож газрын хөрс онгилогдон юутай хүүтэйгээ дээш шидэгдлээ. Тэгээд л гардан тулалдаан эхэлж чухам хаана юу болж байгааг ажихын эрхгүй юм боллоо. Хүний бүдэгхэн орилох, гар бууны тас пясхийх дуун чих дөжрүүлэв.

Би дайралдсан винтовоороо баруун дээд, зүүн доод хамгаалалтууд хийж ёстой л “цохихыг нь цохиж, жадлахыг нь жадалж” галаа. Миний баруухан талд намхан нуруутай, зөвлөлтийн цэргийн нэг хүн цүүцгэр өндөр японтой хоёул барилдан авмагц, япон яах ийхийн завгүй дороо хийгээд авлаа шүү. Би ч үсэрч очоод винтовныхоо бөгсөөр японы дагзан дундуур

дэлслээ. Тэгтэл миний араас нэг хүн тэврээд авах нь тэр. Тонгорч орхисон чинь миний өмнө ойчлоо. Би ч буугаа алдлаа. Манай хүн бодийг нь хөтөллөө. Намайг буугаа аваад эргэтэл хажуунаас дахиад нэг япон дайрлаа. Нөхөр маань өрсөж түүнийг тонилголоо. Гэтэл араас буу тасхийн орос нөхөр минь цээжээ даран салгалаад явчихлаа. Эргээд хартал японы офицерийн буу дахин тасхийж мөр рүү минь хүчтэйхэн цохиод авах шиг болов. Би ч түүнийг жадаллаа. Манай морин цэрэг дайсны хажуу талаас ура хашгиран дайрлаа. Япончуудын зарим нь тарган тарвага шиг паацганан зугтахад үлдсэн хэсэг нь зэвсгээ хаяад гантай жилийн тааруухан ургасан заг шиг ёрдойлцон гараа өргөлөө.

Би, нөхөр дээрээ гүйж очоод шархыг нь түргэхэн боох гэтэл баруун гар минь ясандаа янгиналаа. Аз болоход орос нөхөр минь хөндий цээжээрээ шархадсан байлаа. Бүх чадлаа шавхан байж нөхрийнхөө шархыг боогоод хөлсөө арчтал зүүн гар нь улаан харагдлаа. Санаснаас хөнгөн шарх байсан юм. Түүнийг боолоо. Тэгтэл миний зүүн хөл нойтон оргиод явчихлаа. Нөхөр минь нэг юм хэлээд над руу дөхлөө. Би гутлаа тайллаа. Өнгөцхөн шархаджээ. Түүнийгээ боолоо. Мөрөө яаж ч чадсангүй. Миний аманд түй гэх шүлсгүй, хуруу хөдөлгөх ч тэнхэлгүй болсноо сая мэдлээ. Хамгийн түрүүн ус уух хэрэгтэй байв. Нөхрөө харахад тэр надаас илүү цангасан нь илт. Зүүдэг савтай усаа авч үзтэл хоёр нүх онгойж харагдлаа. Тэгтэл улаан хэрээс тэмдэгтэй орос хүүхэн ирээд миний шархыг боож нөхрийн минь боолтыг заслаа. Бид хоёрт зүүдэг савтай усаа хувааж уулгалаа.

Бид хоёр ингээд зөвлөлтийн цэргийн хээрийн эмнэлэгт хүргэгдлээ. Тэнд хоёул танилцаж нөхөрлөсөн билээ. Түүний нэрийн Саша гэдэгсэн. Дайн эхлэхээс аваад Саша бид хоёр мөр зэрэгцэн тулалдсан мөртөө бие биеэ таньдаггүй байжээ. Биднийг эмнэлгээс гарахад “төлгөн хуц элгэн хад мөргөв” гэгч япончуудад болж дайн дууссан байж билээ. Сэтгэлд танил дотно энэ бүхнийг дурсан суусан Даш гуай хүндээр шүүрс алдав. Тэгтэл ач хүү нь:

- Өвөө! Та юу бодоо вэ? Аа яа, яа! Саяын ниссэн пуужин дайсны онгоцыг ёстой мундаг онолоо шүү хэмээн шулганав. Вьетнамын ард түмнээс харийн түрэмгийлэгчидтэй хийж байгаа дайны тухай баримтат кино дууслаа.

- Өвөө нь авдранд байдаг цоорхой савны түүх, фронтын танил хоёроо бодож сууна.

- Өвөө та яагаад дандаа түүнийг боддог юм бэ?

- Өвөөд нь дайн байлдаантай кино үзэхээр эх орныг минь аварсан зөвлөлтийн улаан арми, миний амийг аварсан фронтын танил хоёр үргэлж бодогддог юм гэлээ.

Даш хананд өлгөөтэй байгаа зөвлөлтийн цэргийн дүрэмт хувцастай залуутай тэврэлдэн байж авахуулсан зургаа сая л анх харж байгаа юм шиг нүд тогтоон байж удаан харлаа. Бид хоёр мөн ч залуу байж дээ гэж бодоход түүний нүдэнд золбоолог оч туяарч байлаа.

МУХАМАДИЙН ЕЛЕУСИЗ

Зохиолч М.Елеусиз 1938 онд Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

1957 оноос уран зохиол сонирхон оролдож “Өрөг нуур” тууж, өгүүллэгийн ном “Ховдын энгэр дээр” роман /казак хэлээр хэвлэгдсэн/ бичжээ.

ТЭМЭЭН НҮҮДЭЛ

Тайван хэвтэж байгаа ширээ бөхтэй шар ат шиг нүдний үзүүрт харагдах шаргал уулсын тэртээгээс үүрийн туяа шөнийн харанхуйг аажмаар үлдэн хөөж эхлэв.

Малчны хот айлын амар тайвныг сэрээмээргүй санагдсан мэт хот дүүрэн тэмээд алтан үрэл лугаа адил тархан хэвтэнэ. Зуны турш гилж шимтэн бэлчээрт хариулж, өвсний сор, усны тунгалагт идээшин ширээ бөх болж таргалсан атан тэмээнүүд бүгчимдэх мэт амьсгаадан үе, үе унжсан уруулаа сэгсрэлдэх ажээ.

Хасаг охидын нүдний адилтгал болсон тунгалаг хархан нүд, түүнийг нөмрөн сэрвэлзэх урт сормуусаа цавчлан хөдөлгөсөн ботго торомнууд унтаа сэрүүн хоёрын хооронд мансууран байна. Олон зууны тэртээгээс тэмээн сүргийг улам өтгөн болгож үр төлөө хайрласан ингэн тэмээнүүд тайван агаад ихэмсэг байдлаар орчноо ажиж, намуухан хивнэ.

Гэнэт амар тайвныг цочоосон нэгэн айхтар дуу сонсогдож үүрийн туяанд гялбан гялбасаар өнгө нь бүдгэрсэн хоёр гэрэл ойртон ирлээ.

Эртэлж ирсэн машин гэрийн гадаа ирж зогсоход гадуур хувцсаа мөрөндөө эгэлдэргэлсэн Картенбай гадаа гарав. Машины кабинд суугчид аажуу уужуу бууж ирээд тайраг тайраг давхин үргэсэн тэмээдийг харж,

- Ай хөөрхий хоцрогдлоо гэж ийм байх юм даа. Яаж мэлхийнээс өөрцгүй энэхүү тэмээ гэдэг амьтнаар тэр нэгэн эрт дээр үед нүүж явсан болдоо гэж бригадын дарга, жолооч хоёртоо малын эмч Шегенбай хэлэв. Жолооч залуу

- Амьдрах гэж ядсаных биз дээ эмч минь! гээд машинаа унтрааж, хаалгаа нээв. Бусад нь Картенбайтай мэндлээд ажил үйлсийн тухай ярьсаар нэлээд удлаа. Энэ үед тэмээчин өвгөний авгай ч босож гал түлэв. Картенбай гэртээ орж хоймортоо завилан тухалсны дараа бас л Шегенбай ам нээж Картенбайд

- Өвгөөн! Би цай уухгүй. Тэмээний айраг ууя гэв. Гэрийн эзэн бригадын дарга руу харж

- Та нар ч гэсэн... гэхэд

- Ганцаараа уухыг хүссэн эмч маань цадахгүй байлгүй. Бидэнд цай ч болно гэж Шегенбай “бид” гэхгүй “би” гэж хэлсэнд дургүй нь хүрч адран хэлэв. Гэрийн эзний авгай дастархан дэлгэнгээ

- Бүгдээрээ ууцгаагтун, хүрнэ хүүхдүүд минь гэлээ. Сайхан исгэж, ханатал нь бүлсэн айраг аягаллаа. Эхний хэдийг бараг амьсгаа авалгүй залгилсан Шегенбай төдөлгүй ухарч суув. Картенбай

- Үүгээр болоо юу гэхэд

- Үхэн хатан уудаг гүүний айраг биш дээ гэж эмч дургүйлхэв. Удаахан сууж элдвийг хүүрнэн

уусан бригадын дарга, Картенбай хоёрын урд хоёр дахь түмпэн айраг ирэхэд эмч тэвчсэнгүй:

- Дарга минь больж үзнэ байгаа. Ажилгүйдээ ингэж яваа биш. Нүүлгэх айлууд гэрээ буулгачихсан байгаа. Тэгээд бас сумын дарга энэ машиныг долоохон хоногийн хугацаатай өгсөн. Бригадын айлуудыг хурдан нүүлгэцгээ. Аймгаас бараа татуулахаар явуулна гэсэн юм. Тиймээс ч бид шөнө дөлөөр гарч танайд очсон юм биш үү! Та харин тэмээчин өвгөнийд очно гэж өөрөө дагаж зүтгэсээр ирсэн. Ингэхэд нэг хоёр гэр лавтай ачиж буулгах цаг ч өнгөрлөө гэж өөрөө айлуудыг нүүлгэхээр сумаас машин авч ирснээ болон бригадын даргын “муу муухайг” илэн далангүй ярилаа.

Хэзээнээс дуу цөөтэй “дуугүй” хочтой бригадын дарга айраг хийсэн аягаа дастарханы хажууд тавиад уртаар хэхрэн айрагны сайхан амтыг ахин нэг мэдэрсэн мэт болсноо Картенбай өвгөнд өөрөө огт мэддэггүй хүний байдалтай,

- Одоогоор бэлэн байгаа тэмээнийхээ тоог хэлээч, том нь, номхон нь хэд вэ? гэлээ

- Ботго, тайлгийг нэмэхэд нэлээд хэд юм бий. Гэхдээ ачааны номхон тэмээ цөөхөвтөр. Бага залуугийн ихэнх нь эмнэг догшин. Бүгдийг эдэлгээнд сургахад хоёр гуравхан тэмээчний хүч хүрэлцэхгүй юм даа. Айлууд буурь сэлгэхийн хооронд машин техник хэрэглэж тэмээг эдлэхээ больж шүү дээ гэв.

- Өө хөөрхий, энэ өвгөний зөнөснийг хар. Шинжлэх ухаан техник хөгжсөн хорьдугаар зуунд сууж байж, тэмээг унаа болгоно гэнэ! гэж Шегенбай хэлэв. Бригадын дарга эмч рүү биш, тэмээчин рүү хандаж,

- Таны хэлдэг үнэн шүү. Бид тэмээ морийг уналганд хэрэглэх явдал багадаж байна.

Энэ бол буруу юм. Гэрийн аар саархан ажилд машин, машин гэхийн хэрэг юу байна вэ?

- Дарга минь үнэн хэлж байна. Нас чинь бага боловч ажлаараа ах шүү дээ. “Чи” гэж хэлсэнд минь битгий гомдоорой. Харин тэмээг машинаас дутууд үнэлж болохгүй. Харин манай энэ нутгийнханд чи тэмээгээр нүүхийг дадал болгож өгөөч! Газар нутаг нь чинь ч гэсэн түүнд тохиромжтой. “Тэмээг бүрэн цуглуулж байгаарай” гэж чи өчигдөр хэлүүлсэн байна билээ. Бүгдийг нь хураагаад ирсэн. Ганц хоёр догшин эмнэгээс бусад нь бүгд бий гэв. Шегенбай эмч тэгтэл

- Ай хөөрхий арилаагүй бүдүүлэг ёсоо гэж дуу алдсанаа ахин,

- Үгүй нөхөд минь одоо та нарын хоцрогдсон феодализм чинь биш, социалист нийгэм байгааг харж байгаа биз дээ. Феодализмын шавхруу шавхагдаагүй байхад энэ чинь эргэж нэмж байгаа хэрэг үү? гэв. “Дуугүй” хочит бригадын дарга нэг уурлавал муугүй агаад цэгцтэй юм хэлдэг хүн. Одоо тэр хэмжээндээ хүсэн бололтой.

- Шегенбай минь, социализм байтугай коммунизмд ч тэмээ хоргүй амьтан. Хэдийд ч ашиг тусаа өгнө, хүн ардаа. Та нар ер нь хуучин нийгмийн үлдэгдэл гэдгийг өөрсдөө мэдэхгүй байж, сагсуурахыг хэдийд болих юм бэ? Чи хэрвээ мэддэг юм бол хуучны үлдэгдэл тэмээ

биш, харин та нар дотор байна. Нэгдэл нийгэмдээ тус хүргэхийн оронд өчүүхэн ажилд машин авч давхидаг. Энэ хүүхэд хэлэг л дээ? гэж жолооч хүүхдийг харав. Энэ үед айраг уухаа больж, аяга таваг хураасан байв. Бригадын дарга гэрийн авгайд

- Намаржаанд буусны дараа айраг ихээхэн исгэж, бригадын айлуудад худалдана. Хөхүүр болон бусад сав суулга бэлдүүлсэн гэхэд авгай,

- Хүү минь эрүүл саруул байвал би, биеэ гамнахгүй. Энэ ариун ундаа олны таалалд нийцвэл залхуурахгүй гэлээ. Уурлаж бухимдсан Шегенбай Картенбай руу зэрвэсхэн харж

- Өгөрсөн толгойноос үмх мах олно гэж явсаар ботго тором үхүүлэхийг зөвшөөрөхгүй гэж хэлэв.

Бригадын дарга түүний үгийг сонссон боловч сонсоогүй байдал үзүүлж

- Намаржаанд буусны дараа бригадын залуучуудыг цуглуулж эмнэг тэмээнүүдийг сургана. Та одоохон мордоод айлуудад очиж «машинаар нүүлгэхгүй, тэмээ авцгаа гэж хэлээд хүмүүсийг дагуулж ир. Тэгээд унаа хөсгийг өгч хамры нь сэтэлж нуруу туруугий нь авуузай» гэж анхааруулаарай гэснээ дөнгөж сэрсэн жолоочид

- Чи Шегенбайн гэрийг ачаалж буулгаад сум руугаа буцаарай гэв.

Халаасаа нэгжиж, түлхүүрээ эрж эхэлсэн жолооч

- Танайхыг нүүлгэхгүй юм уу? гэв.

- Үгүй, энэ Картенбай өвгөн бид хоёр коммунизмд тэмээгээр хүрнэ! гэж хэлээд босов.

Үүнээс цагийн дараа уудам талын амьсгалыг бачимдуулан давхисан «Зил 130» машин малын эмч Шегенбайн гэрийг чиглэв. Харин тэмээ унаж хэдэн тэмээ хөтөлсөн бригадын дарга өөрийнхөө хот айл руу чиглэн «Эх газрын завийн» нэгэн хэмийн үргэлжлэх аясаар хөврөн гэлдэрч явав.

Ш. Жамлийхаа орчуулав.

ХОРОЛИЙН ЗАНДРААБАЙДИЙ

Зохиолч Х. Зандраабайдий 1934 онд Дундговь аймгийн Цагаан Овоо сумын нутагт малчны гэрт төржээ.

Бага дунд сургууль, 1973 онд Улсын их сургуулийн хэл утга зохиолын ангийг төгсжээ.

1960 оноос уран зохиол сонирхон оролдож «Хонхон дуу», «Төрийн нууц», «Их айлын эзэгтэй» зэрэг өгүүллэг, найруулал туужийн ном, «Хонины найр», «Хөх ногооны униар», «Газрын жигүүр», «Гул Аранжин» зэрэг кино зохиол, «Аранга», «Задын чулуу» зэрэг жүжиг бичжээ.

СУМАН ХҮРЭН

Энэ үйлдвэрийн их хаалгаар зөвшөөрөлгүй орж гарч байдаг дархан эрхтэй амьтан нэг л байдаг. Тэр бол хүн биш адгуус учраас аргагүй гэж бодож болох юм. Тэгтэл хашаан доторх сахлаг өвсөнд шунаж хуурай шиг ширүүн хэлээ долоолон ирдэг үхэр бярууг бол тас шавхуурдаад хөөчихдөг. Арьс ширний халим өөх цөвдөл шинжилсан муусайн нохой бол бүр ч горьгүй. Хичнээн аятайхан юмны үнэр танар хамар цохив ч зөвхөн шүлсээ залгиад шалавхан холдохгүй бол дүүгүүрийн чулуунд хавиргаа цөм цохиулах аюул бий. Харин энэ хоол горьдогсдын хор шарыг хөдөлгөдөг нэг амьтан энд байдаг нь сахлаг үстэй өтгөн ширэлдсэн дэл сүүлтэй намхан зузаан биетэй сайн ажигласан хүнд яльгүй шухарган цээжтэй хар хүрэн морь билээ. Энэ амьтанд адил адгуус нь байтугай хүн атаархах нь бий. Зарим нэг салан хүн нэвтрэх үнэмлэхээ орхиж, үүдний манаачид ээрэгдэж зогсож байхдаа, үйлдвэрийн хаалгаар хэнэг ч үгүй алхан орж байгаа хүрэн морийг хараад «Хн энэ муу морь бас санаа амар орж байнаа» гэсэн удаатай. Хүрэн морь хэзээ ч би энэ айлын эзэн гэсэн шиг өглөө ажилчидтай хамт бараг уралдан их хаалгаар орж ирэв. Тэр шууд яваад ердийн хөсөг, тэрэг тоног байдаг буланд нөмөрдөн зогсоод яаран сандран гүйж яваа ажилчин олныг нулимс гүйлгэнэсэн том хар нүдээрээ ажин ажин зогсоно. Түүний ийнхүү зогсож байгааг хэн ч анзаарахгүй. Сайндаа л зарим нэг өвгөн ажилчин «Гэлэграждангийн муу хүрэн байна» гэж танимгайрхана. Хүрэн морь хүний хэл мэддэгсэн бол энэ үгэнд мундахгүй л урамшихсандаа. Хүний хэл гэдэг этгээд хэцүү юмыг адгуус сурах хувьгүйгээс хойш яая гэхэв, сайн ч хэлсэн, муу ч хэлсэн шавхуурдан хөөгөөгүй нь яамай гэсэн шиг үүрэглэн зогсоно.

Явган хүний замаар хижээл насны хоёр ажилчин ярилцсаар гарч ирлээ. Мөр нь гандсан хар савхин дээлтэй өндөр туранхай эр гар дохин зангаж, ханилж яваа ажлын хувцастай буурал өвгөнд ямар нэг юм ойлгуулж ядан явна. Тэр хоёрыг хараад хүрэн морь чихээ сортойлгон толгой өргөж, сунаснаа хоёр алхам дөхөж сүүл шарваад үүрсэв. Савхин дээлт түүнийг хараад гар өргөн дохив. Хажуугийн нь хүн «чи чинь адуунд гараа өргөж ёслоод яаж байгаа юм» гэж асуув.

Миний суман хүрэн гэдэг морио. Бид хоёр залуу насаа энэ үйлдвэрт барж, зан зангаа авсан хоёроо. Энэ маань магтах муулахыг анддаггүй юмдаа.

-Ухаантай адгуус байх нь хөөе.

-Ямар ухаангүй амьтан тэрэг чирэхээ байгаад хүнээр юм бол тэтгэвэрт гарчихсан хэр нь өдөр болгон хүрч ирээд байх вэ.

Илжиг модон хударгандаа гэж тэр биз.

Хүрэн морь, хүмүүсийн ингэж ярилцахыг мэдэхгүй атлаа яагаад ч юм сэтгэл нь амарсан бололтой, хүзүүгээ гүлдийлгэн нэг сайхан суниагаад дахин үүрэглэж эхлэв. Төдөлгүй бүр тонгойн толгойгоо унжуулав. Адуу хүн шиг зүүдэлдэг бол хүрэн морь идэр залуу цагийнхаа сонин дуртгалын нэг хэсгийг зүүдэндээ үзэж байж ч магадгүй юм. Барааг арван таван жилийн өмнө үйлдвэрийн ердийн хөсөгт хэрэглэх хэдэн морь улсын бэлтгэлийн адуунаас авахад Гэлэграждан гэдэг адуунд эртэй залуу ажилчин олноос хамгийн түрүүнд эмнэг хүрэн морийг барьж авсан юм байжээ. Арьс хөрс сайтай, бяр чадалтай бахим чийрэг хүрэн үрээ,

тэргэнд орж өгөхгүй мөн их зовоосон ажээ. Адгуус юм тулд л хүн түүнийг аргагүй эрхэндээ оруулж, арван хэд хоног ноцолдож байж арай гэж тэргэнд сургажээ. Тэр үеэс хойш Гэлэгравдан хүрэн мориноос тэрэг тоног салгалгүй, арьс шир, ноос үс, гутал хувцас, морин тэргээр зөөж болох бүгдийг тээжээ. Хүрэн морь ч өвөл зуны дөрвөн цагийн эргэлтэнд цас бороо, халуун хүйтнээс халшралгүй дааж ядсан ачаатай, хар хөлсөө савируулан зүтгэсээр арван таван жил болжээ. Өглөөнөөс аваад нар шингэтэл явсны эцэст тэрэг тоногноосоо салж сулран үйлдвэрийн хаалгаар гарч бэлчээрт одно. Тэрэгний морьдыг Туулын гүүрээр гаргаж, богд хан уулын аманд хүргээд орхино. Өглөө эрт авчирна.Өвлийн цагт хашаанд байлгаж тэжээнэ. Энүүнийг хүрэн морь төдий л таашаадаггүй юм. Усны тунгалгийг ууж, өвсний соргогийг идэж, эрх дураар явах нь жаргалан учраас хөдсөн өвс хамж, хайлсан цасны ус уух түүнд гутамшиг байжээ. Хан уулсын аманд хэд хоног таавар байна гэдэг амьдын жаргал боловч хяслантай нь түүнийг тэгж дураар байлгадаггүй ажээ. Энэ нь түүнд хэвшил болж өглөө болмогц хот руу дөхөж, орой ажил тармагц гүүрээр гарч бэлчээртээ очдог болжээ. Тэр сайн өдрөөс бусад өдөр амарна гэж үгүй. Харин эзэн нь бол цэцэг жимс дэлгэрсэн зуны сайхан цагаар олон хоног алга болно. Эргэж ирэхдээ лухайсан хүрэн царайтай болсон байна. Гэхдээ Гэлэгравдан морио хэзээ ч мартдаггүй. Амралтаар явахдаа орныхоо хүнд морио, ус хоолыг тохируулан гамтай эдлэхийг захиж орхино. Цөөн хоног боловч шинэ эзэнтэй байхдаа хүрэн морь дургүй, гол нь ачаагаа дааж ядан байхад нь хатуу сураар шавхуурдахад яснаасаа дургүй хүрнэ. Тэгээд эсэргүүцэл илэрхийлж дэмий л чихээ хулмалзуулж, хазах дүр үзүүлнэ. Үүнээс болж хүрэн морины зан жаахан эвдэрч ааш муутай болсон ажээ. Тэгэвч өөрийн эзэнд ихэд дасаж, бас ч хайртай болсны учир түүнийг хармагц зан нь засарч, ойртож ирэхэд нь үүрсэн үнэрлэн тэргэндээ суухад нь сэвэлзтэл алхалдаг ажээ. Үнэндээ эзэн нь түүнд төдий л олон уурлаж, харааж зүхэж зодож занчдаггүй учир хүрэн морь ихэд дасжээ. Арван таван жилийн туршид унаж эдэлсэн мориндоо эзэн бас хайртай сайн байдгийг морь гадарладаг ажээ. Тэгээд ч барагтай нэг ташуурдах юм уу, ус хоолгүй өнжөөчихөд гомддоггүй явжээ. Тэр ч байтугай эзнээ ирэхгүй удвал ирээсэй гэж мөрөөдөж, хүрээд ирэхэд нь баярлан үүрсэж сүйд болдог байжээ. Нэг эзэнд хэтэрхий дассан нь түүнийг муу занд сургаж, бусдыг хазаж хайрах гэж сүрдүүлдэг болсон байна. Зангий нь мэдэх өвөгцүүл «хишшүү» гэхчхээд шал тоохгүй өнгөрнө. Энэ нь айлгаж сүрдүүлчих гэж их бодсоны хувьд урамгүй санагдавч хүмүүс бас л хүрэн моринд дассаны шинж гэдэг нь ойлгомжтой. Нэг өвөл болсон явдал хүрэн морины санаанаас огт гардаггүй.

Цас хайлан мөс дагтаршсан замаар дүүрэн ачаатай морин тэрэг гэлдэрнэ. Хүйтэн жавар тас няс хайрна. Морины хөлс гоожин цантаж, мөсөн молцог унжина. Хоёр хамрын нь самсаа сарталзан их л хүч гаргаж байх боловч газар арвитай дөхөхгүй, тэрэгний эзэн даарч, яарч байгаа ажээ. Ташуурын сур тасхийж, чүү чүү гэж хашгиран шавдуулна. Морь бас энэ ачаанаас л шалавхан салбал өнөөдрийн явдал дуусна гэж мэдээд хүчээ шавхан чармайж, хасаа хөлөргөн зүтгэж байгаа билээ. Явах тусам ачаа хүндэрч, замын хальтаргаа бэрхдэж, замын хальтаргаа бэрхдэж, эзний шавхрах дэндэж байлаа. Хазгай гишгэвэл л хальтарч муугаа үзнэ гэдгийг арван таван жил тэрэг чирсэн хөгшин морь юун эс андах вэ. Гэтэл болдоггүй юм болдоггүй байжээ. Хичээгээд хичээгээд болсонгүй барагшин замын голд хальтран савж унав. Хоёр өвдөг, хэдэн хавирганы өвдөж байгаа гэдэг тоймгүй. Нүднээс нь гал бутрах гэдэг үгээ дахин дахин урсгаж байв. Ар талд машины дохио хангинана.

-Гэлэгравдан чи наад ширээ зайлуулаач.

-Энэ адсага чинь босдоггүй... муу хог...

Энэ үгнүүдээс хүрэн морь гурвыг сайн мэдэж байлаа. Харин өдий жил болоход ингэж муугаа үзэж байгаагүй болохоор «зайлуулах, босохгүй, хог» гэдэг үгийг мэдэхгүй учир чухам юу хэлснийг нь мэдэх авьяасгүйдээ харамсаж хэвтлээ.

-Гэлэргравдан бушуулаач, ачаагий нь буулга.

- Наадхи чинь үхлээ, чи өрөвдөөч.

-Ээ зайлуул муу хүрэн морь больжээ.

-Хэр дээ, энэнээс өөр юм бол үхэх болсон.

-Суман хүрэн нэрнээс цаашгүй болжээ.

-Тун ястай адгуус шүү...

-Хэлээд яахав, ёстой морины хүү...

Ингэж хүмүүс магтаал муушаал давхцуулан ярихыг сонсовч, сонсохоос цаашгүй учир тийчилж чадлаа барахын хэрэггүй гэж бодоод хөдлөлгүй нүдээ анин хэвтэв.

Тэрэгний ачааг буулгаж хүрэн морийг босгов. Хамаг бие нь буларч яс нь янгинан, үсний уг хүртэл өвдөвч гишгэж хөдөлж үзвэл хугарч хэмхрээгүй нь баярлалтай ажээ. Хүрэн морь дахин унахаас болгоомжилж дөрвөн хөл дээрээ эмзэглэн зогсоод шилгээв.

Энэ бид хоёр хоёулаа хөгшрөөд алба хэтрүүлж дөнгөхөө байлаа. Яадаг ч юм билээ. Тэтгэвэрт л гарцгаадаг байхдаа...

-Морь чинь амрах болжээ харин чи юу гэсэн үг вэ.

-Муу хүрнийгээ яадаг юм билээ.

-Тэжээлийн хашаанд өгчихгүй юу. Тэнд муусайн хөгшин морь байгаа. Энэ өвөлдөө тэжээж жаал таргалуулаад шилжүүлнэ биз.

Хүрэн морь эзнээ нэг хүнтэй ийнхүү ярьж байхыг хараад чихээ сортолзуулан үүрсэнэ. Эзэн нь сайхь эрээс салж хүрч ирээд тэрэг тоногийг нь мулталж тавьж туув. Хүрэн морь «яагаад ийм эрт тавив» гэсэн шиг алмайран замын хажуугийн өвснөөс зулгааж байтал эзэн нь хормойгоо сэгсэрч үргээн хөөв. Энэ өдрөөс эхлэн хүрэн морь чөлөөнд гарч өөр зүйлд бэлтгэгдэж байгааг огтхон ч санаандгүй бэлчээртээ одов. Маргааш өглөө нь хүрэн морь үйлдвэрт ирдэг хэмдээ Туулын гүүрээр гараад сажилж явтал морьтой хүн эргүүлэн хөөж морь мал тэжээдэг хашаанд хөөж аваачив. Энэ бол гайхалтай биш, өвлийн хүйтэн болж цас их орохоор тэрэгний морьдыг алсын бэлчээрт гаргалгүй, энэ хашаанд байлгаж тэжээдэг учир хүрэн морь олон удаа энд ирсэн юм. Өнөөдөр үл ялиг гайхах нь юу вэ гэвэл цас бага, их хүйтрээгүй байхад тэжээлд ирж байгаа нь юм. Хүрэн морь хашаанаас гаралгүй хэд хонов.

Тэрэг чирч хүнд ачаанд зүтгэхгүй, бэлэн өвс хамж байх нь амар байв. Эзний бараа харагдахыг болив. Ер нь түүнийг хэн ч хайхрахыг байв. Бусад морьдыг бараг өдөр болгон барьж тэргэнд хөллөж бас унаж явах нь атаархмаар ажээ. Өдөр шөнөгүй хашааны хаалгыг дангинатал түгжинэ. Даваад дайраад гарах янз огтгүй, тийм чадал ч хүрэн моринд байсангүй. Хүрэн морь сүүлдээ уйтгарлаж эхэллээ. Харин бие нь сулдаж, олон уулзахаар шархирч дүүрэн ачаатай тэрэг чирэхийг хүсэх болов. Олон хоног хашаанд хоригдож, дайран гарахыг оролдсон боловч чадсангүй. Яах ч аргаа олохгүй уйтгарлаж байтал санаандгүй хашааны хаалга онгорхой харагдав. Хүрэн морь сэмхнээр гарч одов. Харанхуй шөнө дэлхийг бүрхэн омруун доорх юм үл үзэгдэнэ. Баримжаагаар үйлдвэр чиглэн явав. Ил задгай газар гарч элэгдсэн муу шүдээрээ өвс зулгаах аядан чөлөөт салхиар амьсгалах нь таатай ажээ. Өвс хазлан хазлан дөхсөөр, өглөө очдог хэмдээ үйлдвэрийн хашаанд хүрч очив. Төмөр хаалга хаалттай ажээ. Хүрэн морь цэлийтэл нээгдэнэ гэж бодож байлаа. Үүдэнд хоёр хүн зогсоод ярьж байна. Хэсэг зуур хүрэн морийг харахгүй байснаа гэнэт нэг нь:

-Өө энэ чинь Гэлэгравдангийн муу хүрэн шив дээ.

-Суман хүрэн, сүрхий хөгширчээ.

-Аргагүй шүү дээ, Миний мэдэх л ийм морь байсан. Би үйлдвэрт ороод хориод жил болж байна.

-Энэ чинь наашаа нэг их хараад байна. Хэл мэддэг юм биш биз дээ.

-Тэр ч арай үгүй байлгүй, үзье л дээ.

-Хөөе морио чи юу хийж яваа юм бэ?

Морь гайхан ширтсээр л байна.

-Энэ яасан сайхан тунгалаг хар нүдтэй юм. Өнөөх уурт хар яаж нүдийг нь сох цохичихоогүй юм бэ.

-Хэн?

-Яагаав, Гэлэгравдан... залуудаа мөн ууртайсан.

-Энэ морь уурыг нь хүргэж байгаагүй байхаа.

Хүрэн морь эзнийхээ нэрийг сонсоод сортосхийв.

-Хараач, Гэлэгравдан гэхтэй зэрэг нь чих нь сортолзож байна. Адууг ухаантай адгуус гэдэг юм. Аягүй бол түүнийг эрж яваа шүү. Оруулчих зайлуул.

Үйлдвэрийн хаалга цэлийтэл нээгдэв. Хүрэн морь тахлуулсаар байгаад бацарч далбайсан элэгдсэн муу тахны ортой том туурайтай бороолсон хүнд хөлөө зөөн зөөсөөр хаалгаар оров.

-Хөөрхий амьтан больж дээ.

-Хаалга нээгдэхтэй зэрэг дайраад л ордогсон.

-Тиймээ би л эзэн гэсэн ааштай байдаггүй юу.

-Дайрах байтугай одооч дөрвөн хөлөө даахтай мантай...

Хүрэн морь явсаар тэрэг тоног байдаг тэр газраа хүрч очив. Ижил морьд тэрэг тоног нэг ч үгүй эл хуль болжээ. Оронд нь машины тос ис, араатай төмөр, урагдсан урагдаагүй дугуй мэт байх болжээ. Харин ямагт нар ээж байдаг хуучин хашааны булан улам дулаан болсон юм шиг санагдав. Суман хүрэн шөнөжин гадаа явсандаа даарч жихүүрхэж яваад гэнэт дулаацсаных юм уу төдхөн үүрэглэж, зантгар том толгойгоо унжуулав. Хүмүүс өдөржин хажуугаар нь хойш урагш цувлаа. Ойртон ирэх хөлийн чимээгээр сэрэн харах тоолон үл таних хүмүүс гүйж явна. Хааяа нэг хэн гэж дууддагийг мэдэхгүй их л олон харсан хүн явна. Тэр морийг зэрвэсхэн харчихаад амаа хөдөлгөж үг дуугарах ч үгүй явчихна. Орой ажил тарахын алдад хүрэн морины нойр сэргэж эзнээ харуулдсаар байлаа. Ажилчид ирсээр явсаар бүр үдшийн бүрий болов. Эзэн нь байдаггүй. Заримдаа морио тавьж явуулалгүй байлгасаар бүр од түгсэн хойно гарч ирээд давс шорвог үнэртсэн баахан нойтон шүүстэй юм ачаад явдаг байсан өнө холын юмыг санаж эзнээ гараад ирэх байх гэж хүлээсээр...

Шөнө гэнэт салхи хөдөлж шуурч эхлэв. Цасан шуурга нүүр нүдгүй бургиж, хүйтэн жавар үлээж, хөлдүү газар тахтай хөлийг нь хайрч эхлэв. Идэр залуудаа энэ хэрийн хүйтнийг тоодоггүй байсан нь санагдаж, өтөлж хөгшрөөд бээрэг даараг болсон биш, дулаан газар удаан байсных гэж бодов. Төдөлгүй даарсанд нэрмээс болж гэдэс нь өлсөв. Тийн учир нуруулдсан өвстэй дулаан хашаандаа очихоор шийдээд явах гэтэл хөл нь газарт зоогдсон мэт хөдөлж болсонгүй. Хөлөө зөөх гэж арайтай ойчсонгүй, бяцхан шургачаад тогтов. Түүнээс хойш явах гэж оролдсонгүй. Оролдоод ч нэмэргүйг ойлгов. Хөл нь янгинан хөрч байснаа мэдээ алдан чинэрч байгаад халуу оргиж эхлэв. Алхах гэж үзсэнд хөдөлсөнгүй, их хүчилснээс болж толгой нь дүйрч эргэн чамархайны нь судас лугшив. Уул талыг доргион хангинатал ганц сайхан янцгаая гэсэн хоолой нь боогдоод дуу нь гарсангүй. Унгалдан давхимаар санагдавч сүүлээ өргөж чадсангүй. Хоёр чих нь шуугиад ямар нэг хүн цас чихруулан алхалсаар дэргэд нь хүрч ирэх шиг болов. Эзнээ ирлээ гэж бодоод харах гэсэн зовхи нь нээгдсэнгүй. Ямар нэг юмыг сонордсоны тэмдэг болгож үүрсэх гэсэн бас болсонгүй. Хамаг хүслэн нь ийнхүү бүтээгүй учир хэвтмээр санагдав. Гэвч үхэр шиг налчийтал хэвтэж байх нь хүлэг моринд гутамшиг мэт санагдаж бараг хорин жил газар дэлхийг тамгалсан хурц дөрвөн туурайгаа жийхийн хирээр жийж хаашаа ч хөдлөхгүйгээр хатуу шийдэв.

Өвлийн шөнийн жавар хайрч алс өндөрт одод анивчин гялалзаж байлаа. Үүр шөнө хагацах тэр агшинд дулаан байрандаа бөхөөр нойрсон байсан үүдний манаачийг цочиж, огло үсрэн босохтой пид хийх чимээ гарав. Цочсондоо манаач зүрхээ дарж хэсэг зуур чимээ анир гаргалгүй суув. Шөнийн нам гүмд манаачийн айсан зүрхний түг түг хийх л сонсогдож байлаа. Манаач сэтгэл түгшүүрлэн гарч чимээ чагнан, орчныг ажиглав. Ойрхон ямар нэг юмны амьсгал уртаар татах шиг болоход хирдхийн харвал, тэрэгний муу хөгшин морь тэрийн хэвтэж байлаа. Хүрч очвол хариугүй амьсгаагаа хурааж, эхэр татаж байлаа. Өглөөхөн зүв зүгээр сажлаад ирж байсан юм шүү дээ. Амьтны үхэл ирэхээр мөн амарханаадаа гэж бодоод манаач энэ хашаанд л шороо нь пурхийх учиртай байж дээ хөөрхий юун чанга ойчиж намайгаа цочоовдоо гэж үглэсээр манааны байрандаа орж санаа амрав.

Өглөө ажил цугларах болж түрүүчийн хүн ирэх үед гадаа гарч харвал суман хүрэн явган хүний замын хашлага дээгүүр толгойгоо унжуулаад үхсэн байлаа. Шив шинэхэн цас орж цагаан даавуугаар бүтээсэн юм шиг түүнийг өнгөлөн хучжээ. Ажилдаа яарсан хүмүүс үйлдвэрийн хаалгаар хахан цацан орж ирлээ. Хүмүүс зам таглан үхсэн морийг тойрон гарах боловч залхуурсан буюу яарсан нэг нь толгой дээгүүр нь харайж, зарим нь нэг нь бүр гишгэн гарч байв. Тэдний ард тайван алхалж явсан өндөр нуруутай өвгөжөөр хүн гэнэт зог тусан,

-Юу вэ таминь, энэ чинь миний муу хүрэн морь байна шүү дээ. Суман хүрэн минь хэдийд үхчих вээ, хөөрхий зайлуул гэж харамсан өгүүлээд учиргүй гасалж, толгой дээрх цасыг нь ханцуйгаараа арчиж цэвэрлээд, дэлнээс нь чангааж хүмүүсийн замаас толгойгий нь зайлуулав.

Энэ үед нэг залуу хүн ирж,

-Гэлэгравдан гуай, таны муу хөгшин морь үхчихэж. Цаадуулдаа хэлж холдуулаарай. Үйлдвэрийн хашаанд үхсэн мал байлгаж болохгүй шүү дээ гэж албархуу царай гарган хоолойгоо зориуд шахаж ёсорхуу хэлэв. Гэлэгравдан яая даа гэсэн царайтай ийш тийш харснаа халаасаа суйлж модон иштэй том тонгорог гарган морины хүзүүний ширийг ярж бараг нүд ирмэх зуур аман хүзүүг нугалан толгойг нь огтолж салгаад,

-За би авдгаа авлаа. Үүнээс илүүг даах ч үгүй. Энэ амьтан байдаг чадлаараа адгуусныхаа хэрээс хэтэртэл манай үйлдвэрийн төлөө зүтгэсэн «Тэр ачийг нь бодож та нар үүнийг эндээс зайлуулчихна биз дээ» гээд суман хүрэнгийнхээ толгойг сугавчлан, гүн бодолд дарагдан алхаллаа.

ЦЭВЭЭНИЙ ЗАНДРАА

Зохиолч Ц. Зандраа 1919 онд Сэлэнгэ аймгийн нутагт төржээ. Бага дунд сургууль, багшийн их сургууль, ЗХУлсад киноны дээд сургууль төгсжээ.

Уран бүтээлээ 1936 оноос эхэлж «Гэм нь урдаа», «Манай аялгуу», «Шинэ жил» зэрэг уран сайхны кино болон «Эртний нутгийн солонго», «Миний Монгол» зэрэг олон тооны баримтат кино бүтээжээ.

ХӨЛСНИЙ ДУСАЛ

Зочид буудлын зоогийн танхимд хөл хөдөлгөөн багассан байв. Гэвч танхимын гол хэсэгт эгнүүлэн тавьсан хэдэн ширээнд хөдөө нутгаас ирсэн бололтой одон медалиудаа гялалзуулсан хижээл насны хүмүүс сууцгаана.

Зоог баригчид уван цуван босоцгоож байв. Зарим ширээ хоосорч аяга тавгийн дэргэд талхны үлдэгдэл үлдсэн харагдана. Хажуугийн ширээнд өвгөн Жигмэд хоёр нөхөртэйгөө юм ярилцан сууна. Жигмэд ярианы завсраар тэр хавьдаа үйрсэн талхны бутархайг нямбай цуглуулж хажуудаа байсан ам цаасан дээр овоолон сууна.

Нэгдүгээр хүн: Тэгээд манай нэгдэл энэ хавар төлөвлөгөөгөө нэлээд хэдэн төлөөр давуулах бололцоотой болоод байгаа шүү.

Хоёрдугаар хүн: Манайд тэжээл л мэднэ дээ.

Жигмэд: За ингээд явах уу даа гээд босов.

Энэ үед үйлчлэгч бололтой залуувгар хүүхэн дэргэдэх ширээн дээрх тамхины шилбэ, ам цаасны хог, талхны үлдэгдэл зүсэмүүдийг шалан дээр унагаан шүүрдэж эхлэв. Жигмэд түүнийг зэвүүрхэн харснаа,

-Үгүй хүү минь чи яаж байна?

үйлчлэгч эмэгтэй гайхасхийн ойролцоо байсан нөгөө үйлчлэгч рүү харж мишилзээд:

-Хог цэвэрлэж байна гэж инээвхийлэв.

Жигмэд: Наад талх чинь хог биш гэж талхны зүсмийг заав.

Үйлчлэгч: Энийг хэн идэх юм гэж хэгжүүрхэн хэлэв.

Жигмэд: Талх хэзээ ч хог болж байгаагүй тусад нь ялгаад хурааж болдоггүй юм уу гэж ширүүн хэлэв.

Үйлчлэгч: - (зэвүүцэн) Холихгүй гээд ямар би идэлтэй биш. Илүү үгтэй хөгшин бэ. Хэн болоод та хэнийг загнаж байна гэж шилбэлзсэнээ шалан дээрх ам хүрээгүй өдий төдий зүсэм талхнуудыг шүүрдсээр хогийн хувин руу тар тар хийж байв. Жигмэдийн царай хачин болж уур зэвүүцлээ эс барьж чадав бололтой үйлчлэгч эмэгтэйн мөрөн дээрээс татан хацрыг нь алгадаж орхив. Гэтэл үйлчлэгч дуу алдан гал тогооны өрөө рүү гүйв. Тэндээс нэг залуу үсрэн гарч ирээд өвгөнийг заамдан авав. Хүмүүс шуугилдан зарим нь залууг зарим нь өвгөнийг барьж авав. Өвгөн Жигмэд овойтол шүүрдсэн хогон дотроос талхны зүсэмүүдийг сагсайтал утган аваад:

-Харж байна уу? Ямар байна дээ, энэ чинь тэр хэвээрээ алт шүү дээ гэж үзүүлээд,

Энэ талхыг хүн хөлс, хүчээ шингээн явж буй болгосон юм гэж хэлэв.

Удалгүй сэргийлэгч ирэв.

Цагдаа: -Чимээгүй нөхөдөө. За та намайг дагаад ийшээ явна даа гэж Жигмэдэд тушаасан байртай хэлэв.

Зочид буудлын сэргийлэх хэсгийн өрөөнд залуу дэслэгчийн ширээний өмнө Жигжид сууна.

-Та томоотой хүн байж ийм буудлын газар зөрчил гаргаж ажлаа хийж яваа эмэгтэй хүний эрх чөлөөнд халдсан байна.

-Тэр миний буруу.

- Танай энэ хэрэг бага ч гэсэн та хэдий улсад олон жил ажилласан гавьяатай ч гэсэн бид хууль ёсоор л авч үзнэ дээ, Жигмэд:

- - Гэхдээ талх гэдгийг ойлгооч. Тэр хогтой хамт шүүрдэж байгаа нь дан талх шүү дээ. Цагдаа:

-Хүн идээд үлдээсэн юмыг яахыгаа тэд мэднэ шүү дээ. Манай буудлын үйлчлэгчид сайн ажилтай улс. Та тэдний дотоод хэрэгт оролцох хэрэг ердөө ч байхгүй. Жигмэд:

-Эндхийн дутагдлыг хэлж болохгүй юу. Цагдаа:

-Танаар хэлүүлж болно. Гэхдээ үздэг, хянадаг газартай удирдлагатай юм. Жигмэд:

-Сэргийлэхийн цагдаа хүн ийм ойлголттой байхаар яах ч юм билээ дээ. Цагдаа (уурлан)

-Та битгий хүн доромжлоод бай. Ингэж хандах юм бол бид бас өөрөөр ярина шүү. Таны үйлдсэн хэрэг эрүүгийн хуулийн зохих зүйл ангитай холбогдож байгааг ойлгож байна уу? Жигмэд:

-Шийтгэлээс айх юм алгаа. Гадаа байгаа хогийн савны дэргэдүүр хөглөрсөн талх бас энэ рестораны хог биз? Цагдаа бичингүүт:

-Та үнэмлэхээ үзүүлж байгаад манай ажлыг шалгаарай.

Жигмэд: - Мөн дөө. Та нар ганцхан үнэмлэх л гэж юмны учрыг олохын оронд ам тагладаг вий. Би чамаас хамаагүй залуу байхаасаа эхлээд талхны зовлонг үзсэн хүн гэв.

Энэ үед гаднаас хижээл насны хурандаа орж ирэв. Цагдаа үсрэн босч ёслоод хэрэг явдлыг тоочин танилцуулж рапорт өгөв. Дэд хурандаа холбогдох хүмүүсийг цөмийг нь дууд гэв. Цагдаа ёслоод гарч одов.

Дэд хурандаа: -Жигмэд гуай та аль аймаг вэ?

Жигмэд: Хэнтий аймаг.

Дэд хурандаа: - Аан та Чандаганы аж ахуйгаас ирэв үү?

Жигмид: Тэглээ.

Дэд хурандаа: Нэгдүгээр бригадын Далантайн Жигмэд, агрономич. 1978 оны хөдөлмөрийн аварга та мөн биз дээ? гэж инээв.

Жигмэд: -Нэг их агрономчсоод байх юу байхав, тариачин хүн л дээ. Бүх насаараа хөрсний шим өнгө дагаж газар үнэрлэж явсан хүн дээ. Миний аав Далантай гэдэг янхигар хөх өвгөн тохмын чинээ газар дээрээ модон анжсаа үүрч ирээд, хайнагийн шар хөллөн газар хагалж тариа тарьж чармай нүцгэн цэлдэн хөх арван нэгэн хүүхдээ тэжээж хөлийг нь дөрөөнд гарыг нь ганзаганд хүргэсэн юм. Би тэгэхэд шилбүүр барин хайнагийн шарын хойноос дагаж явсаар энэ талх хаанаас яаж ургадгийг биеэр амсаж, үнэ цэнийг нь мэддэг болсон юм. Аав бид хоёр ажлаа зогсоож чилээгээ гаргах, хайрсан гамбираа идэх гэж өнчин хайлаасны сүүдэрт суухдаа аав минь нарийны голын хужаанууд шуудууны маань усыг боочихгүй бол миний хэдэн хүүхдүүд ирэх өвөл хоолтой гэдэгсэн. Гэтэл удсан ч үгүй тариан талбайн хажуугаар урссан нарийхан шуудууны ус татарсаар бүр хуурай болоход хүрэв. Аав минь түүнийг хараад нүүрний гүн үрчлээсний завсраар нүдний нь нулимс татарч байгаа шуудууны урсгал шиг салаалан бөмбөрч, далай данжаадын хужаа нар усаа харамлаж байна. Одоо яана даа, тэр хоёр талбайг услахгүй бол оройтно гэв. Тэгснээ аавын нүд гялалзаж хүрзээ бариад бослоо. Би учрыг дорхноо ойлгож аавыгаа хориглож гарав.

-Ааваа боль, тэдэнтэй зодолдоод дэмий шүү дээ, тэд чинь олуулаа гэв. Аав миний энэ үгийг сонсох янзгүй шуудуу боож байгаа тариачин хужаануудын зүг шууд явлаа. Би ээждээ хэлэх гэж гэр лүүгээ харайлаа. Буцаж ирэхэд аав шуудууны захад хоёр гурван хужаатай хүрзээрээ зодолдож байв. Би яахав нүүрээ халтар болтол уйлчихсан нэг муу жаал юу хийж чадах билээ. Дэмий л «Ааваа, ааваа» гэж орилохоос цаашгүй. Гэтэл нэг нь аавын хүрзийг гараас нь алдуулаад цавчих гээд далайхаар нь би байдаг тэнхээгээрээ чанга орилоход хужаа намайг хараад гараа татан зогсоход аав:

-Чи намайг алах ч яахав. Хэдэн хүүхдийг минь яая гэх бодож байна. Бас хөнөөх санаа байна уу, хаашдаа өлбөрч байгаа юм гэв. Хужаа алмайран гайхаж зогсоно. Хужаа:

-За больё. Чи бид хоёр адилхан өлбөрч байж хэн хэнийгээ алах билээ гэж этгээд хазгай аялгаар хэлээд:

-За наад усаа орой болтол ав, харин өөрөө энд зогсоно шүү. Далайн данжаад үзэгдвэл өөрийнхөө шуудууг бушуухан хаагаарай гээд хүрзээ үүрэн явцгаав. Аав намайг тэвэрч, үртэй хүн сайхан юм гээд үнсэж билээ. Иймэрхүү зодоон нүдээн ч зөндөө л байдаг билээ. Тэр үедээ энэ бол ердийн явдал байсан юм даа. Арай гэж ургуулснаа гараараа хадаж сарлагаар гишгүүлэн цайруулж хэдэн хүүхдээ тэжээх гэсэн жаахан будаагийн маань долоон тамгын тогоогоор хэмжээд аваад явчих нь даанч хэцүү даанч харамсалтай байж билээ. Ингэж тариа будаатай ноцолддог хүн тэр үед хуруу даран тоолохоор цөөхөн байлаа... гэж ярьж байтал залуу цагдаа өндөлзөн босож:

-Даргаа би хотын сэргийлэх рүү явах уу даа, өнөөх асуудал? гэж нам дуугаар хэлэв. Дэд

хурандаа:

-Хүлээж бай энэ хүний яриаг сонс, чамд хэрэгтэй шүү. Жигмэд яриагаа үргэлжлүүлэн:

-Атрыг эзэмшихэд бид бас зүгээр очоод эзэмшээгүй юм шүү, мянган бэрхшээл түмэн саадыг давж явж эзэмшсэн юм. Атар гэдэг чинь эзгүй хоосон тал газар шүү дээ. Үүнийг эзэмшинэ гэдэг энэ сайхан хялгана өвсөөр халиурсан хивс, шиг талыг хага зүснэ гэсэн үг. Энд сургууль, клуб, улаан булан, хоршоо байгуулж хүний хэрэгцээтэй юм болгоныг буй болгоно. Дөрвөн зүг найман зовхисоос олон аавын хөвгүүд охид цугларна. Тэд энд шинэ амьдралаа зохиосон юм. Манайд Бавуужав гэж ажил амьдралын халуун чулуу долоосон сайн дарга байж билээ. Тэр маань хэлдэгсэн:

-Манай тариачид дан залуучууд. Залуу хүн нойр ихтэй байдаг. Шөнийн ээлжинд нойрмоглож явж элдэв явдалд гарчих вий, зохион байгуулалтаа сайн хийх хэрэгтэй. Үргэлж эргэж тойрч байх хэрэгтэй гэдэгсэн. Нээрэн ч тийм явдал гардаг л байлаа. Манайд Содном гэж залуу тракторч байлаа. Шөнө явж байгаад нойрмоглоод урдаа явсан тракторын хойноос очиж анжсан дээр нь трактораа мордуулаад хамаг юмаа эвдэж билээ. Иймэрхүү явдал гараад байхад нь зохион байгуулалтаа өөрчилж тракторчдыг мөр даруулан явуулдгийг болиулж зайтай, зайтай зэрэгцүүлэн явуулдаг боллоо.

Тэгсэн нэг ийм явдал боллоо. Тэр жил Эмгэнтийн хөндий тэр аяараа нижигнэж байлаа. Би тракторуудаа эргэн, шогшуулж явтал талбайн захад нэг трактор зогсоод байдаг. Хүрээд очсон чинь нэгдүгээр бригадын Бужгар Очир гэдэг залуу мотор дороосоо хар тарлан нүүрээ гаргаж цав цагаан шүдээ яралзуулан инээгээд:

-Онцын юм болоогүй зүгээр Жигмэд гуай. Зоволтгүй би зүгээр карбюратораа цэвэрлэсэн юм аа гэв. Гэтэл Очирын бужгар үс нь цантаж бууралтан дэрийтэл хөлджээ. Би дэвтрээ гаргаж тэмдэглэлээ харсан чинь сүүлийн долоо хоногийн норм нь хэдийн биелсэн байлаа. Жигмэд:

-Ажлын бүтээл дээгүүр байна шүү дээ, чи одоо явж амраач, биеэ дэндүүлж болохгүй шүү гэлээ. Очир:

Зүгээр, одоо хөдөллөө. Энүүхэн хэсэг газрыг дуусгаадхая гээд тэр дороо трактораа асааж хөдөлсөн юм. Би ч өөр талбай руу шогшуулахдаа залуу насаа гэж юм бүхнийг давж гарна гэж бодох нь сайхан юм даа гэж залуу нөхрөө хайрлаж билээ. Тэгээд талбайнуудаа эргэж тойрсоор яваад орой буцаж ирсэн чинь гэр майхнуудын дэргэдүүр амьтан хүн бужигналдаад нэг л өөр болчихсон байв.

Холоос бараа хараад сэтгэл түгшиж мориндоо ташуур өгч шалавхан ирсэн чинь уйлаан майлаантай, зарим нь инээдтэй байцгаалаа. Бужгар Очир дунд нь хувхай царайлаад зогсож байв. Тэгсэн чинь ийм юм болжээ. Оройхон хоол болж газар зуухны дэргэд хүмүүс цугларан хоол цай болж жижүүрийн тогооч хүүхнүүд тогоо шанагаа хангинуулан хоол цай аягалж байж. Гэтэл алсаас тракторын дуу гарч нэг трактор айсуй гэнэ шүү. Зарим нь

-Бужгар ах маань ч ирлээ дээ, манай Долгорсүрэнгийн харц өөр болоод ирэх нь тэр гэж тоглоом тохуу хийж, Долгорсүрэн ичсэн нүүрээ хийх газраа олж ядан байж гэнэ. Гэтэл

трактор ойртон ойртсоор байлаа. Хүмүүс мань Бужгар Долгорсүрэнтэйгээ золгох гэж сүр далайлгаж явна гэлцэнэ. Тэгсэн харин Очирын трактор гал тогоо, зуух, тогоотой хоол, 40 литрийн бидон цөмийг нь дайраад өнгөрч гэнэ. Харин тэнд байсан хүмүүс тракторын араас хөөж урт модоор кабины нь балбаж байж сая нэг нойрноос нь сэрээн зогсоож гэнэ. Тэгсэн Бужгар маань мотороо ухаж байж даараад дараа нь трактораа чиглүүлэн тавьчихаад явж байтал халуун мотороосоо дулаацаад унтаж орхихгүй юу. Удирдаж байгаа, удирдуулж байгаа аль нь ч туршлага үгүйлэгдэж байсан биз. Иймэрхүү явдал болдог байлаа. Атар биднийг мөн ч их юманд сургасан даа. Одоо энэ танай хогтой холиод байгаа цагаан талхны гурилыг тариа будаанаас ялгаж авдаг юм. Тэгэхээр нэг зүсэм талханд хичнээн олон цагийн хөдөлмөр зарцуулсан нь мэдээж шүү дээ. Тариа будааны зовлонг мэддэг хүн талхны хэрчим өдий төдийгөөр үрэгдэж байгааг харахад сэтгэл хачин болох юм байна шүү дээ гэхэд дэд хурандаа:

-Жигмэд гуай та, манай рестораны нийт хүмүүст энийгээ ярьж өгөхгүй юу, маш хэрэгтэй байна гэв. Жигмэд:

-Өө тэр бололгүй яахав. Цаг минутаа л тохиръё. Би тариа будааныхаа л амьдралыг ярина шүү дээ. Өөр мэдэх юм байхгүй. Дэд хурандаа:

-Тэгэлгүй яахав. За Цэрэнлхам аа. Чи чи ахмад хүнтэй хэг ёг буруу харьцсан байна. Юу гэж бодож байна. Алгадуулсандаа гомдолтой юу. Цэрэнлхам:

-Тийм ээ, миний буруу. Одоо бодоход эцэгтээ л алгадуулсан юм шиг сайхан санагдаж байна. Юуны гомдол байх вэ гээд ичсэндээ доошоо харж харин би Жигмэд гуайгаас уучлал гуйя гэхэд Жигмэд баярлахдаа сандран:

-Чи ууртай хөгшин ахыгаа бас уучлаарай! Гэв.

ЧАДРААВАЛЫН ЛОДОЙДАМБА

Нэрт зохиолч Ч. Лодойдамба 1917 онд ГовьАлтай аймгийн Түмэн сумын нутагт малчны гэрт төржээ. Бага наснаасаа сургууль соёлын мөр хөөж, 1954 онд МУИС төгсөж улмаар ЗХУ-д аспирантурт суралцан урлаг судлалын ухааны дэд эрдэмтэний зэрэг хамгаалжээ.

Уран бүтээлээ 1940 оноос эхэлж «Алтай», «Тунгалаг тамир» роман, «Манай сургуулийнхан» тууж, «Малгайтай чоно», «Солонго», «Дусал нулимс юу гэж хэлсэн бол» зэрэг олон арван шилдэг өгүүллэг бичсэний гадна «Гарын таван хуруу», «Өөрийн замаар», «Итгэж болно» драмын жүжиг, «Энэ хүүхнүүд үү» кино зохиол бичжээ.

Зохиолчийн «Тунгалаг тамир» «Алтайд» роман Орос, Чех, Румын, Болгар, Вьетнам, Япон зэрэг хэлнээ хэвлэгджээ.

Ч. Лодойдамба БНМАУ-ын төрийн шагналыг хоёр удаа хүртжээ.

ГЭРЭЭСЛЭЛ

Өнгөрсөн зун би Архангай аймагт байдаг авга ахындаа амарч билээ. Тэдний айлыг Юндэнгийнх гэдэг. Манай ахынхтай нийлж нэгдлийн мянга шахам хонь хариулдаг байлаа. Юндэнгийнх уул нь манай нутгийнх биш. Хожим намайг сургуулийн мөр хөөж гарснаас хойш цагаачлан иржээ. Хүүхдүүд нь тус бүр айл болоод өөр нутагт байдаг ба эх нь Ханд гэгч ная гаруй настай эмгэн хамт амьдардаг байв.

Ханд гуай шиг өндөр настай эмгэд олон үгтэй, ярианд дуртай байдаг. Ялангуяа хуучны юм залуугийн явдлыг нь асуувал цэцэглэж явсан ид сайхан насаа бодож сэтгэл санаа нь сэргэн яриа нь төгсгөлгүй болдог шүү дээ. Харин Ханд гуай бол тийм биш ажээ.

Амарч байхдаа ганц өгүүллэгийн материал олж авья гэж бодоод Ханд гуайтай хэд дахин ярих гэж оролдоод чадсангүй. Энэ тухайгаа Юндэн гуайд гомдон хэлэхэд «Манай ээж урьдах явдлаа ярих тун дургүй. Би хүү нь гэхэд уг нутаг гарал үүслийг нь мэдэхгүй. Эцэг минь ямар хүн байсныг ч ярьж өгөөгүй. Тэгээд би чинь Хандын Юндэн гэж эхээрээ овоглодог хүн шүү дээ гэжээ.

Ханд гуайгаас юм сонсох хүсэл надад их байлаа. Энэ эмгэний түмэн үрчлээс болсон гонзгой бор нүүр, илч гал нь бараг алга болсон цийлэм нүдний цаана урт удаан амьдралын сонин хачин юм нуугдаж байгаа нь тодорхой. Энэ том цоожтой хаалганы цаана мөн ч их юм буй даа. Гэвч нээх арга нь даанч олдохгүй болохоор яая гэх билээ дээ. Амралт минь дуусч явахаар бэлтгэж байтал Ханд авгай орж ирээд бэргэний хийж барьсан цайг ууж хэсэг дуугүй сууснаа:

- Хүү минь чамайг юм бичдэг гэлцэх юм. Үнэн үү? Гэж асуув.

-Тийм ээ. Би зохиолч хүн бас сонины газар ажилтай гээд л өөрийнхөө тухай товч ярьж өглөө. Ханд гуайн асуултыг сонсоод над сонин юм сонсох үлэмж горьдлого буй болсон билээ. Гэтэл дуугардаггүй. Доош харан цай ууж дууссан шаазангийнхаа хээг үзэж байлаа. Энэ үед түүний нүүр харагдсангүй. Гэвч тэр хээг анхааран сонирхож байгаа биш гэдгийг би мэдэж байв. Учир нь дотоод сэтгэлийн гүн бодолд дарагдаад сууж байгаа хүний нүүр нүд далд байвч судас амьсгаа дотор нь болж байгаа их зүйлийг илтгэх ёс бий. Ханд гуайн судас нь гүрвэлзэн, чичирч, хааяа хааяа дотроо гүн санаа алдаж байлаа. Тэгээд над руу үлэмж зөөлөн нүдээр харснаа «Хүү минь манайд ор. Эмээ нь цай чанасан юмсан» гээд босов. Би түргэн босож гэрт нь орлоо. Бүр олбог засжээ. Суумагц аагтай давстай, тос даасан шаргал цай өгч, хуруу зузаан өрөм, бэлцийсэн цагаан ааруул өмнө минь тавив. Идэж ууж байтал эмээ над руу ширтэн хэсэг ажсанаа урт гэгч нь санаа алдаад «Эмээ нь хүүдээ нэг юм яривал чи олон хүнд хэлж өгч чадах уу? Үнэн зөвөөр нь бичээд л сониндоо хэвлүүлж болохсон болов уу гэж байгаа юм шүү дээ» гэлээ.

-Чадалгүй яахав, эмээ минь. Энэ чинь миний хийдэг ажил.

-Эмээ нь нас өндөр болж удахгүй энэ хорвоогоос салан, эсгий гэрээс гарч хээрийн гэртээ очих цаг ойртлоо. Залуу хүмүүст хэлмээр юм байна. Би арван найман настай байхдаа сэтгэлдээ хүнд шарх олсон юм. Тэр шарх эдгэрээгүй. Эдгэрэх ч үгүй гээд дуу нь тасарч доош харахад хэд хэдэн том нулимс тасран унав. Би гайхан харсаар л Ханд гуай алгуураар

толгойгоо өргөж намайг эргэж харлаа. Усан хөшиг татсан нүд нь чичирч байгаа уруулд мухардсан гэмшил дүүрэн. Дотно хайрт хүнээ нас барахад нь очиж чадаагүй хүн «Амьсгал нь тасрахад байж чадсангүй ээ. Халаг» гээд толгойгоо нүдэх гэж байгаа хүнийг харсан бол Ханд гуай яг л тийм байлаа. Хаанд гуай гарынхаа араар нулимсаа арчиж сэтгэл нь шулуудсан бололтой займчин суудлаа зассанаа зэвхий бөгөөд шийдэмгий дуугаар «Би залуудаа нутаг хошуундаа гайхагдсан сайхан хүн байсан юмсан. Чи ч үнэмшихгүй байх даа. Гэвч тийм л байсан» гээд арга нь барагдсан нүдээр намайг харлаа. Үнэндээ ч өмнө минь сууж байгаа эмгэн олонд гайхагдсан сайхан хүүхэн байсан гэхэд үнэмших юм тун ховор бөгөөд гагцхүү жар гаруй жилийн өмнөхөө ярьж байгаа шүү дээ гэж ухаан санаандаа бодож сэтгэлээ хүчлэн үнэмшүүлэхийг хичээж байлаа. Эмээгийн нүдэнд сэтгэлийн гүний баярын оч гялсхийж өчүүхэн мишээл жавьжинд нь тодрох мэт «Манайх үргэлж л Жамбал гэдэг айлтай хамт байдаг байлаа. Тэдний ганц хүү Юндэн бол надаас гурав ах. Бид хоёр хар бага наснаасаа хамт тоглож өсөөд намайг арван зургаан нас хүрэхэд Юндэнгийн зан нэг л биш болоод хувирав. Тэр яавал л надад сайн юм хийх хүсэлтэй. Миний юу л хэлснээс зөрдөггүй болов. Хүн өнгөрсөн юмыг эргэцүүлэн бодоход тэр үед огт ажиглагдаагүй юм тодрон учир нь олодоогүй юмын учир олддог шүү дээ. Ялангуяа сэтгэлд гүн үлдсэн юмыг эргэцүүлэн бодоход харамсах, баясах зүйл мөн ч их гардаг ажээ. Юндэнгийн зан мөн ч өөр болж билээ. Юндэнгийн алхам бүр, хөдлөх бүрээс над хязгааргүй сэтгэлтэй нь илэрхий байж л дээ. Заяагүй хүний хөлд нь эмбүү тавихад дээгүүр нь сохор хүн болж нүдээ аниад гарсан гэдэг. Би Юндэнгийн тэр сайхан сэтгэлийг олж харахгүй байлаа. Түүнийг багаасаа тоглож өссөн сайн нөхөр минь гэж бодохоос түүнд хайр сэтгэл надад байсангүй. Намайг хүсэж мөрөөдсөн улс ёстой л захаас аваад байдаг байв даа. Гаднаас харвал Юндэнд гойд юмгүй. Ялангуяа олон хүний нүд булаасан залуугийн цагт бол шохоорхож хармаар юм түүнд байгаагүй. Жижигхэн биетэй, хонин бор нүдтэй гонзгой царайтай. Эцэг нь багад нь миний өөдөс гэж өхөөрдөн нэрлэснээс аав ээж нь Өөдөс гэж дуудна. Харин сүүлдээ Юндэн уцаарлаж байгаад болиулсан юмсан. Миний дэргэд Өөдөс гэж хэлүүлэх тун дургүй сэн. Гэвч дотор нь уу, ёстой л хүн байсан юм сан. Хүний сайхан дотроо нууц байдаг болохоор олж харахад тун хэцүү. Амьдралын эгзэг таниагүй залуугийн цагт бол бүр ч хэцүү.

Хүүхэнтэй айлд хүн цугладаг. Хүрдтэй айлд буян цуглардаг гэгчээр нутгийн харцуул манайд цугларна. Би тэдний дунд барьцгүй хөвнө. Тэдэнтэй цэц булаалдаж үг хаялцаж байхыг хараад Юндэн бухимдаж ууртай болдог байсан. Гэвч би түүнд нь огт юм бодохгүй. Харин ч инээд хүрдэг байсан билээ гээд эмгэний хоолой зангирахад дуу нь тасрав. Эмээ хэсэг дуугүй байснаа урт гэгч санаа алдаад толгойгоо хэдэн удаа сэжилснээ Нэг өдөр Юндэн хамт хот арилгаж байгаад «Хоёулаа сууж хамт амьдаръя. Ханд минь чамдаа би хязгааргүй дасжээ» гэж палхийтэл шууд хэлдэг байна шүү гээд эмгэн инээмсэглэх мэт болсноо, ер нь Юндэн бүрэг мэт боловч бодсоноо эв хавгүй цөл цал гэтэл цөмийг хэлдэг хүн байсан юмсан. Нэг өдөр манай үнээ тугал нийлж орхиод намайг ээж минь загнаж байхад Юндэн дув дуугүй зогсож байснаа «Дулмаа гуай минь. (Дулмаа гэдэг чинь манай ээжийн нэр) Тугал эхтэйгээ нийлээ л биз. Цайны сүүгүй бол манайхаас ав. Хандыг хичнээн аашлаад тэр хөхсөн сүүг та олж авахгүй гэж билээ» гээд Ханд гуай үгээ таслав. Ханд гуайн нүд нь сэргэж тод инээмсэглэл нүүрэнд тодров. Чухам энэ үед «Үнэхээр залуудаа сайхан хүүхэн байсан болов уу?» гэдэг зурвас бодол маний сэтгэлд орж ирлээ.

«Би Юндэнгийн үгийг юмны чинээ ч бодолгүй тоглоом болгож өнгөрүүлэв» гэж хэлэхэд

Ханд гуайн нүүрэнд тодорсон баясгалан хусагдан алга болов. Нэгэн хэсэг чимээгүй болов. Би чингээд гэж ярианы үргэлжлэлийг хүсмээр байсан авч «Арай ингээд зогсохгүй байх» гэж горьдоод тэсэв. Үнэхээр Ханд гуай бүдэг дуугаар «Тэр үед би нутгийн Гончиг гэдэг залуутай сэтгэлтэй болоод нууц уулздаг байсан. Намрын үдэш юмсан. Хонь хотолж байгаад Юндэн урьдахаа давгаж хэлэхэд нь би тэр яриаг займруулах гэж «Чи ганцаараа гучин тэмээгээр Хүрээ жин тээж чадах уу» гэлээ.

-Чингэвэл чи баярлах уу гэж асуув.

-Эр чадалтай ажилч хүнийг хараад хэн ч баярлана шүү дээ гэв. Ингэж ярьснаас хойш удалгүй Юндэн айлын гучин тэмээг хөлсөлж аваад ганцаараа хүрээн жинд явчихлаа. Би юу хэлснээ ор сураггүй мартчихаад «Энэ хүйтэнд гучин тэмээгээр ганцаараа явдаг бас онгиргон амьтан юм даа.

Нүд улаан, мөнгө цагаан л гэдэг болж байна. Амиа алдах гэж байгаа юм» гэж Гончигийн шоолон инээхэд хамт инээж байж билээ гээд эмгэний хоолойноос хачин авай гарсанаа зангираад тагжрав. Эмгэн тулганы захын үнсийг мойног болсон бор хуруугаараа оролдож газар ширтэн дорой дуугаар Намайг арваад айлынх хүүдээн гуйхад аав ээж өгөхгүй байлаа. Гэтэл хошуу ноёны хүүд гуйхад ухаан жолоогүй баярлан зөвшөөрөв. Би очихгүй гэж уйлан хайлан гуйсан. Огт тус болсонгүй. Энэ бүхнээ Гончигт хэлж даруй түргэн оргож зайлая гэлээ.

-Бид хоёр оргоод хаа зайлъя вэ?

-Оргохгүй бол өнгөрлөө. Чи ойлгож байна уу?

-Орон гэр мал хөрөнгөө хаяад хүний нутаг, гүний газар яаж амьдрах юм бэ?

-Хайр сэтгэл залуу нас байна. Яагаад ч болсон амьдарна. Эндээс зайлъя.

Гончиг эхлээд оргохыг зөвшөөрөхгүй байлаа. Гэвч би уйлж уурлан эцэст нь боож үхнэ гэж баймаажин оргох болоод өдөр цаг болзоод яг явах дээрээ дургүйд хүчгүй гэгчээр баригдаж Гончиг хүний хүүхнийг эцэг эхийн зөвшөөрөлгүй оргуулах гэсэн хэрэгт орж хошууны хар гэрт хоригдов. Би ч чанд хараанд орж гэрээс дагалтгүй гарахаа болив. Мордуулах хоног ойртсоор л байлаа. Нэг өдөр Юндэн жинтэйгээ ирээд гэртээ ч орсонгүй хотны хажууд зогсож байсан надтай уулзан шууд л өврөөсөө бор цаасанд боосон мөсөн чихэр гаргаж өгөв. Харвал хоёр хацар хамрын үзүүр нь хөлдөж барзайн шархалсан байлаа.

-За би гучин тэмээгээр ганцаараа жин тээвэрлээд ирлээ. Чи баярлаж байна уу? гэж нүдэнд нь гал гялалзан бахдаж ядсан баяртай хэлэв.

-Иш Юндэн минь би гэдэг хүн түмэн зовлонд учраад байна гээд бүх болсон юмаа ярилаа. Юндэнгийн баяр бахдал бялхан гэрэлтэж байсан царай нь барайн, гялалзан байсан нүд нь бүдэг мохоо болсон юмдаг.

-Хандаа «чи Гончигоос өөр хүнд сэтгэлгүй юү?» гэж намуу дорой дуугаар асуув.

-Үгүй. Гончигоос бусад хүн над огт хэрэггүй. Би яасан заяагүй амьтан бэ? Гээд уйлав.

Юндэн арга нь барагдан хэсэг зогссоноо «Хандаа. Уйлаад яах вэ. Би» гээд үгээ тасалж над руу удтал ширтэв. Хойно бодоход тэр нүдэнд мөн ч их юм байж билээ гээд эмгэн над өөд арчаагүй нүдээр харснаа үргэлжлүүлэн- Энэ үед эх нь бидний дэргэд ирж «Та хоёр сүүлд ярь даа. Миний хүү халуун цай уу, Иш энэ хацар, хамар нь» гээд Юндэнг аваад явлаа. Хэд хоног Юндэн надтай уулзсангүй. Зайлаад л байлаа. Жинд явж олсон мөнгөөрөө хоёр сайн морь худалдаж авлаа. Нөгөөдөр намайг мордуулна гэж юм бэлтгэж байв. Нэг орой тугал уяж байхад Юндэн дэргэд минь ирж «Чи Гончиг үгүй бол үхнэ гэдэг чинь үнэн үү?» гэж шивнэн асуув.

-Өөр би яахав дээ гээд уйлав.

-Чи надтай оргохгүй юу. Би чамд мөн ч сэтгэлтэй дээ.

-Гончиггүй бол би хаашаа ч явахгүй. Мордуулах болбол энэ хойт хадан дээрээс үсэрч үхнэ гэлээ. Юндэн гарыг минь чанга гэгч барьж урт бөгөөд тасалдуулан санаа алдаад «Маргааш орой сэрэмжтэй байгаарай» гээд шууд эргэв. Юу болохыг мэдсэнгүй. Маргааш нь орой болов. Юу ч болсонгүй унтахаар хэвтэв. Гэвч нойр хүрсэнгүй. Чимээ чагнан сэтгэлд минь ямар нэгэн горьдлогын зул асаж хэвтэн байтал гэрийн ард нэг л ер бусын чимээ гарлаа. Би хэвтээгээрээ шахам хувцаслаж гарах гэтэл хүмүүс сэрэв. Би ч үсрэн гарлаа. Хүмүүс ч босоцгоов. Гэрийн хойно очвол эмээлтэй хоёр бараан морьтой хүн зогсож байлаа.

-За бушуухан морд. Баригдвал баларна шүү. Хойноос буутай хуягууд нэхэж байгаа гэсэн Гончигийн дууг таниад шууд мордлоо. Гэрээс хүмүүс шуугилдан гарахад бид хоёр морины хурдаар давхиж байлаа. Тэр морьдын хурдан гэдэг нь. Гончиг түрүүлэн, би дагаад юм ярих чөлөө завгүй довтолгов. Хойноос чимээ гарсангүй. Үүр цайхад мэдэхгүй газар ирсэн байлаа. Арав гаруй хоног явж хошуу алгасаад харь нутагт очиж айлын мал хариулан амьдрал гээд эмээ дуугаа хурааж хэсэг болсноо уйлж тасалдсан дуугаар Гончигийг хар гэрээс ордуулж хуягийн буудсан суманд өртөгдөн амь нь гарахдаа «Хандад би оломгүй сэтгэлтэй юмсан. Миний хоёр морь та хоёрыг жаргалд хүргэг. Бушуухан яв» гэж Юндэн хэлээд амьсгал хураасан гэдэг гээд Ханд гуай дуугүй болов. Бүх бие нь салганан шанааны нь арьс татвалзана. Нэлээд удсаны дараа нам бөгөөд сэтгэлийн гүн тослог дуугаар «Хүү минь би сайхан сэтгэлийн их хайрыг амсаж эдэлж чадах хүн байсан юмсан. Гэвч түүнийг харж чадаагүй хажуугаар нь өнгөрсөн. Тэр их сэтгэлээс үлдсэн юм гэвэл шаналж харамссан бухимдал Юндэнгийн нэрийг өгсөн хүү хоёр л байна гээд дуугаа таслахад эмгэний нүднээс бөөн бөөн нулимс тасран хацрынх нь үрчлээг дагаж урсахад жавьжаараа шимэн залгиж байлаа. Би Гончигийн тухай асуумаар байсан авч нэг л асуух зүрх хүрсэнгүй. Бас л Ханд гуайн сэтгэлийн гаслан над аяндаа дамжиж дотор минь нэг л эвгүй болов. Гэтэл Ханд гуай шийдэмгий зэвхий дуугаар «Жил болоод хэвлийд минь хүүхэд буй болов. Гэтэл Гончигийн зан хувирч малыг нь хариулж байсан айлын буцмал хүүхэнтэй сэтгэлтэй болоод удалгүй тэднийд хүргэн орлоо» гэхэд «Ямар муухай хүн бэ» гэж өөрийн эрхгүй дуу алдав.

-Иш хүү минь муухай юу байхав дээ. Юндэнгийн сэтгэлийг түүнээс болгосон шүү дээ. Бүхэл насандаа гэмшиж Юндэнг бодож, Юндэнг харж зүүдэндээ түүнтэй ярьж явлаа. Сайхан хайр байдаг юм шүү. Олбол гагцхүү алдаж л болохгүй. Хүний сайхан дотроо нууц байдаг юм даа. Хүү минь чи миний энэ ярьсныг заавал сонинд бичээрэй. Амьдралын замд гарч яваа залуу

хүмүүст хэрэг болж магад Энэ бол миний хүнд хэлж өгөх гэсэн амьдралаас үлдсэн ганц зүйл байгаа юм гээд шавхийтэл босож шууд гарсан юм. Тэр орой Ханд гуайн бие муудаж хүү нь эмчид явж бид тэдний гэрт цугларав. Ханд гуайн царайнд хөнгөн мишээл тодроод үг хэлэх гэснээ хоёр дахин эвгүй зогисоод «Юндэн минь» гээд талийгаач болсон билээ. Би Ханд гуайн ярьсныг нэмээгүй бас хасаагүй. Үнэхээр ч амьдралын замд гарч яваа залуу хүмүүст «Сайхан хайр байдаг юм шүү. Олбол алдаж болохгүй» гэсэн Ханд гуайн үг чухлаас чухал зүйл биз ээ.

ШАРГАЧИН

Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гараад хэдхэн хоносон цайвар цагаан янзага дагуулсан шаргачин орж ирлээ. Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг матран явахад нь эх нь тал бүр сэрвэлзэн өчүүхэн чимээг ч сэрэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг «Юу вэ. Яах гэж байна» гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа. Уураг нь дуусаагүй өег сүүндээ гэдэс нь цадсанаас ч юм уу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юм уу? Аль зуу зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу? Бүү мэд. Юу ч гэсэн дэрсэнд орсны дараа удалгүй янзага нь нуугдан унтав.

Ер нь шаргачин өдрийн цагт нялх янзагаа бут буюу дэрсэнд хяруулж нуугаад өөрөө шинэхэн ургасан ногоо чимхлэн иддэг. Энэ үед ямар нэгэн аюул ирвэл хурдан хөлийн хүчээр дагуулан зугтаж төөрүүлээд эргэж ирхэд, унтаж хоцорсон үрдээ аюулыг зайлуулсан баярт уулзалтаар цэцэглэсэн амьдралаар амтлагдсан сүүгээ өгдөг. Янзагаа нуусны дараа шаргачин зүг бүр гоо чихээ соотгонуулан дээр дээр үсрэн тоглодог. Энэ үед нь түүнийг бүжигчин хүн харвал уран хөдөлгөөний хуримтлал болсон гоёмсог хөдлөлийг тусган авах нь дамжиггүй билээ. Нөгөө шаргачин цовхрон харайлан дэгдэж хэсэг тоглоод хурц үнэр нь хамар руу цоргисон соёолж байгаа нялх тааныг амтархан идэв. Гэтэл шаргачны хажуугаар гарсан замаар жолоочоос гадна гурван зугаалагч суусан машин тоос манаруулан давхиж ирлээ. Хурдлан яваа машин дотор архины эхүүн үнэр, тамхины гашуун утаатай холилдон ханхалж, жолоочийн ар талд суусан хүнээс бусад нь нэлээд согтсон тул нүд нь чиглэсэн юмгүй гөлөлзөн эргэлзэж толгой нь моторын жигд ажиллагаатай цохилт нийлүүлэх гэсэн юм шиг хаялан ганхаж явлаа. Хэрэв жолоочийн хажууд суугч тамхиа ноцоох хэрэг гараагүй бол шаргачин эх үр хоёр гашуун зовлонд учралгүй өнгөрч болох байсан билээ. Гэтэл тамхиа ноцоолгох гэж жолооч руу эгцлэн харсан нүдний нь үзүүрт талд идэж байгаа ганц шаргачин харагдав.

-Зээр гэж хашгирахад яг хойно нь суугч ухасхийн

-Хаана? гэж хариу хашгираад нойрмог нүдээр тал бүхэн рүүгээ харлаа.

-Янзагатай шаргачин бололтой. Тэгээд өдийд цаазалсан шүү дээ гэж жолоочийн ард суугч хэлэв.

-Зугаалж яваа бидэнд ямар хамаатай юм бэ. Буудаж л байвал барав. За бэлтгээрэй гэж жолооч нь хэлээд машинаа эргүүлж чимээнээс цочин сэрэмжилсэн шаргачны зүг хурдлан давхилаа.

-Хууль биелүүлэхийн тулд гарсан хуулийг харин биелүүлэхгүй бол хариуцлага байдаг шүү дээ гэж жолоочийн ард суугч хэлсэнд

-За энэ чинь хууль хамгаалагч гарав бололтой гэж жолоочийн хажууд суугч хэлээд их хөгжилтэй инээснээ.

-За хөөгөөд гэж хэлэв. Уул талд нь янзага нь унтаж байгаа тул ирж байгаа аюулыг холдуулан зайлуулах гэж шаргачин өргөн цагаан тал руу дэгдэн үсэрч гоо чихээ босгон солбиж цойлон

давхив.

Цонхоор нь буунууд шоролзон гарсан машин, зээрийн хойноос байдаг хурдаар довтлон ирлээ. Хурдан хөлдөө гүн итгэсэн шаргачин дүүлж дөрвөн хөл нь газар хүрч байгаа эсэх нь үл мэдэгдэн хурдлав. Гэвч энэ удаа түүний хойноос эцэстээ эцдэг булчин шөрмөстэй амьтан хөөж байгаа биш эцэх цуцахыг үл мэдэх хурдан хөлөг унаж будаан сумаар зэвсэглээд гүйцэгдэхгүй зовоон зугтаж байгаа зээрийг юу болсон ч алах ангийн шунал оргилсон дайсан мөрдөж яваа тул хэдий хүч тавин хурдлавч холдож хоцрохгүй харин улам ойртов.

Буу зогсолтгүй шахам нижигнэж машины дохио чимээ үргэлжлэн дуугарч шаргачны үсрэн цойлох нь ховордон цэлмэг нүд нь бүлтэгнэн манантаж босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа. Машин дотроос «хар барам чинь оногдохгүй нь. ёо ёо ямар их донсолдог юм бэ. Толгой хагалчих нь, аль вэ сум аваад аль. Өмнө нь барьж байгаад мулталж орхи. Аа мондиос болж гараа шалбалж орхилоо. Чамайг уу даа» гэх зэрэг дуу сонсогдож байлаа.

Гагцхүү жолоочийн ард хөдлөлгүй суугаад хөмхийгөө зуун салхинд бага зэрэг гандсан нүүрээ барайлган, барьж ядсан заналхийлэл нүдэнд нь туяарсан нэг хүн дуугаралгүй «Толгойгоо цохих гараа шалбалах чинь юу ч биш. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь л дэндэж байна» гэж сэтгэлдээ дахин дахин шивэглэн явжээ. Үнэндээ хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ. Шаргачин уулруу зугтсан бол өдийд мөрдөгчөөсөө салж, хөшсөн булчингаа амруулаад хярсан үр рүүгээ гэлдрэн явж болохсон билээ. Гэтэл шаргачин хөөх тусам зах хязгаар нь үл мэдэгдэх өргөн талын гүн рүү тэмүүлж байв. Хичнээн километр хөөснийг хэн ч хэмжсэнгүй. Хэд дахин буудсаныг хэн ч тоолсонгүй. Эцэстээ шаргачин хоёр чихээ шилэндээ нааж амаа ангайн богинохон сүүлээ хавчин давлан урсах жигд хөдөлгөөнөө алдаж, өндөгнөн цогих буюу заримдаа бүр шогшдог болов. Будаан сум цайран эхэлж байгаа бөгсийг нь сийчин оноод ухаа ягаан цус хонгыг нь дагаж урсан эхлэв. Гэвч шаргачин сүүлчийнхээ хүчийг дайчлан харайсаар байв. Амьдралдаа хэд хэдэн янзагыг бойжуулан торниулж түмэн бэрхшээл мянган саадыг давж гарсан энэ шаргачин хөөсөн дайсныг хурдан хөлийнхөө хүчээр зайлуулаад унтсан үрдээ эргэн очиж байсан удаа олонтоо нь эргэлзээгүй. Учир нь зээр ямар ч амьтанд өчүүхэн ч хор хүргэдэггүй боловч, түүний дайсан мундах биш даа.

-Сум байна уу? Гэж хашгирах дуу машин дотроос хэд дахин сонсогдсоноо хэсэг чимээгүй болоод цонхоор арзайн гарсан буунуудаа татаж аваад хөл рүүгээ хаялцгаав.

-За одоо яадаг билээ гэж нөгөө жолоочийн дэргэд суугч хоосон буугаа хажуу тийшээ хаях зуур хэлэв.

-Муу золигийг дайруулж орхиё гэж жолооч хэлээд хурдаа нэмлээ.

Амьд гарч янзагатаа эргэн очоод язарч чинэрсэн дэлэнгээ хөхүүлж учралаар гэрэлтсэн хайраар янзагынхаа годгонон тоглож байгаа жижигхэн сүүлийг үнэрлэх хүсэл их боловч хөшиж зангирсан хөл нь урагшаа хөдлөхгүй болоод бүх бие нь салганан амьсгал нь цээжиндээ багтахгүй оволзон саяхан үзэсгэлэн болон сэрвэлзэж байсан хоёр чих нь дараа болон дэлдэгнээд эцсийн эцэст өөрийн эрхгүй сөгдөн шургачиж хэвтлээ. Машин зогсож

хэдхэн цаг зугтаж зовоосон зөрүүд муу шаргачин амьдаараа гарч орох болсонд баярласан хоёр инээлдэн гарч ирлээ. Хэрэв сувай шаргачин буюу ооно байсан бол хөшиж нугараад мод болсон хөлөө хүчлэн тэнийлгэж босоод зугтаж чадахгүй байсан бизээ. Гэвч энэ шаргачин тийм биш болохоор ухасхийн босоод манаран хөхөрч байгаа нүдээ бүлтэгнүүлэн шогшив. Тэд явгалан хөөсөн боловч барьж чадсангүй. Гүйцэгдэхгүй байгаад нь уурлан бухимдаж том том чулуугаар шидсэн боловч оносонгүй. Тэгээд тэд хараал тавин буцаж машиндаа суугаад дахин хөөв. Шаргачин дахин шурган сөгдөн хэвтэв. Машин түүний дээгүүр өнгөрөхдөө өрөөсөн дугуйгаараа дайрлаа. Машин эргэж зогсоход түүнээс анчид гүйцэгддэггүй шаргачинг босох чадалгүй болгосондоо баярлан инээлдэж хөгжил болон гарч ирлээ. Тэрийн хэвтсэн бөгөөд бүх бие нь үхлийн өмнөх чичрэлтээр татагнаж байгаа шаргачин эцсийн хүчээ дайчлан янзагаа нуусан зүг рүү амьдралын оч орхин хаяж байгаа нүдээр харлаа.

-Гүйцэгдэхгүй оногдохгүй байх чинь яав? Гэж нэг нь хэлээд нөгөө нэг нь шаргачны дэргэд ташаагаа тулж ханхалзан зогсоход шаргачин дахин өндийж янзага нь амгалан сайхан унтаж байгаа зүг рүү дахин харах гэтэл хүнд төмөр манивил толгой руу нь тас хийтэл бууж, эцсийн амьсгал нь тасрав. Жолооч нүд рүү нь манивилын үзүүрээр хатгаж үзсэнээ,

- Талийгаач болжээ гээд өврөөсөө хиам гаргаж зулгаан идлээ.

Шаргачны чинэрсэн дэлэнгийн хоёр хөх нь зугтахын өмнө сэрвэлзэн соотгонож байсан хоёр чих шиг нь босож сэрийгээд түүнээс шахагдан гарч байгаа цагаан шаргал сүү нь элсэрхэг хөрсөнд шингэн орж борлуулан байлаа. Жолоочийн дэргэд суугч хөдлөлгүй хэвтэж байгаа шаргачинг өшиглөн хөрвүүлсэнээ,

-За явъя. Туранхай хөхүүл шаргачнаар юу хийх юм. Тарган сан бол оноо засаг нь чанаж, өөх үмхэх юмсан. Чамд юм үлдсэн үү гэхэд нь нөгөө нь

-Хагас шил юм үлдсэн гээд ягаан цус шүүрч байгаа шаргачин рүү ажиглан харснаа мөн догь буудаж шүү гээд бардам гэгч нь инээмсэглэв.

Тэгээд тэд машиндаа сууж явахдаа жолоочийн хажууд суугч

- Ярих сонинтой боллоо гэж хэлэхэд,

Хууль зөрчсөн та нартай ярих юм над бүр ч их бий гэж жолоочийн ар талд суугч боджээ.

Машин тоос татуулан хурдалж далд орлоо. Дээр мандсан нарны гэрэл шаргачны дээрээс жигнэн ямар ч анир чимээгүй өргөн тал мэлтийн тэнгэрийн хаяанаас том гэгчийн хар тас алгуур дэвсээр улам тодрон гарч ирлээ.

СОНОМЫН ЛОЧИН

Зохиолч С. Лочин ГовьАлтай аймгийн Дарви сумын нутагт малчны гэрт төржээ. Бага дунд сургууль, Улсын их сургууль төгссжээ.

1965 оноос уран бүтээлээ эхэлж «Сэтгэлийн өнгө», «Үргэлжлэлтэй долоон өдөр», «Сүйрэл» зэрэг роман олон өгүүллэг, тууж бичжээ.

Зохиогчийн « Сэтгэлийн өнгө» роман Орос, Вьетнам хэлнээ орчуулагджээ.

БИ

Өөрийнхөө тухай илэн далангүй өгүүлнэ гэдэг үнэхээр шударга хүний явдал буйзаа. Хэрвээ тийм бус бөгөөд би яахин ийнхүү зориглохов. Би нэгэн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан хүн. Миний нэрийг за даа. Танд нэр минь төдий л сонирхолтой бус байх. Ердийн л нэгэн нэр. Өмссөн хувцас, царай зүс минь ч бусдаас ялгараад байх юмгүй учир олныг нуршихыг үл зориглов. Өгүүлж буй зүйлд минь учир олныг нуршихыг үл зориглов. Өгүүлж буй зүйлд минь учир шалтгааны холбогдол үгүй учир байгалийн зураглал, цаг агаарын байдал зэргийг тоочих буюу зураглан зай эзлүүлэхгүй. Харин өөрийнхөө талаар өгүүлэх минь л та нарт лав сонирхогдоно. Эрдэм шинжилгээний ажилтан гэдгээ дээр хэлсэн. Нас хорин найм. Тийм ч явчихсан нас биш. Мэдээж эхнэр хүүхэдтэй. Том нь энэ жил сургуульд орсон. Отгон нь хоёр жилийн дараа ардын сургуулийн алтан босгыг алхана. Охиноо би «Отгон нь» гэж үнэхээр отгон хүүхэд минь гэдгийг мэдэж байгаа учраас бат итгэлтэй хэлж байна. Зарим хүмүүс Отгон, Отгонбаяр гэхчилэн нэр өгөөд дахиад хүүхэдтэй болохгүй хэмээн санаархавч нэг л мэдэхэд дахиад хүүхэдтэй болчихсон, тэгээд хэн гэж нэр өгөхөө мэдэхгүй амаа ангайн, гараа алдан зогсож байдаг. Би бол тийм хүн бишээ. Эхнэр минь дээд мэргэжилтэй. Гэвч нэг их удахгүй, эрдэмтдийн тоог нэгээр нэмэгдүүлэх хүний эхнэр дээд мэргэжилтэй байх нь мэдээж болохоор илүү л юм хэлчिव бололтой. Энэ жил боловсон орон сууцанд орсон. Аз болоход гурван өрөөтэй байр. Гагцхүү сэтгэл дундуур байгаа зүйл минь гэвэл байр маань яг хотын төвд биш, гэхдээ Толгойт мэтийн хол газар байр аваагүйдээ сэтгэл өег байна. Өнгөрсөн юм бүрий амархан, одоо бодоход толгой өвдөн, нүд эрээлжлэх шиг санагдах юм. Ай яа, мөн ч олон даваа давсан шүү. Би ч угаас алсын хараатай хүн болохлоор их сургуулийн дөрөвдүгээр ангид байх үеэсээ л байх шууд олох үгүйдээ л гэхэд хамгийн цаад зах нь гурван жилийн дотор байр өгөх тийм газар очих арга мэх сүвэгчлэн эхэлсэн хүн дээ. Чингэтэл бүтэн таван жил тиймээ сунасан таван жил хөөцөлдөж байж байртай болсноо бодохул ёо ёо зүрхээр хатгуулах шиг болном. Би үнэнийг нуухгүй өгүүлнэ гэсэндээ хүрэн хэлэхэд үнэндээ бол би өдийд байргүй л хэвээрээ байж байх ёстойдог. Хэдий тийм авч яагаад байртай болсноо дэс дараагаар нь өгүүлсүгэй. Би олны дунд өөрөөр хэлбэл зоогийн газар юм уу, сайн таньж мэдэхгүй, ааш занг нь гадарлахгүй хүмүүстэй архи уухыг эрс цээрлэдэг хүн авч, байрны төлөө дүүрсэн хэрэг гэж сэтгэлдээ тушаагаад олон ч шил архи, шар айраг тэргүүтнийг танихгүй шахам хүмүүстэй хамтран цааш харуулсандаа. Ажлынхаа газраас байр авах гэж яаж тулалдсан гээч. Эндүүрээгүй, үнэхээр тулалдсан юм шүү. Тэгээд нэг удаа байр авах тун дөхсөн. Чингэтэл сайн юманд саад мундахгүй гэгчээр яг авдгийн даваан дээр урьд нь олон жил нэгэн сургуульд хэдийн багшилж байгаад манай хүрээлэнд ирсэн нэг хүнд өгөх болж, намайг хойшлуулсан. Манайд олон жил ажиллаагүй гэж над хэлсэн. Чингэхэд манай талынхан эрс шийдвэртэй давшилтанд орж, шинэ залуу боловсон хүчнийг дэмжих хэрэгтэй... ер нь найдвар төрүүлж буй, хойшдоо шинжлэх ухаанд бат тогтвортой, үр бүтээлтэй ажиллах хүн. Тэр гуай ч адилхан хүрээлэнд ирээд удаагүй байгаа хүн ялгаагүй гээд л ярьж батлахад нөгөөх багшийн талынхан, нийт дүнгээрээ улсад олон жил ажилласан, найман хүүхэдтэй энэ хүнд олгоно гэсэн нь л хуралд оролцогсдыг талдаа татах түлхүүр болсон. Хүн гэгч амьтан шинжлэх ухаан техникийн үсрэнгүй дэвшлийн өнөө үед юм бүхэн нарийн тооцоонд шилжсэн цагт найм.... хэлэхээс аманд багтахгүй байна. Юу сайхан дур сайхан гэдэг болохлоор би өөрийгөө л хичээж бусдын дотоод хэрэгт оролцохыг больё. Ер нь найм байтугай арван хэдтэй байх нь ч зүйтэй байх. Хүн шиг үнэт капитал байхгүй. Өөрийн минь хувьд бол ч хоёр байгаа нь хангалттай. Бас нэг зүйл гэвэл сургууль төгсөөд өөрийн хийсэн

судалгааны дагуу, гурван жилийн дотор гарцаагүй байр өгөх нэг газар хуваарилагдаж чадсан боловч, жил гаруйхан тэнд ажиллаад хасагдсан. Тэгээд хүрээлэнд ирсэн минь дээд заяа болсон. Ай мөн ч балрах дөхсөн шүү. «Чиний тарыг танилаа» гэж тэр нэг хүний хэлснийг мартаж аргагүй. Одоо ч эргэн бодохоос хүйтэн хөлс гардаг. Ийнхүү тулалдаанд ялагдчихаад нэг хэсэгтээ би гэдэг хүн сэтгэл санаагаар унаж царай зүс алдаад байж байтал хадам аавд минь үйлдвэрийн газар нь байр өгсөн сураг дуулдгаа. Эхнэр маань энэ үгийг хэлсээр орж ирэхэд орон дээрээ хэвтэж байсан би босон харайж, гараас нь барьж авлаа.

-Өө чи баярлаж маасайх хэрэггүй, яарч байна. Манайхыг тэртэй тэргүй байр өчнөөн жил хөөцөлдлөө. Одоо эрхбиш авах биз. Харин муу хүүгийнхнийгээ л оруулья. Олон хүүхэдтэй юм гэж ээж ярьж байна гэв. Олон хүүхэд, олон хүүхэд гэсэн энэ үг зүрх рүү шивсэн зүү шиг байв. Юу гэсэн үг вэ? Хүүхэд л байранд орох ёстой юм бол би ч хоёр хүүхэдтэй. Тэд минь ч бусдын хүүхдийн адилаар байранд орох эрхтэй. Уурласандаа биш, гомдсондоо нулимс гарах шахав. Хадам ээжийн царай нүдэнд хүйтэн байдлаар харагдана. Үнэхээр ч зэвүү хүрмээр ажээ. Намайг байр сууцгүй зовж буйг минь мэдмээр дээ. Үгүйдээ гэхэд төрсөн охиноо боддог байгаадаа. Чингээд би авгайдаа уурлаж нэг үзээд, аргадаж нэг үзээд, эцэст нь эхтэйгээ хэлэлцээр хийх заавар боловсруулж цээжлүүлж өгөөд явуулчихав.

Хадам аав минь олон жил үйлдвэрт ажил хийж буй хүн. Гэр орны бүх хэрэг явдлыг хадам ээж л мэднэ. Харин аав зөвхөн л ажлаа хийнэ. Бусад явдалд ерөөс оролцохгүй. Иймээс эхнэр минь ээжтэйгээ хэлэлцээр хийхээр явсны учир ийм юм. Би сэтгэл түгшин хүлээлээ. Энэ хүлээлт минь найдлага биелүүлж би байртай болсон гэдгийг өчсүгэй. Ийм даваа давсан болохлоор одоо байртай болсон замаа эргэн санахад яахан сэтгэл хангалуун байх билээ. Та бүхэн намайг ойлгож бодлыг минь хуваалцаж байгаа гэдэгт найднам. Одоо би өөрийнхөө талаархи бусад зүйлийг өгүүлэе. Эрдмийн зэрэг хамгаалж нэг сайхан өдөр эрдэмтэн болох минь гарцаагүй байх. Мэдээжээр олон даваа давах хэрэгтэй ч эцсийн эцэст эрдэм шинжилгээний ажилтан би дэд эрдэмтэн болно. Түүний дараа дахиад нэг үсрэлт хийж доктор болно. Өө тэр цагт сэтгэл амарч болно. Дэд болсныхоо дараа улам шургуу зүтгэнэ. Ер нь эрдэм шинжилгээний ажлынхаа талаар сүүл хэсэгт арай дэлгэрэнгүй өгүүлнэ. Одоо би өөрийн сонирхон оролцдог, тэгээд тийм ч муугүй амжилттай байгаа бас нэг зүйлийнхээ талаар ярья.

Би залуу зохиолч гэдэг бас нэгэн нэртэй хүн. Зарим нэгэн сонин сэтгүүлд хэд гурван шүлэг, өгүүллэг гэдэг зүйлийг нийтлүүлж байж л ийм нэгэн нэр олж авсан. Жинхэнэ зохиолч биш залуу зохиолч гэдэг нэртэй байгаа минь учир мэдэхгүй хүмүүст хоёр янзаар ойлгогддог. Нэгд гэвэл, уран бүтээлээ эхэлж цэцэглэх замдаа орж яваа хамгийн найдвартай залуус гэж үзнэ. Гэтэл өөр нэг хэсэг цөөнх нь болохлоор, дөчин насны босгоо түшиж санчгийн үсэндээ буурал орсон хойноо залуу зохиолч хэмээгдэн, жилдээ нэг юмуу, заримдаа хоёр гурван жилд ч нэг удаа ганц нэг шүлэг, өгүүллэг юм уу, сурвалжлага, тэмдэглэл мэтхэнийг хэвлүүлэн байдаг зарим нэгэн хүн санаанд нь ордог юм байлгүй. «Амьд» залуу зохиолч гэдгийг үзэхлээрээ ёжтойгоор мушилздаг. Залуу зохиолч байна гэдэг олон үүрэгтэй. Юун түрүүн багш хэрэгтэй. Нэртэй том зохиолчдоос хэн нэгийг нь багш болгон авдаг. Ингэхлээр би гэдэг хүн уран зохиолын нэг багштай болсон. Гэтэл бас эрдэм шинжилгээний минь ажлын удирдагч буюу багш гэж нэг хүн бий. Ингээд л дор хаяхад хоёр багштай болсон доо. Атаархагч зарим нь муу билүүний баас их муу хүний багш олон гэж ярьдаг гэсэн. Одоогоор над багш хэрэгтэй байгаа тул иймэрхүү яриаг би огтоос тоодоггүй. Залуу гэдэг тодотголыг хасаж ерөөсөө л зохиолч

хэмээх чихнээ чимэгтэй нэртэй болоход зам маань дардан шулуун биш байгааг шударгаар хүлээх хэрэгтэй. Хамгийн наад зах нь «хавгас нийлүүлж» анхны номтой болох нь хойшлуулшгүй чухал. Түүнийхээ дараа номондоо нааштай шүүмжийг нэртэй шүүмжлэгчээр бичүүлж чадвал зорилт минь урагш нэлээд ахина. Номоо гарахлаар «Эрхэм хүндэт... багш тандаа өргөн барив», «журмын нөхөр... юүгээн хүндэтгэн өргөн барив» гээд л гарын үсгээ зурж дурсгана. Номын дэлгүүрүүд дээр уншигч, зохиолчдын уулзалт болж, номын дэлгүүрийг төлөвлөгөөгөө биелүүлэхэд нь туслах «кампанит ажлын» үеэр бол номыг минь худалдан авсан хүмүүст гадна өнгөндөө даруу ч цаанаа ихэмсэг, зохиолч гэсэн хүслэнт эрхэм нэрээ хамгаалсан байдлаар илүү дутуу үг бичилгүй зөвхөн л нэрээ таталсхийн бичнэ. Тиймээ зохиолч гэдэг ийм л байдаг учраас сайхан.

Ийнхүү эрдэмтэн болчихоод бас зохиолч гэдэг дээрээ залуу мэтийн тодотголгүй ч хэний хүү хэн бугайн өмнө ч дүүрэн хэлэх болсон үедээ би эрдэмтэн зохиолч болно. Тэгээд ч зогсохгүй би өгүүлэлт зохиол, шүлэглэлт зохиол бичдэг учир эрдэмтэн зохиолч яруу найрагч гэж бичихэд ч болно. Хожим 50, 60, 70 насны ойгоо хийх үедээ залуу зандан цагийнхаа гэрэл зураг бүхий (аз болж 100 насны ойгоо өөрийн биеэр тэмдэглэх юм биш биздээ) тусгай хөтөлбөр хэвлүүлнэ. Түүнд минь товч намтар, зохиол, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт зэргээ жагсаан бичнэ. Ай мөн ч сайхнаа. Би үнэхээр романтик мөрөөдөмтгий сэтгэлтэй, аргагүй л яс махнаасаа зохиолч байх одон дор төрсөн хүн байх. Хэрвээ тийм бус аваас сэтгэлд минь ийм амтлаг, сайхан зүүд адил бодол яахин төрөх билээ. Энэ бүхнээ гүйцэлдүүлж амьд ахуй цагтаа үр шимийг нь хүртэхийн тулд бие гамнаж байх ёстой. Үдийн цайны цагаар гуанзны мөнгөө хэмнэн контортоо шатар тоглох мэтээр цаг иддэгээ болих хэрэгтэй юм. Нэлээд хүмүүс намайг боловсролтой залуу хэмээн ярилцдагийг сонсоход хичнээн аятай байдгийг өгүүлээд яахав. Ийм нэр олж авахад дээд сургууль төгсөөд олж авсан жинхэнэ боловсролоос минь гадна өөрийн нарийн ажиллагаа хэрэгтэй байдаг. Би энэхүү шинжлэх ухааныг бүрэн эзэмшсэн хэмээх зориг алга. Харин хаалгыг нь татан орж хэрэг явдлын зах зухаас гадарлахтай болсон гэж ам дүүрэн хэлж чадна. Энд үнэхээр нарийн ухаан хэрэгтэй. Сэтгэлийн гүн дэх бодлоо ханилаад суусан эхнэртээ ч гаргаж хэлдэггүй тийм бодлоо нэгэнт л дэлгэж буй болохлоор нуух юм алга юу гэвэл, хамгийн түрүүнд хүнтэй ярилцаж буй үедээ яриан дундаа хавчуулаад час хийсэн амт оруулчих цэцэд мэргэдийн хэлсэн үгнээс нэлээд олныг цээжлэх хэрэгтэй. Зарим үед бага сага засвар оруулаад ярихад чи буруу хэлчихлээ гэж маргах нь тун ховордоо. Зохиолчид гүн ухаантан зэрэг хүмүүсийн үгс үнэхээр оновчтой, ухаалаг байдгийг хэн маргахав. Гагцхүү тэр эрдмийн санг чадварлаг ашиглах хэрэгтэй. Бичсэн шүлэг зохиолдоо зүүлт, дагавар хийн тэр үгсээс, эх хэлээр нь авч хэрэглэх нь уг зохиолыг эх хэлээр нь уншдаг болж харагдахын хөдөлшгүй гэрч болой. Бас яриан дундаа гадаад үгийг ганц нэг оруулна. Чингэхдээ харин тунгий нь хэтрүүлж болохгүй. Чингэвэл хүмүүс муу хэлнэ. Өөр нэг чухал үзүүлэлт бол энд тэнд болж буй дэлхийн спортын элдэв тэмцээн, тоглолт зэргийн зах зухаас хийгээд, алдар цуутай тамирчдын талаар бага сага ойлголттой бай. Энэ бүхнийг заавал унших шаардлагагүй. Спортын хорхойтон гэгддэг алив бүхнийг мэдэж байдаг нэг хоёр хүнийг таньдаг бол гүйцээ. Цаадуул чинь уулзахтайгаа зэрэг чамайг гуйгаагүй байхад л тэнд тийм тэмцээн болж тэр бөгөөд сайн тоглож, энэ улсын шүүгч тэгж буруу шүүгээд гэх юм уу төчнөөн удаагийн аварга тийм тамирчин түүнтэй гэр бүл болсон гэнэ ... гээд л урсгаж гардаг юм. Зохиолч болох хүний хувьд урьд үеийн зарим нэгэн эмгэнэлт амьдрал туулсан энд тэндэхийн зохиолчдын намраас гадарладаг, түүнийгээ уран зохиолын түүх судраас холхон байдаг хүмүүсийн дунд их л итгэлтэйгээр ярихад чамайг

нэг л мэдэхэд боловсролтой залуу гээд дая дээгүүр шуугичихсан байна. Хуучин цагийн зэрэг дэв, мартагдаж хаягдахыг шахсан хуучирсан үг, хэллэг цөөн хэдэн ном судрын урт сунжуу нэр, цээжилэхэд хялбар тэр үеийн нэг хоёр бадаг шүлэг мэддэг бол боловсролтой залуу гэдэг нэр чинь хөдөлшгүй. Ерөөсөө <боловсролтой хүн>гэдэг маань өөрийн толгойг ажиллуулж, алив үзэгдэл юмст өөрийн дүгнэлт өгч чаддаг байх нэг ёс бий. Тиймээс ялангуяа ахмад бөгөөд залуу зохиолчдын бүтээлийг хүн магтаж байвал сөрөөд муулж чаддаг байх хэрэгтэй. Атаархагчид миний энэ бүх арга мэхийг гадарлачихаад муу хэлж байдгийг нь би анхаарч сонсдоггүй «идүүлсэн бут цэцэглэдэг» гэсэн үг бийг санаад л, дотроо шүдээ зуун явдаг. Хожмын өдөр тооцоо хийж болох байлгүй. Эрдэм шинжилгээний минь ажлын хувьд гэвэл <дадлагажигчаас>эхлээд тогтоосон шат бүрийг давж явна. Огтоос төлөвлөөгүй явдал л саад болчихгүй бол гурван жилийн дараа гэхэд <дэд> хамгаалчихаад номын хурим хийх ажил толгой дээр унаж ирэн байх. Хамгаалах сэдвийнхээ талаар одоо дэлгэрүүлж яриад яахав. Гэхдээ бид одоохондоо чанд нууцлан байх ёстой тийм нээлт хийж байгаа биш шүү. Ерөөсөө л ёстой юм ёсоороо яваад оргилдоо хүрдэг. Тэр цагт бүгд мэдэж болно. Зарим нэгэн хүн сэдвийн минь шинжлэх ухааны үнэ цэнийн талаар үг дуугарах, эргэлзээд оруулах хандлага гаргаж байсныг ч нуух юмгүй дурдсу. Би ийм янзтай явж байна. Аминдаа аргатай явна гэдэг амьдарч чадахын нэр. Энэ талаар танд философийн гүн сэтгэлгээ ч төрж мэднэ. Ер нь тийм шүү дээ. Эр хүн сүүхээтэй явахаас алдах юм байхгүй. Би өөрийнхөө талаар урьд өмнө хэзээ ч хэнд ч ийнхүү илэн далангүй өгүүлж байгаагүйгээ танд сануулья. Эрхэм хүндэт Та минь эл нууцыг задруулсан байвал тооцоотой шүү. Хувийн нууцыг хуулиар хамгаалдгийг эрхээ биш мэднэ биз дээ. Танд би найдахгүй бол өөр хэндээ, энэ хорвоод найдах билээ. Өө, та найдвартай, над өчнөөн жил үнэнч байсан шүү дээ. Эргэлзлийн хорт хөх гал сүүмэлзэн ноцох дөхсөнийг минь Та уучлаарай. Уучлаарай. Та бид хоёрыг салгах хүчин байхгүй болохлоор би илэн далангүй байсан юм. Түүнээс биш яалаа гэж дээ..

Хэдэн жилийн өмнө зуурдаар талийгаач болсон танихгүй нэг хүний бичиг цаасыг онгичих шаардлага над тохоогдож, тэгээд яах ч аргагүй болж, даалгаврыг гүйцэтгэж байгаад энэхүү «Зөвхөн л өөрөө өөртөө бичсэн захидал» гэгч зүйлийг олсон билээ. С.Л

ТҮҮНИЙГ УУЧЛАХЫН УЧИР

Баярын өмнөхөн үе гэхэд санасныг бодвол үсчний газар хүн цөөвтөр байлаа. Гэвч чамлахааргүй хүлээх нь гарцаагүй боллоо.

Тав зургаан хүн дараалан суужээ. Нэг бүдүүн эр хана налан, нүдээ аньсан нь энэ хорвоогийн амьдралыг үүрд орхин одсон мэт харагдана. Нэгэн пагдгар эр пиджакныхаа энгэрийн гадна халааснаас сам гарган хананы том толины өмнө очоод үсээ хоёр шанааруугаа ч самнаж үзнэ. Духруугаа ч самнаж үзнэ. Яаж самнавал өөрт илүү зохихоо мэдэхгүй л байгаа бололтой. Хажуу халимаг чамайг оворжуу болгоод духруугаа самнахлаар хүүхэд шиг харагдуулаад байна. Хойш нь самнаач тэгвэл чи гараад өгнө дөө гэж хэлмээр санагдавч би мэдээжээр юу ч хэлсэнгүй. Миний өмнө сууж буй улаан хамартай цоохор нүүртэй эр бугуй дахь цагаа байсхийгээд л харна. Тийн харахдаа хүнтэй л маргаж ч буй юм шиг, инээж наргиж ч байгаа юм шиг морин шар шүдээ ярзайлгах агаад, тун ч их яарч буй хүний байдал илт. Тэр тогтож байж ядан, эгээл сандалд суухлаар дороос нь өргөс хатгаад байгаа мэт. Харин өөрийг нь төлөөлөн сандал дээр түүний барьж яваа, элэгдэж халцарсан том шар цүнх л данхайна. Би түүний цүнхийг мэлрэн харна. Ийм цүнхийг зарим хүн профессор цүнх ч гэдэг. Яагаад ингэж нэрлэдэг нь бол ойлгомжтой. Гэтэл нэг хэсэг хүн ийм цүнхийг Захын шар ч гэх нь бас байдаг. Тиймээ зарахгүй, солих гэхдээ хот даяар биш юмаа гэхнээ ямар ч л гэсэн зах дээр ижил нь барагтайд байдаггүй тийм ховор солих бараагаар дүүрэн байх нь тохиолдогоос ийнхүү нэрлэх болсон тал бий биз. Бас нэг хэсэг хүн ийм цүнхийг Пивоны шар ч гэж л байдаг. Дотор нь ном дэвтэр биш пиво, пивоний шил дүүрэн явах нь тохиолдогоос ийм нэртэй болсон цүнхний буруу юу байхав. Харин эдээ ийм нэртэй болсон эзэд нь л улаан хамартыг би дээрх гурван ангиллын алинд багтахыг хэлж зүрхэлсэнгүй. Нэг харахад профессор биш юм аа гэхэд дор хаяад дээд сургуулийн туслах багш ч байж мэдмээр. Учир юун гэвэл «Нутгийн нэг хүүхэдтэй уулзахаар дээд сургууль дээр очоод мунгинаж яваад оюутны эрдэм шинжилгээний хурал гэгч болж байсан хүнээр дүүрэн нэг том өрөөнд орчихсон чинь яг л ийм хүн, индэр дээр гарчихаад нэг оюутны илтгэлийг бөмбөгдөж »байсан нь миний сэтгэлд мартагдахааргүйгээр үлдсэн билээ. Ахиулан харахад улаан хамар нь нүднээ унаж, Пивоний шарын эзнээс хаашаа зайлах вэ дээ гэсэн бат итгэл төрөвч хэдэн сарын өмнө зах дээрээс хүүхдийн өвлийн гутлыг гурав бөгтөрсөн өндөр үнээр яг ийм шар цүнх барьсан, яг ийм улаан хамартай хүнээс гуйж царай алдаж байж худалдан авсан ч шиг санагдана.

Ийнхүү элдэв дээдийн юм бодон суусаар бас чиг хөөрхөн хүлээснээ золоор анзаарсангүй. Өмнө минь улаан хамарт л (алдарыг нь мэдэхгүй болохоороо л түүнийг сэтгэлдээ ийн нэрлэж байгаадаа өршөөл эрнэм) үлдсэн байв.

Дотор өрөөнөөс 82 гэсэн цариун дуун хадахад улаан хамарт надруу эргэж харин түрүүхэн тогтож ядан байснаа мартчихсан бололтой их л тайвуу дуугаар,

-Та орвол ордоо гэж хүнгэнүүлдэг байна. Энэ нь надад ёстой л цэлмэг өдөр аянга бууна гэгч шиг л санагдлаа. Би ийм үг сонсоно гэж бодоогүй байв. Харин ч урагш зүтгэн оочер дайрахаас буцахгүй эр байна даа хэмээн нүгэлт бодол түрүүхэн төрж байснаа санан өөрөөсөө өөрөө ичиж, ийм найрсаг хүн профессор шарын л эзэн байлгүй яах вэ? Гэж бодлоо. Ингээд би олон юм ч цааш нь бодож амжсангүй,

-Танд их баярлалаа гэж өөрөө ч мэдэлгүй бодсон ч юмгүй автоматаар улаан хамартад хэлчихээд, ухасхийн орлоо. Зөөлөвтэй гамбагар улаан сандал дээр суувал овоо нуруулаг горзойсон өндөр ч гэлээ царай нь хүүхдээрээ охины нүд тормолзон байх нь цэлгэр тунгалаг толиноо тусна. 82(үсчин охин) хайчаа дуугарган үснээс минь шууд л тайрч эхлэхэд нь,

-Миний дүү ахынхаа үсийг хагас битүү засна шүү гэж хэлэхэд

-Уртаас нь хэр зэрэг авах вэ?

-Заа даа, саяныхаа тайрдгийн хэмжээнд л бол дажгүй.

Ингээд л бид хоёр дуугүй болж охин үсийг минь засч би толин дундаас өөрийнхөө дүрсийг харан сууна. Гэтэл удсан ч үгүй Улаан хамарт орж ирэн миний чанх харалдаа сандалд суух нь мөн л ертөнцийг тольдогч том толиноо тусав.

Үсчин охины нимгэн цагаан царай яасан ч юм бүү мэд нэг мэдсэн шүр шиг улайчихсан байв. Охины царай яагаад юунаас үүдэн улайв? Үснээс минь биш байгаа гэж бодсоноос болоод миний өөрийн царай бас л яах ийхийн завдалгүй улайчихлаа. Ийнхүү царай улайн мэгдэж байснаа гэнэтхэн тайвшран эл бүх явдалтай холбоогүй ч гэсэн өөр нэгэн газар урьд өмнө болсон өөр нэгэн явдлын тухай өөрийн эрхгүй бодоход хүрэв.

Би уурхайчин хүн. Налайхын уурхайд ажилладаг. Уг удмаа хөөвөл баруун нэг аймгийнх ч гэлээ Налайхыг өөрийн төрсөн газар унаган нутаг гэж боддог болсон олон хүний нэг. Гэхдээ Налайхад ирж уурхайчин болоод зургаа дахь жилийнхээ нүүр л үзэж байна. Одоо хорин долоотой гээд бодоход уул нь нас бие гүйцсэн хойноо усны урсгалын өөд урууг ялгахтай болсон төдийгүй өрх гэр толгойлоод явах насандаа налайхад ирсэн минь тодорхой. Хэдий тийм ч Налайхыг өөрийн унаган нутаг гэж боддогийн учир нь олон шалтгаантай хамгийн гол нь уурхайтай минь бас намайг уурхайчин болгосон багштай минь холбоотой бүлгээ. Би олныг нуршихгүйг хичээн нэг л удаагийн явдлыг өгүүлсүгэй.

Жав багшийн шавь болсон тэр өдөр миний сэтгэлээс хэрхэн гарах билээ. Намайг уурхайчин гэхлээр нүүрс малтаж хүрздэж, дүнз мод өргөн бэхэлгээ хийдэг хүн гэж бодуузай. Би хөдөөнөөс ирэхдээ уурхайчид гэдэг цөм л нүүрс малтаж гаргадаг хүнийг л хэлдэг хэмээн боддог нэгэн байсан. Гэвч тийм бус байв. Би уурхайд ирээд цахилгаан тэрэгний туслах машинчаар ажиллах болсон билээ. Алсын алсыг зорьсон аяны их цагаан зам адил газрын хөрснөөс зуу гаруй метрийн гүнээ зурайх ган замаар утаа ч үгүй, уур савлуулдагч үгүй, ердөө цахилгаан гүйдлийн хүчээр ажилладаг цахилгаан тэрэг, хурдан давхиж явдгийг мэдэхгүй хүн бүрийг буруутгаж яахин болох. Жав багш минь намайг их л няхуураар ширтэн,

-За хүү минь уурхайд аюул осолгүй ажил гэж байдаггүй юм. Гэвч энэ бол газар сайгүй л дандаа аюул осол гарч байдаг гэсэн үг биш. Ер нь ганц уурхайд ч биш, аливаа ажил дээр ямар нэгэн хэмжээний аюул осол гарах учир байдаг шүү дээ. Ямар ч аюул тохиолдохгүй тийм ажил хаана байхав дээ. Би чамд энэ бүхнийг юу гэж ингэж нуршин өгүүлнэ вэ? Гэвэл нэг талаас уурхай гэдэг өглөө гэрээсээ гарсан хүн орой эргэж ирэх эсэхээ мэддэггүй юм гэсэн сул яриа зарим талаар газар авсан байдаг нь лав чиний чихэнд хүрсэн байлгүй. Тиймээс тэр ор үндэсгүй хий сүржигнэсэн яриаг март гэх гэсэн юм. Нөгөө талаас уурхай гэдэг ийм л айх юм

байдаггүйгээс хойш яаж ч байсан дажгүй гээд энд дураараа дургин бодсоноороо аашлаад байж болдоггүй юм гэдгийг л ойлгуулах гээд буй санаа минь энэ гэхчлэнгээр ярьсан юм даа.

Зургаан жилийн өмнө болсон энэхүү яриа тэр үедээ анх сонсож байхад нэг их номчирхсон, тэгсэн атлаа юу хэлэх гээд буй нь ойлгомжгүй санагдаж байсан. Гэтэл энэ зуур зургаан жилийн хугацаа урсан өнгөрч би ч уурхайн амьдралын зах зухаас нь бас чиг чамлахааргүй зүйл амссаны дараа, багш анх над хэлж байсан дээрхи үг чухам ямар учиртайг, багш минь над юу хэлж байсныг ойлгохтой болжээ. Уурхайд ажиллахаар анх удаа ирж буй залууст би одоо багшийнхаа энэ л үгийг давтан хэлдэг. Би хэдий моншин мунгинуу амьтан ч гэлээ багш минь сайн хүн байсан болохоор хэсэг хугацаа өнгөрөхөд ажилдаа овоо зүгширч олон хайрцаг нүүрстэй тэргэнцэр чирэн, уурхайн хонгилын ган замаар цахилгаан тэрэг жолоодон давхихтай болсон. Хонгилын таазнаа татсан их хүчтэй цахилгаан гүйдэл гүйж буй, хуруу шиг бүдүүн утсыг харахад хааяа бие зарсхийн хачин болох авч өмнөө зурайн ган зам арын гэгээвчний шилээр харагдах цуварсан олон тэргэнцэр дотор гялалзсан хар нүүрс сэтгэлд баясал, бахархал авчрах нь сайхан. Замын зөрлөг дээр очис гялсхийн бутрах нь ч бас л ёслолын буудлагын галт сум адил харагдаж сэтгэлийг гийгүүлнэ.

Эл өгүүлэх явдал болсон тэр өдрийн ажил урьд өдрүүдийнхээс ер ялгагдах юмгүй хэвийн байдлаа эхэлж билээ. Шөнийн гуравдугаар ээлжинд ажилд гараад байв. Уурхайн гүнд орсон хойно өдөр ч байна уу, шөнө ч байна уу ялгагдах нь үгүй ч ажилд ороод удаагүй байсан болохоор шөнийн ээлжинд ажилд гарахлаар шөнө дундаас хойхно нэг хэсэгтээ нойр харанхуйлан нүд аргаж хачин болдог нь шинээр уурхайчин болж буй ихэнх хүнд тохиолддог гэж би боддог. Ажил эхлэхэд Жав багш бид хоёр баруун хээрийн цооногт жаран хоёр тэргэнцэр аваачиж тавилаа. Нүүрсний мөрөгцөгт ажил урагштай байгаа бололтой удаж түдсэн ч үгүй цооногт нүүрс ирж эхэллээ. Ийнхүү байж байтал Жав багшийн цооногийн дэргэдэх утсаар дуудлаа. Онхолдуулагч дээр багшийн хэрэг гарсан байв. Багш явахдаа,

За хүү минь тойруулга болоод зөрлөгүүдээр өнгөрөхдөө тун анхааралтай яваарай гэж над захилаа. Би толгой дохин үлдэхдээ багш маань «хаяагаа манаж» байгаа юм шиг юун ч илүү үг хэлнэ вэ. «Намайг хөдөөнөөс ирсэн чигээрээ толгойны эргүү нь гараагүй амьтан гэж бодсоор байгаа юм уу даа» гэсэн бодол гэнэтээр гялсхийн төрсөн авч дорхноо замхарч билээ.

Дөрвөн цаг өнгөрч байхад жаран хоёр тэргэнцэртэй нүүрс чирээд цахилгаан тэрэгнийхээ бүхээгт суун хөдөллөө. Малгайдаа чийдэн гялалзуулж, ажлын багаж зэвсгээ барьсан уурхайчид, уурхайн агаарын найрлагыг шалгадаг, гартаа тусгай дэнлүү барьсан агааржуулахынхан хааяа хааяа замын хажуугаар өнгөрөх нь харцнаа тусна. Би цахилгаан тэргээ жолоодон амандаа дуу аялан жирийлгэж явлаа. Намайг ингээд явж буйг нутгийнхан маань үзвэл яасан ихээр сүйд майд болцгоох бол? Амьд явбал алтан аяганаас ус ууна гэгчээр ийм техник жолоодоод газрын гүнд орчихсон давхиж явна гэж хэн зүүдлэх билээ? Гээд л шуугицгаана даа гэсэн нэг ёсноо бяцхан бардамнасан бодол цээж түрэн би гэдэг данагар эр сэтгэлээрээ жигүүрлэн дүнгэнүүлж яваад яах ийхийн завдалгүй нэг мэдсэн замаасаа гарчихав. Хамгийн анхны тойруулга дээр л маданд орчихсон байж билээ хөөрхий.

Үсчин охин зүүн чихний мин омогны дээрх үсийг сэтгитэл нь өм цөм авчихсан учир өөрийгөө том толин дотроос харахад тун ч инээдэмтэй болсон байлаа. Профессорын найрсаг зангийн учир үүнд байжээ гэсэн бодол төрнө. Охин ямар ч л атугай үсийг чинь тайрч

гүйцэхэд нь би гамбагар улаан сандлаас босч,

-Их баярлалаа гэвэл охины уруул хөдлөх төдий болоод буруу харав.

Хувцсаа өмсөж байтал Улаан хамарт ч гарч ирлээ. Тэр солгой гараа дээж даялуулан өргөж бугуйн цагаа сөлийн харснаа, цагтаа амжсанд ч юм уу, эсвэл үсээ сайхан засуулсандаа ч юм уу, үгүйбээс намайг араар тавьсандаа ч бахархсан юм уу, үгүй бол өлгүүрийн үйлчлэгч бүсгүй аятай харагдсанаас ч тэр үү ер нь л үл мэдэгхэн байдлаар мушилзан инээмсэглэнэ. Хувцасны өлгүүрийн хажуугийн хананд хадсан том тольруу харан тэндээс өөрийгөө олж харах зориг хүрэхгүй нүд дальдарч байвч би бас л сэтгэл хангалуун байдлаар инээмсэглэлээ. Ийнхүү инээмсэглэсний минь учир гэвэл тааралдаж байсан ч гэлээ танихгүй чамайг ясанд чинь хүртэл таньдаг боллоо гэж Улаанхамартын тухай бодсоноос, үс гэдэг нас байсан цагт ургадаг юм хэмээн сэтгэлээ тайтгаруулснаас, аливаа анхны алхам хийхэд бүдрэх нь байдаг юм хэмээн өөрт тохиолдож өөрийн эндэж бүдэрч байсан явдлуудын хаа нэгийг дурсан санаснаас үүнээс үүдээс үсчин охиныг уучлах учиртай юм гэж бодсоноос билээ.

ЖАМСРАНГИЙН ЛОДОЙ

Зохиолч Ж. Лодой 1918 онд Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт малчны гэрт төржээ. 1950 онд Намын дээд сургууль төгсжээ.

Уран бүтээлээ 1946 оноос эхэлж «Хавтгай цагаан Улз», «Бүрхэг шөнө», «Намын хүний үг» зэрэг шүлэг, өгүүллэгийн ном, «Хурим», «Хувьсгал», «Ариун сэтгэл» зэрэг олон тооны жүжиг бичжээ.

КОМСОМОЛ ХАНДАМ

Нэг

Мянга есөн зуун хориод онд монголын зүүн хойд хязгаараар цагаан Бароны цэрэг орж нутгийн элдэв буруу санаатнуудтай эвсэлдэн ард олныг үймүүлэн бусниулж байтал хойд газраас Оросын большевикууд ирж ард зон адуу мал аль бүхнийг авран хамгаалж байсан үймээний өвөл билээ. Ар өврийн олонд Монголын Хөх Уул гэж алдаршсан өргөн дэлгэр тахилга бүхий өндөр цэнхэр уул өвч бүрхсэн цан хүүргээ өвлийн шөнийн цагаан шаргал сарны дор гялтгануулан дүнхийнэ.

Уулын ар хормойгоор тогтсон Орос, Монголын хилийн дагуу зүүнээ урсагч Ималх голын өтгөн шугуй бараантан Хөх уулаас хойш буусан гүн хар жалга энэхүү шугуйн өмнө талаас золгожээ. Орос буриад хөвгүүдээр бүрдсэн большевик цэргийн нэг салаа уул жалгын модонд түр байрлаад, энэ хавийн газрыг андахгүй нэг залууг дэргэдээ авсан салааны дага Виктор гэрийн дайтай том чулуун овоог налан орчны анир чимээг чагнана. Удалгүй үүр цайж хараа цуцаам нэлэнхүй цагаан тал дээгүүр нарны цацрал цухуйлаа. Алсаас ажихад өндөр биш юм шиг хэрнээ холын барааг ажихад харууц сайтай уул юмаа гэж даргынхаа лавлахад энэ ууланд олон удаа гарч овооны наадамд хэд дахин барилдсан нутгийн хөвгүүн Дугар,

-Бас л өндөр уул юм. Орос монгол хятад гурван улсын хилийн уулзвар орчмын газрууд ил байна. Жишээлбэл хойшоо гэхэд хаа гол байгаа Алхана уулаас авахуулаад Хангилын шил, Харганаачийн тал, Цэрэг нарс цөм ил шүү. Зүүн ба зүүн урагшаа Холбоо хоёр Тарь нуур, алган дээрхээс ялгаагүй харагдахаас гадна сайн дурангаар тунгалаг өдөр Манжуурын станцыг ч харж болно гэлцдэг юм. Баруун урагшаа бол хангай, талын зааг болсон Хөгнийн шил, Угтам уул, Улзын голыг үзэж болно гэлээ.

-Тун ашигтай байх юм даа. Хандам охин ирэх шөнө аль чигээс холбоо барих вэ? Гэж даргынхаа асуухад залуу,

-Тэндээс хэмээн баруун урагшаа зааснаа, Дөчийн голын чигээс гэж давтан тодруулаад амсар талыг нь улаан эрээн хоргойгоор эмжсэн хөх чисчүү уутнаас хятад шар тамхи чимхэж ягаан гадартай эсгэмэл цаасанд чадмаг гэгч ороов. Нутгийн малчин эмэгтэй гэхэд эрэмгий зоригтой моринд сүрхий сэргэлэн охин шүү гэж Хандамын тухай бодож суусан Викторын,

-Танай монголын харуул, хошууны зааг газар эндээс хол уу? Гэхээр,

-Гайгүй ээ, Улз голын хойд энгэрээр «Заагийн овоонууд» гэж байдаг, тэр овооноос хойших нь харуул, урагших нь хошуу нутгийн газар.

-Ойлголоо гээд орос дарга ойр холыг хянамгайлан дурандав.

Хоёр

Дөчийн голын баруун бие дэх өнчин хүрэн толгойн энгэрт Дорлиг харуулынхны өргөл мөргөлийн төв «Дорлиг дуган» хэмээх ганц модон байшин тойрсон хэдэн бор гэрүүдийн нэгэнд зулын бүдэг гэрэл сүүмэлзэж, лам хар нийлсэн дөрвөн хүн аминчлан зөвлөлдөхийг нь чагнавал,

-Буриад оросын буруу номтнуудтай ороолдсон бузар өлөгчин тэр эмийг барьж мөрдөх нь зөв гэж зүүн хоймрын олбог эзэлсэн пяглагар шар ламын шанаагаа оволзуулан шүд зуухад дөл нь замхарсан галтай төмөр тулганы баруун биед завилсан ширүүн хар сахалтай хижээл эр тосч авангуут:

-Ай даа, энэ тань л оносон үг биз. Түүнээс биш тэрний цаадах большевикууд гэдэгтэй та бид тулалдаж мөргөлдөөд юу шалих вэ. «Комсомол Хандам гээч шулмас хаанаас гэнэтхэн хараад ирэвээ» гэхэд түрүүний лам:

-Чөтгөр бүү мэд. Хөх уулын хүчит эзэн шар цоохор хөлөгтнөөс сахиусаар уламжлан сурья байз гэв. Тэгтэл мухар толгойтой мөртлөө хөх даалимбан дээлтэй харимаг насны хүн өвөр дээрээ тавьсан үйсэн бариулт том хутгаа базлан байж ламын зүүн гар талаас:

-Комсомол гээшимнай ер нь юу гэсэн үг юм бэ? гэсэн асуулт тухайлсан эзэнгүй тавихад нь

-Тэр үү? Тэрнийг ч мэдэж ядах юу байж билээ. Хоноц муутай эм гэсэн утгатай үг гээд лагс биетэй лам зулын ардах зурмал Балдан Лхамыг ширтэн өрөөсөн гараараа өвчүүндээ наминчлав.

Хар сахалт хамниганы хажууд хорь гаруй насны залуу Зодов гэгч чих тавин чимээгүй суух зуураа «Хандам ч уг нь уян налархай, үг цөөнтэй хүн. Ийм хатуу ширүүн явдалтай арай ч холбогдмооргүй юм даа. Харин аавыг нь Агын дүмд хэлмэрч байснаа германы фронтод явж ирсэн, архи хөзрийн эзэн элдэвтэй хүн л гэлцдэг байх. Эд нар тэрнийг бариад ч яах юм ширүүн сахалтыг чинь тун чанга ясны хүн гэж дуулсан юм байна. Хамниган хасаг цэрэгт явах үедээ орос японы дайнд оролцож болон хүний тархиар хүзүүний зүүлт хэлхэх шахсан гэдэг юм билээ. Ламтан гуайн хувьд ч яахав. Эр банди, иргэний мах, өргөл барьц үхэл зовлон дөрөв байвал болох нь тэр» хэмээн бодож байтал хажуунаас нь хар сахалт гэнэтхэн,

-Зээ Зодов хөвгүүн чамайг л гэж сонголоо бид. Туг барьдаг тугчхан үзэж хянадаг үзээнгүүд, гүнд нь явдаг гүнийхэн гэж дуулаасан гүүш? Чи одоохон яваад Комсомол Хандамыг хөтөлж авчир. Хөлс шанд нь хурим төрийг чинь бид бэлтгэж хийлгэж өгнө шүү. Хайран сайхан тэр амьтнаа харь оросын хар салтаанд хавчуулж алах гээгүй бол хамгаалж салгаж авахыг бод. Ойлгов уу чи гэж тулгадаг юм байна. Хоймрын лам хүүгийн хариуг ч хүлээсэнгүй,

-Хандам та хоёрын хайр сэтгэл, хувь тавиланг ч мэднэ. Харин эцэг эх нь хорьж боодог юм гэнэ билээ. Тэднийг ч болиулж болно гэлээ. Тулганы зүүн биеийнх толгой дохихоос өөр үг нэмэрлэх эрхээр ч тааруухан бололтой. «Гэрээс гараад хэд хоносон тэрнийг би одоо хаанаас ч олох юм билээ? Оллоо авчирлаа ч гэсэн бид хоёрыг та нарын гэрлүүлэх ч ёстой гонжийн жоо голионы сүүл байгаа даа. Бас «Бузар өлөгчнийг барьж мөрдөх нь зөв» гэлцэж байгаа

мөртөө юү. Амьтны үрийг тэгж тамлуулахаа ч больё доо. Аа харин энэ далимаар хаагуур яаж яваагий нь сайн заалгаж аваад тэр орос морсоос нь салгаж зайлуулахыг бодохоос биш. Тэгье гэхэд тэр миний үгэнд орно уу даа үгүй юү бүү мэд. Хэрэв таарч тохиолдвол тэр хэвээрээ л зайлж холдох нь зөв байх. Аль эсвэл энд авчраад үздэг юм уу. Ээ дэмий байхаа, Хандам надад хайр дургүй ч хүн биш л дээ. Харин хааяа Баян айлын бардам хөвгүүнтэй би яаж тэнцэх вэ? гэдэг л юм. Одоо манайхаас ч илүү баян ноён оросын урхинд орсон байлгүй. Олж аваад үг хэлээр болохгүйд хүрвэл өөрийн ч биш, хүнийх ч биш болгоод хаячихана даа муу цусыг» гэхчлэнгээр Зодовын сэтгэж суутал хар сахалт хамниган:

-Чихтэй амьтай юмаас чи дуугараач. Чамайг явуулдагийн учир болбол хөөрхий тэр хүүхдийн амь биеийг л анхаарсан хэрэг. Хэрвээ хүчээр авья булаана гэвээс хурдан буутай, хурц зоригтой хөвгүүдийг хорь гучаар нь ч морьдуулж болох байна гэж сүрдүүлэхэд Зодов:

-За би явья даа. Харин хаанаас хэзээ яаж болохоо хараахан хэлж чадахгүй нь гээд алгаа хавсран бөхөлзөхөд:

-Чадах л хэрэгтэй болно доо. Очих тосох газар цагийг би зааж чамд буу зэвсэг ч бариулна. Харин хоёр хоногийн дотор багтааж авчрахгүй бол хожим өөрөө эвгүй явдалтай учирч магадгүй гэж мэдээрэй. Хар дээлтэй шар лам чи хамт явалцана ууч хэмээн ширүүн сахалтын нүдээ үзүүлэхэд тулганы зүүнтэйх мухар толгойт:

-Ээ ноён ахай минь, хайрлаж үз. Түрүүний тань зарлигийг л ёсоор болгон гүйцэтгэе гээд тонголзох үедээ «Тавхайн Дугарт очоод большевикийн эсрэг буудалдаанд тавин хөвгүүд туслаач. Би Баяндалайн сууринд буу зэвсэг бэлтгээд хүлээж байя» гэж үүний өмнөхөн өгсөн тушаалыг нь сэтгэлдээ шивэгнэжээ.

Гурав

Большевикууд хэл мэдээ хүргэхээс нь өмнө очих замд нь өрсөж бариад авчир. Биед нь бичиг цаас байвал үгүй хийж болохгүй гэсэн тулгалт Дорлиг дуганд үүрлэгчдээс авч мордсон Зодов авар тавар модны ёроол дахь сарны сүүдрээр морио хөтлөн явснаа өвдөг нугалан ийш тийшгээ хараачилна. Нөгөө талд комсомол Хандам явган бургастай нарийхан хөндийг өгсөхөөр ширүүхэн гарч ирснээ мориныхоо амыг татан түр саатах зуураа улаан мяндсан залаатай цагаан хурган малгайныхаа бүчийг тайлж ойр хавийн анир чимээг чагнавал алс холгүй бололтой чонын улих сонсогдов. Хэд хичнээнийг бүү мэд, бүдүүн нарийн өнгөөр баахан л амьтад улилдана. Чихээ хайчлан сэрвэлзсэн омголон мориныхоо байж ядан эргэлдэхэд суудал засан бүчээ бүчилсэн охин чонодын улсан чигт шулуухан цогиуллаа. Хүрэн хээр ч хазаар даран тэмүүлж, хар туурай хэтрэм зөөлөн цас ч сарны саруулхан туяанд цагаан тоос шиг манарна. Тэгтэл уул хөндийн эх хавьцаа угтаж тоссон Зодов өрсөн харангуутаа «За тэр мөн шүү» гээд хэсэг хус руу нуугдав. Тэгвэл Хандам уул хөндийг өгсөлгүй хажуу хярыг дагаад Зодовоос нэлээд зайдуу өнгөрөхөөр давхилаа. Ямар ч болсон амдаж уулзахаар ухасхийсэн залуу хар хушууны ар ёроолоор хөндлөнгөөс нь ойртоод «Хандамаа. Хөөш Хандамаа» хэмээн бачимдуу аргагүй дуудтал эгшин зуур зогтусан ажигласан охин чиг буруулан давхиж Зодов ч морины хурдаар хөөлөө. Чонодын улилт ч мартагдаж санаж зорих ганц зүйл Хандамын хувьд

Хөх уулын большевикууд. Зодовт бол Хандамыг л гүйцэж барих явдал байв.

Алсаас өргөгдсөн намжаа уулын өргөн хормойн өгсүүрийг ч хэлэх үү. Зодовын халиун эхлээд овоо ойртож очсон авч яваа яваандаа хаягдахад үүрч явсан бирданаа шүүрч аван хоёр ч удаа буудсан сураг алга. Юу ч бол унаанаас нь салгаад авах юмсан гэж Зодов үглэн мориныхоо гүйдэл дунд үсэрч буунгуугаа гуравдахаа буудтал Хандамын хээр эгц өөдөө нэг цоройж боссоноо цас манаруулан онхолдлоо. Зодов тэр дорхноо давхиж хүрэв.

-Аа чи юу? гэсэн Хандамын хорсол заналын оч бутарсан нүд хөлөг мориныхоо савлаж байгаа толгойг илэн байж мөнгөн хазаарыг нь мултлах зуур түүн дээр тусав.

-Хандам минь Хандам минь. Би чинь чамайгаа танилгүй, золтой л юу яачихсангүй. Ээ халаг, хайран морь гэсээр Зодов бууж ирэхэд:

-Танилгүй гэнээ? Танихгүй байж нэрээр минь дуудаа юу чи?

-Явья Хандамаа. Цаана чинь цагаантнууд айсуй. Сундлаад ч болсон холдье.

-Хаашаа?

-Зүүн урагшаа. Манжуурын чигт манайхан нүүсэн.

-Өөрөө тонил, одоохон арил эндээс.

-Яалаа гэж дээ, хайрт минь. Чинийхээ амийг би аврахгүй бол үзэж харах өөр хүн хаа ч алга болсон шүү дээ. Чи аль хүрч яах гэж яваа чинь энэ вэ?

-Ималхын гол, өвөг аавындаа очье.

-За тэгвэл хамт явья, алив морд. Тэгэхдээ харин Тарь нуурын баруун биеэр тойрч очихгүй бол хөх уулын хавь хөл үймээнээр дүүрч тэнд байсан улаантнууд цөмөөрөө сүйрсэн.

-Юу? Нээрэн үү? Хэзээ тэр вэ?

-Өнгөрөгч орой. Ёстой ёрын муухай явдал болсон доо. Хэл авалцахаар чамайг ирнэ гэж хэн чөтгөр нь цагаантанд хов хүргэсэн юм бэ, хэсэг морьтон уулыг бүслээд өөрийг чинь барихаар тосч байна. Тэднээс өрсөж чамайгаа аврахаар миний угтаж яваа царай энэ. Аврахаа ч алд даа. Үйлтэй хар толгой энэ хээр газар унаанаас нь салгадаг байна шүү. За яахав амьд гарч байвал арга бий. Тиймээ Хандамаа?

-Яасан азгүй явдал вэ? Хайран морь хайран хүлэг минь гээд Хандам морио тэвэрч эхэр татан уйлав.

-Аргагүй ээ. Хайрт минь. Одоо яая гэхэв. Арван адуугаар ч хамаагүй би л төлж өгөх ёстой боллоо. За тайвширч үз. Эндээс одоохон зайлж буцахгүй бол бүгдээрээ баригдаж бүрмөсөн сүйрнэ гэсэн үг. Алив явья, бушуул бушуул.

-Би явахгүй ээ. Эндээ л өнгөрье.

-Уухай. Алтан дэлхийд ганц удаа заяасан аминдаа хайргүй тэнэг толгой. Чиний мэддэг ч одоо өнгөрсөн байхаа гээд Хандамыг авч өөрийнхөө морины эмээл дээр суулгах гэтэл морь нь үргэлж Зодов золтой л цулбуураа алдсангүй.

Дөрөв

Зодов эмээл дээрээ, ард нь Хандам сундлаад алхуулж явах үедээ эмээлийн хойд олом жирмийг сэмхэн гэгч суллаж амжлаа. Хойно нь яваа хүнд урьдах олом тайлна гэдэг үнэхээр холдож байв. Сэжиг авахуулж болохгүй нь мэдээж. За байз яая даа? Одоо ховх түлхчихлээр эмээлээ дороо авсан морь учраа алдаж бид хоёр цуг ойчоод бүр аль ч үгүй болдог бол уу? Үдаж буутай юм. Манай большевик ах нар заавал угтаж ирэх учиртай. Ингээд яваад байхлаар очих газар улам л холдоно. Уул хавийн улаантан цөмөөрөө сүйрсэн гэж хэлэх үг энүүний аманд яаж багтана вэ? Юу ч болсон сумнаас нь салгая гэж шийдсэн Хандам Зодовыг тэврэн шогшуулах завсраа бүсэлж явсан дайзтай сумыг нь тайлж аваад харанхуй хар ширэнгэ рүү чулуудав.

Хандам чи хайр сэтгэл гээчийг мэддэг л гэдэг. Ханилж суухаа ч бид хоёр бишгүй ярилцсан. Гэтэл чи сүүлийн үед яахаараа чигээ хувиргаж зүгээ буруулах болсон билээ байз?

Юу гэнээ? Иймэрхүү үгийг хэн маань хэнээсээ асуумаар юм бэ дээ? Унаган ганц хүлгээ чамаар алуулж эзгүй хээр явгарчихаад очих гэсэн аавындаа очилгүй эцэс сүүлд нь чиний хэлсэн зүг чамтай тэврэлдэж яваа минь хайр сэтгэл биш хар санаа болж байна уу Зодов оо?

За за нээрэн ч тийм дээ. Больё больё гээд гэдрэг эргэж худлаа инээснээ Зодов “Энэ учирлын тухайд эрхээ алдаж миний гарт орсноо ингэж бас эргүүлдэг байх нь ээ. Овжин чөтгөр шүү. Эсхүл үнэхээр итгэж хууртсан ч байж мэднэ. Аль нь ч байв. Өөрийн аманд орсон шар тосыг өрөөлийн алган дээр тавихгүйгээ аавын хөвгүүн бас мэднээ. Тэр учраас ч Дорлиг дуганы долоон хотнуудад үүнийг аваачиж үйлий нь үзэхээ ч больё. Тэгснээс холын нүүдэл бараадаж цагийн эрхийг дагавал дээр вий” гэж бодно.

Ёо ёо дороос нухаад яасан ч зовлонтой юм бэ дээ.

Тэр тэгнээ. Чи урьд нь уна л даа. Алив буу буу.

Тэгдэг юм уу. Чинийх ч гэсэн шалбарчихна даа. За яахав ойр ойрхон ээлжилж яваад очихыг бодё гэсээр буусан Хандам:

Ээ харла. Хойд олом маань алдуурчихаж.

Өө золиг. Эмээл даанч урагш болоод байсан юм. Үгүй мөн өөрөө мултардаг олом жирмийг өнөө шөнө л үздэг юм байна. Юу гээчийн муу ёс вэ. Аль эсвэл чи суллагчигсан юм уу? Энүүнийг тайлахаасаа өөрийнхийгөө шувгалбал болоо биз. .. тийм үү комсомольская

Хандамашка? Гээд хүзүүдэхээр нь Хандам:

- Дэмийрэлгүй наадхаа бушуу янзалаа. Энэ хар хүйтнээр тэр маань ч ямай

- Ёстой зөв шүү. Халуун гэртээ очоод ханахаа үзнэ дээ хонгор минь. За морд морд, өвгөн нь араас чинь жаал жигнээд өгье.

- Даарч яваа намайгаа дулаацуулж тусалбал сайн л байна гээд жолоо цулбуурыг нь авч мордсон Хандам Хөх уулын зүг харвасан сум шиг давхилаа. Шагайгаараа татсан цасан дунд явган хоцорсон Зодов сандрахын эрхээр хэдэнтээ муухай хашгираад буугаа шүүрэн буудах гэтэл сум алга. Буунд ч алга, бүсэнд ч алга. Зодов хараал тависаар, Хандам хурдлан давхисаар нэгэн хөтөл дээр гартал большевик дарга, буриад хөвгүүн хоёр өөдөөс нь тосон давхиулсаар уулзах нь тэр.

- Яав Хандам аа? Юун буу хаа дуугарав? Гэж даргыг асуухад

- Тэнд гэж охин заасан газра нөхөдөө дагуулан ирээд

- Энэ миний морь. Алсан эзэн нь тэнд яваа гэхэд Виктор дарга наганаа сугалан атгаж Дугар хөвүүн үүрсэн буугаа гарлан давхисаар бургасан дундах хунгарт бүдчин зугатаж яваа Зодовыг бүслэв.

- Уухай. Зайсан баавайн ховууч хөвүүн Зодов гуай морилж явах шив гээд орос даргын туслах залуу винтовоороо Зодовын малгайг хуу татах үед Хандам найман салаа гээгнийхээ угаас нарийхан хуйлсан цаас даргад барихдаа

- Манайхны өгсөн мэдээ, гээд ялдамхан мишээлээ.

- Баярлалаа, дүү минь. Маш сайн байна. Таны энэ эрэлхэг шударга үйл хэрэг манай хувьсгал хийгээд та бидний ах дүү ёсны хань холбооны түүхэнд үеийн үед мөнхжин дурсагдах болно. Та бол жинхэнэ комсомол мөн, гээд орос дарга уяран хайлсан нүдээр инээмсэглэн талархах ажээ.

Сумгүй буутай, толгой нүцгэн Зодовыг цаст өвлийн ширүүн шуурга өөд даргын туслах Дугар тууж, комсомол Хандам, большевик дарга хоёр хортонд алагдсан хүрэн хээрийн нуруунаас шунхан улаан будагт эмээл салгаж аваад Зодовын халиунд тохож байгаа харагдана.

Сар дээр хөөрч, тэнгэр хойноосоо цэлмэж одод гялалзана.

ПЭРЭНЛЭЙН ЛУВСАНЦЭРЭН

Авъяаслаг зохиолч агсан П.Лувсанцэрэн 1933 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутагт төржээ.

1944 оноос бага, дунд сургуульд суралцаж 1967 онд Москвад М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгсжээ.

Уран бүтээлээ 1962 оноос эхэлж «Нар шингээгүй», «Ус шиг цэнхэр», «Хаврын шувуу», «Мөнгөн аяга», «Сарны сонат», «Нүүдэл» зэрэг олон өгүүллэг «Хөдөөгийн дуун» тууж бичсэн нь «Нар шингээгүй», «Оддын дор», «Хаврын шувуу», «Усны эргүүлэг буюу Борзооны явдал» зэрэг ном болон хэвлэгджээ.

УУРЛАХАД УЧИР БИЙ

Би ширээн дээр тохойлдож шанаагаа тулаад юм ч хэлэлгүй хөдлөх ч үгүй хэсэг суулаа. Юм хэлбэл буруудна. Эхнэрийнхээ уурыг нэг хүргэсэн хүн уурыг нь гартал өөрийгөө зөвтгөх гэж хичнээн ч ухаантай оролдоод дэмий байхаа.

Уг нь ийм яльгүй юмнаас намайг ингэж зэмлэх хэрэггүй байсан юм л даа. Дөчхөн төгрөгнөөс шүү. Яахав, олоо л биз, уугаа л биз. Намайг иймхэн юмнаас ингэтэл байцааж толгойг нь гудайтал загнаад яах нь вэ? Амьдрал чинь ямар дээсэн дөрөөн дээр яваа биш.

- Төгрөг нь яахав. Архи уусанд чинь ингэж байна гэж байна. Энэ зөв өө. Яриангүй. Гэхдээ би үргэлж ууж согтуураад яваа биш шүү дээ. Биеэ өмгөөлөх гэж байна гэж бодов. Юманд бас учир бий. Би өнөөдөр цалингаа авлаа. Бас хамт сурч байсан нөхөдтэйгөө уулзлаа.

- За уулзсаных хэдүүлээ нэг хоол идэх юм бишүү гэхээр нь би “Дэмий байхаа, эхнэр уурлана” гэж хэлж чадсангүй. “Тэгье, тэгье” л гэчихсэн юм. Уг нь ч дотроо дурамжхан л байсан юмаа. Гэсэн ч нэгэнт “За” гэснээс хойш хоцроод яахав, нөхдийнхөө түрүүнд орчихоод “эндхийн хоол муу, тэндхийн хоол сайн” гэж идээ зоогийн газруудаар үргэлж явдаг, андахгүй мэддэг царай гаргаж худлаа ярьж яваад “Залуучууд гуанзанд” орчихсон юм. Нөхөд маань хөдөөнөөс ирсэн би бол аймгийнхаа төвд суурин суудаг хүн болохоор тэдэндээ бас хоторхох санаа байлаа. Баянхонгор маань хэдийгээр төвхнөж тохижиж гүйцээгүй ч гэсэн гаднаас орж ирсэн хүнд бол аргагүй л шинэ цагийн боловсон сайхан хот юм шүү дээ. Олны үзвэр үйлчилгээ тохьтой, дэвсгэр газар, орон барилга, хүмүүсийн төрх галбир юм бүхэн цоо шинэ. Энүүгээр гоц содон, нөхөддөө бахархаад үзүүлж явууштай санагддаг юм.

Энэ бодлоо ойлгуулах санаатай би:

- Чи юмны учрыг ойлго л доо. Үзмээ минь нөхдөө хүн хэзээ ч хүндэлж явах хэрэгтэй. Тэднийг хайхрахгүй байж болохгүй байна шүү дээ гэж эхнэртээ хүлцэнгүй дуугаар хэллээ. Миний энэ үгэнд Үзмээгийн уур нь улам ч хүрч байгаа бололтой.

- Хн, Архичингуудад шалтаг хаана мундах билээ дээ. Уух л бол шалтаг бэлэн байдаг юм чинь гээд тэр над руу ширэв татав.

Архичин гэнэ шүү, бурхан минь. Би хэрэлдэхгүй ээ. Эмэгтэй хүн ямаан омогтой ч гүйхэн бодол гэнэхэн сэтгэл нь уучлууштай байдаг юм.

Юмны учир таниагүй балчир явах цагт амьдрал гэдгийг мөн ч тунгалаг сайхнаар санаж явдаг байж дээ. Адгийн наад зах нь ийм яльгүй юмнаас болоод хэрүүл маргаанд хүрч, хэрэг төвөг гаргачихсан юм шиг бодолд автаж сууна гэдгийг онож санаагүй явсан юм. Хүний амьдрал нэгэн бодлын маш урт мэт санагдавч нөгөө талаар бодоход бас ч тийм хязгааргүй зүйл биш шүү дээ. Сэтгэлд нийцсэн ханиа олох, анхныхаа хүүхдийг төрүүлэх, баатарлаг гавьяа байгуулах зэрэг сэтгэл догдлом үе хүний амьдралд өдөр болгон тохиолдоод байдаг биш. Дор бүрдээ эрхэлсэн ажлаа хийж аар саархан гэмээр юмтай хөөцөлдөж “Хоног сар гэдэг мөн ч түргэн өнгөрөх юм даа” гэж үглэж гайхсаар яваад нэг мэдэхэд хүний амьдралын ихэнх цаг өнгөрчихсөн байдаг. Нэгэнт амьдрал тийм болохоор төдийд өдийд жаргал ирнэ гэж хааяа

гялсхийн өнгөрөх азтай одтой мөчийг хүлээж сэтгэлээ хуураад яанаа? Амьдралд үнэхээр дуртай хүн бол өдөр тутмынхаа амьдралд байгаа сайхныг танин харж сэтгэлээ хөгжөөж цаг зуурын өчүүхэн юмнаас болж амьдралынхаа ганц ч болов мөчийг хиртээхгүйсэн, амьдралын өгөөмөр сайхнаас аль болохоор ихийг олж үзэхсэн гэж хичээж явууштай байна шүү дээ.

Үзмээ, ийм яльгүй юмнаас ингэж уруу царайлж суугаад яахав дээ. Аятай сайхан амьдрахаа бодохоос өөр юу бидэнд хэрэгтэй юм бэ? гэж би эхнэртээ их аятай зөөлнөөр хэллээ.

- Архи ууж явахыг сайхан амьдрал гэдэг юмуу?

- Чи юмны учрыг бас ойлго л доо. Ямар хүүхэд биш

- Ойлгож ядаад байх юу байгаа юм?

Ингээд бид хоёр яриа таардаггүй.

Хүүхэн хүн нэг уурлахаараа юм эргэцүүлж боддоггүй, амандаа л орсон гашуун хорон үг бүхнийг дуустал нь хэлж байж нэг амардаг шиг байна даа. Яая гэхэв. Байгалиас ч тэгж заяагдсан юм билүү. Эмэгтэй хүнийг ингээд нэг уурлахаар ч шуурга намдтал түр зугтаахаас дээр арга байдаггүй бололтой.

Эсхүл “Миний буруу, энэнээс хойш л больё” гэж өвдөг сөгдвөл санаа нь нэг амарч уужирдаг байх. Би тэгж чадахгүй. Эр хүний бардам зан гэж нэг юм бас надад байна. Хэрэв л би тэгж буруугаа ил хүлээх юм бол өнөөх Үзмээ чинь нэг найздаа очоод л “Ганц сайн буулгаж авлаа даа, хөөрхий” гэж ид хав болгоод л бурж гарна. Тэр нь ам дамжсаар таньдаг хүн бүрт хүрч хүүхэн чавганцын доог болоход хүрдгээ. Ингэж явснаас аятайхан шалтаг олж хэлээд гараад явчихвал дээр шиг байна.

Үзмээ орон дээрээ сандайлчихсан над руу үе үе муухай хараад л сууна. Би уртаар санаа алдаж дотроо ямар нэгэн чухал асуудал шийдчихсэн байдал гаргаад:

- За энэ ч яахав мах дууссан. Би урд дэлгүүрт очоод ирье гэж хэлээд сэмхэн босож гадуур хувцас руугаа мяраалаа. Үзмээ юм ч хэлсэнгүй орон дээрээ суусаар л хоцорлоо.

Би босго давмагц эргэж үүдний завсраар сэмхэн шагайж хараад санаа уужирч гудамжинд гарлаа. Сайн өдөр болсныг хэлэх үү, хавар болж байгааг хэлэх үү, эв сайтай эр эм хоёр бол ёстой алхаа нийлүүлээд энэ тэрийг ажиглан гүвэр гүвэр ярьж явууштай налгар өдөр байв. Хамтраад гадагш гарсан бол Үзмээд өөрт нь аштай байх уу даа. Тэгэхэд одоо тэр орныхоо ирмэг дээр жондойтол суучихсан, чамайг яая даа, гэж муу юм бодоод нэг том хүйтэн юм бүхлээр нь залгичихсан юм шиг сэтгэл нь зөгийж суугаа, энэний нь бодохоор бас ч өрөвдмөөр.

Надад хайртай дуртай санаа сэтгэл нь хэвээрээ, одоогийнхоо амьдралд сэтгэл гонсойсон юм байхгүй, өнөөх урьдын Үзмээ, миний эхнэр гэж бахархаж явдаг тайранхай хар үстэй Үзмээ хэвээрээ л байгаа юм шүү дээ, уг нь. Би ч гэсэн хувирсан юм алга. Гэхдээ л бид хоёрын сэтгэлийг тун яльгүй бараг цаас шиг нимгэхэн гэмээр юм л түр ч атугай холдуулж хөргөж

чадаад байх юм даа. Өөрсдөө бий болгосон тэр нимгэн юмыг гар нийлүүлж цуу татаж хаячихаад халуун сэтгэлээр нүүр нүүрээ харан инээлдэж яагаад болдоггүй юм бэ?

Ер нь бид өргөс шиг өчүүхэн юмнаас сэтгэлээ зовоож явах, нэг бодлын дэндүү ч янгууч улс юм даа. Хүн юуны төлөө хэлтэй билээ, больё эвлэрцгээе гэж цаг алдалгүй түс тас ярилцаад эвлэж яагаад болохгүй байхав.

Би энэ бүхнийг бодож хажуугаараа зөрж өнгөрөх хүмүүсийн царай өөд ч харалгүй гэлдэрсээр дэлгүүрийн үүдэнд хүрч ирлээ. Үзмээ намайг гарахад уурандаа барьж авч саад хийсэнгүй гэж гэрээсээ гарахад олзуурхан баясаж явсан маань дэлгүүрийн үүдэнд ирээд бодтол бас биш боллоо. Мань эр хийсэн хэргээ цагаатгаж, намайг аргадах гэж дэлгүүр рүү гүйлээ гэж Үзмээ намайг тохуурхан бодож суугаа байх. Аягүй бол миний хойноос цонхоор хараад бах нь ханасан царайгаар дооглоод инээж байсан ч юм билүү. Ингэж бодохоор би үнэхээр зэмлүүлж гэмшвэл зохих хэрэг хийчихээд гэмшсэндээ Үзмээд тал засах арга ядаад ч яваа юм шиг. Би ямар хэрэг хийсэн юм бэ? Өөрт минь огт буруугүй санагдах ийм жаахан юман дээр би түүний өмнө уучлал гуйсан шинж үзүүлбэл хоёрдох гуравдахь удаагаа үүнээс ч өчүүхэн юман дээр буулгаж сөгтгөх гэж загнадаг. Эмэгтэй хүн бол хаданд авирч яваа ямаа шиг яваад л байж болбол ахиад л байх санаатай гэж миний нэг найз хэлсэн.

Ямар боловч би буруугаа хүлээж аль нэг хэлбэрээр уучлал гуйсан шинж үзүүлэлгүй байж, амьдралаа холбосон хоёр хүн бие биедээ хянуур ялдам сэтгэлтэй байх хэрэгтэй, зохих үед бие биеэ уучилдаг байх хэрэгтэй гэдгийг Үзмээгээр өөрөөр нь ойлгуулж, уурыг нь гаргуулбал зохино гэж шийдээд гудамжаар цаг хиртэй зугаалж мах ч авсангүй буцаж ирлээ. Энэ маань Үзмээгийн уурыг улам хүргэх шалтаг болсноос биш ямар ч тус болсонгүй. Ингэсээр 40 төгрөгөө үрж, нөхөдтэйгөө наргисан архины хор шар ямар ч үлдэгдэлгүй гарчихаад байхад бид хоёрын уурлалцаж муудалцсаны жавар гэр дүүрэн хүйт оргиулсаар маргааш орой нь боллоо.

Би ажлаасаа тараад хорт утааны баг барьсаар гэртээ орж ирэв. Энэ орой нөхдийн яриа шуугианаас ч болсон юмуу, сэтгэл нэг л түгшүүртэй хүйтэн байснаа, гар нүүрээ угаагаад зогсож байгаа Үзмээгийн араас хараад дотор минь уужрах шиг боллоо. Үзмээтэй нэг л аятайхан урт яриа яримаар бодогдоно. Гэтэл Үзмээгийн сэтгэл минийхээс огт өөр байгаа бололтой. Намайг орж ирэхэд гараа савандсаар над руу зэрэвхэн харснаа “Аа өнөөх л байна” гэсэн янзтай цаашаа хараад нүүрээ угааж эхлэв. Тэр тоомсоргүй харц, савантай усаар цэвцийн цайтал угаасан урт цагаан хуруутай гар, ихэмсэг тэгш мөрийг нь харахад цөм л “Эвлэрэхгүй” гэж надад хэлээд байх шиг санагдана. Энэ бүхэн сэтгэл сайхан байгаа цагт надад цөм чимэг болж харагддаг байсан юмаа. Би барьж ирсэн багаа байшингийн буланд тавьчихаад гадуур хувцсаа тайлж хоолойгоо заслаа. Өдий хүртэл Үзмээгийн уур нь гараагүй дуу цөөтэй байгаад гомдох шиг ч санагдаад, түүнийг толины өмнө гар нүүрээ арчиж байх зуурт нь:

- Бидний амгалан сайхан амьдарч явсан цаг гэнэт ингээд дуусчихвал яана? гэж би асуусан харамссан хоёрын оронд хэлээд Үзмээгийн царай өөд хартал тэр миний өөдөөс хараад

- Юу ... юу гэж сунжруулан асуув

- Юу гэнээ? гэж Үзмээ лавлан асуугаад над руу ойртов. Яг ингэж асуухдаа царай нь хувьсаж дуу нь зөөлрөөд ирлээ.

- Би нэг юманд явах боллоо. Үзмээ минь. Энэ бол алсын нэг их аюулын амьсгаа юм даа. Бид хэдэн хоног сараар юмуу, үүрд ч уулзахгүй болчих тийм аюул гэнэт гарч болох цаг л ... Харин энэ удаа урт түрийтэй гутал, хөдөө өмсдөг хувцаснуудыг минь гаргаад аль, гэв.

Үзмээ гайхсан янзтай над руу ширтээд байхаар нь би цагаа хараад “Алив түргэлээч, амжмаар бол нэг хоол ч хийгээд өгвөл зүгээр байна” гэлээ.

-Чи ... Сандагаа чи хайчих гээд байнаа гэж Үзмээ асуугаад байшингийн буланд байгаа хорт утааны баг руу гэнэт эргэж харав.

-За би чамд орой яримз. Хоол л шалавхан хийгээд өгөөч гэж би гуйсан маань бараг шаардсан юм шиг болчихлоо.

-Чи алс хол газар юманд явах гэж байгаа юм биш биз? чи надад үнэнээ хэл л дээ. Хичнээн ч нууц юм байсан би хадгалаад явж чадна шүү гэж Үзмээ зөөлөн дулаан дуугаар хэллээ.

- Хаанаас даа! гэж би тайван инээмсэглэв

- Чи орой лав ирнэ биз гэж лав гэдэг үгийг гоцлон асуув.

- Лав, лав гэж намайг батлан хэлэхэд тэр, тэв тов алхалсаар гал тогооны өрөө рүү ханцуй шамлан орлоо.

Намайг нүүр гараа угааж хувцсаа сольж өмсөөд гал тогооны өрөөнд ороход хоол маань буцалж эхлээд байв. Үзмээ гараа элгэндээ зөрүүлж толгойгоо тонгойсхийгээд тогоотой хоол руугаа мэлэртэл ширтчихсэн зогсож байв. Нүд рүү нь харахад нулимс ч гарсан шиг

- Яваа чи? Царай чинь хачин болчихсон байх чинь, гэж мөрөн дээр нь гараа тавьж асуугаад

- - Чи битгий ингэж яльгүй юмнаас уурлаж түгшиж өөрийгөө зовооч байгаач. Туулай биш дээ гэж би инээмсэглэв.

- Чи хаашаа явахаа хэл, тэгвэл гэж тэр над руу нойтон алаг нүдээрээ харж доройхон инээмсэглэв.

Би түүнийг өрөвдөн чухам хаашаа явах гэж байгаагаа хэлчихдэг юм билүү гэж нэг бодсоноо сэтгэл нь жаал түгшиж юм бодог, бидний амьдралд ер нь юу ч тохиолдохыг яаж мэдэхэв гэж санагдаад,

-Чи зоволтгүй гэрээ байж бай. Би орой хүрээд ирнэ гэж хэлээд гэрээсээ гарлаа.

Үдэш нь үдэш ч гэж дээ бараг шөнө болж байхад би буцаж ирээд иргэний хамгаалалтын хээрийн сургууль хийснээ Үзмээд ярьтал,

-Үгүй тэгээд юун ч сүртэй юм бэ дээ? Өвчтэй юм шиг, хүн айлгачих юм. Нээрэн муу юм бодлоо байна. Явлаа барилаа ч гэх шиг, холын аюул ч гэх шиг. Шал өвчтэй юм.

Үзмээ ингэж уурлаад хувцсаа түргэхэн тайлж уурандаа ширүүн ширүүн шидлэв.

Эмэгтэй хүн гэдэг хаашаа ч сэтгэлтэй байдаг юм бэ дээ. Хэдийгээр шөнө, орой болсон ч хэзээ ч гүйгээд гарахад бэлэн хувцастайгаа сууж байсан байх юм. Юу бодож суугаа бол? Хуурчихлаа гэж надад ч их л уурлаж байх шиг бололтой. Гэсэн ч энэ уур бол өнөөх дөчин төгрөгийн уурыг бодвол дараа нь амархан эвлэрч болох арай «өөр найрлагатай» гэмээр уур байсан юм даа.

ЖАГДАЛЫН ЛХАГВАА

Зохиолч Ж.Лхагваа 1942 онд Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт төржээ. 1966 онд ЗХУ-д Киев хотын политехникийн дээд сургуулийг төгсчээ.

1968 оноос уран бүтээл сонирхон оролдож “Саарал даага”, “Хулангийн тоос”, “Сарны шороо”, “Толгодын цаана ингэ буйлна” ном хэвлүүлж, “Анхны хайрын дууль”, “Тойрох хуудас” кино зохиол бичсэн нь дэлгэцнээ гарч үзэгчдийн хүртээл болжээ.

САРНЫ ШОРОО

“Сайншанд – Улаанбаатар” гэсэн галт тэрэг буудалд ирж зогсов. Угтах хүнээ хэддүгээр вагонд ирснийг мэдэхгүй би бээр арваад вагоны хаалгаар гарч ирэх болгоныг харах гэсэн ер болдог юм биш. Тэгэхээр нь өөрөө үзэгдэхүйц газар зогсох нь зөв юм байна гэж бодоод хүний сийргийг харсаар буудлын байшингийн чанх ард очиж хүлээлээ.

Хүмүүс гарч дуусахад миний тоссон хүн үгүй тул дэмий л гайхаж, буудлын давцан дээгүүр нааш цааш холхин тамхи татаж явлаа. Гэтэл нэг настай өвөө, жаал хүү хоёр вагоноос буух гэж хирэндээ тэвдэж байгааг хараад туслахаар очив. Сэгсүүргэн дээлтэй, чихэвч малгайтай улаан хацартай арван гурав, дөрвөн насны жаал хүү, үзүүрсгэн дээлтэй, лоовууз малгайтай ясархаг байрны бөгтөр өвгөнийг сугадан ирж шатан дээр гишгүүлэхэд өвгөн дороо сууж, суугаагаараа гулгах гэсэнд би яаран түшиж буулгав. Өвгөн миний мөр толгойг эв хавгүй тэмтэрч нэг үзсэнээ:

- Хэний багачуул вэ? гэж өөд харан чагнаж зогсов. Хараа муутай хүн бололтой.

- Та танихгүй байхаа. Би Санжмятав гэдэг хүний хүүхэд гэвэл өвгөн жаахан бодлогоширч байснаа:

- Ямар Санжмятав? ... Хар эрүү юу?

- Үгүй ээ, Би Хөвсгөл сумын хүн шүү дээ. Та аль нутгийн хүн байнаа?

- Аа тэгвэл танихгүй ээ, Би Далан Жаргалангийн унага. Гэхдээ эцэг чинь цэрэгт хэдэн онд байсан юм болдоо. Би ч “Цагаан энгэрийн” застав, “Ханги”-ийн застав гээд л танай нутгийн цаахнуур алба хааж явсан л хүндээ... гээд өвгөн сүрхий сэргэж ирлээ. Би тэр урманд нь:

- Аа. Та “Ханги”-ийн заставт байсан хүн бий. Хангийн булаг мөн сайхан газар шүү гэвэл өвгөн:

-Хай, тэгэлгүй яахав. Чулууны нь сайхныг яана даа. Барилгын бэлэн материал шүү дээ... Дандаа засчихсан юм шиг гээд санаа алдав.

Өвгөний сүүлийн үг их л танил мэт санагдахад нь би нүүр царайг нь сайтар ажиглаж харлаа. Нулимс гоожсон улаан нүд, мөнхордуу хамар, оочны жаахан сахал, том мөнгөн товчтой хүрэн хилэн хантааз, төө хиртэй нударган дороос цухуйх байлдааны хүрз шиг том гар сэлтийг нь нэгэнтээ гүйлгэж хараад дэмий л:

- Та нар аймгаас суув уу? гэвэл өвгөн:

- Үгүй дээ, Далангаас...

- Ингэхэд таны алдар хэн билээ?

- Намайг Дүгэр гэдэг

Дүгэр... Дүгэр ... энэ нэрийг сонсонгуут байлдааны хүрз шиг гарыг нь дахиад нэг ажив. Яг мөн дөө. Одоогоос арваад жилийн өмнө Даланжаргаланд сурвалжлагаар явж байгаад уулзсан Дүгэр... Чулууны Дүгэр байх нь гэсэн бодол тархинд харван орж

-Чулууны Дүгэр гуай мөн үү гэвэл өвгөн ихэд сэргэн дээш олилзож:

- За бас чадалтай үед тэгж л байсан юм гээд өврөөсөө даалин гаргаж тамхилав. Улаан цацтай гартаам хөөргийг нь ч би танилаа.

Даланжаргалангийн намжаа толгод, цагаан дэрст хөндий өвлийн цасанд дүмбийн хаана нь өндөр, хаана нь хонхор газар байгаа нь дасаагүй нүдэнд төдий л сайн ялгарч үзэгдэхгүй бөгөөд сайн ажвал цасны сүүдэр цэнхэр өнгөтэй тул хонхор газар ягаан цэнхэр өнгөөр гэрлэн ший тоглож нүд илбэднэ.

Хаа нэгтээ өвөлжөөний бууц харлан энэ их талын амь амьсгаа болох бөгөөд яраглан хэвтэх олон хониноос өглөөн жаварт уур савсан байх нь жигнүүртэй бууз шиг холоос үзэгдэв. Хөрзөнгөөр дулаалан доторлосон тохилог чулуун хашааг харах бүрий нүдэнд үзэгдэх чулуугүй энэ ухаа гүвээ, дэрст хөндийн хаанаас нь ийм их чулуу гараад ирэв гэсэн бодол байн байн төрсөөр хамт яваа хүмүүсээс асуувал надтай цуг явсан нутгийн хоёр хүн:

- “Дүгэрийн чулуу”, “Дүгэрийн чулуу” хэмээн ам булаалдан хариуллаа. “Их газрын чулуу”, “Бага газрын чулуу”, “Сүнтэй Бударын чулуу”, “Оцол Сансарын чулуу” зэрэг алдартай чулууны нутгийг багагүй дуулсан боловч Дүгэрийн чулуу гэж дуулаагүй тул энэ нутагт тийм нэгэн газар байдаг байжээ хэмээн бодож:

-Эндээс хол уу гэж асуув

Хамт явсан хоёр хүн өөд өөдөөсөө нэг харснаа над руу гайхан эргэж

- Та юу асуугаад байна? ...

- Яагаа вэ “Дүгэрийн чулуу” гэдэг чинь

- Аа...? гэснээ мань хоёр дахиад л бие бие рүүгээ харж, юу гэж хэлэхээ мэдэхгүй юм шиг чимээгүйхэн явах нь мэдэх гэсэн миний хүслийг улам гижигдэж , би:

- Дүгэрийн чулуу чинь хаа байгаа юм бэ? гэж бараг зандрах шахам асуудаг байгаа.

Ийм янзын асуулт асууна гэж огт бодоогүй явсан малын эмч залуу хий л тулгамдан чимээгүй явсан бөгөөд надаас хэд ах бололтой сумын орлогч миний огцом ширүүн дуунд дургүйцэв уу яав:

- Дүгэрийн чулуу юу? ... Хашааныхаа ёроолд байдаг юмаа гээд жуумалзав.

Гэтэл малын эмч залуу санаа зовов бололтой, барилгачин хүн хана өрөхдөө хоёр чулууны ам даруулах эвтэйхэн хавтгай чулуу эрж байгаа юм шиг үгээ цэгнэн бодолхийлж:

- Дүгэрийн чулуу л гэж бид яриад сурчихсан юм... гадны хүнд учрыг нь гаргаж хэлэхгүй бол яаж ойлгох вэ дээ... Манай энд Дүгэр гэж нэг өвгөн бий. Энэ хавийн бүх хашааны чулууг тэр л өвгөн бэлтгэсэн, тэгээд ч Дүгэр гуайн гаргасан чулуу бусад хүний гаргасныг бодвол барилгад илүү тохиромжтой байдаг болохоор нь “Дүгэрийн чулуу” гэж ер нь сайн чулуугаа л хэлэх юм шив дээ. Өөрийг нь бас Чулууны Дүгэр гэдэг юм.

- Мөөн, мөн одоо тэр Дүгэр гуай хаана байгаа вэ?

- Уг нь сумын төв дээр, туслах бригадад чулуу хийдэг юм. Одоо тэндээ хийх ажилсаад байх юмгүй. Өвгөн ямар зүгээр сууж чадах биш. Аягүй бол бидний очих суурь дээр ч байж мэднэ.

- Тэнд юу хийж байх вэ?

- Хойд тэжээлийн цэгийн ахлагч нэг өвгөн дүү нь юм, тэднийхээ ажилд туслахаар ирсэн байж ч мэднэ.

- Дүгэр гуай чинь хэдий настай хүн байна даа.

- Энэ жил далан тавтай

- Тэтгэвэрт гардаггүй ээ?

- Тэр ярихгүй ээ, тэтгэвэрт гарна гэдгийг санадаг ч үгүй хүн байх шүү.

Ийн ярилцсаар тэжээлийн цэг дээр хүрэлцэн очвол хэд хэдэн хүн гэрээс гарч биднийг угтлаа. Гэрээс урагш хөрзөн хороо сэлбэж байсан нэгэн том өвгөн эргэж хараад биднийг чиглэн алхах нь манай нутагт байдаг Мөнхийн хүрэн цохио амь орчихоод надтай золгохоор айсуй мэт санагдав. Энэ лав Дүгэр гуай мөн гэж сэтгэлд шивнэсэн миний зөн хуурсангүй.

- За Дүгэр гуай сайн уу? хэмээн малын эмчийг мэндлэхэд би ч бас хэзээ язааны танил юм шиг нэр алдрыг нь дуудан золголоо. Дүгэр гуай байлдааны хүрз шиг том алгаа дэлгэн мэндэлж баруун хацар дээр минь үнссэнээ:

“Ингэхэд ер нь хэний багачуул байнаа? гэсэн янзтай сүрхий харж улаан цацтай гартаам хөөрөг гарган тамхилаад хүн танихаа болио юу даа хэмээн өөрийгөө зэмлэх мэт чимээгүйхэн дагалдаж явав.

Биднийг хашаа пүнз эргэн үзэж байх хооронд Дүгэр гуай нөгөө л хороон дээрээ буцаж очоод аяганы ширээн шиг дөрвөлжин дөрвөлжин хөрзөн тэврэн өргөж ажлаа үргэлжлүүлэв. Би тэжээлийн цэгийн ажилтай танилцаж дуусаад Дүгэр гуайтай очиж ярилцлаа. Ажилдаа халууцаж, хөлс дааварласан буянтай хүрэн царай нь ундром адил гялтганах агаад цагийн саалтанд номхроо нь үгүй бор нүд, монхор хамар, цахлайн даль шиг цагаан сахал тэнхлүүн биеийн сүр хүчийг илтгэнэ.

- Хөрзөн бол хүрздээд авчих амар эд юм даа. Энд ч чулуу олно гэдэг амаргүй биз хэмээн намайг үл өдөхөд Дүгэр гуай.

- Газар дэлхийн хишиг хаа мундах вэ? Хүү минь

- Гэхдээ л ... ухаан нь энд гэхэд нохой чулуудах чулуу алга шүү дээ...

Шороо байсан газар чулуу байдаг юмаа.

- Бидний саяын үздэг хашааны чулууг та хаанаас гаргав?

- Ойрхноосоо, хүү минь. Тэрүүхэн урдаас ухсан юм гэж гар нь завгүй тул эрүүгээрээ заав.

- Усны шинжээчид худаг гаргах газар олдог шиг, чулуу гарах газрыг бас шинжиж олно биз.

-Тэгэлгүй яахав. Тэгэхдээ зүгээр нэг чулуу ихтэй газрыг эрж олох биш, гаргаж болох чулуу хаа байна гэдгийг мэдэх хэрэгтэй.

- Гарах чулуу, гарахгүй чулуу гэдгийг яаж мэдэх вэ?

- Ярьж л мэднэ дээ. Чулуунд чинь бас өөрийн хэл гэж байдаг юм.

- Та чулууны хэл сайн мэдэх үү?

- Яах вэ, ойлголцоод л байдаг юм.

- Та чулуутай юу ярилцдаг вэ?

- Алив ажилд арга эв олохыг чулуунаас сурсан гэж би боддог. Чулуу гэмээ нь зодож нүдэхэд дургүй, эв ширхэгийг нь олбол хэдэр хүнээс ч амархан. Чадал тэнхээ сайтай, залуу зандан үед багаж зэвсгийн сайнаар чулуу гаргаж байлаа. Томхон царил даахааргүй болсон энэ насанд багаж шилэхээ больж, тамхиа татаж байгаад л өдрийн арван гүүб хийчихдэг юмдаа. Үүнийг би чулуутай хэл ам авалцдаг болсных гэж санадаг шүү.

- Тамхи татах бас чулуу хийхэд хэрэг болноо?

- Хүн залуудаа ажлыг чадлаар хийнэ, насжаад ирэхлээрээ бодлоор (ухаанаар ч гэх юм уу даа) хийнэ. Залуу хүн суугаад босохдоо чадал сэлбэдэг бол настай хүн тамхиа татах бүр ухаан сэлбэнэ. Өөрөөр хэлбэл “Яаж хийх вэ?” гэж бодох бүр тамхиа асаадаг юм шүү дээ. Өвөгцүүлийг хараад л байгаарай.

- Дийлэхгүй чулуу гэж байх уу. Дүгэр гуай?

- Хүн бодно. Чулуу бодохгүй. Гучаад жил чулуу хийхдээ би авья гэсэн чулуугаа авч л явлаа. Харин ноднин Дэлгэрцогтын шовх гэдэг газар гэрийн буйрны дайтай нэг чулуу авах гээд болохгүй болохоор нь хорондоо дэндийлж байгаад дороос нь ухчихсан. Мөн ч олон тэрэг чулуу авсан даа. Тэр чулуугаа яаж авахыг бодож өвөлжин тамхи татлаа. Одооноос л нэг санаанд багтаж байна. Ирэх зун авна даа. Тэгээд ч би л чулуучин хүн билээ гэж газар газар онгичоод шарх сорви шиг юм үлдээж явах дургүй. Уул бүхэн, дов бүхэн өөрийн нүүр царайтай, би ер нь насандаа ганц ч толгойн нүүрэнд сорви үлдээгээгүй гэж боддог...

Худаг дээр ажил гараад Дүгэр гуай явах болсон тул бидний яриа ийнхүү тасарч билээ.

Хад цохио шиг энэ тэнхлүүн өвгөн лужир том биендээ огт түүртсэн юмгүй алхсаар худгийн зүг одоход би хойноос нь харан харсаар зогсохдоо: “Говийн толгод эрдэнийн чулуугаар дүүрэн, орон газар үнэ хаялцан наймаалцдаг мана, гартаамаар хүүхэд тоглож нохой чулуудаж байхыг алийг тэр гэхэв. Газрын өнгөт чулуу нүд булаах нь үгүй боловч эх дэлхийн сүр хүчийг хадгалах тул энгийн бөгөөд аугаа их, ямар ч зориулалтанд бэлэн байдаг. Дүгэр гуай мөн тийм нэгэн хүн юм даа” хэмээн бодож билээ.

Ийнхүү бид хэзээний танил хүмүүс байлаа. Нүд нь хараагүй болж сүрхий турснаас биш янзаараа ажээ. Түрүүнээс хойш бидний хажууд чимээгүйхэн зогссоор байсан бүлтгэр улаан хүүг сая л анхаарч:

- Дүгэр гуай, энэ танай хүү юү?

- Өө тийм. Манай ач ухаантай юм. Нүд болж л яваа юм даа чухам гээд тэмтрэн олж толгойг нь илэв.

Галт тэргээр ирсэн хүмүүс тус тусын унаанд суугаад буудлын талбай дээр бид гурав л үлдсэн байлаа. Угтах гэсэн хүн мань ирээгүй ч гэсэн авчирсан унаагаараа өвгөнийг хүргэе гэж шийдээд:

- Аль орцгоох вэ? би хүргээд өгье гэвэл өвгөн хүүгийнхээ ханцуйнаас чангааж “чи л хэл” гэх мэт урдаа гаргаад:

- Юу билээ, хүү минь гэхэд хүү

- Үзэсгэлэн гэж товчхон хариулаад над руу харлаа.

- Ямар үзэсгэлэн гэж намайг гайхахад өвгөн

- Нөгөө... сарны шороо үзүүлж байгаа газрыг чинь одоо юу гэдэг вэ

Хүү хажуугаас нь

- Зөвлөлтийн шинжлэх ухаан, техникийн үзэсгэлэн гэж надаас урьтан хариулав. Бид гурав тэргэнд орж суугаад үзэсгэлэнгийн зүг хөдөллөө.

Машин хөдлөнгүүт би ам нээж:

- Дүгэр гуай хотод удах уу?

- Удахгүй ээ, энэ хүүхэд хичээлтэй, би ч гэсэн хэвтэрт байгаа хүн шүү дээ. Амжвал өдөртөө буцах санаатай.

- Та хоёр чинь тэгээд тэр газраас зөвхөн л үзэсгэлэн үзэх гэж ирсэн улс уу? ...

Дүгэр гуай хараа муудсанаас хойш алив юманд түүртэн уцаарлах болж, ажил хийж чадахгүйдээ бухимдан шаналж, сүүлийн жил ихэд туржээ. Хүүхдүүд нь он гаргаад аавынхаа наян тавны найрыг хийе гэж гэнэт шийдээд өөрт нь дуулгаж гэж өдөр халж ядан байснаа өнөөдөр дуулгавал өвгөн:

-Юуны чинь найр... урдах ажлаа барахгүй байж юун найрсаг юм бэ? би ер нь хар багаасаа элдэв найр хийж, халамцуу хүнээс худлаа магтаал сонсож байх дургүй. Би чадахаасаа чадахгүйгээ хүртэл барилгын чулуу хийсээр энэ боллоо. Газар дэлхийдээ би их өртэй хүн. Одоо миний чадах юм гэвэл ганц гүүб чулууны зай бөглөж газар шороондоо нойрсох л үлдэж.

Би чулуугаар овоглож, чулуунд нэрээ өгсөн хүн. Чулуу шиг энгийн чигтээ дуусаж, газар шороондоо чулуу шиг орших болно. Харин та нар намайг хөдөөлүүлэхийн цагт элдэв авс, даавуу шувуунд боож новшруулав. Чулуу газартаа ямар байдаг вэ тэр л янзаар ... чармай нүцгэн булчихаарай хэмээн омогдоод оройжин дуу гарсангүй. Хүүхдүүд нь элдвээр аргадаж, амьдралынх нь инээдтэй хөгтэй явдлаас ярьж инээлгэх гээд чадсангүй. Басхүү «нэгдлийн дарга заавал найрыг нь хий» гэсэн гэж зохиож яриад ч бүтсэнгүй.

Дүгэр гуай энэ үгийг дуулаад: «Нэгтгэлийн дарга ажлаа хийлгэхээ л мэддэг юм байгаа биз. Найраа хийх үгүйгээ би өөрөө мэдье» гээд буруу харан хэвтжээ.

Маргааш өглөө нь хүүхдүүд босоход Дүгэр гуай аль хэдийн хувцаслачихсан тамхи татаж суулаа.

- Аав яасан эрт босоов? Гэж охиноо асуухад

- Та нар яасан орой босдог юм бэ? хэмээн аг яг хийгээд - Шалав явж шар ат барьж ир, тэгээд нэг нь намайг суман дээр хүргэж өг гэлээ.

- Аав та сум орж яах нь вэ? гэж цаадуулаа гайхахад:

- Хот явна гэж ганцхан үг хэлээд эргэнэг түшин босоод гарч одов.

Хүүхдүүд нь гайхан шуугилдаж, яах гэж гэнэт хот орох болсныг нь таах гэж оролдоод өөрөөс нь асуувал:

- Араажуу сонсдоггүй юмуу, цаана чинь хотод сарны шороо үзүүлж байна гэнэ шүү дээ. Очиж үзнэ гэжээ.

Үзэсгэлэнгийн их шилэн ордны үүдэнд бугаад өвгөнийг хөтлөөд явахад тэр бээр таягаа сугандаа хавчуулж хөлөө дээр дээр өргөн чагнаж, өвөөдөө зогсох гэж буй хүүхэд шиг ч гэмээр юм уу, түмэн алтан бурхны дунд орсон мөргөлчин л ийм байдаг болов уу гэмээр бишрэн хүндэлсэн, сэтгэл догдолсон байдалтай ажээ.

Үүдний гонхонд орж “Гурван билет авъя” гэсэн миний үгийг Дүгэр гуай сонсоод их л сандарсан байдалтай.

- Хэрэггүй хүү минь, би өөрөө авна гээд баринтагтай ном шиг юм өврөөсөө гаргаж ирлээ.

- Яахав, яахав Дүгэр гуай, би авчихая, надад ойрхон задгай цаас байна гэж намайг хэлэхэд, Дүгэр гуай ханцуйнаас минь чангааж

- Хэрэггүй хүү минь өвөөд нь нэг ухаан байна гээд нөгөө «баринтаг»- аа задлан том хар түрийвч гаргаж

- Алив Боржин, миний хүү, эндээс ажаадаа зуун цаас аваад аль! гэв

Жаал хүү зуун төгрөг сугалан гарт нь бариулбал өвгөн өөрөө цонхны зүг тэмтчин явж:

- Алив, хаа байна... Билет... гэхэд би хөтлөн аваачиж цонхны ирмэгээс бариулав.

Дүгэр гуай цонхны зүг чихээ далжийлган, зуун төгрөгөө сарвайж

- Билет авья нэг гэлээ

Кассын худалдагч буржгар үстэй тарган цагаан хүүхэн мөнгийг авч, цонхруу ч харалгүй

- Задгай байхгүй юм уу. би наадахыг тань задлахаар хариулт нь гэж хачин бутархай юм очих нь байна шүү дээ гэхэд өвгөн:

- Яахав яахав, би хариулт авахгүй.

Хүүхэн алиалж байна гэж бодов бололтой нэг муу инээмсэглэснээ, баруун гарынхаа эрхий долоовор хоёр хурууны үзүүр лүү халыг нулимаад нэгт, гуравтын дэвсгэрт голдуу хуучин цаас тоолж гарав.

Дүгэр гуай тэр битүү шажигнах чимээг чагнан нилээд зогссоноо:

- Нөгөө билет маань бүтэв үү хүү минь?

- Байз л даа, би таныг харсаар байтал зүгээр байгаагүй шүү, хариултыг чинь тоолж байна.

- Би чамаас хариулт авахгүй гэж хэлээд байна шүү. Алив тэр билет шалавхан өгөөдөх!

Хүүхэн кассынхаа цонхруу ухасхийн хараад хөдөөний байртай сохор өвгөн байхыг үзэв бололтой:

- Тэгээд зуун билет авах юм уу?

- Гурван билет авна.

Хүүхэн тоолж байсан төгрөгийнхөө тоог мартчихав бололтой ширээн дээрээ чулуудчихаад:

- Нэг билет нэг төгрөгийн үнэтэй ... ойлгож байна уу?

- За яахав тийм л байж. Гэхдээ би зуун цаас өгчихье л дөө.

- Та ер нь ямар санаатай үйлчилгээнд чирэгдэл учруулаад байна вэ? энэ өвөөтэй хамт яваа хүмүүс байна уу? гэж хүүхнийг хангинахад би очлоо. Кассны хүүхэн намайг хяламхийж хараад:

- Наад өвгөн чинь яах гээд байгаа юм бэ? учрыг нь хэлээд өгөөч

Би Дүгэр гуай руу эргэж:

- Та тэгээд хариулт авахгүй гээд байгаа юм уу?

Дүгэр гуай нилээд гомдонгуй дуугарч:

- Хүүхдийн үс авч байгаа айлд ороход хүртэл арван янчаан тавьдаг байхад тэртээ сар наранд очиж ирээд олз омог үзүүлж байгаа улсын үзэсгэлэнд би ганц зуун цаас өгөхөд ер нь яадаг юм бэ? битгий хариулж аваарай гэв.

Би жаахан бодож байснаа кассны хүүхэнд:

- Энэ хүн Дорноговь аймгаас зөвхөн энэ үзэсгэлэнг үзэх гэж ирсэн юм байна. Одоо ингэсхийгээд 11 цагийн галт тэргээр буцна. Ийм сайхан үзэсгэлэн байгуулсанд нь талархаж хувийн бэлэг өгч байна. Аятайхан, таарсан бэлэг аваад энэ хүний нэрнээс үзэсгэлэнгийн захиргаанд бэлэглэчихээрэй гээд цаасан дээр “Дорноговь, Даланжаргалан. Чулууны Дүгэр” хэмээн бичиж өгөв.

Үзэсгэлэнд ороход балт зөгий үүр шиг олны шуугиан дундаас “Миний төрсөн уудам нутаг, ногоон мод усаар элбэг” хэмээн дууны уянгалаг санаашрангуй эгшиг сонсдож, энд тэнд тайлбарлагчийн цовоо дуу сонсогдоно.

Дүгэр гуай:

- Хаа байна нөгөөх чинь... гэж босго алхангуут хэлсэн тул би шууд хөтлөн явсаар шилэн хоргонд тавиастай дээжийн дэргэд авчрав.

Дүгэр гуай гучин жил чулуу ухаж, баргийн чулуунаас зөөлөнгүй болсон гарынхаа аварга том алгаар бөмбөгөр шилэн хоргыг хэдэндээ илээд:

Ээ элээ. Битүү юмаа даа гэж их цөхрөнгүй өгүүлэхэд нь би өрөвдөж:

- Би танд шинж байдлыг нь хэлж өгөх үү? Гэлээ. Өвгөн адар ширтэн олилзож

- За даа, шороог чинь барьж л үзэхгүй бол үзсэн болохгүй л дээ. Тэгэхдээ ямар шүү янзын юм байна?

- Хар саарал өнгөтэй... бүдүүвтэр ширхэгтэй..

- Аа тэгвэл орос дарьлхуу байх нь ээ?

- Орос дарьнаас арай нарийн ширхэгтэй, шимэлдэгний шаар шиг ч гэх юмуу, нунтаглачихсан кокс шиг л юм байна шүү дээ.

- Аа мөн мөн, тэгвэл “Хөтөл усны хар” шиг газар байх нь гэснээ ачийнхаа толгойг илэх адил нөгөө бөмбөгөр шилийг дэмий л оролдон зогслоо.

Миний тайлбар тус болсонгүй ээ. Би жаал гайхалзан байснаа өвгөн, хүү хоёрыг хүлээж бай гэж хэлээд үзэсгэлэнгийн тайлбарлагчтай очиж уулзав.

Дүгэр гуайн явдлыг бүгдийг нь хэлж, сохор өвгөний санааг амраах арга чарга байна уу гэж намайг хүсэхэд хонгор шар үстэй, украин аялгуутай өндөр хүүхэн их л анхааралтай сонсож аваад:

- Одоохон гэсээр гүйж одов.

Төдөлгүй лагс биетэй, сайхан зантай хижээл насны хар хүн дагуулсаар гарч ирээд:

Үзэсгэлэнгийн захирал гэж тэр хүнийг танилцууллаа. Захирал мэнд мэдэлцсэний дараа Дүгэр гуай, хүү бид гурвыг өрөөндөө урин оруулаад өвгөний нутаг ус, аж байдлын тухай лавлаж, сарны дээж үзэх гэж тэгтлээ зүтгэсний учир байдлыг сонирхоход би хэлмэрчилж өглөө.

Өвгөн хөөргөө гаргаж тамхилаад:

- Миний хийж чаддаг ганц юм бол шороо ухаж, чулуу гаргах л байлаа. Нүд юм үзэхгүй ч гэсэн шороог би имэрч үзээд таньдаг ухаантай юм. Энэ сарыг би наян хэдэн жил харж явахдаа хүн дээр нь очиж болно гэж ухаан санаанд багтахгүй байлаа. Тэр мөртлөө хэлтэрхий, хэсгийг нь авч ирээд би өөрөө гар хуруугаа хүргэж, мэдэрч болно гэж зүүдэлсэнгүй...

Үзэсгэлэнгийн захирал энэ үгийг их л анхааралтай сонсож байснаа, төмөр авдар онгойлгон жижиг шилэн хайрцаг бүхний сарны дээш гаргаж ирээд

Алив юмсын учир утгыг танин мэдэх гэсэн хүний хүсэлд орон зай, он жилүүд саад болж чадахгүй. Хүн төрөлхтөн мэдэхийн хүсэлд автан дэлхийгээс сар хүртлэх замыг туулсан юм. Зөвхөн манай үзэсгэлэнг үзэхийн тулд таны туулж ирсэн зам ч дэлхий сар хоёрын хоорондох зайнаас богиногүй юм гэж үзэсгэлэнгийн захиргаа үзэж байна гэж хэлээд сарны дээж, дурсгалын тэмдэгний хамт Дүгэр гуайд гардуулав.

Дүгэр гуай дээжийг хоёр гардан аваад духандаа нэг хүргэж

- Алив, Боржин миний хүү тагийг нь онгойлгооч гэлээ.

Боржин тагийг нь нямбайлан авч:

- Онгойлголоо. Ажаа!

Дүгэр гуай нударгаа хойшлуулан жижиг шилэн хайрцагны ирмэгийг тойруулж нэг үзсэнээ чичрэнгүй хуруугаар хайрцагны дотрыг тэмтчин хэдэн үртэс сарны дээжид гар хүрлээ. Тэр бээр удтал имрэн үзэж алсын чимээ чагнах мэт гилжийн зогсох бөгөөд нүүр нь үзтэл гэрэлтэн гийж, нялх хүүхэд шиг баярлан хөхив.

Дүгэр гуай, сарны дээжийг ач Боржинд гардуулж:

- Алив нөгөө орос хүү хаа байна хэмээн үзэсгэлэнгийн захирлыг барьж духан дээр нь үнсээд

- За хүү минь өвөөгийнхөө насыг аваарай. Өвөө нь он гараад наян тавныхаа найрыг хийнэ. Наян таван нас чинь учир утгагүй ч юм биш байна. Би чинь зүгээр нэг “Чулууны Дүгэр” биш, сарны шороо барьж үзсэн Дүгэр шүү хэмээн тэнхлүүн цовоо дуугарч инээх аядахад нь битүү байгаад мохоо хутгаараа огтолж гаргасан юм шиг улаан нүднээс сүүтэй цайны ганц дусал шиг цэхэр нулимс бөмбөрөн унав.

ДЭНДЭВЖАНЦАНГИЙН ЛХААСАМБУУ

Зохиолч Д.Лхаасамбуу 1944 онд Архангай аймгийн Баян Улаан суманд малчны гэр бүлд төржээ. Бага наснаас сургууль соёлын мөр хөөж Зоотехникийн мэргэжил эзэмшжээ.

1963 оноос уран зохиол сонирхон оролдож “Миний таамаглал буруутжээ”, “Магсар эмч”, “Тавуулаа таных” зэрэг драмын жүжиг, “Мөнгөн ембүү” тууж өгүүллэгийн ном бичжээ.

ХОЁРДОХЫН ШУУДАН

Элс цас хошууран шуурч хотгор гүдгэрийг тэгшлээд зөвхөн бутны толгой сөөвийж харагдана. Дандгаа жолооч дан дугуйтай ГАЗ-63 машинаа эргэж шаравтал мушгиж тэвшин дээрх хэдэн богцтой хэвлэл ойж бууж яваа нь кабин дахь хүнд дуулдана. Өндөр тэвшийг холбосон төмөр гинж шаржигнан хоёр талын банзан суудал чахарна. Энэ өглөө цорын ганц хүнтэй гарсан шуудангийн жолооч сэтгэл тун дундуур бүрсгэр царайлж хажуудах хүн рүүгээ ч хяламхийсэнгүй өчнөөн газар давхижээ. Түүний хажуу дахь нь гэвэл пөөдийсөн зувцаа дээлтэй эрүү амаа том ороолтоор боож жолооч савхин малгай духдуулсан ийм нэгэн хүн бөгөөд жолооч тээр хойно түүний хоёр нүдийг нэгэн удаа халыг харжээ. Эрэгтэй эмэгтэй нь ч мэдэгдсэнгүй. Мэдэхийг ч хүссэнгүй. Дандгаа жолооч хөгжилтэй самбаатайгаараа хэдэн суманд алдаршиж ах дүү болохоос арай наахнуур танилцсан улс бишгүйдээ. Авгай, хүүхнээ болгочих дөхсөн залуу бүсгүй ч зарим суманд бий гэлцэнэ.

Гэвч хөөрхий Дандгаа энэ удаа юу болсныг бүү мэд, дуугаа хурааж хөмсөг зангиджээ. «Жаргал» нэгдлийн төв харагдахад, хажуугийн үл дуугарагч хүн гэнэт шингэн дуугаар,

- Ахаа хүрээд ирэх нь энэ үү? гэхэд Дандгаа цочиж, тооромзоо нэг нэг гишгэсэнээ

- Аа, аа тиймээ. хэмээн тасалданги дуугаар хариулаад жолоогоо мушгитал машин донсолж, хүчтэй сугсаралтад кабины оройг хоёул мөргөв. Мөргөөд эргэж суудалдаа буух үед нөгөө хүний духдуулж тавьсан малгай нь ойчиж Дандгаан хөл доогуур өнхрөв. Дандгаа солгой гараараа авч эзэн өөд сарвайгаад гайхаж бантахдаа,

- Үгүй ердөө гэхихэв.

Хашир, энэ удаа тун гэнэджээ.

Царайлаг нь аргагүй, залуухан охин нүдээрээ доогтойхон инээмсэглэж байв. Холбооны салбарын үүдэнд торойлдон зогсож буй хэдэн хүн жолоочийг тэрхүү охинтой цааш нь юм ярих бололцоогүй болгов. Жолооч дэмий л

- Ингэхэд дүү охин хэдийд буцах билээ.... гээд буруу харав.

- Хоёрдохоор

Хэдэн богцоо бушуу султгаарай, явах минь гэж агдчин байгаа Дандгааг, холбооны хүүхэн шоолж

- За юу болчих нь энэ вэ, Тогтож хайрла, тоолж авна гайгүй...

- Юуны чинь тоолох, би тэрүүгээр яах юм бэ. битгий гайхуулаад бай гээд дуугаа өндөр болгохоор нь сандарч тэвдсэний нь үнэмшив. Дандгааг гарч явтал эвлэлийн үүргийн дарга Рэгзэн тааралдаж, хуучин танилын хувьд амар мэндээс эхлээд хэдэн үг солих гэтэл бас ч яарч гараас нь хөтлөн алхав.

- За найзуухай. Би танайд нэг хөөрхөн амьтан авчирсан. Хөөрхөөн, хөөрхөн
 - Юу вэ, тэр чинь усан гахай юмуу, туулай юмуу мал эмнэлгээс өгүүлээ юу?
 - Огт таасангүй. Бас л овсгоогүй амьтан юм. Чи үзээд гайхна даа, хо хо гэж инээгээд хаалга онгойлготол юу ч байсангүй. Рэгзэн гайхаж
 - Суудлын чинь араар орчихсон юм биш биз? гэсэн чинь
 - Больж доромжил, та нар намайг дэндүүлдэг шүү гээд уурлалаа.
 - Юу вэ? Чи зүгээр ярь л даа, яагаад байгаа юм бэ? гэхэд Дандгаа
 - Хүргээд өгье гэж байхад чинь... царайлаг хүүхнүүд зальтай шүү, яав л гэж дээ хэмээн гунисан дуугаар амандаа гүвтнэхэд Рэгзэн сая учрыг ойлгоод найзыгаа явж тайтгаруулах арга олсонгүй.
- Дандгаа ч ухасхийж машин дээрээ гарч ууттай сонинг пид пад хийтэл чулуудаж байв. Рэгзэн контор өөдөө алхав. Энэ үед аймгаас ирсэн Тулга хүүхэн сумын зочид буудлын нэгэн өрөөнд замын тоосоо гүвж, үйлчлэгч Хажид дуу алдан,
- Пээ энэ хүйтэнд яаж явнаа? Охин минь оройн хоол юу захиалах вэ? жаал дулаац, нааш ир, энд суу гэж нөгөө өрөөнөөс хашгиран ярьж, нэр хэн билээ? гээд мөн зав чөлөөнд нь шинэ танилыгаа бүхнээс түрүүн мэдэж авахыг хичээнэ.
 - Гантулга уу? зүгээр Тулга уу? гэж бүр илүү үгэнд дурлан эргүүлж асуухад цаадах нь түсхийтэл инээд алдав. За тэгээд хэний суурьт хэд хонох гэнээ? манай энд чинь эмэгтэй хүн, миний мэдэх л сүүлийн арваад жил ирээгүй. Ерөөсөө эмэгтэй хүнийг энэ хол газар явуулдаг юмуу гэж гайхах баярлах нь үл мэдэгдэнэ. Орилоо тэмээний дуу дуулдаагүй бол Хажид авгай нэг өрөөнөөс нөгөө өрөөнд дуулдтал чанга ярьсаар л байх байлаа.
- Гаднаас орж ирсэн хүний бараагаар Тулга дуу алдан сүйд майд болоход Хажид зуурсан гурилаа салгалгүй гүйн гарч ирээд
- Хэдүйдээ та чинь, энэ охинтой танилцаатхав. Энэ хэний үр сад вэ? одооны хүүхэд, төрлөө таних биш гэж асуухад Тулга, өвгөнөөс өрсөж:
 - Би эдний хүүхдээс нь ялгалгүй...
 - Ахай мөөн
 - Танай зэргэлдээ суманд ноднин хаваржсан
 - Үгүй ердөө бас, өдий багаасаа ингэж хэвлүү төрх суучих гэж хэмээн шогшров.

Тулгыг хоол идээд байх зуур Хажид чухам өөрийнхөө хүссэн болгоноо ирсэн өвгөнөөс сэтгэл дүүрэн мэдэж авлаа. Маргааш нь үүрээр шахуу сумын төвийн хэдэн байшингаас цэнхэр угаа

олгойдон орой босдог зарим нэг айл яндангаа тон тон хөөлж байхад Хажид өглөөний жаварт хацраа хайруулан хайруулан цан хүүрэг татуулсаар Рэгзэнгийн д хүрч очив.

- Эвлэлийн үүргийн даргаа, надад нэг ийм санал төрлөө. Тулга гэдэг хөөрхөн бүсгүй ирсээн хэмээн дуу алдсанаа авгай руу нь хяламхийж хөөрхөн ч гэж яахав дээ залуухан л хүүхэн. Тэр охин арван хуруу тэгш төрсөн хүн гэнэ... Мал эмчилдэг, үйл оёдог, дуу дуулдаг, хоол хийдэг, үгүй ядахдаа дээс томчихдаг юм гэнэ. Бас усан будгаар зураг зурж чаддаг гэнэ. Номын мөр хөөсөн улс чинь номоо дэлгэвэл уншчихдаг болохоос тийм, аар саар гэр зуурын чимхлүүр ажлыг ер хийдэггүй юм билээ. Би олоон хүнийг мэднэ чухам гэж бардам яриад энэ төвийн залуу хүүхэн харчуудыг цуглуулж үлгэр дууриал авахуулмаар байна. Аргал түүдэг нь номоо мэдэхгүй, ном уншдаг нь аргалаа танихгүй ийм л болчих гээд байхад, ийм бага атлаа чамбай, хэрсүү ухаантай хүмүүстэй уулзаж учирч байвал юу мэдэж сонсохсон билээ гэвэл.

- За мэдлээ. Хажид гуай гэж Рэгзэнг сая нэг ам нээхэд Хажид санаа нь амраад гарч одов. Тэндээс бага сургууль руу чиглэн алхаж өөрөөсөө зайтай явсан хүнийг Цэдэн захирлаа гэж дуудан даллаж зогсоогоод хөмсөг сормосоо цанттал ярьж зогсов.

- Эгчээ

- Өөв

- Танай нутгийнхан чинь шооч юм уу даа?

- Үгүй чиш, хэн тэгж байгаа юм бэ?

- Би

- Хаанаас даа охин минь, зах зайдуу газарт тэр болгон чам шиг хүн зорьж ирэхгүй юмаа. Ирдэг нэг нь сандруу яаруу цай амсаад хэд гурван үг солиод өнгөрчих юм... манайх чинь чамайг байгаа шиг, ийм гэр дүүрч байсан нь тун ховор оо, малын бэлчээр дагаад хоёулхнаа л нүүнэ. Хөгшин хүнтэй чинь ер нь юу ярих вэ дээ.

- Би бол хамгийн их дуртай

- За тэгээд нутгийн багачуул чинь цагаан сараар л нэг гар зөрүүлнэ. Хөөрхий минь өөрснөө ч завгүй юм. Манайд ямар бүсгүй хүүхэд байхыг үзсэн ч юм шиг. Шохоорхож байгаа гэдэг чинь жигтэйхэн гээд инээмсэглэв. Тулгын нүүр улайж

- Хүн рүү дэндүү их гөлрөөд, эвшээлгэн эвшээлгэн суухыг нь яана гээ. Малгайгаа авахаа ч мэддэггүй юм уу даа, хөлсөө ханцуйгаар шударч уур савссан халуун цайг хамрынхаа үзүүрийг ширтэж байгаад оочихыг нь яана гэж нэрийг нь гаргахгүйгээр нэг залуугийн тухай ярив.

- Хэлээд өгөх хүн байх биш. Охин минь чи бусдад нь сонирхож дурласны нь зааж өгчихөөд, тэр хүүг л гадуурхаж гэнэ.

- Ирсэн улс цөмөөрөө яваад өгөхөд, тэр ганцаараа тамхи татан үлддэг шүү дээ. Үг ярихыг огт дуулдаггүй юм шиг гөлийгөөд гутлынхаа түрийг байн байн илээд, хаашаа янзын зуршилтай

юм бэ дээ.

- Цэрэгт яваагүй юм чинь хир шүү дээ. Энэ хоёрдохын шуудангаар аймаг орж малчны сургуульд суух юм гэнэ лээ. Тэгвэл ядаж хүнтэй ярьж зүгширнэ бий хөөрхий. Хэзээ ч чиний дайтай цагааширна даа, нас бас гуч дөхсөн дөө гэхэд Тулга хн гээд битүүхэн санаа алдав.

Энэ айлд Тулгыг ирнээс хойш чамин тавилаг нэмэгдсэн байлаа. Бөөрөнхий зууван янз бүрийн хэлбэртэй шил сав, гялтгар өнгөтэй, буузны жигнүүр шиг мөртөө дээрээ сэнжтэй сав, хөөрхөн жижиг тун туухайнууд элдэв үнэртэй эм танг нэг харахад сумын эмнэлэг шиг санагдана. Тулга ер зүгээр суухгүй. Хоёр хөгшний сэтгэлийг зовоож

- Та нар минь л намайг байхад амраад ав л даа гэж хэлдэг ажээ.

Гэр нь зай орчихсон ч юм шиг. Зэлүүд газар, цомхон сурчихсан энэ хөгшчүүлийн сурсан занг эвдэж, өдөрт тоотой дуугардаг хаалга үүд нь хүртэл олон хөл босго давуулж байлаа. Тулгын эднийд ирсэн сураг, цууг сумын буудлын Хажид авгай сайн тарааж амжжээ. Анх нутгийн харчуул ганц нэгээр цувран ирж шохоорхож хараад буцна. Тэгснээ хүүхэн харчуул цуварч ирээд, яах гэж яваа зорилгоо өөрсдөө эс мэдэж, дэмий Тулгыг гарвал гараад, орвол ороод байхад нь айлын авгай ам нээж нутгийн залуучуудыг нэг ёсны багштай болгож өгчээ.

Тулга хэмээх хаа хол аймгийн нэг бүсгүй энэ айлыг ингэж цөөхөн хоногийн дотор төвхнүүлэв.

...Шуудан ирлээ багшаа гэж хэдэн хүүхэд бие биенээсээ өрсөж хэлэх гэж сандарч байхад Цэдэн захирал, Рэгзэн дарга руу нь хэл өгүүлэв. Аанайхан нөгөө Дандгаа жолоочийг давхин ирэхэд холбооны салбарын үүдэнд баахан багачуул хүүхэд зогсож байхын бараанаас баярлав. Энд Дандгаагаас хүндтэй хүн байсангүй.

-Ай хөө Дандгаа

- Дандгаа хампаанаа

- Дандгаа ахаа хэмээн авгайлан дуудуулж, та өнжөөд явна биз дээ гэцгээв. Энэ үг ихэмсэг зангий нь хөдөлгөж,

- Шуудан саатаж болохгүй ээ гээд хаалга тав хийтэл хаагаад нуруу үүрэн маадгар алхав. Цугласан хүмүүсийн дотор

- Яагаад ирдэггүй юм бэ?

- Өнөөдөр л буцна гэж дуулсан даа гэлцэн битүү үг хэлэлцэнэ. Дандгаа яаралгүйгээр шуудангаа тушаачихаад хүмүүс дундуур зүсэн гарч, өөрийг нь үдэх гэж байгаа юм шигээр сэтгэж, кабиндаа орсон хойно гараараа даллана хэмээн санаад хаалгаа онгойлготол манарсан утаан дунд нэг булиа эр сууж байв. Тэр жолоочийн эвгүйд бузгай загнаснаа юм чинээ бодохгүй гэдгэр байгаад нь Дандгааны дургүй хүрч,

- Чамайг хэн суу гэсэн юм бэ хө хэмээн ширүүхэн дуугарваас нөгөө этгээд огло үсрэн

сандарч,

- Сумын захиргаа гээд өврөөс том түрийвч гаргаж ирэв. Шуудангийн машин аажим хөдөллөө. Тойрсон хүмүүс хамт хөдөлцгөөж,

- За ашгүй энүүгээр л лав явсангүй. Одоо бүтэн долоо хоног гэцгээн гэр гэрийнхээ зүг баяр хөөртэй алхацгаав.

ДҮГЭРЖАВЫН МААМ

Зохиогч Д.Маам 1935 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Багийн сургууль, багийн дээд сургууль, Москвагийн олон улсын харилцааны дээд сургуулийг төгсөж 1979 онд түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

1954 оноос уран бүтээлээ эхэлж “Сүүлчийн захидал”, “Хөгийн тэнүүлч”, “Мандах зул”, “Тэмээний дууль” тууж, өгүүллэгийн ном, “Газар шороо”, “Гишгэх газаргүй хөл” роман бичжээ.

ӨНДӨР СҮХЭЭ ГУАЙ

Гурван жилийн өмнө барилгын ТМС төгссөн, Эрдэнэ Ус нэгдлийн туслах бригадын дарга миний бие өчигдөрхөн улсын комисст “Онцсайн” дүнтэй тушаасан зуун хүүхдийн дотуур байрын үүдэнд ёстой л данагар данагар алхалсаар хүрч ирэв. Анх удаа би энд аль нэгэн дутуу ажлыг гүйцээлгэх гэж биш, эсвэл бүр эхлээгүй ажлыг дэглэх гэж биш, зүгээр л өөрийн тааваар гэх юм уу, ер нь л огт өөр зорилготой ирж байгаа минь энэ юм. Бүтэн хоёр жил сэтгэлээ өгч, бүтэхгүй хийгээд эндэх осолдохын зовлон, бүтэх болон олох, олохын тул эрэхийн жаргалыг амсаж үргэлж буцалж даргилж явсан энэ газар яг одоо гэвэл намайг хэн ч шахамдуулан угтах ёсгүй байлаа. «Онцсайн дүнтэй шүү» гэж бодоод нэгэнт дууссан, нүдэнд дулаан тэр байшинг харахад сэтгэл аяндаа гэрэлтэнэ. Огт өргүй, хийхээ хийсэн, хийлцэхээ хийлцсэн хүнд л тэр торгон агшинд надад төрж буй шиг сэтгэгдэл төрдөг бизээ. «Маргааш өглөө шинэ байшингийн суурь нүх ухуулна. Дугуй булантай цай хадганд ороож тавих юм шүү» гэж би бахтай бодов. Алхаа маань улам идэрмэг болж явлаа. Говь нутгийн найман сарын салхин гэнэт бүлээнээр амилан, шил дарсан халимаг үсгийг хөвсөлзүүлэн үлээхэд би уртаар амьсгаа татна. Цээж уужирч байв. Залуу насны хөөрч дэвэрсэн сэтгэл улам бадран оргилж «Арслангийн зулзага нь жигүүргэндээ хүчтэй яа хөө» гэсэн аялгуут үг, хүнийг биш ч гэсэн, хүний дархалсан дууг мөнхөлдөг хорвоогийн альхан нэгэн булангаас уужирсан цээжинд шуургалан орж ирэхүй дэлхий дээр би л ганцаар байх шиг санагдана. Би азтай хүн явлаа.

Цаг хараахан болоогүй байсан учир сургуулийн захирал Мажидсүрэн алга байгаад байрын довжооны хадан цагаан шигтгэж чимсэн цээмэнтэн хашлага дээр сандайлдан саатав. Сүхээ гуайн саналаар ингэж хадан цагаан шигтгэсэн юм даа, тун аятайхан болж шүү гэж бодтол нэгдлийн захиргааны байшингийн зүүн буланг тойроод нэг хүн гарч ирсэн нь өндөр Сүхээ гуай байлаа. Дөнгөж хоёрхон жилийн өмнө ашиглалтанд орсон зүрхэн сүмбэр оройтой хоёр давхар тэр байшин Сүхээ гуайн дэргэд тун залуухан, Сүхээ гуай тэр байшингийн дэргэд их хөгшин харагдав... Сумын төвдөө бол хаш цагаан ордонхон гэж хэлэгдэхээр тэр байшинг Сүхээ өвгөн дангаар биш ч гэсэн Сүхээ өвгөн голлож бүтээсэн юм. Байшингийн суурийг тавих ёслол дээр амлалт авч байсны нь санав. Ийм ч хөгшин байгаагүйсэн. “Сүхээ гуай шиг ажлын төлөө төрсөн хүмүүс идэр наснаас нь үлдсэн цог золбоо, хур хүчээ, үл шавхагддагаараа хосгүй өгөөж сайн сэтгэлийнхээ хамт, тэнгэр нь газартаа хур хайрладаг шиг хөдөлмөртөө соёрхож, хорвоод залуу, залуу бүтээл туурвилаа соёолуулан орхиод, өөрсдөө хөгшрөн оддог ажээ” гэсэн бололтой тамхиа хувааж нэрэх зуур пир пир алхалсаар над руу дөхөж яваа Сүхээ гуайгаас би нүдээ салгахгүй суулаа.

Манай бригадын мужаан энэ эцэнхий өндөр шар өвгөн Сүхээ нэрэндээ тун зохисон хүн. Үе тэнгийнхэн нь түүнийг “Өндөр” Сүхээ гэхээс гадна “Сүх” Сүхээ, Хангинуур Сүхээ гэж хочилдгийг би ажигласан юм. Тэгж шогчлон дуудахад лавгайяа хорин жил мод цайруулж, хадаасны толгой шигтгэж яваа урт иштэй муу хангинуур нь нүдэнд үзэгдэнэ... Харин хангинуур нь хаа нэгэнтэй хэвтэж байвал Сүхээ гуай хаачсан юм болдоо гэж үгүйлэгдэнэ... Яах аргагүй сэргэлэн хангайн шилээс сорлож авчирсан идэр цагаан хусны мөчрийг долоон улирлын нар салхинд эвшээж шаантагласан боловч түүний муу сүхний иш нэгэнт ажилд нэвгэрч олон жилийн балбалтанд энд тэндээ цуурч зад аваад, бас ухааны хушуу болтлоо хэлтийж тун ч нэг эг маггүй хөгширсөнтэй адил зуугийн хагасыг их хэтэрсэн өвөө насны энэ

эрхэм бас л өнгөрөх ёозыг олжээ. Хээр хонож, хэц дэрлэсэн нь өдрөөр биш, сараар ч биш, бүр жилээр тооцогдох ёстой болсон тул тэр сайхан хүний уг нь цагаан шаргал царай итгэгдэхэд бэрхээр хар болсон аж. Цагаа ирэхлээр хоёр пүүгийн дөш хүртэл олгойтой ус мэт шальчийдаг, төмрийн хаан хуурай ч дарханд тоогдохыг нэгэнт болиод, хурууны хээ мэт үрчлээс төдий ортой гөлчгөрхөн төмөр болж өөрчлөгддөг, мөнх биш хувирамтгай хирнээ мөнхүү мөнхийн байж чаддаг энэхүү орчлонг ер юу ч гэх билээ дээ.

- За сайн байна уу? Сүхээ гуай

- Сайн байнаа, дарга та сайн байна уу? Захирлыг намын дарга дуудсан гэнэ. Таныг хүлээсний хэрэггүй гэлээ.

- Өө тийм үү, за тэгвэл явъя даа. Ингэхэд та чинь илүү цагаа нөхөж амрах ёстой бишсэн бил үү? Юунд энд яваа юм бэ.

- Хоёр давхрын мухрын өрөөний хаалганд яльгүй нойтон банз орчихсон юм. Одоо л эвэрч эгшсэн байх учиртай, шахья уу даа, гэж ирлээ.

Хоёр жил ноцолдож өчигдөрхөн тушаасан энэ байшин бага ч болов дутуу байна гэдгийг хүлээх болсон минь надад эвгүй сэтгэгдэл төрүүлэв. Саяхан хөөрч оргилж байсан дэврүүн бодол уурших мэт замхран одож билээ.

Нөгөөх урт ишгэй хангинуураасаа дугуугүй хайрладаг ногоон илгэн уугаа Сүхээ гуай барьчихсан явааг би одоо л ажиглалаа. Уугаа миний хөлийн дэргэд тавихад ам нь доош шальчийн сууж, дотор нь хийсэн төмөр ишгэй орос алх, нарийн гарын харуул, бас жижиг лаазтай цагаан будаг, багц үзэгдэв. Харин хангинуур нь хэзээний солгой тэр өвгөний зүүн гарт онгио хүртэл цайвалзан, урт халтар ишиндээ ёнхойж харагдах нь үнэнийг хэлэхэд миний эгдүүцсэн сэтгэлийг яггүй хатгав.

- Та чинь одоо нэгэнт хүлээлгээд өгчихсөн өгөх өгөхдөө Онцсайн дүнтэй өгсөн байшинг задалж ажил удах гэж яваа хүн үү? Харуул хөрөөний засвар хийхээр ирээ юу даа? гэж би нэг мэдэхнээ ёозгүйхэн дуугарчихсан байлаа. Миний харц өвгөний нүүрэн дээр нэг тусч, гялталзан цайвалзах сүхний онгин дээр нэг тусч байв. Миний эгдүү уцаар Сүхээ гуайгаас сүхэнд нь илүү төрж байсан юм. Үүнийг мэдрэхдээ би гайхаагүй билээ. Сүхээ гуайг өөд татдаг юм тэр сүх байсаны дээр Сүхээ гуайг хааяа хэвтэрт ортол нь ажиллуулж уруу татдаг юм бас л тэр сүх байсан болой.. “Нээрээ тоглоом биш нэгэнт өндөрлөсөн ажлыг дахин задалж хангинуурын дуу хадаах нь дэмий хэрэг” гэж би бат нот бодно. Бас будаач будаач гэхээр сахлаа будав гэгчээр юунд л ингэж явдаг юм бол доо”, “Долоон хөл зовлогоо ч амраадаг болоосой” гэж өвгөнийг өрөвдөнө. Гэвч би хайраа дотроо хадгалж, мань эрийг зэмлэнгүй ширтсээр довжооны хашлаган дээрээс яаралгүйхэн бослоо. Тэгээд

- Алив наад сүхийг чинь үзээд орхиё гэж огцом хэлээд гараа эрмэг тосвол өвгөн:

- Та, та... яах нь вэ? гэж хоолойгоо зангируулан хэлээд хангинуураа ардаа барив.

- Яахав, зүгээр л барьж үзье

- Таны харц сүртэй байна... Энэ бид хоёр одоо алив идэр орчлонгийн гарын аяыг даахыг больжээ. Чулуудаж орхивол онги нь бут явна шүү дээ. Төмрийг ямар боож баглаж болох биш. Би ядарсан мужаан хүн, гарнаас минь дутахгүй гар болсон сүхнээсээ салчихвал яана.

Өр минь нимгэрэх шиг болж би өвгөнд баярлан инээмсэглэв. Муу санаа санаж сүхийг нь үнэхээр аваад чулуудчихья гэж бодсон хүн ч бас инээмсэглэх байсан буйзаа. Сүхээ гуай “Енхороо” өмнөө гаргаж ирлээ. Намайг үл итгэх харцаар ширтсэн хэвээр хангинуураа хоёр гараар зуурч, элгэндээ аваачиж тэврэв. Тэгээд:

- Дарга минь үгүй дээ, тийм сүйдтэй засвар хийх гэж байгаа юм биш. Үртэс зоргодос бараг гарахгүй. Бага зэрэг гарна, би өөрөө цэвэрлэчихнээ. Сэтгэл нэг л дундуур болоод хүрээд ирлээ.

- Таны сэтгэлийг би ойлгож байна. Тэгэхдээ хүлээлгээд өгчихсөн байшин шүү дээ, зарчмын хувьд ердөө ч таарахгүй. Илжиг, модон хударгандаа гэж үг бий. Та ингэж явж байж ядарчихна. Хоёр хоног амар гэсээр байтал... гээд би үгээ таслав. Гэнэт шөнө унахын адил өвгөний хар царайд сүүдэр татаад, шар өөх хурсан хөгшин хөвхөр нүдэнд нь үзэгдэж эхэлсэн сэтгэл тэнүүн байдал алга болоход би ухуулгаа аргагүй зогссон нь тэр.

- Та намайг илжиг гэж. Таны ч миний ч хайртай барилгынхаа ажлыг модон хударга гэж байгаа биш байх л даа...

- Үгүй, үгүй яалаа гэж, яалаа гэж, би таныг амраасай гэсэндээ л будлиж, эвгүй зүйрлэж орхив. Ер таныг гомдоох гэсэнгүй билээ.

- Би өтлөөд гомдомтхой, бас чихэрт дуртай болсон маань үнэн ч, танд огт гоморхсонгүй, харин ч илжигтэй нэг зиндаанд тавиулна гэдэг аз гэж бодож байна

Өвгөнийг харвал түүний үрчлээс батга хоёрт баригдсан ойн хар хөрс мэт тослог хар нүүрэнд тоглож тохуурхсан буюу намайг тавлаж цаашлуулсан янз алга байв.

Зөгий, шоргоолж, илжиг гурав хорвоогийн ховор тэсвэртэн, ховор хөдөлмөрч амьтад шүү гэж өвгөн хэллээ. Түүний үг өөртэй нь адилхан энгийн үнэн, гүдэс цагаан байв. Би дуугарсангүй, бодлогошрон зогслоо.

Тэд өөр өөрдсийнхөө төрөлд хосгүй хүчтэнүүд боловч хосгүй энхч, бүтээлч, юу гэмээр юм бэ дээ, дайнч хийрхүү биш гэмээр амьтан юмаа. Тийм байгаль төрх бол нандин чанар шүү, хүү минь...

Сүхээ гуай намайг хүү минь гэсэндээ баахан эвгүй болж мушилзав. Дараахь хурамд түүний урт буурал хөмсөг босчихсон эрвэгнэн хөдөлж байна уу даа гэхээр сүртэй харагдаж байлаа.

- Та үнэн юм ярьж байна, энэ чинь гүн ухаан байна

- Үгүй л дээ, дарга минь энэ бол гүн ухаан биш байх, энэ бол зүгээр л хар борог амьдралын захын бяцхан үнэн болов уу?

Би илжигний тухай яриаг орхих санаатай:

- За хөөрхий, тийм байдаг байж, илжгээ гэж сонин амьтан шүү. Өөр юутайв, Сүхээ гуай, та тэгээд засвараа хийвэл хий л дээ.

- Сонин амьтан шүү гэнээ? гэж яриан дундуур орж ирсэн нь өвгөн миний үгний сүүлийг огт сонсоогүйн тэмдэг байлаа. Цааш хүүрнэх нь:

- Илжиг яагаад ч юм бэ, муу нэртэй боловч би түүнийг хайрладаг. Урт чихтэй төрсөн нь тэр адгуусны буруу биш л дээ. Үүрсэж янцгааж чаддаггүйн учир түүнд гэм оноож бас болохгүй. Адгуус болгон хүлэг байсан бол модон хударганд юу дөрөөвчлүүлэх вэ. юун нь ачуулж тэгнүүлэх вэ? одоо ч яахав, техникийн зуун. Илжигний зуун гэж байгаагүй байх л даа, гэхдээ л илжигний үе гэж байсан байж таарна. Энэ бол их тархсан амьтан, би ганцхан монгол нутгийнхаа хэмжээнд яриагүй байна...

- Тийм ээ, бага Ази, Ойр болон Дундаг Дорнод, Кавказ, Энэтхэг, Хятад ер нь газар болгонд байдаг байхаа... Сүхээ гуай уучлаарай. Таны амьдралд энэ адгуус нэг л сайн үйл гүйцэтгэсэн учиртай юмаа даа? гэвэл Сүхээ гуай надруу ухаантай хийгээд гунигтай дөлгөөн бор нүдээ өргөв. Тэгээд удаан харав. Тэгснээ хадан цагаан шигтгэсэн довжоон дээр сууж, ёнхор хангинуураа өвөр дээрээ тавиад, хар халтар иший нь хүүхдийн зулай мэт аяархан илбэв. Энэ бол урт ярианы эхэн байж билээ.

- Монгол морины холын садан байж ч болох энэ амьтан намайг эх оронд минь хүргэж авчирсан юм даа

- Үгүй ээ, яалаа гэнээ? Та өөр газар оронд явсан юмуу?

- Тийм ээ, тэгсэн юм. Би Манжуурын толгод, Хиросимын гудамж энээ тэрээ гээд холын нутаг хэрсэн хүн шүү... Миний нүд орой дээрээ гарсныг үзэж:

- Та гайхаж байна уу? завтай бол би хуучилъя л даа гэв. Би:

- Завтай, гэв

Сүхээ гуай өгүүлэх нь:

Би нэгэн мянган есөн зуун арван таван оны төл, одоо жаран тав хүрлээ... гучин хоёр оны эсэргүүний жил говийн хойт зоогоор нутаглаж байсан манайхны хэсэг айл муу хүмүүсийн хоморгонд автаж, өсөхөөс заяасан нутаг усаа орхин Дотоод Монгол руу зулбан очиж суурьшсан юм. Аав минь башир үгэнд залигуулж чадагдсанаа удалгүй ухаарч, төрсөн газар шороогоо гансран мөрөөддөг болов. Ээжид нэг удаа:

- Долгороо, урьд шөнө би галбын шаргал говийнхоо зэрэглээнд умбаж тоглож, тэгээд уусаж алга болж байна гэж зүүдэллээ гэж ярьж билээ

- Яадаг билээ юуны дохио юм бол гэж эх дуу алдав

- Харин тийм, сайхан хэрнээ сонин зүүд юм. Би бодохноо энэ бол төрөлх Монгол орондоо дариу нүү гэсэн тэмдэг байх гэж бодно. Унасан газар шороондоо шингэж ширгэх шиг жаргал хаана гэж аав хариулав.

- Чиний минь таалал мэдэж дээ гэж ээж дуугарч суув.

Тэгээд л шөнө дунд нүүгээд хөдөлчихнө тэр. Нүүх юу байхав хамгийн хэрэгтэй гэснийгээ л ганц муу өндөр шар атандаа ачаалсандаа. Аав морьтой, эх бид хоёр явган. Үүрийн гозон гэгээтэй уралдаж хилийн дээс алхана гэсэн маань байдаггүй, төөрчихдөг байна. Хийвэл битгий ай, айвал битгий хий гэгч болжээ. Шөнө хүлээх арга алга. Буцах замд бууны гохон дээр дайсны хуруу тавиастай учир ухрах газаргүй бидэнд эх орноо тэмцэн шамдах ганцхан зам үлдэв. Нэлээд ч дөхчихлөө. Зуны нар тэнгэрийн зулайд цойлсон үе, гэнэт битүү нүргэлсэн их чимээ гарсан нь халуунаа багтааж ядаж байсан нар дэлбэрэх шиг санагдаж билээ. Ээж хэлэв:

- Очир чи яв. Монгол нутгийнхаа гүн рүү орж үз. Чиний морь сайн, зугтаа. Харж байна уу, гурван морьтой хүн шуургалан орж ирж байна. Очиж эх орноосоо уучлалт эрвэл бид хоёрыг ч гэсэн буцааж авна, говь шигээ сэтгэл нь уужим эх орон минь. Очиж соёмбот тугандаа мөргө гэлээ. Би хэзээ ч ээжийг ийм үг хэлнэ гэж санаагүй юмсан. Чи урт үстэй ч урт ухаантай хүн шүү. Хүү бид хоёр азтай улс юмаа гэж нэгэнтээ аавын ээжид хэлсэн нь миний санаанд орж байв.

- Харинээ Долгор минь. Үхэвч сэхэвч гурвуулаа хамт нь дээргүй юу? Уг нь нутаг минь саахалтын газар л гэж хэлтэл нь аавын минь үгийг гүйцээхгүй гэсэн шиг дахин буун дуу тасхийв. Эцэг эмээлийнхээ бүүргэнээс халыт шүүрэн атгаад хонгор мориныхоо дэлэнд эвгүй бөхийсөн нь шархадсан хэрэг байлаа.

- Амьсгалахад нь хүнд байна. Нүд юу ч харахгүй болов. Амьдрал төгслөө... Морийг минь ташуурдаад өгөөч. Нутгийнхаа шороог үзэж... гэж арай ядан хэлээд бүүргээ алдвал арханд пижигнэх туурайн чимээнээс цочиж, халиун нь огло үрсэн давхилаа. Нүдний үзүүр тусах эс тусах газар очоод аав морь хоёр салав. Морь нь баруун хойш гэлдрэн одоход тэнгэр газрын савслаганаас зэрэглээн тэнгисийн бөөн долгион хүрч ирээд аавыг хаман авч одох лагуу адил алга болговой. Галбын шаргал говийнхоо зэрэглээнд аав минь умбан тоглож, уусан шингэж байгаа нь энэ үү дээ, мөн ч хатуу хорвоо еэ гэж би төлжиж гүйцээгүй дэгдээхэй ухаандаа бодлоо. Морин дээрээсээ халин төрөл элсэндээ шингэж арилсан аав, хилийн гадна дайсанд бүслэгдсэн явган хүү наддаа азтай хүн санагдана. Эх орон аав хоёрыгоо нэгэн зэрэг бүрмөсөн алдаж байна уу даа гэж би дотроо харлуулан зогсоно.

Муурч унасан эх цагийн дараа сэргэхэд хилийн гурван цэрэг биднийг буцааж туулаа.

Ингэсхийгээд суурьшсан болж, шар хоног бор өдрийг өнгөрөөж байгаад төрөлх говийн мэлмий нааш харсан өдрийг олж хөдөлбөр нутагтаа харьчихна даа гэж эх ярьдаг байж билээ. Дүрэвсэн айлуудын ихэнх нь буцаж амжсан. Надад эрийн ухаан дутаж, чамд эрэмгий бяр дутаж бид хоёрыг бөгсөө даахгүй суутал хил бүрмөсөн хаачих вий гэж ээж үглэдэг байв. Үнэндээ гэвэл юм юмны тохироо нэг л бүрдэхгүйгээс гол нь бид хүмүүсийн хараанд орчихсоноос хөдлөх аргагүй байлаа. Ээжийн тухайд гэвэл тэр минь миний нүдэн дээр улам

улам л өөр хорвоо болж байсан юм. Зарим төмөр голд ороод шавар болж бутардаг байхад, зарим төмөр ган болж хатуурдаг гэдэг, эх минь ган болж хатах төмөр байжээ.

Харамсал болоход эхийн болгоомжилсон нь онож Монгол руу оргох гэсэн өвөрлөгчийн хэдэн гэрийн хамт гоминданы түшмэлийн шийдвэрээр гурван сарын дараа манайх гэдэг айлыг Манжуурын толгод руу нүүлгэх болвоо. Тэр нүүдлийн аянг тэр чигээрээ зовлонгийн далай байсан гэвэл хилсдэхгүй. Гэхдээ л бид туулах л ёстойгоос хойш туулсан даа. Биднийг заагдсан газраа зорьж нүүж явахад япон цэрэг бас тэр газрыг зорьж нүүж явжээ. Бид ч Манжуурын толгодод хүрсэн, Манжуурын толгод ч Японд эзлэгдсэндээ. Мэдээжийн энэ бол бид ч эзлэгдлээ гэсэн үг. Нуур амаргүйгээс хойш нугас юунд амар байх билээ. Яргуй мишээж, харгүй борлонтож, таван сарын явган зэрэглээ татсан өдөр юмсан. Салхин зөөлөн зөөлөн үлээнэ. Говийн минь баян бүрдийн ус шиг тэр салхин бас бидрэнтэж байх шиг санагдана. Ийм өдөр бид нэг аятайхан гэсэн дов олж буугаад, би муу овоохойгоо босгосон шиг байв. Ээж минь бор цайгаа өндгөн тогоондоо чанаж дуусаа юм биз.

- Хүү хүрч ир. Хоёул гадаа цайлая гэж дуудахад нь би хүрч ирэв. Хоёр хоёр аяга цай ууж амжсан маань л их юм болж билээ. Сургаа та нарт олонт сонгосон, одоо зүсээ харуулна гэсэн шиг япон цэргүүд шуургалаад ирэх нь тэр. Нар салхи эзэгнэсэн хүлгийн тоост монгол хүний нүдэнд яах аргагүй зэвхий цагаан царайтай, ижилхэн ногоон даавуун өмд цамц өмссөн, хятад алхаандаа шалмаг явдалтай тийм хүмүүс байлаа, япон гэдэг. Тэд мөн ч олон хятад, манжийн амиар наадаж олон тосгоны нь хяравсалсандаа. Бид хоёрт түйвэх сэтгэл байснаас, түйвээлгэх хөрөнгө байсан биш. Харин Эх орноос минь үлдсэн ганцыг мэдсэн хэрэг байлгүй, өндөр шар атыгминь авсан юм. Миний нүдэнд нулимс мэлмэрэн гарч ирэхийг атныхаа араас харж зогссон эх ажиглаж:

- Унхиаатай байж үз. Хөгшин эм надаас дор уу чи. Ямар Монгол эх орноо гэсэн санаагий чинь эд авчихсан биш. Авчихаж чадах ч биш гэж хэлээд дээлий минь арыг гайгүй хөөргөж байсан юмсан. Эр хүн хэтэрхий элгээ дарж бүслэх нь хүүхэн ёоз, унхиагүйн тэмдэг гэж эх боддог байжээ.

- Хүү чи эр болох гэж яарч, яарсныхаа хирээр ч эр хүн болж байна. Гэхдээ ч чиний ясны араншинд байдаг юмуу, охин намба үзүүлэх чинь их юм. За за, яншихаа больё. Япон биднээс юу авна гэж эргэж ирэх вэ? Нэг самуурай аавын чинь баруун гар явсан хангинуурыг авснаа, тээршаасан хэрэг биз зүүн тийшээ чулуудаж орхино билээ. Тоос манараад ойчихыг нь би харсан, явж авчир гэж ээж тушаав. Би ч бас, харсан байлаа. Би бас хэлүүлэлгүй очоод л авчих байлаа. Харин хангинуур аавын баруун гар явсныг эх зориуд буюу тохиолдлоор сануулсан нь миний хувьд ухаан нь геологчид Эрдэнэтийг нээсэн шиг л хэрэг болж билээ. Хороогдсон мужаан ааваа орлож би гэдэг хүн чухам мужаан л болох учиртай юм байна гэж тэгэхэд л эргэж буцах замгүйгээр ойлгосон юм. Аавын баруун гар явсан сүх миний баруун гар болно гэж бодоход юу гэмээр юм бэ дээ... сайхан л байсандаа. Адаглаж ертөнцийн мужааны тоо ааваар хорогдохыг болих ёстой байв. Энэ бодол ч намайг баярлууллаа. Тоос хадаан гүйсээр аавынхаа сүхэн дээр очсон юмсан. Сэвтсэн ч үгүй, эмтэрсэн ч үгүй байгаад нь сэтгэл хөөрч онгин дээр нь үнсэхдээ ээж харчихсан байх вий гэж дотроо их л хулчийж билээ. Харин тэгж төмөр үнссэнийгээ одоо ч охин араншин гэж боддоггүй юм. Сүхээ аваад эргэхдээ газраас ургасан тэнгэрээс унасан алин болохыг бүү мэд хажууханд минь нэг муу илжиг бэхцийн

зогсохыг үзэв. Ээжид ирээд хэлбэл:

- Саяын муусайн самуурайнууд орхичихож л дээ. Дээрэмчин цэрэг ядуу хүний алх сүхийг данслахаас наагуур хурааж байхад, дээрэмдүүлсэн бид тэр цэргийн бүхэл бүтэн адгуусыг хардаггүй байна шүү. Энэ лав дайны ухаан гэдэг нь байлгүй дээ, очиж үзье гэлээ. Бид очиж үзэхээр явав.

- Хөөрхий энэ амьтны тураал нь гүйцэж ясан хэдрэг нуруу, янгирцаг сүүж хоёр л үлдэж дээ. Шороо нь энд овосхийгээ юм биз... Үгүй ээ, энэ чинь юун их унжсан гэдэс билээ? гэснээ эх тэмтэрч үзээд:

- Хээл нь тулсан хөөрхий байна шүү дээ. Ийм зовлогонд давхар бие ачаад энэ амьтан яаж үхэр буу даахав. Хариугүй унагалах нь гэж бодлогошрон хэлэв. Тэгээд толгойгоо дээш өргөж зоримгоор.

- Төл хүлээж авахад бэлдэе гэлээ.

Энэ үед манай гаднаас хөдөлсөн японууд хамгийн ойрмогхон байсан манж нарын суурин руу очиж хярваслах ажлаа хийж эхлэв. Цагаан суурин хүрэн улаан гал болж хувирах нь цусандаа хутгалдан амь тавьж байх шиг санагдана. Удалгүй хар нурам боллоо. Амь тавьсан нь тэрээ. Үүнийг хараад би бодов. “Эд японууд эвдлэн сүйтгэж байхад, эднээс дутуугүй бүтээн босгогчид бас байх ёстой. Заавал байх ёстой. Тэгэхгүй бол юу болох вэ? миний мужаан болох учрын тэн хагас нь энд байна. Ингэж би түрүүчийнхээ олсон бодлыг гүйцээсэн юмсан. Гэвч мужаан болоход мужаан болох хүсэл, хангинуур сүх, нялх биетэй илжиг гурав их дугааж байлаа. Тэгэхдээ эцсийн эцэст л энэ гурвынхаа хүчинд мэргэжилдээ хүрсэн. Хүртлээ хагас жил болсоон. Энэ хооронд, энэ хооронд гэдэг маань японы эзлэн түрэмгийллийн уур дарагдтал гэсэн үг, амь зуухын тулд зүглээгүй зүг, зүхүүлээгүй хараал, хийгээгүй хар ажил үгүй, удалгүй японууд хүнд байшин сав хэрэгтэй гэдгийг ойлгож оромж овойлгохыг зөвшөөрөх болсон юм. Ээж илжиг хоёр шавар зөөнө, сүх бид хоёр модон дээр ажиллана. Хэрээс нь хэтэрсэн ажил өгөөд өөрөө хэрдээ таарсан ажил авахад надаас сүүлд ядардагт нь би илжгэндээ баярладаг байна. Нарнаас нар хүртэл ажиллаад буцахдаа ээжийг би дагаад, илжиг намайг дагаад илжигийг унага нь дагаад явдагсан. Сүүлдээ цувааны тэргүүнд би гардаг болсон юм. Цэргийн хэлээр бол парад командлагч нь гэхүүдээ. Бид дайнд сүйтгүүлсэн мөн ч олон байшингийн сэгийг зайлуулж, мөн ч олон суурин сэргээн босголцсондоо. Ажил маань амьдралын маань хэрэгцээ байснаа бусдын амьдрахын хэрэгцээ болж хувирч байна гэдгийг би ойлгож билээ. Нутгийн манж нар биднийг “энхийн жагсаал” гэж хочилдогсон. Биднийг гэдэг маань ээж бид хоёр тэгээд хоёр илжиг шүү дээ. Бас “барилгачдын бригад” гэдэг ч нэр зүүвдээ. Жилийн дараа ганц өрөө байшинтай болж би ч эрийн цээнд хүрч, илжигний унага ч илжиг болж өслөө. Энэ бол эрдэнэт нутгийнхаа босгыг дотогш алхахын тул нэг үзээд алдаж болно гэсэн үг. Гэвч даяар олноор цаг төр үймж Халхын голын дараа хоёрдугаар дайн шатаад зүүн зүгт ч байдал хурцадсан нь зуд боосон шиг л болж, бидний оргох зулбах санааг бэрхээр хашив. Тэснэ тэснэ гэхэд хэмжээ байдаг юм билээ. Ээж хоёул ярилцаж 44 оны 12-р сарын 22-нийг товлон авлаа. Хамгийн урт шөнийг сонгосон нь тэр. Бэлтгэлийг ч мөн ч олон хоног нарийн чамбай хийсэндээ. Газрын зураграхуу юм хүртэл зэхсэн юмсан. Шөнө, дунд хагаслан мордохоор болоод ээжий хөгшин илжгэндээ хөл хөндийлж, би залуугий нь дөрөөвчилнө гэж тохиролцоод хэвтэв.

- Хүү минь чи хангинуураа бэлдсэн биз гэж ээж гэнэт асуулаа

- Ямар мужаан хийх гэж яваа биш, аваагүй ээ гэж би шогчлон хариулав.

Яг энэ үед хаалга нүддэг байна шүү. Хичнээн чанга балбасан гэж санана. Би ч давхийлээ, ээж ч давхийлээ. Дараахь хурманд хоёулаа зэрэг орон дээрээ шомбойтол суучихсан байв.

Япончууд орж ирэв. Хятад лааны гэрэлд үүдэнд зогсох тэдний царай төдий л сайн ялгарсангүй. Харин ээж бид хоёр биенээ тун сайн харж байна билээ. Ингээд л баригджээ гэж бодсон би ээжийг сэжиглэн харвал, ээж намайг илүү хортой, хорсолтойгоор сэжиглэн харж байв. Хоёулахнаа хуйвалдчихаад, хоёулханаа оргохын босгон дээр баригдах болдог. Надад ээж минь Эрдэнэ -ус баян бүрдээсээ олон дахин хямдхан санагдаж билээ. Тэгтэл япончуудын нэг нь дэмий нэг юм ам нээж нүглийн хүлээс тайлагдах нь тэр.

- Шөнө дунд тав алдуулж яваадаа уучлалт эрье. Ноён Сүхээ таныг Японы Хиросим хотод гурван жилийн хугацаатай нарийн мэргэжлийн сургуульд илгээхээр шийдсэн. Муухан мужаан Та лав л дунд зэргийн болж ирнэ гэсэн үг. Жил болгон амралтаар чинь ирүүлнэ. Их наран улсын эзэн хааны өмөгт өлмийд ойрхон очих өндөр завшаандаа Та баярлаж байна уу гэнэ. Би ээж рүү харвал ээж толгой дохиж суугаа. Би:

- Би баярлаж байна гэсэн юмсан. Өглөө нь эх намайг мордуулахдаа:

- Буутай гурван цэрэгт чи бид хоёр өөр ямар үг хэлэх билээ дээ гэсэн юм.

Аавыг нас барснаас хойш надад нулимсаа бараг үзүүлээгүй ээж гаргаж өгөхдөө уйлсан. Урьд шөнө нь хүйтэн харц зөрүүлснээ санаад ч тэгж уйлсан байж болох юм. Үнэхээр өнгөрсөн шөнийн тэр нэгэн агшин өмнө хүлээж байгаа Хиросимын гурван жилээс ч хар байлаа. Би эхийн толгойг илж:

- Эх Та намайг хүлээж байгаарай. Эх орон минь бид хоёрыг хүлээж байгаа гэж хэлсэн. Анх түрүү төрсөн ээждээ том үг хэлж байгаа маань тэр.

Хиросимд 45 оны 1 сарын 15-нд очсон санагдана. Ээжтэйгээ ярилцаж тохиролцсон ёсоор улсынхаа элчин сайдын яамыг сэм сураглахаар Токио хот орвоо. Бүтэн хоног тэнээд ямар ч үр дүнгүй. Тэгээд арга барахдаа төв цагдаагийн газар нь очиж баривчлагдахаас наагуур юм болж билээ. Гозгор цагаан дарга намайг доромж нүдээр шог хараад:

- Одоохондоо Хятад манай хоёрын дундын өмч байгаа, мөд удахгүй Хятадтайгаа хамт Их наран улсынх болох ганцхан Монголын би мэднэ. Өөр Монголыг би мэдэхгүй гэж агсрахад нь би сүү долоосон гөлөг шиг л гарч одсон.

Харин дотроо: “Та нар Халхын голд хэнд муугаа үзэгдсэнээ, яаж муугаа үзэгдсэнээ мартаагүй баймаарсан” гэж хорсон зүхэж явлаа. Гэхдээ л энэ бол жадны үзүүрт зүрхээрээ тулж очсонтой адил гэнэн хийсэн том алдаа байсан юм... Би өөрийгөө зэмлэсээр Хиросимд буцаж ирэв.

Байрын хаалгаар орвол тогооч авгай гудманд зогсож угтлаа. Түүний уриалгахан инээмсэглэл

миний сэтгэлийг засах гэсэн юм шиг санагдана. Нутгийн орос тэр эмэгтэй намайг юу гэж явсныг мэдэхгүй байж, хэрэг зориг хэрхэн бүтсэнийг асуусанд би түүнд урамгүйхэн хариу тавив.

- Би удалгүй Хабаровск бүр мөсөн явна. Надад урилга ирчихсэн. Чи Монгол руу захиа илгээх бол надаар явуулчих. Москва дамжаад л хүрнэ гэж мэдээрэй гэв. Би тэгэхэд нь:

- Харин ээ, гэж хариулав. Үнэндээ хэнд ч захиа явуулах байлаа даа. тэгээд үсэг бичгээ ч мэдэхгүй хүн шүү дээ би чинь.

- Чи юунд харин ээ гэж байгаа юм бэ? нэг бол за, нэг бол үгүй л гээч. Би бол эх орондоо явлаа гээд л явж байгаа юм.

Би шууд ам өгөхөөс бултах санаатай Галя гуайн цэнхэр нүдийг зөөлөн харж:

- За, үгүй хоёрын хооронд бүхэл ертөнц багтдаг гэсэн байхаа гэж займруулбал:

- Тэгэлгүй яахав, энэ хоёр үг, үнэн худал хоёр шиг, үхэл амьдрал хоёр шиг үгсийн хоёр туйл юм чинь. Эдний хооронд чиний эргэлзэж байгаа чинь багтана. Чи өөрөө ч багтана... Яамай даа тоглосон юм. Ингэхэд чи оросоор за, үгүй гэдэг хоёр үгийг мэдэх үү?

- Би оросоор ганц ч үг мэдэхгүй

- Бүх үг энэ л хоёрын завсар багтах учир энэ хоёроос эхлээд хоёр захаас нь хамаад сурчихгүй юу. Адаглаж надтай танилцсаны дурсгал болог доо.

- За тэгье, заагаад өг.

- За гэхийг “да” гэдэг юм. Үгүй гэхийн “нет” гэдэг юм

- Да нет, да нет, да нет.. За сурлаа гэвэл Галя гуай тас тас инээж:

- Одоо монголоор надад хэлж аль. Чамтай танилцсаны дурсгал болог гэв. Би дуртайяа хэлж өглөө. Токио ороод миний хөрсөн сэтгэл одоо дулаацаж байгааг би мэдрэв. Галяг гуайлахгүй “чи” гэж дуудаж байна гэж шийдлээ. Ингэх нь миний түүнд дотносон сэтгэлийг илэрхийлэх ёстой байв.

Найман сар гарах дөхлөө. Би уг нь ээжийгээ, эх нутгаа жаал жаахан санаад л байсан юм. Гэтэл нэг шөнө зүүдэлдэг байна. Ямар зүүд байсан гэж санана. Манан хүдэн ч биш, май утаа ч биш ер нь юу нь үл мэдэгдэх нүглийн их бие ертөнцийг ороосон байх юм. Гэтэл гэнэт гал мөндөр хоёр зэрэг буудаг байна. Галдаа тэр, усыг шатаадаг гал байлаа. Мөндөрдөө тэр усан дээр унаад гал болдог мөндөр байлаа. Бүх газар орон энэ галав юүлэхийн угтал ч байж мэдэх аюулд нэрвэгдээ юу гэж бодтол миний эрэг дээр нь унасан галбын говийн Эрдэнэ- ус баян бүрд нүдэнд дурайн үзэгдэв. Эрэгт нь нэг хүн зогсож байх юм. Сайн харвал ээж минь. Ээж баруун мээмээрээ намайг даллаж байв. Үг хэлэхгүй юм байхдаа гэтэл үг хэллээ. Сайн чагнавал: Хангинуураа битгий мартаарай. гэж байна. “Хүү нь яаж очих билээ?” гээд хашгираадахсан чинь дуунаасаа цочоод сэрчихсэн юм. Дөнгөж нэг цаг болж байв. Тэр шөнө

унтсангүй. Ингээд л гэртээ харих өдрийн бодол шөнийн зовлон эхлэх нь тэр. Өвчин олохыг дөхлөө. Яаж ийж байгаад чөлөө авахаар болов. Гэтэл мөнгө байдаггүй ээ. Галяг сураглалат нутаг буцчихсан байлаа. Оройн цагаар очиж хар бор ажил хийж ганц нэгэн зоос олдог байсан нэг баяныд гуядаж хүрэвээ. Учраа хэлсэнд:

- Чи барьцаанд нь юу өгөх юм бэ? гэлээ

- Барьцаанд өгөх юмтай бол юунд ингэж явах вэ гэж хэлчихээд “Яхирладаг буруу болов” гэж дотроо гэмшиж суутал:

- Зардлын мөнгө зүгээр олох гэсэн бол заавал над руу ирдэг чинь юу вэ ноён Сүхээ? Чи намайг болоод өөрийгөө тийм гэнэнд тооцоогүй биз?

- Би зээлэх л гэсэн юм

- Зээлэх гэдэг үг япон хэлнээс хасагдаж байгаа шүү дээ, хонгор минь, Чиний гэрт чинь ямар хөрөнгө бийв?

- Хөгшин залуу хоёр илжиг, гайгүй сайн ганц өрөө байшин бий

- Чи хэдүүл билээ?

- Ижийтэйгээ хоёул суудаг

Тэгвэл ганц өрөө байшин, хоёр илжигний үнэний тэн хагасаар дэнчин тавьж түр зээлдэхийг би зөвшөөрч байна. Төрөлх нутгаа санаж үзсэн миний мэт хүн чамтай дайралдсан нь аз болжээ. Хорвоо дээр итгэх ганц зүйл үлдсэн юм. Энэ бол чамд байгаль дүрээрээ байгаа гэнэн хонгор зан билээ. Хүмүүс чамайг дорой ядуу болгосон ч эвдэж чадсангүй... за хоёр хувьд өргөдөл гарга. Зургаа наагаад гарынхаа үсгийг зурчих гэдэг байна.

Би баярлахдаа өвдөг дээрээ суучихсан юм. Түүний нэмэн хэлэх нь:

- Капитализм гэдэг цар хүрээ өргөн, чигжрүү үйлчилгээтэй нохой шүү. Тэр тутмаа японы капитализм бүр нэг чамбайхан гэж мэдээрэй. Чамайг сар руу зугтаасан ч цаад гайхал чинь олоод л бидний өрийг цайруулчихна.

Би толгой мэхийв

...Намайг гэртээ хүрч очиход ээж мэгшин уйлж тосов. Үс нь бараг цагаан болсон байлаа. Тэгээд надаас айж байгаа юм шиг ухарч зогсоод, ер галзуурчихсан байна уу гэтэл том том харж хонгор эх минь.

- Чи минь мөн үү, чи минь. Эсвэл эсвэл бурхан надаар тоглож байна уу? гээд нэг хэсэг зогсоод байсан шүү.

- Би чинь мөн байнаа, ээж минь. Сүхээ чинь, хүү чинь байна. Аавын баруун гар явсан хангинуураа аваад ирсэн, Та хараа гээд өөр рүү нь хоёр алхтал сая надруу тулж, хоёр хацар

дээр минь үнсэж билээ. Тэгээд юу юугүй энгэр заамыг минь тайчиж гарав.

- Миний чамд хайрласан нэг онгон мэнгэ байх ёстой. Байх л ёстой. Аан энэ байна, мөн байна. Чи минь ч мөн байна гээд ээж минь тэр мөнгийг лав тоо алдартал үнсэж билээ. Тэгээд нэлээд тайвширч

- Тийм байна, яах аргагүй чи минь. Нар тэр байна. Энэ бол шөнө биш, би зүүдлээгүй гэсэн үг, гэхэд нь би хариуд нь:

- Би атомын бөмбөгөнд үхээгүй ээ хүү нь яваад ирсэн. Эх орон та хоёр минь намайг зүгээр нэг хүлээж суугаагүй, намайг үхэлд өгөлгүй даллаад аваад ирсэн шүү дээ гэж хариулав. Эх миний үгийг сонсохгүй байлаа. Түүний бодож байснаа хэлэх нь:

- Миний толгойтой үс юун хамаа, цагаан л болоо биз дээ, хоёр хоногт үс цайчихсан... Үүгээр чөлөөлөлтийн орос монгол цэрэг явсаан. Би очоогүй. Ямар ч гэмгүй хүүгийнх нь заяаг түшиж чадалгүй атомын бөмбөгөнд сүйтгүүлчихээд ямар нүүрээрээ улсынхаа тэр зэвсгийн элчид бараалхах билээ гэж бодсон. Тэгээд очоогүй ээ гэж ээж ярив.

Өглөө нь бид хоёр муу илжгээ дөрөөвчилөөд баруун зүг мордлоо. Нар бидний араас гарч байв. Би эхийгээ төдийгүй, нарыг дагуулаад эрдэнэ болсон эх орон, монгол түмэндээ очих гэж байгаа юм шиг аугаа сайхан байж билээ. Долоон гүвээ даваад бид хоёр амрахаар саатсан юм. Эхийг асганы сүүдэрт түр суулгачихаад өөрөө хомоол аргал этрүүлэхээр баахан зайлж одов. Гэтэл хаанаас гараад ирснийг бүү мэд над дээр хоёр орос цэрэг хүрч ирдэг байна. Их л сэжигтэй нүдээр харахад нь би солиотой юм шиг инээмсэглэн ширтэж байлаа. Нөгөөдүүл чинь хоорондоо баахан шулганалдсанаа өндөр бүдүүн нь намайг нэгжиж эхэлдэг байна шүү. Тэгснээ миний япон саарал цамцны наангинаас нөгөөх баян хүнд бичсэн өргөдлийн нэг хувийг гаргаад ирвээ. Дэлгэж харснаа намайг бууны бөгсөөр түлхэж:

- Японский солдат... гээд баахан хилэгнэсэн нь оргосон япон цэрэг л гэж андуурч байгаа бололтой. Би дотроо учир нь олдох байлгүй, би ч харин даанч нэг япон биш дээ. Хэл мэдэхгүй хүн гөлийж л байхаас даа гэж бодож зогсов. Тэгтэл нөгөөтөх чинь гэдрэг болоод автоматаа мөрнөөсөө шүүрэх нь тэр. Над руу юу юугүй галлах нь ээ. Хурам л алдвал би хорвоогоо алдах байлаа. Ээжийгээ дагуулаад эх орондоо очиж яваа хүн үхэж болох уу даа. Би нэг л мэдэхнээ баахан юм хашгирч байсан шүү. Юу гэж санана, орос хэлээр шүү.

- Би нет японский. Би да монгольский. Москва, Орос, Ситалин да. Токио, Берлин, Гитлер нет. Улаанбаатар, Чойбалсан да. Ром нет гэж орилж байлаа. Орос цэргийн нүдэндэх хилэнгийн оч номхорсон боловч, тэр зэвсгээ хураахгүй л зогсоно.

Бүхэл биенд нь тээнэгэлзсэний шинж илэрхий.

“Дэлхийг, нарыг тахлаас чөлөөлсөн орос цэргээр нүгэл хийлгэх хэрэг үү” гэж би бодов. Тэр бодол намайг дахин галзууруулжээ.

-Галя да, самуурай нет. Илжиг да, танк нет. Сүх да, атомын бөмбөг нет...

Орос цэрэг инээмсэглэн автоматаа мөрөвчлөхөд би сая л нэг юм өөрийн ухаан орлоо. Цэргийн уруулд Галягийн инээмсэглэл байхыг таньж, өөрөө хангинуур сүхээ тэвэрчихсэн зогсож байгаагаа мэдсэн юм. Бас ээж минь хажууд орь дуу тавьчихсан ирж явааг харлаа. Хоёр оросын нэг нь:

- Это есть настоящая монгольская мать – (Энэ ёстой нэг монгол эх байна даа?) гэж хэлээд эхийг очиж сугадвал нөгөөх нь миний гараас хангинуурыг авч:

Старик ты прав (Өвгөн минь чи зөв хэллээ) Топор да. Атомная бомба нет гэхэд нар сар, газар дэлхий, ээж хоёр илжиг минь хүртэл цөмөөр тэр үгийг давтах шиг санагдаж байв шүү.

Яриагаа өндөрлөсний тэмдэг болгож Сүхээ гуай инээмсэглэв. Харин би яагаад ч юм бэ, уйлмаар байлаа.

Май, гэхэд нь нүд өргөвөл тэр над руу хангинуураа сарвайж харагдана.

- Мөн үү? гэсэнд

- Мөн гэв. Энэ сүхнээс хэзээ нэгэн цагт адис авна даа гэж би бодлоо.

Намрын салхин миний урт үсний хөвсөлзүүлэн хийсгэж байв.

ДЭМБЭЭГИЙН МЯГМАР

Зохиолч Д.Мягмар 1933 онд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Улсын их сургууль, Москва утга зохиолын дээд курс төгссжээ. 1950 оноос уран бүтээлээ эхэлж “Нэг байшингийн тууж”, “Тээрэмчин”, “Газар бид хоёр”, “Цоморлигоо нээсэн цэцэг” зэрэг тууж, өгүүллэгийн ном, “Нандин эрдэнэ”, “Би яагаад...” драмын жүжиг бичжээ.

Зохиогчийн тууж, өгүүллэг орос, украин, литв хэлнээ тусгай ном болон хэвлэгджээ.

БУУРШГҮЙ СЭТГЭЛИЙН ИЛЧ

Бусад олноо хууран мэхэлбэл

Бүхэл насаар сэтгэлээ тамлах

«Сургаал үг»

Түвдэн өвгөн жаран насныхаа ойг хийсэн сүүлийн хэдэн шөнө ер унтсангүй. Унтъя гэвч нойр нь үл хүрнэ. Өвгөний сэтгэлд баяр хөөр, уур уцаар багтаж ядан, үерлэхдээ эргээ халин улаан хоормогоор гүвэлзэн урсдаг их мөрний ус шиг болжээ. Сэтгэлийнхээ тэр хуйлран оволзож байгаа үерийг өөрөө сайн мэдэж байв. Түвдэн, хүн болж төрөөд өнөөдрийг хүртэл ингэж айхавтар сэтгэл нь буцлан булгилж байсан нь бараг үгүй. Харин тээр жил баазын шилдэг ажилчин гэгдэж ёстой л шижигнэж явсан ид залуу насандаа нэгэн зүйлд шаналж яг одоогийнх шиг хэдэн шөнө нойргүй хоносон нь бий. Тэр тухай хожим өгүүлсүгэй. Харин албан газар нь баазынхаа тулгын чулууг тавилцсан ахмад ажилчныхаа ойг үнэхээр хөлтэй тэмдэглэжээ. Түүний гэрч гэсэн шиг бүтэн тав хоног үргэлжилсэн найр наадам бас л шувтрах болоогүй.

Зуны шөнө. Хөвчит уулын амаар зэрэгцэн буусан зуслангийнхны мөөг шиг цагаан гэрүүд зүүрмэглэсэн сүрэг хун мэт анир чимээгүй нам гүм байгаа нь шөнө орой болсныг гэрчилнэ. Уулын амны нөөлөг даган хүй хүй үлээх үелзүүр салхинд моддын орой үе үе сэрчигнэх, хад чулуун дундуур харгиатан урсах бяцхан горхины шуугих эд бүхнийг шуулттай хаяагаараа Түвдэн чагнан чагнан хэвтэж байв. Өдөр олон хүний үймээн бужигнаанд ханхалж байсан архи тамхины эхүүн хурц үнэр цөм шөнийн сийрэг агаарт цэвэршээд одоо зөвхөн айрагны исгэлэн үнэр л сэнгэнэсэн хэвээр ажээ. Өдрийн ажилд сульдсан хүүхдүүд болон зуны халуунд гол тогоотой зууралдаж ядарсан хөгшин нь нам тайван унтаж байлаа. Гагцхүү Түвдэн өвгөний нойр яавч эс хүрнэ. Тэрээр огт ядраагүй хүн үү гэвэл ерөөс тийм биш. Ойгоо тэмдэглэж найр наадам хийж байгаа хүн бусадтай адил сул чөлөөтэй байна гэж яавч үгүй. Ямар зочин хэзээ ирэхийг хэрхэн мэдэх билээ. Хүн хүрээд ирэхэд гай болоод байхгүй байвал урьсан зочноо хүндэтгээгүй хэрэг болно. Тэгэхээр яая гэх вэ, идээ будаа зассан ширээний ард бүтэн тав хоног ёстой амьд бурхан шиг суужээ. Эвдэрч хэмхэрсэн, элдэв гэмтэл согог суусан мотортой өдөр шөнөгүй ноцолдож он жил өнгөрөхийг анзааралгүй сурчихсан ажилсаг өвгөнд ингэж өнгөрүүлсэн тав хоног нь үнэндээ таван жил шиг урт санагдана. Тэгээд энэ хэд хоногоор бүх зүйл төгсдөг бол ч бас яах вэ. гэтэл энэ маань ажилгүй суухын төгсгөл биш, харин эх нь болж байдаг гэж санахаар уур нь аяндаа хүрч сэтгэлд нь аймшиг төрнө. Өрхийг нь хагас тэгшилсэн тооноор туссан сарны гэрлийг дэмий л ширтэн хэвтгэл юу юугүй гэрийн тооно далбилзан хөдлөх шиг санагдав. “Толгой эргэж байнаа даа” гэж санаад нүдээ анилаа. Үнэхээр толгой нь эргэжээ. Оройтож ирсэн зочинтой тулгаад уучихсан хэдэн хундага архи, үймэрч байгаа сэтгэлтэй нь нийлээд өвгөнийг согтоож байв. Тэгээд аажмаар нүдээ нээлээ. Тооноор шагайх сарны зэвхий цагаан туяа, ягуухан зүүншилсээр нүүр дээр нь тусав. Сарны туяа тусвал саа дайрдаг гэж хууччуулын ярьдгийг санаад хөнжлөө толгой дээгүүрээ мухлайдан нөмрөв. Гэтэл толгойд нь өдрийн олон амьтны тамхины халуун утаа, архины

эхүүн үнэр шиг элдэв бодол манаран буцалсаар байв. “...Тэр үнэн гэж үү? Тийм бол ч зүгээр өнгөрөөхгүй дээ. Шууд л сайдад өргөдөл гомдлоо бичнэ. Хэрэв хүлээж авахгүй бол бүүр дээш нь мэдүүлнэ. Би хөгширсөн болохоос биш, хөдөлмөрийн чадвараа алдсан биш. Би тэдний ажилд ямар саад болоо вэ? Хэрэв саад болсон юм бол миний дутагдлыг улаан нүүрэн дээр минь хэлээд шууд л хөөчих хэрэгтэй шүү дээ. Ингэж ажил чирэгдэл учруулж, ой мой хийх ямар хэрэг байна. Уран аргаар хөөж байгаа нь энэ үү? Өөдгүй заль мэх. Дутагдлыг минь хэлээд хөөчихсөн бол би ингэж сэтгэлээр шаналахгүй амар тайван байхсан. Гэтэл тэгсэнгүй. Тэгсэнгүйгээр барахгүй нийт ажилчдыг цуглуулж, хурал цуглаан хийж намайг хоосон магтаж, цаасан малгай өмсгөж маяглаж байхад нь би яагаад ухаарсангүй вэ. Тэнэг амьтан. Бүүр хүүхэд шиг үнэмшчихээд индэр дээрээс Даш даргыг илтгэж байхад нь “Би ингэж хүндлүүлэхээр юу бүтээчихсэн хүн билээ?” гэж санахаас нүдний нулимс аяндаа гарч байсан шүү. Тэр бол баярын нулимс байлаа. Гэтэл өнөөдөр....

Дэрэн дээр нь дусал нулимс байлаа. Энэ тэгээд үнэн гэж үү? Ээ мэдэхгүй. Хэрэв үнэн бол юунаас болов? Даш хэдий дарга болсон ч гэсэн миний сэтгэлийг мэдэх л ёстой. Ер нь маргааш орж учраа дуулбал яасан юм бэ?

...Ээ дэмий байхаа, нэгэнт шийдчихсэн юмыг чинь. Яагаад миний жаран насны ойг хуурамчаар хийж намайг ажлаас халах болов. Уржигдар орой зочдын хөл татарсан хойно, олон жил хамт ажилласан Лувсан ганцаар үлдээд... магадгүй, надад түүнийг хэлэх гэж зориуд үлдсэн юм билүү? Энэ тэрийг ярих зуур гэнэт харамссан мэт уртаар санаа алдан “Намайг ч гэсэн бас л хэдэн жилийн дараа чам шиг ажлаас халах байх даа” гэхэд нь “Юу?” гэж би гайхан асуувал “Чамайг сайндаа ч биш, ажлаас халах арга эрж ойг чинь хийж байгаа юм гэнэ” гэж амьтны ярихыг сонсоод зориуд дуулгая гэж бодсон юм. Гэтэл түлхүүр багажаа залууст гардуулж байхдаа чиний нүднээс нулимс бөмбөрч байхыг хараад би хичнээн их өрөвдөв өө” гэж хэлсэн тэр үг яав ч худал байх ёсгүй. Тэгэхээр чухам ямар учраас намайг ингэх болов? гэж эргэцүүлэн байтал эгзэгтэй зүйл сэтгэлд зурсхийн орж ирэв. Ноднин жил баазын хэмжээгээр төлөвлөгөөгөө зуун тавин хувь давуулан биелүүлэх үүрэг авах талаар яриа гаргахад нь “бүтэхгүй” гэж зөрснөө гэнэт санав. Яагаад... Яагаад би эсэргүүцсэн юм бэ? тэд ер нь юу амлах нь над шиг болсон амьтанд ямар хамаа байна?

...Үгүй ээ, хамаатай болоод л зөрсөн байж таарна. Үйлдвэр болон ажилчдынхаа цаад нөхцөл бололцоог харахгүй, хий хоосон амлалт авахын хэрэг гэж чухам юу байнаа? Хэрэв ажил төрөлдөө гаршсан арваад залуус маань цэрэгт явчихаагүйсэн бол... бас шилдэг таван залуу маань гадаадад курс сургуульд явчихаагүй бол учир байсан. Байснаас барахгүй уужуухан биелүүлэх юм чинь. Гэтэл эд бүхнээ бодолцохгүй дөнгөж сургууль комбинат төгсөөд ирсэн хэдэн хүүхэдтэйгээр тэгж худлаа амлалт авч яаж болох вэ?

Энэ бол үнэндээ өөрөө өөрийгөө хуурч байгаа хэрэг. Тэр булай явдал... Үнэнийг хэлэхэд ажилчдын хүчийг өнгөрсөн жил луйвардсан шүү. Бүх ажилчдыг улаан буланд цуглуулж байгаад норм төлөвлөгөө биелэхгүй байна гэж баахан унжруу сунжруу юм ярьж, эцэст нь “Илүү цагаар ажиллахыг эсэргүүцэж байгаа хүн та нарын дотор байвал гараа өргө” гэсэн. Тэр олон амьтны дунд “Би ажиллах дургүй байна” гэж мэдээжээр хэн гар өргөх вэ дээ. Цөм биенээ харж алмайран гайхаж байх зуур нь Даш дарга амжуулаад л тэгвэл цөм зөвшөөрч байх шив дээ гээд л гүйцэх нь тэр. Тэгээд эцэст илүү цагаар өдөр шөнөгүй ажиллуулж байж

биелүүлэхчээн болсон. Энэ чинь болдог хэрэг үү? Зүй нь “илүү цагаар хэн ажиллах хүсэлтэй байна? гэх ёстой биш үү? гэтэл тэгээгүй юм.

Өнгөрсөн жил тэгээд хичнээн их гомдол гарав. Эцсийн эцэст төлөвлөгөө норм тооны хувьд л биелж байвал чанар чансаа ч бүр хамаагаа алдсан. Эд шалгагчид ч, дарга нар ч түүний тоохоо байсан. Ингэж болдог юмуу та минь. Энэ чинь наанадаж өөрсдийгөө, цаанадаж улс эх орноо хуурч мэхэлж байгаа хэрэг. Үүнд ажилчид ямар буруу байна. Ямар ч буруу байхгүй. Тэгээд хэн буруутай болж таарах вэ? Үнэнийг хэлэхэд дарга л энэ суудлаа алдахгүй байвал бусад нь яах вэ гэж хар амиа бодсон хэрэг. Би үүнийг л хэлсэн. Гэтэл энэ үг миний жаран насны ойг өргөн тэмдэглэх болгочихлоо гэж үү? Хачин юм даа. Харин энэ жил бол төлөвлөгөөгөө зуун тавин хувиар, хагас сарын өмнө биелүүлнэ гэж үүрэг авахад ёстой болох жил. Яагаад гэвэл гадаадад явсан залуус мэргэжлээ улам ахиулаад ирсэн. Өнгөрсөн жил үйлдвэрийн босго дөнгөж алхаж байсан хүүхдүүд ч зохих туршлагатай боллоо. Тэр жил цэрэгт явсан залуус мань бас эргээд ирсэн. Гэтэл өнгөрсөн жилийнхээ өөдгүй явдлаас дэмий айчихаад амлалт үүрэг авъя гэхээр дургүйцээд байгаа юм. Нийт ажилчид дэмжээд байхад яагаад болохгүй байх вэ. Энэ тухай ярилаа гэж л намайг эвтэйхэн халах арга олсон нь энэ байжээ. Тийм байхаа даанч, уржигдар өглөө Дашийг ирэхэд «Ойгоо хийсний дараа тэр захиалгатай арваад моторыг шалавхан боогоод гаргачихъя. Хоёроос бусдыг нь ээлжийн бус бүлүүр солиод л орхивол шинэ боллоо гэсэн үг» гэхэд.

- «Энэ талаар санаа зовох явдалгүй. Бид цөмийг ярилцсан. Ер нь өнөөдрөөс эхлээд та ажил төрөл гэж сэтгэл түгшихгүй байж болно. Сул цалинд гарах таны бүх юм бэлэн болсон. Эрхийн дэвтрийг маргааш авчирч өгнө байх. Цалинг чинь харин дээгүүр тогтоосон шүү» гэхэд нь зүрх минь палхийгээд явчихав. «Та нар энэ талаар яагаад надтай ярьсангүй вэ?» гэхэд «Таныг харин ч баяртай зөвшөөрөн байх гэж бид итгэсэн юм», “Хэрэв би тэтгэвэрт гарахгүй гэвэл яах вэ”, “Яаж болдог юм бэ Түвдэн гуай. Нэгэнт шийдчихсэн юмыг та тэртэй тэргүй манай хүн шүү дээ” гэж хэлсэн үг өвгөний чихэнд гантай төмрийг иргүй хуурайгаар үрэх мэт чихран сонсогдсоор байв. Тэгээд өвгөн “Заргалданаа, сайдад өргөдөл гомдлоо бичнэ” гэж амандаа дахин үглэв.

Сарны туяа орны толгойноос хэдий нь холдон хоймрын эрээн авдарнаа туссан байв. Гэтэл авдран дээр тавьсан улаан хавтастай тэтгэврийн дэвтэр сарны цонхигор цагаан туяанд бүүдийн харагдав. Өвгөний дотор улам бачимдаж гэрт халууцаад ч байх шиг болохоор нь дээлээ нөмрөн, гутлаа холхиндог углаад гадагш гарлаа. Түвдэн өвгөний бачимдан бухимдсан сэтгэлийг орчин ертөнц байтугай гэрт амар тайван унтаж байгаа үр хүүхэд нь ч ажиг сэжиг аваагүй юм чинь. Харин зуны шөнийн цэнгэг агаар түүний сэтгэлийг түр боловч тайтгаруулав. Айхтар ширүүн аадар бороо орох янзтай, тэнгэрийн хаяанд бөөгнөрөн нүүдэллэх асга хад мэт давхарласан хар үүлсийн зах сэжүүрт халхлагдсан дүгрэг сар түүнээс зугтах мэт өнхрөн зүтгэсэн ажээ. Түвдэн гаансныхаа галыг унтраангаа “Аль эсвэл би өөрөө улс орныхоо ширүүхэн алхаанаас амьсгаадан хоцорчихоод өөрийнхөө алхаатай бусдыгаа хөл нийлүүлэх гэж мунгинан зүтгээд, ажил төрөлд нь үнэхээр саад болж байна уу? Зориг зүрх байлаа ч, хүч тэнхээгүй болчихоо юу? Нарийн ширийн хувиар тоог харалгүй алдаа хийчих вий гэж л сэтгэл зовох юм. Би үүнийг өөрөө мэдэлгүй бусдыгаа зовоож байгаа юм биш байгаа. Тэгээд надад хэлэх нь эвгүй болохоор... намайг гомдоочих байх гэж санахдаа ингэж ой мой тэмдэглэж хөл хөөрцөг болсон юм биш байгаа. Хэрэв тэгсэн бол дээш нь заргалдахын

хэрэг байна уу? За яах вэ үнэхээр би хоцрогдсон бол үнэний минь хэлээд л өгнө биз. Харин өргөдөл гомдлоо хэнээр бичүүлдэг юм билээ байз. Хүүхдүүдээрээ бичүүлэх үү? Болохгүй ээ. “Аавыг маань ажилдаа тэнцэхгүй болохоор ингэсэн юм байж” гэж ойлговол яана. Тийм булай юмыг үр хүүхдүүд минь бүү сонсог.

Харин ажлынхаа газрын залуусаар бичүүлж болох юм. Гэвч бол тийм ч сайн зүйл биш. Тэгэхээр хэнээр бичүүлэх вэ? тэгээд ч сайд дарга нарт ойлгогдтол бичих ёстой гэж бодов. Тэнгэрийн дор хаяанаас шаргал гэгээ татаж эхлэв. Харанхуй ертөнц үүрийн гэгээг сүлэгдэн цайхын сацуу өвгөний бухимдсан сэтгэлд нэгэн бодол гэрэл гэгээ мэт зурсхийн орж ирэв. “Зөв, тэр зөв шүү. Ноднин жил миний тухай бичнэ гэж надтай уулзсан нөгөө хүүг олох хэрэгтэй. Нэр нь хэн сэн билээ? Аа тийм, Бадрах. Хүнд ойлгогдохоор юмыг, тэр хүү биччихэж дөнгөнө бий вий. Өвлийн тухайн тун адтай бичсэн байсан шүү. Нүдэнд харагдмаар...

Ер нь өнөөдөр хот орж тэр сурвалжлагчтай уулзъя гэж хатуу шийдэв. Тэгээд үүр цайж буй тэнгэрийн хаяа ширтэн хэсэг сууснаа “Айл амьтан босох үед ганцаараа гадаа сууж байх ямар олиг байв вэ? амьтан хүн ч юу гэж хэлэх юм билээ” гэж бодоод гэртээ орлоо. Удалгүй хөвч ойд хөхөө донгодон зуслангийн гадуур галуу тахиа хашгичин хүүхэд багачуудын дуу, машин тэрэгний чимээ нүргэлэн хөл хөдөлгөөн ихэслээ. Түвдэн гуай тэр өдрөө сурвалжлагч Бадрахтай уулзахаар яаран хот орж сонины газраас сураглаад хөдөө ажлаар явсан, маргааш нөгөөдрөөс хэтрэхгүй ирнэ гэж жижүүр нь хэлжээ. “Бадрахыг ирэхээр өгөөрэй” гэж нэгэн зурвас бичиж бас гэрийнхээ хаягийг үлдээгээд зуслан руугаа эргэх гэснээ “Надад хойшоо яарах ажил ямар бий биш, эрт буцаж юу хийнэ. Хот орж ирснийх ажлынхаа газраар ороод гаръя” гэж бодоод бааз руугаа яаран алхаллаа. Тэгээд хашааны үүдэнд ирэнгээ гэнэт зогтусав. “Ингэж явдаг маань мөн үү, ер нь тэтгэвэрт гарчихаад долоо хонолгүй эргэж буцаж гүйгээд яасан тавьтаргүй өвгөн бэ? Ажлын хэнээ тусаж зөнөчихсэн амьтан юм гэх байх. Больё зүгээр” гэж бодоод зуслан руугаа яаран буцав.

Сурвалжлагч Бадрах хөдөөнөөс ирснийхээ маргааш нь жижиглэн үлдээсэн бичгийг олж үзэв. “Хараач хөөе, нөгөө Түвдэн гуай маань тэтгэвэрт гарчихаж, тэгээд надтай уулзах ямар хэрэг болоо юм бол? Уулзах ч яах вэ, Харин нэг л эвгүй юм болох нээ дээ. Ноднин жил найруулал бичнэ гэж амлаж амлачихаад тэр маань гологдоод сонинд нийтлэгдээгүй өнгөрсөн л харамсалтай байна. Хүний нүүр халуун. Одоо уулзахаараа юу гэж хэлнээ. Хэрэв дурсвал үнэнээ л хэлэхээс биш.

Есдүгээр сарын арван гуравны тэр нэгэн өдөр намайг эрхлэгч дуудаж билээ. Өрөөнд нь ортол сонинд нийтлэх зүйлсийн төлөвлөгөөг гаргаж:

- Дараачийн дугаарт ажилчны тухай найруулал бич гэж үүрэг өгөхөд нь би хичнээн их баярласан гэж санана. Энэ жил бол хар багаасаа мөрөөдсөн мөрөөдлийн минь биелэлийн он билээ. Яагаад гэвэл сэтгүүлчийн мэргэжил эзэмшихсэн гэж зүтгэсээр сургуулиа төгсчихөөд байгаа минь энэ. Энэ сар бол хөдөлмөр гэгч аугаа их үйлсэд миний зүтгэх анхны сар. Энэ өдөр бол сурвалжлагад гарч байгаа миний баярын өдөр гэж бодохоос сэтгэл хөрсөөр анхынхаа найрууллын баатартай уузлахаар... дугаар баазын чиглэн алхаллаа. Тэгээд уриалгахан зантай, ахимаг насны даргатай уулзаж сурвалжлахаар яваагаа хэлсэнд:

- Юун сайхан хэрэг вэ. Тэргүүний хүн манайд зөндөө бий. Чухам ямар л бол ямар. Залуу ажилчин уу? Хөгжин настай нь хэрэгтэй юу? гэдэг байгаа. Би самгардахдаа “Аль нь ч яах вэ?” гэж хэлдгийн даваан дээр “Настай нь амьдралын туршлага элбэгтэй болохоор арай илүү сайн юм ярих байх” гэж бодонгоо:

- Уул нь настай хүн байвал зүгээрсэн гэхэд

- Тэр болноо. Манай баазын ууган ажилчин, олон залуусыг моторчин болгосон Түвдэн гэж нэг өвгөн бий. Түүнтэй уулз гэв.

- Тэр өвгөн хаана... гэтэл

Моторын цехэд гэж хэлж дуусаагүй байтал утас хангинан дуугарч бидний яриаг таслав. Тэгээд би моторын цехийг эрж явтал дээр үеийн зүс таних Даш гуайтай санамсаргүй тааралдав. Тэрээр намайг бага байхад манай аймгийн баазад үйлдвэрчний хороон дээр байж билээ. Бид энэ тэрийг ярилцан, би ч зорьж яваа хэргээ хэлж Түвдэн өвгөний хаа байдгийг сурагласанд Даш гуайн нүд нь орой дээрээ гарчих шахан, үргэсэн тором шиг болсноо намайг сугадан байшингийн буланд аваачаад их л аминчлан:

- За хүү минь, чи очиж очиж Түвдэн өвгөнг сурвалжилдаг нь юу вэ? тэр чинь амьтан уруу татсан хачин нөхөр байгаа юм. Бас дураараагий нь яана. Ер нь тийм этгээдийг мандуулж бичээд байх юм бол... гэхэд нь:

- Танай дарга л бич гэсэн шүү дээ гэв.

- Дарга хэлэх яах вэ? Үйлдвэрийн дотоод ажлыг ямар нарийн мэдэх биш, харин би бол эндхийн боловсон хүчний хувьд хүн бүрийг нарийн мэдэж байна.

Та тэгвэл даргадаа хэл л дээ. Хоёулаа очье гэсэнд Даш гуай зальтайгаар инээмсэглэн

- За больё, чамайг хожим нь хэл аманд орооцолдчих вий л гэсэндээ сануулсан юм. Надад ямар хамаа байх вэ, би тэртэй тэргүй хэдэн сарын дараа гадаадад сургууль курсэд явах гэж байгаа юм гэснээ:

- Моторын цех цаанаасаа гурав дахь хаалга гэхихээд яваад өглөө.

Энэ яриа миний бодлыг бүрэн үймрүүлж орхилоо. Тэгээд гайхаш тасарч хэсэг зогслоо. “Ер нь больдог юм уу? Болохгүй ээ, сонины материал тасарна. Ямар ч байсан заавал уулзах хэрэгтэй” гэж шийдэн моторын цех гэсэн өрөөнд яаран орлоо. Чулуун царс модон шал шиг гялалзтал зүлгэжээ. Оронгуут тоос, бензины содон үнэр хамар цоргив. Хана даган байрлуулсан шүүгээний нүд том жижиг түлхүүр багаж, хэмжих нарийн хэрэгсэл цөм бүрэн бөгөөд өрөөний голын урт бандан дээр нь тав зургаан мотор зэрэгцүүлэн тавьсан харагдана. Мотор бүрийн дэргэд хэдэн хөвгүүд охид толгой өөд таталгүй ажиллаж байлаа. Зарим нь эрэг боолт чангалж, зарим нь бүслүүр бүлүүрийг нарийвчлан хэмжинэ. Би үүдэнд тээнэгэлзэн зогсов. Тэдний хэн нь ч намайг анзаарсангүй.

Тэртээ булангийн ширээн дээр суугаад нэг охинд юуг ч юм ой тойнд нь ортол тайлбарлаж суугаа, нүдэндээ зузаан гэгчийн шил зүүсэн, янхир том биетэй, халимаггүй мухар толгойтой, шанааны яс ёрдойсон туранхай гэгчийн өвгөнийг лав Түвдэн гэгч мөн биз гэж бодоод мэнд усаа мэдэлцэн, ирсэн хэргээ шууд л хэлж орхив. Өвгөн над өөд сүрхий гэгч нь харснаа:

Ер нь тоосон шинжгүй нөгөө юмаа тайлбарлаж гарав. Сурвалжлуулах гэж байгаа хөгшин, залуу хэн ч болов нүд нь сэргээд, цаанаа л баярлаад явчихдаг байх гэж миний бодсон талаар болов. Магадгүй, энэ өвгөн сайшаагдлаа гээд баярлаж муушаагдлаа гээд гомдох нь өнгөрчихсөн ч толгой юмуу? Эсвэл мань мэтийн амьтанд шалгагдсаар байгаад тогтмол хэлдэг, тоотойхон хэдэн үгтэй ч болчихсон хүн юм билүү, хэн мэдэх вэ гэж бодтол сэрэвгэр буурал хөмсгөө нэгэнтээ өргөн:

- За тэгээд яах хэрэг болж байна? гэлээ

- Танай цех надад урьд өмнө бодоогүй сонин санаа төрүүлсэн. Эмнэлгээр бол хүний зүрхэнд мэс засал хийдэг л өрөө гэсэн. Тэгэхээр техникийн зүрхэнд мэс засал хийдэг газар гэж нэртэй болсон биз гэсэнд:

- Бололгүй яах вэ, ёстой үнэн гээд урамшсан нь илт мушийтал инээж байв.

- Та ажил төрлөө надад сайхан яриад өгөөрэй гэтэл:

- Калапаны зозоор харах нүдгүй, хараншгээний боолт чангалах тэнхэлгүй болчихсон хүн чинь юугаа ярьдаг билээ гэдэг байна.

Яггүй яхир өвгөн байх нь ээ гэж би бодлоо. Тэгээд хэн хэн маань дуугаа хурааж хэсэг зогсоцгоолоо. Дуугүй байх гэгч энэ аюулаас мултрахын тулд үг өдөж:

- Та норм төлөвлөгөөгөө яаж биелүүлдэг вэ, түүнээсээ ч ярьж болно шүү дээ гээд тавьчихсан чинь тэр өвгөн лав сүүлийн дөчин жил ингэж инээж үзээгүй болов уу гэмээр...

- Норм төлөвлөгөө чухал байлгүй яах вэ. Гэхдээ та сая манай цехийг зүрхний мэс заслын өрөө гэж тун уранаар олж хэлсэн шүү. Гэтэл зүрхэнд мэс засал хийдэг эмч нар норм төлөвлөгөө хөөж орхивол мөн сүйд болноо. Би ч залуудаа норм төлөвлөгөөний хойноос унтах нойр, идэх хоолоо мартан өдөр шөнөгүй зүтгэж гялалзаж явсан удаа ч бий. Ер нь энэ орчлон гэдэг юмыг яахлаараа тэгж зөрүүлж зохиож чадна вэ? Хүн гэдэг амьтан дөнгөж ухаан сууж эхлэхээр хүч тэнхээгүй болчихдог. Хүчтэй чадалтай гялалзаж явахад нөгөө ухаан санаа нь хов хоосон байдаг. Энэ хоёр хэзээ нэг тохирдог байнаа...

гээд л овоо юм ярих нь уу гэтэл таг чиг болж орхилоо.

Ингэсээр байтал ажил тарах хэдий нь болж нөгөө залуус түлхүүр багажаа шүүгээ савандаа хийгээд нүүр гараа угааж, дээл хувцсаа сольж өмсөөд гарахдаа:

- Багшаа, түлхүүрээ ширээн дээр орхилоо баяртай гэгцгээгээд яваад өглөө. Бид хоёр хоёулахнаа үлдэв. Би бүүр гайхаш тасарч:

- Та юу ярихаа өнөө шөнө сайн бодно уу даа. Би маргааш ирье гэхэд

- Хүү минь, өнөө маргааш хоёрын ялгаа юу байна. Ах нь арван жил бодсон ч юм эвлүүлж ярьж сурахгүй хүн гэв. “Ярьж чаддаг хүн хийж чаддаггүй, ярьж чаддаггүй хүн хийж чаддаг” гэж үнэн байх шүү. Одоо би яана аа.

Хүү минь, би чамд яаж тусалъя даа. Уул нь бичих гэж байгаа зүйл чинь чанар чансаатай юм болчихвол аштай юу? гээд яг л над шиг уртаар санаа алдав.

- Та л олигтойхон яриад өгвөл түүнээс илүү тусламж хаа байх вэ. тэр чанар чансаа ч яамай болж гэхэд минь над өөд анх харсан шигээ хөмсгөө сэргийлгэн өргөж

- Тэгээд наадах чинь хэзээ хэрэгтэй юм бэ? гэдэг байна

- Нөгөөдөр өглөө бэлэн болгочихсон байх ёстой. Гэтэл би бичих материалаа олоогүй явж байдаг, мөн хэцүүеэ.

- Хм, яасан ч богинохон хугацаа вэ. Хаа газар адилхан юм даа. Манайд ч бас л ялгаагүй. Өнөөдөр засварт өгсөн моторыг маргааш бэлэн болго гэж заримдаа шаардахыг нь яана. Шаардаж ч болно. Бэлэн болгож ч болно л доо. Гэхдээ учир их бий... за энэ ч яах вэ, би маргааш өөрийг чинь аваачиж, нэг баазын моторчин залууг харуулна гэхэд нь:

- Түвдэн гуай та юу ярина вэ? Өөр хүний тухай биш, таны тухай найруулал бичих ёстой. Ер нь танай даргатай ярьж тохиролцсон юм шүү гэхэд

- За тэгвэл яах вэ, бичих зүйлд чинь л тус болох болов уу гэсэндээ хэлсэн юм. Түүнээс биш өөрөөсөө булзааруулж байгаа хэрэг биш. Түүнийг харахаар залуу насаа би өөрийн эрхгүй санадаг юм. Тэгээд л ярьж чадахгүй болохоороо залуу насаа төлөөлөөд харуулая гэж байгаа нь тэр гэж нэлээд гомдсон байртай хэлэв.

- Түвдэн гуай. Таны хэлдэг тун зөв. Тэр залууг харахад л таны залуу насыг харсан шиг болно гэдэг хичнээн сайхан бэ? Гэтэл тийм зав надад даанч алга. Ганцхан маргааш л үлдлээ гэж учирлан гуйсанд:

- Хм. Та нар дандаа л нэг яаруу тэвдүү.. Түүхий нойтон... гээд л толгой сэгсэрснээ, хувцсаа сольж өмсөөд түлхүүрээ авангаа:

- Надад өөрөөс чинь нэг хүсмээр юм байна гэлээ

- Юу вэ. Чадах л юм бол дуртай зөвшөөрнө гэхэд гайхсан мэт хэсэг зогссоноо:

- Ухаан нь, эргэн тойрон амьтан хүнгүй уудам талд өвлийн жин хүйтэнд осгож үхэх аюулд орсон жолооч хүний тухай нүдэнд харагдаж, сэтгэлд буутал бичээд өгөхгүй юу? Надад маш их хэрэг байна. Ухаан нь маргааш ирэхдээ юмуу гэхэд нь:

- Түүний чинь зохиолч хүн л бичихээс биш, над шиг нь яаж чадах вэ гэж цааргаллаа.

- Юу гэсэн үг вэ. хүн хүндээ тус болохоос илүү сайхан юм гэж ер байдаггүй. Чи надад тэгж л тус болж үз. Аягүй бол чамд... Чиний энэ бичих юманд чинь ч хэрэг болж мэднэ гэдэг байна. Надад юун хэрэг болох билээ. Байсаар бүүр хүүхэд шиг хуурах нь шив гэж бодсон авч яая гэх вэ “Тэгье” гэж ам алдчихлаа. Түвдэн өвгөн маш их баярлаж:

- Маргааш хүү минь хэдэн цагт ирэх вэ. Би өглөөгүүр эрт ирдэг хүн шүү гэхчлэн хөөр болсоор гэрийн зүг явлаа.

Би тэр орой давж давшгүй өрөнд орсон хүн шиг сэтгэл гонсгор байлаа. Сурвалжлагч болоод анхны маань бичих гэж байгаа найруулал ийм бүтэл муутай байхад яаж урамтай байх билээ. Тэр ч байтугай, найрууллын маань баатар надаас зохиол шиг юм нэхээд, бүүр эх адаггүй тоглоом шиг явдал боллоо. Гэлээ гээд яах вэ, нэгэнт л ам алдсанаас хойш.. өвгөний захиалгат зүйлийг бичихээр цаас харандаа авч ширээнийхээ ард суулаа.

...Зах хязгааргүй цаст цагаан тал нүдний үзүүрт цийлэлзэн, исгэрэн шуугих цасан шуурга чихний үзүүрт шунгинаж, огторгуйд түгсэн үй түмэн одод бие жихүүцэм гялалзаад, будант тэнгэрт дураар хөвөх дүгрэг саран, яхир зант эмгэний нүд шиг давхарласан цагираг хүрээ татуулаад, замын хажуугийн утасны модод яс янгинам хонгиноод ... Бүх юмс нүдэнд харагдавч цаасан дээр бууж өгөхгүй сэтгэл тамлана. Хэд дахин хуулж бичлээ. Ер болж өгдөггүй. Гэтэл хээрийн замд хэмхэрсэн, дүүрэн ачаатай машин нүдэнд минь дахин харагдаад, тэр ч байтугай жолооч нь машинаасаа нэг гарч нэг орно. Машиндаа ороод сууя гэвч ар өврөөс нь бүхээгний хүйтэн төмөр жиндүүлэн хайрч, бүүр эцэст нь дулаацах санаатай цас дагтаршин мөс болон хөлдсөн зам дээр дэвхцэн цовхчиж байгаа нь хүртэл сэтгэлд нэвт харваж, дулаан тасалгаанд суугаа бие минь зарсхийх шиг болно. Нар уулын цаагуур шингэх үед тэр машин, оройн хүйтэн жавраар амьсгалсан талын явган шуурган дунд бүртийн торойсоор..

Эд бүхэн сэтгэлд бичигдэхээс биш цаасан дээр буудаггүй. Харин сүүлдээ би өөрийнхөө хий бодолд орооцолдов. Тэгээд хөөрхий тэр жолоочийг одоо яах вэ? гэдэг хүнд асуулт намайг давхар зовоож эхлэв. Үнэхээр эргэн тойрон хүн амьтан алга агаад амьд хүнтэй дайралдахгүй бол тэр жолооч яах вэ?

Ээ бүү мэд. Эд бүхнийг эргэцүүлэн бодож хуулан бичсээр суутал хэдий шөнө дунд өнгөрсөн байлаа. Толгой дээш татан саяны бодлоос арай ядан ангижиртал хамаг бие зарсхийн халуурч, толгой лаг шавар шиг хүндэрчээ. Тэгээд гэрлээ унтрааж хэвтэв. Гэвч нойр хүрдэг юм биш. Зүүн чихнээ “Чи яагаад сонины материал таслав” гэсэн эрхлэгчийн дуу, баруун чихнээ өдөр үзсэн засварын газрын суурь машины төмөр зорох чихарсан чимээ сонсдоод, хав харанхуй атал тасалгааны маань хана цаст тал болж хувирахад ёстой л элс цасаар биш, үймсэн бодлоор дүүрсэн сэтгэлийн ширүүн шуурга ухаан бодолд маналзаад, толгой гэдэг халчихаад бут үсрэх гэж байгаа мянган лааны чийдэн шиг...

Арга тасрахдаа гэрлээ асааж нөгөө бааз руугаа очлоо. Түвдэн гуай аль хэдий нь ирчихсэн байв. Тэгээд надаас шууд л :

- За хүү минь, миний хүссэнийг юу болгов гэлээ

- Нэг юм бичих нь ч бичсэн гэж хэлээд

- Та сонсоно уу? гээд халааснаасаа гаргаж ирсэнд

- Энд хэрэггүй. Хоёулаа манайд очъё гэв.

- Нээрээ зөв шүү. Гэр орондоо ямаршуу амьдралтай байдгийг нь үзье. Тэндээс ч миний найруулал эхлэх юм билүү, хэн мэдэх вэ?

- Түвдэн гуай. Танд баярын бичиг олон бий юу? гэсэнд

- Байлгүй яах вэ, чамд нэг амьд бичиг үзүүлнэ. Тэр бол насан туршид минь зэмлэж донгодсон нэг ёсны шийтгэл байгаа юм гэв.

Үнэхээр хачин өвгөн. Би найруулал бичих гэж сайшаалын үнэмлэх сураглаж байдаг. Гэтэл зэмлэл донгодлогын бичиг үзүүлнэ гэж байх. Бид хоёр явсаар өндөр өндөр барилга бүхий шинэхэн хороололд ирлээ. Тэгээд цахилгаан шатаар өгсөж есөн давхарт гараад нэг хаалганы хонх дарав. Урдаас минь сайхан зантай тарган шар авгай угтав. Тэр бол Түвдэн гуайн хөгшин ажээ. Цаад өрөөнд нь дөч эргэм насны хөдөөний байрын хүн сууж байлаа. Тэр хүнийг манай худ гэж танилцууллаа. Бид Түвдэн гуайн сайшаалын үнэмлэхүүдийг үзэх гэж сэтгэл яаран байтал

-За хүү минь, нөгөө юмаа одоо уншина. Ямар болсныг энэ хүн хэлээд өгнө гэж худ руугаа заалаа. Би онц гайхсан ч үгүй, урьд шөнөжин нойргүй сууж бичсэн зүйлээ уншиж гарлаа. Тэгээд уншиж дуусмагц

- За ямар болж вэ? гэж Түвдэн гуайг асуухад

- Яггүй бичсэн байна гэж нөгөө хүн хэлэв. Түвдэн гуай над руу харснаа

Чиний наад жолооч энэ хүн шүү дээ гэв. Би тэр хүнийг сайтар ажиглан хартал хоёр суга таягтай ажээ. Дотор палхийгээд явчихав. Гэтэл тэрээр ярианд оролцон

- Яг л өөрийн чинь бичсэн шиг эзгүй хээр талд, өвлийн жин хүйтэнд машин маань эвдэрч би хоёр хөлөө хөлдөөсөн юм. Тэгээд шинэхэн, засвараас гарсан тэрэгний юу нь эвдэрснийг шалган үзэхэд засвар хайнга хийснээс болжээ гэсэн дүгнэлт гарсан гэхэд нь Түвдэн гуай өлгөн авч:

- Тиймээ, тэр машиныг нь би зассан хүн гэв. Би бүүр гайхаж орхив. Тэгээд:

-Та нар чинь ураг төрлийн холбоотой улс байж... гэхэд минь

Үүнд ураг төрөл ямар хамаа байх вэ. Уул нь ийм явдал болсон юм. Чамд би залуу насныхаа тухай ярьж байсан байхаа. Нэг өглөө мастер маань миний засаж байсан моторыг хойш тавиулаад “Үүнийг маргааш өглөө гэхэд бэлэн болго. Хөдөө явах машины дотор” гэж үүрэг өглөө. Тэгэхэд миний дагалдангаар Даш гэдэг хүн ажиллаж байсан юм. Даш гэж одоо манайд боловсон хүчин хийж байгаа хүн бий. Бид хоёр өдөржин ноцолдоод арай чүү дуусаж билээ.

Тэгэхэд Даш шатахууны гайхны нэг дөр дутуу хийснийг би засах гэж байснаа мартаад мотороо боочихсон байхгүй юу. Тэгэхэд наадах чинь гэж суга таягт хүнийг заагаад:

- Ёстой машин барьж давхих хорхой нөхцсөн насан дээрээ явсан байх. Мөнгө шиг цагаан моторыг машиндаа тавьж угсарч дуусаад гарахдаа “Одооч ёстой жийгүүлээд байдаг хэрэг ээ” гэж хэлэхэд нь л нөгөө юмыг засаагүй мартсанаа гэнэт санаад “Одоо яанаа” гэж бачимдан Дашид хэлэхэд” “Яах вэ, хэмхэрдэг юм бол хэмхэрнэ л биз. Хэрэв үнэнээ хэлбэл чи бид хоёр дахин засахад хүрнэ. Бас хариуцлагагүй хийсэн гэж донго авна. Тэгээд чиний нөгөө бусдыг манлайлдаг норм төлөвлөгөө чинь хоцроход хүрнэ шүү дээ” гэхэд нь би нэр сүрээ бодоод дув дуугүй өнгөрч билээ. Тэгсэн хирнээ сэтгэл зовоод зүүн чих хангинаад болдоггүй. Ер нь хүнд совин гэж байдаг нь үнэн дэг шүү. Өвлийн хүйтэнд мотор нь хэмхрээд хээр суучих вий гэж бодохоос хэдэн шөнө нойргүй хонож, сэтгэлийн там эдэлж билээ.

Харин Даш маань юу бодож байсныг бүү мэд, нэг мэдэхнээ үйлдвэрчний хороон дарга болоод л яваад өгсөн юм даг. Ээ дээ сэтгэл сэвтэй юм хийж бусдыг хуурна гэдэг үү гэхэд нь:

- Тэр үед та нар чинь бие биенээ таньдаггүй байсан хэрэг үү?гэсэнд:

Яалаа гэж таних вэ. Харин саяхан миний ач хүү эдний охинтой нийлж гэр бүл болсноос хойш л бид чинь энэ бүхнээ мэдэлцсэн улс байхгүй юу. Тэгэхээр байна шүү, чи миний тухай бичихдээ тэнгэрт тултал битгий магтаарай. Магтаал чинь дотор сагуулахаас биш, юм бодуулдаггүй юм билээ. Харин уншсан хүнд юм бодуулахаар

...Ухаан нь саяны явдлыг бичиж болно шүү дээ. Энэ чинь хэрэгтэй юм. Одоо ч гэсэн тооны хойноос хэт хөөцөлдөөд чанаргүй юм хийх явдал зөндөө л байна гэж билээ. Тэгээд би дээрх явдлаар найруулал бичээд очсон чинь сонинд гологдсон юм даа гэж бодоод Түвдэн өвгөний үлдээсэн зурвасыг Бадрах дахин гүйлгэж уншихдаа “Яргайтын амны бүүр эхэнд... Замын баруун талд” гэж давтан хэлээд гадагш гарав.

ҮНЭГЭН ДЭЭЛ

Говийн нэгэн аймгийн төвийн дунд сургуульд тоо физикийн багш Дарам, хэлбичиг утга зохиолын багш Дэрэм хоёр гэгч хоёул өнгөрсөн жил хотоос иржээ. Тэдний алхаа гишгээ, яриа хөөрөө, бие бялдар цөм өөр...Зүйрлэвэл, хичээл номыг тэр дор нь ойлгодоггүй авч нэг ухаарч авбал ер мартдаггүй лагс ухаантай хүүхэд хааяа байдаг даа. Дарам бол яг тийм төрхийн хүн. Гэтэл юмыг тэр дор нь гялсхийтэл тогтоогоод авчихдаг мөртөө маргааш нь болоход мартчихдаг нэн сэргэлэн атлаа овилгогүй ухаантай хүүхэд бас байдаг. Дэрэм бол яг л тийм төрхийн хүн. Бие бялдар нь хүртэл ухаан бодолтойгоо зохицсон мэт. Дэрэм бол яс хөнгөнтэй, мах мяраа муутай байхад Дарам бол боргил зузаан, хүдэр чийрэг ажээ. Тэд хоорондоо ийм эрс өөр байх ч бас яах вэ. Харин заадаг хичээл нь тэр хоёрыг дууриасан мэт бас өөрийг яана. Дунд сургуульд хамгийн хэцүү хичээл бол тоо, хэлбичиг байдаг. Тооны хичээлд овоо хүүхэд хэлбичигт тааруу. Хэлбичигт сүрхий хүүхэд тоо муу байх нь элбэг. Үүнээс болоод эхний жил улирлын дүн гарах бүр Дарам, Дэрэм хоёрын хооронд маргах, зүтгэлцэх, тэр ч байтугай хэрэлдэх явдал ч үе үе гардаг байв. Одоо бол тэгж эг маг хийлцэхийн оронд тоо, хэлбичгийн хичээлд хүүхдийг яаж адилхан сайн болгох вэ гэж уйгагүй махран зүтгэцгээх болжээ. Дэрэм бол бүтсэн бүтээгүй хамаагүй аль дайралдсан амьтанд тус болохыг хичээнэ. Дарам бол тийм хөнгөн хөдлөх нь үгүй.

Хэрэв нэг заа гэвэл ёстой ёогүй хүн. Гэтэл тэр хоёрт бас төсөөтэй юм бий. Тэр нь юу гэвэл хоёул гэр бүлгүй залуус. Тийм ч учраас өөд өөдөөсөө харсан ганц ганц өрөөнд амьдран сууна. Шинэ жил болох дөхөж аймгийнхны хөл хөдөлгөөн хэдий нь ихэссэний хажуугаар хоёрдугаар улирлын дүн гарах гэж багш сурагчид бүр хөлтэй байлаа. Гэтэл сүүлийн хэд хоногт Дарам ямар нэгэн зүйлд сэтгэл зовсон нь илт, толгой гудайн гүн бодолд дарагдан, үе үе уртаар шүүрс алдан сэтгэл бодол нь үерлэсэн голын ус лугаа адил улаан хоормогоор эргэлдэж байхыг Дэрэм аль хэдий нь ажигласан боловч сэтгэл санааг нь юуг урвуулж хөрвүүлснийг надад аяндаа хэлнэ биз гэж өөр шигээ бодно. Нээрээ өөрөө бол сэтгэлдээ юуг ч хадгалж чаддаггүй, хэнд ч хамаагүй хэлээд тавьчихдаг хүн. Гэтэл Дарам тийм бишээр барахгүй, миний бодол санааг хэн ч мэдээгүй гэж батгаж итгэж явжээ.

Нэгэн өдөр Дэрэм тэднийд зориуд орж шалгалтын дүнгийн тухай ярилцан, бас маргаашаас эхлэн арван хэд хоног явж амрах вэ гэхчлэн ярианы сэжүүр гаргаж байгаад, сэтгэлээр нэг л дундуур явах болсныг нь асууж орхив. Дарам эхлээд “ Яагаа ч үгүй, зүгээр байдгаараа л байна” гэж булзааруулахыг оролдсон боловч Дэрэмийн хэл амны хэцүүд автав уу, аль эсвэл тэртэй тэргүй мухардсан хэрэг болохоор үнэнээ хэлье. Бас ч тус болж юуны магад гэж горьдов уу? Ямар боловч хэлье гэж шийдээд:

- Дэрэм минь, чамаас би юугаа нуух вэ? Оюутан байх үедээ нэг бүсгүйд сэтгэлтэй болж хэдэн жил хөөцөлдсөн авч “За ч гэдэггүй, үгүй ч гэдэггүй. Хайр сэтгэл гэдэг чинь санааны зоргоор шийдчихдэг юм биш” гэхихээд явсаар байгаад өдий хүрчихсэн юм. Би энэ зун арга тасраад “Чимгээ минь болж бүтэхгүй гэж бодож байгаа бол түүнийгээ зүгээр хэл, хэн хэн маань замаа бодъё” гэж хүртэл үзлээ. Гэтэл урдаас “Чи тэгж байгаа бол яах вэ. Харин би эхэлж ийм үг хэлээгүй шүү” гэхээр нь бас горьдлого тасралгүй байсаар наашаа ирээд хичнээн ч захиа явуулав даа. Тэгсэн чинь хэд хоногийн өмнө нэг захиа иржээ” гээд инээмээр болсноо хий дэмий мурчилзав.

- За тэгээд юу гэж бичиж вэ дээ гэж Дэрэмийг асуухад Дарам:

Хайр сэтгэлийн талаар бол ч яах вэ. Нөгөө хэлдгээ бараг хэлсэн байна билээ. Харин нэг яггүй юм надаас хүссэн байх юм. Тэр нь тийм амархан биелэх зүйл биш ээ. Би хэд хоног бодоод бодоод бодын шийр дөрөв гэгчийн үлгэрээр ороод байнаа гэж цөхөрсөн нь илт уртаар санаа алдав.

- Үгүй ээ, тэгээд чамаас юу хүсээ вэ? Чи хэл л дээ. Дөнгөх юм байвал өвгөн чинь бас туслахыг бодъё.

- Дэрэм минь, тэгвэл сайн л байна. Арван дөрвөн хоногийн дотор гучин ширхэг үнэгний арьс олж яаралтай явуулаач гэсэн байх юм. Гэтэл тэр хугацаанаас нь ганцхан долоо хоног одоо үлдээд байна.

- Тэр олон үнэгний арьсаар юу хийдэг хүүхэн байх нь вэ. тэгээд үлгэрт гардаг шиг хоног хугацаа заадаг нь ч юу билээ дээ. Одоо долоо хоногийн дотор гучин үнэг алах хэрэг болж байна уу? гээд толгой сэгсрэн Дэрэмийг инээхэд нь Дарамын зэвүү хүрсэн боловч бас инээх дур үзүүлэн:

- Тэгэх л болж байна. Уул нь үнэндээ ч их л хэрэгтэй юм байна л даа. Чимгээ удалгүй гадаадад явах болсон юм байх. Тэгээд үсийг нь гадагш харуулсан үнэгэн дээл хийлгэж өмсөх гэж яарч сандарч байгаа бололтой гээд Дарам толгой бөхийн суув.

- Тэгвэл одоо яанаа найзаа? Ядахдаа жилийн хугацаатай юм бол ч бас учир байхсан. Ингэхэд чи ан гөрөө хийдэг билүү? гэж Дарамаас асуув.

- Өвгөн чинь ан гөрөөний хувьд ёстой “А” ч үгүй амьтан даа. Уул нь хугацаа уртсан бол үнэ хайрлахгүй худалдаж аваад л өгчихмөөр байна. Тэгэхээр ийм юмыг ер яавал дээр вэ? гэж Дэрэмээс асуув

- Ёстой бүү мэд ээ. Үнэндээ ухаан санаанд багтамгүй юм байна. Ер нь аваагүй байхдаа авгай сайхан, алаагүй байхад үнэг сайхан гэдгийн үлгэрээр л орох бололтой доо гэж хэлэхэд нь:

- Уул нь анхны нь хүсэлтийг яаж ийж байгаад биелүүлчих юмсан. Гэтэл санаа байвч сачий хүрэхгүй гэдэг л болоод байна даа гэж цөхөрсөн нь илт хэлэв. Дэрэм нөхрийнхөө сэтгэлээр унасныг хараад өрөвдөж:

- Найз минь, аргыг нь олохыг бодъё л доо. Эр хүний дотор эмээлтэй морь багтдаг гэж эртний үг байдаг болохоор арга ухаан сүвэгчилъё.

Хүчээ зарахаар ухаанаа зар гэж ер нь үнэн үг шүү. Бид аргыг нь олж чадахгүй байгаагаас биш, арга нь олдохгүй юм амьдралд ер байдаггүй гэдэг. Тэгэхээр урдаар бодъё. Маргааш болтол сайн бодъё гэж нөхрийнхөө сэтгэлийг түр боловч тайтгаруулаад Дэрэм тэднийхээс гарч гэртээ оров.

Өвлийн өдөр яах ийхийн зуургүй дуусаж орой болсон байлаа. Дэрэм нөхөртөө яаж тус болъё

доо гэж элдвийг эрэгцүүлэн бодов. Гэтэл тэр Чимгээ гэдэг ямаршуу янзын хүүхэн бол? Бодвол цав цагаан царайтай, өндөр туранхай хүүхэн байгаа байх. Аягүй бол үнэг шиг зальтай амьтан ч байж мэднэ. Ямар ч гэсэн аашилж ч чаддаг, аргадаж ч чаддаг амьтан байх гэж бодсоноо ганцаар түсхийтэл инээд алдаад “За тэр хүүхэн ямар байх нь надад юуны хамаа байна. Гагцхүү нөхөртөө тус болох арга чарга юу байдаг билээ?” гээд анчин гөрөөчидтэй уулзан учирч энэ тэр элдвийг яриулан байсан бүхнээ эргэцүүлэн бодовч, анчдын адил явдлаас авахаар юм ер бодогдсонгүй. Гэтэл яагаад ч юм бэ, өнгөрсөн зун Тэрэлжийн амралтанд амарсан нь гэнэт санагдав. Бодвол тэнд нэг сүрхий загасч залуу байсныг санангуут ч тэр бүхэн сэтгэлд нь урган ирсэн байж мэднэ. Энэ бүхнийг лавшруулан бодоход Туулын ус тууз мэт цэнхэртэн урсаад, үүний хөвөөгөөр нарлан хэвтэж байгаа хүүхнүүдийн булбарай цагаан бие цогцос харагдах шиг болж, зуны хурц нар зулай дээрээс ээх шиг болох нь бүр ч сэтгэлд тааламжтай агаад цааш гүнзгийрүүлэн бодох хүслийг улам оргилуулав.

Амралтанд очсон эрэгтэй хүн бүхний ганц дуртай ажил гэвэл загас жараахай өдөржин эргүүлнэ. Хэдэн өвгөдөөс бусад нь өглөөнөөс орой болтол голын хөвөө өгсөж уруудаж тэнэнэ. Зарим өвгөчүүл хийх ажилгүй уйдаад эхлэхээрээ өөрсдөө барьж чадахгүй ч гэсэн бусдын барих аргыг сонирхон явах нь бий. Амрагчдын дунд загас барихдаа гоц нэгэн залуу байв. Голын хоёр захаар эгнэн зогсчихоод зэрэг л дэгээ, гувчуураа чулуудаж эхлэхэд бусдынхад нь ганц ч тээглээгүй байхад нөгөө залуугийнхад заавал орсон байна. Тэрбээр уснаас дэгээгээ хоосон гаргана гэж заяа нь үгүй. Өдөрт арав хорь хүргэнэ. Атаархсан зарим нь түүнийг загасны эрлэг гэнэ. Бахадсан нэг нь түүнийг загасны бурхан, эвсэл загасны тэнгэртэй хүн гэнэ. Голын хөвөөний хайрга элсэн дээр хаягдсан загас хурц нарнаас зайлж бургасны сүүдэрт орохыг хүсэх мэт холбирон хөлбөрч, нойтон сүүлээрээ газар цохилон, ангалзан эргэж хөрвөсөөр тэнхээ нь алдарч хурц цагаан өөхийгээ дээш харуулан хөдөлгөөнгүй хэвтэх яг тэр үед нь усанд эргүүлж хийнэ. Харин барьсан загасаа ална гэж ер үгүй. Тэгээд яах гэж барьдаг юм бэ? гэхэд “Яах вэ, сонин байдаг юм. Энэ чинь нэг ёсны биеийн тамир шүү дээ” гэнэ. Цаанаа бол яаж загас барьдгаа бусдад гайхуулах гэж тэгж хэлдэг биз ээ. Тэр ч байтугай “Энэ загасыг би өглөөхөн бариад тавьчихсан юм. Дахиад орчихож” гэж бардамнах дуртай билээ. Өглөө орсон загасыг ялгаж таних гэдэг тийм ч амаргүй баймаар... гэтэл тэр залуу андахгүй таньдаг нь бас сонин “Ойр хэвийн загас жараахайг хашрааж орхиод бүүр баригдахаа болилоо” гэж ангийн хорхойтой хүмүүс илт дургүйцнэ. Нэрээ л тэдгээр хүмүүсээс зугтдаг атлаа нөгөө залууд баригдаад байдгийн нууцыг олох санаатай хэдэн өдөр би зориуд дагаж, голын хөвөөний битүү бургасан дотор суугаад сэм ажигладаг болов. Ус шил толь шиг тунгалагхан болохоор гүнд нь ийш тийш хошууран хөвөх загас жараахай ив илхэн. Тэр залуугийн бусдаас онцлог нь гэвэл шидсэн дэгээгээ татаж авах нь нэн уран. Халбага төмөр нь эрчлэн мушгир эргэн хөврөх нь загасны байтлаа хүний боловч сониуч занг хөдөлгөмөөр... хараад байхад загас жараахайнууд дэгээний араас өрсөн дайрна. Нээрээ л саяхан баригдаад хаа нэг газраа сэт тагуулсан загас ч хүртэл эдний дунд явж байгаа болов уу? гэж бодогдмоор. Загас гэдэг үнэхээр сониуч амьтан. Халбага төмрийн өнгийг солиод шидэхэд бүүр улайран хөөцөлдөхийг нь яана. Тэр залуугийн цамц өмдөнд нь гялалзаж гялтганасан чимэг зүүлт дүүрэн болохоор тэр нарны гэрэлд туяаран усны үелзэх урсгалд тусаад загасны хорхой хөдөлгөдөг онцлогтой ч байсан юм билүү, хэн мэдэх билээ. Ямар ч гэсэн түүн шиг мэргэжсэн хүн ховор биз ээ. Хэрэв үнэгийг тэгж амархан агнадаг хүн байвал ч гучин арьс гэдэг юухан байх вэ гэж шал дэмий юм бодож хэвтэв. Тэгээд ухаан санаанд нэгэнт юм орохгүй болохоор одоо яая гэх вэ, эртхэн унтаж амраад өглөө сэргэлэн толгойгоор бодвол эв

арга нь олдож юуны магад гэж бодоод гэрлээ унтрааж орондоо оров.

Тий, тий яасан хүйтэн юм бэ... Татаад бай. Усны гүехнийг дагуулаад тат. Сөргөөж татвал дэгээний утас тасарчих нь шүү... Зүйтэй гаргаад голын эрэг дээр хаячих. Наадах чинь яасан гоё үстэй үнэг вэ? говийн халтар үнэг гэдэг ёстой мөн дөө. Аль вэ, Дарам аа, дээшээ яваад тэр цүнхээл рүү дэгээгээ нэг шийдээд орхи. Аяархан.. нэг том үнэг ч наад цүнхээлд чинь байна даа. Даанч хашир юм. Дэгээндээ загасны сүүл хийгээд хаяад орхи. Зөв, зөв. Урсгалыг нь дагуулаад тат. Үсний сор ч гэж ёстой алт аа алт. Чи бид хоёр санасныг бодвол овоо шүү. Үдээс өмнө энэ голоос таван үнэг барьчихлаа. Одоо ус нь булингартаад юу ч харагдахаа болилоо. Үдээс хойш цаад нуурнаас чинь баринаа гэж хашгиран хэлтэл дуунаас нь цочсон юм шиг нөгөө хэдэн үнэг тал тал тийшээ год үсрэн цас манаруулан харайлгаж одоход “Хүүе яадаг билээ” гэж муухай хашгираад зүүд нойрноос Дэрэм арайхийн сэрэв. Тэгээд саяны зүүдээ эргэцүүлэн хэсэг хэвтэв. Гэтэл нэгэн сонин бодол сэтгэлд нь зурсхийн орж ирэх нь тэр. “Нээрээ болох юм биш үү? Загасны хараа нь сайн байдаг бол үнэгний хамар нь сайн...Ер нь дэгээндээ мах хөлдөөгөөд оосрыг нь бөхөөхөн төмөр утсаар хийгээд мэдэгдэлгүйгээр цасанд булж орхивол л болох юм бишүү. Үнэг шарх даахдаа муу гэдэг. За тэгээд үнэгэнд бол хичнээн ч дэгээ хэрэглэж болно. Үнэг элбэгтэй газар бол гучин үнэгийг барьж ядах юухан байх вэ гэж бодоод ганцаар инээмсэглэв. Зүүд нойрноосоо ургуулан ийм сонин арга ухаан олсондоо баярлаж гэрлээ асаав. Тэгээд “Ер нь энэ аргаа одоохон Дарамд хэлье” гэж бодоод яаран босож хувцаслав.

Маргааш өглөө нь Дарам, Дэрэм хоёр өвлийнхөө арван хэд хоногийн амралтыг ан гөрөө хийж хөдөө өнгөрөөхөөр тохиролцоод дэлгүүрээс том жижиг янз бүрийн зуун ширхэг дэгээ худалдан авав.

Энэ дэгээ нь сайн, тэр нь муу гэж голж шилж маргалдахыг нь харсан танил худалдагч хүүхэн “Загас барьдаг улсыг харахад дэгээг халбага төмөртэй нь л хамт авдаг юм байсан. Та хоёр чинь хөхөө өвлийн хүйтэнд халбага төмөргүй дэгээгээр, тэгээд бас говь нутгаас ямар гэгч загас барих нь вэ дээ” гэж тоглоом тохуу хийн тас тас хөхрөхийг ч тэр хоёр юман чинээ саналгүй яаран гэртээ харив.

Тэгээд Дарам дулаан хувцас хунар, хоол хүнс бэлдэхээр болж, Дэрэм сургуулийн манаач өвгөнийхөөс хоёр номхон морь гуйж ирэх бас калибр буу сум олохоор яаран явав. Үд өнгөрч байхад тэр хоёр анд явахад хэрэглэгдэх юмсаа жин тан болгоод хамгийн ойрын сум нэгдэл рүү маргааш өглөө эрт хөдлөхөөр тохиролцов. Тэгээд маргааш нь сумын төв ч орсонгүй, шууд л суурь бригадын айлуудаар бууж, үнэ хярс элбэгтэй нутгийг хөгшчүүлээр заалган гуу жалга, уул хадны нөмөр нөөлөг, хаваржаа намаржааны ойр хавиар, хаана гүйдэл мөр элбэгтэй газраар мах хөлдөөсөн дэгээнүүдийг нууцлан тавиад өдөржин явж түүнийгээ эргэх ажилтай болов. Эхний өдөр дөрвөн үнэг, нэг хярс барив. Загасны дэгээгээр ингэж амархан барих арга олсноо Дэрэм бусдад сайрхан ярихыг хүссэн авч Дарам түүнийг эрс хориглож, цөмийг буудаж алсан юм гэж худал хэлэв. Тэгээд өдөрт гурав дөрвөөс доошгүй антай ирдэг болсон тул нутгийн хүмүүс “Төвөөс ирсэн хоёр багш өдөрт арваас доошгүй үнэ алах юм. Тэдний буудахын цэцнийг яана. Үнэг, хярс нүдэнд нь өртвөл амьд гарах номгүй” гэсэн цуу үг дэгдэж, тэр хоёрыг бараг хорвоод ховорхон анчид гэж ярилцах болов. Тэгээд долоо хонотол нээрээ ч үнэг хярс урьдынх шиг үзэгдэх нь ховордсон тул зэрэгцээ орших өөр нэг сум нэгдлийн нутагт

очин дахин долоо хоног гөрөөлөв. Тэгтэл өвлийн амралт дуусаж, мань хоёр ч гучин үнэг, арван нэгэн хярстай аймгийн төвд буцаж ирэв.

Нэг өдөр Дарамыг долдугаар ангид хичээл зааж байхад нь хүн ирээд уулзъя гэж байна гэв. Түүнийг яаран гарч очиход нэгэн залуу тосч уулзан өөрийгөө жолооч хүн гэж танилцуулаад Чимгээгийн нэрийг дурдаж “Танаас үнэгний арьс аваад ирээрэй” гэсэн юм. Дарам тэр жолооч залуутай хэдэн үг яаран солиод “Та хичээл завсарлатал түр хүлээнэ үү? Тэгээд манайд очъё, цай хоол хийе” гэсэнд нөгөө жолооч “Би тун яарч явна. Та тэр юмаа л өгөөд орхи” гэхэд нь яагаад ч юм бэ Дарамын сэтгэл дорхноо хөрөөд явчихав. Тэгээд хоёр шуудай тэвхийтэл чихсэн үнэг хярсны арьсыг тэр жолоочоор өгүүлж нэг ёсны сэтгэл амрав. Түүнээс хойш хэдэн удаа захиа явуулсан боловч хариу ирсэнгүй. Бодвол өдийд гадаадад явчихсан биз гэж санаад захиа бичихээ болив. Өдөр хоног ээлжлэн өнгөрсөөр нэг мэдэхнээ хавар болж, дараа нь удсан ч үгүй сургуулийн зуны амралт эхлэв. Энэ жил Дарам хот орж амрахаар явлаа. Түүний яаран явдгийн учир нь нийтэд тодорхой юм чинь. Харин Дэрэм нутгийнхаа нэгэн нэгдлийн амралтад амрах болов. Энэ зуны хувьд тэрбээр маш их ажилтай байлаа. Сургууль тарсны дараа хагас сар шахуу сургуулийн байшин барилгын засвартай баахан ноцолдов. Дараа нь сумдын бага сургуулийн хэлбичгийн багш нарын семинарт хичээл зааж бүүр наймдугаар сар өнгөрсөн хойно амралтад явав.

Барагшин замаас дутахгүй тэгшхэн, говь нутгийн хайргархаг замаар машин тоос татуулан давхина. Энэ бол “Урагшаа” нэгдлийн амралтад амрахаар яваа хүмүүс билээ. Тэд нэгэн өвгөнөөс энэ тэрийг шалгаан асууна. Амралтад очиж байгаа хүмүүст асуух юм юу эс мундах вэ. машины кабин налж суусан нэг эр “Та энэ нэгдэлд удаж байна уу? гэж асууснаар уул яриа эхэлсэн билээ. Тиймэрхүү албаны маягийн яриа маань яван явсаар “Танай амралтын хоол унд хир вэ?”, “Ойр уул толгод бий юу?”, “Гар бөмбөг тоглодог уу?” гэхчлэн хүн бүхэн өөр өөрсдийн сонирхож байгаа зүйлийг асууж гарав. Дэрэм яаж дуугүй байгаад байх вэ гэж бодоод:

- Өвгөн гуай. Танай амралтын айраг хир вэ дээ? гэж асууж орхив.

Нярав өвгөн өтгөн хар хөмсгөө нэгэнтээ өргөснөө:

- Айраг зүгээр. Гэхдээ ер нь сааль сүүний хувьд урьд жилүүдийг гүйцэхгүй байгаа гэв.

- Яагаад тэр билээ? Энэ жил хур бороо элбэгтэй, сайхан жил биш үү? гэцгээхэд

- Тийм нь ч тийм. Гэхдээ бэлчээр тааруу. Үлийн цагаан огтоно элбэгшээд бэлчээр нутаг сүйтгээд хаячихсан

- Яахлаараа тэгж оготно гэнэт элбэгшээд байнаа? гэж хүмүүс дахин шуугилдав.

- Яах юу байх вэ. Үнэг хярсныг хядаад дуусчихаар аргагүй шүү дээ. Өнгөрсөн өвөл аймгийн төвөөс айхгар хоёр анчин багш ирээд өдөрт л арав хориор нь алаад байна гэж дуулдсан. Тэрний л гай гарч байхгүй юу. Энэ өвөл ч манай нэгдлийнхэн өөр тийш отор нүүдэл хийхгүй бол барахгүй байхаа гэж хэлээд дуугүй болов.

Говь нутгийн халуун салхи өмнөөс сэвэлзэн үлээнэ. Машин улам хурдлан урагшлан давхина.
Амрагчдын хэн нэг нь дуу эхэлмэгц бусад нь цөм хөгжилтэйгөөр түрэн авч дуулцгаав.
Гагцхүү Дэрэм л машины хашлага налан суугаад өнгөрсөн өвөл үүгээр үнэг хярс хөөж
явснаа, бас нөгөө Дарамыг ... дараа нь Чимгээг эргэцүүлэн бодож, алсад мяралзах зэрэглээг
гөлрөн ширтэж явлаа.

СУЛТАНЫ МАГАУЯА

Зохиолч С.Магауяа 1925 оны Баян-Өлгий аймгийн нутагт малчны гэр бүлд төржээ.

Улаанбаатарт намын дээд сургууль төгсжээ. 1955 оноос уран зохиол сонирхон оролцож “Мамык” тууж, “Намын батлах”, “Чонон бор”, “Бөөн баяр” зэрэг өгүүллэг найруулал бичжээ.

САЛ СЕРИК, САЛИХА ОХИН ХОЁР

Айлууд нүүж зусланд гарсан үе. Хэзээнээс малаар амьдарч ирсэн хасаг айлууд буян хишгийг нь хүртэж, бөөн бөөнөөр буун зэл татаж гүү уяцгаалаа. Айраг иссэний дараа залуус, ноёд ихсийг даган айлчилж, хажуулдвал дэр нь, баярлавал инээд нь, уурлавал үг нь, уйдвал дуу нь болж явав.

Янз бүрийн бэл чадалтай айлуудаас гаралтай ийм хэсэг хүмүүс хэн нэгнийд үдэлж, дараагийнханд хонон өнжин өөрсдийнхөө ая тааваар явсаар, арав хэд хоног орон гэртээ арайхийн эргэнэ. Ийм хүмүүсийн явсан газар бүхэн наадам цэнгээ байдаг билээ. Тэд харилцан дуугаар тэмцэлдэж, доомбороор ая тоглоно. Ноёд тайж нарын зугаа цэнгэл мэт боловч, учир начиртай өөрийн гэсэн нууцтай бөлгөө.

... Ийм нэгэн хэсэг хүмүүс хойно урдаа орон шуугилдаж Балекений хот айлаас мордон явтал хясааны доорхи тунгалаг булгийн тэнчээгээс нэгэн уянгалаг агаад гунигдуу дуу сонсдоо. Залуучууд чих тавин гэнэт зогсоход нөгөө дуу эд нартай зориуд өрсөлдөн байгаа юм шиг улам цуурайлав. Удам тусам гайхаш төрүүлж сэтгэл уяраах намуухан уян, туйлын нэгэн гайхамшигт аялгуугаар дуурслаа.

- Үгүй энэ чинь хаанаас гараад ирсэн тэнэмэл вэ?

- Айхгар дуулж байна гээч

- Бас доомбортой юм

- Зориуд биднийг өдөж байгаа юм байлгүй

- Түүнд ер нь очицгооё л доо

Зугаа цэнгэл хөөсөн залуучууд дуу цуурайтсан тэр зүгт дүрхийн хөдлөв. Очтол Хөхбулагийн хөвөөнд зуугаад хонь ямаа бэлчиж харагдана. Хүн амьтан харагдсангүй. Тэд хашгирч гуугалсан боловч, дуу чимээ эс сонсдов.

- Үгүй энэ чинь чөтгөр үү? Зүүд үү?

- Чөтгөр ч биш, зүүд ч биш, дуучин хүүхэд л байна

- Туулай зүрхтэй тэнэмэл амьтан хадны ангал завсраар нуугдаж орхио биз

- Түүнтэй уулзах юм сан

- Ямархуу царайтай амьтан байгаа бол

- Хэний хэн гэдэг юм бол гэж залуучууд шуугилдав.

Тэд арагшаа эргэж харах ч үгүй цааш одоход нөгөө дуу ахин сонсдож уул талаар долгион цуурайтсаар байлаа.

Балекен тайж өөрөө айтыс хэмээх харилцаа дуугаар тэмцэлдэхэд гэхээс биш, ер нь дуунд тийм дуртай биш байв. Түүний гурав дахь хүү Залел харин дуу хууранд туйлын дуртай. Тэрбээр эрх мэдэл төдийлөн хөөцөлдөхгүй ихэнхдээ зугаа цэнгээ хөөсөн залуучуудын дунд явдаг байв. Тиймээс Залел дуучин хүүхдийн тухай сонсоход түрүүлж эцгээ дагаад явчихсандаа гасаллаа. Залуучууд түүнийг “хүүхэд тайж” гэдэг. Учир нь эцэг нь хоёр том хүүгээсээ Залелийг илүү үнэлж, түүнийг өөрийгөө орлох хүн хэмээн ихэнхдээ дэргэдээ дагуулж явдаг юм.

Залел дуучин хүүхдийн тухай сонссоны дараа эцгийнхээ явуулахгүйг мэдэж, орой хүртэл ямар нэгэн газар ажилтай хэмээн зөвшөөрөл авлаа. Тэгээд үе тэнгийн дуучин залуу Билал, доомборчин Сүгирийг дагуулж, хот айлаас холдсон дараа нөгөө дуучин хүүхдийг олж уулзах, хэрвээ санаанд таарвал түүнээс хойш үргэлж дагуулж явна гэлээ. Хүүхэд тайжийн хэлсэн үгийг үгүй гэдэггүй тэд за хэмээн алгаа хавсран зөвшөөрөв.

Дуучин хүүхдийн дуулсан газрыг мэддэг доомборчин Сүгир нөхдөө дагуулан хүрч ирвэл, тэнд юу ч байсангүй. Тэд хэсэг гайхан зогссоноо, хажуу талын усгүй хуурай сайраар өгсөж, хүн амьтан тааралдвал асуухаар шийдэв.

Үгүй тэгэхэд айлууд зусланд гарчихсан байхад ийм газар, эзгүй жалганд хэн биднийг хүлээгээд сууж байдаг билээ гэж Билел гайхан хэллээ.

- Байлгүй яахав дээ. түрүүний хэдэн малаа зуслангаас намаржаанд тууж ирлээ гэж бодоо юу? Зусланд гарч чадахгүй бол чадал муутай зарим айлууд замаас зайдуухан бууж, ус зөөж уудаг юм гэж Сүгир хэлэв.

Гурвуулаа нарийхан хавцлыг өгсөж явтал урьдаас нь эмэгтэй хүний дуулах нь сонсдох нь тэр. Түүний дуулсан дуу ч гэсэн зүрх сэтгэлийг дорхноо эзэгнэн уяраалаа.

Билал хошигнож:

- Бид өөрсдийгөө дуучин гэж сагаж явахад жинхэнэ дуучид энэ хавьд байдаг юм биш үү гэв

- Жинхэнэ дуучин гэж түрүүний баньдийг хэл. Түүний дуу бас л иймэрхүү аятай. Гэхдээ өөр. Сонсвол яана. Шууран цуурайлаад, цаанаа л нэг тэнгэр тулах мэт болно. Бас доомбор дардагийг нь гайхмаар гэж Сүгир шагширлаа.

Залел, эмэгтэй хүний хайлан дуулах дууг сонсон хэсэг зогссоноо:

- Энэ эмэгтэй түүний ээж нь юм уу, эгч нь байж бидний бодсон юм ёсчлон бүтэж магадгүй гэв.

Гурвуулаа жалгыг өгсөн явтал эхэнд нь ноорхой бор гэр харагдлаа. Тэрхэн зуур ганц тугалаа горхины уснаас услахаар ирж яваа цагаан нөмрөгтэй авгай гэнэт гарч ирсэн хүмүүсээс айж, басхүү дуулж явсандаа эвгүйрхэн гэнэт зогсов.

Залуучууд өргөн шанаатай шар авгайг цоо ширтэцгээлээ. Хувцас хунар нь тааруухан гэхээс

үзэсгэлэн гоо нь буураагүй нарийхан хөмсөг нь зурайж, хар нүд нь мэлмэрэн байлаа.

“Хүүхэд тайж” хамгийн түрүүнд ам нээж,

- Амархан сайн уу гэлээ

- Бурханы авралаар мэнд сайн явж байна

Залел яриаг улам өдөж,

- Эгч минь таньсангүй. Уг нь бид Балел тайжийн хот айлын хүүхдүүд гэв

Балекен гэдэг хүн энэ хавийн отогийн удирдагч тайж. Тэр хүнийг мэддэггүй хүн энэ хавьд үгүй билээ.

- Бид тариачид. Нөхөр маань тарианд яваа. Ганц хүү маань хэдэн малаа хариулдаг гээд өнөө эмэгтэй ахин түгдэрлээ.

Галтай нүд доомборчин Билалд тусахад түүнийг ямар нэгэн халуун амьсгаа ширвэх шиг болов. Нүдээ анивчилаа. “Хүүхэд тайж” дахин,

- Нөхрийн тань нэр хэн гэдэг вэ? гэв

- Аман

- Хүүхдийн чинь нэр?

- Серик

- Эгч минь Серик одоо хаана байна гэж Сүгир ярианд оролцов.

“Түүгээр яах гэсэн юм бол” гэж мөнөөх эмэгтэй айдас хүрэх шиг боллоо. Эмэгтэй хариу хэлж амжаагүй байтал Билал үүнийг ойлгож:

- Эмэгтэй минь таны нэр хэн бэ? хэмээн наргиа болгов. Одоо л дасаж эхэлсэн авгай зориг орж:

- Эхлээд энэ хатгамал алчууртай эрхэмийн асуултыг хариулья гэж Сүгирийг заалаа. Хүү минь малаа хариулж явна гэж хэлсээр атал “тэр хаана байна” гэж асуумааргүй юм. Одоо энэ эрхэмд миний нэр хэрэгтэй бол хариулья. Миний нэр Томпи.

Сүгир цэцэрхэх гэсэн боловч үгэнд дийлдсэнээ мэдэж дуугарсангүй. Билал мөнөөх эмэгтэйн нэр эвгүй санагдсан юмуу?

- Томпи..... гэж дуу алдан чангахан хэлж орхилоо. Түүний юу ч үзээгүй юм шиг гайхсан нь эмэгтэйн дургүйг хүргэв.

- Тиймээ, миний нэр Томпи. Харин гарал минь Жадик овогийнх бусдыг өвөг дээдсийн сүнсээс асуугаарай гэлээ. Энэ нь “Томпи” гэдэг нэрийг эцэг маань надад хайрласан юм шүү гэж, егөөдсөн үг ажээ.

Мэдсэн хүнд Билал бас л үгэнд дийлджээ. Одоо яриаг “Хүүхэд тайж” эхлэв.

- Эгч минь элдэв буруу юм хэлсэн бол уучлаарай. Маргаан эрж давхилдан, дайсан эрж сүржигнэн яваа улс бишээ. Дуу хуур, наадам найр эрж явна. Та түрүүчийнхээ дууг ахиад нэг дуулж өгөөч.

Томпи яльгүй ичингүйрхэх шиг болсноо дорхноо бие барьж,

- Үнэндээ дуу ч гэсэн үе тэнгийхэнтэйгээ цуг байдаг юм. Үнэхээр дуу сонсохыг хүсвэл овоохойд минь орж, юм амсацгаа. Өтгөн айраг, өнгийн хивс үгүй боловч алаг ширдэг, ааруул хоормог бий. Өдрийн зоогонд гаргаж өгөх ирэг үгүй ч гэлээ, зусаг бий гэв.

Гурвуулаа үгэнд дийлдсэнээ мэдэж “Хүүхэд тайж” халааснаасаа хатгамал алчуур шанд нь гаргаж өгөнгөө:

- Бид дийлдлээ, дийлдлээ, одоо та биднийг хөтөл гэлээ

Залел энэ өдрөөс эхлээд Серикийг дэргэдээсээ холдуулдаггүй болов. Талийгаач эцэг нь амьд сэрүүн дэрээ эрх мэдлээ Залелд өгч,

- Залел минь намайг дуурайсан юм. Хазсан газраа шүд нь, барьсан газраа гар нь үлддэг эр боллоо. Хэнээс ч дутахгүй зоригтой, үгэнд дийлдэггүй ухаантай боллоо...

- Одоо энэ багахан овгийн хувь заяа чиний гарт байна. Хатуу бай, халширдаггүй бай. Дуу хуурыг больж энэхүү Серик мэтийн дорд гаралтнаас тойрч яв гэсэн юм.

Гэвч дуунд дуртай төрсөн Залел эцэгтээ л харагдан Серикийг сүүдэр мэт дагуул болгов. Серик ч гэсэн Залел таалбал таалахаар сасери сайхан залуу хүч тэнхээтэй эр болж өслөө. Түүний хоолойноос хүчтэй цуурайлах дуу, гараас нь хүнгэнэсэн ая эгшиг урсаад зогссонгүй. Арван хуруу нь авьяасаар тэв тэгшхэн байлаа. Серикийн олс дээл томж, үзэмж бүрэн гутал оёж, нэхмэл нэхэж, алтыг давгаж, мөнгийг шарж хийхгүй юм үгүй. Хүч чадал нь бас тийм. Сэгсрэн татахад сэхэшгүй болгодог, тулж дарахад дороос өндийлгөхгүй болгодог хүчтэй. Суран аргамжийг огцом татахад тас тас хийн тасардаг байлаа.

Серик бас ухаантай хүүхэд байв. Харин одоо эрэлхүү, болоо юу бүү мэд. Насны дундад тэр болгоны үгэнд орохгүй дур мэдэн явдаг болжээ.

Залел тийм ч гэсэн дуугарсангүй дэргэдээсээ холдуулахгүйг бодож ганц эмэгтэй дүү Айгултай суулгав.

«Сал серик» нэрлүүлж өмсөх хувцас, унах морь, эмээл хазаарыг нь хүртэл төхөөрч өглөө. Бүхий л хэрэглэлийг алталж, мөнгөлсөн эмээл хазаартай, хос хилэн хар морь өглөө. Тэрхүү хилэн хар жороо морьдын хөлөнд нь хийсэн алтан бөгжнүүд ямар үзэсгэлэнтэй гэж санана.

Нүд гүйцэм газраас гялалздаг ажээ.

Сал Серикт оёулж өгсөн хувцас нь бүүрч гайхам. Толгойд нь салаа оройтой халиун тоорцог, биенд нь хээ хатгасан хамба хилэн дээл, хөл нь өндөр өсгийтэй хээ суулгасан кебис маси өмсгөлөө. Энгийн цагт болон хол явахад өмсдөг хоёр ээлжийн хувцас хунар эмээл хазаар морь уналгатай болгов.

Таргалахыг хониноос бусад нь даадаггүй гэдгийн үлгэрээр Сал Серик энэ хайр хишгийг даасангүй. Эр хүн болж, ухаан суух тусам хэдэн залуу дагуулж хол ойрлуу тэнэж оддог болжээ. Энэ хорвоо өөрөөс нь хүчтэй, өөрөөс нь уран, өөрөөс нь дууч хүнгүй юм шиг бодож, өдөр шөнөгүй хээнцэр амьдрал хөөсөөр явлаа. Түүний гоолиг сайхан бие улам улам хэнхийн ханхайж, нарийхан гэдэс нь бүдүүрч мөнгөн хонх мэт байдаг нарийхан хоолой нь сөөнгөтөж эрүүний арьс унжиж эхлэв.

Цаг агаар ойрдоо эвдэрч тэнгэрийн өнгө булингартай. Сал Серик толгойлсон хээнцэр ганган залуучууд нэг удаа бас л нутаг хэсэн явах. Тэдний очсон айл болгонд ямагт найр наадам, айтыс болж заримдаа энэ нь хэдэн хоног үргэлжилдэг. Тэр байтугай урьдаас нь айраг ундаа тэгнэн мал алж өдрийн газраас угтдаг явдал ч жирийн хэрэг байв.

Тэрхүү “салууд ирж явна” гэдэг мэдээ сонсвол малтай баян айлууд тавьсан гүүгээ ахин уяж, зарим нэгэн алдар хөөцөлдөгчид улам ихээхэн гүү уяж “Сал Серик нар хэдийд ирэх вэ?” гэж сураглан суудаг байлаа. Зарим нь:

- Нэг нэгэндээ хэл чимээ өгье

- Урьдаас нь угтаж авахгүй бол эвгүй юм болов

- Хичнээн хүн юм бэ?

- Сал серүүд ирэхгүй явбал шившигтэй хэрэг болно гэж хий дэмий далбаганан давхицгаана. Зарим харамч баячууд салуудад дэвсэх зузаан хивс, хоол хийх том түмпэн аяга таваг эрж бужигнана.

Зарим баярхуу хүмүүс салуудад ямар мал гаргах, ямар бэлэг сэлт өгч баярлуулахаа мэдэхгүй зовно.

Авгай хүүхдүүд “салуудыг” үзнэ гэж шуугилдан, ядуу зүдүүхэн нэг нь “нэг удаа цадах байх” бушуухан салууд ирээсэй гэж битүүхэн хүлээцгээнэ.

“Бэл буулгана гэдэг буулгахаасаа сонин” гэж ярьдагчлан сарын турш мөрөөдсөн салууд тэгж тэгж нэг ирдэг байгаа. Тэд хамгийн түрүүнд буусныг бэлэгшээж Конекбайн хот айл гайгүй сайн найр хийлээ. Айтаст ялсан дуучин, түрүүлсэн морь, бөхөд бусдыг гайхуулмаар шан өгөхөөр боллоо. Айтыст Сал Серик ялав. Түүний санаа сэтгэлээс урсан гарсан уран шүлэг, сайхан аялгуу хүмүүсийг үнэхээр баярлуулав. Хасагийн барилаанд Сал Серик бас урдаа хүн оруулсангүй. Үзэгчид:

- Ая дууны аварга юм

- Арслан барсын хүчтэй юм

- Салуудын сайн нь гэсэн хүмүүс л ийм л байдаг байх гэж шуугилдана

Баяр наадмын эзэн яг энэ өдөр гараа атгасан харамч хэвээрээ үлдсэнгүй, бусаддаа атаархсан дотроо тооцоотой ч байсан юм. Нүдээ анин “за яахав” гэж шийдсэнээрээ шийдэж, хос хүрэн жороо морио бай шанд нь өгөхөөр сүргээс бариулан авч ирлээ. Өчүүхэн юманд хууртдаг цайлган хүмүүсийн найр наадамд олз омог олж сурсан салууд уралдуулах хурдан морьдоо ч авч явдаг байв. Айлууд бэлэглэсэн мал тууж явдаг цовоо сэргэлэн залуучуудыг ч дагуулан очжээ.

Маргааш нь салуудад зориулан хурдан морь уралдууллаа. Гэвч тэдний уясан дөрвөн хурдан хүлгээс нэг нь ч жолоо өргүүлсэнгүй. Айраг ууж халамцуу суусан салууд түүнийг бие биеэсээ боллоо хэмээн бухимдацгаав. Үгнээс үг сөрж, гурав дахь удаагийн уралдаанд горьдлого тасраагүй Сал Серик өөрийн хурдан хөх морийг нь уяж явсан уяачинд ухасхийхэд Серик рүү уяач залуугийн ах Күртик ташуур далайн наадмын төгсгөл зодоон болж хувирлаа. Гэнэт тасхийн буусан ташуурын ор Серикийн цохонд зурайж үлдэв. Уурлан ухасхийсэн Сал Серик ганц тавихад Күртик цусандаа холилдон үүдэн шүд нь цаашаагаа хэмх орсон байлаа. Олон хүн салуудын зодооныг арайхийн зогсоов. Эсвэл нэг нэгээ алахаас буцахааргүй болжээ.

Күртик Залелийн өөртөө ойр дотно авч явдаг ач дүү нь байв. Тэрбээр бусдад үл дийлдэн мордоход салуудын ихэнх нь түүнийг даган одлоо. Энэ гэнэтийн зодоон нутгийн ардуудын дотор агшин зуур тархаж, янз бүрээр ярьцгаав. Зарим нэг нь “галзуу салууд” гэвэл, зарим нь “зөрүүд салууд” гэж шоглоно. Зарим нэг морь уралдуулсан толгодыг “салууд зодолдсон толгод” гэлцэнэ.

Кенекбай өвгөн дэгдэх шахам явж Серик толгойлсон арав гаруй залууг арайхийн авч үлдээд үүр цайтал найрлуулав. Маргааш нь өөрийнхөө их гэрт аваачин зочиллоо. Ах дүүтэйгээ зөвлөлдөж Серикт торгон дээл бусдад нь дээлийн бөс даавуу өгч замд нь үдлээ. Салууд ахин сэргэж дуугаа дуулан тоглоом наргиан болсоор, айлууд хүндэтгэл хүлээлгээсэнд сэтгэл гаргаж баярласаар тэндээс мордоцгоолоо.

Сал Серик нар өнөөдөр бүүрч баяртай. Хос хүрэн жороогийн явдлыг ээлжлэн шагширч сэтгэл нь цадаад, Кенекбай баяны эр хүн болохыг гайхаж, бусдад өгсөн бэлэг сэлтийг нэг хэсэг яриа болголоо. Эргэн нэг ирвэл энэ өвгөнд ер бусын хүндлэл үзүүлэн, бэлэг барих тухай ч мөрөөдөн ярьцгаав.

Гэнэт тэдний нүдний үзүүрт нэгэн хот айл харагдлаа. Үд хэвийсэн үе байв. Тэнд очиж морьдоо амраахаар болов. Сал Серикийн унаж яваа хилэн хар жороо “чүү” хэмээн давирахад мөнгөн ус шиг гялалзан, тув тунгалаг нуурын долгио шиг туналзан жороолов. Урьд хоёр хөлөнд нь хийсэн өргөнөөрөө дөрвөн хуруун чинээ алтан бэлзэг туяаран гялалзана. Эмээл хазаарын алт мөнгөн цутгамал товруунууд наранд гялбан, гөрмөл ногтын мөнгөн чимэгнүүд нь жингэнэнэ.

Сал Серик ч гэсэн сая нэг сэтгэл амарсан юм шиг догдлоод дөрөөгөө жийн эмээл дээрээ яльгүй хазгай суугаад, миний сал болохыг энэ олон түмэн улам улмаар мэдрэг гэсэн шиг шар шувууны өд намируулан уясан шар алаг ташуураа барьсан баруун гараа үе үе өргөн, зүүн гараа барьсан жолоогоо хааяа нэг долгилуулан хөдөлгөнө.

Халиун малгайны хос алтан оройд багц багцаар нь хатгасан өд жороо морины явдлын хэмээр сэвс сэвс намирна. Нөгөө гэрт ойртох тусам угтаж хэн ч гарахгүй болохоор Сал Серик морин дээр удчихвал эвгүй юм болно гэж серүүдийн хамгийн залуухан нэг нь түрүүлэн айлын гадна шахам давхин хүрэв. Янзыг нь үзсэн юм шиг том цагаан гэрээс хэн ч цухуйсангүй. Сал Серик гэрийн гадаа ирж зогсоход бусад нь түүнийг түшиж буулгаж, үүд сөхөн гэрт орууллаа.

Гэр дотор солонго татсан мэт үзэсгэлэнтэй ажээ. Алаг эрээн модон ор, заваг тултал хураасан өнгийн хивс, угалзалсан эсгий гудас, сүлжмэл хивсэн том том тэнгүүд, гэрийн дотор нэлд нь битүү шинэ ширдгүүд, хивс дэвсжээ. Гал тогооны тэрүүгээр хоёр хөхүүр харагдана. Эхнийх нь алталсан бүлүүртэй агаад чандмалсан үзүүрт нь өд хатгажээ.

Гэрт хоёрхон хүн байлаа. Зүүн талын орны доохнуур гэрийн ахайтан бүдүүн шар авгай сууна. Түүний өмссөн хувцас гаднаас орж ирсэн салуудынхаас ялгаагүй ажээ. Баруун талын орны тушаа хивсэн дээр нэхмэл нэхэж нэгэн охин харагдана. Алт, мөнгөн торгон утсаар урласан орны аравч нүд хужирлах ажгуу. Энэ охин ч гэсэн салуудыг гайхуулах гэсэн мэт нүдээ гартал гоёжээ. Яльгүй биерхэг гэхээс биш энгэр заамаас нь наран ургаж байгаа мэт гэмээр. Хархан үсээ салаалан сүлжиж үзүүрт нь мөнгөн дугай цагаан мөнгө уяжээ. Ногоон торгон хантаазаа улаан саагаар эмжиж, түүнийг дагуулж бас ар нурууг нь хүртэл цагаан товч хольсон сувд хатгасан байв. Өмссөн цагаан торгон койлектээ гурван давхар хормой гаргаж, хормой бүрт нь улаан торгон утсаар шувуун хушуу хатгажээ.

Салууд орж ирэхэд аажуухан боссон охин гадаа гарах гэтэл ээж нь:

- Салиха охин минь, энэ хүмүүст айраг хий гэлээ. Нутаг хошууныхан бүгд замын дундаас тосон авч, бүр үгүй гэхэд гэрийнхээ гадна угтан ямагт “салууд” гэдэгсэн. Түүний аль нэгнийг ч давтсангүй. Түүгээр ч барахгүй “салууд” ч гэсэнгүй “энэ хүмүүст” гэж ярьж байгааг нь хараач. Гэрийн ахайтан “Энэ хүмүүст айраг хий” гэхэд салууд бие биеэ аяархан нударлаа.

Сал Серик ганц хоёр юм ярьсан боловч гэрийн ахайтан олигтой хариу ч хэлсэнгүй. Ямар ч байсан охины нэр Салиха болохыг л мэдлээ. Энэ чинь бас нэгэн дагина юмаа гэсэн салууд бие бие харцгаана.

Салхиа охин эргэж өдөт бүлүүртэй хөхүүрийн дээд талын томхон борвитой айргийг жижигхэн мөнгөн бүлүүрээр нь хэдэнтээ бүлж, түмпэнд айраг юүллээ. Хүмүүсийн урдуур шар цацаг нь намирсан цагаан торгон дастархан дэлгэж том модон халбагаар, алаг хулуудад айраг хийгээд дээжийг ээждээ өглөө. Хүмүүс өтгөн шаргал айргийг шавхтал нь ууж, аяга тавгаа хураасны дараа охин гадаа гарч ирснээ ээждээ шивэгнэж:

- Ээжээ энэ хүмүүс нөгөө салууд биш биз гэв

- Салууд байлаа л гэсэн яахав дээ, эхлээд гэм буруугаа ойлгож, татвар торгуулийг өгнө биз гэж

ахайтан дуугаа улам өндөр болгож хэлэв.

Сал серүүд гайхан хоцров. Нэг нэгээ харлаа. Учрыг нь мэдсэн нэг нь явья гэж дохив. Үнэндээ эд нар буруутай байсан юм. Кенекбайн хот айлд болсон барилдаанд Сал Серик, Салиха охины ах Саментай “нохой мордож” шуугиан дэгдсэн юм. Үнэндээ Самен унагаасан байлаа. Дахин барилдаанд Самен унаж онгиороо сагсүү Серин толгой дээгүүр нь алхчихсан билээ. Ингэж доромжилсон нь ахайтан хийгээд Салиха нэрт бүсгүй уур хилэнг бадраасан билээ. Түүнээс хойш Самен ч гэртээ ирсэнгүй. Гэхдээ эд нар зодооч салууд буцаад явсан биз ээ гэж боджээ. Тэрхүү зөрүүд гэжүүд сал нар гэнэт хүрээд ирснийг мэдсэн учир домогт Ахи хэмээх бөхийн авгайн үс, зараа шиг арзайсан нь энэ билээ. Нэр хүндэд нь толбо суулгасныг ойлгосон Салиха охины уур нь ч буцлав.

Ихэмсэг давилуун ирсэн салууд одоо унжуу улцан царайлан гарахаас өөр аргагүй боллоо. Ахайтан хийгээд Салхиа охин ч тэдэнд хөл хөөрцөг болсонгүй. Салиха охин ирсэн гийчид гарахаар үүд чиглэхэд ээж рүүгээ эргэж нэг харахад хонин бор нүднээс нь хилэнгийн оч цацрах шиг боллоо. Энэ үед Сал Серик Салиха бүсгүйн хажуугаар гадаа гарахаар өнгөрч явлаа.

Алдар нэрээр хамгаалах гэж шатаж байсан Салхиа хүчит гараараа Сал Серикийн хормойноос нь агшин зуур хавсран барьж уур омгондоо гэнэт угзран татсанаа өөрөө ч анзаарсангүй. Сал Серин гуйван толгойгоо унинд цохив. Гэвч мэдэхгүйг хичээн гарч одлоо. Салууд явахыг завдаж мордож эхлэхэд Салиха охин ээждээ:

- Зүггүй салуудыг зогсоогооч ээж минь. Одоо би барилдъя. Унавал боол нь больё, унагаавал шан байд нь юу өгөхийг үзье гэлээ. Бүүр занаж зүхэж, шүд хавирч суусан ээж нь гэнэт зоригжин шийдэд хүмүүсийн хойноос гарч,

- Ай салууд минь. Гэрт суугаа хөгшин хөвөө улсууд хүндтэй салуудыг хэрхэн таних билээ. Оодорч ороод, цуварч гараад үл тоомсорлон явцгааж байгаа хэрэг үү эсвэл айгаад явж байгаа юм уу хүлээцгээ. Бид ч гэсэн найр наадамд дуртай улс, хоноод явцгаа. Гэрийн эзэн байхгүй боловч хүү нь бий. Хүү нь одоогоор байхгүй ч гэсэн охин нь бий. Тэр охин нь хоноод явагтун гэж ярьж байна. Хүсэлтийг хүлээж авна биз ээ хэмээв. Энэ нь «барилдана» гэснийг арай ондоогоор хэлснийх билээ. Салууд ончий нь олж хэлсэн үгийн зөрч чадсангүй хонохоор шийдлээ. Гэхдээ энэ үг ямар нэг учиртай ойлгож гэрт орцгоов.

Ороход нь үзэсгэлэнт Салиха охин зовсон ч үгүй босож хүндэтгэл ч үзүүлсэнгүй, буруу харж юм нэхсэн хэвээр суусаар ажээ.

Хоймор суусан салуудын нэг нь

- Хүүхний хүслээр ахин орж ирэх шив дээ

- За юу хүснэ вэ?

- Дуу юу, эсвэл өөр юм уу? гэж өдөж ярьцгаав.

Гэхдээ Салиха яльгүй инээмсэглэн дуулдах төдий «өөр юм» гэлээ. Гайхсан нэгэн сал,

- Өөрөө гэж чанга давглаа

- Тиймээ өөр

Тэд гайхахын ихээр гайхав. Хэсэг нам жим болтол гэрийн эзэн авгай гадаа хэн нэгэн хүнд,

Энэ хоноцуудад мал гарга. Мал гаргахдаа суувай гүүний даага гарга гэх нь дуулдав.

Тэгээд гэрт найгалзсаар орж ирээд минжийн арьс тойруулан суулгасан ширдэгэн дээрээ тухалсны дараа намуухнаар ярьж эхэллээ.

- Хүндэт салууд минь мэдээгүй байтал орж ирцгээлээ. Өнөөдөр эрт боловч хоноод явцгаа. Авьяасаа үзүүлцгээ...

Миний яриа гэдэг чинь уулын цуурай гэсэн үг. Бүү юманд бодоцгоо. Салуудыг хүндэлж гэрийн эзнийг орлох хүн энэ охин. Нэр нь Салиха гэдэг юм. Талийгаач эцгээ дууриаж төрсөн хүүхэд. Охин минь морин дээрээс эр хонийг шүүрч авдагсан. Бөх салууд ирлээ гэхээр сэтгэл нь хөөрч суугаа бололтой.

Энэ үгийг сонсоход бүрэгдүүхэн, түтгэлзэж, тээнэгэлзэн суусан залуучууд шуугилдаж эхэллээ. Нэг нь доомбороо тоглож, нөгөө нь хоолойгоо засах зэргээр дорхноо хөгжөөд явчихав. Залирхуу зарим нь инээд наргиа болгож Салихад үг хаяж ч үзлээ.

Гэтэл ахайтан өөрөө босч өөр нэгэн боривноос томоо саванд айраг хийж авч ирлээ. Түрүүчийнх бүгд модон хулууд байсан бол одоогийнх бүгд мөнгөлсөн аяганууд ажээ.

Тэгтэл Сал Серик

- Эгч минь айргийг одоо гадаа ууя гэв. Уг нь тэр гадаа хивс дэвсүүлж айраг уунгаа хүч сорилцоё гэж бодсон хэрэг. Гүүн зэлний дэргэдэх ногоон зүлгэн дээр дорхноо ширдгүүд дэвсч дээр нь хоёр том хивс дэвсүүллээ. Залуучууд өтгөн шаргал айраг хэд хэд татаад барилдаж эхлэв.

Нөгөө бүсгүйн хүсэлт бий шүү дээ. Энд ирж сууг. Магадгүй залуучуудтай барилдана гэнэ биз гэхэд айраг самарч суусан авгай,

- Ганц охин аалгүйтэж аль тааралдсан залуучуудтай барилдалтай биш дээ. ахлах хүнтэй нь хүчээ сорилцог гэлээ.

Сал Серик доороо ямар нэг юм болохыг ойлгосон мэт,

- Зүйтэй, зүйтэй эгч минь. За залуучуудаа аль ахлах чадалтай чинь барилдах нь байна шүү дээ гэв.

Тэгтэл мөнөөх хот айлын нэг залуу:

- Тэгвэл тантай барилдах нь байна шүү дээ гэлээ

- Тэгэлгүй яахав гэж өөр нэг нь дэмжлээ

Салууд ч гэсэн:

- Тэгнэ

- Тэгнэ гэж хөөрөн шуугилдав. Охины ээж нь хүртэл «зүйтэй» гэж дуу алдсанаа дараа нь мэдлээ

Энэ үед нэгэнт шийдэж, ер бусаар хувцаслан, үсээ боож, бүсээ чанга бүсэлсэн гоо сайхан охин Салиха гарч ирлээ. Сал Серик ч барилдах үеийнхээ хувцсыг өмсөв.

Тэгтэл,

- Мөрий!

- Мөрий!, мөрий!

- Мөрий хэрэгтэй гэж хот айлын хүмүүс шуугилдав.

Гэрийн эзэн авгай толгой дохиж,

- Тиймээ мөрий хэрэгтэй. Хэрвээ охин минь унавал, тэр унагаасан залуу хүргэн минь болог!. Хэрэв охин маань унагаавал залуучууд эмээл хазаартайгаа хорин жороо морь өгөг гэв.

- Мөрий бол мөрий!

- Их л бодож бүгд явган буцна биз

- Шийдлээ!, гэлцэж хөөрүү салууд ч шуугилдав. Энэ үед аяга тавгийг хурааж, том хивсэн дээр сал залуу хийгээд, сайхан хүүхэн хоёрын барилдаан эхэллээ.

Нэр төрийнхөө төлөө яахаас ч буцахааргүй болсон хүүхэн шув шулуухан ирж, олноос онцгой, түмнээс сондгой сал залуутай хав дөрвөлжин барилдаад авлаа. Үүнийг харсан салууд уруулаа зууж, дуу алдацгаав. Зөвхөн гэрийн эзэн ахайтан алмайрч орхисон мэт гараа эрвэгнүүлэн охин нь хөдөлсөн зүгрүү ганхана. Удалгүй салууд ч ахайтныг дууриан ганхах мэт хөдөлж хазайсаар байлаа. Хот айлын хүмүүс “хавтгайдаа” гэнэт нирхийн шуугилдав.

Ш. Жамлийхаа орчуулав.

ХУЛБАКИЙН МАХФУЗ

Зохилч Х.Махфуз 1924 онд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Санхүүгийн техникум, намын дээд сургууль төгсжээ.

1960 оноос уран зохиол сонирхон оролдож “Улаан хус”, “Нурбала”, зэрэг тууж өгүүллэгийн ном, “Хэн нь буруутай вэ” жүжиг бичжээ.

АЙЛАГУЛИЙН АРГА

Ажлаас дөнгөж тараад харьж явсан Арганбек шар тос авч харихаар дэлгүүрт орлоо. Оронгуут худалдагч Айлагүлд

- Нэг хийл шар тос авъя гэж мөнгөө өгтөл хөмсгөө тас зангидсан худалдагч

- Тос байхгүй дуусчихсан гэж сочмог хэлээд эргэв.

Айлагүлийн хамгаалагч шиг дэргэд нь хөдөлгөөнгүй цэх зогсож дадлага хийж байгаа охины нүд нь бүлтгэлзэж Айлагүл, Арганбек хоёрыг ээлжлэн харна. Арганбек тэднийхэнтэй айл ажээ. Энэ охин хөршийндөө ганц хийл тос мөнгөөр нь өгч чадаагүйдээ эгдүү хүрэн бухимдаж, торх дүүрэн тос байтал, байгааг үгүй гэсэн Айлагүлийн явдалд уурсан шүд зуув. “Саяхан гурван зуун хийл тос буулаа гэсэн биз дээ. Нүд ирмэх зуур хэрхэн дуусч орхидог байна. Худалдаанд гарсан зүйлийн тэн хагасыг өндөг шиг өр дороо дарж авдаг эд нарт ямар чөтгөр нь шүглэсэн юм бол” гэж дотроо гомдсон Арганбек дэлгүүрийн нөгөө тал руу эргэлээ.

Дадлагын охин ээждээ гомдсон хүүхэд шиг уруулаа цорвойлгон:

- Эгч минь тэр хүнд ганц хийл тос өгчихгүй яавдаа гэлээ

- Тос өгөхөөр тэр чиний юу юм бэ?

- Манай хөрш

- Хаана ажилладаг вэ?

- Барилгын трестэд мужаан

- Хэн гэдэг юм бэ?

- Арганбек

Айлагүл нэгэн зүйлийг гэнэт санасан бололтой алгаараа амаа таглан, нүдээ эргэлдүүлэн хэсэг бодолхийлэн зогслоо. Тэднийх дөрвөн өрөө байшин барьж байгаа юм. Айлагүлийн нөхөр Долбай “Барилгын трестэд Арганбек гэдэг модыг олс шиг зангиддаг уран хүн бий. Бас манай овгийнх. Түүгээр байшингийнхаа хаалга цонхыг нь хийлгэж авахаар боллоо” гэдэг байсан. Айлагүл тэрхүү Арганбек энэ залуу хоёрыг ойлгож тос өгөөгүйдээ амаа барин, аманд орсон юмыг хэлээрээ түлхлээ гэж бодов. Тэгээд дадлагын охин Батимаагаар Арганбекийн дуудуулан

- Дүү минь хүнийг гомдоож голыг нь харлуулах гэж би боддоггүй хүн. Энэ хүмүүс гэдэг чинь хэцүү. Үгүйг ол гэдэг. Өгөхгүй бол гомддог. Худалдагч хүнд ч хоол хэрэгтэй шүү дээ. Бид өөрсдөө худалдаа хийж байсан атлаа, гар хоосон харьдаг өдөр бишгүй олоон. Энэ өөртөө авсан ганц хийл тос. Чиний сэтгэлийг бодоод өөрийн эрхгүй өгч байна гээд дээлний хормойн

чинээ дэрийсэн зузаан бор цаасаар жингийн тавгийг нөмөрсөнөө, дээр нь нэг хэсэг тосыг хаяж, туухай нь тэнцэв үү, үгүй юу шүүрч аван дугтуйлан битүүлж Арганбекийн гарт атгуулж орхив.

- Эгч минь өөртөө авсан юм бол бүү зовоорой. Бусад дэлгүүрүүдэд байгаа байх гэж Арганбек лангуун дээгүүр өөрлүү нь гулгуулав.

- Өө, гөөгий дүү минь чиний авсан чинь, миний авснаас юуны ялгаатай. Тэгж болохгүй, муу ах чинь чиний нэрийг амнаасаа бурхны уншлага шиг салганаа гэж байхгүй. Арганбек байхад гэр оронд хэрэгтэй модон эдлэлийг хэнээс ч гуйхгүй гэдэг. Үүнээс хойш, хэрэгтэй зүйлээ захиж дуртай цагтаа авч байгаарай гэж Айлагүл нөгөө тосыг Арганбекийн гарт хүчээр бариулав.

Зузаан цаасанд ороосон атган чинээ тосыг авч дэлгүүрээс гарсан Арганбек, Айлагүл эхлээд байхгүй гэж эцэст гуйх шахам өгсний учрыг одоо л оллоо.

Айлагүлийн нөхөр нэлээд томхон байгууллагын дарга. Тэр Арганбекийг ойр төрлийн хүн хэмээн “дүү минь энэ барьж байгаа суут ухаантай юмны хаалга цонхны мод чиний хар толгойд гэдгийг мэдэж аваарай. Ийм үед туслахгүй бол, хэдийд туслах юм бэ?” гэж тоглоом шоглоом болгон хэлдэг байлаа. Арганбек ч “бололгүйдээ” гэж ам өгсөн удаатай. Урьд таньдаггүй болохоор Айлагүл анх анзааралгүй өнгөрчээ.

“Тэгэхээр нийгмийн хөрөнгийг өөрийн өмч шиг амин хувийн хэрэгт ашиглаж буй нь аргагүй гэмт хэрэг бус уу?” гэж Арганбек бодлоо. Арганбек, Айлагүлийн тос боож өгсөн цаас том тэгээд бас зузаан байгаагийн учрыг ч ойлголоо. Цаас нь эвхэхэд эв хавгүй адууны адсага адил билээ. Наандаад тавин граммын жинтэй. Тэгэхээр зуун хийл тос зарвал таван хийл тосыг хувьдаа завшина. Тэр нь жаран төгрөг болно. Тэгэхээр түнтийтлээ тэр таргалахгүй, хэн таргалах билээ. За бас Айлагүлийн жингийн хоёр тал тэнцэв үү, үгүй юу тавьсан юмаа шүүрэн авдаг өвчин бас бий. Түүнээс хичнээн ашиг ордогийг гагцхүү “эзэн тэнгэр” мэдэхгүй бол хүн хараа цавчих зуур хэрхэн мэдэх билээ.

Арганбек дэлгүүрээс гарсан тэр мөчид ханхалзсан өргөн цээжтэй, хайнагийнх шиг хамрын нүхтэй, өвдгөө хүртэл унжсан гэдэстэй нэг эр орж ирээд,

- Айлаш минь арилжаа наймаа өөдрөг болтугай гэсээр инээд алдлаа

- Ерөөл орштугай Зээ минь. Нөгөө захисан юмаа авахаар ирээ юу? гэж Айлагүл тогтож ядав

- Хүний доторхийг хэлэлтгүй ойлгодог эгч минь, чам шиг буянтай хүн, хүний хорвоод өөр байдаг болов уу гэж бүдүүн гэдэстэй булиа эр маг маг инээлээ. Айлагүл:

- Зээ минь хичнээн хийл хэрэгтэй юм бэ? гэж жингийн тавганд шар тос тавьж эхлэв.

Тэр, энэ удаа зузаан бор цааснаасаа дэвссэнгүй. Нөгөө эр:

- За, тавыг гэлээ

- Хайртай зээ минь, үмхийрч байгаа тос энд алга. Ийм байгаа дээр нь аривхан шиг авч авдрандаа цоожлохгүй юу гэж Айлагүл ихэд дотносон хэллээ.

- Ай сайхан ааштай, саруул ухаантай эгч минь түүнийг би мэдэлгүй яахав, нөгөө тоолдог юм нь дугаад байна шүү дээ гэж халаасаа гөвж үзүүлэв.

Айлагүл арван хийл тосыг боож эвтэйхэн гарт нь бариулаад:

- Өчүүхэн юманд өөдсөн чинээ болж зовох гэж. Таван хийл тос зээл өгч чадахгүй бол зээ гэж чамайг дуудах хэрэг юун. Тийм төрөл төрөгсөд гэж байдаггүй юм гэлээ. Тэгээд бас,

Нагац ах чинь аж ахуйн юманд арга дүйгүйг мэднэ шүү дээ. Зээ минь. Байшин барина, байшин барина гэдэг. Түүнд юу хэрэгтэй огт мэдэхгүй. Будаг шунх, хадаас, энээ тэрээ юмнаас өөр сурах байхгүй. Бурхан минь энэ бүгд чиний гарт байгаа нь бидний заяа л гэсэн үг. Нагац ах чинь чамд л итгэдэг юм шүү дээ гэж хэлье гэсэн үгнийхээ зах зухаас нь хэлж амжив.

Эгч минь тэр талаар битгий зов. Хэрэгтэй цагт нь ирж аваарай. Миний ухаан ходоодондоо байдгийг та мэднэ шүү дээ. Амттай хоол, өөхтэй мах байвал боллоо гэж бүдүүн гэдэст бас л тоглосон болж өөрийнхөө бодлогыг хэлж орхилоо.

Дадлагын охин Айлагүлийн дэргэд байсан хоёр гурван сарын дотор ийм юмыг өчнөөн төчнөөн удаа үзэж сонсчээ.

Тэр анхандаа Айлагүлийн нууж худалддагийг мэдэлгүй, нууж тавьсан юмыг нь худалдан авагчдад “байна” гэж хэлж орхиод Айлагүлээс олон удаа сануулга авч, заавар зөвлөлгөөнийг сонссон удаатай. Тэгэхэд Айлагүлийн ярьдаг юм нь гэвэл:

- Худалдагч хүн овсгоогүй явбал үхсэнээс ялгаагүй. Манай казахт “Тогоо цутгадаг хүн чихийг нь хаанаас нь гаргана гэвэл өөрийн дур” гэж үг байдаг. Түүний нэгэн адил гартаа орж ирсэн эд барааг яаж худалдсан ч худалдагчийн өөрийн эрх.. худалдаа гэдэг маань шавхагдашгүй газрын баялаг адил, саагаад байвал, ивлээд байдаг юм. Эвийг нь олж, атга чимх гэхгүй аргалж өөрийнхөө олз омгийг ч бодох хэрэгтэй. Зөвхөн аргыг нь олж чаддаг байх нь чухал. Хүрч ирсэн хүмүүсийн төрх байдал хэн болохын, юу хийдгийг таван хуруу шигээ мэдэж бай. Юмны илүү дутууг мэддэггүй үлбэгэр ноомой амьтан орж ирэхэд авна гэсэн юмны нь тэн хагасыг хийгээд өгсөн ч мэддэггүй. Тийм үед барьж ирсэн сав хүүдийтэй нь хийлэлчих. Жингийн хоёр таван тэнцэхийг хүлээж зогссоны хэрэггүй. Нэг тал нь хөдлөв үү, гүй юу шүүрч аваад савруу нь хөмөрчихвөл боллоо гэсэн үг. Хүмүүсийн ихэнх нь тав арван мөнгийг тооцоолоод байдаггүй юм. Өөрөө гуйхгүй юм бол “үүнийгээ ав” гэж бүү шарвалз. Шинээр ирсэн барааг хамаагүй дуустал нь бүү худалдаж бай. Хагасыг нь авч үлд. Түүнийг өөрт чинь тус хүргэдэг хүмүүстэй улам найрсан, ойр дотно байхад ашиглаж сур дүү минь. Гарт нь эд хөрөнгө, ховор нандин зүйл байдаг нярав, машин унадаг жолооч, тушаал цолтой дарга даамалтай холбоотой байна. Тэднээс байдаг л юм бол бүү харамла. “Өгвөл авдаг” гэдэг шүү дээ. нярав байвал гуйсныг чинь өгнө. Жолооч байвал түлээ түлш, элдэв зүйлийг чинь ойртуулж өгнө. Дарга даамал бол гэм бурууг чинь дарж өчүүхэн алдрыг чинь тэнгэрт тултал өсгөнө. Нөгөө нэг шүлс нь гоожин, хөл нь гуйвж, нүд нь гөлийж толгойгоо ганзгалж явдаг

архичингуудыг мэднэ шүү дээ. Тэд тийм үедээ ганц шил архины төлөө өмсөж яваа хувцас, зүүж яваа цагаа тайлж өгөхөөс буцахгүй. Шил архи аваад өгвөл халаасандаа хичнээн юм байна, бүгдийг нь өгөөд уухай тас алга болно.

Зарим нь зээл өгөөч гэж үхэн хатан гуйдаг. Тийм үед баахан цааргалж байгаад ганцханыг өгөөд хоёрыг бичих. Бас сурвалжлагч мурвалжлагч гэж зүрхэнд хүрмээр гашуун нясуун үгтэй айхтар хүмүүс байдаг. Тэднээс хамгийн их болгоомжил. Товчин чинээ юмыг тэмээн чинээ болгож бичдэг улс шүү. Өдөр бүр олсон тав арван мөнгөө сайтар тооцож халаасандаа хийгээд бай. Тооллого болохын өмнө хэн ирэх нь вэ? гэдгийг урьдчилан мэдээд гэртээ урь. Хоолойд нь тултал хоол, ухаан алдтал нь архи өг.

Ийм үгэнд нь залхаж гүйцсэн Батиймаа нэг өдөр:

- Эгч минь, би таниас ард түмэнд хэрхэн хөнгөн шуурхай үйлчлэхийн арга ухаан, бүртгэл тооцоог хэрхэн эмх цэгцтэй хөтөлдөг, эд барааг яаж хамгаалдаг арга ухаан сурахаар ирсэн юм. Элдэв булай муухай аргаар хэрхэн ашиг хонжоо олохыг сурах гэж ирээгүй. Би эвлэлийн гишүүн хүн. Тийм замаар орж чадахгүй. Энэ мөчөөс эхлээд таны дэргэдээс явлаа хэмээн бусгах мэт гарч одлоо.

Чив чимээгүй, хий гэснийг нь хийгээд явдал ноомой охины энэ явдал Айлагүлийг ихэд тэвдүүлээ. Түүний нүдний өмнө хийсэн юм нь нэг нэггүй дэс дараалан харагдаж эхлэв.

ДОНРОВЫН НАМДАГ

Зохиолч Д.Намдаг 1911 онд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

1934 оноос уран бүтээлээ эхэлж “Сүрэг чоно”, “Шарай голын гурван хан”, “Тэмцэл”, “Шинэ байшин”, “Оролмаа”, “Хярааны хонхор”, зэрэг драмын жүжиг, “Эрхэм зураг”, “Тогос хээр” зэрэг өгүүллэг, шүлгийн ном хэвлүүлснээс гадна “Цаг төрийн үймээн” роман туурвижээ.

Зохиогчийн “Цаг төрийн үймээн” роман орос, казак хэлнээ орчуулагджээ.

Д.Намдаг БНМАУ-ын төрийн шагнал, БНМАУ-ын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртжээ.

НЭГЭН ЭКИПАЖИД БОЛСОН ЯВДАЛ

Ховдоос Улаанбаатарт эргэх онгоц тэнгэрийн муухайд бүтэн хоёр өдөр саатаж, гурав дахь шөнөө өнгөрүүллээ. Энэ бол өдөр тутам хэдэн мянган километр нисэх үүрэгтэй бөгөөд түүнгүйгээр дэмий цаг нөхцөөж чадахаа больсон экипажийнханд бөөн уйтгар. Иймд тэд цаг тутамд тэнгэрийн байдлыг ширтэх зуураа эргэх замын буудал бүрээс агаарын байдал ямар байгааг радио холбоогоороо асуун лавлаж байлаа. Үүнд хойт зам Завхан аймгийн төв базаалтай биш байх боловч буух бололцоотой. Урд замын Говь-Алтайн төв хэрхэвч буух боломжгүй, Хойд замын Архангайн төвд тэнгэр тунгалаг агаар тогтуун байхад урьд замын Баянхонгорын төв базаахгүй боловч буух боломжтой. Гэтэл Улаанбаатар гэвэл урин дуудах мэт бүрэн сайхан. Ер нь урд өдрүүдэд ийм байсан бөгөөд одоо ч ийм л аж. Харин санаснаас гуравдахь өдрийн өглөө эрхбиш засрах нь уу гэмээр болж ирэв. Гэвч Улаанбаатараас цаг уурын мэдээ зарлахдаа Ховд аймгийн нутагт өөрчлөлтгүй гэсэн нь хэн бүхний сэтгэлд зовуур төрүүлсээр аж. Иймд экипажийнхан түр зуурын сэгийсэн дээр нь эндээс сугаран авья гэж хэлцэн тохиролцов. Гэтэл авч явах хүмүүс хаана вэ? түрүүчийн хоёр өдөр онгоцны буудлын бяцхан байшинд багтаж ядан чихцэлдээд орох гарах бүрд: “Одоо явах болоогүй юу?” гэж ам амандаа шуугилдаж, чихэнд чийр болж байсан бол одоо хэн нь ч алга. Үнэндээ тэд цөхөрсөн байв. Экипажийнхан ч цөхрөнгөө барсны хувьд, нөхөд минь битгий бухимд. Бид тэнгэрийн байдал засармагц гайгүй та нарт зарлая гэж амлан тараачихсан байв.

Иймд одоо яаран зарлах хэрэгтэй болжээ. Аймгийн төвийн радио холбоо, утас шөрмөс өөр бусад хэлдэг хөдөлдөг бүхнийг хөдөлгөлөө. Энэ нь бараг бүтэн цэг үргэлжилсэн тул тэнгэрийн байдалд түр зуурын өөрчлөлт орсныг ашиглах гэсэн экипажийнханд маш их хугацаа шиг байлаа. Гэвч хүмүүсийн цугларсан нь нэгэн зэрэг. Тэр мөртөө онгоцонд орохдоо дараалал баримтлахыг мартан ухаан жолоогүй зүтгэн цаг алдуулах нь бас ч хэцүү. Эцсийн хүн гэвэл нэг залуухан эмэгтэй, давхар биетэн. Энэ хүүхэн хаана ямар ажилтайг хэн мэдлээ. Ер нь эр нөхрөө дагаж ирсэн гэрийн сахиул ч байж мэднэ. Юу ч атугай төрөхөө ойртоход Улаанбаатарт байдаг аав ээж дээрээ очих гэж яваа юм байж. Харин энэ дашрамд тэмдэглүүштэй нь хүүхнийг хүргэж ирсэн хоёр залуу онгоцны хаалган дээрээс буцахын оронд заавал оруулж суудал олгож өгнө гэж үйлчлэгч хүүхэн Ганьдмаатай зөрөлдөн хэг ёг үг хаяснаас нь үзэхэд дүрэм журмыг баримтлагчид биш болох нь илэрхий.

Зорчигсод суудлаа эзэлж онгоцны хаалга нэг мөсөн хаагдмагц хоёр мотор ээлж дараагаараа асаж сэнс нь эргэлдэн, хүнгэнэх дуу нь үргэлжлэв. Ихэд хөрсөн моторыг зохих хэмжээнд нь хүртэл халаахад бас хэдэн минутын хугацаа шаардагдана. Энэхэн зуур тэнгэрийн аягүйцэл ширүүсч цас шороо хоёрыг манаруулахад хүрсэн нь экипажийнханд мөн л түгшүүр. Гэвч Ганьдмаа зорчигсод тэнгэрийн муухайг сануулан хүн бүр суудлын даруулга бүсийг сайтар бэхэлж авахыг сануулмагц онгоц хөдлөн улмаар хурдаллаа.

Ганьдмаа зорчигчдын өмнө ирж, бие чангалан зогсож “Эрхэм хүндэт зорчигчдоо, энэ удаа та бүхэн АН-24 онгоцоор нисэж байна. Онгоцны экипажийн бүрэлдэхүүнд ахлах нисэгч Шаравжамц, хоёрдугаар нисгэгч Даваажав, механикч Батсүх, мөн холбоочин Дэмбэрэл, үйлчлэгч нь би. Миний нэр Ганьдмаа. Бид одоо Завхан, Архангайг дайрах хойт замаар явж байна. Урд зам гэвэл Алтай, Баянхонгор, Өвөрхангайг дайрна. Энэ бидний зам хэдэн зуун километрээр ойр байдаг. Нислэгийн хугацаа 4 цаг. Та бүхэнд тавтай нисч, зорьсон хэргээ

гүйцэтгэхийг экипажийнхаа өмнөөс хүсэн ерөөе” гэв. Энэ дашрамд Ганьдмаад эгцлэн харсан хүмүүсийн дундаас онцлон харагдсан нь давхар биетэй хүүхэн. Тэрбээр нуруу гэдийлгэн, сандлын ар түшлэгт наалдуулан амьсгаадан сууна. Дараа нь нэг толигор тунгалаг царайтай ахимаг настай авгай. Түүний хагас ангайсан амны нь баруун талын соёо алт. Өмссөн дээл зузаан сэгсүүргэн дотортой алтан саа эмжээртэй хүрэн торго. Тэрбээр хараа дээгүүр, хир баргийн хүнийг тоомгүй шинжтэй бөгөөд одоогоор түүнд хажуудаа тэвэрсэн хоёр литрийн багтаамжтай халуун савтай юмыг л энхрийлж байгаагаас өөр юм алга. Дараа нь нэг залуухан хүүхэн. Царайгаар базаахгүй боловч засаж чимэглэсэн нь сүрхий. Дархан хотын нэхий дээлийн үйлдвэрийн тэргүүн хийцтэй нэхий дээл өмссөн. Толгойдоо цагаан шаргал сорт булган малгайг чихэндээ тулган дарсан нь уг царайг нь ихэд дээш татжээ. Гутал нь зузаан ултай урт түрийтэй, хүрэн өнгийн сайхан савхи. Гэвч тэр Ганьдмаагийн хэн бүхэнд анхааруулахыг ихэд хичээнгүйлэн ярьсныг сонсохын оронд гоё цүнхнээсээ бяцхан толь гарган бараг хамрынхаа үзүүрт тулган бариад уруулынхаа будгийг сэлбэн сэргээж байсанд Ганьдмаа сэтгэл гонсойн гомдоход хүрч байлаа. Тэгээд хажууд нь ямар хүн сууж буйг сонирхоход хүрсэн бөгөөд тэр нь оюутан болов уу гэлтэй хуучирсан хар пальтотой нэг залуу. Хүүхэн түүнд ер царай өгөхгүй байгаагаас Ганьдмаа энэ хоёрын хооронд хайр дурлалын харьцаа яавч байхгүй гэж бодов. Бусад хүмүүс цөм жирийн. Албан хаагч, ажилчин, малчин хувийн хэргээр яваа энгийнхэн болох тул Ганьдмаад нэгэн жигд харагдсанаас өөр юм алга.

Ганьдмаа тэндээсээ нисэгчдийн кабинд орлоо. Энд хүмүүс царай дүнсгэр бодол болсон төдийгүй хоор зуураа зөрөлдсөн бол уу гэлтэй үзэгдэнэ. Урьд өмнө энэ экипаж иймэрхүү явсан удаагүй. Цаг ямагт баяр баясгалан, ялангуяа ахлагч Шаравжамц 12 жил агаарт нисэхдээ хөмсөг зангидаж байсан удаагүйгээрээ нэрд гарсан хүн байлаа. Ганьдмаа гайхан юу болсныг асуухад холбоочин Дэмбэрэл:

- Сая Улаанбаатарт Ховдоос гарч амжсанаа мэдэгдэхэд харин биднийг Говь-Алтайгаар дайрахыг шаардав гэж бухимдуухан хэлэв. Үүнд Ганьдмаа Ховдоос гарсаар 100 гаруй километр явснаа харуусав

- Юунд тэр вэ гэж лавлан асуухад

- Говь-Алтайд Их хурлын депутат гэнэ үү. Улсын баатар малчин өвчтэй байгаа юм байж. Тэгээд түүнийг заавал авчир гэж шаардав гэж Дэмбэрэл хариулав. Энэ тухайд Ганьдмаа наад цаадыг бодохын оронд шууд хүнд өвчтөнийг эрхэмлэн:

- Тэгвэл одоо урагш эргэхэд л болоо бишүү? гэхэд

- Хонгор минь Говь-Алтайд буух боломжгүй байна

- Яагаад тэр вэ?

- Яагаад гэнэ шүү! Энэ тэнгэр! Хөндлөнгийн салхины хүч 20-21-д хүрч байгаа энэ гэж Дэмбэрэл уцаарлан хариулав. Үнэндээ онгоц буухад хөндлөнгийн салхины хүч, секундэд 18 метрээс дээш байвал, онгоцыг хажуу тийш шидэхэд хүрдгийг Ганьдмаа олонтой сонсжээ.

Үүнээс цааш бас хараа 100метрээс дотогш байвал буух газар онгоц хүлээн авдаггүйг мэдэх

тул

- Хараа хэд байгаа бол? гэж асуувал мэдээжээр Говь-Алтай хоёр хүн хоорондоо төөрөхөөр л байгаа биз гэв. Ахлагч Шаравжамц үг дуугүй явснаа:

- Тэр хараа ч яахав олонтой буусан газрын баримжаа мэдэгддэг хэмээн амандаа өгүүлснээ, алив чи Говь-Алтайтай ахин ярилц гэлээ. Дэмбэрэл чагнуураа чихэндээ суулгаж, радио долгионы залгууруудыг хөдөлгөн: “Байна уу, байна уу, Говь-Алтай” гэж үргэлжлүүлэн дуудав.

Харилцан ярилцах нь тэр дорхноо бүтсэн бөгөөд Говь-Алтайн салхины хүч арай зөөлөрч байгаагаас гадна, аймгийн удирдах хүмүүс өвчтөн хүний тухай сандран тэнгэр ширтэх, онгоц нэхэх хоёроос өөр юу ч үгүй байгааг мэдэгдэв. Энэ даруй Шаравжамц:

- За, дүүрсэн хэрэг гэж шийдэмгий өгүүлэв. Энэ шийдвэрийг эсэргүүцэх хүн алга. Тус бүрийн сэтгэлд салхи. Салхи ер юу болгох бол гэсний цаана өвчтөн сандарч буй хүний амь, өөрийн газрын алдар нэр, амин хувийн үүрэг хариуцлага энэ бүхэн нэгэн зэрэг бодогдоно. Онгоцны хүч хоёр мотор боловч энэ тухай бодолцох мэт дуу нь чангарч хөндлөнгийн салхинд дайвалзав.

Ганьдмаа энэ удаад ард суусан зорчигсдод анхаарал тавин, дотор аягүйцвэл хэрэглэдэг цаасан дугтуйнуудыг тарааж өгөхөөр орлоо. Энэ зуур онгоц хямарсан үүлс ба үелзүүр салхинд хэдэргэт замаар машин явж байгаа мэт сэгсчин донсолж хүмүүсийн царай шарланги, санаа сэтгэл шаналалтай яваа нь нүдэнд илхэн. Тэр дундаас түрүүчийн толь барин уруулаа будагч ганган хүүхэн хажуугийн залууг түшин унаж тэврүүлээд, өгсөн дугтуйг авах чадалгүй хажуугийн залуугаар авахуулж байгааг үзэхэд бүр ч унаад өгсөн байв. Харин санаснаас тунгалаг царайт гоё авгай ер давгүй халуун савтай цайнаасаа аягалан ууж байх бөгөөд дугтуй өгөхөд авахаас татгалзан толгой сэгсэрч байх нь бахдал ч юм шиг бодогдов. Энэ дашрамд Говь-Алтай дайрах чухал хэрэг болсныг дурдахад хүмүүс эсэргүүцэл тавихын оронд тус бүрнээ санал алдан толгой сэгсрэв. 5000 метрийн өндрөөс онгоц доошлов. Доош харахад уул толгодын орой үелзэн буй хүчит цасан шуурганд хохилзон харагдана. Доошлох тусам газрын бараа тодрохын оронд бүдгэрэх нь аймшиг. Гэвч Шаравжамц хуучин олонтой буусан газарт баримжаа байдаг гэсэн ёсоороо буусан бөгөөд эсэн мэнд. Улаан хэрээс тэмдэгтэй эмнэлгийн битүү машин, суудлын машины хамт манарсан шуурган дундуур хүрч ирэхэд онгоцны хаалганд шат тавигдлаа. Эмнэлгийн машинаас дамнуурган орон дээр битүү хучаастай хүнд өвчтөнийг хоёр хүн дамнан гарч шат өөд авирахад Ганьдмаа хаалгаа нээв. Энэ даруй хөндлөнгийн шуурга хүч түрэн онгоцонд орж хүн бүхний нүүр өөд хүйтэн ус цацах мэт болжээ. Суудлын машинаас аймгийн удирдах хүмүүс бугаад онгоцонд орж буй өвчтөнд эрүүл мэнд болон эргэж ирэхийг ерөөх дашрамдаа дамнагч хоёр хүнд Улаанбаатарт хүргэж өгөөд эмнэлэгт хэвтүүлэн өдөр бүр эргэж, аймаг руу мэдэгдэж байхыг даалгав. Гэтэл уг өвчтөн хариу үг хэлэхийн оронд шүд зуун янцаглахаас цаашгүй байгааг үзэхэд үнэхээр сэтгэл зовом хүнд байгаа нь илэрхий. Эдгээрээс гадна онгоцонд дөрвөн хүн нэмэгдэн суув.

Энэ удаа юм бүхэн маш яаруу. Зорчигчид ч яаран явахын мөрөөдөс. Экипажийнхан ч яаран сугаран гарахын мөрөөдөс. Тэр дундаа Ганьдмаа хүнд өвчтөнийг хурдан хүргэхсэн гэхдээ хаалга үүдээ яаран түгжиж авав. Гэтэл санаснаас энэхэн зуурт нүүр нүдгүй шуурч байсан шуурга намдаж хүч нь нэлээд буурч байжээ. Онгоц аймшиггүйгээр хөдлөн хурдалж газраас

тасран дээш хөрлөө. Газарт гарч болох аюул даруй тэнгэрт гарсан мэт 4000 метрийн өндөрт гарч тэргүүн зэргийн хурдаар явж байтал онгоц гэнэт уул мөргөх мэт дугтарснаа доош уналаа. Энэ бол агаарын цөмрөл. Энэ тухайд цочоогүй, сандраагүй, дуу алдаагүй хүн нэг ч үгүй.

Ганьдмаа зоригчдыг үзэхээр ирэв. Хамгийн түрүүн Их хурлын депутат баатар малчны төлөө сэтгэл зовох аж. Дэргэд нь очиход чимээ алга. Өнгөрчихөөгүй байгаа даа гэж бодон айдас хүрч:

- Энэ хүн яаж байн? гэхэд дэргэдэх хүн нь

- Мэдэхгүй. Саяын ширүүн донсолгооноос хойш чимээгүй л болсон гэв.

Үүнд Ганьдмаагийн сэтгэл палхийж хучлагыг нь сэм сөхөж үзвэл ашгүй амьд. Нүүрэнд нь халуун хөлс дааварлаж нам тайван унтаж байв. Дараа нь давхар биетэй хүүхэнд анхаарал тавихад амьсгаа дээр, нүүр минчгэр ихэд тамирдаж яваа нь илэрхий. Гэвч хажууд суусан ахимаг настай нэг малчин байрын хүн түшиг тулгуур болж яваад нь сэтгэл тайвшран амрав. Дараа нь ганган хүүхнийг ажихад дэргэдэх залуугийнхаа өвөр дэр тэгнэн унасан төдийгүй нэг гараар нь тэврүүлж, нөгөө гарт нь дугтуй дүүртэл огиулсан бохирдлоо бариулсан байх тул Ганьдмаа түүний нь авч шинэ дугтуй өгөв. Энэ зуураа Ганьдмаа энэ хоёрыг өөрийн эрхгүй хувь заяа нь ингэж холбож байгаа байхнээ гэж бодон нэг талаар инээд хүрч, нөгөө талаар баяр хүргүүштэй бодогдов. Гэтэл гоё авгай ер ажиггүй. Алтан бөгжтэй сайхан хуруугаа эргүүлж тойруулан хуруу хумсаа цэвэрлэж байв. Бусад хүмүүс зүс царай мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байх боловч цөм хөгжилтэй.

Түрүүчийн донсолгоонд айсан, сандарсан цочсоноо инээдэм болтол хэлэлцэх тул өөрийн эрхгүй даган баясалцахад хүрэв. Ганьдмаа урьд кабинд орж зорчигсдынхоо амар мэнд явааг мэдэгдэв. Гэлээ ч Шаравжамц хүнд өвчтөнийг Улаанбаатарт яаран хүргэхийг эрхэмлэн Баянхонгор, Өвөрхангай хоёрт буухгүйгээ мэдэгдлээ. Ингээд зүүн тийш явах тусам салхины эрч эрс бууран, үүл шингэрч хурц нар тусах болсон нь юутай сайхан. Гэтэл бас ахин сандрал. Зорчигчдын нэг “Хүүе та минь хүүхэд, хүүхэд” гэж сандран орж ирлээ.

- Юун хүүхэд гэж гайхан асуухад

- Энд хүн төрөх гэж байна гэх нь тэр. Үүнд цөм сандарлаа.

Улаанбаатар хүртэл хоёр цагийн зай байна. Тэр болтол тэсвэрлээд байж болдоггүй юм болов уу гэж Даваажав хэлэв. Юуны чинь тэсвэрлэх. Тэсвэрлэж болохгүй юм төрөхөд л байдаг байх. Алив Ганьдмаа цаад хүмүүс дотор чинь эрх биш эх барьж чадах хүн байж мэднэ гэж Шаравжамц хэлэв.

Ганьдмаа зорчигсод дээр ирлээ. Хөөрхий давхар биетэй хоёр хүнээр түшүүлснийхээ дунд дуу тавин ёолж байлаа.

- Хүүе та минь гарах хүүхдийг эх барьж авч чадах хүн байна уу гэж дахин давтан асуухад хүмүүс бие биеэ харахаас өөр ямар ч хариу алга. Ганьдмаагийн сэтгэлд өнөөх ахимаг настай гоёмсог авгай орж түүнийг л яавч чадах биз гэж бодогдов. Тэгээд түүнийг эгцлэн харахад

авгай тэр юухан байхав гэх мэт дээгүүр харан инээмсэглэж байгаад бүүр ч итгэн:

- Алив авгай минь та л нэг чадах байж мэднэ гэж тулан очив. Гэтэл авгай дээгүүр харсан инээмсэглэлээ орхин буруу харлаа. Ганьдмаагийн сэтгэл гутарсан нь жигтэйхэн. Арга буюу гэдрэг эргэж кабинд орж чадах хүн алга байгааг хэлэхэд:

- Тэгвэл чи өөрөө гэж тушаав

- Бурхан минь, би чадах байтугай үзээ ч үгүй

- Тэр юуны хамаа гээд Шаравжамц Дэмбэрэлд хандан

- Алив чи Улаанбаатартай ярь. Дэмбэрэл гайхан

- Юу гэж ярих вэ? гэхэд Шаравжамц

р Хүүхэд яаж эх барьж авдгийг асуу. Ганьдмаа чи сайн тогтоож ав гэлээ.

Энэ бол тун бэрхтэй хэрэг. Гэвч хүн өөрийн эрхгүй юманд тулгарахдаа мөн өөрийн эрхгүй хөдөлдөг аж. Улаанбаатарын иргэний нисэх онгоцны радио холбооны газар эх нялхас барих талаар үнэхээр тасархай тул тэнд бас бөөн будлиан. “Байна, байна Улаанбаатар гэж хариу өгснөө-Аан, юу гэнэ ээ?... Хүн төрөх өө? Хүүхэн юмуу?.. Одоо яана аа... Үгүй тэгээд яа гэж.. Эх барих аа. Түргэн тусламж дууд гэж үү? Дуулж байна, дуулж байна. Бүү мэд. Энд мэдэх хүн алга... мэдэхгүй, мэдэхгүй миний санаанд ч чадах хүн алга... Аан, за? Юу гэнэ?... Хэнээсээ? Хошууч Онцол гуайн эх, зөв. Тэр зааварлаж чадна ... одоохон, би хүн явуулъя машинаар... байна уу, байна уу. Хүн явсан. Ирэхтэй нь зэрэг би эндээсээ залган ярилцуулъя” гээд холбоо тасарлаа. Иймд одоо хүлээх л хэрэгтэй болов. Гэвч хүн бүрийн сэтгэл хошууч Онцолынд машин очих, очсон хойноо эхэд нь учирлах, учир мэдүүлсэн хойноо радио холбоон дээр авч ирэх, ирсэн хойноо холбоо залган ярих энэ бүхнийг санахад бүхэл бүтэн жилийн хугацаа байх шиг санагдана. Гэлээ ч хүлээх гэснээрээ хүлээхээс өөр ямар ч аргагүй болох нь илэрхий. Гэтэл баатар малчныг хүргэж яваа хүний нэг нь:

- Хүүе та минь та нар яачихваа. Тэр хүүхэн чинь юу юугүй төрөх дээрээ туллаа гэсээр кабинд орж ирлээ.

- Үгүй бид Улаанбаатараас эх барих заавар авах гэж хүлээж байна гэхэд

- Тэр хэрэггүй ээ, энд хүн бэлэн байна

- Хэн бэ?

- Манай депутат утас шөрмөс, хайч хөвөн, марль олж ир гэж байна. Энэ ч бас хачирхалтай. Тун саяхан үг хэлэх тэнхэлгүй байсан хүнд өвчтөн гэнэт эх барих дээр хүрснийг хэн ч итгэхэд бэрх.

Гэвч экипажийханд энэ тухайг бодох завдал байсангүй. Ганьдмаа онгоцонд хэзээ ямагт бэлэн байдаг аптекаа шүүрэн авч зорчигсдын кабинд үсрэн орлоо. Депутат баатар малчин хөл

дээрээ зогсож байхаар барахгүй хүүхний дээлийг нөмгөлүүлэн, сандлын өнцөг тэврүүлэн суулгаж ханцуйгаа шамлаж байлаа. Ганьдмаа аптекаа өгөх зуураа эмнэлгийн хүнээс сонссоноо санан:

- Баатар гуай, суулгасанаас хэвтүүлбэл дээр биш үү гэхэд

- Зүгээр, суугаа нь дээр байдаг юм гэж баатар маань шийдэмгий өгүүлээд, өлгийдөх юм одоохон олж ир гэж тушаав. Ганьдмаа эргэн үсэрлээ.

Санаанд нь цонхны хөшиг өөрийн нь өрөөнд байнга байдаг хөнжил дэвсгэр, цагаан даавуу, дэр тэр бүхнийг хуулан хумиж авчрав. Ингэснээр сэтгэл амсхийж хүмүүсийг ажихад нийтдээ энэ төрөлт юу болох бол гэж сэтгэл догдлон хамрынхаа үзүүрийг ширтэхээс цаашгүй байхад гоёмсог авгай ханцуйгаараа амаа таглан нүд буруулан цонхруу ширтэж байгаа нь үнэргүй байгаа юмыг үнэрлэн ой нь гутаад ариун биенд минь бузар бохир үсрэх вий гэж байж ядаж байгаа нь илэрхий. Ганган хүүхэн өнөөх залуугаа тэврэн цээжий нь дэрлэн нүд анисныг харахад дэргэдээ юу болж буйг мэдэх сөгөөгүй байгаа нь илэрхий. Гэтэл хөнгөрөх гэж буй хүүхэн аль болохоор аяар дуугарахыг хичнээн шүд зуун ёолж байснаа тэсвэрлэшгүйд хүрэн дуу алдаж бүх тэнхээгээрээ ёолж гарлаа. Эцэст нь гэнэт хүүхдийн дуу. Эхээс гаруут агаарт цохигдон анхныхаа амьсгалыг авч байгаа нь тэр байж. Эх барих баатар ч спиртээр гараа цэвэрлэн амаа марлиар боож байснаа утаж хайч хоёрыг шүүрэн авч доош бөхийв. Тэгээд дэмий сонирхохын үүднээс өнгийснийг үзэн ядах байдлаар зандран хориглов. Харин Ганьдмаа боож авах гэж байгаа тул эх барихыг бүрэн чөлөөтэй харж байлаа. Гэхдээ сэтгэлд нь юмыг яаж мэдэх вэ. хэрэв онгоцонд ахин ийм явдал гарвал... гэсэн нэг бодол эргэлдээд эцэст нь болох л юм байна гэж сэтгэл ханан баярлалаа. Баатар малчин “гүйцлээ, бүх юм зүй ёсоор болсон” гэж дээш өндийсөн нь хэн бүхэнд бахархал. Ялангуяа энэ онгоцны экипажийханд. Бусдын өмнө “манай онгоцонд хүн төрсөн” гээд дараа нь энэ тухайд эхлээд хичнээн сандарсан... Гэтэл хүнд өвчтэй явсан Их хурлын депутат гэнэт босож эх барьсан энэ бүхнийг ярихад бас бодоход ч өөрцгүй ямагт баяр бахархал болж байхыг санан санан баярлах аж.

Ер нь энд хүн төрсөн тухайд баярлахгүй байгаа нь гоёмсог авгай, ханцуйгаараа амаа таглан аль түрүүн цонх руу ширтсэн чигээрээ суусаар байгаа нь баясахын оронд үзэн ядсаар байгаагийнх. Хоёрдахь нь ганган хүүхэн өдий болтол дэргэдээ юу болж байгааг олж анхаарах чадалгүй яваа нь түүнд харамсалтай ч байж мэднэ. Онгоц Улаанбаатарт ойртож алгуур доошилж эхлэв. Эргэн тойронд үүлгүй. Доор газар тов тод. Уул толгодын бараан өнгө түүний оройн барзгар сарзгар хад чулуу алган дээр байгаа мэт ялгаран харагдана. Үүнд хүмүүсийн сэтгэл тэнэгэр. Юм бүхэн амгалан тайван болсны хувьд хүнд өвчтөн баатрыг анхаарах цаг болсон аж. Түүнийг эв эрүүл хүний ёсоор сандал дээр суухад хүргэж яваа хоёр хүн “Хүүе та хэвтэж үз” гэж нэгэн зэрэг сугадан авлаа. Зүгээр би суузная гэж баатар хэлэв. Ганьдмаа дэргэд нь нялх хүүхдийг энхрийлэн тэвэрч байснаа:

- Нээрэн та хэвт. Одоо Улаанбаатар орсоор эмнэлэгт хэвтэх хүн гэвэл баатар нээрэн тийм дээ хэмээн босож биеэ чагнаснаа:

- Үгүй миний бие зүгээр хэмээн доош суух гэтэл нөгөө хоёр нь “Бид итгэхгүй байна” хэмээн эмнэлгийн дамнуургыг өмнө нь тавилаа.

- Би ч бас итгэхгүй л байна гээд баатар маань дамнуур дээр хэвтэж өвчтөн хүний маягаар хучуулав. Буух цаг болоход хүмүүсийн бие хөнгөрөн нүд сэргэсэн бөгөөд ганган хүүхэн ч дээш өндийн зууралдсан залуугаас биеэ салгаж авлаа. Дотор нь тун базаахгүй байгаа нь илт мэдэгдэм байвч үс зүсээ яаран янзалж, уруулынхаа будгийг сэлбэн сэргээхэд хүрэв. Онгоц зөөлнөөр газардан зогсоход түргэн тусламжийн хоёр машин яаралтай нь аргагүй ирж явлаа. Гэлээ ч онгоцон дахь хүмүүс тус тусынхаа гар тээшийг барин гарах гэж чихцэлдэх тул түргэн тусламжийнхан өвчтөнөө хүмүүс гарч гүйцсэний дараа авууштай болжээ. Хүмүүс гарахдаа Ганьдмаад баяртай “зам зуурт сайн явж ирснийг нөхөддөө мэдэгдэж баяр хүргээрэй” гэж гар сунган барьж байхад янтгар авгай “Баларсан хар юманд сууж чухам арай гэж ирэв байна” гэж амандаа үглэсэн бөгөөд үүнд нь Ганьдмаа дуугарсангүй.

Ер нь Ганьдмаа түүнийг хүний үнэргүй хар амиа бодогч гэж үзэж байсныхаа хувьд дуугарахгүй гаргах юм шүү гэж бодож байсан аж. Хүмүүсийн эцэст хүүхнийг чадах ядахаараа арчилж явсан залуу чемоданы нь барин би чамайг хүргэж өгнө шүү гэсэн байдлаар сэтгэл хангалуун зогсож байв. Гэтэл хүүхэн “Алив чи миний чемоданыг” хэмээн гараас нь шүүрэн аваад түрүүлэн гарав. Араас нь залуу үг дуугүй дагалаа. Хүүхнийг онгоцны хашаанаас гармагц такси машинаас өндөр залуу эр угтан авав. Хүүхэн түүнд чемоданаа өгөн биеэ тэврүүлээд машинд суухдаа өнөөх залууг эргэж харсан ч үгүй. Эцэст нь өнөөх залуу “одоо миний явах автобус хаана вэ?” гэсэн мэт ийш тийш харан эргэлдэв. Үүнийг ч Ганьдмаа мөн олж харсныхаа хувьд замын хань, зам зуураа хүнийг ашиглах ба хүнд ашиглагдах гэж ингэхийг хэлэх вий гэж бодох. Хүмүүсийн шувтарганд эх нялхсын эмч, сувилагчийн хамт онгоцонд орж ирлээ. Тэгээд тэд онгоцонд эсэн мэнд хүн төрснийг нүдээр үзэнгүүтээ хичнээн их сонирхон бахархсаныг энд өгүүлэх юун. Өгүүлүүштэй нь эмчээс “энэ хүүхдийг эх барьсан нь хэн бэ?” гэхэд баатар малчин “Би” гэж хучлагаа хуулан босож “Та нар сэтгэл зоволтгүй. Бүх юм зүй ёсоор болсон. Харин эх нь тун тамирдуу байгаа байх. Та нар очингуутаа шөл л өгч үз. Хонины өөхгүй, давс султай шөл байдаг юм шүү” гэж зааварлав.

Баатарын энэ үг бол монгол хүний үг. Монгол хүн монгол биендээ хэдэн мянган жилийн турш хэрэглэсээр ирсэн арга. Ер нь одоо үзвэл баатар малчин бие бадриун, царай хүдэр, гар хуруу нь лужир. Ийм хүн эх барьсан байх гэж үү гэмээр. Гэвч малчин хүний санаа сэтгэл хүн мал хоёрын төлөө. Иймээрээ ч малчин баатар Ардын Их Хурлын депутат, ахлагч Шаравжамц, туслах Даваажав, механик Батсүх, холбоочин Дэмбэрэл нар төрсөн хүүхэд, төрүүлсэн эх хоёрт баяр хүргэн үдэж гаргахаар ирлээ. Этгээд тус тус тусынхаа санаа сэтгэлийг хэрхэн илчилснийг энд дурдах юун. Дурдууштай нь үр төрүүлсэн эх гэнэт ам нээн “Эрхэм хүндэт ах нар, үеийн эмэгтэй Ганьдмаа та бүхэн надад санаанд багташгүй сайхан тусламж үзүүлсэн, би чин сэтгэлээсээ баярлаж байна. Ер нь би хүн хүнээ хүндэтгэн харилцан бие биеэ түшилцэхэд л хүн байдаг гэж боддог байсныхаа үнэн зөвийг та бүхнээс олж харлаа. Иймд миний энэ хүүхэд энэ онгоцонд ингэж төрснөө хэзээ мэдэх болсон цагаасаа эхлэн хүн, ёстой та нар шиг хүн болж явна гэдэгт би бат итгэж байна” гэж бэлэн зэлэн өгүүлсэн нь гайхалтай, юунд гэвэл энэ хүүхэн урд өмнө ёолохоос өөр ганц ч үг дуугаараагүйн хувьд хэн боловч үүнийг бүрхэг бүдүүлэг эрх чөлөө эдлэхийн оронд очиж зовиурлахад дарагдсан амьтан гэж үзэж үл тоомсорлууштай байсан бол дээрх үгийг хэлснээрээ тийм биш үе тэнгийхнийхээ дунд дур мэдэн ангалзах, ах зах хүмүүсийн дэргэд бие тоон бардамнах зэргээс гадуур байдаг жинхэнэ монгол эмэгтэйн төв дарууг баримтлагч болох нь илэрсэн бөгөөд үүнд нь ч хамаг гоо сайхан нь нуугдаж байжээ. Өөрөөр хэлбэл өнгө үзэмжийн гоо сайхнаас далдын гоо сайхан бол

мөнхийн гоо сайхан байдгийг энд онцлон тэмдэглэе. Эх нялхсын түргэн тусламж эх хүүхэд хоёрыг авч одмогч дараачийн түргэн тусламжийн хүмүүс залган авч орж ирлээ. Тэд үнэхээр хүнд өвчтөнийг авах гэж яваадаа маш яаруу. Эмч нь орж ирэнгүүтээ:”Өнөөх хүнд өвчтөн хаана вэ?” гэж ийш тийш харан эрэлхийлэв. Хариуд нь хэнэггүйхэн зогсож буй баатар малчныг “Би байна” гэж биеэ заахад эмч:

- Та юу гэж ихээр гайхан харлаа

- Тиймээ. Би уг нь анх аймгаас гарахад тун базаахгүй байсан. Гэтэл зам зуур яагаадыг мэдэхгүй гэнэт зүгээр болчихов гэж баатар гуай өөрөө гайхан хэлэв.

Эмч үл үнэмшин хм гэж толгой сэгсрэн баатрын царайг эгцлэн харж ажсанаа “За тийм байдаг байж” гэж нэг үе бодсоноо “Юу ч атугай одоо эмнэлэгт очиж үзүүлсэн нь дээр шүү дээ” гэв. Баатар гуай ч “Өө тэгэлгүй яахав” гэж уриалгахнаар хэлэв.

Ингээд хойшид чухам юу болсныг товчхон дурдахад Улаанбаатарын ..дугаар эмнэлгийн эмч нар баатар малчны биеийг сайтар судлан шинжлээд бөөрөнд бий болсон чулуу уг байрнаасаа хөдлөн бөөрний ажиллагааг гэнэт зогсоосноос ширүүн өвчлөөд дараа нь сууж явсан онгоц нь агаарын цөмрөлтөнд орсноос хүчтэй дугтрал гарахад өнөөх чулуу хуучин байрандаа ороход бие нь зүгээр болж гэсэн онош тогтоожээ.

ДАШДОРЖИЙН НАВААНСҮРЭН

Зохиолч Д.Наваансүрэн 1922 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Улаанбаатарт намын дээд сургууль, Москвад утга зохиолын дээд курс төгсжээ.

1950-иад оноос уран бүтээлээ эхэлж “Нөхдийн ач”, “Ууланд болсон явдал” “Анхны хундага” зэрэг өгүүллэг, туужсийн түүвэр “Минжсийн хангай” роман бичжээ.

ТҮМЭННАСТ ГУАЙ

Мотор нь халсан машин аагчин мацсаар хадаг яндар, өнгийн даавууны өөдөс намирсан модтой чулуун овооны дэргэд ирж зогсов. Наранбулагийн даваан дээр гарч байгаа нь энэ. Өртөө гаран өгсүүлдэг энэ давааны адаг уужим цэлгэр бөгөөд тэнд зах нь үл үзэгдэх тариан тэнгис долгиолно. Ам өгсөх тутам нарийсаж хяраа хүрэхэд машин зөрөх зайгүй болно. Давааны ар өвөр шигээ нүцгэн биш битүү ой модоор хучигджээ. Энд замын хажуугаас эхлэн хангай нутгийн мод бут, өвс ургамлын сорыг дээжлэн цуглуулсан мэт. Өндөр өтгөн, элбэг баян харагдана. Машин хөрөх чөлөөнд анх хөл тавьж байгаа энэ газар нутгийн гоо үзэсгэлэнт сонирхон нүд хужирлахаар буув. Мөнх ногоон нарс, гацуур, цагийн аясаар түмэн навчаа шаргалтуулан байгаа хус, улиас, үр жимс нь улайран навч мөчир нь хүрээ сор татан байгаа монос, нохойн хушуу, өрөл, долоолгоно, тэхийн шээг намрын тунгалаг өдрийн нарны хурц гэрэлд өнгө хослон атар нутгийн анхилам, цэнгэг агаар, өвс ногоо, жимсний үнэр гойд содон сэнгэнэнэ. Замаас гаран хэд алхтал анис жимс ширдэг шиг улайран арын шар төмсний хонх зайгүй үзэгдэнэ. Ой модоор хэрэг болгон бүтэн өдөр эрхэд ганц нэгээс илүү олддоггүй шар төмс энд ингэж зайгүй ургасан байх гэж.. Энэ бүхнийг сонирхон гар сарвайхад л бэлэн жимснээс нэг хоёрыг түүж амтлан явгал хажуухан талд өвөө гэсэн эмэгтэй хүүхдийн цангинасан дуу гарав.

Мод бутны чөлөөгөөр тэр зүг харвал арваад насны охин сөхөрч суугаад нэг юм оролдож байгаа өвгөн дээр гүйж очоод миний зүг заан юм хэлж байна. Бодвол хүн явж байна гэж байгаа бололтой. Өвгөн мөн зүг өлийн харснаа ажлаа хийв. Жимс ид боловсорч байгаа цаг болохоор жимс түүж яваа улс байна гэж бодон тэдэн дээр явж очив.

Шингэн цагаан сахалтай гав шавхийсэн өвгөн даавуун дээр дэлгэсэн буурцаг мэт атлаа зүрхэн хэлбэртэй жижиг хүрэн юмыг том жижгээр нь их л нямбай ялгаж сууна. Охин яг л тийм юм атга атгаар түүж ирээд ялгаагүй хэсэг дээр хийж байна. Амар мэндээ мэдэн хажууд нь суухад өвгөн хариу мэндэлсэн болоод юмаараа оролдоно. Тэр нэг л уцаар, бас зожиг юм шиг...

- За боль, боль гэж охиныг зандраад дэлгэж тавьсан юмаа хааш яайш боож ийш тийш нь шидэлж эхлэв. Өвгөн яагаад ингэж муухай аашилж байгааг хэрхэн мэдэх билээ. Охин ч учрыг эс олон гайхан зогсоно. Бид хоёрын яриа нэг л эвт орж хөгжиж өгөхгүй нэлээд болов. Тэрээр нүдний булангаар намайг ажин бушуу далд ороосой гэх мэт байхад нь би бүр тухлан сууж хамт яваа нөхдөө дуудан машинаас савтай айраг, замын хүнсээ авчруулав. Өвгөн байж ядаж байна.

- Эр хүн эрээгүй нь дээр, айраг уу, юм ид өвгөн гуай гээд айраг аягалж өгөхөд өвгөн дурамжхан авч амсаад тавив.

- Яасан сайхан үзэсгэлэнт нутаг вэ. Энэ шар төмсний ургасныг хачин юм. Би хангайн хүн гэхдээ шар төмс ингэж нэг газар бөөнөөрөө ургасныг огт үзээгүй юм байна. Бас энэ аньс, нохойн хушуу, мойлыг хараа. Наран цэцэг шиг энэ чинь ямар гээч ургамал вэ? Ер урд үзээгүй ургамал байна. Зун цэцэглэхийг нь харах юмсан, ямар өнгийн сайхан цэцэг гардаг бол. Ёстой гайхаж баршгүй, үзэж ханашгүй сонин сайхан газар байна даа. Даруй дархалж хамгаалууштай

газрын нэг байна гэхэд өвгөн энэ ер нь юу хэлэв гэх мэт нухацтай харснаа:

- Хэлдэг л үг гэж мушилзаад боож баглаж байсан юмаа хойш тавьснаар өвгөн бидний яриа хөгжиж эхлэв.

- Байгаль дэлхийг хар нүдний цөцгий шиг хайрлаж түүний төлөө үг сонсвол сэтгэл нь сэргэж магнай нь тэнийдэг хүн ажээ. Өвгөний дүнсгэр царай бүрхэг тэнгэр цэлмэх мэт болж далан үрчлээст нүүрэнд нь мишээлт тодрон яриа нь нэмэгдэв. Өвгөнийг Түмэннаст гэнэ. Түмэннаст гуайнх энэ нутгийн унаган айл ажээ. Эднийх зунд давааны тулах эхэн дэх Наранбулаг хэмээх тунгалаг булгийн дэнжид зусаж амны дунд хирд орших Хүүш хэмээх намхан уулын бэлд намаржин одоо тариан талбайн зах болсон Нөмрөг гэдэг жижиг толгойн өвөрт өвөлжсөөр өнөөг хүрчээ. Хүүш уулын бэлд чандмалсан гурван цагаан гэр байсан нь эднийхэн байжээ. Түмэннаст гуай өнөө өглөө нарнаар ач охиноо дагуулан явган гарч хагас өртөө газар аялан энд ирж ажилдаа дөнгөж орж байсан юм байна.

- Та энэ сайхан газар нутаг, түүний гоо үзэсгэлэн, намтар домгоос ярьж өгнө үү гэхэд өвгөн юунаас эхлэх билээ гэсэн мэт хэсэг дуугүй байснаа ийн өгүүлрүүн:

- Энэ газрын Наранбулаг гэдэг. Даваа, ар өвөр нь мөн тийм нэртэй. Урд бол хойш урагш давах морин замтай байсан юм. Одоо ард нь атрын сангийн аж ахуй байгуулж их замын газар болжээ. Онцгой намтар домог гээд байх юм байхгүй, өнтэй өгөөжтэй сайхан нутаг. Та нарт өөрийн мэдэх нэг л зүйлийг цухас ярьж өгье. Би тэр үед энэ охин шиг л байсан байх. Манай өвөө наян тавныхаа найр хийсэн намар л юмсан. Аавыг нэг удаа анд явахад өдөр шөнөгүй харуулдан чих тавьж байгаад ирэхэд нь хүүхэд шиг гүйж очиж мориноос буугаагүй байхад нь чи өнөөхийг олж ирэв үү гэж яаран асуув. Аав гайхсанаа бүснийхээ үзүүрийг тайлан үрэл шиг хэдэн хүрэн юм гаргаж энэ мөн үү гэхэд өвөө тэр юмыг алган дээрээ тавин ажин харснаа мөн мөн, гялайлаа хүү минь. Зуу наслаарай гээд хадагт боож авсан юм. Тэгээд маргааш өглөө нь унтаагаар Түмэннастаа босоорой. Өвөөтэйгөө юманд явна гэв. Хаана хүрч юу хийхий нь мэдсэнгүй дагаад л явлаа. Явсаар байгаад яг энэ ард ирлээ. Тэгснээ газар шинжиж яваа бололтой энд бол яах бол гэж үглэн явсаар тэр горхины цаад эрэгт арваад, дээхнэ талд наана нь арваад энэ дээд хонгорт хэд, давааны өврийн ширэнгэний захад бас хэдийг суулгаад буцлаа. Хавар цас ханзармагц нааш байн байн ирнэ. Нэг өдөр бид хоёр цуг ирж намар үр суулгасан газраа очвол судгийн баруун эргийнх соёолж байв. Өвөө, ургах нь ургаж байна. Хангай дэлхий минь гэж бөөн юм болов. Орой болтол өвөө маань түүнийг ажиглан явж өгөхгүй, арай гэж авч буцав.

Тэр зуны өврийнхөөс бусад газар тарьсан нь цөм ургасан. Нэг ирэхэд сайхан ягаан цэцэг гарсан байсан. Ингэж л манай энд цээнийн ягаан цэцэг анх ургасан юм даа. Өвөө бид хоёрыг үүр цүүрээр Наранбулагийн даваа өөд шогшиход айл саахалтынхан гайхаж зөнөг, тэнэг хоёр юу хийж гийгүүлэв гэж аав тоодоггүй байв. Ингээд анхны намраас өвөө надад цээнийн цэцгийн үрийг хэдийд авч яаж суулгадгийг зааж өгсөн. Дараа нь шар төмсний үр, ер нь ховор ургамлын үрийг түүж шинээр суулгаж ургуулах гэж намар нь хавар бид хоёр их л хөл болдогсон. Өвөөгөө дагаж явсаар байгаад байгаль дэлхийгээсээ холдож чадахаа байсан юм. Тэгээд өвөөгөө эсэн мэнд байхад, өөд болсноос нь хойш жил бүр намрын намарт зав гарсан хонуут өнжүүт энд ирж ховор өвс ургамлын үрийг түүж арилган, нэмэн суулгасаар нэг мэдэхэд Наранбулагийн ар маань цээнийн цэцэг, шар төмс, мойл энэ тэрээр элбэг газрын нэг

болсон юм даа гээд Түмэннаст гуай айраг залгилав.

- Үр нь унаад өөрөө аяндаа бас ургана биз дээ Түмэннаст гуай?

- Ургах нь ч ургана. Гэхдээ удаан, арваас нэг л болов уу даа. Бас тэгээд оготно хулгана, жирх, хэрэм, шаазгай гээд энэ үрийг хөрсөн дор орохоос урьтаж гоочилдог амьтад мундахгүй гэв.

- Цээнийн цэцэг чинь ховор ургамлын нэг гэдэг байхаа. Эмчилгээнд хэрэглэдэг гэлцдэг гэхэд өвгөн тосон авч:

- Юу ч л гэсэн байгалийн дээд зэргийн чимэг дээ. Газар бүр ургах нь ургадаггүй байхаа. Гэлээ гээд баян хангайг ямар нэгжиж үзсэн биш. Манай энд л гэхэд тэр харагдаж байгаа хөх уул, эндээс сунгуу гурван өртөө гаруй зайтай уул даа. Олон уул, даваа, гол гатлаж байж хүрдэг хир баргийн хүн очдоггүй аглаг уул. Тэр уулнаас өөр ууланд байхгүй. Тэр Хөшөөт уулнаас далаад жилийн тэртээ өвөөгийн минь захиасаар аавын авчирсан хэдэн үрнээс манай Наранбулагт ургасан юм.

- Эм танд ордог гэдэг нь гэдэг байх. Түүний нь ах нь сайн мэдэхгүй. Ер нь ний нуугүй хэлэхэд ярих баахан дургүй дээ. Дургүй ч юу байхав сүйд хийчинэ гэж айхдаа амаа тас жимийсэн л байдаг юм. Манайхан чинь нэг л юм дуулбал дуу дуугаа авалцан шууран дайрдаг улс болж шүү дээ. Тийм хүмүүс хэцүү. Авдаг цаг хугацаа, хэрэглэх ёс журмыг мэдэж нарийн учрыг олохоосоо өмнө үр үндэсгүй болж устаж үгүй болохыг юмын чинээнд бодохгүй. Ганц тун хэрэгтэй бол ачааны машинаар ч авч байхаас сийхгүй хүн бий. Тэд үржүүлж төлжүүлэх, хайрлаж гамнахыг даанч юман чинээнд санадаггүй юм. Юмыг яаж мэдэх вэ, хамар дор хагархай юм заяасных гэж бурж байтал нэг мэдэх маань энэ хэдийг минь баллачих бий гэж зүрх шимшрэхдээ амаа тас жимийж явдаг юм. Манай эндхийнхэн бол өөрөө хэн ч дураараа ирж авахгүй шүү. Хэрэг болсон нэг нь над дээр ирж учир явдлаа хэлж би өөрөө авдаг өдөр нь ёс журмаар нь авч өгдөг юм. Та нарт хэрэг болбол ахдаа хэл өгүүлээрэй. Сэтгэл зовохгүй цаг гэж нэг ч алга. Энэ даваа мань их хөлийн газар болжээ. Улс хөгжиж эх орны өнцөг булан бүрт олон сайхан үйлдвэр, аж ахуй бий болоход баярлахгүй хүн хаана байх вэ. Гэлээ ч сэтгэл зовоож уур хүргэх хүн гарах л юм. Энэ даваа ар өвөр аль аль талаасаа өртөө гаран өгсүүлдэг сүрхий өндөр болохоор машин заавал юм шиг халж орой дээр нь зогсоно. Тэгээд хэдэн хүн л сууж явна тэд цөм л хавар зун бол онцын хэрэггүй мөртөө цаанаа ховор живэр, үнэтэй цэнэтэйг эс анхааран дайралдсан цэцгийг багц багцаар таслан авч хаяна. Сайндаа гэр орондоо аваачиж усанд суулгаж үр жимс нь гарахгүй болж нэг мэдэхэд энэ газарт уг ургамал үгүй болно шүү дээ. Намар бол жимсний нь авч байгаа нь энэ дараа жилээ бодохгүй хамаа намаагүй мөчир гишүүг хугачина. Даанч хайран шүү. Та нарыг ирэхэд бас л тэгж сүйтгэдгийн өрөөсөн дугуй гэж уур хүрч байсан юм гээд өвгөн хангайн энэ ууланд жимс, цэцэг, мод бут тарьж төлжүүлэн байгаагаа бидэнд нэг нэгэнгүй зааж мод бут бүрийн дэргэд намтар түүхийг нь ярьж хагас өдөр болов. Хэсэг тэрэлжийн дэргэд зогсоод хавар намрын түрүүнд цэцэглэж энэ ойг чимж, агаар нь цэвэршүүлдэг бут даа. Энэ бут бас үгүй өөрийн түүхтэй эдээ. Тэрэлж гэдэг юм.

- Далийн цэцэгний ...?

- Тиймээ. Уг нь манай ард ургадаггүй байсан юм. Тээр жилдээ, тэрэлжийн амралт анх

нээгдэж байсан цаг юмсан. Би нэг намар тэнд хэд хоног амарсан юм. Тэгээд энэ бутын учир начирыг хүнээс дуулж баахан үр түүж ирээд суулгасан юм. Төлөөгүй ургасан хөөрхий. Хаврын хаварт таван сарын хорьдоос зургаан сарын эх хүртэл ид цэцэглэхэд ирж жаал суудаг юм. Манай нутгийнхан ч амралтаа хүртэл аваад л ирж суудаг болсон. Зарим сүржин нэг нь их даваадуулж өвчин бүрийг анагаадаг юм шиг ярьдаг юм байна билээ. Тэр нь ч юу юм бэ, ямар ч гэсэн зэгсэн амралт л болдог юм гээд цааш нарсан ой дундуур дагуулж явав. Энэ ой өндрөөсөө намсан намссаар тохой, сөөм болон шувтрав.

- Зориуд жил бүр үелэн тарьсан юм шиг ямар сонин ургасан нарс вэ? арай та бас тарьдаг юм биш биз дээ гэхэд Түмэннаст гуай баярлан инээмсэглэж магнайныхаа хөлсийг алгаараа шувтраад

- Тарьдаг юм. Хориод жилийн өмнөөс эхэлсэн юм. Анх тарьсан маань тэр одоо тав зургаа зарим нь арван метр ч дөхөж байна. Жилд нэг эгнээ болгон зуун үр суулгадаг юм. Ноднингийнх энэ гэж сөөм төдийн сөөсийж байгаа бяцхан нарсны дэргэд явган суугаад булбарай шилмүүсийг нь энхрийлэх мэт илэв.

- Энэ гацуурыг мөн тарьсан уу гэвэл:

- Гацуурыг тариагүй. Манай энд хаа очиж гацуур өөрөө сайн ургадаг юм. Хориод жилийн өмнө мөн жаахан монос тарьсан. Тэр байна гэж судаг даган ургасан моносыг заав. Ус, чийг, нар л байвал өөрөө төлөөгүй ургадаг юм. Харин вансэмбэрүүт л ургуулах гээд дийлэхгүй байна. Нутаг газар л зохидоггүй юм байх. Хүр орхоодойг ч санаа байлаа. Даанч ховор юм. Тэр Хөшөөтийн нуруунд уг нь байдаг л гэдэг юм. Залуу тэнхээтэй байхдаа хоёр намар сар тэнээд хайрханыг олоогүй юм. Энэний маань хийх ажил болох байх гээд ач охиныхоо хонгор үсийг илж инээмсэглэв.

Өвөөгийнхөө захиа даалгаврыг хойт үедээ үлдээхээр ач охиндоо зааж, зурж, хэлж үзүүлж яваа минь энэ ухаантай юм. Миний ач овоо, одоо мэдэхгүй ургамал, түүний үр жимс, хэдийд гүйцдэг, хэдийд яаж авч хаана яаж тарьдаг, ер нь юм юмны нь гадарлах болсон байна. Миний хүү бас ч үгүй ургамал нэг бүрийг нарийн бүртгэлтэй болгож байгаа хүн. Энэ бид хоёр ер нь хавар зун, намар ихэнх цагаа энд л бардаг юм. Хэн хэнд маань зэгсэн амралт ч болдог.

Түмэннаст гуай нь ная гараад гэлдэрч байна. Эмгэг өвчин гэх юм байхгүй. Энэ ой мод, цэцэг, жимс, агаар улирал л өвөөг нь ингэж наслуулж, жаргуулж байгаа юм даа. Энэ газар нутаг бидний ач үрс үеийн үед аж төрөх өлгий болохоор хайрлах ч юмны нэг дээ. Цэцэг навч, өвс ургамал, мод бутыг ганц гэлгүй хайрлаж хямгадаж, үржүүлж төлжүүлж байхыг хичээ хүүхэд минь. Эзэн хичээвэл заяа хичээнэ шүү. Эзэн хичээ гэдэг чинь хий, бүтээ, торд хямгад, сэтгэл зүрхээрээ хандаж, бие хайргүй зүтгэ л гэсэн үг шүү. Хүүхэд минь байгаль дэлхий ид сэргэн цэцэглэх зун цагт нэг ирээрэй. Сэтгэл сэргэнэ шүү гэж Түмэннаст гуай өгүүлэв.

Эх орны аглаг нэг хэсгийг зүрх сэтгэлээрээ хайрлан ариун цагаан хөдөлмөрөө тэнд шингээж үржүүлэн тордож цэцэглүүлэн байгаа буянт буурлаас салмааргүй, түүний дусал хөлсөө шингээсэн бут ургамал, мод бүрийг нь үзэж бахдаж сургамжит яриа, дууриалалт ажлаас нь нэгээхний ч гэсэн сурч мэдэж авахсан гэж бодогдон аяны замыг хөөхдөө Түмэннаст гуай түүнийг залгамжлан авч байгаа ач охин Байгалмаа хоёрт сайн сайхныг хүсэн дахин баяртай

уулзахын ерөөл дэвшүүлэв.

НАНЗАДЫН НАДМИД

Зохиолч Н. Надмид 1925 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Марксизм- ленинизмийн оройн дээд сургууль, МУИС-ийн дэргэдэх утга зохиолын оройн дээд сургууль тус тус төгссжээ.

1950-иад оноос уран бүтээлээ эхэлж “Залуу жуулчид”, “Дүү нартаа”, “Эцгийн нэрээр”, “Сүхбаатар”, “Учраагүй танил”, “Болзоо” зэрэг өгүүллэг, туужийн ном “Хүлээс алдарсан нь” роман бичжээ.

Зохиолчийн “Сүхбаатарын тухайн өгүүллэгүүд” ном ЗХУ-д орос, тажик, молдав хэлээр хэвлэгджээ.

ХӨВЧИЙН ЗОЧИН

Маам нэг гартаа хүү Идэрийгээ хөтөлж, нөгөө талдаа хоточ халтарыгаа дагуулж, хашир малчны заншлаар унтахын өмнө хотоо эргэж явав. Тэртээ зүүнээ дүнхийх, урагшаа хошуурсан барзгар уулын дээгүүр зуны дунд сарын арван тавны төгрөг сар цэлмэг тэнгэрт мэлтийнэ. Налайн хэвтээ олон хонины дэргэд том цагаан гэр бөмбийн цайрах нь цэнгэг нуурын захад ганц хун нугдайн суугаа мэт ажээ. Орчин тойрон жигтэй нам гүн агаад, ойрхон аргамжаатай морь хаяа тургиж, сахлаг ногоо шир шир зулгаах, хотны энд тэнд хоньд яраглах сонсдоно. Хэрэв мал маллаж, хээр хөдөө байж үзээгүй хүнсэн бол энэ зэлүүд газар аймаар эль хуль байлаа.

- За хоёул харьж унтъя даа гээд Маам, гэрийн зүг гэлдрэв. Нохой нь эх хүү хоёрыг дөхүүлж өгч буй мэт үүдээ хүртэл даган оччихоод буцаж гүйж хотын цаадах хэвтэр дээрээ очиж, оцойн суугаад чимээ анир чагнан ийш тийш харав.

Идэр ороо засаж хэвтэх үедээ:

- Аав одоо хэзээ ирэх вэ? гэв

- Иш миний хүү, аавыгаа санаад байна уу, эсгүүл эзгүйд нь айгаад байна уу?

- Би аавыг эзгүйд ч гэсэн айгаагүй л дээ

- Малчин хүн малынхаа дэргэд байхад хэзээ айж байлаа

- Тэгээд аав чухам хичнээн хоноод ирэх вэ?

- Болоогүй, яваад дөнгөж хоёр долоо хонож байхад. За тэгвэл аав чинь өчнөөн хоноод ирнэ гэж ээж нь босом унинд улаан даавуу уяд гэрийн униа бараг бүгдийг тоолоод нэг унинд цэнхэр даавуу уяв.

Энэ улаан даавууг өдөр бүр нэг унь ахиулан уяж байгаарай. Улаан даавуу цэнхэр даавуунд хүрсэн цагт л аав чинь ирэх болно гэв.

Шөнө дунд өнгөрсөн хойно олон морьтой хүн давхилдан ирэх чимээ сонсдон нохой нь угтан боорлох, хонь нирхийн үргэх, майлалдах чимээгээр Маам сэрж, дээлээ эгэлдрэглэн яаран гарав. Гэтэл морьтой улс ирсэн зүгтээ буцаад явчихав бололтой, төвөргөөн нь сонсдож, нохой нь тэднийг хөөж яваа бололтой тээр тэнд хуцаж байв. Маам үргэсэн хонио хураан хэвгүүлээд гэртээ оров. Идэр хүү саяын чимээ нүргээнийг огт мэдээгүй бололтой тайван нойрсож байлаа. Юун улс ирдэг билээ. Дуу шуу ч гаралгүй, нохойд хөөгдөөд явчихлаа гэж үү? Хачин юмаа гэж тэр бодов. Удалгүй нохой нь үүдэндээ гүйн ирж эзэндээ ямар нэгэн юм илтгэн хэлэх мэт хэд хуцчихаад хэвтэр рүүгээ очив бололтой. Өглөө нь эх хүү хоёр хонио бэлчээж зүүнтээх намхан гүвээн дээр гарав. Зэлүүд отрын бэлчээрт байгаа болохоор хүн малын бараа харагдана гэдэг нүдний гэм билээ. Гэтэл Гэээгт хайрханы баруун урьд бэл дэх нарийн горхины эхэнд адуу юмуу, үхэр юмуу хоёр бод малын бараа харагдав. Алсад харагдах тэрхүү хоёр амьтны барааг эх хүү хоёр таньж ядан харсаар суулаа. Тэр хоёрын дээгүүр хоёр хэрээ

гуагалан эргэлдэж байв. Хоёул саарал зүстэй агаад нэг нь хэвтэж, нөгөө нь зогсоод л байх аж. Босоо нь хөндөлдөн зогсохыг харвал адуу биш, буга болохыг тэд сая танив. Хоточ халтар хойд хоёр хөл дээрээ оцойн сууж тэр зүг харан “бич очиж үзээд ирье” гэсэн мэт хэд хуцчихаад тийшээ давхин явчихав.

- Ээжээ юун буга манай энд ирэх нь энэ вэ? гэж Идэр хэлэв.

- Өнгөрсөн өвөл хойд хөвч рүү цас их унасан учраас буганууд цас зуднаас дайжиж, тал руу уруудаж ирж байна гэж улс ярьж байсан. Их хөвчөөс тасдаж аваад тавьчихсан юм шиг талын дунд ганцаараа дүнхийх урагшаа хошуурсан, баруун урьд хажуугаараа асга хадтай ар дээрээ хүний гээг шиг төгөл модтой уулыг Гэээгт хайрхан гэдэг. Энэ хайрханд ч хэдэн буга ирсэн байна гэж дуулсан. Тэдний зарим нь энд ирсэн юм байх даа гэж Маам бодоод:

- Уруудаж ирсэн буга байх нь л дээ гэхэд Идэр:

- Хоёрхон юмаа гэж Идэр хэлэхэд нээрэн “Өнөө хэдэн буга чинь цөөрсөөр гуравхан үлджээ. Хаврын тачирт турж үхээд байна уу, эсвэл сүүлтэй сүүлгүй чононууд хороогоод байна уу” гэж хэдийн Мандах ярьж байсан. Хөөрхий өнөө үлдсэн гурвын хоёр нь байх нь ээ. Бас нэг нь яачихсан юм бол доо гэж Маам бодов.

Нохой нь дөхөж очиж, шинжин харж зогссоноо, урагшаа хэд алхаад, оцойн сууж, биеэ танилцуулж байгаа мэт алгуур дөхсөөр бүр ойртож очив. Босоо байсан согоо нь үргэж цааш хэд харайгаад эргэн харж зогсоход нөгөө нь хэвтээд хоцров. Халтар нохой хэвтээ бугад тулж очсонгүй, түүнийг хэд тойрч үнэрлээд “ээд минь ээ энд ийм хоёр зүс үзээгүй амьтан ирсэн байна. Хонь иддэггүй өвс иддэг амьтан байна” гэсэн мэт тайвнаар хуцаж байв.

- Ээжээ, хоёул тэр бугануудыг очиж үзье гэж Идэр шаардав.

Маам талын бүсэд төрж хангайд бэр болж ирсэн хүн тул, эх хүү хоёр буга гэдэг амьтныг тулж үзээгүй ажээ. Тэд хонио алгуур дөхүүлсээр хоёр бугад дөхөн очив. Хоньд нь чихээ дэлдийлгэн, хүзүүгээ өлийлгөн үнэрлэсээр хошууран ойртоход хэвтээ буга даргар эврээ дэрэлзүүлэн толгойгоо шилгээхэд хоньд нь хуйлран үргэж буцаж давхилдав. Маам, хүүгээ мориндоо сундлан бугад ойртон очив. Гэтэл морь нь хамраа дуугарган үргэж давхиад хавьтаж өгсөнгүй. Буга гэдэг чинь хүн рүү дайрдаг, өшиглөж чавчдаг, ялангуяа эмэгтэй хүнийг их тохуурхдаг юм гэнэ билээ гэж дуулсан. Маам тулж үзье гэж хичээсэнгүй. Үд болсон тул тэд хонио хэвтүүлж, өөрсдөө ундаа уухаар гэрийн зүг дөхөв.

Дараа шөнө нь хоточ халтар байн байн зүүн гүвээн дээр гарч хуцан чимээ өгч, буцан ирж хотоо сахиж, буга хонь хоёроо манах гэж их л зав муутай хонов бололтой. Хоёр буга тэр шөнө гэр лүү нэлээн дөхөж, зүүн гүвээний зүүхэн хажууд ирж хоножээ. Нөгөө буга нь мөн л хэвтсээр өнжихөд хэрээнүүд ээлжгүй манаач шиг хоёр талд нь сахин сууж өдрийг барав. Нөгөөдөр нь Маам өглөө босож харвал өнөө буга зүүн гүвээн дээр нь гарч ирээд яг гэрийн зүг ширтэн хэвтэж, даргар том эвэр нь ургаж байгаа нартай таширлан асар том алтан бөмбөрцгийг дороос нь тулсан хоёр тулгууртай олон салаа багана ч юм шиг, нарыг хоёр мутар дээрээ өргөн барьсан хүний ч гар шиг харагдав. Хэрээнүүд улам олхн болж, дээгүүр нь эргэлдэн бужигналдаж байв. Нохой нь түүний өмнө бараг хошуугаа нийлүүлэн хэвтээд сүүлээ

шарван эрхэлж байв. Маам ихэд гайхаж:

- Өнөө хоёр амьтан чинь бүр манай гадаа яваад ирж. Яах гэж манайх руу дөхөөд байгаа юм бол? Боохойг хэрээ дагадаг, бадарчинг балаг дагадаг гэдэг. Гэтэл манайхыг буга дагаад байдаг нь юу вэ? хоёр буга манайд дасах гэж байна уу, дайсагнах гэж байна уу гэхэд хүү нь

- Манай мал болох гэсэн юм бол уу, ээжээ очиж үзье гэв. Маам бол жирийн нэг шавилхан хархүүтэй ноцолдож гэхэд, түүнийг бөх шиг мэх хийгээд унагахгүй л бол өөрөө тэнгэр харж унахгүй биеэр мөчирхөг чацархаг, гар нь бяралхаг бүлэрхэг, биеийн тамирч баймаар боловч ёстой л малчин байгууштай хүүхэн билээ. Түүндээ эрэмшсэн ч юм уу, буга эмэгтэй хүнийг тохуурхдаг гэсэн домгоос эмээсэнгүй, юу ч гэсэн тулж үзье гэж боджээ. Бүдүүн ташуур барин хүүгээ дагуулан тийшээ явав. Өнөө буга тэдний ирж явааг хараад босож, өөдөөс нь эгцлэн ширтэж зогсов. Халтар нохой эзнээ харчихаад тосон ирээд өмнө нь хөрвөн эрхэлж, буцан давхиж бугын өмнө очин шарвагнан тоглож, хүн адгуус хоёрын хооронд жуулчилж байгаа мэт ааш үзүүлж байлаа. Тэднийг дөхөн очиход согоо нь айж сэрэмжилсэн янзтай эргэн эргэн харсаар цааш явахад буга нь хөдлөх ч үгүй ширээ шиг зогсон хоцров. Идэр хүү ээжийнхээ баруун гараас хөтлөн, айх гайхах бахдах шохоорхох хослон харж зогсоход зүүн гар талд нь халтар нохой нь оцойн сууж сүүлээ түргэн түргэн шарваж эзэн болон бугыг ээлжлэн харж хэлээ унжуулан аахилан сууна. Гэтэл нөгөө буга тэдний өөдөөс хэд алхаад зогсож, дөхөн дөхсөөр хэдэн алхамын зайтай ирж зогсоод эх хүү хоёроос аврал эрэх мэт саваа мэт урт нарийн хөлөө сөхрөн, гуалиг сайхан хүзүүгээ сунган хэвтээд өгөв. Түүний өндөр сайхан цээж өвчүү, омрууны тус газар ямар нэг ирт мэс буюу хурц шүдээр сэнжлэн сэт татжээ. Тэрхүү гарх нь сэдрэн өтөж цус шүүс шүүрч байлаа. Эх хүү хоёр түүнийг өрөвдөн үзэсгэлэн сайхан арван хоёр салаа эвэр, өнгөлөг буурал сортой урт сайхан хүзүү өргөн тэгш зоог илэхэд зовлонт тэр амьтан бишүүрхэж эмээх байтугай аврал эрэх мэт тэдний гарыг дагуулан харж байв.

- Энэ хөөрхий амьтныг ямар дайсан ингэж урчих нь энэ вэ? гэж Идэр хүүг өрөвдөж хайрласан дуугаар хэлэхэд ээж нь:

- Чоно урчихаж. Эртээр шөнө энэ хоёрыг олон чоно хашиж хөөсөн бололтой. Энэ буга ижил нөхрөө хамгаалж, чонотой тэмцэлдэн цавчилдаж байгаад ингэж шархдсан байна. За хоёул энэ хөөрхий амьтныг эмнэж эдгээе гэв. Эх хүү хоёр гэртээ ирж, мал эмнэлгийн хэрэгсэл саваа хувин устай аваад буцаж ирэв. Гэтэл өнөө буга тарайн хэвтэж, нохой нь түүний цээжний шархыг долоон цэвэрлэж цаадах нь тун таатай хүзүүгээ өлийн хэвтэж байв. Эх хүү хоёр бугын шархыг марганцын уусмалаар угааж, эм цацав. Буга шархандаа ихэд шаналж, халуурч байгаа бололтой бие нь чичирч хамар ам нь хатангиртан омголтжээ. Маам хувинтай усаа толгойд нь ойртуулахад буга усны үнэр авмагц толгойгоо өндийлгөн хувин руу шааж, ус залгилж эхлэв.

Тэгэхэд Маам санаа авч халууны ба өвчин намжаах эм усанд нь хийж орхив. Тэр буга хэд хоног хэвтэрээсээ боссонгүй. Согоо нь хот тойрон бэлчиж, шөнө нь ижлийнхээ дэргэд ирж хэвтэнэ. Эх хүү хоёр аль сайн амттай үнэртэй өвс түүж өгөх боловч буга бага багаар зажлан хаяна. Харин хужир шүүг бүхлээр нь үмхэн хэмлэнэ. Эх хүү хоёр өдөр бүр усалж, шархыг нь угаан цэвэрлэж эм түрхэх ба нохой нь хэзээний л цээжин дор нь оцойн сууж шархыг нь долоож харагдана. Түүний шарх нь хунигдан эдгэрч буга босож явах болов. Тэр хоёр гэрээс

холдон бэлчээрлээд үдэш нь гадаа ирж хонины захад хонох ба зарим халуун өдөр гэрийн сүүдэрт хэвтэн өнжинө. Буга нь эх хүү, нохой гуравт дасаж заримдаа гэрт орох гэж хаалгаар толгойгоо оруулчихаад даргар эвэр нь босгонд тээглэн гэрийн нь яйжигнуулан өндөлзүүлдэг байв. Согоо нь хүнээс айхаа больсон ч хүн гар хүрэхэд үргэн зайлна. Идэр түүнд бүр хайртай болж хошуу ам, цээж сэрвээг илж, маажихад буга дуртай янзтай ажиггүй зогсоно. Идэр нэг удаа.

- Ээжээ энэ бугын юугий нь оосорлон унадаг бол? гэхэд, ээж нь

- Мэдэхгүй хүү минь, цаатан гэж цаа буга унадаг хүмүүс байдаг юм. Ээж нь багадаа нэг кино үзэхдээ харсан. Гэхдээ юуг нь яаж оосорлосон байсныг би санахгүй байна гэв.

- Ээжээ энэ бугануудаа оргоод явчих болов уу, эсвэл алдчих бол уу гэж айх юм. Аавыг иртэл яаж тогтоож байх вэ? Ер нь энэ хоёрыг аргамжаад юм уу чөдөрлөж байя гэхэд, ээж нь

- Ой хөвчид дураараа өссөн амьтдыг хүлж баглаад яахав дээ хөөрхий. Нэгэнтээ бидэнтэй дассан болохоор холдохгүй биз гэв. Ээж хүү хоёр нэг өдөр хонио хариулж явтал, хоёр буга замдаа нэг ч удаа хушуугаа газар хүргэлгүй явсаар Гэээгт хайрхны арын мод руу ороод явчихыг харсан Идэр:

- Ээжээ, ээжээ өнөө хоёр буга чинь тэр мод руу ороод явчихлаа. Одоо буцаж ирэхгүй, яана. Би хэлээгүй юу? Аргамждаг л байсан юм.

- Миний хүү гэрээсээ олон хоног хол явбал гэрээ санана шүү дээ. Хөөрхий ойн амьтан ой модоо санаж л дээ. Буцаж ирэх байлгүй дээ гэв. Ээж хүү хоёр орой хонио хотлуулж ирэхэд буга согоо хоёр нь бараа ч үгүй байв. Тэр орой Идэр ихэд урамгүй, дуу шуу ч үгүй байв. Тэрээр зүүн гүвээн дээр гарч гэгээ тасартал харуулдсан боловч бараа харагдсангүй.

Идэр чимээ анир чагнан удтал унталгүй хэвтэв. Нохой нь ч чимээрхэж хуцсангүй. Идэр өглөө эрт сэрж гарч харвал хоёр буга нь хотны захад хэзээний гэрийн амьтан шиг тавтай хэвтэж байгааг хараад Идэр тэсгэлгүй баярлаж:

- Ээжээ, өнөө хоёр чинь нээрэн хүрээд ирж. Одоо энэ хоёр бүрмөсөн манай мал болжээ гэж хашгирсаар орж ирэв. Тэр өдөр хоёр буга бэлчээрт гарсангүй, гэрийн сүүдэрт ирж хэвтэв. Идэр «даргай» гэж нэрлэдэг бугаа эрхлүүлж, илж маажиж байснаа, түүнийг унаж үзэхсэн гэсэн хүсэлдээ хөтлөгдөн санаандгүй мордож орхив. Тэгтэл буга босон харайгаад тэр чигтээ аваад давхичихав. Буга ар тийшээ хумгар олон салаа эврээрээ Идрийн хоёр өвдгийг цээжин дээрээ хавсран дарж, ойчих байтугай хэлтийх ч аргагүй болжээ. Нохой нь эрхэлж тоглож байгаа нь юмуу, нэхэл дагал болж байгаа юмуу, хажуугаар нь хуцаж давхилаа. Буга гэрийн гаднаас босон харайх үед Идэр арай гэж “Ээжээ” гэж хашгирчээ. Түүний дууг сонсоод Маам гэрээс гарч, хүүгээ багын нуруун дээр шоохойтол суучихаад дэнж дээгүүр тоос манарган давж явахыг хараад,

- Идээр, гэж хэд хашгираад алдаж орхив. Маам хашин хээртээ мордож баруун солгойгүй гуядан давхисаар зүүн гүвээн дээр гартал буга согоо хоёр Гэээгт хайрханы хажуу өөд чавхдаж явав. Маамыг уулын бэлд ч хүрээгүй явтал буга согоо хоёр Гэээгт хайрханы хажуугийн хад

цохион дундуур дүүлэн харайлгасаар даваад явчихав. Халтар нохой нь ч тэднийг гүйцсэнгүй. Хол хаягдаад эзнээ тосон гүйж ирэв. Маам, хашин хээр, халтар нохой гурав Гээгт хайрханы эгц энгэр өөд өгсөж, тэднийг гүйцэх нэгэнт өнгөрчээ. Хүүгийнхээ тоос манарган давсан чиг рүү Маам нулимсаа дуслуулан харж зогсоод гүн бодол болов. Хүүгээ орхих уу, хонио орхих уу гэж бодсоноо гэрийн зүг буцах нь зөв мэт санагдав. Түүнийг эргэн явахад нохой нь хойноос нь даган шогшиж явснаа эргэн харж оцойн сууж байгаад эзэндээ ямар нэг юм хэлэх мэт хэд хуцчихаад Идэрийн явсан мөрийг шиншлэн уул өөд шогшин одов.

Маам, Мандах хоёр хэн хэн нь хэдэн жилийн өмнө сумын сургууль төгсөөд нэгдэлдээ ирж ажилласан залуу малчид билээ.

Тэд сүүлийн хэдэн жил нэгдлийнхээ сувай хонь хариулах болсон агаад хонио тарга тэвээр авахуулахын тулд отрын байдлаар хариулж заншжээ. Энэ жил ч мөн л тэр заншлаараа энэ зэлүүд хөндийд саяхан нүүж ирээд байгаа ажээ. Гэтэл ойрмог нэгдлийн захиргаанаас аймгийн төвд нэгдсэн суурийн ахлагч нарын түр сургуульд Мандахыг гурван сарын хугацаагаар явуулжээ.

Идэр хүү өдөр бүр унинд уясан улаан даавууг нь нэг унь ахиулан уясаар нэлээд уджээ. Нэг өдөр, Идэр улаан даавуугаа, цэнхэр даавуунд тулгаж уячихаад:

- Ээжээ, ээжээ аав маргааш ирэх болж гэж баяртай хашгирав. Маам унинд уясан даавуугаа хараад инээд алдаж,

- Хаа байсан юм. Дахиад бараг сар дутуу байхад чи алгасч ахиулаад байж үү дээ гээд улаан даавууг нь дахиад үлдсэн хоногийн тоогоор ухрааж уяж өгөв. Мань эр заримдаа мартчихаад нэг өдөр хоёр унь ч ахиулчидаг байсан юмуу хэн мэднэ. Ямар ч гэсэн аав нь ирээгүй л байлаа. Хоёр буга өдөр нь холын бэлчээрт гараад, шөнө нь хаяанд нь ирж хоносоор, тэр хэд улам л ижил дасал болсоор байв. Нэгдлийн захиргаа бригадаас нь Мандахын нутаг бэлчээр, малын эрүүл мэнд тарга тэвээршлийг үзэхээр хүмүүс зөндөө л ирнэ. Нэг удаа малын эмч ирээд:

- Чи хө эртээр бугаар хөлөглөөд давхиж байлаа гэж үү? гэхэд Идэр,

- Тэгсэн, их хурдан гээч. Нисэх онгоц шиг уулан дээгүүр хамаагүй давхих юм билээ гэв.

- Чи хө унах ч яахав. Аавыгаа иртэл сайн хариулж байгаарай. Битгий алдчихаарай гэв.

Тэр өдөр Маам, хамгийн ойр нутаглаж байгаа айлд хэл хүргээд гэртээ ирэхэд орой болж байв. Тэрхүү хэл өгсөн айлынхан цаашаа суурь бригадынханд хэл өгч хүмүүс цуглуулж, эрэлд мордохоор тохиролцсон аж. Маам хонио эрт хотлуулаад, хүүгээ ирж явна уу гэж Гээгт хайрханы зүг нэг харж, бригадын зүгээс хүмүүс ирж явна уу гэж харуулдан хүлээж, гэртээ орон гаран байлаа. Үдэш харуй бүрий болохын хирд нохой нь их л холоос давхисан бололтой хэлээ унжуулан аахилсаар гүйн ирж, эзнийхээ өвөр өөд цоройлсноо газар хөврөн эрхлэв. Маам нохойдоо цийдэм хийж өгөөд:

- Халтар. Идэр яасан, Идэр хаана байна гэсэнд нохой нь сүүлээ шарван гийнан гасалснаа

зүүн хойш харан хуцав. Тэгтэл удсангүй зүүн хойдох гүвээн дээгүүр өндөр нам хоёр хар юм бөртөлзөн гарч ирж яваа харагдав.

- Ээжээ гэх Идэрийн сэргэлэн дуу сонсдоход Маам тэссэнгүй тосон гүйв. Буга тайван алхан ирж явснаа Маамд ойртон ирмэгц “энэ томоогүй хүүхдээ ав, намайг энэ хүнд ачаанаас салгаад өгөөч” гэсэн мэт хэвтээд өгөв.

Миний хүү яаж томоогүйтэж байгаа нь энэ вэ? гэж Маам бугын эврийг өргөн өндийлгөж хүүгээ буулган авав. Тэднийг дөнгөж гэртээ ортол өмнөөс хэдэн морьтой хүн давхилдан ирэв. Тэд гэрийн үүдэнд ирж, мориноосоо буулгүй, мэнд ус ч асуулгүй,

- За юу болсон бэ? Хаашаа явах вэ? бушуулъя гэлцэв

- Би хүрээд ирсэн л дээ гэж Идэр гэрээс хашгирав. Тэд мориноосоо бууж гэрт орон настайхан нь:

- Томоогүй тархи, ажил удаж, ээжийгээ зовоогоод гэж зэмлэхэд зарим нь

- Сэргэлэн эр бугын нуруун дээр суух байтугай, Восток хөлөг дээр суудаг цагаа зөв гэж өөгшүүлж

- За тэгээд чи хаагуур давхиж давхиж ирэв? гэцгээв

Манай даргай саарал намайг унуулаад Гэээгт хайрханы дээгүүр нисэж нисэж ар руу нь буугаад модны хаяанд очоод хэвтээд өгсөн. Би буух гэсэн. Намайг гэрээ олохгүй төөрөх байх гэсэн юмуу, түрүүлээд явган харьчих байх гэсэн юмуу намайг эврээрээ дараад буулгасангүй. Тэгээд буга газар хэвтээд би түүний дээр суугаад л байлаа. Тэгтэл манай халтар намайг эргэж очсон. Халтар маань бид хоёрын тойрч нэг нэг үнэрлэхихээд бугатай хошуугаа нийлүүлэн хэвтээд л байсан. Орой болохын хирд халтар маань гэрийн зүг явснаа эргэж хараад дороо сууж “харьцгаая” гэсэн мэт хау хау гэж хуцсанаа биднийг явахгүй болохоор буцаж ирж тойрон хуцаад дахин нэгийн зүг гүйж, биднийг хүлээн эргэн харж зогсоод байсан. Тэгснээ даргай саарал маань гэнэт босоод нааш явсан. Ирэхдээ ч газар дээгүүр явж ирсээн. Ай мөн ч хурдан амьтан юмаа. Сансрын хөлөг л тэгж хурдалдаг байх аа гэв.

Нэг өдөр бригадын даргаас танайх удахгүй нүүж, намаржаа руу дөхөж бууна шүү, бэлтгэлтэй байгаарай гэж хэл иржээ. Энэ мэдээ Идэрийн сэтгэлийг ихэд түгшээсэн боловч, нүүх болтол аав ирнэ биз. Улаан цэнхэр хоёр даавуу нийлэхэд хоёр гуравхан унь үлдээд байна гэж бодон тайвширчээ. Одоо намар боллоо. Аав л бушуу ирээсэй. Буга ямар өвс иддэг бол? Аав бид хоёр бугандаа дуртай өвсийг нь тусгайлан хадаж бэлтгэнэ. Өвөлжөөнийхөө хашааны дэргэд тусгай пин барина. Хойтон хавар согоо нь хөөрхөн тугал гаргана. Сүүг нь сааж ууна. Хөөвөр зогдрыг нь авч хоршоонд тушаана. Мөн ч их ажил байна даа гэж Идэр бодно. Гэтэл нэг өглөө хоёр чиргүүл чирсэн белорусь трактор пажигнан ирэв. Суурийн ахлагч, жолооч хоёр ээжтэй нь хамжин гэрээ буулган яах ийхийн зуурдгүй ачаалав. Хоёр буга нь трактороос үргэн зүүн дэнж дээр гаран, эд яах гэж байгаа юм бол гэсэн мэт тэдний зүг харан зогсоно. Ээж нь ачаа хөсөгтэйгээ явж, Идэр халтар нохой хоёр хонио туух болжээ. Идэр хоёр бугаа хоньтойгоо цуг туух гэж хөөцөлдсөн боловч угаас тууж сураагүй амьтан болохоор явж өгсөнгүй. Идэр хонио

хариулгаар нь туух зуур эргэж харсаар явав. Хоёр буга нь замдаа эргэж ч харсангүй өвсөн толгой ч шүүрэлгүй шууд явсаар Гэээгт хайрханыг даваад явчихав.

Тэдний хойноос нүдээ чилтэл харуулдан явсан Идэр гүн санаа алдан манайх бүхэл нүүдлийн газар, бараг хагас өртөө газар нүүж бууна. Тэгэхээр эд манайхыг олж очихгүй. Яг аавыг ирэх болохоор хоёр бугаа орхичихдог мөн хайрнаа гэж харамсан явав.

Идэрийг очиход ээж нь шинэ нутаг дээр гэрээ барин төвхнөчихсөн байлаа. Идэрт цай унд уух ч хүсэл байсангүй.

- Хоёр буга маань манайхыг олж ирэхгүй. Одоо яанаа гэхэд ээж нь:

- Бидний мөрөөр хөөгөөд ирэх байлгүй дээ гэж хүүгээ тайвшруулахыг оролдов.

Идэр хотныхоо хойдох гүдгэр дээр гарч баруун амнаас тоос татуулан ирэх унаа, машин, зүүн хойдох урт хөндий уруудан ирэх хоёр бугаа харуулдан зогссоор харанхуй болгов. Шөнө нь аль нэг нь ирж магадгүй тэгвэл нохой маань заавал биднээс урьдаар мэдэж чимээрхэн хуцна гэж чагнан хэвтсэн болов ч нохой нь ганц ч ган гэсэнгүй. Ашгүй хөвчийн зочин өнөө хоёр нь толгойн архан шил дээр хэзээний гэрийн мал шиг тайван хэвтэж байв. Идэр баярлахдаа:

- Ээжээ, өнөө хоёр буга чинь олоод ирсэн байна гэж хашгирсаар гэрийн зүг гүйв. Гэртээ орж ирээд хүү нь

- Одоо аав л ирэх хэрэгтэй байна. Аав яагаад ирэхгүй байна. Та юу гэж бодож байна? гэв. Ирэх хугацаанаасаа дөрөв тавь хоног өнгөрөөд байгаад гайхаж байсан Маам:

- Харин л дээ. хөвч хэцэд төрж идээшсэн адгуус хүнд дасаж айл хүн бараадаж байхад, ханат гэрт төрсөн хүн, хань, ижил үр хүүхдээ мөрөөдөн ирэхгүй яах билээ гэж сэтгэлээ тайвшруулан

- Ирнээ ирнэ гэв.

Хүү дахиад л гадаа гарч тэртээ хөндийд ногоон торгон дээгүүрх шар утсан хаваас шиг өл халзан зам руу ширтэн зогсов. Гэвч тэр зүгт бүдүүхэн шувуу ч нисэж яваа үзэгдэхгүй байлаа.

САМБУУГИЙН НАДМИД

Зохиолч С.Надмид 1934 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Бага сургууль, 1958 онд Улсын их сургуулийн биологийн салбар, 1964 онд утга зохиолын оройн дээд сургууль төгсжээ.

Уран бүтээлийн ажлаа 1951 оноос эхэлж, “Сүүдэр хүү”, “Нарны охид”, “Бордоотой бороо”, “Улаан дээвэртэй байшин”, “Дааганы уралдаан”, “Тоодой цоохондой” зэрэг тууж, өгүүллэгийн ном хэвлүүлжээ.

ТҮМЭН ЦАГААН ХОНЬ

Говьд зуны урт өдрийн том улаан наран аажуухан жаргалаа. Энэ нутгийн харуй бүрий Хангай газрын үдшийн хар чийг шиг эцэс төгсгөлгүй хээр талын элгэн биенээ алгуур зөөлөн унахуй, умраас зурвас зурвас салхин үлээв. Салхи ид шидийн хүчээр ирж байна уу гэмээр бөгөөд сэтгэл сэргэм энэхүү сайхан салхийг хаа тэртээ орших хөглөгөр их хөвч тайга, умрын сүрлэг уулс зөвхөн аяны холд алжаан ядарсан нөхрөө сэвэн сэрүүцүүлье хэмээн урт нарийхан хоолойгоор зам тосуулан үлээж байх шиг таатайхан санагдана.

Бид салхин өөд ташаа тулан зогсож, бяцхан амсхийгээд цааш хөдөллөө. Өдөржин ус нь буцлаад халгай идсэн хөгшин ат шиг урагш ахихгүй байсан нэгдлийн ГАЗ-69 ч хүйтэн булаг уусан тайлаг таврах мэт дэрс сондуул дээгүүр дэгдэн дэгдэн давхих болов. Энэ сацуу Начиндагва даргын нозоорсон нойрмог нүд агшнаа сэргэж, “Нөгөөхөө цааш нь ярих уу даа” гэсэн харцаар над руу эргэн харлаа. Чингээд “тэгээч” гэхийн хооронд дарга хаалга руу нуруугаа харуулан хажуулдасхийн суудал засаад ийн өгүүлсэн нь:

- Тэр чавганц чинь ганц бие хүн байсан юм. Мөндөр шиг олон сайхан цагаан хоньтой. Хүмүүс Янжин гуайнх гэхээсээ “Олон хоньт ганц чавганцынх” гэгцгээдэгсэн.

Эрэгтэй хүн шиг өргөн мөртэй, өндөр янхир эмгэн байж билээ. Өргөн мөрөндөө тааруулсан гэмээр хэн хүнийхээс том арга үүрээд, аргал түүж хонио хариулна. Учиргүй бүдүүн иштэй, том савар барьдаг асан. Аргал голно гэж жигтэйхэн. Дандаа үхрийн хатсан хөх аргал түүж түлнэ.

Түүний аргаа үүрээд аргал түүж, энэ Хөшөөтийн талд хонио хариулж яваа нь одоо ч харагдах шиг болж байна. Янжин гуай мөн ч сайхан амттай ааруул тавьж, тос хольдогсон. Ер тэднийхээс илүү их тос авдаг айл тэр үед байгаагүй байх. Харамсалтай нь нутгийн хүмүүс, бидний хүүхэд шуухад өвөл хаврын тарчиг цагаар цагаан бүтээн юм амсах гэж л Янжин гуайнхаар ордог байснаас биш, хөөрхий зайлуул ганц бие юм, туслая гэж шагаадаггүй байжээ. Тэгээд ч тэр юмсан уу, айл амьтантай ойр байх дургүй. Хөшөөт уг нь говьтой, хээртэй сайхан нутаг. Хөшөөтийн худаг ундаргатай, тагнай ташим хүйтэн устай. Нутгийхан энэ л хавийг түүнд өмчлөөд өгчихсөн юм шиг ойртож ч буудаггүйсэн.

Эмгэний ганцаардмал зожигдуу байсныг манай нутгийнхан этгээд гэмээр яхир зантай нь холбоотой гэгцгээдэг байв. Одоо бодохноо этгээд яхир нь юу байх вэ, өөрийн гэсэн бодолтой, баахан хатуу хүтүү яриа хөөрөөтэй л хүн байж. Энэ зан чанар нь нийтээр нэгдэлжих үед улам тодорхой болсон гэдэг юм. Би ч бас зах зухаас нь мэднээ. Тэр үед би чинь энэ “Говийн нар” нэгдлийн хүний бага эмч нэртэй, айл амьтнаар орж хүн бүртэй уулзаж явдаг, хонхортоо л албаны сүрхий амьтан байв шүү дээ.

Сумын захиргааны даалгавраар, нэгдэлд элсэх, эсэх тухай саналыг нь авахаар Янжин гуайнд очсоноо санаж байна. Янжин гуай намайг морио тушаад гэрт орон ортол харж зогссоноо:

- Гомбын дунд хүү юу дээ гэж билээ. Хүүхдийг байтугай, өөрөөсөө дүү хүнийг нэрээр нь дууддаггүй, тэдний тэр, эдний энэ гэж ярьдаг хүн байсан.

- Тиймээ. Дунд хүү нь байна гэж хэлээд би амар мэндийг нь мэдэн ирсэн учраа шулуухан хэлэхээр шийдэн:

- Таныг нэгдэлд орох болов уу? Юу бодож байгааг тань мэдэхсэн л гэж явна даа гэв. Янжин гуай нэгдэлд элсэхийн ач тусыг ер надаас доргүй мэдэж байх шиг байлаа. Тэгээд ч тэр юмсан уу

- Элсэлгүй яахав хүү минь гэж уриалгахан хэлэв.

Би их баярлалаа. Хичнээн айлыг нэгдэлд элсүүлснээр сумын төлөөлөгч ажлаа дүгнүүлдэг байсан юм. Янжин гуайг хүмүүс “яхир янхир” гэцгээдэг.

Зүгээр л хүн шүү дээ гэж бодоход сэтгэл сайхан байв. Тэгтэл байна шүү, юу гээч болсон гэж бодно.

- Орсон дээр байлгүй яахав. Ганц бие өндөр настай хүнд аятай байх уу. энэ олон хонийг та ганцаараа яаж маллах билээ. Яаж унгас үс, сүү саалийг нь авах билээ. Нэгдэлд элссэн даруй чинь таны малыг өөр айлд өгнө. Зөвхөн өөрт үлдээхээ л авч хоцорно. Ёстой хөнгөрөөд явчихна даа гэсэн чинь эмгэний нүд гурвалжилж, туранхай шанааны нь арьс хэдэнтээ татваганах мэт болоод:

-Хүү минь чи юу хэлэв. Тэгвэл би тэр нэгдэл мэгдэлд чинь заяа нь элсэхгүй. Амьд мэнд сажилж яваа цагт буянт сүргээ хүний гар дээр өгөхгүй гэж шууд хэлдэг байна.

Дотор палхийгээд явчихлаа. Янжин гуай ярьсаар байв

-Энэ хэдэн хонийг чинь би нэг настай нялх үстэйгээсээ малласаар байгаа юм. Унгас ноос, сүү саалийг нь авсаар байгаа юм. Хүний царай харах болоогүй байна. Яахав, эмээгээ нүд анимагц бүгдийг нь туугаад яваарай. Нэгдэлд элсэхгүй... үгүй шүү хүү минь...

Би юу ч хэлж чадсангүй. Тэр оройгоо давхин ирж захиргаанд бүгдийг тайлагнав. Сүүлчийн үг л илүүдэх шиг боллоо. Түүнийг юунд хэлэв хэмээн бодсоноо хүртэл тоочлоо. Тэгтэл намын үүрийн дарга: “зүгээр ээ, зүгээр хүү минь. Зовох хэрэггүй” гэсэн шиг тайван хараад

- Зөв шүү дээ. Үнэнийг л ярих хэрэгтэй. Хэнийг боловч үгээр хуурч болохгүй. Яахав дээ. Янжин гуай явж л байг. Харж байя. Харин нэгдэлд элссэн элсээгүй түүнд тусална шүү гэж билээ.

Начиндагва ийнхүү яриад газрын баримжаа авч буй бололтой гадагш тонголзон харав. Орчин тойрныг түнэр харанхуй нөмөрчээ. Машин урт хос гэрлээрээ энэхүү түнэр харанхуйн дор нойрсох ихэр юм шиг намхан дов толгодыг тэмтчин, зүг чигээ олж хурдалсаар явна. Дугуй дор жижигхэн хайрга чулуу шажигнан үсчихээс өөр чимээгүй.

- Бид нэг хэсэгтээ Янжин гуайнд очсонгүй. Битүүхэн л харж байсан хэрэг. Эмгэн ч яахав, хонио хэнээс дутуугүй сайхан малласаар байв. Өвөл нь хатуухан, хавар нь ширүүхэн өнгөрсөн боловч тэднийх нэг ч эх, төл хороогоогүй юмсан. Мал ид төллөх үеэр би тэднийхээр очсон

- За Янжин гуай минь өвлийг яаж шүү өнгөрөөв дөө. Ядрав уу гэж суув. Тэгэхэд Янжин гуай

- Ядрахгүй яаж мал маллах билээ гэж хэгжүүхэн хариулаад “тавлаж байна уу хө” гэсэн янзтай, өөдөөс нүд дальдартал харсан нь санаанаас ер гардаггүй. Ээ, мөн сүрхий хөгшин шүү. Хавийн хүмүүсийн ярилцахыг сонсвол Янжин гуай тэр өвөл харсаар байтал гурван том гүзээ тосоо хониндоо хуваагаад өгчихжээ. Малчид:

- Бидэнд шагайн чинээг ч амсуулаагүй. Муухай амьтан гэцгээж байв. Янжин гуайн малд үнэн голоосоо хайртайг мэдсэн юм.

Нэгдлийн ерөнхий хороо, намын үүрийн даргын даалгавраар бидний хэсэг залуус Янжин гуайд туслах, хонины нь уртын ноосыг авч өгөхөөр очлоо. Залуучууд болсон хойно, яахав дээ ширүүн гараар үзээ биз. Тэгсэн чинь эмгэн:

- Хайран сайхан амьтдын маань бөөр зүрхийг унагачих дөхлөө. Яасан ч их үргээж цочоодог, яасан ч ширүүн унагадаг үхээрүүд вэ? зөөлөн барь, аятайхан холбо, хүзүү толгойг нь таслалчхлаа гэхчлэн хангинаж гарав.

Чингэтэл бүр хэрэг бишдэж, манайхны нэг нь нэг төлний нимгэн цавьны дээхэн талд эсгэчихжээ. Янжин гуай түүнийг үзүүт жигтэй муухайгаар зүхэв

- Алив хөө, өмдөө тайлж бай. Би чиний цавийг хайчлаад орхиё! хэмээн сайхь залууг бахим том гараараа барьж авлаа. Хичнээн их сандаргасан гэж санана. Бид гараа цэврүүттэл хонь хяргав. Ядарч, өлсөж байгаа ч гэж хачин. Нөгөө цавиа хайчлуулах дөхдөг залуугийн дургүй их хүрч байгаа бололтой хүзүү сэрвээгээ хөдөлгөн:

- Хөөе, Янжин гуай гэж дуудаад

- Та чинь ийм олон сайхан хоньтой байж, ганц охин төлөг ч гаргадаггүй хүн үү? ёстой өмд маань өөрөө шувтарлаа гэж хэлэв. Бас л буруудсанаас зайлсангүй. Эмгэн хөмсөг өргөн, нүд босгож:

- Юу гэнээ, амьтны амь хорооё гэв үү? Эмээ чинь өдий болтол халуун зунаар сэвс гаргаж үзсэнгүй. Чи чинь ингэхэд хэний хүүхэд гээчив. Манай энэ хонхорт ийм жудаггүй муухай амтай, талхгүй хүүхэд баймааргүйсэн билээ гэхчлэн үнэн голоос хилэгнэн уурсав. Тэгээд Янжин гуай том саахуу дүүрэн тараг, түүхий сүүний бяслаг, хатаасан даргар шар өрөм, базмал ааруул тэргүүтнийг авчирч өгөх зуураа:

- Халуун зун улаан мах хэрэггүй, хүүхдүүд минь. Өвөл, зунгүй мах идвэл хэрхэх вэ? Ёстой амьдаараа өмхийрч, тээрч үхэх байгаа даа. Тэгээд ч эмээ чинь энэ сайхан амьтдыг өсгөж өдий хүргэснээс биш, хорооё гэж яваагүй юм шүү гэснээ биднийг басхүү эх хүний өрөвч сэтгэлээр энхрийлэх мэт хараад

- Тараг, ааруул ид. Үүн шиг сайхан хоол хаана байна хэмээн буцааж гаргатал шахаж билээ.

Хоёр жил өнгөрлөө. Хавийнхан бүгд нэгдэлд элсэхэд Янжин гуай л ганцаараа хоцров.

Малчид дургүй байлаа. Бид ч гэсэн “яхир янхир хөгшин сум орны нэрийг гутаах нь. Малчид зуун хувь нэгдэлд элслээ гэсэн мэдээ үүнээс л болоод сонинд гарахгүй байна. Яая даа, энэ зөнөг төгцөг чавганцыг” хэмээн бухимдах болов. Зарим нь бүр илэрхийгээр:

- Хувийн өмчийн шалбаагт шигдсэн энэ муу чавганцаар нэгдэл дутахгүй. Ганц араг аргалын нэмэргүй ийм амьтад нүд аниж хөгжлийн маань замыг цэвэрлэж байвал таарна. Янжингаас улсад хонь нь хэрэгтэй. Тэр сайхан цагаан хонь хэзээ нийгэм олныхоо их сүрэгт нийлэх бол хэмээн ярилцдаг боллоо.

Чингэтэл энэ мэт ойворгон яриа намын байгууллагын сонорт хүрсэн бололтой. Намар оройхон намын үүрийн дарга баахан хариуцлагатныг цуглуулаад:

- За, та нар Янжин эмгэнийд оч. Цаадах чинь хөлдөж үхэх дөхөж байгаа. Нэгдлээс хоёр хонины мах, нэг бор эсгий, хэдэн сав ёотон, шуудай гурил, бас нэг ногоон цай аваачиж өг. Гэрийг нь Хөшөөтийн баруун өвөлжөөнд буулгаад бор эсгийгээрээ дулаалаарай гэж хэлэв. Энэ үгийг сонсоод нягтлан бодогч хүүхэн, ихэд дургүйлхсэн янзтай:

- Тэр чинь нэгдлийн гишүүн биш шүү дээ, юу боллоо гэж Янжин чавганцыг нэгдэл тэтгэж, тэжээх билээ гэв. Дарга муухан инээвхийлэх шиг болсноо:

- Та бид чинь Янжин гуайн хонины бүх ноосыг мултаж аваа биз дээ. Нягтлан та харин түүний хөлсийг одоо болтол юунд бодож, өгөөгүй байна вэ? нэгдэл бол луйврын газар биш шүү хөө гэж сүртэй хэлэв. Үзтэл даргын зөв байсан боловч бид баахан маргаж билээ. Маргах ч юу байх вэ саналаа хэлцгээв.

- Ерөөсөө Янжин гуайг нэгдлийн гишүүнээр бүртгээд авчихъя. Түүний саналтай, саналгүй ямар пад байна. Тэртэй тэргүй нэгдэл хонины нь үс ноосыг нь авч, хөлс хүчийг нь өгч байна шүү дээ гэж шуугилдсанд дарга тайвнаар:

- Үгүй ээ, болохгүй. Хэдий өндөр настай ч цаадах чинь хүн шүү дээ. Янжин гуайд буруу байхгүй. Үнэндээ цаадах чинь хувийн өмчийн үзэлд автаж, хоцрогдсондоо ч биш, малдаа чинхүү хайртай монгол хүний зангаар хониноосоо салж зүрхлэхгүй байгаа юм. Хонь бүхэн нь түүнд хар нялхаас нь өгсөж өндийлгөсөн үр хүүхэд шиг санагдаж байгаа. Хүүхдээ хэн хүнд өргүүлчихдэг хүн ховор биз дээ. Та бүхэн Янжин хөгшинд элдэв муу юм ярьж огт болохгүй. Сонсвол “хоцрогдсон чавганц” гэдэг бололтой. Түүнийг нэгдэлд элсээгүйгээр манай улсын хөгжил хойш болохгүй. Харин та нарын балай яриа хожим засч болохгүй муу юм болж мэднэ шүү гэж хатуухан сануулав. Манай намын үүрийн дарга Насанжаргал гуай мөн ч уужим дэлгэр ухаантай хүн байсан юм даа. Надаас өөдтэйхэн хүн бол их юм сурах байсан байх...

Машин хурдалсаар байлаа. Нэг харахнаа говийн хилэн хар тэнгэрт тоо тоймгүй олон түмэн од түгж, сулавтар цагаан туяагаараа мөнөөхөн хав хар тэнгэрийг ягуухан сүлэн байх ажээ.

Тэгээд цааш нь.. хэмээн яриандаа халсан анчин шиг намайг өндөлзөхөд дарга:

Янжин гуайн нэгдэлд орсон, ороогүй хамаа алга, хонь нь нийгмийн өмч гэдгийг бид мэдэж, тал талаас нь харуулдаж байсан юм. Гол нь чоно нохойд идүүлчих вий гэж их айж байсан.

Хөөрхий хөгшин насны эрхээр хүч тэнхээ муудсан байв.

Тэр зун айхавтар бороосог, үе үе ширүүн аадар асгадаг байж. Нэг удаагийн хүйтэн бороонд Янжин гуайн хонь уруудаж, бараг тал нь тасарч нэлээн хол айлын хонинд нийлжээ. Эмгэн хагас өртөө шахам газар дагаж, үлдсэнийг нь гэртээ тууж авчирчээ. За, яг энэ явдлаас бид нэг муухай хэрэг хийсэн юм даа. Үгүй, муухай ч гэж болохгүй юмаа. Бид айлын сүрэгт нийлсэн нөгөө хонийг Янжин гуайгаас нуухаар шийдэв.

Тэнгэр хайрхан Янжин чавганцын хониноос хоёр зуун далан тавыг нэгдлийн сүрэгт нийлүүлжээ. Дахиад хахир хатуу эмгэний гарт түүнийг хийхээ больё. Энэ чинь тэртээ, тэргүй нийгмийн өмч байгаа юм гэж ярилцаад өөрт нь болохоор...

- Хонийг чинь бид эрж байгаа, тэр хаа холдох вэ? Хавьд чоно нохой идсэн юм дуулдахгүй байна. Нэг л мэдэхэд манайхан туугаад ирнэ дээ хэмээн ам нэгдэн ярьж байлаа. Эмгэн “нээрээ хэлж байгаа биз хөө” гэсэн байртай хүнд зовхио өргөн, их л сэжигтэй харна.

Сураг сонсвол нутгийн мэрэгч өвгөдөөр зоос гүйлгэн, дал тавиулж байсан билээ. Мэрэгч өвгөд гэдэг маань манайхан болохоор яалаа гэж үг алдах вэ?

Хонь чинь эндээс хол, буянтай хүний хотонд байна. Ганцын ч гарз алга. Эрэлчид төөрөөд байгаа юм байна гэхчлэн залдаг байжээ. Эмгэний санаа сая амарч

- За тэгвэл яамай. Үхэж хорогдоогүй бол болох нь тэр. Төрийн минь сүлд өршөө гээд мөндөр шиг цагаан хоньдоо толгой дараалан зүслэн харж байх янзтай элгээ дарж эвийлж, санаа алддаг байжээ.

Чухам хонио алдаж, сэтгэл тавгүйдсэнээс болсон юмуу. Янжин гуайн бие гэнэт муудлаа. Эмчийн хуваарь би байн байн очно. Онцын өвчингүй атал бие нь улам доройтсоор байв. Гэхдээ “би яана” гэж ер хэлэхгүй, ийм тийм борлон шүдлэн бий. Тэр маань ямар байна. Хүү минь сайн хараад ирээч гэж гуйна. Тэгснээ “нөгөө хэдэн мөндөр минь хаана байгаа бол?” гэж үглэснээ

Хөөрхийг төрийн минь сүлд өршөөг гэж залбирна. Төр засагтаа хайртай, түвшин сайхан, малч эмээ байсан юм шүү гээд дарга хөнгөн бүрх малгайгаа авч өргөн магнайгаа илбээд:

Ээ дээ, ухаангүй явдал утгагүй үг бүхэн балай байдаг. Намынхаа даргыг хэлж сануулаагүй бол бид “хувийн өмчийн мунхаг үзэлтэн, хоцрогдсон зөнөг чавганц” гэсэн хатуу хүтүү үгийг түүний чихэнд дуулгаж, гомдоох байсан биз гэж бодохоос одоо айдаг юм. Хэрэв тийм үг хэлчихсэн бол хөөрхий хөгшинтэй хамт энэ үг одоо ч Хөшөөтийн хонхорт хэвтэж байх учиртай. Үг үхдэггүй юм. Янжин гуайг нэгдэл Хөшөөтөд оршуулсан юм байхгүй юу дээ...

Начиндагва ийнхүү өгүүлээд санаа алдаж байна уу гэлтэй болж, оворлог биеэ эгцлэн суув. Би машины цонхоор огторгуйн хаяаны олон одыг харлаа. Одод Янжин хэмээх буянтай буурал эмгэний улс нийгэмдээ үлдээсэн олон цагаан хонь талаар дэлхэн бэлчиж яваа мэт санагдана. Энэ сацуу Янжинтай төсөөтэй өөр нэг эмгэний тухай Өмнөговьд явж байхдаа сонин баримт олсныг нэгдлийн даргад яримаар санагдаж билээ.

Замд, тэр тусмаа шөнийн замд ярьж явах үнэхээр сайхан. Би ямар азаар үнэн зүрхний яриа хөөрөөтэй ийм хүнтэй нүүр учрав? Начиндагва гэгч энэ хүн том нэгдлийн дарга. Мэдээж энэ хүнд эх захгүй их ажил байгаа боловч сурвалжлагчийн зовлон, сурвалжуулахын хариуцлагыг мэддэг ухаантай хүний зангаар намайг өөрөө дагуулан, малчдын бригад, сууриар өдөржин давхиж эцэст төв орохоор буцаж яваа нь энэ билээ. Өөрийнхөө тухай хэр зэрэг сонирхолтой хуучилдаг бол? Хүний бага эмч байгаад намын дээд сургуульд сурч төгсгөн төрөлх нутагтаа ирж нэгдлийн дарга болсон энэ товчхон намтрын цаана их юм бий дээ. Юутай ч малчин түмэндээ машинд хайртай хүн юм гэхчлэн бодоод аль болохоор яриа өдөөхийг хичээн:

- Би бас нэг сонин эмгэний тухай мэднэ гэвэл дарга “Уухайс, үгний ээлж байдагсан даа” гэсэн шиг биеэ огцом эргүүлэн хажуулдасхийв.

- Тэр эмгэн тэмээчин болохоос биш, Янжин гуайтай маш адилхан гэмээр юм. Олон сайхан хүрэн тэмээтэй хүн байж. Хүмүүсийн ам түүнд бас л сайнгүй. Тагш шиг жижигхэн бор гэртэй. Гэртээ ганц хар авдартай. Задгай гал түлдэг болохоор хамаг юм нь хөө тортог. Өөрөөр ч гэсэн хүрэн хар царайтай, агийсан бор эмгэн байж л дээ. Хүмүүс:

Хувьт чавганцын юм бүхэн хар. Гэр шигээ дотор сэтгэл нь хүртэл хар. Хэнтэй, юу ч хэлэлцэхгүй, муу санаатай гэгцгээдэг байжээ. Тэр ч байтугай аав, ээж нь үр хүүхэддээ:

- Хувьтынхаас хол яваарай. Хар гэрээс нь амьтны морь үргэж, эзнээ үнсэн дээр нь бухаж хаяад хулчин одсон юм гэнэ лээ шүү гэж захидаг байв гэнээ хэмээсэнд дарга

- Би бас дуулсан юм байна. Мөн л нэгдэлжих хөдөлгөөний үеэр гээ биз дээ гэв.

-Тийм ээ, Янжин гуай шиг ганцаараа нэгдэлд элсэлгүй үлдсэн хүн юм байж. Гэвч нэгдэл түүнд баярламаар сайхан тусалсан гэдэг юм. Бөөн бөөнөөрөө очиж, бүх тэмээний нь ноосыг авна. Эмнэг догшин тором, тайлгийг эдэлгээнд сургана. Зөвхөн Хувьт гуайн тэмээний буйлийг зорж, бурантгийг томох бригад гаргаж байсан юм гэдэг. Тэр эмгэний тэмээндээ хайртай байсан баримт бий. Хангай нутгийн нэг жолооч тарган тэмээний махтай буцах гэж тэднийхээр зориуд очжээ.

- Нэгдэлд элсээгүй хувьдаа олон тэмээтэй ганц айл. Хувьд чавганцынд л оч гэж хэн нэг нь хэлсэн юм байх. Жолооч эмгэнээс нэг байтугай хэдэн ат салгана гэж бодож байснаас зайлахгүй. Гэтэл халгаасангүй.

- Таны гутал муу байна. Сайхан эсгий гутал хэдийг л бол өгье. Тохош хийхээр хивс өгье. Үгүй бол монгол гутал өгье. Муу хар гэрийг чинь бүрэх эсгий өгье гээд ч бүтсэнгүй.

- Юуны чинь алах идэх. Тийм нүгэлтэй юм бүү хэл гээд халгаагагүй байжээ.

Хувьд гуайн нэгдэлд элссэн гол шалтгаан нь бол дээрх мэт идэш эрсэн жолооч нараас болсон юм гэдэг. Нүд анихдаа хөгшин:

- Миний тэмээгээр жин тээгээрэй. Харин хангайн жолооч нарт л өгч болохгүй шүү гэсэн юм гэнэ лээ. Хөөрхий эмгэнийг өөд болсноос хойш нэгдлийнхэн “Хөө шиг хар хүн биш, харин ч

цав цагаан дотортой хүн байжээ” гэж ярилцдаг болсон байна. Янжин гуай яг ийм хүн байжээ гэсэнд дарга

Тэр цагаас хойш хорин жил өнгөрчээ гээд нэг чухал юм санав бололтой

- Маргааш таныг Янжингийн сууриар оруулна гэв. Тэгснээ:

Янжингийнх гэнэ шүү. Уучлаарай. Улсын хошой аварга малчин Доржийн сууриар оруулна. Манайхан тэдний шилмэл хонины суурийг Янжин эмгэний суурь гэгцгээдэг юм. Тэр ч байтугай Хөшөөтийн хуучин худгийг Янжингийн худаг гэх болжээ гэв.

Тэгэхээр тэр Доржийн шилмэл суурь гэдэг чинь угтаа Янжин эмгэний хониноос үүсэлтэй байх нь уу?

- Тэгэлгүй яахав. Бид эмгэнийг өөд болсон даруй бүх хонийг нь Дорж гэгч сайн малчинд тушаасан юм. Ажаад байхад арай л өөр хонь байж билээ. Хүйтэнд гайхалтай тэсвэртэй, мах, ноос, сүү элбэг. Сураглаад байвал Янжин гуайн талийгаач нөхөр бүр дээр үед аймаг алгасан явж өөр омгийн хурган хуц олж ирсэн байлаа. Сайн хоньтой болох гэж л тэр. Одоо бодоход амьтнаас зожиг байсны учир нь хонио элдэв юмтай эвцэлдүүлэхгүй гэж бодсоных байсан юм билүү дээ. Хожим бид төвөөс мэргэжлийн хүмүүс урьж, шинжилгээ хийлгээд үзсэн чинь “Ардын авьяасаар шалгарал олсон шинэ омгийн сүрэг байна. Энэ хонийг тусад нь өсгөх хэрэгтэй” гэсэн юм. Эдүгээ нэгдлийн хонин сүргээс авдаг бүх ашгийн хорь илүү хувийг энэ хониноос олж байгааг бод л доо. Янжин гуайн цагаан хонь одоо нэг түмд хүрээд байна. Хөгшнийг бие бармагц хонийг нь айл, айлд тараагаад өгчихсөн бол эдүгээ энэ хонь утсан байх асан биз...

Машин ялимгүй өгсөх шиг болсноо огцом тонгойход тэнгэрийн заадал мэт сунасан нэгдлийн төвийн гэрэл өмнөөс гялалзан угтлаа.

Тийнхүү бидний энэ үдшийн яриа арга буюу засварласан бөгөөд маргааш өглөө нь Начиндагва дарга намайг түмэн цагаан хонины суурь руу авч явсан юм. Замдаа миний хичээн гуйснаар Хөшөөтийн энгэрээр дайрав. Бөртний ч үүлгүй цэлмэг цэнхэр энэ өдрийн тэнгэр шиг налгар сайхан энгэрийг Хөшөөт гэдэг ажээ. Дарга замчилсаар нэгэн хөшөө чулуун дээр ирэв. Түрэгийн үеийн булш бололтой. Аян дайны замд нөхөцсөн баатар эр буюу, хэн нэгэн хэргэмтэн язгууртны шарил түүн дор байгаа нь лавтай. Гэвч хөшөө чулуунаа үлдсэн бичиг сэлт үгүй, байсан нь ил боловч, он цагийн урсгалд оргүй арилжээ. Дарга хөшөө чулууг харж бодлогошрон зогссоноо:

- Үүгээр явах бүрт энэ том оцон шувуу аргаа үүрээд аргалаа түүгээд явж байгаа Янжин эмгэн шиг харагддаг юм.. Янжин гуай энээхэн хавьд зогсоод савраа өргөн тээр энгэрт гарсан сонинхоо хойноос эршүүд сайхан хоолойгоор “Чаа ийг” хэмээн уянгалуулан хашгирдагсан. Тэгэхэд хоньд нь хушууран нааш эргэнэ. Хачин шүү, тэр цагаас хойш хорин жил өнгөрсөн гэхэд бүх юм ил тод байдаг гэж хэлээд “За хөдлөх үү дээ” гэсэн харцаар над руу харлаа.

Доржийн суурь эндээс холгүй ажээ.

ШАГДАРЖАВЫН НАЦАГДОРЖ

Зохиолч Ш.Нацагдорж 1918 онд тэр үеийн Амгаланбаатар хотноо төржээ. Бага, дунд сургууль, Улсын их сургууль төгсөж ЗХУ-д эрдмийн зэрэг хамгаалжээ.

1940-өөд оноос уран бүтээлээ эхэлж “Сорилт”, “Сувд эрдэнэ хоёр”, “Сугаавадийн орон”, “Мандхай цэцэн хатан” зэрэг өгүүллэг, туужийн ном, “Залуу үе”, “Ичээнд нь” жүжиг, киноны зохиол бичжээ.

Ш.Нацагдорж БНМАУ-ын төрийн шагналтан, академич хүн юм.

ҮҮЛЭН ЧӨЛӨӨНИЙ НАР

Эмч намайг босож өрөөн дотор явахыг зөвшөөрсөн тэр өдөр би хаврын нарны бүлээн элч ээсэн өмнө талын цонхонд ойртон очиж, эмнэлгийн хашааны доторхийг харвал илаарь болж байсан өвчтөн гадна наранд ээж, хүүрнэн сууцгааж байна. Цагаан нөмрөг өмссөн нэг өндөр залуу хүн том баадантай юм ачааны тэргэн дээр ачиж байхыг хараад, өөрийн эрхгүй юу билээ? гэсэн шиг бодогдов. Арай биш байдаг байгаа. Тэр хэрэв энд байвал нар баруун хойноос гарна гэдэг болох бий гэж нүдээ арчин дахин нарийвчлан харвал яахын аргагүй мөн. Би сонин юм байна даа гэж гайхан бодов. Тэгээд маргааш өглөө нь мөн л цонхон дээр очиж сонирхон бодов. Тэгээд маргааш өглөө нь мөн л цонхон дээр очиж сонирхон харж байтал өнөөх маань бас л цагаан нөмрөгтэйгөө эмнэлгийн хашаан дотор ажил хийж явна. Бидэнд эм өгөхөөр орж ирсэн сувилагч Цэцэгмаагаас «Хүү минь хурдан нааш ирж цонхоор хараарай» гэв. Цэцэгмаа гайхан юу болов? гэсээр цонхон дээр гүйн ирэхэд би хуруугаар зааж «Хүү минь чи тэр цагаан нөмрөгтэй өндөр залууг харж байна уу? энд ажил хийдэг юмуу? гэж асуухад Цэцэгмаа: Гонжоо юу? Тийм, тийм манай нярав сувилагч. Та таних юмуу? Би толгой дохиж «танихгүй яахав. Таних танихдаа хачин сайн танина шүү?» гэв. Цэцэгмаа цаадах чинь таныг энд хэвтэж байгааг мэдэхгүй байх. Би аяар тааралдахдаа хэлэмз гэв. Баахан байж байтал өнөөх маань гаднаас ороод ирэв. «За Молом гуай сайн байна уу? олгойгоо авахуулсан гэлүү, Үгүй ер. Таныг энд хэвтэж байхыг огт зүүдэлсэнгүй. Мэдсэн бол шөл цай авчирч өгөхгүй юу», шөл цай ч яамай. Чамайг манай түүгээр үзэгдэхгүй болохоор бид гайхаж байсан юм. Харин энд байгаа юм бий. Гонжоо инээж, «Би энд ажилд ороод жил илүү болж байна. За Молом гуай би одоо тун их ажилтай байна. Энэ орой энд би жижүүртэй. Тан дээр орж ирнэ. Яриа ч их бий» гээд гарч одлоо. Тэгээд өнөөх маань орой нээрэн халуун савтай цай, бяцхан боодолтой боов шоов барьсаар орж ирлээ шүү. Үгүй ер тэгээд цай нь сайхан гэдэг нь. Нэг аяга уугаад авгайнхаа цай уусан юм шиг санагдаж, дотроо «Яахав даа хөөрхий, хүний санаа, зуны ялаа гэсэн шиг» бодож байв.

Би цай уух зуур: Хүү минь чи ашгүй энд ажилладаг болсон юм уу? гэж асуухад Гонжоо инээн «Молом гуай би эндхийн үндсэн ажилчин болсон шүү» гэв. Би нөгөөдөхөө хамт хэвтэж байгаа улсаас ичиж зовох байх гэж бодоод нүдээ сэм ирмэж дуугаа нам болгон «За даа, сайн байна. Хүү минь. Ах чинь чиний орноос баярлаж байна» гэв. Гэтэл Гонжоо ер нуух далдлах гэсэн царайгүй манай өрөөний өвчтөн рүү хандаж: «Энэ Молом гуай Төв Засангийн харгалзагч байгаа юм. Намайг ч олон удаа цоожлоо биз дээ. Хэзээний л хулгай хийчихээд хүрээд ирнэ. Молом гуай л хөөрхий чинь намайг сайхан хүлээж аваад цоожилж орхино шүү гэхэд би орноос нь зовж, «За, за хүү минь өнгөрсөн юмыг яриад яахав. Харин чи яаж ашгүй ингэж зөв замд орчихоов» гэхэд Гонжоо «Тэр өдөр би засангаас суллагдаж гараад, найз нартайгаа уулзаж мөн тэр өдөр зусланд гарсан айлыг ухахаар хэлэлцсэн юм. Гэдэс өвдөж эмнэлэгт хэвтээгүйсэн бол дахиад л тан дээр хүрээд очих байсан» гэв. Би гайхаж юу гэнээ? хүүхээ гэдэс өвдсөн гэнээ? гэхэд Гонжоо хоолойгоо засаж «За тэгвэл та нар сайхан дуулж бай. Би яаж хөглөснөө ярья» гэв.

Тэгээд түүний ярьсан нь:

Тэр үдэш бид гурав айл амьтан хойно дөчин мянгат руу очив. Тэнгэр бүрхэж бороо шивэр шивэр орж байхад ашгүй гэж баярлаж байв. Өдрийн тэмдэглэсэн байшингийн дэргэд хүрч

ирэв. Хамгийн наад талын хаалгаар сэмхэн орж гурван давхарт гараад том гэгчийн монгол цоожоор цоожилсон хаалгын цоожийг эвдээд орж дотроос нь түгжив. Гэрлийг ноцоож үзвэл биднийг ав гэсэн юм шиг хамаг юм нь ил задгай байна. Бичгийн ширээн дээр байсан нэг гоё тамхины гялгар асаагуурыг би яаран авч өвөртлөв. Би хэдийнээ тийм нэг юмтай болох гэж санаж байсан билээ. За тэгээд бид гурав яргуйд орсон ямаа гэгчээр айлын юмнаас бие биеэс уралдан авч гарлаа. Тэгж байтал миний гэдэс гэнэт сүрхий базалж эхэлдэг юм байна. Намжих байх гэж баахан хүлээсэн чинь харин улам ширүүсэв.

Сандал дээр суугаад ёолж байв. Нэг харсан нөгөө хоёр маань бараан өнгөтэй пиджакийн хоёр ханцуйнаас нь зуурч би авна, би авна гэж булаацалдаж муудалцаж байв. Би ч юу авах сөгөөтэй юм. Хурдхан тэндээс холдохын мөрөөс болж байлаа. Тэгээд нөгөө хоёр маань орны даавуу хуу татаж аваад юмаа янгинатал боолоо. Миний авах гэж цуглуулсан юмыг ч хамт боосон шиг байна. Тэр хоёр юм авах гэж улайгаад миний ёолон суухыг мэдээгүй боллоотой. Харин гарч явахын үед сая мэдэж, чи юу болоод байна гэж сэм асуув. Би арай гэж гурван давхраас шатны хайсыг түшиж өндөр дуугаар ёолж гарав. Нөгөө хоёр маань надаас холдохын мөн болж: «Чи явж чадахгүй бол эндээ суугаад түр хүлээ. Бид хоёр энэ юмаа нэг газар тавиад, түргэн ирье» гэж шивнэн хэлээд даруй явлаа. Би хангинатал ёолж үлдэв. Нэлээд удав. Үгүй ер үхэх нь ээ. Хааяа ухаан ч балартаж байх шиг. Гэтэл хоёр хүн тэндээс дүнгэр дангар ярьсаар ирлээ. Би нөгөө хоёрыг гэж санаад улам чанга ёолоход тэр хоёр хүн цочиж зогтусан нэг нь миний дэргэд ирж: Юун хүн бэ? гэж асуув. Би гэдэс, гэдэс гэж ёолж байв. Үнэндээ олон үг дуугарахын ч сэхээ байсангүй.

Тэр хоёр хүн түргэн тусламж дуудахаар юм болж нэг нь яваад удалгүй ирж: «одоохон түргэн тусламж ирнэ. Түр хүлээ» гэв. Тэгсэн төдхөн түргэн тусламжийн машин довтлон ирж хоёр цагаан нөмрөгтэй хүүхэн намайг түшиж, машинд оруулан суулгаж эмнэлэг дээр авч ирэв. Хүлээн авах өрөөнд намайг дамжлан оруулж хэвтүүлэв. Санчигийн үс нь бууралтсан, нүдний шилтэй нэгэн хижээл эмч орж ирж намайг нэлээд чагнаж тогшиж үзээд, дэргэдэх сувилагчдаа: «Ажилбар бэлтгэ» гэв. Би дотор палхийж эмчээс: «ямар өвчин бэ? та нар намайг одоо хагалах гэж байна уу?» гэж асуухад эмч инээмсэглэн: «Ер айх зүйл байхгүй. Гэдэс зангираа болов уу. Та харин азтай хүрч иржээ. Жаахан хожимдсон бол хэрэг биш болно» гэв. Тэгээд хармаанаасаа тамхи гаргаж татах гэтэл шүдэнз байсангүй. Бүх хармаагаа гараар тэмтчиж намайг оруулж ирсэн хоёр сувилагчаас «гал байна уу?» гэж асуухад тэр хоёр бие биеэ харж жумалзан инээж үгүй гэв. Эмч тамхи татах гэж тун хүсэж байгаа бололтой. Дахиад л хоёр гараараа хамаг хармаагаа тэмтчиж эхлэв. Би өврөөсөө өнөөх асаагуураа гаргаж түүнд өгөв. Эмч миний өгсөн асаагуураар тамхиа асаагаад хачин их сонирхсон байдалтай харж: «таны энэ чинь яасан таатай эд вэ? хаанаас авсан юм бэ?» гэхэд «би хойноос хүн авчирч өгсөн юм» гэв. Эмч дахин нэг эргүүлж тойруулж үзээд надад өгөхөд би эмчид «та одоохондоо галгүй бол хэрэглэж байгаад над сүүлд өгөөрэй» гэв. Ухаан нь дотроо эмчид ая тал засаж байгаа хэрэг юм даа.

За тэгээд намайг түрдэг тэргэн дээр хэвтүүлж нэг гэрэл гэгээ болсон том гэгчийн өрөөнд оруулж ирлээ. Өдий төдий цагаан нөмрөгтэй хүүхнүүд байв. Эмч өвчүүнээсээ нэгэн бор хулдаас дүүжилж хоёр гартаа резин бээлий хийгээд амаа марлиар битүүлэн уясан байна. Үгүй ер сүртэй ч юм шиг аймаар ч юм шиг. Тэгээд намайг том толин доор өндөр ширээн дээр хэвтүүлээд нэг сувилагч үүнийг үнэрт гэж нэг юм хамарт ойртуулахад сайн гэдэг нь

үнэртээд авлаа. Тэгээд юу ч болсныг мэдсэнгүй. Сэрсэн чинь эмч резин бээлийгээ тайлж байна. Нүүр дүүрэн хөлс бурзайжээ. Тамхи гаргаж миний өгсөн асаагуураар сурамгай гэдэг нь асаагаад хармаандаа хийж байна. За тэгээд намайг нэг өрөөнд оруулж хэвтүүлэв. Хоёр хүн хэвтэж байна. Намайг оруулж байхад нэг нь сэрж хөдлөн ханиаж байна. Өвгөжөөр хүн бололтой. Надад өвдөх, хавдах юмгүй. Бие хачин сайхан амарсан байна. Тэгээд таг унтжээ. Нэг мэдэхэд өглөө болсон ажээ. Манай өрөөний хоёрын настайвтар нь аль хэдийн босчихсон нүүр гараа жалмайтал угаачихсан байна. Нөгөө нь унтсаар, настайвтар хүн: «миний биеийг ямар байна?» гэж халамжтай гэгч асууж байна. Өвгөн бэтэг авахуулаад удахгүй гарах гэж байгаа гэнэ. Унтаж байгаа залуу руу дохиж үүнийг Бат гэдэг юм. Барилгын хүн, хэд хоногийн өмнө барилга дээрээс унаад гараа гэмтээгээд хэвтэж байгаа юм гэв. Сувилагч халуун үзэхээр орж ирэв. Бидний ярилцахад сэрсэн Бат: «Манай Цэцэгмаа ашгүй хүрээд ирсэн үү? Зүүн өрөөний Самдан Цэцэгмаа ирэхгүй нь санаад үхэх нь гэж сүйд болоод байна билээ. Чи орсон уу?» гэв. Цэцэгмаа: үгүй ер намайг санадаг хүн олон гарах нь шив дээ гэснээ өвгөн рүү харж «Насанцогт гуай манай Болд эмч сүйд болсон шүү. Урьд шөнө жижүүр хийж байхад нь хулгай ороод хамаг юмыг нь тоноод явчихаж гэнэ. Авгай нь амралтанд явсан юм гэнэ»..... гэхэд миний дотор сэртхийж «За биш боллоо. Өчигдрийн бидний ордог айл байх нь. Би эмчийн гэрийг ухаж, эмч миний гэдсийг уудалсан хэрэг болж байх шив дээ» гэж бодож, за дүүрчээ гэж сэтгэл шулуудаад хэвтэж байтал гэнэт энэ саяны Цэцэгмаа гэдэг чинь яасан согоо шиг хөөрхөн амьтан бэ? дахиад ороод ирэх болов уу? тэр Самдан санаад үхэх гээд байдаг нь аргагүй зөв байх. Би ганцхан харчихаад хэцүү болж байна гэж санав. Тэгж байтал цай орж ирэв. Би ямар юм идэж болох биш. Нөгөө хоёр маань ууж идэв. Бат: «Насанцогт гуай танай хуулийнхан энэ муусайн хулгайч нартай яагаад олигтой тэмцэж чаддаггүй юм бэ? яагаад тэднийг сайн залхааж болдоггүй юм бэ? миний санахад манай хуулийн бодлого дэндүү зөөлөн байх шиг. Энэрэнгүй ч байх л ёстой юм биз дээ. Тэгэхдээ хулгайчийг энэрч болох уу? тэд чинь энэрэх тусам элэг өшиглөх улс байгаа юм. Ер нь хулгай нарыг хүмүүжүүлэх гээд яадаг юм. Хэзээ ч засрахгүй улс. Эсвэл яс цоожилж үгүй бол ердөө л цааш харуулаад байвал таарна» Насанцогт сүү болсон цайг тааламжтай оочилж ширвээ хар сахлаа имэрч суухдаа «манай хуулийн бодлого бол хүнийг засаж хүмүүжүүлэхийг урьдал болгосон юм. Хулгайчтай хатуу тэмцэх хэрэгтэй гэдэг чинь зөв. Харин хулгайч засрахгүй гэдэг чинь буруу. Хүн эхээс төрөхдөө хулгайч төрдөггүй. Хулгайн зан бол тэр хүний сүүлд олж авсан муу дадал заншил байгаа юм. Хулгайч байгаад сүүлдээ ариун цагаан хөдөлмөрөөр амьдрах болсон хүн алийг тэр гэхэв» гэв. Бат том гэгчийн талхан дээр тос зузаан гэгч нь түрхээд цахиур цагаан шүдээрээ ёотон тас хазаж, талхнаасаа үмхэлж суухдаа толгойгоо сэгсэрч: ээ дээ Насанцогт гуай хулгайч хүн засрах гэдэг ёстой өдрийн од шиг цөөхөн байдаг байх. Тэр жил манай нутгийн нэг сүрхий хулгайч арав шахам жил шоронд суугаад улсын баяраар өршөөл үзэж суллагдаад мөн тэр өдрөө хулгай хийгээд шорондоо буцаж очсон гэнэ билээ. Өчигдөр Болд гуайн гэрийг ухдаг тэр хулгайч аягүй бол шинэ хулгай биш. Харин хэд дахин хулгайн хэргээр шоронд орсон өөдөлшгүй амьтан дөнгөж гараад гар нь загатнаж дахин хулгайгаа хийсэн байж магадгүй л байх бий.

Би Батын хэлэхийг сонсоод, гайгүйдээ чамайг сүүлд нэг дайралдвал гэж дотроо занаж байв. Гэтэл Болд эмч орж ирэв. Миний дотор палхийж: За одоо яадаг билээ гэж бодов. Эмч миний дэргэд ирж суугаад халууны тэмдэглэлийг харж: сайн байна, халуун алга. Бие чинь хөнгөн байгаа биз дээ. Өвдөх юм байна уу? гэхэд Би толгойгоо дохиж, «зүгээр, сайхан байна» гэв. Эмч инээмсэглэн хармаанаасаа асаалтуур гаргаж: танай энэ тун аятайхан эд байна. Надад яг

үүний нэг адил байсан юм. За их баярлалаа. Май асаалтуураа ав гээд өгөхөд би яаран: «үгүй, үгүй та наадахаа бүр ав. Надад хэрэггүй» гэв.

Болд намайг нэг сүрхий хараад юу ч хэлсэнгүй толгойгоо дохиж инээмсэглэн Насанцогт Бат хоёртой ярьж байгаад гарав. Бат гадуур явж байгаад ирж хэлэх нь «Өнөөх уржигдрын Болд гуайн гэрийг ухсан хулгайчийн хоёр нь тэр дороо баригдсан гэнэ. Юм нь ч зүсээрээ байна гэнэ. Харин гуравдахь хулгайчийг олоогүй юм байх» гэхэд би дотроо «гуравдахь нь энд байна даа. за дүүрсэн хэрэг баривал барьдаг юм байгаа биз. Баригдаж үзээгүй толгой биш. Биеий минь зүгээр болгож байгаад аваад явдаг юм байгаа биз» гэж бодож байв. За тэгээд 2-3 хонов. Насанцогт, Бат хоёр ч намайг ямар хүн болохыг ер зүүдлээгүй бололтой. Болд эмчийн ааш зан ч хуучин янзаараа, эмнэлгийн улс ч ер мэдсэн шинжгүй. Цэцэгмаа хүүхэнтэй би сүрхий тоглоом наадам хийж байдаг боллоо. Тэгээд тоглоом наадмаар ч ер зогсохгүй харин нэлээд учиртай яриа ярих боллоо.

Би нэг өдөр доод давхарт явж байлаа. Эргэлтийн өдөр юмсан. Халуун сав барьсан миний үеийн нэг залуу намайг ээждээ цай оруулж өгөөд биеийг нь асуугаад ир гэж гуйв. Тэр өдөр Цэцэгмаа жижүүртэй байсан юм. Эргэлтийн хүн учиргүй олон. Цэцэгмаа ганцаараа гүйгээд гүйгээд бардаггүй. Би Цэцэгмаад тус болох гэж тэр залуугийн цайг авч дээд давхарт гарч 5-р тасагт оруулж өгөв. Цонхны хажуу дахь орон дээр зовиурлан хэвтэж байсан авгайд «танай хүү гадна ирээд биеийг чинь асууж байна» гэж хэлэв үү үгүй юу нүүр дүүрэн баяр баясгалан тодрон: «миний хүү ирээ юу? Хаана байна?» гэж дуу алдан өндийхийг үзээд гэнэт ээж минь сэрхийтэл цээжинд ороод ирэх нь тэр. Би ээжтэйгээ уулзаагүй олон сар болж байгаа юмсан. Ээж минь намайг засанд байхад долоо хоног бүр эргэж, очих болгондоо еэвэн авчирч өгдөгсөн. Би еэвэнд учиргүй дуртай. Нэг амиар 2-3 ыг идчихдэг билээ.

Гэвч сүүлдээ ээжийн эргэж ирэх тоолонд еэвэнгийн тоо хорогдсоор харин нэг ирэхдээ ганц ч еэвэнгүй, хэдэн чихэр боож ирэхэд би уурлан «ээж та ядаж надад ганц еэвэн авчрахгүй яав даа. Еэвэн байхаа болио юу?» гэхэд ээж минь буруу хэрэг хийсэн юм шиг инээмсэглэн «ээжид нь тун мөнгө байсангүй. Дараа ирэхдээ заавал хүүдээ авчирна» гэж байсан нь санагдаад би ээжээ бодож өрөвдөн өөрийн эрхгүй хамар шархиран халуун нулимс хацар дээр бөмбөрч байв.

Айлын хүүхдийг харж, арав таван төгрөг олдог гэж ярьж байсан юмсан. Одоо яаж байгаа бол. Өнөө айлдаа хэвээр болов уу гэж бодов.

Насанцогт, Бат хоёр нэг өдөр эмнэлгээс гарах болов. Тэр хоёр гэдэг чинь хөл нь газар хүрэхгүй дэгдэж, гэр орондоо харина. Ажилдаа бушуухан орно гэж хөөрч байв. Би дотроо энэ хоёр ч яахав ажил ажилдаа ордог юм байж. Надад ямар ажил ч байх биш дээ гэж санаснаа ер нь би эмнэлгээс гараад юу хийх болж байна гэж өөрөөсөө асуудаг юм байна. Бас л хулгайгаа хийх үү, гэж бодтол үгүй больё. Одоо нэг хүн дүрстэй явья. Муу ээжээ ч зовоохоо больё гэж санав. Тэгээд хаана ямар ажил хийх вэ? Ер нь над шиг хүнийг тоож авах газар байх болов уу? эмнэлгээс холдмооргүй санагдаад болдоггүй шүү. Эмнэлэг гэж худал яриад ч яахав. Ердөө л Цэцэгмаагаас л холдох дургүй байсан байхгүй юу. Эмнэлэг гэж бодоод Цэцэгмаа, Цэцэгмаа гэж бодохоос эмнэлэг санагдаад болж өгөхөө болилоо. Болд гуай ч гэр ухсан гурван хулгайчийн нэг нь гэж намайг сайн мэдэж байгаа ш дээ. Харин яагаад намайг ил гаргаж хэлсэнгүй вэ? Лав асаагуурыг нь өгөхөөр яахав дээ ер нь юу гэдэг бол? Цэцэгмаа намайг

хулгайч муу хүн гэж мэдсэн бол надад царай өгөх байтугай хүн ч гэж тоож харахгүй биз гэж бодов. Би ер нь хүн болсоор тийм их бодлого болж байгаагүй билээ. Тэгээд хэд хоногийн дараа эмнэлгээс гарах болов. Гарах өдрөө би Болд гуайн өрөөнд оров.

Болд «За чи гарах гэж байна уу?» гэж асуухад би түгдрэн байж «эмчээ би танай эндээс явах дургүй байна» гэв. Болд гуай намайг гайхан харж «Чиний бие бүр зүгээр болсон шүү дээ. Эмнэлгээс гарахад ямар ч саадгүй» гэж хэлснээ, баахан бодоод, «Аа мөн чи тэр шөнийн явдлаас зовж байна уу? Чамайг одоо яах ч үгүй. Би гомдолгүй гэж хэлсэн. Харин чи залуу хүн байна. Энэ явдлаа эртхэн засаж ариун цагаан хөдөлмөрөөр оролдох хэрэгтэй» гэв. Би «таны дэргэд л ажиллах хүсэлтэй байна. Та намайг юугаар ч хамаагүй үлдээж ажиллуулаач. Би таны нэрийг хөөдөхгүй шүү, хичээе» гэж гуйв. Болд гуай инээж «үгүй ер би чамайг хаанаа авах билээ. ажил юу мундах вэ?» «Би ганцхан таны дэргэд ажиллах хүсэлтэй. Та намайг үхлээс аварсан. Одоо та надаар хүн хийж ав» гэж үхэн хатан гуйв. Болд арга барагдаж юу ч болсон би дарга нартайгаа ярьж. Чи түр сууж бай гээд гарав. Нэлээд удав. Над шиг хулгайч муу хүнийг яалаа гэж авах вэ. Орон тоогүй гээд л гаргах бий гэж бодож суув. Гэтэл эмч маань орж ирэв.

Чи яаран бостол «дарга нартай ярилаа. Ашгүй чиний азаар нярав сувилагчийн ор мөд гарах гэж байна» гэв. Үгүй ер миний баярласныг яриад яахав. За тэгээд эмнэлгээс гарав. Юуны түрүүнд ээжтэйгээ уулзъя гэж өнөөх байдаг айлд нь очлоо. Тэгсэн чинь тэр айл нь нүүгээд явчихжээ. Хажуугийн айлаас нь эдний хүүхдийг харж байсан хөгшин байсан юмсан хаана байгаа бол, гэсэн мэдэх хүн ер алга. Одоо яаж ээжээ олдог билээ. Арай үхчихээгүй байгаа гэж дотор бачимдан ээжээ та хаана байна вэ гэж хашгирмаар санагдлаа. Замаар явсан настай авгай бүгд ээжтэй минь адил харагдаад хүрээд очиход хаанаас мөн байх билээ. Орох ч газар олдохгүй гудамжаар дэмий л явж байтал нэг хүн «хүүе Гонжоо» гэж дуудав. Харсан чинь ойр хавь хүнгүй. Тэгтэл дахиад л дуудлаа. Хаанаас дуудаад байна гэж гайхан зүг зүг тийш харж байтал тэртээ баруун талд барьж байгаа өндөр барилга дээрээс хөх комбинзонтой, салхины шил зүүсэн хүн Гонжоо гэж намайг даллан дуудаж байна. Ойртоод очоод харсан чинь эмнэлэгт хэвтэж байсан өнөөх Бат байна. Бат «за чи хэзээ эмнэлгээс гарав? Бие сайн уу? Юу хийж явна» гэхэд би дөнгөж өнөөдөр гарлаа. Харьсан чинь манайхан эзгүй. Тэгээд дэмий л явж байна гэв. Бат, чи намайг наанаа хүлээж бай. Удахгүй ажил дуусна. Хоёулаа манай гэрээр очье гэв. Миний баярласныг хэлээд яахав. За тэгээд Батынд очив. Барилгын ажилчдын байр гэж мундаг сайхан байр юм. Батынх гурван давхарт байдаг юм байна.

Бат хаалганы хонхны цахилгаан товчийг дармагц мантайсан цагаан хүү тэвэрсэн залуухан хүүхэн үүдээ тайлж өглөө. Бат орсоор «Үзмээ, энэ Гонжоо бид хоёр эмнэлэгт хамт хэвтэж байсан юм» гэж намайг танилцуулав. Үзмээ инээж «таньж байна, таньж байна. Таны тухай Бат надад ярьж байсан» гэв. Юу гэж холиогоо бол доо гэхээс дотор аягүй болж байв. Тэгээд намайг том өрөөнд суулгав. Бат нүүр гараа угааж байхдаа Үзмээгээс чи яасан эрт ирээв? Эмээ хайчсан бэ? хоол хийсэн үү? гэж асууж байна. Би дотроо Батын сууж байгааг, миний явж байгааг гэж өөртөө гомдох шиг болов. Тэгж байтал үүдний хонх дуугарав. Үзмээ босож тайлж байх нь өнөө эмээ нь бололтой. Хоолны дараа бид хоёр тамхи татаж элдвийг ярьж суутал бие нэг л сул хөлс чийхраад ядраад байх шиг байна. Бат ч байдлыг мэдсэн бололтой. Царай чинь базаахгүй байна. Дөнгөж өнөөдөр эмнэлгээс гараад баахан явж ядарсан байлгүй. Наадах диван дээрээ хажуулж амар. Үзмээ бид хоёр ингээд явлаа. Оройн сургуультай гэв. Би

зүгээр гэсэн боловч диваан дээр нь хажуулдан хэвтэж байгаад үхширтлээ унтчихжээ. Тэгээд бас зүүдэлжээ. Ээж минь нэг нялх хүүхэд тэвэрсэн байх юм. Би, Цэцэгмаа байх юм. Бид хэд нэг харахад яг Батынх шиг сайхан байранд байгаа юм шиг, нэг харахад нэг их цэцэг навч болсон уудам талд байгаа юм шиг, тэгж байтал тэнгэр харанхуйлж учиргүй үер цутгав. Цочин сэрээд өндийтөл ээж минь миний дэргэд толгойг минь илээд уйлан сууж байна. Би эхлээд итгэхгүй зүүдэлсээр байна уу? гэж нүдээ нухлан лавлан харахад аргагүй ээж минь мөн. Харин үс нь улам буурал болж шаналсан царайд нь атираа нэмж хачин их өтөлжээ. Би ээжээ гэж ухаангүй хашгираад хүзүүдэн учир зүггүй уйлж гарав. Ээж мөн намайг тэвэрч хүү минь, үр минь гэж уйлж байхдаа тиймээ. Өнөөдөр даанч баярын совин татав, хүү минь гарчихаагүй байгаа даа гэж бодож байсан юм. Тэгэхдээ өнөөдөр энд чамтайгаа тааралдана гэж яаж зүүдлэх билээ. Сэтгэл догдолж нэг л хачин болоод байхаар нь салхинд гараад ирсэн чинь нэг хүн гаднаас ирсэн бололтой. Эдний танил нь биз гээд ер санаад орсонгүй. Харин инээх ярих нь миний муу хүүтэй яасан адилхан юм бэ гэж бодогдож байсан юм. Тэгээд өнөөх хоёрыг явсны дараа наадахь өрөөний чинь юм хумыг өөд татъяа гэж ортол харин чи унтаж байна. Гайхсан баярласныг хэлээд яахав. Ухасхийгээд дэргэд чинь очтол царай чинь хачин цонхигор, тун ядарсан, ухаангүй унтаж байна. Хүү минь жаал унтаж амраг. Цочоож сэрээгээд яахав гэж бодоод хажууд чинь сууж байсан юм. Нулимсаа дусаагаад хүүгээ сэрээчихлээ гээд ээж минь дахиад л намайг тэвэрч ээ миний нар минь, миний үүлэн чөлөөний нар минь чи хэзээ намайгаа орхиод бас явах гэж байна, гэж уйлахад би мөн уйлан ээжийнхээ буурал үстэй толгойг илж, ээж минь би одоо үүлэн чөлөөний нар шиг үзэгдээд алга болохгүй. Үргэлжид ээж таныхаа дэргэд байна. Бүтэлгүй муусайн юмнуудад уруу татагдаж хайран сургуулиа хаяж аль байдаг муу муухайг ажлыг хийж ачит эх таныхаа их л зовоолоо. Их ч гомдоолоо. Хүү чинь одоо хүн шиг явъя. Би таныг дахиад яасан ч зовоохгүй гэв. Ээж минь баясан хэлсэн нь: «Мянган өдөр гасалсан эхийн сэтгэл үрийнхээ ганцхан үгэнд баясдаг юм шүү. Хүү минь ээж чинь чамайг явдал замаа засна гэхээр баярлаад хэлэх үг ч олдохгүй байна. Юу ч гэж чамдаа зүйрлэж хэлэх билээ. Ээж чинь чамайгаа төрүүлэх гэж хичнээн их зовсон гэж санана. Төрөхийн зовлон ямар байдгийг чи эр хүн яаж мэдэхэв дээ. Хамаг биений бүх яс үе үеэр салж, судас шөрмөс тэр аяараа тасарч байгаа юм шиг байдаг юм. Тэгээд яахав дээ. Ёстой юм ёсоороо гэгчээр чи ч гардаг, өнөө өвдөж байсан чинь өргөс авсан юм шиг дороо зүгээр болчих нь тэр. Үхэж дууслаа гэж байсан хүн чинь одоо мөнхөрлөө гэж бодож байсан юм. Чамайг боогоод өгөхөд нь хичнээн өвдөж үйл тамаа эдэлж байсан минь ер өчүүхэн төдий ч бодогдохгүй, харин би бас сайхнаа. Би хүүтэй хүн, би үртэй хүн гэж хэнхдэг цээж тэр аяараа баяр баясгалан бялхан дүүрэн байж билээ. Хүүгийн минь саяны хэлдэг үг яг чи төрөөд би чамайг элгэндээ тэвэрч би үртэй хүн, би хүүтэй хүн гэж бахархан баярлах сэтгэл төрж байсантай адилхан тийм сайхан цээж дотрыг минь баясган амраалаа».

Би ээжийн эдгээр үгийг сонсоод юу ч хэлж чадахгүй мэгшин уйлж суух зуур дотроо би бас эхээ хачин их зовоосон хүн юмаа гэж өөрийгөө зүхэн харааж байлаа. Би ээжийнхээ сэтгэлийг засан таны зовлонгийн тоо өнөөдрөөс эхлэн дуусна. Одоо таны жаргах цаг ирнэ. Хоёулаа яг энэ Батынх шиг сууна гэв. Ээж минь: «Юу хэлэхэв, юу хэлэхэв хүү минь ариун шударга л хүн бол тэгвэл гүйцлээ. Ээж чинь ходоод хоосон хоновч сэтгэл цаггалан унтана» гэв. Би ээждээ засангаас гарсан, эмнэлэгт хэвтсэнээ цөмийг яриад Батынхтай яаж танилцсаныг нь асуувал ээжийн түрүүний хүүхэд харж байсан айл нь хөдөө суухаар явахдаа Батынхтай танилцуулж өгсөн байжээ. Ээж минь «ээдээ хүү минь чи энэ Батаас л үлгэр ав. Бат Үзмээ хоёр чинь ажил эрдэм хосолсон, томоотой тохитой тэгээд бас хөгшин хүнд хачин сайн улс шүү гэв. Тэгээд

Ээж бид хоёр зовлон жаргалаа ярьж суутал Бат Үзмээ хоёр ч ирлээ.

Бид хоёр ч тэдэнд хамаг юмаа эрээ бараагүй ярилаа. Бат надад Гонжоо минь чи Насанцогт гуай бид хоёрын маргаж байсныг санаж байна уу? Өвгөн маань аргагүй хашир хүн гэж зөв хэлсэн байжээ. Би хүн сайн бол сайнаар дуусдаг, муу бол муугаар дуусдаг гэж их буруу бодож явжээ. Гэтэл хүнд өгсөх уруудах янз бүрийн явдал тохиолддог юм байна. Тэгэхдээ хүн уруудахыг боддоггүй харин дагнан өгсөж өөдлөхийг боддог юм байна. За Гонжоо минь би чиний орноос их баярлаж байна. Одоо ажил л хийдэг хэрэг. Чи хаана ажиллах гэж бодож байна гэв.

Би Болд гуайн дэргэд ажиллах болсноо хэлэв. Бат баахан бодоод, үгүй яахав дээ ажил хийвэл хаана ч яахав. Уул нь манайд орсон бол зүгээр байсан юм. За тэгээд хэд хоногийн дараа би энд ажиллах болов. Ээж бид хоёр Батаагийн дүр байгаад нэг байранд орж суув. Бат Үүзээ хоёр хүүгээ манайд авчирч өгнө. Ээж ч тэр хүүхдэд хачин хайртай юм. Цэцэгмаа бид хоёроос хүү гарвал ээж маань нэгийг биш хоёрыг хүүхлэх байхдаа. За тэгсэн чинь бас хөгтэй, манай Болд гуай хэзээний л асаагуураа мартчихдаг хүн гэнэ. Эмнэлгийхэн дунд энэ талаар олон инээдтэй яриа явдаг юмсанж. Тэр шөнө мөн л мартчихсаныг би аваад өвөртөлчихсөн байжээ. За тэгээд намайг ажилд орсоор өнөөхийг маань нэг ухасхийгээд аваад ирэхгүй юу гэнэ. Би ч өнөөх гэдэг нь асаагуурыг хэлж байна гэж мэдээд юу билээ ч гэж асуулгүй шууд гэрт нь очоод авчраад өгнө дөө. Болд гуай намайг манай энэ хүү мартсан асаагуур гэрээс минь авчирч тус болдог юм гэж хүнд хэлж л суудаг юм. Тэр нь миний анх хулгай хийснийг хэлж байгаа юмуу? Сүүлийн авчирсаныг хэлж байгаа юм болов уу бүү мэд. За ийм л сонинтой байна даа. Молом гуай минь гэв.

Гонжооны яриаг сонсож суусан манай тасгийнхны дотроос өвгөн Бэрх «Хуучин үгэнд тэнгэрийн муухай арилна. Хүний муухай арилдаггүй гэсэн байдаг билээ. Үүгээр бол хуучин үгэнд хуудуу их байна» гэв. 1964 он

ЧИМИДДОРЖИЙН НАЦАГДОРЖ

Зохиолч Ч.Нацагдорж 1935 онд Булган аймгийн Сэлэнгэбүрэн сумын «одоогийн Хангал» нутагт малчны гэр бүлд төржээ.

1960 оноос уран зохиол сонирхон оролдож “Нэргүй нэгэн цэцэг”, “Эр зоригийн дууль”, “Тэмдэглэлийн есөн хуудас” зэрэг тууж, өгүүллэгийн ном, “Шарилжсин дундах цэцэг” либретто, “Миний чин зоригт бяцхан найз” жүжиг бичжээ.

ХАРИУ ХҮСЭЭГҮЙ ЗАХИДАЛ

Би энэ захидлын хариуг ирээсэй гэж хүсэхгүй байна. Тэгэх тусмаа ажлын тухай чамайг дахин бүү дурсаасай гэж гуйя. Магадгүй чи энэ захиаг хүлээж аваад надаас уучлал гуйхаар санагдах ч юм билүү. Магадгүй чамд би ухаантай, эсхүл бүр тэнэг ч юм шиг бодогдож болно. Ямар ч байлаа гэсэн чиний амнаас тэр тухай дахин сонсохыг л би хүсэхгүй байна. Чамд энэ бүхэн минь тун арчаагүй бөгөөд бүсгүй хүний аргаа барсан гуйлт юмуу, эсхүл өөрийгөө эрхэмлэн өмгөөлөх гэсэн арга саам шиг л санагдаж болно. Ямраар ч санагдлаа гэсэн намайг уучлах хэрэггүй. Бүсгүй хүн гэхэд миний энэ бичиж байгаа бүхэн хатуу хариг болж таашаал энхрийллийн үнэр амт алдсан байж болно. Эрхэм нөхөр минь үүнийхээ төлөө чамаас биш гэргийгээс чинь уучлал гуйхад би бэлэн байхсан.

«Нэг үйлдвэрийн ерөнхий инженер болно гэдэг чиний амьдралд яагаад муугаар нөлөөлөх юм бэ. Чамд сайн сайхан амьдаръя, ажиллая гэсэн хүсэл тэмүүлэл, авьяас чадал бүх юм бий. Гэтэл чи тэр зорилгоос мэдсээр байж ухрах гэж үү».

Чамаас би ийм үг дуулна гэж даанч санасангүй. Намайг мөн ч их өрөвдөж дээ. Чамайг би өрөвч зөөлөн сэтгэлтэйг мэдэх боловч ажил төрлийн хувьд ийм ялдам бодол санаатай болсныг чинь мэдээгүй явжээ. Мэдсэнсэн бол энэ тухай юу гэж дурсах вэ. Чиний бичсэнийг өөр хүн үзлээ гэхэд намайг, үгний өө эрсэн юун ч их номчирхуу амьтан бэ л гэнэ. Энэ ч аргагүй. Аль нэг савтай юмыг тэмтэрч үзчихээд тааж хэлэх амаргүй л байдаг сан.

«Дэлгэрмаа, чи яагаад энэ ажилаас татгалзсаныхаа учрыг над тодорхой бөгөөд яаралтай бичээрэй. Би ойлгоогүй байж ч болох юм». Хэрэв чамайг ингэж бичээгүйсэн бол би энэ захиаг бичихгүй байсан. «Яаралтай» гэж онцлон бичсэн чинь надад тийм ч аятайхан сонсдохгүй байна. Миний төлөө ингэтлээ донсолсон сэтгэл чинь тийм ч их халуун дотно санагдсангүй. Нэгэнт би тэр ажлаас татгалзсан болохоор чиний энэ шаналал чинь талаар болж л үлдэх нь дээ. Одоо яая гэх вэ. Харин чи «тодорхой» гэсэн ганц үгэнд чинь л хариу бичиж байгааг минь чи ойлгоорой.

Ерөнхий инженер мөдхөн солигдоно. Энэ хүн хэний өмнө ч худлаа ярьж, хэнийг хууран мэхлэхээс буцахаа байжээ. Чи, түрүүчийн захианаас энэ мөрийг минь уншаад ийм хүнийг тийм удирдах өндөр тушаалд ажиллуулж байдаг яачихсан дарга нар вэ гэж бараг тэр өдөржингөө бухимдан зовсон байж ч магадгүй. Нэг өдөр чамайгаа тэгж зовоход чинь бүтэн жил зовсон гэдгээ би нуухгүй. Үүнийг уншаад чи үхээнц дорой арчаагүй амьтан гэж одоо намайг хэлбэл чинь би маргахгүй ээ. Хүн амиа бодоод ирэхийн үед хөөрхийлөлтэй болдогийг биеэрээ, бүр зүрх сэтгэлээрээ гашуунаар мэдэрсэн минь нэг хүнд хэрэг болж мэднэ. Би залхууралгүй, гэмшиж ухаарсныхаа хүчээр энэ тухай бичиж, чиний сэтгэлийг бага ч гэсэн тайтгаруулах гэсэн юм.

Би дээд сургууль дөнгөж төгсүүтээ энэ үйлдвэрт ирсэн гэдгийг чи андахгүй. Юу хийж эхэллээ, цахилгааны засварчин. Чи үүнийг сайн мэднэ. Гайхаж ч байсан, дээд сургууль төгссөн инженерийн мэргэжилтэй, тэгээд бүсгүй хүнийг энэ үйлдвэр ингэж ч хатуухан гараар хүлээж авах гэж дээ гэж чи халаглаж байсан удаа бий. Над ч гэсэн заримдаа тэгж санагддаг байлаа. Хэрэв ганцхан намайг ингэж хүлээж авсан бол чи бидний зөв байхсан.

Харин Адьяа л цахилгааны инженерээр шууд томилогдсон нь миний хувьд ичгүүртэй мэт байлаа. Хамт сургууль төгсөөд, хамт нэг үйлдвэрийн нэг цехэд хуваарилагдсан хэрнээ түүний захирамжинд ийнхүү гэнэт орсондоо хэд хоног сэтгэл тавгүй байлаа. Эхний үед ажиллаж болмооргүй шиг санагдаад өөр үйлдвэрт цэвэрлэгч ч хийсэн яахав гэж бодож байв. Тэр үед би, энэ тухайгаа чамд ер яриагүй. Ярих ч аргагүй байлаа. Одоо ч гэсэн хэлэхэд ухаангүй хэрэг мэт боловч бага ч гэсэн юмны учрыг олохын тулд үнэнийг ярилцахаас өөр зам алга гэдгийг чи хүлээн зөвшөөрнө бизээ.

Адьяа дээд сургуулиа хутганы ирэн дээр төгссөнийг би мэднэ. Диплом хамгаалах үедээ цахилгааны задгай хэлхээний зураг дээр гүйдлийг буруу зааж байсан хүн өнөөдөр үйлдвэрийн цахилгааны инженер, тэгээд бүр удирдах хүн болчихсонд л би гайхширч байлаа. Магадгүй тэвдэж сандарсандаа тэгж байсан байж болно. Гэлээ ч...

Хэрэв чиний бие муудсаныг олж сонсоогүйсэн бол миний диплом хүмүүсийн хүсдэг тэр өнгөтэй байж ч болох юм. Гэвч би сайн төгссөн. Ганц удаа намайг уучлахыг хүсэж байна. Чи ингэж бичсэнийг минь энэ удаа уужим сайн сэтгэлээр цагаатган бодож үзээрэй дээ. Энэ бол хувь заяаныхаа эндлийг өөрөөсөө зайлуулах гэсэн хэрэг огт бишээ. Харин ч би тэр нэг шалгалтанд тааруу дүн өгчихсөнийгөө чамд улам ихээр ойртож байгаагаар мэдэрч, сэтгэлдээ чамайг хичнээн ихээр үгүйлж байснаа одоо нэхэн бодоход амьдралын минь хамгийн сайхан үеийн нэг шиг санагдаж байна. Чамайг энэ тухай сонсохыг хүсвэл дараа чамд ярьж өгөхөөсөө ч татгалзахгүй.

Харин одоо Адьяа бид хоёр юу болсон нь чамд сонин байлгүй дээ. Автомат тохируулагч бүхий олон машинтай энэ үйлдвэрт Адьяа шиг мэдлэгтэй хүн амьдрахад бэрх болохыг би сайн мэдэж байлаа. Тэгэх тусмаа над ч гэсэн энд ажиллахад түүнээс хүнд болохыг би битүүдээ ойлгож байлаа. Үнэнийг хэлэхэд ад би атаархсангүй, засварчин болсондоо л гутраагүй юм. Цахилгааны засварчин арваад хүн байлаа. Тэдний хамгийн ахмад нь Балдан гэж жар гасан нэг өвгөн. Хамгийн залуу нь надаас гурав дүү нэг намхан хархүү, бусад нь хижээл насны хүмүүс. Тэд шинэ инженертэй болсондоо баярлаж байгаа гэж жигтэйхэн.

За охин минь, чи инженер болчих нь энэ үү. Аль нутгийнх вэ дээ гэж Балдан гуай анх удаа надтай ам нээсэн юм. Чухам «охин минь» гэсэн энэ хүний өег дотноор өгүүлсэн үгэнд л би баригдаж хэд хоноогүй бол өөр үйлдвэрт саналаа өгөөд явчих байв. Зарим нь ажилдаа дарагдсан шинжтэй тэвдэж бухимдсан, заримдаа алгуур наазгай мэт эвшээлгэж суниасан, эсхүл үг ч солих завгүй засвартаа улайрсан энэ хүмүүсийн дунд нэг мэдэхэд гурван сар болчихжээ. Санасан бүхэн өөрөөр эргэсний учрыг олоход бэрх юм. Бид хоёр ч энэ хүмүүсийн дунд нэр нүүрээ барж хөгөө тарина гэж бодоод түргэн шиг өөр тийшээ шилжих нь зөв гэж бодож байв. Мэдээж хэрэг, элдвээр буруу шаардлага тавьж дургүйг минь хүргэнэ. Ингээд л маргаан гарч, мэдэх мэдэхгүйдээ хүрэхийн үед бид гэдэг ажилчдын дунд ямар хүн болж таарах вэ. Гурав хонохын ч арга алга гэж бодсон чинь даанч богинджээ. Адьяагийн нэг удаа л эвгүй үг хэлснийг тооцохгүй бол бидний дунд чанга ярилцах ч хэрэг гарсангүй. Адьяа засварчдаас зайдуухан явж төвөгтэйхэн гэмтэл гарвал намайг үзэхийг гуйна. Би ч дуртай үзнэ. Тэгээд нэг өдөр Адьяа засварчдын дунд ирээд:

Манай Дэлгэрмаа ч цахилгааныхаа хувьд надаас хавьгүй дээр. Би яахав ганц хоёр томьёо л илүү бодож мэднэ гэж шуудхан хэлчихэв. «Томьёо илүү мэднэ гэнэ ээ» гэж бодогдсон боловч

мэргэжлийн хувьд үнэнээ хэлсэнд нь баярлахдаа

Надад Адъяагаас илүү юм байхгүй шүү. Тэр ч байтугай над Балдан гуайгаас асуух юм гарч байна гэж яаран хэллээ. Бидний яриа засварчдад дотно санагджээ.

Ийм инженерүүдтэй улс чинь зүтгээд байхаас өөр яах билээ гэж тэдний нэг нь хэлэхэд Адъяа «баярлалаа» гээд толгой дохион мэхэсхийв.

Энэ ярианаас хойш төдий ч удсангүй. Адъяа гэж хэн болох нь над мэдэгдлээ. Механик цехийнхэн улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн товч үг хэллээ. Олон үг нуршаагүй боловч хэлсэн бүхэн нь худал гээч. Юу болох нь энэ вэ. Үүнийг тэр үед надаас өөр хэн ч мэдээгүй дээ. Хэн нэг нь намайг сайн ажигласан бол миний улайсан нүүрийг хараад улан цайм хэнэггүй ярьж буй Адъяагийн үгэнд эргэлзэх л байсан. Хөөрхий, хэн ч түүнийг анзаарсангүй. Үгэнд нь итгэж битүүдээ талархсан хүмүүсийг л би харж суулаа. Энэ үед би гэгч хэн гэдгээ үзүүлж түүнийг суумагц л босож ний нуугүй хэлмээр санагдана. Гэвч чадсангүй. Ай нөхөр минь, хүн гэдэг нэр төрд ямар их дуртай амьтан бэ. Тооцоогоор үзэхэд цахилгаан хэмнэлттэй нь тодорхой байвч үнэндээ хэмнээгүй учрыг хэлчихэд тун амархан. Цехүүдийн доторхи хүч ихтэй хэд хэдэн сэнсний хөдөлгүүр дараа дараагаар эвдрэхэд бид засварын цехэд аваачиж өгсөн юм. Гэтэл засах сэлбэг байгаагүй учир арга тасрахдаа бэлэн байгаа жижиг хөдөлгүүрүүдийг оронд нь авчирч тавиад туршиж үзсэн хэрэг л дээ. Хөдөлгүүрүүд хүч багатай ч гэсэн сэнснүүд хэвийн ажиллагаанд орж тэгээд л цахилгаан бага хэрэглэсэн нь тэр. Гэтэл Адъяа энэ сорилтыг, хэмнэхийн тулд шинэ санаачилга гаргасан гээд машинуудын цахилгаан багтаамжийн зайн хуваарийг шинэчилсэн гэж ярьсан юм. Нэгэнт ийнхүү хэлчихсэн болохоор хэргийг задалж орхивол засварчдын урам нь хугарч ажлаа үнэлж үзсэнгүйд тооцож бас ч намайг атаархсандаа нэгнийхээ мууг үзлээ гэж санах ч хүн гарч магадгүй байв. Ингээд л би амиа бодоод үлдчих нь тэр дээ. Адъяа ч шинэ санаачилга гаргаж, ажилд шуурхай хандсан нэр олоод сар ч хүрээгүй байтал өөр цехийн дарга болж удсан ч үгүй үйлдвэрийн ерөнхий инженер болчихсон юм даа. Бидний гол нэг дутагдал маань хэн ч гэсэн хийх ёстойгоо хийлгүй заншчихсанд л байна шүү. Сандал уначихсан хэвтэж байхад босгоод тавьчихсан хүн шинэ санаа сэдэж, ажил хийсэн нэр авч байна. Бид ч тэр, ажилчид ч тэр ялгаа алга. Найз минь, харамсах юм гэвэл энэ л болоод байна.

Намайг чи бүсгүй хүн болохоор одоо л хамаг юмаа дэлгэж бие биенийхээ нүгэл хилэнцээ уудлах нь гэж битгий бодоорой. Чамайг санаж мөрөөдөж, сэтгэлдээ хий хоосон хүсэн хүлээж, түүгээрээ өөрийнхөө зүрхийг тэжээн баярлаж, өөртөө гомдож, бас дахин сэтгэл тэнийж явснаа би нуухыг хүсэхгүй. Одоо чамд үүнийгээ хэлэх эрхтэй гэж би бодож байна.

Тэгээд яалаа. Аа тийм. Адъяа бид хоёр зэрэг шахуу дэвшиж дээ. Би түүний оронд цахилгааны инженер болчихлоо. Ажил их. Хаанаасаа гараад байгаа эх нь үл мэдэгдэнэ. Бухимдах, ширүүн үг хэлэх бишгүй гарна. Адъяа яагаад тэгж эв дүйгий нь олоод байсан юм бол. Нэг өдөр гүйцэтгэх цехийн дарга над дээр ирлээ.

- Дамжлага бүрэн биш байдаг, яавал дээр вэ Дэлгэрмаа, уг нь та нартай холбоотой нэг ажил ч дарагдаад бараг хагас жил болж байна гэж миний янзыг үзэх гэсэн мэт тэр хүн үгээ зөөн байж хэлэв.

- Та Адьяаг байхад хэлсэн үү?

- Хэлсэн

- Яаралгүй багтай сайн бодож үзье. Одоохондоо би нэг зүйл үйлдвэртээ нэвтрүүлэх санаатай оролдоод... гэсэн.

Үнэндээ тэр Адьяад оролдсон юм огт байгаагүй л дээ. Бид зогссон дамжлагыг шалгаж үзвэл гадаадаас сэлбэгээ авдаг машин байлаа. Машины дулаан тохируулагч нь шатжээ. Сэлбэг нь Англиас ирсэн боловч хүчдэл нь тохирохгүй байж. Тэгээд л уг тохируулагч агуулахын буланд хэдэн сар тоосонд булаастай хэвтчихсэн байв. Үзвэл хүчдэлийг нь тохируулж болох байлаа. Хийц нь нарийн боловч бидний мэдэх жирийн л юм. Энэ тохируулагчаас болж би тэр удаа үхтлээ ичиж билээ. Чухамдаа үүнээс хойш Адьяагаас болж шүү. Хүчдэл бууруулах трансформатор хийх гэж бүтэн долоо хоног боллоо. Шатсан трансформаторын гол олж ороомгийг тооцоолон ороогоод хэд хэд шалгасны дараа тохируулагч ч хэвэндээ ажиллаж эхэллээ. Гэтэл нэг өдөр ерөнхий инженер биднийг цуглуулж цехнийнхний өмнө намайг магтаж гарлаа. Бараг техникийн шинэ нээлт хийсэн юм шиг ярихад нь би нүүр хийх газраа олж ядахдаа:

- Нөхөдөө. Адьяа намайг сайн таньдаг болохоор надаар зүгээр л тоглож байна. Энэ трансформаторы чинь Балдан гуай бид хоёр хийсэн юм шүү. Үнэндээ Балдан гуай л хийсэн юм гэж хэлэхэд:

- Тэгж ярихгүй. Бид шинэ санаачилгын комисст илтгэнэ. Чи ч өргөдлөө бич. Шагналы нь олгоно уу гэж бичихээ мартав гэж албархуугаар хэлээд гараад явчихдаг байна.

Миний уур хүрсэн гэж. Даанч, хүнээр ингэж тоглох гэж байх уу. Инженерийн хувьд хийх ёстой юмаа хийж байхад ингэж зориуд дэвэргэсэн нь намайг доромжилсон хэрэг байлаа. Гэвч түүний ийнхүү сүр бадруулан ярьсан нь өөрийнхөө урдах гэмийг булах гэсэн арга байсныг би хожим нь мэдсэн юм.

Адьяаг харахад нуруу чацархаг, зүс царай тэгш, инээх нь аялангуй, ер түүнээс өөлөх юм үгүй, хэн ч харсан нүдэнд дулаахан залуу. Гэвч түүний алхах гишгэх бүр нь илбэдэх мэт хуурмаг байгааг мэдэх тусам ажил хийх сонирхол минь улам багасгах шиг болно. Ийм хүнийг дэвшүүлж байдаг дарга нарыг бодохоос л тэд бүгдээрээ Адьяатай адил хүмүүс шиг бодогдож юунд ч энд ирлээ дээ гэж санагдах үе ч гарна.

Хэрэв манай Балдан гуай шагнуулаагүй бол, гүйцэтгэх цехийн нэг машин эвдрээгүй бол би энэ үйлдвэрээс явчихсан байж мэдэх юм. Намайг амралтаар яваад иртэл өнгөрсөн сарын үйлдвэрийн төлөвлөгөө 10 шахам хувиар давсан сайхан мэдээ үүдэнд хадаастай харагдаж, манай цехийнхэн ч сайшаал магтаалын үг сонсож зарим нь ч бүр шагнал авсан байлаа. Цахилгаанчдаас Балдан гуай маань шагнал хүртсэн дуулдлаа. Би энэ хүнийг хайрлаж «а» үсэг ч уншиж мэдэхгүй мөртлөө цахилгаанчны энэ мэргэжлийг гайхамшигтай эзэмшсэний нь учрыг олох гээд чадаагүй юм даа. Гэмтлийг зургаар хараад ер мэдэхгүй. Зүгээр л тээстрээ «цахилгаан хэмжигч бага» бариад гарахаараа надаас түргэн олчихно. Яарч сандарсан үед Балдан гуай л аминд орно. Тэвдэхээрээ хамрын нь хөлс бурзайна. Тэр үед нь юу ч асуугаад

нэмэргүй дуулах ч үгүй, дууллаа гэхэд хариу хэлэхгүй. Нөгөө гэмтлээ олох гээд олсон бол засах гээд хэдэн цагаар ч сууж мэднэ. Гэм нь жаахан гэжүүд. Санаандаа таараагүй юманд хуруугаа ч хөдөлгөх дургүй. Харин энэ удаа нэг л хачин юм болжээ. Балдан гуайг шагнуулсныг мэдээд баяр хүргэх гэж зориуд уулзсан минь санаандгүй юмтай тулгарчихлаа.

- Балдан гуай, танд баяр хүргэе. Та л манайхаас шагнуулсан байна гээд гар барих гэтэл

- Үгүй хүүхээ.. Дэлгэрмаа... Аан би ч шагнуулсандаа.. гэснээ гараа дуртай дургүй өглөө. Би эхлээд гайхсанаа тэр дороо л хөгшний нь биеийг асуучихлаа. Балдан гуай ч

- Манай хөгшин сайн шүү. Харин уржигдар орой халуун саваа хагалчихсан. Тэгээд... гээд түгдэрсхийснээ... хүүхээ чамтай би нэг уулзъя гэв.

Балдан гуай хувцасны шүүгээнээсээ цаасанд боодолтой зүйл аваад өрөөнд минь орж ирээд хоёулханаа байсанд их л аминчлан

- За инженер минь би ч буруу юм хийгээд л шагнуулчих шиг боллоо доо гээд боодолтойгоо задлахад халуун сав, нэг зурагт номын хамт байв. Би гайхсандаа

- Юу ... гэснээ яамай даа халуун саваар шагнаа юу. Та хагалчихсан гээ биз. Одоо үүнийгээ аваачаад өгчих гэв.

- Харин дээ хүүхээ. Би өчигдөр аваачих гээд л бас л болж өгөхгүй оргиод

- Яагаад

- Ерөнхий инженер маань хоёр машины автомат салгуулаад цахилгааны нь машинтай шууд холбуулчихсан шүү дээ. Одоо ч хөөрхий дүнгэнээд л байна. Энэ зөв юм бол ч муу Балдан гуай нь энэ халуун саваа гэртээ аваачнаа. Хүүхээ, Чи л хэлж өг, би чамайг хүлээгээд л сууж байна. Эндээ гэхэд нэг л буруу юм шиг санагдах юм.

- Та тэр холбосны төлөө шагналаа гэж бодоод байгаа юм бол, таныг би түүний бурууг мэдсэний чинь төлөө энэ зүйлээр чинь шагначихаж болно биз дээ.

Энэ ярианы дараа би шууд ерөнхий инженерийн өрөө рүү гүйхээрээ очлоо. Орох гэтэл яг өмнөөс минь Адъяа гарч ирснээ намайг хараад сонирхсон шинжтэй үг ч дуугарахгүй зогсчихов.

- Та чинь яаж байнаа

- Аа, яаж байна? Таныг харахад би зогсож байгаа биз

- Тийм байна. Түр зогсчихоод, тогтонги ус шиг ялзарч..

- Хн.. өрөөнд ор л доо , та

- Та хэд хэдэн машины автомат..

- Аа тэр үү. Тэр яах вэ. автоматын зарим нарийн сэлбэг алга. Түүний чинь хүлээвэл төлөвлөгөө..

- Мэдэж байна. Энэ сард техникийн бүрэн ашиглалтаас төлөвлөгөө биеллээ гэж та яриа биз дээ.

- Би таныг бүсгүй хүний чинь хувьд хүндэлж үзээд энэ ялыг чи өөртөө авья.

- Машин эвдэрвэл та өөрөө машин болох уу?

- Би толгойгоороо хариуцна

- Танд хариуцлаганд дэнчин тавих юм бий гэж үү?

Ингэж хэлчихээд цехийн машинуудыг шалган үзээд шууд холболтыг тасалж зогсоогоод хэзээ ч сэлбэг ирсэн цагт машиныг ёсоор нь ажиллуулмаар санагдав. Гэвч би тасалж чадсангүй. Шууд холболтыг тасдахад утас биш өөрийгөө л энэ машинаас, энэ үйлдвэрээс, энэ хүмүүсээс тастан хаячих гэж байгаа юм шиг бодогдоод, хэрэв тастлаа гэхэд энэ ажилчин, энэ хүмүүсийн бодол санааг мөн л тастаж, ажиллаж хөдөлж түүндээ хүсэл бодлоо өгсөн хүмүүсийн эсрэг ганцаараа зогсож, тэднийг хүндэтгэн үзээгүй юм шиг санагдаад ирэхийн үед өөрийгөө хий зэмлээд, эрх нь байдагсан бол бүх удирдлагыг солиод Балдан гуайгаар дарга тавьчихмаар ч бодол санаа урган ирнэ. Жаахан юм балгад халамцаад ирэхийн үедээ:

Инженерээ, би чинь хорь шахам жил энэ үйлдвэрийн судсыг барилаав шүү. Энэ үйлдвэр ч минийхийг барилаа. Хэн хэндээ өлзийгөө өгөөд бид хоёр чинь нэг судастай болчихлоо шүү дээ, хүүхээ гэж Балдан гуай үе үе ярина. «Нэг судастай» гэдэг энэ үгийг одоо л би эргэцүүлэн бодож сууна. Ажилчин хүн машин техниктэйгээ нэг судастай болохгүй бол ажлын тухай яриад ч хэрэггүй юмаа. Ийм суутал засварын цехийн нэг ажилчин орж ирүүтээ:

- Та нэг машин үзээч. Ерөнхий инженерийг явж байхаар нь үзүүлтэл би цахилгааных биш автотехникийн инженер гээд хавьтуулсангүй, хачин юм даа гэж хэлчихээд гараад явчихлаа.

Адъяа яагаад ийм үг хэлдэг байна. Мэдэхгүйдээ бантаад амь нь тэнцэхдээ ийм үг хэлсэн нь миний хувьд ил байсан юм. Гэхдээ энэ чинь намайг, энэ үйлдвэрийн бүх ажилчдыг шууд басамжлан тохуурхсан хэрэг юм. Цахилгаангүйгээр автотехникийн тухай ярина гэдэг инээдэмтэй, тэгээд ч бүр ичгүүр сонжуураа алдаж улаан цаймдаа гарсных. Ийм ч ерөнхий инженер байх гэж. Энэ чинь үсгээ мэдэхгүй байж уншина гэсэн хэрэг. Эсхүл ус уусаар байгаад цангаж үхлээ л гэсэн үг юм.

Энэ хэрэг над гэнэт нэгэн бодол төрүүлсэн учир би хэнтэй ч зөвлөлгүй шууд үйлдвэрийн дарга дээр орж Адъяагийн тухай мэддэг бүхнээ урсгаж гарлаа. «Адъяа ямар ч буруу байхгүй, бид бүр онцолбол би гэдэг хүн энэ хүний хамаг алдааг мэдсээр байсан хэрнээ хэлж засалгүй байсаар ийм байдалд хүргэчихлээ. Түүнд буруугий нь хэлээгүй маань амьдралаа, үйлдвэрээ ажилчдаа хууран мэхлэхэд хүргэж байна. Би буруу бодож байжээ. Би алджээ. Над л хамаг буруу байна».

Маргааш нь үйлдвэрчний хорооны дарга намайг дуудлаа. Тэр тун залуу, гэлээ ч ажилсаг чамбай хүн дээ.

Адъяагийн тухай дууллаа. Чи асуудлыг тун зоригтой шударга тавьсан байна гэж намайг талархан хэлэхэд над нэгэн бодол зурсхийн орж ирлээ.

Үнэн юмыг үнэнээр нь хэлэхэд зоригтой хүн болчихдог нь аймшигтай байлаа. Сэтгэлд нэгэн яруу найрагчийн шүлэг эргэлдэж, үнэнээ ярихын тулд ихээхэн зориг зүрх гаргаж байсан ямар ч янзын хүмүүс байж вэ дээ гэж хойч үе маань гайхах байх даа гэсэн санаа нь бууж ирлээ. Би үүнийг хэлмээр байтал тэр хүн өөрөө ч тэр зуураа бодоод олчих шиг санагдсан учир олон юм ярьсангүй.

Хожим хэдэн сарын дараа намайг дуудсан хүн намын үүрийн дарга байлаа. Жирийн юм ярьж эхэллээ. Гэр орон, ах дүү, таньдаг нөхөд. Тэгж байснаа:

- Өөрийг чинь бид ерөнхий инженерээр ажиллуулах бодолтой байгаа юм. Үүнийг юу гэж үзэж байна гэлээ. Би тулгамдсандаа шууд хариулж амжилгүй, амьсгаа аваад:

- Би их баярлаж байна. Намайг хариуцлагатай ажилд итгэж ажиллуулах гэсэнд. Гэхдээ энэ итгэл зөвхөн ганц таны ч байсан би энэ ажлыг хийж дийлэхгүй гэв. Бид бие биеэ үе үе харж хэсэг зуур дуугүй суутал:

- Тиймээ, итгэл... Зарим хүмүүс олны энэ итгэлийг ганцхан өөртөө л зориулах гэж оролддог юм. Бид залуус та нарт итгэдэг. Итгэхгүй бол энэ үйлдвэр, улс орон маань ч дэвжиж дээшлэхгүй. Та бид хоёр ч энэ тухай энэ өрөөнд ингээд яриад сууж байхгүй шүү дээ. Адъяа бол та бидний итгэлийг түрийвчиндээ хийчихсэн байна. Түүний хэлсэн бүхэнд бид итгэж байсан. Энд хяналт шалгалт суларсан тал бий боловч бас учир бий. Ийм хүмүүс байдгийг бид бас мэднэ. Гэхдээ би итгэсээр л байх болно гэж намын үүрийн дарга хэлээд «өөртэй чинь дахин уулзана» гэлээ.

Итгэл. Энэ үг огцом богино сонсдоод зүрхний минь цохилттой хэм нэг бол сэтгэлийн гүнд аянга мэт нижигнэн байгааг одоо би мэдэрч байна. Би чамайг хүсэн хүлээдэг байсан боловч итгэдэггүй байж дээ. Чи ч бас над итгэсэнгүй. Чамд би «хайртай» гэж хэзээд ч хэлээгүй. Чи тэр үгийг хэлээд байсныг би мэднэ. Гэвч чи над итгэсэн бол ганц л харцнаас минь энэ үгийг олж болох байсан. Магадгүй би энэ үгийг хэлж чадаагүй байж ч болох юм.

Эрхэм найз минь. Чамд энэ захидлыг яаралтай явуулах гэтэл бидэнд хүнд зовлон тохиолдож саатсан болохыг хэлмээр байна. Балдан гуай маань бараг гэнэт л биднийг орхин одлоо.

- Дэлгэрмаа, хүүхээ чи.. ерөнхий инженер болчихвол муу Балдан гуайгаа мартчих байх даа гэж гомдонгуй атлаа өрөвдөм сулханаар өгүүлэв. Яриандаа болоод тамирдаж байгаагий нь би мэдээд:

- Би ерөнхий инженер болохгүй. Тэгэхээр таныг мартажгүй дээ. Тэгээд ч хүн мартчихдаг хүнийг дэвшүүлж болдог юмуу гэснээ орны нь урдуур унжсан хөгжлийн үзүүрийг өргөж засуугаа. Та хэвтвэл зүгээргүй юу гэлээ.

Балдан гуай ядарсан нь илт байлаа. Духанд нь хөлс чийгтэй дааварлаж, бие барьснаас зүүн гарын хуруунууд нь үлмэдэг чичирхийлж, санчигны судас нь хүчтэй түргэнээр лугшин гүрвэлзэж байгааг харахад ямар нэг амьтан амь нь тэмцэн цовхчиж байх мэт. Өвгөн чичирхийлж байгаа зүүн гараа барьж базлан:

- Би ч бүр зөнөчихөө юу дээ. Яалаа гэж чи намайг мартаж вэ, тэр үнэн шүү гэснээ хоолойгоо засаад ямар даргатай байхаа бид чинь мэднэ шүү хүүхээ. Муу Балдан гай нь дор хаяад л ерөнхий инженерээр ямар хүнийг тохоон томилохоо мэдэх л хүн дээ гээд яльгүй инээвхийлэх төдий болов.

Гэрт нь ярилцсан энэ яриа бидний хамгийн сүүлчийнх байсан юм. Гэхдээ энэ хүн намайг тохоон томилсныг би сайн мэдэж байна. Намын үүрийн даргатай дахин уулзахдаа би үүнийг дурсан ярилаа.

- Тиймээ, бид бүгдийн санал бодол байгаа юм гэж тэр хүн хэлж билээ. Тэгэхэд нь

- Хэрэв миний саналыг асуувал би их засварын мастер Пэрэнлэй гуайг л энэ ажилд томилно доо гээд харин Адъяа маань хаана ажиллах юм бол гэж асуучихлаа

- Эндээ

- Дургүйцэх болов уу?

- Дуртай дургүй ч заавал энд ажиллуулна. Зангий нь мэдэхээрээ бид тэр хүнийг харж байна. Өөр газар оччихвол бас л..

- Тийм дээ..

Хэд хоногийн дараа ерөнхий инженерээр түр томилогдсон хүн нь Пэрэнлэй гуай байлаа. Энэ хүн дээд сургуулийн диплом, тэмдэгтэй боловч амьдралын их сургууль төгссөн бидний багш хүн юмаа. Миний саналыг дагаагүй нь мэдээж боловч хамт олныхоо бодолт ойртон очсондоо би дотроо баярлаж байна. Ингээд би ерөнхий инженер болоогүй юм даа.

Захидлынхаа төгсгөлд чиний хүсэж хүлээж байсан тэр үгийг одоо л би чамд хэлж чадах байна. «Чамд би хайртай тиймээ, хайртай». Энэ бичсэнийг минь хань ижилдээ уншиж өгөөрэй. Тэр хүн намайг танихгүй ч гэсэн энэ үг эмэгтэй хүн, найз нөхрөө хүндэтгэн хайрласан жирийн сайхан сэтгэлийн ариун үг гэдгийг ойлгоно биз ээ.

Хариу захиа хүсэхгүй байгаа минь энэ захидлын хариу болж байгааг чи битгий мартаарай.

Дэлгэрмаа 1974 он

БАТЫН НЯМАА

Зохиолч Б.Нямаа 1928 онд Хэнтий аймгийн Батиширээт сумын нутагт төржээ.

1942 оноос уран зохиол сонирхон оролдож “Гомпил”, “Хамаатан садан”, “Анхны жил” тууж, “Араараа модтой Биндэрьяа” “Бид гурав”, “Арандалынхан” роман, “Төөрсөөр төрөлдөө” кино, “Нэр төр”, “Нүд” зэрэг драмыг жүжиг бичжээ.

Б. Нямаа шилдэг бүтээлээрээ Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртжээ.

ТӨРИЙН ХУУЛЬ

Өвгөн Балбар хашин зээрдээ эмээллэж хуучин гар борцоо ганзгалаад «Ай хөөрхий. Данхар толгойт, далай нөхөөст нэр минь бид гурав ч хөг нь өнгөрч дээ гэж толгой сэгсрэн өгүүлэв. Эмгэн нь дайзтай сум авчирч өгөхдөө:

- Яасан ч хэрээ мэддэггүй өвгөн бэ дээ чи. Хар гөрөөс намнана гэж ганцаараа хөвч зүглэснээс Ононгийн эргээр муу дэгээгээ чирээд гэлдэрч явбал ашгай юу гэжээ. Өвгөн нь:

- Түй харалмар. Эр хүний явдалд битгий оролц гэж эс хэллүү чамд. Хөвчид баавгай олширч, хандгай буга идэж байгааг сонсоод би зүгээр суух хэрэг үү

- Дал хүрсэн чи л хар гөрөөс цөөрүүлдэг нь болоо юм биздээ. Гай болж мориноосоо ойчвол ч яах юм билээ. Өмх яс чинь хуурай мөчирөөс амархан хугарна шүү дээ

- Ан гөрөөнд мордох гэж байхад билэггүй юм бүү донгос. Хөвчөөр тэнэх завгай хүн надаас өөр хэн байгаа юм бэ. Түй харалмар. Гэрийн мухар сахиж, цай гүзээлсээр байгаад хамаг бие минь улцгар хөх зовлого болж гүйцлээ. Анч Балбар өтөллөө ч гэсэн үхсэн мах бишээ. Хээр гарч хийморио сэргээх ёстой гэв. Өвгөн чухам мордох үедээ муу хөгшнөө арай ч дэндүүлэв үү дээ гэж бодоод сэтгэлийг нь засан зөөлөн үг хэлэхээр шийдэв.

Гэсэн ч тийм үг ололгүй гайхаш тасран зогссоноо:

- Хөгшөөн хүрэгч үнээний чинь дэлэн хавдсан гэлүү. Би чамдаа Баавгайн савар авчирууж. Чи маажиж домноорой гэж аль болохоор аятай зөөлөн хэлжээ.

Балбар гуай залуугийн цагт буу үүрээд гарахдаа «хөгшөөн чи тогоогоо тавьж байгаарай. Би нэг гур үүрч ирэх минь» гэдэгсэн. Балбар шиг ингэж хэлсэндээ хүрдэг бол ч бардам ам илүүдэхгүй шүү гэж манай нутгийнхан ярьцгаадаг байлаа. Аглаг зэлүүд газар хүрч ирэхдээ өвгөний хийморь үнэхээр сэргэжээ.

Ай хөөрхий, мөнх ногоон хангай, мөнгөн цагаан сарьдгууд минь гэж залуудаа сонсож байсан бөөгийн дуудлагаас шивгэнээд чиний хээр өвөр суган дор ядаж арван жил гөрөөлөх юмсан гэв.

Гэрээсээ дагуулж гарсан хэрмэн цоотгор гэдэг нохой нь чандага хөөгөөд явчихсан үед өвгөн, овгор хар бутан дээр ихэмсэг хэвтэж байгаа том гэгчийн баавгай олж үзэв.

Мөн ч лут эд юм. Жинхэнэ шар маахай гэдэг чинь энэ дээ. Тэгээд хорин дөрөвдөх минь болно шүү. Тиймээ, хорин дөрөвдөх гэж өгүүлэн морио бургасны мөчирөөс уяж, бойтог гутлаа тайлж хаяад сүлжмэл ноосон оймстой хөлөө зөөлөн гэгч зөөж тависаар дөхөв. Буун дуугаар шар маахай ухасхийн босож, газар доргитол хашгирснаа хар эрчээрээ дайрч ирэв. Буу, хоёр дахин тасхийсэн боловч баавгай ойчсонгүй. Харин агшин зуур өвгөнийг үслэг том савраараа дарав. Балбар гуай, амьсгал давчидах зуур соёо нь ярзайсан аймшигт том амнаас эвгүй муухай үнэр ханхалж байхыг мэдэрчээ. Энэ хүнд мөчид цуут анчны ухаан самбааг үзүүлж, хутгаа сугалахыг оролдтол баавгай огцом хүчтэй чарлаад өвгөнийг орхиж эргэв.

Балбар гуай, өндийж харвал хэрмэн цоотгор нь хүчирхэг араатны ууцан дээр хачиг мэт наалдчихаад чадлын хирээр хазаж, шархтсан баавгай, тоос манаруулан эргэлдэж байлаа. Энэ үеэр үнхэлцэг нь хагарах шахсан зээрд морь, бургасны мөчрөөс цулбуураа суга татаад хар борцоо далбагануулан давхиж одов. Өвгөн, буу руугаа ухасхийх гэсэн чинь хөл нь хөндүүрлээд хөдөлж болсонгүй. Хэрмэн цоотгор, баавгайн нуруунаас үсэрч буунгуугаа буруулан зугадаж, эзэндээ тулгарсан аюулыг холдуулж чадлаа.

Анчин өвгөн хэрмэн цоотгороо хөтлөөд таяг тулж ой тайгаар хэдэн өдөр мацлаа. Хүйтэн булгийн уснаас гэдсээ цүдийтэл залгилаад, түр амсхийх зуураа «Би ер нь бүх насандаа ингэж өлссөн бол уу» гэж бодов. Аа тийм. Архангелийн татлаганд очоод иймэрхүүгээр өлссөн юм байна. Үүнээс өөр огт үгүй гэж шивэгнэнэ. Хэрмэн цоотгор, ямар нэгэн ан айсууг ажигласан бололтой чихээ хөдөлгөж өндөлзөв. Балбар гуай, цоотгорын толгойг хормойгоороо хучаад буугаа бэлтгэтэл унанги мөчир хуга гишгэсээр нэгэн гайхамшигт амьтан өмнө нь хүрч ирлээ. Сайхан хангал буга, ногоон нүдээ гялалзуулан суниагаад сөөг бургас гам хайргүй мөргөж эхлэв.

Цусан эвэр чинь загатнаж байгаа биз дээ. Гэнэхэн хонгор минь долоовор хуруугаа хөдөлгөх төдийгөөр дор чинь хэвгүүлээд, тастан огтчин идчих тийм хүчтэний өмнө байгаагаа мэдэж байна уу. Чиний оронд муу улаандай, ядаж өмхий хүрэн ч байсан бол гэж өгүүлтэл хэрмэн цоотгор нь хуцан архираад цочсон буга, хажуугийн төгөл рүү цойлов харайв.

Хоёр гөрөөчид гунхан ганхан сажилсаар эртний нэгэн марааны дэргэд хүрч ирлээ. Балбар өвгөн, дагуулынхаа толгойг хормойгоор хучаад мараа сахиж шөнөжин суужээ. Адтай муу өлсгөлөн, Архангелийнхаас лав хоёр дахин илүү болж дээ гэж бодов. Үүрээс өмнөхөн ямар нэгэн амьтны бараа тормолзоход нуухтай нүдээ арчиж ажигласаар буугаа шагайв. Гар нь чичирч бууны нь ам жингийн годил шиг савлаж буйг мэдээд дэргэдээ ирүүлж байж туршихаар шийдэв. Архайж дархайсан хоёр хандгай, бараг эгц дээрээс нь өнгийн зогссонд өвгөн шүлсээ гүд хийтэл залгиснаа уур цухал нь гэнэт дүрсхийж:

- Үхлээ эрсэн гайхлуудаа нүднээс далд ор гэж хашгирав.

Тамир нь барагдсан өвгөн, сүүлчийн ганц сумаа гунигтайгаар ширтэнэ. Хичнээн ч шувуу, бор гөрөөсөнд тургив даа. Тэгээд шалбалж ч чадаагүй шүү. Доройтол гэдэг мөн ч бэрх юмаа гэж хоолой чичрүүлэн үглэв. Цог шиг улайсан нүдээ эргэлдүүлэн, омголтож хатсан уруулаа хөдөлгөж үхье үү, амьдрая уу гэж бодсоноо амьдрах ёстой. Яалаа гэж үхэх билээ, гээд хашгиран босох гэсэн нь сохор номингийн шороо үмхээд ойчжээ. Тамиргүй гараараа газар тулж дахин өндийгөөд хөөрхий нохойгоо улангассан нүдээр ширтэж хирчигнэн өгүүлрүүн:

Би сэтгэлт хүн учраас амьд үлдэх ёстой. Аврагч минь чи, дахиад авар. Мэдэвүү. Дахиад намайг авар. Тэгэхдээ амь насаараа авар гэлээ. Хөөрхий цоотгор эзнээ эгц ширтээд алжаангуйгаар эвшээв. Энэ өвгөнд үнэн зүрхнээсээ зөвшөөрч «За» гэх шиг санагджээ.

Би чинь сэтгэлт, жаргалт хүн учраас л ингэх ёстой. За чи минь цаашаа хараач дээ. Над руу бүү ширтээч, ухаалаг нүд чинь хичнээн өрөвдөлтэй байгааг ойлгооч гэж бувтнаад нохойгоо дахин ширттэл өмнө нь гурван цоотгор бүртэлзэж, газар дэлхий ногоон өнгөөр туяарав.

Анчин, эцсийн хүчээ гаргаж, ширэнгэт гацаа руу заагаад «туу, туу» гэж шивгэнэлээ. Ядарч туйлдсан цоотгорын анч авьяас сэргэж, эзнийхээ заасан зүг рүү эргэж хуцтал буу тасхийжээ.

Амьсгаадан уухилсан моридын хамар, толгой дээр нь паржигнаж хүчирхэг хэдэн гар өвгөнийг хийд өргөн авав. Балбар гуай нүдээ алгуур нээж, толгой сэгсрэн:

- Та нар ялимгүй хожимдож дээ. Даанч ялимгүй гэхэд нь

Морь чинь сая очсон шүү дээ. Тэгээд л бид хожимдчихлоо. Гэсэн ч таныгаа амьд мэндэд чинь олсондоо бид баяртай байна. Хэрэв буун дуу сонсоогүй бол олохгүй өнгөрч ч мэдэх байсан гэж цаадуул нь хариулав.

Балбар өвгөн арваад хоног хэвтээд тэнхэрч билээ. Турж үхэхийн туйлд хүрчихээд байж хажуудаа ирсэн хандгай буцаана гэдэг чинь мөн ч гайхалтай хэрэг. Үхэх нь байна шүү дээ. Сэвсэн дээр чинь уйлах үр ачгүйсэн бол бас ч яая гэхэв гэж эмгэн нь хатуу зэмлэжээ. Өвгөн, нударга шиг том модон гаансаараа дохиж занган сүрдүүлээд:

- Түй харалмар. Төрийн хууль гэдэг чинь Балбарын амьтай чацуу юмуу. Би өлсвөл зөрцөнө гэж тэр хуулийг чинь батлаагүй. Дахиад ингэж бүү дуугар гэжээ.

ЧОЙЖАМЦЫН ОЙДОВ /1917-1963/

Жүжгийн нэрт зохиолч агсан Чойжамцын Ойдов Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт малчны гэрт төржээ.

1939 оноос уран бүтээлээ эхэлж “Долоодой хүү”, “Төрсөн нутгийн баяр”, “Зам”, “Жаргалыг хүссэн Мөнхөө” драмын жүжгүүд “Их жанжин Сүхбаатар танаа”, “Баясгалан” кино зохиол “Эв зүй”, Чөтгөртэй бууц” зэрэг олон өгүүллэг найруулал бичжээ.

Ч.Ойдов БНМАУ-ын төрийн шагналыг 1947 онд хүртжээ.

ДАВХАР МАЙХАНД

Өвөл цаг билээ. Тэнгэр бүрхэг, хачин сүүмгэр өдөр би... сумын төвөөс 8 дугаар баг хүрэхээр өртөөний тэмээгээр мордов. 8 дугаар баг бол тус сумын хамгийн ойрхон бөгөөд саадгүй явбал нартай байхад хүрчих газар юм. Онд тарган орж байгаа сайхан улаан тайлаг, зогсолтгүй зогдор хөдөлгөж байв. Ширээ хоёр бөхний нь хооронд би ч тавтай гэгч нь сууж, даарсан нүүр хацраа сахлаг ноостой бөхөнд нь хааяа хааяа хүргэн жигнэхэд сайхан гэдэг нь аргагүй байлаа.

Миний хүрэх газар, цэлмэг өдөр ойрхон харагддаг олон жижигхэн хөх уулс, өнөөдөр бараа туруу нь ч алга. Ганцхан тэр чигт чий гэж тааварлан хоёр их нурууг тусгаарласан өргөн хөндийг туулж явлаа. Өтгөн цас хаялж эхлээд салхины хүч ихдэв. Нэгэн жигд зөөлөн аятай тэшиж яваа тэмээн дээр анхандаа аятайхан санагдаж явсан маань замын уртад сэтгэл нэг л уйтгарлаад ирлээ. Тэгээд урьд хэзээ хаа ч тэгж дуулж үзээгүйгээ үзье гэсэн мэт хоолойныхоо бүх чадлаар, сөрөх салхины сэнгэнэхтэй уралдан дуулж явав. Миний хоолой тийм ч муу биш шиг санагдаад, улам гарган дуулья гэтэл гэнэт паг гэтэл зогсоход, эзгүй хээр ганцаараа инээд алдаж билээ. Миний явдал инээд биш ханиад болоод байжээ. Өргөн хөндийг туулсны дараа дайралдвал зохих хуурай саарийг яасан хол болчоов гэж бодож явсан юм. Гэтэл хуурай саарь биш түүний эх болох, үерийн усанд идэгдсэн өндөр эрэгтэй ганга дайралдахад хазайж буруу тийшээ явчихсанаа мэдэв. Би барагцаалбал чиг замаасаа 15км хазайжээ. Нар нэлээд орой болж байв. Салхи улам ширүүсээд шуурга тавьж эхлэв. Та бүхэн говь нутгийг мэднэ шүү дээ. Ийм өдөр явуулын хүн байтугай, нутгийн хүн ч төөрдөг. Ингэхээр над 8 дугаар баг хүрэх төлөвлөгөөгөө шууд орхиод хаа толгой хоргодож хонох билээ гэдгийг бодож олох амин чухал явдал тохиолдов.

Говь нутагт айл эрэх бас л хэцүү, үргэлжилсэн сархиа уулсын аль аманд нь бий гэж мэдэх вэ. Нутгийн хүмүүс бол малын мөр хаанаасаа хаашаа одсон, хэнийх хэдийд хаа нутагладаг зэргийн сайн мэддэгээс гадна утааны үнэр, нохойн дууг анддаггүй, сонор соргоогоороо олдог юм билээ. Над тийм дадлага байсангүй тул айл олно гэдэг итгэл ч бага байв. Гэвч яваад байлаа. Хичнээн явсныг бүү мэд, Бүр шөнө болчихоод, унаж яваа тэмээний толгой харагдахгүй болов. Сайхан улаан тайлаг маань хамгийг бүрхсэн харанхуйг хагалах мэт миний залсан зүгт л яваад байлаа. Гэтэл хамрын сонорт нэг юм үнэртэх шиг болов. Танил сайхан ч үнэр шиг, утааны үнэр ийм байдаг болов уу гээд тэмээгээ зогсоогоод, дахин дахин үнэртэхэд сүүлдээ тэр үнэр огт байхгүй болчих шиг болов. Газрын баримжааг би хэдийнээ алджээ. Хаашаа ч явсан хамаагүй мэт санагдаад юу боловч салхины өөд жаахан яваад үзэх юм биш үү гэсэн бодол төрж тийш нь тэмээгээ зүглүүлбэл дуртай гэгч нь эргэв. Тэгэхээр нь над нэг сохор горьдол төрж билээ.

Анхандаа газрын өөд яваад байх шиг байв. Цас нүүр нүдгүй лавшин шавах тул аргагүйн эрхээр анивалзан онилзон явлаа. Ер нь өнөө шөнийн харанхуйд харж явсан, аньж явсан хоёр адилхан байсан юм. Нэг хэсэг явсны дараа салхины хүч эрс багадаад тогтуун болоход нүдний үзүүрт галын гэрэл сүүмэлзэх шиг болов. Баярлах, үл итгэх хоёр зэрэгцэн дахин сайтар харвал үнэхээр гал дүрэлзэн ноцож байх нь түүдэг гал шиг санагдаж билээ.

Ойртон очоод харвал түүдэг гал биш, майхны амаар улалзсан тулгыг галыг би тэгж харжээ.

Урдуур хойгуур боргон хуцах нохойг олж харахыг хичээвч огт харагдахгүй, шидтэй албин мэт аль хазайсан зүгээс хоргоож, тэмээг минь үргээлээ. Майхны задгай амаар нь түгсэн гэрэл, орчин тойрныг дэнгийн гэрэл мэт сулхан улаан гэрлээр сүүмэлзүүлж байлаа.

Майхны үүдэнд хэдэн тэмээг ачаанаас нь уяж хэвтүүлсэн нь хэзээ хэрэгцээт цагтаа бэлэн хэрэглэдэг бэлтгэлээсээ өл хоол залгуулан, тайван хивж байв. Би нохойны хоргоон хуцахыг үл хайхран, тэмээгээ хэвтүүлээд бууж байхад майхны том амыг халхлан гарч ирж байгаа лут эрийг ажиглаад яагаад ч юм бэ айх сэтгэл төрж байв.

Тэр хүн, хойлоог, хойлоог гэж хүнгэнэсэн бүдүүн дуугаар нохойгоо дуудан хориод, майхныхаа үүдэнд зогсож байгаа нь ямар нэг хүчит баатар эрийн төсийг санагдуулав. Би тэр хүний царай зүсийг сэтгэлдээ таамаглан, майхны зүг явж байхад өтгөн хар хөмсөгтэй, ширүүн дориун нүдтэй, үг дуу цөөтэй, аймаар муухай эр санагдаж байв. Энд салхины хүч ердөө алга. Харин хад уулын дээгүүр хүнгэнэн шуугиж байгаа нь нэг их хилэгнэсэн хүний амандаа битүүхэн занан зүхэх дуу шиг ажээ. Тэр хүн намайг угтан ирж:

Сайн явж байна уу гэж мэндлээд та ор гэсэн байдалтай гараараа дохиж майхандаа урив. Би түрүүлэн орлоо. Хоймор талд нь 14-15 насны хүү хөлөө хонин хөнжлөөр хучиж, нүүрээ гал руу хандуулан цамцтай цээжээ ил гарган унтаж байв. Сайхан унтаж байгаа энэ хүүхэд атаархмаар санагдав. Жижигхэн майхан дотор богц сав, дах, дэгтий, хувин сав тэргүүтнийг энд тэнд тавьсан нь эргэх чөлөөгүй мэт байвч би зайчлан сууж байтал нөгөө хүн орж ирэв. Миний таамаглаж байснаас шал ондоо нас нь 50-60 орчим болов уу гэмээр үрчгэр болсон нүүртэй, нэг их таньдаг хүн ороод ирэв. Хэн гэдэг билээ энэ чинь гэтэл нэр нь санаанд алга, аргагүй босон харайж:

- Төөрсөөр төөрсөөр төрөл дээрээ гэж харин таньдаг хүн дээрээ яваад ирдэг байна шүү гэтэл тэр хүн хаа үзсэнийгээ гайхан бодож байснаа

- Хүү минь чи яаж олж ирэв дээ? Гадаа ч хэцүү л юм болж байх шиг байна. Би ч давхар майхантай болохоор айх юм алга гэж миний ярьснаас огт өөр юм ярихад нь нэрэлхэхдээ:

- Утааны үнэхээр л олж ирлээ, ашгүй салхи тогтов уу даа гэхэд

- Залуу хүн ч мөн сонор соргог байх юм даа. Ийм цагт утааны үнэрийг олж мэднэ гээг их л хэцүү байдагсан. Манай энд ч яахав газар нь даанч давчуу болохоос биш гай нь бага гэж алдаршсан газар байгаа юм. Ямар сайндаа майхан гэж нэрлэх вэ дээ гээд сайхан амттай хээрийн хар цайгаар зочлохын хамт тогоондоо дахин ус хийж таваг дүүрэн махыг халаахаар үйгээд

- Бид байгалийн байгуулсан нөмөрхөн майхан дотор майхнаа бариад сууж байна даа. Юу алзах вэ гээд олон үрчлээ болсон нүүрэндээ хөгжилтэй гэрэлтэж байгаа нүдээр намайг харах нь яах аргагүй сайн таньдаг хүн байв. Гэтэл тэр хүн намайг таньсан шинж огтгүй ингэж ярьж байгаа нь хачин санагдаж билээ

- Та бид яах аргүй хуучин танилууд шиг санагдах юм. Чухам хаа танилцлаа. Нэр чинь хэн билээ гэдгийг олохгүй байна гэхэд

- Магадгүй ээ, би ч мартамхай гэдэг нь яг л нялх хүүхэд шиг амьтан шүү дээ гээд тогооноосоо мах гарган намайг дайлав. Заг модны илчит улаан цог майхан дүүрэн дулаан илчээр төөнөж тун аятайхан байв.

Өвгөн сониуч нүдээрээ намайг ажиглан харж байв. Би таана амтагдсан зээрийн мах идэж суухдаа энэ өвгөнтэй чухам хаа танилцсаныгаа бодож өөрийн амьдралын явсан суусан бүхнийг эргэцүүлэн бодлоо.

- Хүү минь чи чинь аль сумын хэний хэн гэдэг билээ дээ гэж өвгөн асуув

- Энэ аймаг бишээ. Би хангайн хүн, энд түр ажлаар ирээд байгаа. Намайг Батын Өлзийбаяр гэдэг гэхэд,

- Батын Өлзийбаяр гэж амандаа урт удаан хэлтэд дуулаагүй ч үгүй юм шиг байна гэж бас уртаар аялгуулан хэлээ. Чухам хаа хэдийд танилцсанаа бодож олох гэж бүр цөхрөв. Нэг болохд энэ хүнтэй Улаанбаатарт танилцсан шиг санагдана. Тэгээд

- Та хотод хэдийд очиж байсан бэ? Гэж асуув

- Би баатар хотоор бишгүй л орж байсан. Аян жингээр л голдуу явж байсан даа. Нэг удаа хуралд очсон гэхээр нь би

- Аа мөн, мөн. Сайн малчдын хуралд биз дээ. Бид тэнд танилцаж дээ, хэд дүгээрт нь та очсон бэ?

- Гуравдугаарт нь гэж хариулав. Би гуравдугаар хурлын үед хөдөө байсан тул тэнд танилцах аргагүй байлаа. Эсвэл цэрэгт байхдаа танилцсан юм болов уу гэж бодоод

- Та ер нь зүүн хязгаараар явж байсан уу? гэхэд

- Явж байлгүй яахав. Тамсагт манай нэг хүү цэрэгт алба хааж байсан юм. Түүнийг эргэж хоёр ч очсон. Бас Чоно голд нэг хүү маань байсан. Түүнийгээ эргэхээр очдог байсан юм гэв

- Аа мөн мөн. Чоно голд танилцаж, танай хүүгийн нэр хэн билээ?

- Бадрах гэдэг юм. Хилийн цэрэгт заставын дарга байсан юм гэж огт дуулдаагүй хүний нэр хэллээ

- Хэдэн оноос хэдэн он хүртэл хаанахын заставын дарга байсан юм бэ? гэж намайг асуухад:

- 1937 оноос 1940 он хүртэл цагаан уулын заставын дарга байгаад баруун хязгаарт шилжиж очсон юм даа гэж миний мэдэхгүй үеийг зааж хэллээ.

- Тэнд бас биш боллоо. За байз таныг чухам хаа үзлээ гэхэд

- Үгүй ээ хүү минь чи арай буруу таниад байгаа биш биз дээ. Би л таныг үзсэнээ огт санахгүй юм байна гэв. Тэгээд гайхаш барагдаж байснаа өдий болтол алдар нэрийг нь асуугаагүйдээ

ГОМДОЖ,

- Таны алдар хэн гэдэг билээ гэвэл

- Хичээнгүй гэж, миний таниад байгааг аргагүй итгүүлсэн энүүхэнд ойрхон байгаа одоохон бодоод олчихоор нэг зүйлийг сануулах мэт болов.

- Тэрдээ тэр. Таны царайг таниад байгаагаар барахгүй нэрийг чинь сонсоод бүр таньж байна гэж баярлан хэлэхэд өвгөн миний инээсэн царай руу сайтар ажиглаж харснаа

- Тоглоомгүй хүү минь. Би чамайг огт үзээгүй юм байна гэж зэвүүцсэн царай гарган хэлээд майхны зүүн талаас гудас дэвсэж

- Тэр дахаар хучаад унт. гэж эвгүй хэлэв. Ингэж өвгөний дургүйг хүргэсэндээ би гэмшсэнгүй, танилцсан түүхээ заавал бодож олоод харин ч нүүрийг нь улайгана даа гэж бодохтой зэрэг бид хоёрын танилцалт нэг л хөгийн явдалтай шиг бодогдов. Өвгөн дахин үг дуугарсангүй, намайг солиотой амьтан гэж бодсон бололтой. Тэгээд бид хоёр хэвтэв.

Заг модны задгай галын цог их улаан байдаг тул майхан дотор гэрэлтэй байв. Миний нойр хулжаад, ганцхан, өвгөнтэй хаа яаж танилцлаа гэдгийг бодож байв. Өвгөний нойр ч хулжсан бололтой байн байн хий ханиалган, орон дотроо эргэж хөрвөөж байгаа бололтой. Би бодож болох гэсэн зүйлээ олсон ч үгүй нам унтчихжээ.

Өглөө нь оч тас няс хийн гал дүрэлзэж байхад сэрэв. Өвгөн алга байв. Бяцхан хүү дүрэлгэр том нүдээрээ намайг гайхан харж байв. Би түргэхэн босоод гадна гарч ямар шүү газар ирчсэнийгээ сонирхон харвал, сархиа их хадан уулсын энэ хэсгийн тогтсон байдал их сонин харагдлаа. Хойт талаас дээврийг нь хагас нөмрөгсөн овоохойн доторхи зай шиг бяцхан талбай байв. Хойт уулын ёроолоос эхлэн догшин хальж хөлдсөн мөснөөс өвгөн хагалж байгаа харагдав. Гялалзсан хүйтэн өглөө салхи тогтоогүй боловч тэнгэр цэлмэх шинжтэй болоод салбарч урагдсан эсгий шиг болчихоод сиймхий цагаан үүлсийг өмнө зүг тийш сарниулан хөөж байлаа.

Өвгөн бид хоёр майханд бараг зэрэг оров. Цай чанах зуур өвгөний энд ирсэн учрыг асуувал, Майхан гэдэг энэ газрын хавьд нутаг бэлчээрийн тохиромж муугаас айл нутагладаггүй бөгөөд хааш хаашаа тэмээний хоёр гурван бэлчээр газар айлгүй гэнээ. Энэ давчуу бяцхан аманд ийш тийшээ зорчин явагчид буудаллахад тун тохиромжтой нь өвлийн цагт дулаан нөмөртэй байдаг, бас задгай устай тул цагийн ямар ч улиралд аянчин жинчингээр тасардаггүй ажээ. Хааш хаашаа 2-3хан зуугаад метр талбайд нь ногоо сайхан ургадаг юм гэнэ. Тэгээд Хичээнгүй гуай өнгөрсөн хавар Майхны талбайн ашиглаж болохоор га илүү газарт эрдэнэ шиш тарих гэж багийнхаа хэдэн хүнтэй хэлэлцэж тохироод тарьсан нь 3м илүү өндөр ургаж санаснаасаа их ургац аваад эндээ даршилсан юм гэж ярихаар нь би өвгөнийг сая таниад тэсгэлгүй дуу алдаж билээ.

- Таныг таниад байсан маань нүүр учирч танилцаагүй юм байна шүү дээ. Таныг эрдэнэ шиш амжилттай тарьсныг сайшааж хэвлэлд зурагтай чинь гаргасан өгүүллээс таньдаг болсон юм байна гэхэд өвгөн үл мэдэг инээж

- Би таныг таньдаг гэж яриад байхаар анхандаа үнэмшиж байсан юм. Сүүлдээ мунгинаж байгаа юмуу, эсвэл тоглож марзганаж байна гэж бодоод уур хүрэх шиг болсон шүү гэж ярилаа. Өвгөн бид хоёр улам танилцлаа. Хичээнгүй гуай олон үр хүүхэдтэй хүн байв. Дагуулж яваа жаал ач хүү нь юм байна.

Сумын сургуулийн дөрөвдүгээр ангид онц сурдаг гэнэ. Өвлийнхөө амралтаар өвөг эцэг дээрээ очоод буцаж яваа юм байжээ. Хичээнгүй гуай сумын төвд бусад ач нартайгаа сууж байгаа эмгэндээ саалийн үнээнд нь дарш аваачиж өгөхөөр замаасаа хазайж энд иржээ.

- Хүү минь эрдэнэ шишийн дарш гэдэг мөн ч эрдэнэ шүү ашигтай юм даа. Манай эмгэн олигтой сүүтэй ганц үнээгээ аваад дөрвөн ачтайгаа сумын төвд сууж байгаа юм. Энэ даршны ачаар үнээ нь бараг л зуныхаа саалийг өгөөд тэд тараг бүрж байгаа даг шүү гэж ярилаа.

Тэгээд өвгөн тэмээнүүдээ ачаалж эхлэв. Бяцхан хүү нь ажилд эвлэг дүйтэй гэдэг нь надаас илүү юм. Би «Давхар майханд» ингэж мунгинаж хоносон юм. Үүнд миний сэтгэл алгасангуй буруу байвч, бүтээлт ажлаараа товойн алдаршсан улс даяар танигдсан сайчуудын тоо өдрөөс өдөрт олширч байхад энэ мэтийн төөрөгдөл хэнд ч тохиолдож болох юм.

ЭРДЭНЭБАТЫН ОЮУН

Зохиолч Э.Оюун 1918 онд хуучин Нийслэл хүрээ одоогийн Улаанбаатарт төржээ.

1927 оноос бага, дунд сургуульд суралцаж, 1957 онд Улсын их сургууль төгсөж, 1960 онд ЗХУ-д урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

Э.Оюун 1939 оноос уран бүтээлээ эхэлж “Хот айл”, “Нөхдийн уулзалт”, “Ах дүү нар”, “Амарсанаа” зэрэг жүжгүүд, “Улаан дээлт хүүхэн хэн бэ?”, “Хурандаа шинель”, “Шуудан хүргэгч Цэрмаа” зэрэг олон өгүүллэг бичжээ.

Э.Оюун манай урлагийн ахмад зүтгэлтэн ардын жүжигчин юм. Гоголь, Лопеде-вега, Симонов, Корнейчук, Шекспир, Софокл зэрэг орос - зөвлөлтийн болон дэлхийн сонгодог зохиолчдын 40 гаруй жүжиг орчуулжээ. Э.Оюун 1946 онд БНМАУ-ын төрийн шагнал хүртжээ.

УУЛЗАЛТ

Москвэд энэ өвөл цас ихтэй, дулаан гэдэг нь жигтэйхэн байлаа. Нэг өдөр цас учиргүй орж, унасан дороо хайлан байсан учир хүн бүр метро руу орохыг яарч байсан байх. Би ч «Хувьсгалын талбайн» буудал орохоор яарч явсан юм. Энэ буудал дотроо маш гоё. Хувьсгал хийхэд амь бие хайргүй тэмцсэн хувьсгалын анхны үеийн ажилчин, тариачин, далайн цэрэг эмэгтэй хувьсгалч, дайз бүсэлсэн явган цэрэг, чулуу сандайлсан, дайсныг анхаарч харан, юм түшээд амарч суусан цэргүүдийг дүрсийг амьд юм шиг ган төмрөөр цутган хийж «Хувьсгалын талбай» нэртэй метрогийн энэ буудлыг туршид нь чимэглэжээ.

Зорчигчид тоо томшгүй, цахилгаан шатаар бууж л явна, Зогссон хоёр талын вагоноос гарсан хүмүүс дээш явж л байна. Нэг хоногт Москвагийн энэ метрогоос таван сая хүн зорчдог гэсэн тоо байдаг юм билээ. Ингээд вагонд ороод явж байтал өвлийн саарал пальтотой, хиймэл үсэн хүрэн малгайтай, өмдөө хуучивгар хар гутал дээгүүрээ тавьсан, цаасаар нандигнан бүрхсэн томоохон нэг юм барьсан хүн түүний зүүн гараас сугадан яваа галт шил шиг нүдний тийм их томруулдаг шилтэй, гартаа том цүнх барьсан жар шахам настай бол уу гэмээр хоёр хүн тэртээ сандал дээр зэрэгцэн сууж нэг юманд их яарч, баярлан догдолсон байдалтай байгаа нь анхаарал татмаар байв. Цаасаар бүрсэн юм барьсан хүн нь цаасан доторхи юмаа байн байн үнэрлэж байгаа юмуу, шагайж харж байгаа алин болох нь мэдэгдэхгүй юм. Гэвч маш нандин юм дотор нь байгаа нь ойлгогдож байлаа. Тэр хоёр хүн бас яг Москвагийнх биш өөр хотоос ирсэн бол уу гэмээр. Хоёулаа байн байн инээмсэглэж, хүүрнэн ярьж байгаа нь тун их догдлонгуй. Юунд их баярлаж яараа юм бол оо? гэж бодтол цаасан бүрхүүл дорогш мултартал дотроос нь хоёр том улаан намуу цэцгийн түрүү цухуйхад тэр хүн барвайсан гараараа мултарсан цаасыг нь дээш болгож цэцгийн түрүүд, хүрэхдээ хичнээн энхрий, нандин хүрэв ээ. Сэтгэл сайхан, ертөнцийн ариун бүхэнд дуртай хүн л цэцгэнд ингэж нялх булбарай хүүхдэд хандаж байгаагаас илүү эеврүү ханддаг байхдаа гэж бодогдон тэнд явсан нэлээд хэдэн хүн үүнийг бас онцлон харах шиг боллоо.

Гэтэл метроны «Комсомолын» буудалд ирж тэр хоёр буусанд юманд дуртай хүн гэж хэцүү, би ч бас бууж тэр хоёрыг дагав. Тэр хоёр ер нь нэлээд яаруу явсаар яг метроны аман дахь чөлөөнд зогсож ийш тийш харан энд уулзахаар болзсон хүн нь байхгүй байгаад тэвдэв бололтой. Би бас хүн хүлээгч болон зогсож байх зуур нүд муутай нь

- Цаадах чинь алга уу? Яачихаа вэ? Галт тэрэгний буудал дээр очих уу? гэсэнд цэцэг барьсан өндөр нь

- Ирнэ вий. Галт тэрэгний буудал дээр очвол вагоны дугаар нь мэдэхгүй, тэгээд ч тэр олны дунд яаж бие биенээ олох юм бэ? Одоо чи бид хоёр шал өөр, тэр маань ч бас л жигтэйхэн өөр болоо биз? гэлээ. Тэгтэл хөх пальтотой махлагдуу буурал санчиг нь тарваган малгай дороос нь цухуйсан монголжуу царайтай хүн орж ирэв. Нөгөө хоёрын өндөр нь орж ирсэн хүний дэргэд очсоноо, биш юм байх гээд буцав бололтой. Монголжуу нь

Сергей Петрович Кудрявцев? Это вы? гэхэд цэцэг нандигнан барьсан өндөр хүн огцом эргэн харж, нөгөө нүд муутай дээрээ очин гараасаа хөтлүүлэн

- Тиймээ би байна. Балдан чи яасан ондоо болоов? Гоолигхон, тас хар үстэй, туранхай цагаан

царайтай шаг хийсэн залуу байж билээ гэсээр энэ гурав хоёр орос, нэг монгол өөд өөдөөсөө инээмсэглэн баярлаж уулзах нь ямар ч ах дүү, төрөл садан уулзаж байгаагаас ялгаа алга. Нүд муутай нь

Аль вэ, Балдан чи ойртооч, би чамайгаа нэг сайн харъя. Чи чинь тийм бүдүүн тарган, буурал болчихсон гэж үү? Намайг тэр халуун элсэн дунд шархадчихаад хэвтэж байхад хорь шахам километр газар үүрч, хээрийн эмнэлэгт хүргэж өгсөн юм чинь бадируун чийрэг эр байсан биз. Чиний чадалтай нуруу намайг өдий болтол амьд явуулж байгаа юм. Алив, нааш ир Балдаан, би энэ томрулдаг шилийнхээ цаанаас чинийхээ царайг нэг сайн харъя. Балдан гэгдэгч хачин болж, гайхаш тасарсан маягтай нүд муутын дэргэд очиж,

- Иван Дмитриевич Антонов та юу? Би таныг танилаа гэсэн нь Антоновын сэтгэлийг тайвшруулах гэсэн байх. Үнэндээ бол цагаан шар үстэй Иван Антонов, зориг ч гэдэг нь ган, золбоо гэдэг нь гал гэлээ гэв гэх шиг сайхан ч эр, сайн ч хүн байжээ. Хүнд шархтай, хөдөлж чадахгүй элсэн дунд хэвтэж байх тэр мөчид Балдан, Антоновыг харангуутаа хэний хүү, хаана ирчихээд ингэж байгаа юм билээ дээ, яасан ч цэвэрхэн орос вэ гээд үүрч тэвэрч, гудачсаар яваад монголын хээрийн эмнэлэгт хүргэж авчирч тушаачихаад цааш явсан юм.

Монголын явган цэргийн нэг ангийн урагшлах давшилтыг боож байсан Жээ - хээ хэвийн нурсан тосгоны нэг муу байшингаас пулемётын дуу тасалдахгүй шахам байж босч давшилтанд орох гэсэн оролдлого хийх бүрд, боссон хүн бүрийг алдахгүй хяргаж байгааг хараад холбоо залгах даалгавар авч түүнийгээ биелүүлчихээд эргэх замдаа явж байсан Антонов, энэ муу байшин руу сэм очиж гранат хаяж дайсны тэр пулемётыг дуугүй болгосонд манайхан, хэн гранат шидсэн юу болсныг мэл гайхан байтал Антонов бүр аюулгүй болсон эсэхийг шалгах гэж өндийж, байшин тийш явах гэтэл дайсны амьд үлдсэн нэг цэрэгт цээжээрээ буудуулж ойчсон боловч монголын явган цэргийн тэр ангид давшилтын зам нээж өгсөн билээ. Тэр ангийн дарга Антоновыг буудсан дайсны цэргийг баривчлуулж, Балдан, Антоновыг авч явсан нь тэр юмсанж. Түүнээс хойш энэ хоёр уулзаж дайралдаа ч үгүй, харин Антонов хээрийн эмнэлгээс төвийн эмнэлэгт очихоосоо урд овоо болсон хойноо «сестра Жавзангаас намайг тэр холоос үүрч авчирсан хүн хэн гэдэг хаанахын хүн бэ чи хэлээд өг» гэхэд нь Жавзан туж инээсээр байгаад юу ч хэлдэггүй зөвхөн л Балдан гэдэг юм даа, Балдан гэдэг юм гээд л инээдэг. Яагаад ингэж инээгээд байсан юм бэ гэвэл Жавзан, Балдан хоёр Дорнодод дөнгөж танилцаад, хайр сэтгэлийнхээ тухай бараг юу ч яриагүй байтал Балдан фронтод явчихсан. Жавзан сестра болоод явсан, Салснаасаа хойш дөрөв, гурав хоногийн дараа уулзаж байгаа нь тэр байж. Санамсаргүй ажлаа хийж байтал гэнэт санитар хийж байсан Жанцан:

- Чамайг тэнд хүн уулзья гэж байна. Ёстой нэг лужир биетэй орос эрийг авчирч дээ, би тэр оросыг нь нэгдүгээр асарт хэвтүүлчихсэн, Самбуу эмч намайг тариа хий гэж байна билээ гэхэд нь Жавзан дорхноо хийж байсан юмаа дуусгаад гарсан чинь шороо тоосонд дарагдсан нэг хар амьтан халуун тогооны дэргэдэх ганц хоёр заг байсныг дэрлээд унтаж орхиж,

- Хүүш чи юун хүн бэ? босооч гэж дэргэд нь очиж дугтартал Балдан сэргэж эргэн харвал Жавзан дуу алдаж,

- Балдан минь чи юу? Юу болоов? Шархдаа юу? гэхэд

- Юуны чинь шархдах. Зүв зүгээр. Харин би нэг цэнхэр нүдтэй сайхан ах үүрч авчирлаа. Одоо бодож байхад ер нь яаж ашгүй энд хүргэж дөнгөв өө. Лут том эр ээ. Жавзан сестраг дууд гэхээр нь чамайг энд байгаа юм биш байгаа даа гэж тэр цэргээр дуудуулсан юм. Яамай. Сайн. Жавзан аа, би явлаа биеэ мэдээрэй. Мөд уулзамз гээд анги руу нь ойртож очих машинд суугаад явсан. Жавзан араас нь:

- Балдан минь ээ. Сайн яваарай гээд удаан зогсож араас минь хараа ч үгүй цааш явсныг бодвол өнөө авчирсан зөвлөлтийн цэргийг асрах хэрэгтэй болсон байх гэж Балдан бодож байснаа гэнэт одоо тов тодхон саналаа.

Тэгээд дайнаас хойш Жавзантайгаа суучихсан хойноо Антоновыг хэн намайг авчирсан бэ гэхэд нь намайг амьд мэнд явааг харсандаа, бас ийм эрийг үүрч ирэх тэнхээ яаж хүрээ юм бол гэж баярлан бодохдоо инээд нь хүрээд Балдан гэдэг юм. Балдан гэхээс өөр юу ч хэлж чадаагүй гэсэн нь ч чихэнд дуулдах шиг болоод Антоновыг дахин сайн харж тэр шарх нь хүнд байсан, мэдрэлийн судсыг нь гэмтээсэн байсан, тэгээд дороо Москва руугаа явсныг нь дуулсан байлаа.

Түүнээс хойш юу болсныг үнэхээр асуугаа ч үгүй, мэдээ ч үгүй байтал харин хорооныхоо сургагч байсан Кудрявцевыг Москвагийн ойролцоо машины үйлдвэр дээр ажиллаж байгаа гэж эмнэлэгт хамт хэвтэж байсан нэг хүнээс дуулж хаягийг нь аваад явахынхаа урдын урд өдөр ил захидлын хуудас явуулаад мөн л бол уулзъя биш бол ондоо хүнтэй уулзана биз гээд хүлээж уулзсан нь энэ байжээ.

Нүд муут Антонов, Балданг шилнийхээ цаанаас сайн харна. Чанга тэврэнэ. Үнсэнэ. Энэ үеэр Кудрявцев

- Нуруу яах вэ, сэтгэл гээч. Тал нутгийн монгол хүний уужим хүнч сэтгэл намайг аварсан юм. Тухайлбал чиний өмнө зогсож байгаа Балдангийн сэтгэл шүү дээ. Антонов байн байн Балданг тэвэрч үнсэн,

- Миний монголын хүү. Би одоо хүртэл монгол нутгийг санадаг. 1945 оны тэр дайн амар биш байсан. Танай нутгийн зүүн хязгаар, хэцүү газраа бид унд усгүй, элсэн шуурганд зүдэрч явж байсан ч бид хамтаар ялалтаа байгуулсан. Тэгээд одоо хүртэл би монголоо санадаг. Хээрийн эмнэлгийн Жанцанг, сестра Жавзанг, эмч Самбуу бүгдийг нь би мартаагүй, миний бодол зураг шиг торойж байдаг. Тэнхээт монгол энэ хүнд Балдан чамд тэврүүлж үүрүүлж би энэ сайхан ертөнцөд хоёрдохоо мэндэлсэн юм даа гэхэд нь Кудрявцев

- Тэнхээ хамаагүй гэж хэлээд байхад сайхан сэтгэл Балданд байгаагүй бол чамайг үүрэх тэнхээ ч гарахгүй байсан юм шүү дээ гэж ярихаар нь Балдан эвгүйцэж:

- Би та нараар ингэж хий хоосон магтуулах гэж уулзъя гээгүй. Антоновыг тантай хамт байна гэж би санаагүй. Үүрсэн дүүрсэн гээд байх юм. Антоновын оронд би шархдаад хэвтэж байсан бол та хоёрын нэг нь тохиолдоод бас л үүрэх байсан шүү дээ. Энэ гавьяа биш. Гэтэл нүд муут Антонов цав цагаан алчуураа гаргаж, нүд шил хоёроо ээлжлэн арчиж,

- Одоо санахнаа нь сестра Жавзангаас намайг авчирсан хүний нэр усыг хэлээдэх гэхэд Балдан

гэдэг юм. Тэр хүн үүргээ л биелүүлсэн. Зөвлөлтийн цэрэг ч монголоо, монгол нь ч Зөвлөлтийнхнийг үүрч авчирч байдаг алийг тэр гэхэв. Дайны хүнд цагийн жирийн л явдал гэж билээ. Өчигдөр энэ Кудрявцев манайд орж ирж «чиний дулаалгат цэцэрлэгээс хамгийн сайхан хоёр цэцгий нь авна» гэхээр нь би «сангийн юм шүү» гэсэн чинь «сангийн гэдэг чинь Зөвлөлт улсын юм», эвдэрч тасаршгүй, амин голоороо найрамдсан монголын нэг найздаа Зөвлөлтийн энэ цэцэг өгөх юу ч биш. Гэвч би дэлбээт цэцэг үзээгүй учир үнэхээр гайхан баярласандаа Кудрявцевийг чанга тэврэв.

Хажуугаар явсан хүмүүс, эрэгтэйчүүд бие биедээ цэцэг барьж тэврэлдэн байхыг хараад гайхан өнгөрч, зарим нь тэдний дэргэд очиж учрыг нь мэдэхтэйгээ зэрэг тэр хүмүүсийн зарим нь би монголд байсан сайхан ч нутаг, сайн ч хүмүүстэй шүү. Сайншандын цэргийн ангийн Цоодол, Өвөрхангайн нисэх буудлын Занаа, Хөвсгөлийн онгоцны Цэгмэд, Дорнодын мажкомбинатын Дожоо гэх зэрэг олон хүнийг асууж, Балданг мэдэхгүй юмаа гэхээр «аргагүй ээ, аргагүй, тэр уудам нутгийн тэр олон хүний алийг нь энэ хүн таних вэ. Найрамдалт монгол оронд мэнд хүргээрэй, бид үүрд ах дүүс шүү» гэх зэрэг үгнүүд дуулдсаар удахгүй цуглаан ч болох нь уу гэмээр болов. Тэгээд ч метрон дотор олон хүний замын газар тээг болон зогсох нь эвгүй болохоор тэр гурав Зөвлөлтийн олон хүний сайн санааны үгс сонссоор гадагш гаран шууд галт тэрэгний зогсоол тийш явав. Хүмүүс зарим нь «баяртай», «сайн байна уу?», «Жамбалу привет», «Увс нурскому агроному Дэжид привет передавайте» гэж олон үг хэлсээр зүг зүгтээ явцгаав. Мань гурав, гурвуулхнаа үлдэж мөн нэлээд ярьмаар юм байвч Балдангийн явах цаг тун ойртсон байлаа. Кудрявцев

Чамайг бид хоёр гэртээ аваачиж хэд хонуулаад явуулна. Бид билетийг чинь авч өгнө гэхэд,

- Яаж болох вэ? бид энд эмчлүүлээд сайн болж бас нэмж олон найзтай болоод явж байна. Аннад мэнд хүргээд үүнийг өгөөрэй. Антонов танд энэ. Би тантай уулзана гэж үнэхээр санасангүй, Гэвч Жавзан их ярьдаг юм. Та авгайдаа үүнийг өгөөрэй гэж тус тусад нь нэг, нэг тэмээний ноосон гоё бээлий бэлэглэв.

Балдангийн хоёр найз, яах нь вэ, юу гэсэн үг вэ? гэхэд Балдан,

- Би та нарыг байнга дүүрэн амьдралтай байг гэж дээш харсан амтай бээлий өглөө шүү дээ. Жавзан өөрөө нэхсэн юм гэлээ. Антонов,

- Миний Балдан мөн бол Жавзангийн дуртай цэцгийг өгч явуулна гэж би үүнийг авч гарсан юм. Намайг өгч байна гэж өгөөрэй. Намайг мартаагүй байгаа? Би нүд юм харахгүй шахам болсонд үхмээр бодогдсон өдөр олон байсан боловч Жавзангийн өвгөн аав, хараа муутай ч гэсэн хэрэгтэй юм хийсээр явааг санаад цэцэг ургуулдаг хүн болсон. Миний энэ цэцэг сайхан байна уу. Балдан аа, гэхэд Балдан,

- Ёстой дээд сайхан цэцэг. Харуугаа би бүр гайхсан шүү дээ. Энийгээ яасхийж аятай авч явж Жавзандаа аваачина даа гэж бодож байна гэсэнд Антонов,

- Одоо вагондоо оронгуут шилтэй усанд хий. Жавзанд энэ цэцэг хүрвэл маш сайнсан. Ариун сэтгэлээ шингээсэн хөдөлмөрөөр минь ургасан цэцэг гэх зэрэг энэ гурав хичнээн ч яривал ярих, дурсаж бие биедээ хэлэх зүйл тун их байсан ч юм бүхэн эхлэл, төгсгөлтэй, цаг гэдэг

хэмжээтэй болохоор яах ийхийн завдалгүй хонх цохиж Балдан вагондоо орохоос өөр аргагүй боллоо. Гэтэл Балдан гэнэт Кудрявцев дээр гүйн ирж,

- Чиний хүү монголд бий гэж дуулсан. Хаа байдгийг нь би мэдье гэсэн юм шүү дээ. Бүр мартчихаж гэхэд Антонов тэсч ядан баярлаж,

- За тэр шүү. Бидний нөхөрлөл, найрамдал хэзээ ч тасаршгүй хэлхээтэй юмаа. Ёстой гоё байгаа биз дээ гэж уйлан инээнэ. Кудрявцев,

- Нээрэн чи очиж уулзвал сайхан л санагдана наадхад чинь, нисгэгч хүн шүү дээ. Эхнэр, охин гурвуулаа танай тэнд бий. Гэнэт уулзсандаа тэвдэж мартаад байна. Балдан Кудрявцевийг дахин тэвэрч мөр рүү нь алгадаад,

- Тийм юм мартаж яаж болдог юм бэ?

- Хүүг минь тэнд байгааг чи бас хэнээс олоод мэдчихэв?

- Ертөнц дэлхий яриа сургаар дүүрэг байдаг гэж танайхан хэлдэг биз дээ? Эмнэлэгт хамт байсан хүн хэлсэн юм.

- Тэр хүн чинь хэн гэдэг юм бэ?

- Осипов, Яков Семенович чамайг.. гэхэд Кудрявцев:

- Тийм тийм мэднээ, мэднэ. Тэрүүнтэй би уулзаж чадна. За чи Далхаа, Цэвээн, Сүрэнжав энэ тэрд цөмд нь мэнд хүргэж хаягийг минь өгч өөрөө ч захиа бичнэ шүү гэв. Кудрявцевийн дэргэд зогссон Антонов, - Балдан аа, чи хүүхдээ бас энэ Кудрявцевийн дэргэд зогссон Антонов,

- Балдан аа, чи хүүхдээ бас энэ Кудрявцевийн хүүхэдтэй танилцуулаарай. Ай хөөрхий, дайн тулаанд ч хамт явж, энх цагт ч хамт амьдарч, ажиллаж улам сайхан цагийг ойртуулахын төлөө зүтгэцгээж явна даа бид,

- Тэгэхгүй яах вэ. надтай хамт хэвтэж байсан хүний хүү нь манай Дорнодын махкомбинатын барилга дээр ажиллаж дуусгаад одоо дулааны цахилгаан станцын барилга дээр ажиллаж байгаа юм байна. Найрамдал гэдэг үг жирийн сонсогдох мөртлөө хүчтэй үг юм, энэ үгээр жигүүр хийсэн хүмүүс дандаа ариун мөртэй гэж Балданг хэлэхэд Кудрявцев найз нөхрөө харж ханахгүй байгаа юм шиг баяртай ширтэн зогссоноо,

- Балдан чи минь найрамдлын цуглаан дээр үг хэлж байгаа юм шиг байх чинь вэ? гэхэд Балдан явах цаг нь болсондоо тэвдэн хоёр сайн хүн энэ найз нартаа чухам ямар сайхан үг хэлэх билээ гэхэд хэлэх үг олдохгүй байв.

Кудрявцев халааснаасаа тэмдэглэлийн дэвтэр гаргаж цаас урж аван, Монголд ажиллаж байгаа хүүгийнхээ хаягийг бичиж өгөхөд Балдан сэтгэлдээ үнэн голоосоо баярлаж Кудрявцевийн хүүтэй, ачтай нь бэртэй нь очиж уулзаад Кудрявцев бичнэ гэж баярлан галт тэрэг тун явчих гээд болохгүй тул хоёр нөхрөө сайн тэвэрч үнсээд вагон руугаа орж цонхон

дээр очсон боловч, залуу цагийн найз нартайгаа түр ч гэсэн уулзаж, залуугийнхаа хэцүү бэрх мөртлөө цог золбоотой амьдралаа эх орныхоо төлөө тэмцэж, ажиллаж байсан цагаа бүгдийг нь ил тод санаж баярын нулимс нүдийг нь бүрхсэн учир цаадуулыгаа харж ч чадсангүй гараа далласаар явав.

Их найрамдлаар ахан дүүс болсон хүмүүс хэзээ ч бие биеэ мартдаггүй юм байна. Амьдрал, хөдөлмөр, тэмцэл гэдэг л хүмүүсийг танилцуулж мөнхийн нөхөд болгодог юм байна гэж Балдан ч бодсон, Москвагийн төмөр замын буудал дээр үлдэж хоцорсон Кудрявцев, Антонов хоёр ч бас бодсон юм.

ЖАМБЫН ПҮРЭВ

Зохиолч Ж.Пүрэв 1921 онд Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт малчны гэр бүлд төржээ. 1952 онд Улсын их сургуулийн түүхийн анги, 1961-1963 онд Москвад утга зохиолын дээд курс төгсжээ.

1940-өөд оноос уран зохиол сонирхон оролдож, энэ засвар олон тооны өгүүллэг, тэмдэглэл, найруулал бичсэний гадна «Нэр хүнд» тууж «Хөгжмийн эгшиг», «Ундрах инженер», «Аадар бороо», «Мянган захидал» роман зэрэг томоохон бүтээлүүд туурвижээ.

Зохиолчийн «Нэр хүнд» тууж «Гурван зангилаа» роман нь Москвад орос хэлээр хэвлэгджээ.

СЭТГЭЛД ХОНОГШСОН НАМАР

Алимын цэцэрлэгт

Кавказын хормойгоор бидний хийж яваа аялал хэнд ч хэзээ ч мартагдахын аргагүй хөгжилтэй байлаа. Уртын замыг туулах ялдамдаа бид тэнгэр чичсэн шовх хүрэн уулс, ногоон ойгоор бүрхмэл ухаа толгод, нүд алдам хөндий дүүрэн халиуран найгаж байгаа тариа будаа байн байн дайралддаг ганган цэмцгэр хот суурин, үйлдвэрийн утаа, бургилсан өндөр яндангуудыг харж, байж байгаа хэвээрээ яруу найраг, болсон тэр үзэсгэлэн гоо бүхнийг ширтэн нүдээ баясгаж, сэтгэлээ догдлуулан явсан билээ. Энэ бол тун саяхны хэрэг.

Бидний сууж явсан ГАЗ-24 машин дотор Антонина Викторовна Ломакина /зөвлөлтийн зохиолчдын хорооны ажилтан/, Багиров Рафик /Баку хотын ажилтан/, манай залуу яруу найрагч Шагдарсүрэн жолооч М.Г.Каграманов энэ таван хүн бүтэн өдөржингөө хөгжилдөн ярилцаж нэгийгээ Кавказын савдаг, нөгөөгөө Ногоон Дар-Эх болгон өргөмжлөх зэргээр наргиж явлаа. Бид үзсэн, сонссоноо бүхнээ ярьж байснаас гадна замд тохиолдсон хот тосгоноос угтан баяр хүргэж байгаа хүмүүстэй уулзан саатаж, алим нимбэг, жүржээр дайлуулан, Азербайжан нутгийн ганган охидын урт цагаан гараа дэлгэн хүндэтгэн барьж өгсөн тансаг ундаанд дотор халж бүр ч их хөгжилтэй болсон байв. Түр саатсан ногоон талбай дээр бид бас нэгээр /бөмбөр/, тар /хуучир/, түтак /бишгүүр/, журна /үхэр бүрээ/ хөгжмийн аялгуунд бүжиг хийж баланбика /лимбийн/ уянгат эгшиг сонсон таалж, ер бусын их баясгалангаар цэнгэж байлаа. Хүн бүрийн үг яриа үзэмж уран цэцнээр баяжин, сэтгэл оюун нь хөөр баясгалангаар дүүрч, Шагдарсүрэнд маань онгод орон «Кавказын хормойд» гэдэг шүлгээ машин дотор сэдэвлэн зохиож эхэллээ.

Бид энэ өдөр Гусарийн хорооны Лейб-гвардийн бага дарга Михаил Юрьевич Лермонтовын хөшөөнд хүндэтгэлийн цэцэг өргөн түүний яриа дуулалт зохиолыг бадагчлан уншиж, ёслолд оролцон хөгжил дээр хөгжөөн нэмлээ. Цааш аяллаа үргэлжлүүлэхэд машин дотор ярьдаг яриа маань яруу найраг болон хувирч:

Эх орныхоо төлөө бид

Энэ толгойгоо үл хайрлана

Бородинод болсон тулалдаанд

Үхэхээс ч бид буцахгүй гэсэн,

Үнэхээр тангарагтаа эзэн болов

гэж Михаил Лермонтовын бичсэн «Бородино» гэдэг алдарт шүлгээс нэг маань уншив. Энэ бүх хөгжилтэй яриа, тулалдааны тухай Оросын их зохиолчийн яруу найраг нь өдөржин таг дуугүй замаа ширтэн явсан жолооч Михаил Георгиевич Каграманов гуайн сэтгэлийг хөгжөөн, дайн тулалдаанд биеэрээ оролцож явсан намтар түүхээ бидэнд ярихад хүргэсэн нь гарцаагүй боллоо.

Каграманов гуай бол угаас дуу цөөнтэй, үлэмж тайван сайхан ноён нуруутай, жар эргэм насны бөгөөд жирийн тогтуухан амгалан харцтай, махлан бүдүүн биедээ тохирсон зузаан хацартай, лүхийсэн эрээ. Харваас түүний дөлгөөн харцанд амьдралын олон үйл явдал шингэсэн нь илэрхий.

- Дайн тулалдаан гэдэг бол үнэхээр үхэхээс буцахгүй явж ялалт хийдэг үйл хэрэг дээ гэж Лермонтовын шүлэглэснийг Каграманов батлаад

-Би нэг мянга есөн зуун гучин есөн онд танай Халх голд японы цэрэгтэй байлдаж явлаа. Тэр үеийн үйл явдал танай нутагт танилцсан хүмүүс одоо миний сэтгэлд тун тод санагдаж байна. Би анх монгол хүнтэй их сонин учралаар танилцсан юм гэж уртын яриагаа эхлэв. Бид хамаг анхаарлаа Каграмановын зүг хандуулан яриа чагнасаар, өөгүй цардсан урт замаар хурдалсаар байгаад нэг мэдсэн Губа нутгийн алимын цэцэрлэгт ирчихсэн байлаа. Бид тэрэгнээсээ гаралгүйгээр Каграманов гуайн яриаг чагнаад л баймаар байв.

Цэнгэг агаар цээж дүүрч, эгнүүлэн тарьж ургуулсан модтой тэр цэцэрлэгийн цаад хязгаар нь нүдэнд харагдахгүй хол байна. Баян тоглоомоор чимэглэсэн шинэ жилийн наадмын сүлд мод адил тэр цэцэрлэгийн мод бүрт улаан шаргал алим дүүрэн ярайж харагдлаа.

Миний байлдаж явсан тэр Халх голд энэ цэцэрлэг адил алим ярайж байгаа гэнэ билээ. Би тэнд очоод ирсэн хүнээс саяхан сонссон юм. Хачин их хурдан өөрчлөгддөг байна шүү гэж Каграманов хэлээд, эргэн тойронд битүү ярайж байгаа жимсний моддыг шохоорхон харж уртаар амьсгаалав.

Борцтой шөл

Наймдугаар сарын аагим халуун өдөр байлаа. Дорнодын нүд алдам талыг зүссэн дардан зам улайстлаа халсан мэт. Замын хажуугаар ургасан сахлаг ногоон тэр уудам талыг хамба хилэнгээр битүү хучсан мэт халиуран харагдаж байв. Атар онгон нутгийн ногооны анхилам үнэр юутай тансаг вэ. Каграманов тэрэгнийхээ салхивч шилийг нээн, бүхээгнийхээ ирмэг дээр тохойлдоод, жолоогоо чанга барин хацар илэх зөөлөн салхи сөрж, хаазаа гишгэн «шидэж» байлаа.

Тэрээр монгол нутагт очсон дороо Хэрлэнгийн түр зогсоолоос Халх голд хүргэх галт хэрэгсэл ачаад, ачааны хэдэн тэрэгний дунд цуваагаар явж байгаа нь энэ ажээ. ~Ачаа саатуулж болохгүй. Тэнд байлдаж яваа цэргүүд сумаар дутаж магадгүй. Замдаа аюулаас болгоомжилж яв. Дайсны онгоцны дайралттай тохиолдвол тэрэгнүүд салж таран, цаашлах замдаа цуваандаа нийлэх хэрэгтэй гэсэн тушаал авснаа тэрээр санаж явлаа. Хүчээ авсан ЗИС тэрэгний моторын хүнгэнэх дуун жолооч цэргийн давхих урмыг сэргээх нь бас зугаатай ажээ.

Каграманов хажуудаа суулгасан хүнгүй, урдаа яваа тэрэгний тоос шорооноос зайлсхийн зайгаа алсхан аваад жигдхэн хурдалж байв. Холын замд ийнхүү ганцаараа яваа хүний сэтгэлд бодогдох юм юутай олон байх вэ. Тэрээр цэрэгт татагдан мордохоос хэдхэн сарын өмнө хайр сэтгэлээ илэрхийлсэн захидлаар харилцан, амьдралаа нэгтгэхээр тохиролцсон хонгор бүсгүйгээ юу юунаас түрүүн санаж:

~Чи минь нээлттэй цонхоороо миний явсан зүгийг ширтээд зогсож байгаа болов уу. Эндээс зургаан цагийн зөрөөтэй болохоор манай тэнд ч оройн сэрүүн ороод, охид хөвгүүд нимгэн хөнгөн хувцсаа дэрвүүлэн цэцэрлэг дунд зугаачан яваа бий. Тэд хөгжилтэй байгаа даа хэмээн ганцаараа шивэгнэн ярьж, алтан шаргал үстэй, цэнхэр нүдэн бүсгүй юугаа мөрөөдөн санаж явлаа. Бас хар, хор ч бодогдолгүй яахав. Тэдний цэцэрлэгийн хашаа руу тэрэгчний хүү Сергей очих дуртай байсан даа» гэх шиг юм санаанд нь үе үе харван орж ирж байлаа.

Каграмонов нээлттэй салхивчаараа цээжээ гарган дуу аялж, исгэрэн явав. Нар баруунаа гудайн тэрэгний сүүдэр үлэмж томорч ирэв. Тал нутгийн захад хүрэх ягаа ч үгүй мэт, тэнгэрийн хаяа тэртээ алсад цэлийн харагдана. Цувааны даргын шийдвэрээр бүх тэрэг ногоон тал дээр бөөгнөрөн зогсож амраад, шатахуунаа сэлбэн саваа дүүргэж аваад хөдлөв. Харамсалтай нь гал тогооны хэрэгсэлгүйд хавчигдан энд бөөнөөрөө байж хооллох боломж гарсангүй.

За нөхөд минь бид саадгүй давхиад байвал өглөөний нартай уралдаад анги дээрээ хүрч очно. Тэнд сайхан амттай хоол бий. Битгий хоцроорой. Тэрэг шөнө саатвал гэрлээ гурав дахин асааж, унтраан дохио өгөх хэрэгтэй. За бушуу хөдлөө гэж цувааны дарга хэлээд машиндаа суулаа. Анаа л хязгааргүй цэлийх ногоон тал дундуур хүнгэнэн давхиж эхэллээ.

Нар тэртээ тэнгэрийн баруун хаяанд дөхөж очсон харагдав. Тэрэг саадгүй хүнгэнсээр урагш зогсолтгүй довтолгож байлаа. Гэнэт урд яваа тэрэгний жолооч улаан дарцаг өргөн хойш дамжуулж түгшүүр зарлаад «бушуу таралт хий» гэсэн дохио өглөө. Каграманов яаран бас дарцаг өргөж уг дохиог хойш нь дамжуулангаа байдлыг ажиглавал зүүн урдаас дайсны гурван онгоц агаар зүсэн гарч ирж үзэгдсэн дороо юу юун тухандгүй дээр нь тулаад орж ирэв. Цэрэг жолооч хамаг хүчээр жолоогоо баруун гар руугаа залаад замаа орхиж дайсны онгоцыг сөрөн хурдаллаа. Олныг бодох зав чөлөө түүнд байсангүй. Урд нь явсан тэрэгний тус газар бөмбөг дэлбэрч сонсогдов. Хаа юу ч болж, цувааны хэдэн тэрэгнээс аль нь дайсны бөмбөгөнд өртөн сүйрч байгааг Каграманов ажиж мэдэх сөхөөгүй л зам буруулан давхисаар байв. Агаарт ноёлж байгаа Японы дугуй наран тэмдэгтэй онгоцны нэг нь түүнийг дагаж хөөн, урд нь түрүүлж гараа замд нь бөмбөг хаяж байгааг тэрээр харсан дороо бас жолоогоо эргүүлэн залж зайлсхийн довтолголоо. Дэлбэрсэн бөмбөгийн хар угаа тэрэгний хажуу хоншоор дор харанхуйлан манарч, жигтэй их нүргэлсэн дуу чихийг нь дүлийртүүлэв. Барьж яваа тэрэг нь хааз гишгэсэн хүчээр хурдалж байгааг тэрээр мэдэрч байлаа. Онгоц хойно, урд нь гарч ярдаг хэдгэнэ адил ээрэн дагаад дээрээс нь буудаж эхлэв бололтой байн байн тас няс хийн сум исгэрэх нь бас сонсогдов. Каграманов жолоогоо баруун, зүүн гар руугаа огцом эргүүлэн дарж зам муруйлган дайсны сумнаас зайлж давхив. Онгоц дээгүүр нь ээрч ёрын муухай дуугаран дагаж буудсаар билээ.

Цэрэг жолоочид «Би үхэх байгаа. Яадаг билээ?» гэж бодох завгүй, тал тал тийшээ займчин сэлж давхихдаа «Дээр ачаатай яваа сум, гранат дэлбэрвэл галын шугаман дээр байгаа өөрийн цэрэгт аваачиж өгөх юмгүй болно. Яаж ийж байгаад ачаагаа дэлбэлүүлж орхихгүй юмсан» гэдэг ганц бодол хамаг оюун санааг нь юутай ч хуваалцалгүйгээр эзэгнэсэн байлаа. Онгоц ээрэн дагаж буудсаар, бүр хажуу хавирганд нь шороо манасхийлгэн тас няс буулгасаар билээ. Каграманов хаашаа яаж өөрөө явж байгаа, нөхөд нь юу болж байгааг ажиж мэдэх сэхээ авч чадахгүй, мурилзуулан эргэж, ташиж сэлэн давхисаар явав. Үлэмж хол зайд дайсны сумнаас

булган давхижээ тэр. Замд ганга жалга, эрэг гуу тохиолдохгүй, засаж тэгшилсэн мэт тал хөндийд давхиж байгаа нь түүнийг сүйрлээс аварч байсан нь мэдээж.

Каграманов онгоцны дуу намжихаар сэхээ аваад байдлыг ажвал нэгэнт үдэш болж орчинд бараан сүүдэр сүүмийн тулж ирээд алсын бараа тасарсан байлаа. Тэрээр тэрэгнийхээ хурдыг жаахан хасан огторгуйг шинжвэл японы ногоон саарал онгоц тэнгэрт хар цэг адил төдий бараатай болж гонгинон улисаар өөрөөс нь салж цааш агаарын уудамд алга болж замхарлаа.

Жолооч хүү сая цээж дүүрэн амьсгалаад тормос гишгэн тэргээ зогсоон дороо яран бууж ачаагаа тойрч гүйн ажив. Хаягдан гээгдсэн зүйлгүй, харин татлага нь нэлээн суларч, зарим хайрцагтай юмны булан задарч сум сул асгарсан байлаа. Тэрэгний нь өрөөсөн шаврын хаалт цоо буудуулан, гэрлийн нэг том шил хагарчээ. Нам гүн чимээгүйн дотор тэр бүхнээ янзалж засах ажилд Каграманов ороод биеэ ажвал хамаг хувцас нь хөлсөндөө нэвтрэн зүсэр бороонд цохиулсан адил болжээ. Тэрээр татлагаа чангалаад тамхи асаан гүн сорж сэтгэлээ жаахан амраагаад сэхээ авч хөдлөх болов. Сандран давхисандаа болоод зүгээ алдаж, хаашаа чиглэн явахаа төсөөлж мэдэх аргагүй болжээ. Тэрэгнийхээ тоолборыг харвал өдөр амарч зогссоноосоо хойш нэг зуу гаруй км явсан байна.

Шөнийн нэвсгэр харанхуй нөмрөн орж ирээд алсын бараа харагдахаар бүр байлаа. Нөхдөө хаа явааг мэдэх баримжаа алга. Гэрэл асааж дохио өгье гэхэд дайсанд ойр очсон бол аюулд орох болно. Тэнгэрийн одыг хараад тэрээр баруун, зүүнээ олж мэдлээ. Гэлээ ч чухам хаашаа явж замаа олохыг мэдэх баримжаа даанч алга.

Каграманов уулархаг нутагт төрж өссөн болохоороо мэлийсэн талд орж ирээд баахан давхиж орхисон, бас шөнийн харанхуйг хэлэх үү, урьд нь огт явж үзээгүй нутагт хаашаа явна гэх вэ. Шийдэж хөдлөхөд тун ч хэцүү боллоо. Тэрээр тэрэгнийхээ хажууд зогсоод дэмий тал тал тийшээ харж гайхан баахан ажлаа. Зүг бүхнээс аюумшигт харанхуйд хучигдсан хавтгай тал нутаг сүүмийж харагдахаас өөр торойх юм даанч алгаа. Шумуул хөгжимдөхөөс өөр ямар ч чимээ анир сонсогдохгүй байв. Гайхахдаа тэрээр тэрэгнийхээ гэрлийг гурав асаан унтрааж, дүүрсэн хэрэг гэсэн шиг хий хашгирснаа:

~ Энэ ч болдоггүй хэрэг дээ. Нөгөө самуурай нь гэнэт нөмрөөд орж ирвэл би ганцаараа явж ч чадахгүй, сайндаа хоёр гурван япон сүлбэж алаад л баригдах хэрэг болох байгаа. Тийм дээр хүрвэл ч үзэлцэх л болно доо гэж Каграманов ганцаараа ярьж тэрэгний бүхээгт байгаа винтовоо авч сумлан, дайнд бэлэн болгоод хажуудаа тавьсан дороо, машинаа асаагаад барагцаалан бодож байгаа зүг рүүгээ хөдөлөө. Нүдэнд торох юм даанч алгаа.

Ямар их уудам хачин нутаг вэ, энэ. Энд хот суурин тарианы газар огт алга. Хамаг хүн амьтан нь дайн дажны хөлөөс зугтаагаад нүүж орхисон юмуу? Тэгсэн бол хоосон ч гэсэн орон байр, буурь суурь нь баймаар юм даа хэмээн тэрээр бас ганцаараа ярьж явав. Тэрээр нэлээн зайтай газар ганцаараа давхижээ. Сахлаг ногоо ургасан тун ч өөгүй тэгш газар урд нь харагдан дээгүүр нь цардмал замаар бөмбөрч байгаа адил дүнгэнүүлсээр байлаа. Каграманов ногоогоор битүү хучигдсан тэр газрын хөрсөн дээр юу байгааг нарийн ажиж явах боломжгүй байв. Тэрэгнийхээ хурдыг жаал нэмэн, хотоос маягийн хонхордуу газраар давхиж явгал гэнэт тэрэгний нь дугуйг хүчтэй чангаан ус шал палхийн дуугарч, урдах шилэн дээр нь шавар үсэрчээ. Мань эр тоормосоо гишгэсэн ч үгүй урагшаа жаахан дөхтөл тэрэг нь шаварт шигдэн

суулаа. Эргэн гарах санаатай хэд холхиултал дугуй дороо хий эргэн ус шавар цацалж пижигнэн тэрэгний гол далд ортол шигдэх нь тэрээ. Яах ч арга алга. Каграманов тэрэгнээсээ буун харайгаад өвдгөөр хатсан шалбааг дунд үсрэн буунгуутаа сая сахлаг ногоогоор хучигдсан намагт орж шигдсэнээ мэдэв. Тэрээр баахан ноцолдсоноо тэрэгний дугуй дор хийх мод, чулуу эрж нааш цаашаа гүйлээ. Нүдэнд торж, гарт нь баригдах юм огт дайралдсангүй.

Адаглаад хад чулуу нь хүртэл дайжаад алга болдоггүй баймаар гэж жолооч гасалснаа эргэж тэргээ тойрон ажихад ганц хүн яаж ч ноцолдоод түүнийг шавраас гаргах нөхцөл алгаа. ~ За байз яах вэ? Өглөөний нарнаас өмнө намагнаас гарахгүй бол нөгөө японы онгоц ирж салам бөмбөгдөөд хавтгайлж орхих байгаа. Тэгээд би яах вэ? гэж тэрээр өөрөөсөө асуувал дотор нь хий цухалдан, аймшигтай олон юм бодогдож эхэллээ. Хоргодож гарсан сарны сүүн цагаан гэгээ сая ертөнцийг гийгүүлж, ойрын юмны бараа харагдахтай болов. Гэвч нүдэнд нь торойх хүн амьтан, мал юмны бараа даанч алга. Каграманов өвдөг тулсан шавар дундуур таваргаж тэргэндээ ороод винтов буугаа, дайзтай сумтайгаа хамт аваад:

~ Зүгээр зогсоод ч яахав дээ, юм эрье гэж амандаа гүвнэн шалбааг усны эх өөд сөрөх маягаар баруун гараа бариад алхаллаа. Чимээ аниргүй, нүдэнд торойх ч юмгүй хэвээр. Эргээд харахад тэрэгний нь бараа харагдахаа байлаа. Зэгсэн хол явжээ. Урд нь ухаа толгой маягийн газар дайралдав. Түүн өөд авирсаар яваад дээр нь гарав бололтой. Түр саатаж тамхи асаан ~ Хайчдаг юм билээ? Эргээд явбал тэргээ олохоо больдог хэрэг арай болохгүй байгаа? гэсэн юм бодогдож байв. Каграманов гайхаш барагдахдаа өндөр дуугаар хэд хашгираад хариу чимээ чагнав. Тэртээ баруун гарт нь нохой хуцах шиг боллоо.

Байз, санаа дагав уу? Үнэхээр нохой хуцав уу? гэж тэрээр ганцаараа яриад нөгөө чимээ гарсан зүг өөд яаран алхаллаа. Нэг готос гатлан бас нэг гүвээн дээр гараад мань эр дахин хоёр хашгирч чимээ өглөө. Үнэхээр нохой хуцаж хариу сонсогдов. Тэр зүг рүү яаран алхах замдаа «За байз? Би юун дээр яваад очиж орхих гэж байгаа бол? Дайсан энд арай ч байхгүй байхаа. Дарга маань өдөр ярихдаа нэг зуун наяд км яваад фронтын шугамд ойртож очно гэж байв. Түүнээс хойш би зуун км-ээс илүү хол яваагүй» хэмээн жолооч эр бодон ямар ч болсон цэргийн хүн бэлэн байх ёстойг санаж буугаа сумлаж бариуд урагшаа зоримгоор алхлаа. Нохой хуцах чимээ ч ойртон цаана нь мэдэхгүй хэлээр хүн ярилцаж сонсогдов.

За нэг учир ургалаа. Япон л лав биш байх. Дайсан байгаа бол ингэж ярьж байхынхаа оронд намайг бүсэлж аваад барих гэж оролдох ёстой гэж тэрээр амандаа ярисаар дөхөж очвол урдаас нь гурван нохой боорлон харваж орж ирлээ. Араас нь монгол хүн нохойгоо дуудан хорихоор бас угтав. Сарны цагаан гэрэлд тэд бие биеэ харж хэн болохоо танилцав бололтой. Каграманов шавар шавхайтай хутгалдаад хүн аймаар хачин юм болсон байлаа. Гэвч угтаж учирсан монгол хүн түүнээс айж сэжиглэсэн янзгүй байв. Тэрээр монгол улсын хилийг анх давж орж ирэхдээ нөхдөөрөө заалгасан «Сайн байна уу?, Улаан цэрэг» гэдэг хоёрхон үг монголоор хэлж мэдэх билээ. Гэлээ ч гэсэн нэгэнт хань ижлээ таньсан хойно яагаад ч ярьж болно гэж мань эр бодож байв.

- Сайн байна уу? я /би/ улаан цэрэг

- Өө, СССР гэж Каграманов анхны уулзсан монгол хүнтэйгээ ярилцаж учрав. Дээл өмссөн өвгөжөөр насны монгол эр цэрэг жолоочийг эелдэглэн угтаад гэртээ орууллаа. Энд гурван

гэр айл маргааш нүүхээр юмаа бэлтгэн цөөвгөр үхэр, хонио хотондоо хураасан байжээ. Мэдээжийн тэд дайны хөл үймээнээс зайлан ар тийшээ нүүж яваа нь илт. Бас сэргэмжтэй, шөнө орой болсон ч гэсэн унтаагүй байжээ. Каграманов гэрт оронгуутаа бас л:

- Сайн байна уу? Я улаан цэрэг гэж бөхийн мэндлээд яаран шанага авч хувинтай уснаас хутгаад уух гэтэл гэрийн эзэгтэй авгай ухасхийн шанагыг шүүрэн авч:

- Хар усаар яах нь вэ? муу ёс гэж хэлээд монголчууд хоорондоо хэдэн үг ярилцсанаа галлаж цай чанаж эхэллээ. Тэдний юу ярьж байгааг улаан цэрэг юугаа мэдэх билээ. Гэхдээ «Надад эд нар муу санаалж байгаагүй нь лавтай» хэмээн бодож байв. Хот айлынхаа энэ гэрт бөөгнөрөн Каграмановыг сонирхож хоорондоо ярилцан:

- Энэ ганцаараа яаж яваа хүн юм бол? Нөхдөөсөө төөрсөн юм уу? Оргодол л лав бишээ янз нь. Манайхаар хааяа ирдэг СССР цэргийн ижил л байна.

- Ам нь л их анаж цангасан бололтой. Гутал хувцас нь шавар шавхай болсныг харахад их яарч, намайг шалбааг дундуур хамаагүй гүйсэн эр юм.

- Хөөрхий дээ, аль газрын хүний үр ингэж манийгаа өмгөөлөн аврах гэж шавар шавхайтай хутгалдан харанхуй шөнөөр ганцаараа гүйж яваа бол хэмээн орж ирсэн эмгэд хөгшдийн ярьж байгааг Каграманов огт ойлгохгүй, хэсэг зуур ангайж амьтны ам харж сууснаа машин шаварт суусан, япон бөмбөгдөж хөөсөн гэдгээ монголчуудад ойлгуулах гэж амаараа дүнгэнэн онгоц, машин болж гараараа элдэвлэн заагаад дохиогоор ярьж эхэллээ. Хүмүүс түүнийг гайхан харж янз янзаар тааварлаж ярьж эхлэв. Цай боллоо. Өрөм хөвүүлсэн сайхан шар цай том мөнгөн аяганд хийгээд зочиндоо барив.

- Юутай сайхан амттай вэ? гэр дэх хүмүүс улаан цэргийн яриаг ойлгож ядан:

- Машины жолооч хүн гэж энэ тань өөрийгөө заагаад байна. Тэрэг нь эвдэрсэн юм уу, шавар усанд сууж орхисноос зайлахгүй гэсэн яриа гэрт болж байлаа.

Каграманов цай ууж тэнхээ ороод, гэрийн эзнийг надтай хамт явж тэргээ гаргалцаж өгөөч гэж гуйгаад, винтов буугаа авч явахыг заавал эзэгтэй суу гэж ярьж саатуулан, удаж төдөлгүй аяга овоолон будаатай халуун шөл хийж өглөө. Ямар сайхан амттай яасан сонин үнэртэй хоол вэ. Улаан цэрэг маань өнгөрсөн шөнөөс хойш хоол идээгүй болохоор тэр борцтой шөл орчлон дээр нэн ховор тохиолдох хамгийн сайхан амттай зоог байлаа.

Яасан сайхан хоол вэ, энэ юуны мах вэ? гэж улаан цэргийг асуухад ойлгож хариу өгөх хүн алга. Гэрийн эзэн сайн гэж л толгой дохин эрхий хуруугаа гозойлгоно. Тэр борцтой шөлийг Каграманов ууж, будаа идээд хамаг бие нь тавигдан амарч, усанд орсон адил хөлсөндөө нэвтрэн цээжээ яран сэвэхдээ «Энэ яасан сонин хоол вэ? хуурай махаар ийм лут амттай чанарлаг хоол хийдэг газар монголоос өөр орон байдаггүй байхаа. Яаж энэ сайхан хоолыг ийм хурдан хийж чаддаг юм бол? » хэмээн гайхшран боджээ.

Улаан цэрэг гэрийн эзэгтэйд хандаж баярласнаа илэрхийлэн мэхийн ёслоод, явахыг яаран гэрээс гарангуут айлын гадаа байгаа үхэр рүү зааж хоёр хуруугаа гозойлгоод, дээс авч

цээжиндээ углан, чирч урагшаа зүтгэх байдал үзүүлж, амаараа тэрэг болж дуугарав. Хүмүүс гайхан:

- Юу гээд байгаа юм бол? гэж хоорондоо баахан ярилцаж байснаа улаан цэргийн дохионы үгийг сая ойлгон:

- Та минь. Наад хүү тань машин тэргээ тэртээх Бөөрөлжүүтийн шаварт суулгаж орхиод үхрээр татаж өгөөч гээд байх шиг байна

- За, за ойлголоо. Нээрээ тийм байна шүү. Цэргийн хэрэгсэл ачсан тэрэг байх даа. Хоёр шараар татвал дийлдэг болов уу? эрэгтэйчүүд хамт явахаас биш горьгүй гэсэн яриа хот айлын хүмүүсийн дотор болоход Каграманов тэр бүх нарийн явдлыг ойлгоогүй боловч «Эд надад туслахаар шийдэв бололтой» хэмээн таамаглаад үлэмж баясан:

- Да, да, Хорошо, гэж хариу өгүүлэн, баясгалантайгаар инээв.

Чигээ олсон нь

Үүрийн гэгээнээр үхэр хөтөлж олс татлага, шилэвч, буулгавч барьсан хэдэн хүн шаварт налчийтлаа суусан, дүүрэн ачаатай тэргэн дээр ирлээ.

- Тэгнээ тэр. Лав ингэж ядарсан амьтан аргаа бараад явж байгаа хэрэг байн

- Энэ нөхөр ганцаараа яах гэж үүгээр давхиа юм бол

- Газар мэдэхгүй төөрөө байлгүй дээ

- Энэ ачаатай, ногоон модон хайрцагтай юм нь юу байгаа бол? Дайнд хэрэглэх л зүйл бизээ.

- Тэр хараач, хараач. Ханзарсан хайрцагны булангаар бууны сум гоожсон байна.

- Аргагүй чухаг зүйл авч яваа эр юмаа. За бушуулж л үзье

- Муусайн япон цэргийн толгой руу буулгах полиосон мөндөр авч яваа нөхөр байна шүү, энэ тань

- Энэ муу галзуурсан дээрэмчин самуурай нарын ховдог хомхой хоншоорыг тас цохин, нарим буулгаад өгөх цаг одоо холгүй болоо бий. Энэ дайчин ах нар хүрээд ирчихсэн болохоор «Их наран улсын» цэрэг оодроод юу шалив гэж дээ гэсэн яриа монголчуудын дунд болж байв.

Каграманов хүрз барин шавар ухаж, монголчууд чулуу хормойлон гүйж тэргээ дээш гаргах ажилд оржээ. Манан бүрхсэн тэнгэрийн хаяанаас өглөөний том улаан нар урган гарч ирэх нь тал нутагт ойрхон харагддаг учир яг дэргэдээс нь гараад ирэх шиг Каграмановт санагдан гоц сонин байлаа.

- Танай нутаг нартай айл байдаг юмаа? гэж тэрээр хошигноод тэргэндээ орж суугаад асаалаа.

- Хөж, гэж монголчууд хашгиран, тэрэг татахаар хөллөсөн үхрээ гуядав. Ачаатай машин хамаг нийлсэн хүчинд татагдан сэвсхийн намгаас гарч ирээд дүнгэнэтэл ассаар байлаа. Цэрэг жолооч баярласандаа тэрэгнээсээ буун харайж ирээд дэргэдээ байгаа монгол нөхдөө тэврэн авч талархал илэрхийлэн:

- Одоо би хаашаа явбал замд нийлэх бэ? гэж гараараа умард, өмнөд, дорныг заан асуув. Монголчууд түүний асуусан зүйлийг ойлгож ядан гайхцрахад Каграманов толгойгоо хуруугаараа зааж гараа дугуйлан хий эргүүлэнгээ:

- Наад хүн чинь төөрсөн юм байна. Замаа асуугаад байгаа бололтой гэж хэдэн монгол эр хоорондоо ярьж байснаа нэг өвгөжөөр насны эр нь эелдэгхэн инээгээд:

- Би тантай хамт явж замчлахгүй бол улаан цэрэг их хол байгаа. Та намайг дараа нь гэрт хүргэж өгнө шүү гэж хоёр биеэ зааж дохиогоор ярилаа. Каграманов «Би хамт явж зам зааж өгье» гэдэг үгийг таамаглан ойлгож:

- Очень хорошо гэж хэлээд хоёул бүхээгтээ орж суухдаа үлдсэн хүмүүст талархал илэрхийлээд зүүн зүгийг барин дүнгэнүүлж эхлэв.

Каграмановт олон сонин зүйл бодогдож байлаа. «Би яасан сонин учралаар монгол хүнтэй анх удаагаа уулзав аа. Яасан их тусч, ямар их сонин цагаан сэтгэлтэй, хүнд итгэмтгий ард түмэн бэ. Монгол хүн яг л энэ хязгааргүй тал нутаг шигээ уудам саруул сэтгэлтэй юм байна. Харанхуй шөнө намайг хэн гэж бодон сүүтэй цай чанаж, хоол хийж өгөв өө. Хоол нь яасан сайхан амттай вэ. хонины хатаасан мах юутай ч зүйрлэмгүй сайхан юм. Тэр цай хоол намайг лут их тэнхрүүлээ шүү. Энэ миний дэргэд сууж яваа өвгөн маань бас л тэр их тусч сайхан санаат анд нөхдийн нэг төлөөлөгч байна. Би одоо энэ хүнийг хээр явгалан орхиж болохгүй. Яасан ч болохгүй» гэхчлэн зүйлийг цэрэг жолооч бодон давхиж байлаа.

Өвгөн хааяа инээмсэглэсэн нүдээр улаан цэргийн нүүр өөд хараад, гараараа чиг заан эелдэглэж элдвийг ярихыг хичээнэ. Тэр хоёрт ярих зүйл мөн их байсан боловч даанч хэл мэдэлцэхгүй нь хясаж байв. Гэлээ ч ам дуугүй явсангүй. Энэ өвгөний байдал Каграмановт аавын нь төрхийг санагдуулж байв.

- Самурай японы халдаад ирсэн цэрийг түргэн устгах ёстой. Бусдын нутагт усанд шунаж ирсэн тэдний дээрмийн үйл хэрэг сөнөх тавилантай гэж өвгөнийг хэлэхэд жолооч эр энэ хүн японы эзлэгчдийг занаж байна хэмээн ойлгон:

- Монгол цэрэг, улаан цэрэг хоёр нийлээд японы довтлон орж ирсэн дайчдыг устгана хэмээн гар зангидан зангаж, омог сүрээ бадраах мэт явах нь өвгөний сэтгэлд Зөвлөлт улаан цэрэг ч үнэхээр ялагдашгүй хүчтэй дээ. Японы далайн усаар явдаг цэрэг ч манай энэ хуурай, тал нутагт ирээд сайнаа үзэхгүй нь лав биз. Харин хэр зэрэг удаан хугацаанд түйвэргэдэг юм бол? Улаан цэрэг ингэж бууныхаа сум хэрэгслийг нааш нь татаж байгааг бодоход мөд удахгүй тэр самурайн толгойн дээр мөндөр буулгаж хаях нь гарцаагүй болоо бий. Болж, муусайн

новшнуудыг бушуухан л тонилгон амьтныг амар заяагий нь үзүүлээсэй билээ. Тэр барамнууд хаваржин, зунжин элдэв муухай явдал дэгдээж түйвэргээд нутаг ус ч шилүүлэн явуулахаа байлаа. Саваагүй, шунахайдаа зүгээр байж чаддаггүй барамнуудыг дахиад наашаа санаархах ухаангүй болтол нь нармийлгаад буцаагаасай билээ» гэсэн бодол төрүүлж билээ.

Тэд өдөржин хоёулаа давхилаа. Каграманов бөмбөгдүүлээд, зам буруулан давхихдаа явж байсан замаасаа бараг буцаж зүүн урагшаа чиглэн довтолгосоор мэдэхгүй хүн яаж ч яваад олохгүйгээр холдсон байжээ. Замч өвгөн цэрэг жолоочийн энэ бүх байдлыг дохио ярианы эцэст бүрэн ойлгож авлаа. Оройн нар хэлбийх үед тал нутгийн зүсэн дорныг зорьсон дардан замд тэд оров. Нааш цааш холхилдон давхиж яваа машин, их буу, цэрэг ачсан тэрэгний цуваа ч тэр замаар тоос манарган үргэлжлэн давхисаар байна. Бүх хүн, машин, хамаг юмны толгой зүүн зүг рүү чиглэжээ. Тэр бүхнийг ширтэн харж яваа газарч өвгөн маань гайхшран толгой сэгсрээд:

- Пээ, яасан олон цэрэг, машин буу явж байна вэ. энэ бүгд цөмөөрөө японтой байлдах гээд давхиж яваа хэрэг бий. Манай муу довтолж ирсэн дайсан ч энэ их хүчний өөдөөс яаж ч байлдах юм билээ. Юу ч үлдэхгүй болтлоо хиар цохиулах нь гарцаагүй болоо шив хэмээн амандаа үглэн ярьж явлаа. Замын хажууд гараад эгнэн зогсож байгаа ачааны арваад машиныг Каграманов харсан дороо инээд алдан, нүдээ том болгоод:

- Энэ манайхан байна хэмээн дуу алдан, тэрэгнийхээ жолоог тэр зүг рүү залав.

Каграманов сайн малчны тусламжтайгаар цуваагаа гүйцэж иржээ. Жолооч байлдагч цувааны даргад орчиж ёслон эсэн мэнд ирснээ илтгэж, бусад нөхөд нь түүнийг найрсагаар угтан тэврэн авч хөгжилдөж байхыг замч өвгөн тэрэгний бүхээг дотроос хараад «Эд нар хоорондоо нэг аавын хүүхэд шиг ямар их элэгсэг дотно юм бэ. Энэ жолооч хүүг нөхөд нь үгүүлээд сүрхий санаж мөрөөдөж байж шүү» хэмээн бодож байв.

Каграманов гүйж ирээд тэргэндээ орж суунгуутаа цувааны хамт аяллаа цааш үргэлжлүүлэн, замчин нөхөртөө хандаж:

- Та ёстой сайн нөхөр байна. Одоохон бид цэргийн анги дээр очиж ачаагаа буулгаж өгөөд би тантай хамт буцаж таныг гэрт нь хүргээд, өөрөө бас ачаа зөөнө. Өчигдөр японы онгоцны бөмбөгдөлтөнд манайхаас нэг машин дайрагдан жолооч цэрэг нь шархдаж дээ. Бусад нь зүгээр гэж ярихад өвгөн «Энэ нөхөр маань надад муу юм яасан ч хэлэхгүй нь лавтай» хэмээн бодон, дэргэдэх нөхрийнхөө яриаг бүрэн ойлгож байгаа янзаар инээгээд:

- Зүйтэй сайн байна гэв.

Тэгтэл урд нь яваа тэрэг улаан дарцаг өргөн, түгшүүр зарлаж бас цуваанд таралт хийх тэмдэг өглөө. Каграманов энэ удаад огтхон сандарсангүй, замаас зайлсхийн тэрэгнийхээ хурдыг нэмлээ. Байдлыг ажиглавал аанай л «зүгийн муу» зүүн урдаас нь японы тэмдэгтэй гурван онгоц агаар цалгилуулан гарч ирж байгаа харагдав. Урд хойно нь яваа улаан цэргийн бусад цуваанаа ангиудаас дайсны онгоцыг угтан гал нээж пулемёт нажигнан, том буу ч пин хийн сонсогдлоо. Японы онгоц цувааны дээр арай ирж завдалгүй байтал тэр зэвхий онгоцны нэгнээс хар утаа манаран зам татуулсаар муухай дуугаран унаж эхэллээ. Нөгөө хоёр нь энд

тэнд бөмбөг мултлан хаяж, дэлбэрэлтийн дуу нүргэлэн бөөн бөөн хар утаа баагиулаад эргэн зугтаж харагдав. Каграманов тэргээ тооромсоглон зогсоогоод:

Тэр, тэр хараач! Өчигдөр биднийг элэг бариад гайхуулж байсан чөтгөрийн муу заяатангууд өнөөдөр сөнөх чинь энэ дээ. Мөд та нар бүгдээрээ өөхийгөө наранд ээх бий гээд, тун тайван байдлаар инээн, газарт унан тэртээд дэлбэрэн шатаж байгаа японы онгоцыг харж байв. Замч өвгөн бас сэтгэл тайван янзаар агаар ширтэн:

Хувхай сүүлээ хавчаад зугтаж байгаа чоно шиг самурайн энэ онгоц нэг морьтой хүн давхиж явсан ч хөөж буудаад байдаг муухай золиг гэнэ билээ. Та нараас ч ухаангүй айн зугтаж байх шив. Улаан цэрэг мундаг байна шүү гэж хэлээд Каграмановынхаа гарыг шүүрэн авч чанга атгажээ.

Бид Губагийн ногоон цэцэрлэг дундуур удаан явж зугаалахдаа Каграманов гуайн яриаг чагнан Халх голын тулалдааны талбарт байгаа юм шиг сэтгэл хөдөлсөн байв.

Би замчин өвгөнийгөө гэрт нь хүргэж өгөх далимаар Хэрлэнгээс дахиж нэг ачаа аваад, дараа нь фронтын шугаман дотор ангиудын хооронд юм зөөдөг боллоо. Өдөрт хэд хэдэн удаа японы онгоцны дайралттай учирдаг болохоор сүүлдээ агаарын довтолгооноос огтхон ч эмээхээ байж, харин тэдний урьдаас манай онгоц хөөрч тэнгэрт тулалдахыг л шохоорхон харах дуртай болов. Даан их удсан ч үгүй монгол улсын газар нутаг дээр цөмрөн орж ирсэн японы цэргийн тэр бүхэл бүтэн арми дээр манайхан ёстой л аянга буулгаж орхисон доо. Бид японыг алагдсан цэргийнхээ илжирсэн хүрийн халуун нарнаар элсэн дотроос малтаж аваад цааш нь зөөж хөгөө тарьж явахыг удахгүй харсан. Тэр бол тун зэвүүн, гутамшигтай хэрэг билээ гэж Каграманов яриад баахан бодолхийлж явснаа:

~ Тэр цагаас хойш гуч гаруй жил өнгөрлөө. Халх голд өнгөрүүлсэн намар миний сэтгэлд хоногшсон юм. Нэн их зочломтгой сайхан сэтгэлд нөгөө монгол айлд айлчин ёсоор очих гэж би боддог. Одоо удахгүй тэтгэвэртээ гараад завтай болно. Миний хүртэж байх сул цалинг хоёр удаа дайнд оролцсоныг харгалзан их дээгүүр тогтоогдсон. Би тэр мөнгийг барьж идэхгүй, хүүхдүүд минь бүгдээрээ биеэ даасан зэгсэн амьдралтай болсон. Би хөгшнөө дагуулаад Халх голд очиж шинэ алимны амт үзнээ. Миний нэг найзын шарил тэнд бий. Би түүнд бас цэцэг өргөнө гэж өвгөн жолооч маань хэлээд яриагаа төгсгөв.

Азербайжин нутгийн өтгөн хар хөмсөгтэй, цэцэрлэгч бүсгүйчүүд замд тохиолдон, гарт багтамгүй шахам том ягаан алим бидэнд авч ирж өгөөд:

- Зоогло! Зоогло! Бид энэ жил улсад тушаах усан үзмийн төлөвлөгөөгөө хорин мянган тонноор, алимаа түүнээс хол давуу хэмжээгээр илүү гарган тушааж байна гэж бахархал болгон ярьж, хөгжөөнт дуугаараа ая цэнгэцгээж байлаа.

Эд бүхэн жинхэнэ ах дүү хүмүүсийн чин сэтгэлийн угаас ундран гарсан хүсэл тэмүүллийн үр дүнд болсон үйл хэргүүд байлаа.

САНЖИЙН ПҮРЭВ

Зохиолч С.Пүрэв Говь-Алтай аймгийн Дарви сумын нутагт 1941 онд малчин ардын гэр бүлд төржээ. 1976 онд УБДС, 1980 онд Москва хотноо М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуулийг тус тус төгсжээ.

Уран зохиолын ажлыг 1963 оноос эхэлж «Уулын цууриа», «Уулын намар», «Оноо илүүдэхгүй» зэрэг туужийн ном, «Эх газрын чулуу» роман бичиж хэвлүүлсний дээр «Суварган цэнхэр уулс» кино зохиол бичжээ.

АЗЫН ЦЭНХЭР УУЛ

Өглөөний сэрүүнд газар хороохоор их говиос үүр цүүрээр хөдөлсөн нүүдэл өдөр дунд уулын хормой түшив. Нүүдлийн түрүүн зам даан цуварсан хэсэг үхэр явдалд залхан эврээ сэжлэн хүзүү шөргөөж, говь гатлан уул давж үзээгүй тугалууд нь эхийн сүүдэрт нойтон хамраа хаа нэг шургуулан шөрөн шөрөн алхална. Түүний араас энэ хоёр айлын хоньд нарийн хүрэн тоос будруулан тааваараа урагшилна. Гэрэлмаа эмээлийн бүүрэгнээс зүүсэн жижигхэн хүлээн авагчийнхаа дууг сонсон олныг бодож явлаа.

Цогтбаяр энэ жил арван найм шүргэж аминдаа эр танаглаж яваа ч Гэрэлмаагаас баахан нүд хальтрамтгай. Залуу нас гэгч түүнд эр бяр амтагдуулан, бардан сайхан хүслэн хайрлавч айж ичих, нууж шаналах юм гэгч бас бий. Цогтбаярын ээж хэмээх бүдүүн ташаатай, харваас тамирлаг байрын зузаан бор авгай урьд эртийн журмаараа нүүдлийн хөтөч болж нүдэнд нь усан хүрээ татсан ахимаг цагаан атныхаа бурантагнаас үе үе чангаан, биед түшигтэй хэмээн өчигдөрхөн сүргээс барьсан номхон хээр мориныхоо эмээл дээр хазгайдуухан суужээ. Цагаан атны нуруунд тэгнэсэн хоёр арагт Цогтбаярын ихэр хоёр дүү нэг нэгээр сууж, өөдөөс сэвэлзэх намираа салхинд нүд нухлан, гар хуруугаараа наадаж алжаалаа мартана. Ачааны хажуугаар хойтонгийн нүүдлийн ач даахгүй шахам болсон ноолгор халтар нохой чулуунд бүдчих авч бус сөөг шиншлэн шогшино. Тэр бас сэрүүн сайхан уулынхаа нэгэн зуныг үзэх гэж амь тэмцэн яваа бүлгээ. Бие биенээс нь чөрхөлсөн тэмээд хүзүү сунгасхийн, хамар сарталзуулж газрын өгсүүр өөд зүтгүүхэн явна. Ачааны дунд хирд Цогтбаяр, Гэрэлмаа хоёрын аав морины хөнгөн явдалд бие бүүвэйлэн хол ойрыг ярилцсаар гарч ирэв. Сүүлчийн тэмээн ачааны араас, идэр залуугийн сайхан нь тэр л чигээрээ үлдсэн духандаа ов тов сэвхтэй, бие нуруу гоолиг тавиун харц, өрөвч сэтгэлтэй Чулуун явна. Тэр хүн энэ ганц охин төрүүлсэн нь Гэрэлмаа билээ. Чулуун, жилийн жилд нүүдлийн араас гэлдрүүлэн аль тэмээний ачаа суларч алиных нь хазайсныг харж засаж явдаг билээ.

Дарвийн нурууны давчуухан хөндийн зам мөшгөх үес цэнгэг усны чийг амьсгал зөөллөн, голын хойт талын дэвсэгт буй хэдэн гэрийн гаднаас хоёр хар нохой ярдаг чанга дуугаараа хад хавцал алгадан нүүдлийн зүг сум шиг орж ирэв. Тэр чимээнээр гэрээс улсууд гарч, эхнэр хүүхдүүд домботой цай, тавагтай идээгээ барьсаар нүүдэл тослоо. Цогтбаярын ээж Ханд морины жолоог татан зогсоос, бүх хөсөг хөл амраан сая л уул гэгчийг үзэж буйн адил нүдэн дээр тулж ирсэн бараан уулсын орой дээгүүр тэнгэр харан, зарим нь ботигорсон шаргал шээс савируулж тэр нь замаа уруудан яах ийхийн зуургүй жирэлзэн урсах нь энд хур бороотой, газар дэлхий усанд ханасныг бэлхнээ хэлэх ажээ. Гэрэлмаа Цогтбаяр хоёр хол замд ам цанган уруул хатаж явсан болохоор цай уухаар ачаан дээрээ ирлээ. Нүүдлийнхэн чухамдаа насандаа мартаггүй шаргал цайнаас хөлс савируулан ууцгааж эрдэнэ, хаш соруулт урт гаансандаа дүнс нэрэн:

- Танайхыг удахгүй хярд гарна гэж мэдэж байлаа л даа. Өвгөн бүр хүлээж цөхрөөд нүүдэг ч юмуу гээд өглөө ачлагтаа явсан. Одоо энд бүгчимдээд сууж болохоо байлаа хэмээн нэгэн хэмийн үргэлжилсэн намхан дуугаар ярив. Хүү нь эхийнхээ хормойноос зууран хажуу талаар нь хавтгай шар нүүр гялайлган хүн хүнийг гайхсан харцаар нүд цавчилгүй ажина. Хүүгийн ээж Цогтбаярыг гүймэг хараад:

- Энэ ингэтлээ том болох гэж. Хоёр дүү шигээ арганд сууж ачаанд тэгнүүлээд хяр давж байсан нь саяхан даа гэж тэртээ олон жилийн цаадтайхыг гүймэг дурссанаа, Цогтбаярын хоёр дүүгийн зулай дээр үнэрлэв. Алив хүүгээ нээрэн ч том болсон юм уу гэсэн байртай олзуурхан харснаа:

- Овоо л болж байгаа юм. Гэхдээ яаж арван тэмээ ачаалах вэ. цэрэгтээ яваад ирэхээр бяд ухаан хоёр сууна гэсээр тавагтай идээ дээр байсан том өрөмнөөс тасдан аягатай цайндаа хийлээ.

- Манайхыг хүлээгээд л зусландаа гарч чадалгүй суугаад байв уу? хэмээн Гэрэлмаагийн аав нь асуулаа

- Хүлээлгүй яахав энэ чинь. Говь гаталж ирж байгаа улсад аяга цай залгуулаагүй амиа бодоод нүүлээ гэж амьтан ах дүүс муулах байгаа. Чухам нутагт гараагүй юм хийнэ гэсэн үг гэж хэлээд мөнөөх авгай дахин цай аягалав.

- Танайхан хаагуур зусах гэж байна?

- Майхны эхэнд буух байхаа, өвгөн тийм юм хэлж байсан

- Ашгүй дээ! Ганц зун ч бол айл аймаг зусаж шуугиж явъя.

Нүүдэл хөдөллөө. Авир морины олмоо чангалах зуураа:

- Хүүхдүүдээ! Үхрээ тэгээд орхичих, аяндаа цаадуул чинь хойно урдаа орж гэлдэрсээр байгаад даваа давчихна. Харин та хоёр хонио туу! Ямаа цоролзуур мал шүү. Хойт урьд хоёр уулын асганд авирчихвал цаашаа л явна уу гэхээс наашаа толгой эргүүлэхгүй гэлээ.

Гэрэлмаагийн цэнхэр дурдан алчуур, ханцуй нь сэмэрсэн ногоон тэрлэгийн мөр малын хөлийн тоосонд дарагдан бууралтжээ. Халуун цай уусан болохоор хошуу нь тэрүүхэндээ тойрон улайж нөгөө л дунд сургуулийн наймдугаар ангид байсан шигээ даруухан сүлжсэн тийм ч өтгөн бус хоёр салаа гээг нь эмээлийн ганзаганы үзүүр шүргэж алдан сугсалзана. Гээгэндээ зүүдэг тууз нь л алга байлаа. Бусад юм бүгд хэвээрээ, харин бие төрх өсөн харц булаах нь даанч хэцүү. Цогтбаяр тэр хоёр дөрөө харшуулан явсаар хонио гүйцсэн хойноо морины жолоог татан эргэж нэг харлаа. Тэртээ доод руу ХҮЙсийн говь усан зэрэглээгээрээ наадан цэлэлзэж, газар тэнгэр хоёрыг ялгах нь аргагүй намилзана. Сайн ажвал ногооны униар тэнгэрийн хаяа шүргэж алдан гүн цэнхэртэж, түүнээс дээш сийрүү саруулхан ажээ. Тэнд Гэрэлмаа төржээ.

- Хоёулаа хониныхоо хоёр талаар явах уу? хэмээн Гэрэлмаа асуув. Цогтбаяр эмээлийн бүүрэгнээс базлан доройтон тонгойсоор

- Хамт л явж байя гэж уруул хөдөлгөх төдий дуугарав

- Ичиж байна

- Хэнээс? Би наад радиог чинь сонсож явмаар байна шүү дээ

- Тэгвэл май! гэсээр Гэрэлмаа ширэн хайрцагт жижиг хүлээн авагчаа эмээлийн бүүрэгнээс мултлан дууг нь хангинуулсаар Цогтбаяр руу сарвайхдаа сүрхий шоглосон янзтай инээв. Цогтбаяр энэ хир эр хүн гэсэндээ дотор дүрсхийн:

- Наадахаар чинь яах юм гэв.

- Тэгээд? эгчээрээ оролдох санаа байна уу? Аав ард явааг мартаагүй биз? хэмээн өгүүлээд Гэрэлмаа нүүр буруулаад хоёр мөр нь тэрүүхэндээ хөдөлж байв. Түүнийг доог тохуу хийн инээсэнд нь Цогтбаярын эгдүү хөдөлж:

- Ядахдаа зургаан сарын түүрүүн төрсөн бол ийм үг хэлж болно доо гэхдээ энэ үгийг аав ээж сонсох юм шиг хулгасхийн эргэж харахад нүүдэл тэртээ дор бүрэн баран байсанд дотор уужран Гэрэлмаагийн морины жолоог шүүрч

- Хөтлөөд давхичихна шүү гэв

- Буугаад үлдчихнэ гэж сайхан юм бий

- Чиний санаа чинь гүйцэгдэхээ өнгөрчээ

Тэр хоёр гэнэт түсхийн инээд алдаж бүр элгээ доргитол хөхрөлдөн юу ярьж хэлэлцсэнээ мартан байтал Гэрэлмаа урд уул руу гар сунган:

~Тэр харав уу? хэмээв. Чавга гэдэг нэрийг хэдий нь билээ хүртсэн хув улаан ямаа бүх сүргийг удирдан урьд арын асган өөд дүүлж байлаа. Ямаа асга дамжсан цагт хуурай модны ёроолоос гал тавьчихсан лүгээ адил алга болж өгдөг болохоор Цогтбаяр морины жолоог тийш эргүүлж ард нь Гэрэлмаа:

~Хүүе Цогтоо! Энэ хоргодоод байсан хүлээн авагчаа авахгүй юм уу? гэх доогтой дуу хадаан хоцров. За гайгүй ээ, чи тэгж л бай! гэж Цогтбаяр өөртөө шивнэсэн авч өдөржин гэгэлзсэн сэтгэл нь тогтож, арай дэндүүлчээгүй байгаа би хэмээн бодож эмээлийн гөлмөө дарчигнуулан давхисаар шогшуулав. Гэрэлмаа түүний араас харц үл салган сургуульд байхдаа толгойг нь аваад явсан ч хөдлөхөөргүй амьтан байсан, хүн бас ийм юм ярьдаг аа. Хачин хүүхэд шүү хэмээн бодно. Тэр хоёр хар нялхаас нэг голын шороог ухан тоглож, усыг амтлан өссөн боловч дунд сургуульд орсон цагаасаа эхлэн бие биеэс баахан хөндийрч Гэрэлмаа нь Цогтбаярыг, намайг харж хандахгүй байна гэсэн бяцхан гомдлыг сэтгэлийн мухарт өнөө хүртэл хадгалан яваа билээ. Тэглээ гээд хошуу мурийсангүй хоёр гэрийнхээ хонийг ээлжлэн хариулж, инээхдээ инээн, ичихдээ ичсээр Алтайнхаа нар салхинд бие сэтгэл бойжсоор яваа нь энэ. Цогтбаяр урд ар өөд өссөн хонио намд буулгаад Гэрэлмаа дээр ирлээ. Тэд хэсэг зуур жолоо сул тавин гэлдрүүлснээ олон жил айл нутаглаагүйгээс эзгүйрч халгай шарилж сэгсийтэл ургасан бууцын хажуугаар гарахдаа нурж сэтийсэн чулуун хашааг харан Цогтбаяр

- Энд шинэ хашаа барих уу? хэмээн Гэрэлмаагаас асуулаа

- Барь барь!

- Чи зүгээр ярь л даа

- Зүгээр л ярьж байна шүү дээ. Дахиад л цаад улаан ямаа чинь уул өөдөө шоролзлоо.

- За яахав тэгээд жаахан явж байг. Би чамтай ярих юм байна. Чи сонсох уу?

- Би дуу сонсож байнаа. Тэр нь чамд ч дээр биз дээ? гэж Гэрэлмаа эгдүүтэй хэлээд инээмсэглэв. Түүний инээмсэглэл, эртхэн бодол харцанд нь наадсан гал хоёр нүд, огтоос дуу сонсоогүй харин ч сэтгэл нь нууцхан дэвэрснийг бэлхнээ хэлэх ажээ.

- Наадахаа унтраачих, зай нь дуусчихлаа

- Дууссан ч яах вэ. Дуугарч байсан нь дээр юм.

Тэд ийн ярилцсаар хөндий өгсөн, сэрүүн тэнгэрийн хэвлий өөд ойртсоор байлаа. Нүүдлийн түрүүч мөнөөх бууцны хажуугийн замаар гарч ирэх үес Цогтбаярын эцэг эхнэрээ гүйцэн ирж:

- За Ханд минь алжааж явна уу? хэмээн тоомжиргүйхэн лавлав. Тэр хоёрыг хөндлөнгөөс харахад ханилж суусан хориод жилийн амьдралдаа ярих юмаа бүгдийг шавхчихсан гэлтэй гэр орондоо ч хээр гадаа ч үг цөөн солино. Ханд нөхрөө гайхан харснаа:

- Чи чинь өнөөдөр юу болчоо вэ? гэв

- Яачихсан байна? Ингэхэд чи санаж байна уу? Хандаа? Танайх тэр зүүн буурин дээр, манайх баруун буурин дээр нь байлаа шүү дээ. сайхан байжээ бид хоёр.

Ханд бүдүүн ташаагаа хөдөлгөн эмээл дээрээ суудал засаж, нөхрөө бас ч гэж сэтгэл хөдлөн хайрын нүдээр харсан хирнээ:

- Энд чи надаар анх наадсан чинь санагдав уу? гэж егөөдөв. Тэгсэн мөртлөө дотроо, манай Авир залуудаа ч сайхан амьтан байсан юм даа. Яаж ч болохгүй сэтгэл булаасан хүн хэмээн хайрлаж нөгөө өл ялдамхан харцаараа хүрлэгэр царайг нь илэв.

- Наадах ч гэж дээ хө, ертөнцийн жам хойно яахав. Тэглээ гээд бид дордсон юм алга. Гурван сайхан үртэй болж л явна шүү дээ. Юм гэдэг ингээд цагаа дагаад өнгөрөх аж. Энд манайх буулгүй хичнээн ч жил болов. Хашаа маань нурчихаж. Халгай шарилж ургасаар байгаад хот маань гэрийн буурь шиг л умгар хар юм үлдэж дээ.

- Чи ухаантай эр хүн мөрсөн бол намайг сахиж суухаар нутгаа засаж явах учиртай. Манайх буудаггүй юмаа гэхэд өөр нэг нь нутаглана. Муу эр гэр амьтай гэдэг сүрхий үг шүү гэсээр нөхрөө энэ яаж нь вэ? гэсэн байртай харав. Бууцын хөлний халгайн дотроос хэдэн болжмор дэргэн нисч, нурсан хашаан дээр суун өд сөдөө гөвөө. Ханд, бид хоёр дэндүү сайн байдаг болохоор бие биенээ гомдоно чинээ саналгүй үгээр шөргөөцөлдөх юм даа. Энэ чинь миний хань, гурван сайхан үрийн минь эцэг, нэг биеий минь дөрөв хувааж, дөрвөн халуун амьсгал болгосон эр хүн шүү. Би амаа татаж явахад гэмгүй хэмээн өөрийгөө зэмлэж үзэв.

- Хойтон ирж буунаа. Хөөрхий муу талийгчаас хойш, сэтгэлээ зовоож явалгүй мартагсан гэж санаад буухаа байсан юм. Хүүхдүүд маань ч бид хоёрыг энд хана дугуйлж тооно өргөснийг мэдэж аваг.

Авир ийн өгүүлснээ эхнэрээсээ үг сонсох санаатай хөлс дааварласан нүүрий нь ажиг. Ханд түүнийг харсан ч үгүй

- Үхэхдээ үгээ хэлнэ гэж хадгалж явсаар байгаад үр хүүхэддээ юу ч сургахгүй өнгөрөхөөр, хэлэх юм байвал ухаан саруулдаа хэлж, сургаж байвал дээр дээ. Аав минь надад зөндөө л юм ярьдаг байсан. Чамд өгөхийнхөө урьд өдөр хүртэл цаадах чинь архинд дуртай хүн шүү, сайн хэлж бай! Хүний үрийг болно бүтнэ гэж санаж яваа бол үгээ битгий харамла! гэсэн намайг үг хэлэхэд чи нохой хуцсаны чинээд бодох биш гэсээр том алчуур өврөөсөө гарган магнайнаас эхлэн эрүүгээ шувтарсаар хөлсөө арчив.

- Чи намайг дандаа хэтрүүлж байх юм. Чиний үгэнд зөндөө л орлоо. Одоо ч орж явна гэсээр Авир дөрөөн дээрээ өндийн эхнэрийнхээ бэлхүүсээр тэврэн биедээ ойртуулав. Ханд тийм ч дургүй биш байлаа

- Хар халуунд хүн ноолоод. Уйдаггүй юмуу?

- Сайхан л байна даа. Сайхан гэж Авир хэлэв

- Цаашаа бай! Чулуун, Эрдэнэ хоёр юу гэх юм билээ. морин дээрээ ноцолдоод юу болчиг гэвэл... хэмээн Хандыг сануулахад Авир эхнэрийнхээ бэлхүүсээр таалан тэвэрсэн гараа авч

- Үе үе сэтгэл хөдлөх юм даа гэж санаашран дуугарав. Ханд эр нөхрийнхөө үгийг сул гээдэггүй зангаараа:

- Би ч чамд үргэлж сайхан харагдах биш дээ. Гурван хүүхдээ чирээд зайлах газаргүй болохоор голомтны чинь үнсийг зөөж явах юм. Би чамайг өрөвдсөндөө өврөө нээсэн юм. Чи намайг эдлэхээ мэдсэнээс биш эрхлүүлэхээ мэдээгүй. Эмэгтэй хүн нэг ч бол дураараа эрхэлж жаргах юм шиг байдаггүйг чи насаараа мэдэхгүй явсаар одоо боллоо гэхдээ тэгтлээ ч цөхөрсөн янзгүй, харин ч жуумалзан инээмхийлэв.

Нээрэн ч тийм шүү золиг! Энэний үглэдэг ч аргагүй л байхаа даа гэж Авир эхнэрээ өрөвдлөө. Тэд анх л айл гэрийн үүдийг нээж өрх татсан, энэ орчлонд мартаж болохгүй бууцныхаа хажуугийн замаар тэмээн тавхай ярс ярс хийлгэн өнгөрлөө. Тэд ид залуу нас, бие биедээ хуурай тунирхавч сэтгэлдээ жаргалын шүтээн болгон хайрлаж явдаг анхны учралаа нэхэн санаж үг дуугүй гэлдрүүлэв. Авир насны даваанаас залуу цагаа эргэж харсан гундуухан бодлоор зүрхээ булгиулан сайхан ч байж дээ. Ахиад нэг залуу болдогсон бол тэр цагийн алдаа нүгэл бүхнийг гэсгээн ухаантайгаас ухаантай амьдрагсан ч гэж бодно.

- Ханд аа! Дахиад нэг залуурахсан гэж нөхрөө өгүүлбээс Ханд:

- Яах нь вэ! өөр авгай авах нь уу? хэмээн цаашлуулав

- Үгүй дээ, одоогоосоо ухаантай явахгүй юу

- Харуусах хэрэггүй ээ. Чиний залуу нас чинь аль түрүүн хөндийн өгсөөд хэдэн хонио хөөгөөд алга боллоо. Даваан дээр гараад уулзаарай. Түүнийгээ л нэг хүн шиг болгож үз хэмээн эхнэр нь бардам хэлэв.

Нээрэн ч тийм юм даа. Миний хүү эр болж явна шүү. Хүнд түшигтэй л хүн болоосой билээ. Бидний багыг бодоход одоогийн эд сургууль соёлын мөр хөөж үзсэн нь бага байлаа гэхэд дуулсан нь их болжээ. Тэгээд ч манай Цогтбаяр хашир хүүдээ хэмээн хүүгээрээ бардаж нэг бодов. Эхнэр нь, хичнээн ч жил би үүндээ тунирхах вэ. одоо амаа татаж явъя. Энэ байхгүй бол би өдий зэрэгтэй байх уу? Хөөрхий минь хүний урманд намайг мөр улайлгаж, гэдэс өлсгөсөнгүй хэмээн санаж улаан нүүрэн дээр тулж ирсэн хад асгат бараан уулсын оргил өөд ширтлээ. Уулсын харц шовх оройд хөнгөн будан сэмэрч, тув тунгалаг тэнгэр алга дарамхан газар цэнхэртэнэ. Тэр шовх бараан оргилын цаана гарч, тэнгэр цэнхэртсэн зусландаа буухад амьсгал уужрах билээ. Эрдэнэ ачааны түрүүчийг гүйцэн ирж Авиртай зэрэгцэн:

- Хоёр банди унтчихаж хө гэв.

Авирын ихэр хоёр хүүхдэд Чулуун, Эрдэнэ хоёр амь мэт хайртай бөгөөд бид хоёрт хүүгийн заяа дутсан гэж ярих дуртай. Хүүхдүүд тэмээний явдалд бүүвэйлэгдэн нэг нь урагшаагаа нугдайж, нөгөө нь арагны ирмэг халхалсан дээл дээгүүр можигор гар унжуулан унтаж байв. Өгсөх тусам газар огцомхон сэрүү татаж, аги гангын үнэр анхилан, алтан хараацай унасан морины омруун доогуур сүвлэн нисэж эхлэв. Сэрүүн сайхан Алтай гэгч зундаа амьд бүхнээ оргилдоо дууддаг бүлгээ. Шувууд хүртэл цэцэг жимс, нар салхиа дагах юм даа гэж Авир ус нутгаа бахдан энэ азын цэнхэр ууланд амьтан бүхэн бий. Жаргая гэсэн хүн энд төрдөг юм. Миний хүү азтай хүү шүү дээ. Тэрийн болгон хүн ийм сайхан газар, ийм эрээн алаг цэцгэн дээр хөл тавьдаг юм биш. Уул шигээ түшигтэй, тал шигээ сэтгэлтэй хүн яваарай хэмээн захисан эцгийн сургаалийг чимээгүйхэн санаж явлаа.

Зуны эхэн сарын гал шаргал наран Сутай уулын баруун мөрөн дээр алтарч байхад нүүдэл даваан дээр гарч ирлээ. Нүүдлийн түрүүнд даваа давсан хонь үхэр нь бэлчээр дүүрэн налайж, хүү охин хоёр нь оройд ёрдойх хоёр гурван зэвхий модноос уясан элдэв даавууны тасархай зөөлөн салхинд үе үехэн дэрвэнэ. Нүүдлийнхэн овооны дэргэд ачаагаа зогсоон овоонд чулуу нэмэрлээд, Авир түрүүчийн тэмээг сөглөн хэвтүүлж нойрондоо дарагдсан хоёр хүүгээ сэрээн арганаас буулгаж газар гишгүүллээ. Нойрмог хүүхдүүд өтгөн өвсөнд хөл орооцолдуулан хоёр гурав бүдэрснээ тэнцэж газар дэлхийг гайхан байв.

- Айдаа бас сайхан зуншлагатай байна даа гэж Эрдэнэ өврөөсөө дуран гарган хавь ойрыг дурандахдаа хэрэг болгон Гүний овоо хэмээх уулын орой руу харав. Хоёр бараан морь бие биенийхээ сүүдэрт толгой хоргодон сүүлээ шарваж зогсоно. Чингэтэл охин нь морьдын цаад талаас, Цогтбаяр араас нь гарч ирэхийг хараад дурангийн хараагаа бушуухан эргүүлж

- Ай даа бас сайхан зун болж байна даа гэдэг үгээ давтав. Авир түүний нь ажин эхнэр рүүгээ нүд ирмэснээ, манай тэр гайхал ер нь юу л хийгээд яваа хүн бол? гэж санав

Чулуун ногоон дээр жижигхэн ширмэл ширдэг дэвсэж идээ цагаа засан аяга шаазан тавиад:

~ За цай ууцгаа! Гэхдээ ёс төрийг бодож Алтайдаа цайны дээж өргөхдөө аав ээж маань ч сайхан заншилтай улс байж дээ. Нутгаа хайрласнаас л ийм заншил гарсан байхдаа гэж санан түүхий сүүний тос даасан бяслаг, зүсэм өрөм, хэдэн ааруул овоон дээр тавилаа. Үүнийг Алтай зооглохгүй, Алтайн минь нэг амьд амьтан, үнэг туулай ч юмуу, жигүүртэн үгүйдээ чоно ч бол аваад идчихэг гэж бодов. Чингэснээ ачаа даган туйлдаж нүд цийлсэн нохойдоо зэхий хярам долоолгон голыг нь норгов.

- Хүүхдүүд ирж цайгаа уугаасай билээ. Эд ч тэгээд цайсах биш дээ. ус ч бол унд болж явдаг нас гэж Ханд хэлэв.

- Ачаагаа хараад ирцгээх байлгүй гэж Эрдэнэ эхнэрээ нүднийхээ булангаар ажин өгүүлээд гаанс тамхи гаргав. Ханд халуун хүзүүнд нь хадаг уясан ваартай архиа гарган дөрвөнтээ домчлоод сөхөрч суун түшиж аягалав

- Май хө Эрдэнээ? Чулуун алив чи наашаа суу гэсээр хундагатай нэрмэл барив.

- Намайг мартчихаж байгаа юм биш биз дээ? хэмээн Авир хүд хүд хөхрөн завилж тухлав.

- Хаанаас даа. Муу өвгөнөө мартчихвал гомдоно байгаа гэж Ханд хэллээ. Бид дөрөв даанч сайхан үерхсээр, түүнийхээ хүчинд өдий хүрчээ. Ханд Авир хоёр шиг түшигтэй улсыг бидэн хаанаас олдохов гэж Чулуун дотроо бодож суулаа.

Гүүний овоо хэмээх эрт цагийн тахилгат уулын орой дээр хоёр морь сүүл шарван зогссоор л байлаа.

~Ачаа даваан дээр ирчихсэн байна шүү дээ! Хэмээн Гэрэлмаа, Цогтбаярт анхааруулсан хиртээ тэртээ доргогш шовх орой нь түмэн жадны үзүүр шиг шивээлсэн сүр бараат их уулсыг харсаар суулаа. Тэр уулсын тэхийн биенээс арай дээхнүүр торгон будан мушгирч, нарны туяа туссан хад хавцал нь хүрлийн хүрэнтэнэ. Уулсаас цааш үүр шөнөөр ачаалан гарсан Хүйсийн говь үлгэр, зүүд хоёрын алин болох үл мэдэг өнгөөр суунаглан сэтгэлийг нь булаана. Хараад байгууштай байлаа. Газрын оёороос оройд нь гарсан энэ нүүдэл Гэрэлмаагийн амьдралд хэдэнтээ давгагдсан ч өнөөдөр шиг сэтгэл сэнсрүүлсэн нь үгүй. Мөнөөх эмээлийн бүүрэгт өлгөсөн хүлээн авагч нь ая дуу ч үгүй паржигнаж хэрчигнэсэн чимээгээр чих цоргино. Гэрэлмаа өчигдөрхөн хонь хариулж явсан, одоо нүдний үзүүрт униартах их говио ажсаар, аавыг сумын төв орохоор гоё дугуй толь, нүүрний будаг захъя байз гэж бодож суулаа.

Цогтбаяр мөн л Дарвийн нурууны ар болох цийлэн цэнхэр говьдоо харц бэлчээн Гэрэлмаагаа өнөөдөр би дэмий л зовоож дээ. Тэгээд л энэ маань ингэтлээ бодол уйтгар болсон байх хэмээн өөрийгөө зэмлэнэ. Тэртээ дор шовх оргил дээгүүр түүрүүнээс хойш эргэлдсэн хоёр тураг шувуу, баасанд цайрсан ханан хадан дээр зэрэгцэн сууж элгэн биеэ наранд ээнэ.

- Явах уу? Хэмээн Цогтбаярыг асуухад Гэрэлмаа:

- Явья л даа гэж зүрхэнд ойрхон хэлээд Цогтбаярт гараа өглөө. Гэрэлмаа хормойн цагаан өвсийг гөвсөөр морь руугаа очлоо. Цогтбаяр түүнийг ажин магнайгаа гунигтайгаар үрчийлгэн хөмхий хазална. Газрын намд буусан хойноо Гэрэлмаа айж цочирсон дугаар

- Аав юу гэх бол? хэмээн гэнэт асуув

- Бид юу ч хийгээгүй шүү дээ

- Тэгсэн ч гэсэн дээ

Тэр хоёр давааны ард налайх хонь руугаа явлаа. Тэднийг харсан Эрдэнэ хоолой засан, өмнөх хундагатайгаа балгаад

- Хүүхдүүд ирж амныхаа цангаа гаргахгүй юм болов уу? гэж Авираас асуух янзтай дуугарав

- Аяганы амсар зуулгалгүй яахав. Мал дагасан муусайн хүүхдүүд буяны нь үзнээ гэсээр Авир суудлаасаа босч хөлс шороонд пад хар болсон хуучин бүрх малгайгаараа даллав. Гэрэлмаа

- Очоод яах юм бэ гэж Цогтбаярыг хориглоно

- Очье доо, өөр хаашаа явах вэ

Гэрэлмаа Цогтбаярыг даган гэлдэрлээ. Одоо түүнд энэ хүн шиг нөмөр нөөлөг байхгүй санагдана. Эр хүн гэсэндээ зүрхтэй байх нь гэж бас ч сэтгэлдээ урамшив. Тэр хоёрыг ирэхэд эцэг эх нь санасныг бодоход юу ч хэлсэнгүй, харин ч холын зочид шиг хүндлэн

~Миний хүүхдүүд цай уу. хөөрхийс дөө, мал дагасаар байгаад явдалд харшчихаж. Тэгж явсаар байгаад нэг юм болноо. Энэ азын цэнхэр ууланд чинь ажилтай, ухаантай, ах дүүдээ элэгтэй хүн амьдардаг юм хэмээн аавын сургаалыг хүүдээ хэлээд Авир, Цогтбаярыг эр болж дээ гэсэн харцаар ажиг. Эрдэнэ:

Алив хө Авираа, чи Цогоод шимийн юмнаасаа хийгээч гэж хэлэхэд нь Цогтбаяр эцгээсээ эмээн царай улайлгав. Аав нь архи хундагалан хүүдээ ёс төртэй барилаа. Цогтбаяр, үгүй мөн хачин юмаа. Аав надад архи өгч байдаг. Уучихвал яадаг бол? Хэмээн гайхсаар Гэрэлмааг сэм харвал түрүүхэн зүрх нь хагарчих гээд байсан хүн харин өрөөсөн нүдээ ирмэн дооглох аястай суув.

Даваан дээр гарсан эр хүн байна даа, балгачих гэж Эрдэнийг өгүүлбээс Цогтбаяр нүдээ аниж байгаад хүртэж орхилоо. Хамар амаар сэнгэнэн, нулимс цийлэлзэж өр гол зураад явчиг. Арайхийн амьсгаа аваад эцэг эх хоёроо харваас бүрд гайхаж хоцорсон улсууд амаа ангайх нь холгүй сууна.

- Одоо болноо гэж Цогтбаяр хахаж цацан хэлэв

- За хөдөлцгөөе. Бид хоёр түрүүлж очоод гэрийн буурь харж байя. Ханд та хоёр зүтгүүлээд хүрч үз хэмээн Эрдэнэ эхнэртээ хэлэв.

- Миний хүүхдүүд хониндоо яв гэж Авир хүүхдүүддээ хэлээд өвсөн дээр дээш харуулан хаясан хуучин бүрхээ өмслөө. Хүүхдүүд малдаа явж, туулайн зоо шиг уран дэнж дээгүүр Авир, Эрдэнэ хоёр шогшуулан давав. Ханд, Чулуун хоёр голын үгээ ярьж явлаа.

- Хөөрхийдээ би муу Авирыгаа оролдсоор байгаад ууры нь барчихсан юм. Эр хүн үерхэнэ гэдэг хараад атаархмаар юм даа. Манай нуруунд энэ хоёр шиг салж хагацахаа байсан нь ховор шүү. Мал хүртэл ижилддэг хойно хүн ч аргагүй юм байхаа даа.

- Ёстой хар нялхаасаа үерхсэн хоёр доо. Чи бид хоёр ч азтай шүү хө. Энэ нутагт ховорхон л эрчүүдийн гал түлж явна. Үүнээс илүү яахав хэмээн ярьж явлаа.

Майхны гол ус булаг нь харгилан, цэцэг нь алаглаж байлаа. Түрүүлж буусан айлуудын мал хунх хотоос болгоны нь эзлэн налайж, хүн мал шуугилдана. Гэрэлмаа, Цогтбаяр хоёр гэрээ барьж байхад ирлээ. Ачлагаас суларсан тэмээд гол уруудан ааг зоог алхална. Цогтбаяр жолоо татан морины алхаа сааруулж:

- Гэрэлмаа, дахиад уулзах уу? гэж аргадангуй дуугаар асуув

- Уулзъя аа. Зургаан мөнгөн мичид дээр уулзъя. Би тэнд таныг хүлээж байна гэсээр Гэрэлмаа хормойгоороо өвдгөө ороон эмээл дээрээ цэмцийв

- Үнэнээ хэл л дээ Гэрэлмаа

- Үнэнээ хэллээ. Тэнд надтай уулзаарай

Тэр орой нүүдэлд ядарснаас ч тэр үү уртаас урт бүргэр үдэш болов. Гэрийн дотор эд хогшил, авдар саваа нааш цааш нь зөөж байрлуулан сүү сааль гэсээр од түгсэн хойно унтацгаалаа. Гэрэлмаа ор дэвсгэрээ тэврэн гадаа унтана гэсээр гарав. Цогтбаяр мөн л хөнжлийн цагаан даавуугаа хөглөрүүлсээр гарч алга боллоо.

Их уулын шөнө сэрүү татан, хар шүүдэр бууж чийг даана. Хаа нэгтээ монголын бух сүр бадруулан урамдаж, голын ус шоржигнон урсах нь хүртэл ойрхон сонсогдоно. Шөнийн зөөлөн салхи чихнээ нэгийг шивнэх ажээ. Гэрэлмаа бараг нүүрэн дээр унасан зургаан мөнгөн мичдийг ширтэж, Дарвийн нуруу гэдэг даанч өндөр юм даа. Одод дунд хонь нь хотлохоор газар. Ингээд зусландаа ирдэг байжээ хэмээн бодож нойр хулжаан байлаа. Цогтбаяр элгэн дээрээ гараа зөрүүлэн гүн харанхуй тэнгэр өөд ширтэж, мөнөөх зургаан мичдийг нүдээр тоолон яах ч аргүй зургаан л од юм даа. Сайхан ч од юм. Гэрэлмаа хачин хүүхэд шүү гэж санаснаа гэнэт сэхээ авч лав гадаа унтсан байх. Тэгээд л хэмээн босч нойтон өвсөнд оймсоо норгосоор мярайж очив. Гэрэлмаагийн толгой тус газар чимээгүйхэн сууж амгалангаас амгалан царайг нь хэсэг ажлаа. Гэрэлмаа зөөлхөн амьсгалж бөх гэгчийн нойрсон байв.

- Гэрэлмаа би байна. Гэрэлмаа!

Гэрэлмаа нүдээ аньсан хэвээр:

- Би болзоондоо оччихоод ирсэн шүү дээ

- Чи унтаагүй байсан юмуу?

- Яаж унтах юм? Юм бодож байна

- Юу бодож байна?

- Аав толь авчирч өгөхөөр нүүрээ харж гоёод тэгээд болзоонд дахин очихгүй юү!

Цогтбаяр түүнийг хайрлан харсаар байлаа. Гэрэлмаа тэрүүхэндээ инээмсэглэснээ, гэнэт гүн бодол нүүрэндээ тодруулан сүүрс алдав. Ингээд л явж байя даа. Энэ хүн өөрөө мэднэ биз. Цаг нь болохоор энэ айлын ачааг би хөтөлж, цаст цагаан уулынхаа даваа бүхнийг давах ч юм билүү хэмээн боджээ. Гэрэлмаа Цогтбаярын гарыг халуун алгаараа атган:

Явж унт даа, маргааш чиний хонины ээлж, явж унт гэв.

Үүр хаяаран уулсын дээгүүр шаргал туяа хярхаглана. Цэв цэлмэг нэгэн сайхан өдрийн зураг шиг ганц шунхан улаан үүл Гүний овооны хад чулуунаас хагацаж ядан зууралдах ажээ.

БЯМБЫН РИНЧЕН (1905-1977)

Зохиолч Б.Ринчен, 1905 онд Хиагтын Бул Сарай гэдэг газар төржээ. Бага наснаас монгол орос хэл бичиг сурч дунд сургууль, ЗХУ-ын Ленинград хотын дорно дахины институтын тусгай курс төгсөж, 1956 онд “Монгол хэлнүүдийн харьцуулсан түүхэн хэлний зүй” бүтээлээрээ БНУАУ-д хэлний шинжлэлийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Уран бүтээлээ 1923 оноос эхлэн “Үүрийн туяа” гурамсан роман, “Заан залуудай” балар эртний сэдэвт роман, “Гүнж”, “Бэр цэцэг” зэрэг шүлэг өгүүллэгийн ном “Цогт тайж” түүхэн сэдэвт кино зохиол бүтээжээ. Б.Ринченгийн “Үүрийн туяа” роман орос, чех хэлнээ орчуулагджээ. Б.Ринчен олон жилийн турш эх хэлнээ гадаадын утга зохиол орчуулах ажилд хүч чадлаа дайчилж Горький, Маяковский, Эренбург, Тихонов, Шолохов, Мопассан, Химкет, Барбюс, Фучик нарын шилдэг зохиолтой уншигч олноо танилцуулжээ. Б.Ринчен 1944 онд БНМАУ-ын төрийн шагнал хүртжээ.

ШҮХЭРЧ БУНИА

Манж дайчин Улсын Тэнгэрийн тэтгэсэн хааны аравдугаар он билээ. Улиастайд суугаа зарлигийн манж сайд Авгай сайн хааны байгуулсан Эрдэнэ Зуугийн хийдийг сонирхон үзэх гэж зуны дэлгэр сайхан цагаар Зуугийн цамын үест очсон байжээ.

Ойр хавийн монгол ноёд тайж, ард олон цам үзэх гэж Зуугийн орчин тойронд их л хөлтэй. Энд тэндгүй эрээн майхан, гоёлын хувцас өмссөн хүрэн улаан царайтай өргөн их хэнхдэгтэй, идэр талын хүдэр эрчүүд, чилгэр сайхан биетэй, сайхан царайтай хүүхэн, тэгшхэн зассан дэлтэй, гоё эмээл хударгатай морио унацгаан, хэд хэдээрээ дөрөө зэрэгцэн өргөн талд давхиж явахыг манж сайд үзээд, моринд чадамгай, бие чийрэг, зориг хатан энэ монголчууд, манай манжаас давуу эртний соёлт, эрх чөлөөнд дуртай улс ажээ. Уран арга эс хэрэглэвэл, захирахад амаргүй улс, шарын шашнаар номхотгох гэж тэнгэр тэтгэгч эзний явуулж байгаа бодлого маш зөв ажээ хэмээн бодсоор Эрдэнэ зуугийн цамын баг хэрэглэл маш нарийн гоёмсгийг гайхан, монгол урчуудын чадлыг бахдан үзжээ.

Баруун зүг шинэ хязгаар, хошоо аймгийг байлдан дарах аянд явалцсан манж сайд бие хатингар, моринд сүрхий эр. Нойр багатай эрт босдог хүн байжээ. Зуугийн их лам танаас зарлигийн сайдад тусгайлан барьсан гэрээс нар битүүгээр гарч, хээр талын сайхан өвс цэцгийн үнэр анхилсан агаарыг амьсгалаад гадаа орчин тойрныг үзэж, Эрдэнэ Зуугийн олон сүм дуганы оройг хартал, Зуугийн их сүмийн орой дээр нэг юм хөдлөх шиг болжээ. Шувуу гэхэд дэндүү том, хүн гэхэд, тийм эрт хар үүрээр сүм дээр хэн гардаг билээ гэж тэр зүг гайхан хартал, үнэхээр хүн бололтой.

Энэ ямар хүн, юу хийж байгаа билээ? гэж ажиглан ширтгэл, нэг хүн, сүмийн орой дээрээс доошоо үсрэх шиг боллоо. Араас нь шүхэр шиг нэг юм дэлгэж, тэр хүн шүхэрт өлгөгдөн үүрийн зөөлөн салхи даган намрын цэнхэр өдөр шүлсээ дэлгэн нисэх аалз мэт гар арваганан, шүхрийнхээ татлагыг татан залж нэлээд нисээд далд оржээ.

Баахан ухасхийгээд бас дахин Зуугийн өндөр сүмийн орой дээр өглөөний тэнгэрт маш тодхон зурайж үзэгдээд, бас харайжээ. Манж сайд түүнийг их л жиг болгож дахин сүм дээрээс үсрэн буухыг хичнээн хүлээтэл үзэгдсэнгүй. Сайдын бараа болж явсан цэргийн дарга нь гарч орон, амбаныг ёсолсонд хариу ёслон дохисхийгээд гэртээ орж, хойш өглөө юу болдог бол, бас л энэ үед гадаа гарч үзье гэж боджээ.

Өглөө хойш мөн өнөөх сүмэн дээрээс тэр шүхэрчин харайжээ. Хүн амьтан цөм унтаастай гэж бодсон бололтой. Үймүүлэн цочоох хүнгүй тул дөрөв дахин харайгаад үзэгдэхгүй болсонд түүнийг алсаас харж байсан манж сайд дотроо сайхан, цамчин цөмөөрөө хэдийн буцсан тул, манж сайд, тэр өдөр Улиастайд буухаар болж, их ёслолоор Зуугийн лам тушаалтан мяндагтан үдэх үед амбан сайдаас зуугийн их ламд хоёр өглөө үзсэнээ гайхан хэлжээ.

Зуугийн лам, махлаг том биетэй олныг захирч сурсан эзэрхэг царайтай өвгөн тэр манж сайдын үгийг сонсоод,

- Танхай банди нар дүрсгүйтэж байгаа бол уу? Учрыг нягталж мэдээд, номын сахилга бат алдсан тэр хуваргыг хэрхэн шийтгэснийг сайдад дараа айлтгая гэжээ.

Эжий нь эвлэг зөөлөн гараараа ар нуруугий нь илж байх шиг болж, Буниа гэнэт нүдээ нээж үзвэл, хамаг бие хөшиж, нуруу зоо тэсгэлгүй хорсон өвдөж, нэг мэдэхнээ баруун гараа дэрлээд, зүүн гараа бие дагуу сунгаж, «Хэвтэж байгаа арслангийн маягаар» хуучин муу журам дээрээ эзгүй хээр ууланд хэвтэж байснаа гайхан мэджээ.

Тэр нуруугий нь зөөлөн гараараа илж байсан нь эжий нь биш сагсгар үстэй нохой долоож байснаа, жаал бандийн хөдлөсхийхэд, нүүрийн тушаа ирж, нэг долоочихоод оцойн сууж сүүлээрээ газар пад пад цохилж, Буниагийн царайг цэцэн нүдээрээ ширтэж, босож өндийж үз гэсэн юм шиг харжээ.

Буниа тэр нохойг, өдөр бүр яс мах хаяж өгдөг золбин халтар гэж таниад, хөдөлж босох гэтэл, бүх бие хөшин, уруул хатаж, ам тэсгэлгүй цанган, толгой заадсаараа задрах гэж байгаа мэт машид өвджээ. Хамаг бие хэмх зад буусан юм шиг нүд эрээлжлэн зовхио аньсхийж нэгэн хэсэг хэвтээд дахин нээж урьд нь харагдаж байгаа газрыг гайхан хартал Зуугийн лам нарын яс тавьдаг газар мөн бололтой. Тэнгэр баахан үүлтэй, хээрийн сэрүүн салхи сэнгэнэн жаал хүүгийн халууран өвдөж байгаа биеийг дэвүүрээр дэвэх мэт сэрүүцүүлэх ажээ.

Буниагийн ухаан санаа ороолдон зангирч жуушаан утас мэт хөврөн эх захгүй болж юунд энд яс тавьдаг газар хүрч ирээд хэвтэж байгаа билээ? Хэдийн таньдаг энэ газар дэлхий хөх тэнгэр яагаад жигтэй шарлаж, сонин өнгөтэй танигдашгүй хачин үзэгдэх болов? Би энд хичнээн хэвтэв гэж бодтол гэнэт ухаан орсон юм шиг сэтгэлд нь хамаг юм тов тодхон санагдлаа.

Улиастайн амбан сайд явсны хойш өглөө, нар битүүгээр Зуугийн гол сүмийн орой дээрээс дахин нисэх гэж шүхрээ үүрч гараад татлага холбоогий нь хоёр суган дороо бэхлээд доошоо үсрэн татлагы нь ээлж ээлжээр татаж залсаар урьд урьд өглөөнийхөөсөө нэлээд хол буусандаа бахдаж шүхрээ яран эвхэж дахин сүм өөд сэмхэн хөл нүцгэн гүйхдээ, анх лойлинд орхимжоо дэлгэн нисэж явсан лам нарын бяцхан баримлыг үзсэнээсээ санаа авч хулгайгаар замын хэрэгсэл, номын баримтгийн хуучин даавуу сэм зүүж багшийнхаа хуучин шүхрийн үлгэрээр хийгээд хашаан дээрээсээ үүрийн шөнөөр үсэрч шүхрийнхээ голд нь салхи дээшээ гарах нүхтэй болгож тэр хэмжээгий нь их болгосоор давхар илүү байшингийн дээрээс зүрхлэн үсэрч сургууль нь хийж шүхрээ хүн унтсан хойно хулгайгаар засаж сэлбэсээр Зуугийн бага шиг дуган дээрээс үүрийн шөнөөр үсрэн хальж эцэс сүүлдээ өндөр сүмэн дээрээс үсэрч шүхрээ залж улам улам ахиулан нисэж байснаа санаж нүдээ аниад амбан явсны хойт өглөө болсон явдлаа бодоход сайн ниссэнд улам урамшиж дахиж сүмэн дээрээс авиран нистэл доошоо нэг харсанд хэдэн чийрэн дуганч нар сүмийн довжооны хайсны цаана бүгж байснаа өндийн харах нь үзэгдэж одоо л хэрэг биш боллоо гэж, агаарт шүлсэндээ асан нисэж яваа аалз шиг гараа арвагануулан салхины аясыг дагаж хэрэв даваад буудаг бол ухаантай юмсан гэж бодтол нь, сүмийн довжоон дээрээс гутал нижигнэх чимээ гарч билээ.

Одоо л намайг барих нь, тэнгэр минь, салхи минь тусалж энэ хэрэм дээгүүр саадгүй давуулаасай гэтэл хөлөөс нь нэг юм шүүрээд авах шиг болж, барь барь! гэж хашхиралдан, өөрийн эрхгүй доошоо татагдан ойчсон билээ.

- Чи муу яаж байгаа чинь энэ вэ? гэж, гүйж амьсгаадсан бүдүүн цоохор дуганч, Буниаг тас тэвэрч хэдэн дуганч нар шүхрий нь мулт татаж аваад их гэсгүйд хүргэсэн нь санаанд оров.

- Горьгүй юм боллоо! гэж Буниагийн зүрх түгшин хоёр талаасаа чийрэг дуганч нарт шахуулан , эх гэсгүйд хүртэл эрт унтаж , орой босдог гэсгүй лам хэдийн босож өргөөндөө хүрдээ эргүүлэнхэн хоймортоо сууж байснаа,

- Задарсан хар тархи, чи яаж байгаа нь энэ вэ? Орон хийдээд түмэн түвэг татаж , зарлигийн амбан сайдад ёсон бус явдлаа мэдэгдсэн чамайг зад торлогдож, олон шавь нарт цээрлэл үзүүлнэ гэж нүүр нүдгүй загнаж Зуугийн ламд муу нохой ёсон бус хэрэгслийн хамт барьсныг айлтга гэж шавь нараа зарж удалгүй Зуугийн ламын шавь нь ирж багш, Буниаг яаж ниссэнийг үзэх гэж байна. Сүмийн тэнд аваачина уу гэж иржээ.

Шүхрээ татлагаар нь хоёр сугандаа торгоод нисдэг тэр сүмийн тэнд хийдийн мяндагтан цөм нэгэн зэрэг зарласан мэт хэдийн цуглаж , зүрх түгшин айж эмээсэн Буниа тэр их багш лам нарын өмнө сөгдөн асуулгаад , Зуугийн их лам ,

- За, чи бидний өмнө нэг нисээд үз. Ямар буг шулам чамд ийм арга зааж өгсөн юм бол! гэхэд гэсгүйд зандруулсан Буниа , бүх бие чичрэн , айн эмээж дахин тэр сүмэн дээр гараад шүхрээ татлагаар нь хоёр сугандаа торгохдоо айсандаа болж ухаан нэг орж нэг гарч байх шиг болж өндөр сүмийн орой дээрээс улаан шар хувцастай ихэс лам нарыг харахад бор шувуу шиг жижигхэн харагдаад их гэсгүйг гараараа зангаж үсэр гэж дохиод миний энэ шүхэр минь хан гардийн далавч шиг болж эндээс намайг долоон уулын цаана буулгадаг ч болоосой гэж аман дотроо ээжий минь ! гэж шивнээд үсэрсэн нь санаанд оржээ.

Шүхэр нь пад хийтэл дэлгэж Буниаг хоёр суганаас нь өргөж олон удаа үсрэн нисэж бие нэг сонихон болоод ирдэг байдал нь мэдэгдэж үүрийн зөөлөн салхины аясаар шүхрээ таталгаар нь залж дор ногоон зүлгэн дээр сууж байсан ихэс лам нарын дээгүүр нисэн өнгөрөхдөө зуугийн лам нарын гуулин шанага шиг хүрэн халзан толгой нь тов тодхон ив илхэн үзэгдсэн нь Буниагийн санаанд орж , гайхан цочицгоосон лам нар , гар хуруугаараа зааж дүнгэр дүнгэр дуугаралцаж байсан нь дуулдаж олон суврагат хэрмийн ёроолд буучихаад өөдөөс нь лам нарын зүг эмээн харж байсан нь санаанд орж ирлээ.

Тэгээд тэр өдөр олон лам хуврагийн өмнө их гэсгүй бэрээгээр багана цохин цогдомлож Винайн ёсонд хувраг хүний зарчимд үл нийлэлцэх явдал үзүүлсэн банди Буниаг шүхрий нь шатааж зуу торлогд гэж ял оноосон , чийрэг дуганч нар зоон дээр нь торлогдож эхэлсэн нь санаанд оржээ.

Зиндааны нөхөд нь айн сандарсан нүдээр харж, торлог нуруун дээр нь буух нь тэсхийн аргагүй өвчтэй ижий ижий гэж бархирч байсан арав арван нэг, арван тав, арван зургаа гэж торлог тоолж байсан дуганчийн дуу дуулдаж байснаа юу ч мэдэхээ больсон, одоо зуугийн лам нарын яс тавьдаг газар хэвтэж байгаагаа бодвол, намайг үхсэн гэж, энэ рүү авчран хаяжээ гэж бодоод толгой өндийх гэтэл ар нуруугаар нь хутгалах шиг өвдөөд шилэн хүзүүгээр хатгуулах шиг болж ёлсонд золбин халтар сүүлээ хавчин босож, Буниагийн омголдсон уруулыг долоожээ.

Өндийж босох гэтэл зад нүдүүлсэн биеэ тэсгэлгүй өвдсөнд Буниа түр ухаан алдаж, дахин мэдээ ороход өнөөх золбин халтар ч байхгүй улам ганцаардсан шиг болж нүднээсээ нулимс цувруулан цурхиртал уйлах гэтэл зодуулж бархирсаар сөөсөн хоолойноос шуухинах чимээ

гарахаас биш дуу гарч өгсөнгүй, ижий ижий гэж шивнэн, омголтсон уруулаа долоож, цангаж хатсан амаа дэмий л ангалзлаа.

Торлогдсон нуруу зоо нь улайсгасан төмрөөр хайрч байгаа юм шиг өвдөж, жаал хүүгийн бүх бие халуурч толгойг төмөр боолтоор шахаж боосон юм шиг, хоёр чамархайд нь луг луг , лүг лүг гэж лантуугаар цохиж байх адил, багадаа цоорхой хар гэртээ ижийнхээ дэргэд хэвтэж байх шиг хүүгээ дэмий ч лам болгов уу даа гэж тэр жил хэлж байсантайгаа адил, ижий нь гасалж, нуруугий нь илж байх шиг зөөлөн хуруугаараа хөлөөс нь өөд нь илэх бүр өвдөх нь барагдан бие тун сонин хөнгөхөн болж байх шиг шүхэртээ өлгөгдөн агаарт хөвж нисэж байх шиг, санагдсаар, ижий ижий ! гэж шивнэсээр Буниа мэдээ алдаж үхэтгэхийн өмнө,

-Хүү минээ , хаашаа ир чи хаана байна? гэж аль хэдийн нас барсан эжий нь холоос дуудах шиг чихэнд нь дуулдаж, ээ би энд байнаа! гэх гээд, хоолой нь хэрчигнэж нэг юм дуугарах шиг болоод хөлөө жийн бүх бие нь тавигджээ.

Монгол улсын арван наймдугаар онд, Герман улсын монголч эрдэмтэн Эрих Хенишгэй баруун аймгаар явахдаа Улиастай хотод орос Цэрэн гэдэг өвгөнг Улиастайн гэсэр сүмэнд орон нутгийн тун сонихон музей үүсгэн байгуулсанд нь тэр үеийн судар бичгийн хүрээлэнгээс музейн модон тэмдэг хүргэж өгөөд, өвгөн Цэрэнгийн байгуулсан музейн нэг байшинд Улиастайн амбаны хуучин данс бичиг байсныг сонирхон сөхөж үзэхэд Тэнгэр тэтгэсний аравдугаар оныг бичиг хэргийн дансанд Эрдэнэ зууд шүхэр хэрэглэж ниссэн банди Буниаг торлогдон шийтгэсэн учрыг мэдүүлсэн бичиг үзэж, Европт Отто Лилиенталь гэдэг герман хүн, анх шүхэр хэрэглэж нисэхийг оролдсоноос аль эрт Эрдэнэ зууд нэг ядуу жаал банди Буниа, цовоо ухаан санаагаараа шүхэр хэрэглэж нисэх гэж оролдоод торлог даасангүй үхсэний нь Улиастайн амбанд айлтган мэдэгдсэн бичгийг гашуудан үзсэн билээ.

Парашют гэж манайхны гадаад үгээр хэлдэг нь монголоор шүхэр гэсэн үг тул , ах дүү Өвөр монголд парашют ч гэдгийг шүхэрч гэж дэлхий нийтийн ёсоор тэр үгийн утгыг өөрийнхөө эх хэлээр орчуулан нэрлэдэг нь бахтай хэрэг.Гагцхүү улирал бусын цагт төрөөд, урьдын үест ардын хичнээн авьяастай хүн ингэж хөөрхий Буниа шиг авьяас чадлаа гаргаж чадалгүй амь бие хохирч байсныг санахад гашуудалтайг хэлэх үү !

Миний тэмдэглэлийн дэвтэрт хорин есөн жилийн өмнө Улиастайн амбаны хуучин данснаас гэсэр сүмд байгуулсан музейд Буниа бандийн шүхрийн хэрэглэн , тэнгэр тэтгэгчийн аравдугаар онд нисэж торлогдуулан үхсэнийг үзэв гэж товч тэмдэглэл хийснээ энэ 1957 оны зуны сүүл сард туурь болгож бичсэн учир гэвэл Улиастайд өвгөн Цэрэнгийн байгуулсан музейг намайг тавин таван онд Чехословакийн Эрдэмтэн Поухатай Улиастайгаар явахад байхгүй болж, гэсэр сүм нь ч байхгүй болж Улиастайн амбаны хуучин данс хар нь ч үрэгдэж үгүй болоод, ойрын хэдэн жилд шинэчлэн байгуулсан орон нутгийг судлах кабинетэд ч амбасын хуучин данс хар үгүй тул , монгол шүхэрчийн тухай түүхэнд орох гашуудалт тэр баримт нь үгүй боловч уран зохиолын нэг өгүүллэгт нэр нь орж хойчийн уншсан хүнд дурсагдаг гэж үүнийг бичлээ.Уг бичиг нь байвал, сүрхий лам түшмэл зохиож, хөөрхий Буниагийн өгсөн өчиг нь арван тав зургаатай хүүхдийн амнаас гарсан үгийг тэр хэвээр нь тун аятайхан тэмдэглэн авч хэрхэн торлогдон шийтгэсэн мөн тэр шийтгэлийг даалгүй үхсэн зэргийг сүрхий бичсэн бичиг байсан билээ.Орос Цэрэн өвгөн тэр жаалыг гол нь тасраагүй байхад хаячихсан гэж хууччуулын амнаас багадаа дуулсан гэж хэлсэн үг нь миний цээжинд

одоо хүртэл тодорхой бий. Гагцхүү тэр бичгийн доторхи нарийн үг өчгийг он удаж мартжээ.

ДЭЛГЭРИЙН РАВДАН

Зохиолч Д.Равдан 1932 онд Өвөрхангай аймгийн нутагт малчны гэр бүлд төржээ.Бага дунд сургууль, 1957 онд Багшийн дээд сургууль төгсжээ.1956 оноос уран зохиол сонирхон оролдож, “Учрал”, “Цуцашигүй жигүүртэн” өгүүллэг, туужийн ном, Орхоны шуугиан “ роман бичжээ.

ЕРӨӨЛТЭЙ ХҮМҮҮС

Надад сайн хань дайралдсан юм шүү гэж сэтгэл өегших үе Доржид олон тохиолддог ажээ. Түүний гэргий Нямын хийсэн дээл хувцасны энгэр зах, эмжээр товчийг харахгүй өнгөрөх хүн бараг байхгүй. Өглөө нөхрөөрөө өрхний оосор татуулахыг тэр шившиг гэж үзнэ. Бас хоол унд төхөөрөх хувцас хунар угаахад нөхрийгөө хүргэх нэн дургүй. Үүнд нь Дорж баярлаад зогсохгүй, хүн ингэж байхад би яаж зүгээр суух билээ гэж бодох тул орой ажлаасаа тарж ирээд түлээ мод хөрөөдөж хагалахаас эхлэн эмэгтэй хүнд хүндэдмээр ямар ажил байна, тэр бүхнийг унтан унтатлаа уйгагүй бөөцийлдөг ажээ.

Иймээс Доржийн гэрт гадаах ажил цаг ямагт жин тан байх бөгөөд хавь ойрын настайчуул хааяа үр ач нараа зэмлэж үглэхдээ ~ Чи Дорж, Ням хоёрын аж төрж байгааг хар гэнэ. Гэтэл Дорж, Ням хоёр ингэж хэлүүлэх дургүй билээ. Бямба гариг байв. Ням аймгийн соёлын ордонд шинэ жүжиг үзэхээр явсан тул Дорж хоёр хүүхдээ харж, оройнхоо хоолыг хийж байв. Таван ханатай гэрийн дотор саруулхан цэлгэр агаар салхи орох сиймхийгүй мэт пүн хийнэ. Цэцэрлэгтээ яваад ирсэн охин хүү хоёр нь хамаг хувцсаа тайчаад гэрийн хоймор дэвссэн том хивсэн дээр элдэв янзын эрээн мяраан тоглоомоор наадан, энэ тэрийг эв найртай шулганалдана.

Гал дээ пор пор буцалж буй сонгино сармистай хоолны сайхан үнэр хамраар сэн хийж арааны шүлс асгаруулна. Чагнаваас алсад цахилгаан моторын дуу нэгэн жигд лүг лүг хийж, цахилгаан хөрөө үе үе дэргэд юм шиг ханхийн цуурайтсанаа салхины урсгал мэт алгуурхнаар алсхан замхарна. Юм бүгд саруулхан, чөлөөтэй, бас уран уяхан ямар ч сайхан хорвоо вэ дээ хэмээн Дорж сэтгэл уужран бодтол хаврын орой мэт урихан бөгөөд харзын ус мэт тунгалаг харцтай, ааш авир шулуун, гишгэх нь шалмаг багын амраг, үнэнч гэргий нь өөрийн эрхгүй үгүйлэгдэж, түүний булбарай халуун гарыг атгамаар, сэвлэг зөөлөн үсийг нь илбэмээр санагдана.

Авгайгаа одоохон ороод ирнэ гэж бодохоос Дорж хөлийн чимээ байн байн чагнана. Гэвч гэргий нь ирэхгүй л байв. Хоолоо идэцгээлээ. Хоёр хүүхдээ унтууллаа. Бас л ирсэнгүй.

Дорж орон дээрээ бүхлээр хэвтээд Нямаатай эхэлж танилцсанаа дурсан бодож эхлэв. Сэтгэл санаа тав алдсан үед чухам үүнийг л бодвол ямарч бэрхшээлийг даван туулах зориг сэтгэл аяндаа төрдөг ажээ. Жараад оны сүүлээр билээ. Мал сүргийг хашаажуулах их ажил орон даяар өрнөж байв. Энэ үеэр Өвөрхангай аймагт хашаажуулах ажлыг удирдахаар Зөвлөлтийн мэргэжилтэн Орлов гэдэг хүн хамгийн түрүүнд иржээ. Үс шар, нүд цэнхэр Курчатов шиг задгай халимагтай, голдуу хөвөнтэй цамц, саравчтай малгай өмсөж явдаг тэр инженер өглөө хамгийн түрүүнд үйлдвэр дээр ирж, орой хамгийн сүүлд гэрлүүгээ явах бөгөөд хаа явсан газраа «Төмөр мэт сахилга бат, нэг хүн шиг нэгдмэл ажиллагаа» гэж амандаа бувтнах нь олонтой үзэгдэнэ.

Бас хийж байгаа хашааны материалыг ор нэг болгох буюу цаг минут тасалж үрэгдүүлэх ахул орос монгол ажилчдын хэнийг ч хэн гэхгүй улаан нүүрэн дээр нь улалзтал хэлнэ. Гэвч тэр ажилчдын хийх ажлыг мэргэжил чадварт нь тохируулан өдөр тутам маш нарийн тодорхой хуваарилаж өгөөд хүн бүрт нэг бүрчлэн тусалж гүйцэтгэлийг өөрийн биеэр нэг бүрчлэн

шалгаж үзэхийн дээр албан ажил дээрээ бүхнээс илүү хөлс гаргаж бүхнээс илүү ядрах тул түүнийг ямар ч залхуу хүн эсэргүүцэж үл чадна. Ганц үүнээс шалтгаалаагүй ч гэсэн Өвөрхангай дахь хашаажуулах ажил шуурхай өрнөж байв.

Шинэ жилийн баяраас өмнөхөн Орлов техник туслалцааны трестээс шинэ тэрэг техник барилгын материал авчрах далимд ээлжийнхээ амралт аваад Москва явах гэж байгаа эхнэр хүүхдээ Улаанбаатарт хүргэж өгөхөөр ГАЗ-69 машинаар Арвайхээрээс гарахад хашааны ангийн дарга Доржийг түүний машинд суулгаж өгчээ.

Дорж төвийн үйлдвэрт шаардлагатай мэргэжилтэн боловч нэг удаа архи ууж ажил тасалсан учир зэрэг буурч хээрийн бригадад ажиллах болсон юм.

Арвайхээрээс гараад хоёр цаг гаруй явсны дараа Орлов жолоочийн урдуур бөхийж харсан чигээрээ,

-Тэр хэнийг даллаад байна гэв.

Цэл залуу жолооч нь

-Биднийг биз гэв.

-Тэгвэл очьё.

-Бензин хүрэхгүй. энэ чинь ирэх очихын лав арваад километр байна шүү дээ.

-Зүгээр бензин олдож болно.

-Та олох юмуу?

-Тэгнээ.

-Тэгвэл явья л даа , жолооч машинаа зүүн гар тийш нь эргүүлэхэд Дорж урд цонхоор тэр зүгийг харвал үнэхээр тав зургаан километрийн тэртээ уулын энгэрт нэг хүн том хар юмаар даллан тонголзож байв. Машин уулын бэл өөд оволзтол тонгочуулсаар хоромхон зуур түүн дээр хүрч очвол нэг гартаа шуудай , нөгөө гартаа шилбүүр барьсан настай авгай байх бөгөөд Орлов Дорж хоёрыг машинаас гармагц

- Ачтан минь ах дүү нар минь гээд хоёр гараа алдлан ухасхийснээ өөрийн эрхгүй бахардан унав.

Орловын царай барсхийж, эмгэний тохойноос сугадаж босгоод

-Юу болоов эмээ . Та түргэн ярь , бид тусалъя гэсэнд өнөө хөгшин энэ орос хүний ийнхүү монголоор сайхан ярьсанд гайхсан бололтой, түүний нүдрүү ширтэж, амаа ангайснаа,

-Хүү минь , хүү минь .Бид гэдэг чинь сүйд болоод байна гээд хүн хүнрүү харж амьсгаадна.

Тэгснээ, Орлов руу дахин харж ,

-Өвгөн маань уржигдар шөнийн шуурганаар хэдэн хонио эрээд гарсан.Одоо хүртэл сураг байдаггүй.Гэтэл охин минь, Ганц охин минь гээд цааш нь үгээ гүйцээж чадалгүй мэгшин уйлав.

Орловын том цэнхэр нүд орой дээрээ гарч ,

-Суу суу . Танайх хаана байна гээд эмгэнийг урд талын суудалд бараг өргөх шахам суулгав.

Машин эмгэний заасан замаар жирэлзэн довтлох зуур Орлов,

-Тэгээд, тэгээд яасан бэ эмээ гэвэл авгай,

Яасныг бүү мэд хүү минь. Гэв гэнэт мушгилдаж ойгоод бурхан минь , яг л төрөх гэж байгаа хүн шиг орь дуу тавьж байгаа гэдэг жигтэйхэн. Ээ бурхан минь гээд нүдээ анив.

Машин хурдалсаар их бууцны хөлд ганцаар торойх цагаан гэрийн гадаа очиж зогсоод, хүмүүс бүгд машинаас буувал, эмэгтэй хүний яраглан дагжих дуу гэрээс тодхон сонсдож байв.

Дорж, Орловын хойноос дагалдан орвол гялалзсан хар нүд цонхийсон цагаан царайтай залуу эмэгтэй зүүн талын орон дээр нааш цаашаа хөлбөрөн ёолж байснаа орж ирэгсдийг олж хармагц дуугаа хураагаад цээжээ ил гартал дээш нь шууж татсан торгон палаажныхаа хормойг чичирхийлсэн урт цагаан гараараа чадан ядан доош нь болгож байв.

Орлов эцгийн харцаар бүсгүйрүү харж, хувцсыг өвдөгнөөс нь өнгөртөл татаж доошлуулаад,

-Яаж байна хүү минь юу чинь өвдөж байна гэтэл залуу эмэгтэй Орловыг эмч гэж бодож байгаа бололтой энгэрийнхээ товчийг тайлах гэснээ гэнэт амь нь тэмцэв бололтой царай нь үнс мэт хөхрөн зэвийж, нүдээ тас аниад, доод уруулаа хэгз хазаж нуруугаараа нумлан өндийв.

Хэд тэгсний дараа царай нь үл мэдэг засрахад,

-Нуруу тасарчих гээд л байна гэж үгээ зөөж шивээнэв. Үүнээс хойш бүсгүй хэд хэдэн удаа ингэж амь тэмцсэн боловч огт дуугарахгүй байв.Дорж түүнийг сүрхий хатуужилтай эмэгтэй юм гэж бодно.

Орлов бүсгүйн байдлыг ажиглаж байснаа,

Энэ хурц мухар олгой байж магадгүй түргэн явах хэрэгтэй.Одоо түргэн хувцасла.Алив Таня чи туслаарай гээд босоход Орловын авгай бүсгүйн дэргэд очиж суугаад хувцасаа өмсөхөд нь туслав.Орлов жолоочдоо хандаж,

-Ваня чи энэ охиныг яаралтай Арвайхээрт хүргэж өг гэснээ авгайруугаа харж

-Чи хамт явсан нь дээр байх гэв. Үнэгэн захтай пальто өмссөн өндөр авгай Таня

-Тэгье л дээ.Харин хүүхдүүдээ яах билээ гэсэнд Орлов

-Хоёуланг энд үлдээнэ. Ах нь дүүгээ хараад байж байг,энэ эмээтэй хамт гэсэнд эмгэн ,

-Ээ бурхан минь уйлах байгаа даа гэв.

-Зүгээр уйлахад үхэхгүй. Харин хүйтэн юм битгий өгөөрэй.

-За за эмээ нь хичээлгүй яахав.

Тэгтэл Татьяна Владимировна гайхсан харцаар нөхөрлүүгээ харж ,

-Дорж та хоёр мөн энд үлдэх үү гэв.

-Тэгнээ гээд Орлов Дорж руу баясгалантай харж,

-Бид хоёр эдний өвгөнийг эрнэ гэв .

Ингээд Орлов, Владимировна хоёр залуу эмэгтэйг сугадан гарч , машинд суулгаад Виктор , Иванович хоёр хүүхдээ дагуулж гэрт оров.

Машин хөдөллөө. Доржийн дотор өөрийн эрхгүй уйтгар төрнө. Энэ залуу эмэгтэй замдаа зүгээр хүрэх боловуу . Мухар олгой мөн үү! Зууртаа цасанд суучихвал яана гэж бодохоос санаа зовно.

Цасан шуурганы дунд утаа хаялан холдож буй машины хойноос ширтэн зогссоноо Дорж түүнийг далд ормогц гүн шүүрс алдаад гэрт оров.Орлов энэ эмээгийн үгнээс гаралгүй дулаан гэрт тогтвортой сууж байхыг хүүхдүүддээ захиад Орловын хойноос гарав.Цасан шуурга маналзаж, хүчтэй нөөлөг хуухичсаар л байв. Дорж , Орлов хоёр эмгэний заасан зүгийг барин явав. Зөвхөн ийш тийшээ харж, анир чимээ чагнан нэлээд дуугүй явсны дараа Дорж ,

-Виктор Иванович аа, та түрүүнд монгол морь сайн унаж сурсан гэж ярьсан, хаа яаж сурсан юм бэ? Түүнийгээ та ярихгүй юу гэтэл Орлов,

- Тийм тийм би чамд ярина гэж бодож байсан юм гээд захныхаа цасыг гэвснөө ийнхүү ярьж эхлэв.

- 1941 оны өвөл цаг Гитлерийн фашистууд Москвад тулж ирээд байсан тэр хүнд үед юмсан. Манай морин хороо фашистийн хүчтэй цөмрөлтөнд өөрийн эрхгүй шахагдаж гэдрэг ухарсаар байсан юм.Гарз хохирлыг бол дэндүү их амссан. Чи бод л доо бүхэл бүтэн хорооноос ганц тасаг хүрэхгүй цэрэг үлдэж байсан юм шүү дээ. Гэвч бид Зөвлөлт эх орноо ялна гэдэгт өчүүхэн ч эргэлзэж байгаагүй. Биднийг тэр үед авч явсан гол хүч бол энэ итгэл л байсан юм. Харин өөрийн хувьд гэвэл амьд гарна гэдэгт би л хувьдаа тэр бүр итгэж байгаагүй.Эхлээд нэгийг устгавал солио, хоёрыг устгавал хожоо л гэж бодож явсан даа үнэнийг хэлэхэд гээд Орлов тайван шүүрс алдан инээмсэглэснээ, яриагаа үргэлжлүүлж,

-Яг энэ үеэр монголоос ирсэн бэлгийн морьдыг түгээхэд надад нэг хөөрхөн зээрд таарлаа.

Бэлэг түүгээр тогтсонгүй бас нэг захиа байв. Эх бичгийн ард орчуулж бичсэнийг нь уншвал ердөө арван найман настай нэг малчин эмэгтэйтэйгээс бичсэн байх бөгөөд хамгийн эцэст бичсэн ерөөлийн үгийг уншаад өөрийн эрхгүй нүднээс нулимс гарч билээ гээд Орлов дахин шүүрс алдав. Нэг тамхи асаагаад тэр цааш нь ярихдаа,

-Тэнд юу гэж бичсэн байсан бэ гэвэл, Зөвлөлт оронд хэзээд ялахын адил зөвлөлтийн нэг цэрэг та хэзээд амьд буцаж ирнэ. Тэр үеийг би тэсэж ядан хүлээнэ гэсэн байсан. Хүний сэтгэл гэдэг хачин шүү. Түүнээс хойш би өөрийгөө амьд үлдэж юуны магад хэмээн бодох болж билээ. Тэгтэл ч удалгүй Москвагийн дэргэд фашистийн бүх хүчийг анх удаа бут ниргэж манай армийн давшилт эхэллээ. Манай хороо ч бүрэн бүтэн болж сэлбэгдлээ. Түүнээс хойш манай арми зогсолтгүй давшаар дөрвөн жилийн дараа Берлинг чөлөөлж, Зөвлөлт орон ялалтынхаа их баярыг тэмдэглэхэд жирийн нэг цэрэг би амьд мэнд гарахаар барахгүй хошууч цолтой болчихоод улаан талбайн парааданд алхаж явахад мөн ч сайхан байсан даа. Тэр монгол эмэгтэйн бэлэгтэй сайхан үг өөрийн эрхгүй санаанд орж байсан. Харин хөөрхий зээрд морь минь энэ ялалтын баяртай золгож чадаагүй тэр ялалтыг дөхүүлэлцэж яваад л Дунай хөндийд үрэгдсэн юмсан гээд Орлов гүн шүүрс алдаж дахин нэг тамхи асаав. Дорж , Виктор Иванович хоёр хүн төрөлхтнийг фашизмын хар шавраас аврах их үйл хэрэгт оролцож яваад үрэгдсэн тэр монгол морины дурсгалыг хүндэтгэх мэт дуу шуугаа хураагаад лагалтсан цасан дундуур хөлөө дээр дээр өргөн зүтгэж явгал гэнэт хүн ханиах чимээ гарахад тэр зүг харвал үнэгэн малгай хулгавчилсан нэг морьтой хүн хамар дээр зогсож байв. Дорж , Орлов хоёр зөвхөн бие биерүүгээ хараад ойртож очвол цаанаас нь олон хонь ямаа цухуйв. Морьтой хүнтэй уулзаж амар мэндээ мэдэлцээд, хэрэг зоригоо асуулцвал өнөө айлын өвгөн мөн байлаа. Хэн хэн нь бөөн баяр болцгоож тэгснээ аймаг руу явсан эдний охин залуу эмэгтэйтэй ярилцан сэтгэл зовцгоож баахан тамхи татацгааснаа гурвуулаа зэрэгцэн хонио тууж, айлын зүг явцгаав.

Бараг харанхуй болохын үед өнөө айлын зүүн хамар дээр гарч ирвэл аймаг явсан машин ирчихсэн байв. Дорж , Орлов өвгөн гурав хонио санд мэнд бууцны хаяанд оруулаад гэрт орцгоовол Орловын авгай Владимировна бүхнээс түрүүлж ам нээж,

-Өвчилсөн эмэгтэй сайн хүрсэн. Өнөө шөнө багтаж мэс засал хийнэ гэсэн. Мэс заслыг эмч нар өөр нэг хүнд мэс засал хийгээд завгүй байсан тул бид эмчилгээний үр дүнг дуулж чадсангүй арга буюу наашаа эргэлээ гэснийг Виктор Иванович орчуулав. Эмнэлэгийн газар хүргэхээс илүү яахав дээ. Одоо ер болох нь тэр, ачтан минь гэсэн боловч өвгөн эмгэнийхээ нэгэн адил үлэмж санаа зовж байгаа нь түүний хоёр самсай нь шаргалтах баргар царайнаас илэрхий харагдаж байлаа. Өвгөний царайг ажиглан юм бодож суусан Орлов ,

- Та охин дээрээ очмоор байна уу гэсэнд хоёр нүд арван наймтых шиг золбоотой эрвэс хийж ,

- Тэгмээр байна гэв

-Та тэгвэл бидний машинд суугаад яв . Баян өндөр ор . Тэндээс Арвайхээр орох замын машин бишгүй олдоно.

-Нээрэн тэгдэг хэрэг байна шүү гээд өвгөн хувцсаа солихоор бүсээ тайчиж эхлэв. Тэгтэл

Виктор Иванович гэрийн эзэгтэй эмгэнд хандаж,

- Та энэ олон хоньтой ганцаараа байгаад байж чадахуу гэвэл эмгэн духнаасаа эхлэн бууралтсан шингэн үсээ илбээд ,

- Амьд хүн байна .Эрүүл саруул байгаа юм байна болох байгаа гэв.

-Ёстой л үнэндээ. Гэвч ..гэснээ Орлов Дорж руу харж

-Гэвч бодит байдал өөр байна .Иймээс чи энд үлдэнэ байгаа ямар ч гэсэн өвгөнийг эргэж иртэл эмээд хань бараа болж байсан нь дээр.

Би эргэж ирж байгаад хашааны ангийн даргатай ярилцана. Зөвшөөрөх үү гэв.

Дорж дотроо чухамхүү ингэх юмсан хэмээн хүсэж байсан тул өөрийн эрхгүй ,

-Зөвшөөрөлгүй яахав гэж дуу алдав.

Ингээд Орлов нар Улаанбаатар луу гарч Дорж өвгөнийд үлджээ.Тэгээд маргааш өглөөнөөс нь эхлэн өдөр бүр хонь хариулж , өглөө оройны цагаар хот хорооны цас малтан өвс тэжээл бэлтгэх болов. Бас тохилог дулаан саравчгүй тул тэнгэр муухайрсан шөнө бараг нойргүй хононо. Байн байн гарч хайсан хашааны амыг үзнэ.Ер нь унтсан ч чимээ чагнасаар үүр цайлгах шиг санагдана.

Ажлын байдал тийнхүү амар биш боловч Дулам хэмээх нэртэй гэрийн эзэн авгай байнга гал өрдөж гэр дотор ямагт дулаан байх бөгөөд шар цагаан тос, тарган хонины сүүл, сүү тос болсон цай зэрэг аль дөмөг сайн чанарын хоол өгөх тул энэ жилийн зун цэргээс халагдсан хорин гурван настай залуу эр Доржийн сэтгэл ямагт өег явна.Ялангуяа тэнгэр цэлмэг дулаавтар үдэш хонио хашиж өрхөө тэгшилсний дараа Гэндэн хэмээх нэртэй гэрийн эзэн өвгөний авдрын ёроолд удаан хадгалснаас үл мэдэг хөгц вам үнэртсэн төө хирийн сахлаг үстэй, бор цувцаа нөмрөөд нэрийг нь Нямаа гэх өнөө залуу эмэгтэйн сайхан үнэр анхилсан орон дээр хэвтсэн хойно сэтгэл тун ч хангалуун сайхан болдог ажээ. Харин заримдаа тэр Нямаа мөдхөн эрүүл саруул болчихоод яралзтал инээсээр орж ирнэ.Хурц хатгалгаас болоод инээж чадахгүй байсан болохоос биш мөн ч сайхан бүсгүй билээ дээ.Нуруу туруу гэж ёстой л хангайн согоо гэсэн үг.Түүнтэй учран танилцахын ерөөл ч байдаггүй байхдаа.Бараг л үгүй биздээ. Ийм залуу сайхан охин юунд нөхөргүй байх вэ за яахав би ямар нүдэндээ харагдсан цэцэг бүрийг үнэрлэж явах ёстой мал биш, хамгийн гол нь зуны эхэн сарын зулзаган ногоо шиг тэр залуу хүүхэн л түргэн эрүүл саруул болоод эргэж ирээсэй.Тэгвэл хамаг хэрэг гүйцэх нь тэр. Тэр хэнийг хайрлаж, хэнтэй суулаа ч гэсэн эрүүл энх , эсэн мэнд явбал юу шиг сайхан билээ гэж бодоод дулаан дээлэндээ шургахад бие сэтгэл нь ёстой жаргалын дээдэд умбаад өөрийн эрхгүй зүүрмэглэж эхэлдэг билээ.

Гэтэл хэд хоногийн дараа Гэндэн аймгаас ирж, охин Ням мэс засал хийлгээд бие нь одоо тун сайн болж байгаа гэж ярихад Дорж, Дулам эмгэний нэг адил зүрхнээс гэрэлтэн царай нь гэрэлтэн байв.Үүнийг хараад Гэндэн өвгөн ,

-Халуун хар элэгтэй ялгаагүй, хаа газрын улс ав адилхан, ээ дээ мөн ч сайхан хорвоо юм даа хөөрхий гэж нулимсаа арчсанаа Доржид хандаж,

-Хүүгийнхээ ажлыг баахан үрчихлээ дээ . Тэгээд одоо хүү минь яахав, буцах уу. Эндээ хонох уу гэв.

Дорж Нямаатай ямарч гэсэн нэг уулзана гэж бодох боловч , албан ажлыг олон хоногоор алгуурлаж болохгүй. Ажилтай байж амьдралтай байна. Амьдралтай байж авгайтай болно гэж бодох тул

-Одоо явалгүй дээ. Унаа олдвол өнөөдөр ч хамаагүй гэсэнд өвгөн ,

-За тэгвэл би мориор хүргэж өгье гэснээ эмгэндээ хандаж хүүд идэж уух юм бэлтгэ. Бас очоод хэдэн өдөр амандаа хийх юм боож өг гэв.

Доржийн очих хээрийн бригад эндээс өртөө шахам зайтай бөгөөд их замын яг мөрт тул ,

-Морь малаар юу хийх вэ, Гэндэн гуай би урд зам дээр очоод замын машинд суучихна гэвэл эмгэн Дулам ,

-Хөлдөж үхэлгүй яадаг юм бэ гэхэд Дорж инээж,

-Зүгээр зүгээр , хэрвээ машин олдохгүй даармаар болвол би буцаад ирнэ гэхэд Гэндэн,

-Тэгвэл ядахдаа зам хүргэж өгье дээ гэв.Тэгээд цай хоол идэж уусны дараа Дорж чанасан мах, шар цагаан тос зэрэг уут дүүрэн хоол хүнсний зүйл ганзагалаад яг аав шиг нь тослог агаад гандмал сэтгэлд дулаахан үнэр анхилсан хүдэр өвгөн Гэндэнтэй зэрэгцэн өргөн талын дундуур шугам татсан мэт зурайх гол замыг чиглэн гарав.Энд тэнд ганц нэгээр торойх мал, тэнгэрийн хаяа зэргийг харж аман дотроо үглэн явснаа Гэндэн,

-Би ер нь орос хүнтэй үнэхээр ерөөлтэй хүн юм гэв.Нямыг эргэж ирэхээр яаж ийгээд нэг уулзах юмсан хэмээн бодож явсан Дорж өвгөний юу хэлснийг төдий л сайн ойлгоогүй боловч

-Аан гэвэл Гэндэн яриагаа цааш үргэлжлүүлж ~ тэр жил Петр гэж нэг цэрэг миний аминд орсон бол Орлов мэргэжилтэн сая охины минь аминд орлоо гэв. Харин үүнийг нь тодорхой ойлгосон тул Дорж

- А мөн та орос эмчээр эмчлүүлж байсан юмуу гэхэд Гэндэн,

-Үгүй үгүй , өөр юм гээд алс зүүнээ цайвалзах хөх тэнгэрийн хаяаг ширтэж хөнгөхөн шүүрс алдсанаа,

Тэр жил 1939 онд би Халх голд Япончуудтай байлдаж явсан хүн л дээ.. Тэгээд манай дивиз Япончуудад сүрхий бөмбөгдүүлсэн нэг өдөр би хайрт мориноосоо хагацаж, түр ухарсан нөхдөөсөө хоцроод алаг шоргоолж шиг ирж яваа дайсны өмнө яаж ч чадахгүй, нуувчнаасаа шоволзож байтал нэг морьтой хүн л толгой дээгүүр харайх шиг болсон чинь намайг өвс шиг

шүүрч аваад л пижигнэх нь тэр .Эргэж харвал орос хүн байх бөгөөд намайг жаахан хүүхэд шиг өмнөө дүүрчээ.Тэгтэл төдсөнгүй морь минь үсрээд явчихлаа.Бид хоёр давхраараа харуулдаж унаад, дөнгөж өндийтөл хойноос хөөсөн гурван морьтой япон улаан тулаад ирэх нь тэр. Орос нөхөр маань нэгийг нь , би хоёр дахий нь буудаж өнхрүүллээ. Гэтэл гуравдахь нь орос нөхрийг минь буудчихлаа. Би ч дор нь өнөө японыг унагалаа гээд уул үйл явдал сая болж байгаа юм шиг Гэндэн өвгөний амьсгаа нь давхцаж, нүд нь хурцаар гялалзав.Тэгснээ, урт уртаар тасалдуулан гүн шүүрс алдаад өвгөн,

-Ингэж миний амийг аварсан юм даа хөөрхий минь. Бичиг баримтыг нь үзвэл Петр гэдэг хүн байсан. Миний үр хүүхэд бол ёстой марташгүй хүн дээ. Би хэзээ хойно ухаараад гэр орон эцэг, эх, хань нөхрийг нь олох гэж сураг тавьсан боловч олж чадаагүй юм.

Миний мунхагаас болоод олдох ч боломжгүй болсон байх, түүний бичиг баримтыг зөвлөлтийн ямар анги салбарын хэн гэгч хүнд өгсөнөө мэддэггүй,

Осолдохгүй орос даргад л өгснөө санадаг юм.. хэмээн ярьж явгал баруун талаас нэг машин давхиж ирэв.

Дорж мориноосоо яаран бугаад гараа өргөвөл тэр машин зогслоо. Ингээд Дорж Баян өндөр дахь хээрийн бригад руу гарч, Гэндэн өвгөн гэр лүүгээ буцав. Дорж бодон бодсоор байж хэд хоногийн дараа замын машинд сууж өвгөнийд ирвэл Ням гэртээ ирчихсэн байв. Түүний нүүр царай, бие бялдар нь анх үзсэнээс шал өөр болсон алим мэт өнгөлөг булбарай болсон байх бөгөөд Доржид ер бусын дотно хандаж байх шиг санагдана. Тэр ээжээсээ түрүүлэн цай хоол төхөөрч, зочныг дайлав. Тэгснээ зургийн альбом, маркийн цуглуулга зэрэг нарийн нандин юмаа чемоданаасаа гаргаж үзүүлнэ. Ингэж байтал Гэндэн тэдний ярианд оролцож,

- Одооны хүүхэд та нар мэдэх нь их боловч үзсэн нь бага болохоор гэндэнх явдал гаргах гээд байх юм гэснээ Дорж руу харж

- Чи эртээр намайг эргэх гэж явахдаа Орлов гуайг түлш түлээ, аяга шанага авч явья гэхээр дургүйцэж үзсэн гэлүү гэв.

Дорж инээмсэглэж

- Тэгсэн шүү гэтэл Гэндэн яриагаа үргэлжлүүлж,

- Тэр чинь тун буруу хүү минь. Би яг Орлов гуайн хэлдэг шиг зүйлийг тэгэхэд авч явсан. Чухам түүнийхээ хүчээр хоёр гурав хоног амьд явсан хэрэг шүү дээ. Хэрэв тийм юм авч яваагүй бол энэ өвгөн чинь өдийд гэхэд нь эмгэн нь

- Нүгэл хэмээн дуу алдав.

Гэндэн баясгалантай инээмсэглэж

- Юуны нүгэл байх вэ! ямар тэгж хэллээ гээд тэр ёсоор болчих бус гэснээ, өтгөн саарал хөмсгөө эрвэсхийтэл өргөн Ням, Дорж хоёрыг хараад,

- Харин болохгүй, болгоомжлохгүй л байвал осолдож болно. Ингэхээр буух газраа харж ниснэ гэгчийн үлгэрээр учрах тохиолдлыг бүгдийг бодож тунгааж байж, хүн чинь юманд явдал байна шүү дээ.

Ялангуяа осол эндэлтэй үед... хэмээн ярьж байтал нэг хөнгөн тэрэг сурхийн хаяанд нь ирээд зогсов. Гэртэх хүмүүсийн зарим нь гарч амжаагүй байтал монгол орос хоёр хүн орж ирсэн нь мөнөөх мэргэжилтэн Орлов, хашааны ангийн мастер хоёр байв. Бүхнээс түрүүлж гарсан Ням, Дорж хоёр гадаа үлдээд хөнгөн тэрэгний цаана энэ тэрийг ярилцан зогсоно. Ням хөөрхөн алаг нүдээ тормолзуулан

- Та энэ машинаар явах уу гэвэл Дорж

- Уул нь сайхан унаа юм. Яг л манай бригад орно доо гэсэн боловч бүсгүй өөрийг нь явахад дурамжхан юм шиг байхаар нь

- Өнөө шөнө, үгүй өнөөдөр өнжөөд явбал ямар вэ өөрөө юу гэж бодно хэмээн зүрх алдан хэлбэл,

Бүсгүйн царай аажуухнаар гэрэлтээд, доошоо харсан боловч зургар хоёр хөмсөг, шөмбөгөр хөөрхөн уруулаараа инээмсэглэн,

Өөрөө л мэд гээд машины дугуй өшиглөв.

Анх Дорж Нямаатайгаа ийнхүү танилцсан ажээ. Тэр үеийн тэр өдрийн энэ гайхамшигт учралаасаа салж ядан зүүрмэглэж байтал эхнэр Ням нь үнэхээр танан цагаан шүд, улаа бутарсан хацраасаа гэрэл туяа цацруулсаар гэртээ орж иржээ.

ТӨРДАШИЙН РИНЦЭН

Зохиолч Т.Ринцэн 1923 онд Баян-Өлгий аймгийн Алтан цөгц сумын нутагт малчны гэр бүлд төржээ.

Улаанбаатар хотод намын дээд сургууль төгсжээ. 1957 оноос уран зохиол сонирхон оролдож “Өлгий одод”, “Шинэ даваан” зэрэг өгүүллэг туужсийн ном бичжээ.

КОМИНТЕРНИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТУСЛАХ

«БӨ-87-88» гэсэн хөнгөн тэрэгний зөөлөн сандал налан 50 гаруй насны махлаг биетэй дунд хирийн нуруутай нэгэн хүн барьсан сониноо их л хичээнгүйлэн уншиж сууна. Тэр хүнд энэхэн үед уншиж буй сониноос нь илүү анхаарал татах гоц өөр зүйл ер үгүй бололтой. Сүүлдээ тэвчээр алдаж сэмхэн дэргэд нь очоод:

- Уучлаарай, Булгамбай гуай. Танаас би нэгэн зүйл лавлаж асуумаар байна гэхэд Булгамбай гуай сониноо эвхэлгүй над руу дурамжхан харснаа,

- За за, асуу асуу гэв

- Таныг коминтерний төлөөлөгчийн жинхэнэ туслах нь явсан гэж манайхан ярилцахыг сонсов. Энэ үнэн үү? Булгамбай гуай атираа тогтсон хүрэн бор царай нь туяаран гэрэлтэж инээмсэглэх аядсанаа царайгаа төв болгон баруун халааснаасаа хайрцагтай тамхиа гарган ороонгуутаа

- Тар арай л хэтрүүлж байх шив дээ. коминтерний төлөөлөгчийн жинхэнэ туслагч нь ч юу юм бэ, зүгээр л гар хөл, хэл ам нь болж явсан тал байж болох юм гээд машины урд гэгээвчээр алст цайвалзанхан харагдах цаст сарьдгийн оройг ширтэн тамхиа сорсон нь миний хөндсөн асуудлыг нэхэн санаж хариу өчих бэлтгэл болох мэт.

Эрэгнээсээ халин давалгаалсан омогт Ховд голын ус татран нүүдлийн шувууд нутгийн минь тэнгэрээр зэл татан өмнө зүгийг чиглэж, гангар гунгар дуугаран өнгөрч байсан 1930 оны намрын нэг таатай өдөрсөн. Хошуу тамга маань ардын эрхт төрөөр солигдож, анхны сумын захиргааны хэдэн цагаан гэрүүд босов. Түүний баруун талд дөрвөн зуугаад метрийн зайд нэгэн омбогор бор гэр барьжээ. Гэтэл тэр гэрийн гадуур хэдэн өдөр өнгөрөхөд ер хүн харагдахгүй нэг л эл хуль оргино.

Нэгэн өглөө нөгөө омбогор бор гэрийн үүдэнд дунд хирийн нуруутай урд нь энэ нутгаар огт үзэгдээгүй хачин маягийн хувцастай хоёр хүн харагдах бөгөөд мөн гэрээс бас арав эргэм насны хүү байн байн орж гарах нь олны анхаарлыг аандаа татах болдог юм байна. Тэд сумын төвөөр ажил албатай улс бололтой байснаа төдхөн нөгөө хоёр хүн сумын доохон талд холгүй байсан Булгамбай гуайн гэрээр хааяа орж аавтай нь элдэв юм ярилцдаг болжээ. Эд хаанахын юун улс болохыг арав гаруйхан настай агсан Булгамбай яахан мэдэх билээ. Тэр намрын цэлмэг нэг өдөр Согогийн голыг уруудан хэдэн ямаагаа хариулан гэр рүүгээ зүглэж явтал нөгөө хоёр хүний нэг нь хүүхдээ дагуулан Булгамбайн замыг амдан ирээд дууджээ.

Булгамбай урд нь таних болсон болохоор шууд яваад очжээ. Нимгэндүү царайтай тунгалаг зөөлөн харцтай тэр хүн хүүхэддээ нэг үг хэлэх шиг болсноо Булгамбайг харж халааснаасаа хоёр чихэр гаргаж өгөөд толгойг нь илж, сайртаж энд тэндээсээ цус нэвчсэн хөлийг нь өрөвдөнгүй харж:

- Бид аавд чинь хэлье. Чи манайд бай! Манай хүүтэй хоёул хамт тоглоно. Гоё сайхан хувцас өмсөж ном сурч сургуульд орох болно гэх нь тэр

- Ингээд би аавынхаа зөвшөөрснөөр тэдний өргөмөл хүү нь шиг байх боллоо. Сургууль байгуулна гэж хоёр гурван гэр барьсан боловч эхний үед нэг ч хүүхэд ирсэнгүй. Нөгөө хоёр хүний царай, сэдсэн ажил нь бүтэмж муутай байгаа болохоор нэг л баргар оргиод үе үе санаа алдан гүн бодолд ордог байлаа.

Би тэдний ямар зорилгоор энд ирснийг ярианаас нь болон ааваасаа мэдсэн болохоор тэдэнд туслахсан гэж хичээх боловч юугаараа туслах ч билээ яваад, хаа ч хүрэх билээ.

Дээр өгүүлсэн омбогор бор гэрт ирсэн энэ хоёр хүний нэг нь Чарип Отепов, нөгөө нь Абай Касымов гэдэг байв. Эд ардын хувьсгалын анхан үед хасгийн ард түмний дотор нам, эвлэлийн байгууллага, ардын сургууль байгуулахад туслалцах зорилгоор манай намын тусгай урилгаар зөвлөлт улсаас ирсэн коминтерний төлөөлөгчид байжээ. Тэдний зорьсон ажил нь түмэн олны дэмжлэгээр тууштай бүтэж байсан авч, сургууль байгуулах ажил туйлын урагш муутай байв. Энэ үед нөгөө хоёр хүнийг хасгийн молда /лам/ баяд феодалууд нүд үзүүрлэн хялайж, улаан оросын элч, мусулман шашны дайсан олж устган оргүй тонилгох хэрэгтэй. Эдний үгэнд орж, үр хүүхдээ сургуульд оруулж хэрхэвч болохгүй. Тэр сургуульд орсон хүүхэд эргээд эцэг эхээ алах ном сурдаг юм гэсэн айхтар хортой цуу тараасан нь айлаас айлд хүнээс хүнд хуй салхи шиг агшин зуур тархан дэгдэж байв.

Нэг орой би байсан айлынхаа хүүхэд Карлтай гэрийн гадаа тоглож байтал Абай, Чарип хоёр намайг дуудан гэрт оруулж:

- Чи энэ гутал, малгай хувцсыг цөмийг нь өмс, чамд улсаас үнэ төлбөргүй өгч байгаа юм. Өнөө орой гэртээ хариад маргааш орой хавийнхаа айлын хүүхдүүдтэй хамт тогло! Хувцас чинь муухай болчихно гэж битгий зов. Дахиад хувцас өгнө. Хүүхдүүд чамайг сонирхож энэ хувцсыг чинь хэн өгөв? Аав чинь өгөв үү? Гэж асууж шална. Тэгвэл миний орсон сургуулиас өглөө, тэнд би хувцастай болоод зогсохгүй, гучаадхан хоногийн дотор ном сонин уншдаг боллоо гээд энэ сониныг халааснаас гаргаад «хүн бүхэн тэгш эрхтэй, хүүхэд бүхэн сурах ёстой» гэсэн энэ гарчгийг уншиж өгөөрэй, хувцас хунарынхаа тухай ч үнэн мөнөөр нь ярьж өг. Болж өгвөл ямар ч хамаагүй хэдэн хүүхэд дагуулж ирэхийг бод гэв.

Би багшийнхаа даалгаврыг хэлсэн ёсоор нь тун сайн биелүүлж, хоёр хоногийн дараа өөрийн зиндааны тарчиг амьдралтай манайхтай ойролцоо байсан хэдэн айлын сайн таних Хөгсөгөөн, Мулигсан, Күлэндээ зэрэг таван хүүхэд дагуулан очиж анхны хичээлээ заалгаж билээ.

Тэр намрын нэг орой би байсан айлынхаа морь унаад гэртээ очиход аав минь гэрийн гаднаас намайг их л зовонгуй угтаж шивнэнгүй дуугаар:

- Чи бушуухан буц! Морио сайн гуяд! Өнөө шөнө баян хасгууд ардын засгийн бодлогоос урван тэрсэлж Алтай шинжаан руу оргон зайлах гэж байна. Тэгэх мөртөө нам эвлэлийн зарим хүмүүсийг амьдаар баривчилж, чиний байсан зөвлөлтийн хоёр багшийг хүүхдийнх нь хамт алах гэнэ. Би чамд хэл хүргэх унаа ололгүй мунгинаж байсан маань энэ. За бушуулаарай гэх нь тэр.

Харанхуй ч боллоо. Би ч модон дундуур гарсан жим замаар морины чадал мэдэн давхисаар

Тэдэн дээр хүрч оронгуутаа учир явдлыг товчхон өгүүлээд, тэдний хамаг нууц албан хэргийг авалцан бид гэрээс гараад дөнгөж модны захаар орж амжих үед морин төвөргөөн тачигнан, хүмүүс хашгиралдан манай гэрийг мод шийдэм, бороохой барьсан хүмүүс бүслэн авч хавирган сарны сүүмгэр гэрэлд сэгэн дээр амьтан шиг арзганаж харагдав. Аавын минь хэлсэн үг зөрөөгүй яг таг таарч, урвагчид сумын захиргаа сургууль байгууллагуудыг бусниулж толгойгчдыг нь баривчлан аваачив.

Сумын төвд яйжийсан хэдэн гэр, сандарч гүйлдсэн хүмүүс харагдахаас өөр юмгүй. Асай Чарип хоёр нурах шахсан омбогор бор гэртээ дахин ирж дүнгэр дүнгэр ярилцаж байснаа намайг дуудаж:

- Чи эр хүн байна. Эх орон ард түмнийхээ төлөө нэг чухал үүрэг гүйцэтгэ! Чамд бид туйлаас итгэж байна гэхэд нь би

- За гэв

- Чи наадах бүх хувцсаа тайлж энэ муу навсайсан хувцаснуудаа шалавхан өмс! Бид өгсөн энэ хоёр бичгийг төмөр утас жингийн зам, Ховд голыг огтлон гарсан тэр газар /одоогийн аймгийн төв/ голын хөвөөнд бярааз дээр байгаа нэг орон хүнд хүргэж өгөөрэй! Замаар явж болохгүй голоо дага! Хүн амьтан бараг дайралдахгүй байх. Хэрэв чамд /энэ бичигт/ ямар нэгэн хүн саад хийхийг оролдвол тулалдахаас битгий буц! гээд долоо үсэрдэг гар бууг арван дөрвөн сумтай өвөртлүүлээд нөгөө хоёр бичгийг бүсэнд минь тайлагдахааргүй чанга ороон зангидаад ард нуруу минь шургуулав.

Бичгийн гадна талд, давхин яваа морины туурай, яаран ниссэн шувууны зураг байгаа нь маш яаралтай гэдгийг нь илэрхийлж байлаа. Би шалавхан гарч гол уруудлаа. Тэгэхэд арван дөрвөн настай байв. Миний очих газар одоо санахад тойруу замаар 60 шахам км зайтай учир явган хүнд тийм ч ойрхон зам биш нь тодорхой. Би голдуу даваанаас бусад газар нохой шогшоогоор шогшиж явлаа. Замд саад тохиолдсонгүй. Аймшигтай нь гэвэл орой дээр минь ойрхон махчин шувууд эргэлдэнэ. Халуун гэж жигтэйхэн. Ядарсан ам цангасныг өгүүлээд баршгүй. Хамаг бие хар хөлс нэвчиж, зарим газар хорсож байв. Хөлийн ул халуу оргиж хөндүүрлэн лугшина.

Мандах нартай уралдаж гараад жаргах нарны өмнөхөн бяраазны орос А.И.Ждановын тэнд хүрч бүсээ тайлахад хар хөлс цутгасан нуруунаас минь нөгөө бичиг ховхорон унав. Тэднийх намайг тухтай амраагаад маргааш нь морь унуулан буцааж билээ гэхэд нь:

- Та коминтерний төлөөлөгчийн аргагүй л туслагч бөгөөд ардын хувьсгалын ололтыг бэхжүүлэхэд бас яахын аргагүй оролцож, хувь нэмэр өгсөн ариун үйлстэн ахмад хүмүүсийн нэг байна шүү гэхэд Булгамбай гуай маг маг инээж:

- Тийм нь ч тийм байж болох л юм. Үүнээс өөр надад улс нийгэмдээ бүтээчихсэн гавьтай зүйл юухан байх билээ гэв.

1932 онд Монголтрансын харьяа монгол тээхийн жолооч нарын түр курсийг төгссөн Баян-Өлгий аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны жолооч Какивайн хүү

намын гишүүн Булгамбай гуай тус аймгийн анхны тээвэрчдийн нэг. Ган хөлгийн жолоон дээр тасралтгүй 40 шахам жил суусан 30 шахам жилд нь аймгийн гүйцэтгэх захиргааны даргын тэрэг барьж жил бүр олон зуун төгрөгийн хэмнэлт гаргадаг байна.

Булгамбай гуай ардын нам, засаг төрийнхөө үйл хэргийн төлөө өдий хүртэл хүчин зүтгэж яваагаа гары нь ганзганад, хөлий нь дөрөөнд хүргэсэн Зөвлөлт Холбоот Улсын иргэн Чарип Отепов, Абай Касымов нарын ач гавьяа хэмээн дурсан явна.

Загарайн Сандагаа

Зохиолч З.Сандагаа 1927 онд Төв аймгийн нутагт малчны гэр бүлд төржээ. Бага, дунд, офицерийн сургууль, Улсын их сургууль, Москвад утга зохиолын дээд курс төгсжээ. 1947 оноос уран бүтээлээ эхэлж “Хамт авахуулсан зураг” өгүүллэгүүд, “Хүний ганц”, “Эр бор харцага” роман бичжээ. МАХН-ын гишүүнд 1951 онд элсжээ.

ЗУРААЧ БҮЖИГЧИН ХОЁР

Зуны адаг сарын хуучдаар цаг тогтуун тал, хөндийд цэцэг ногоо алаглан жигдэрч, Алтайн нурууны эгц цавчим уулс сүр жавхлангаараа өрсөлдөх мэт ноён шовх оргилоороо тэнгэр баганадан буурал тэргүүнээ үүл манангаар халхалжээ. Тэдгээр асгат өндөр уулын хоорондуур урсах нарийхан голын хөвөөнд орших нэгдлийн төв орчим тоос манарах нь олон хүн цугласны шинж ажээ. Тэнд нэгдлийн хорин жилийн ой болж, наадам хийж байгаа юмсанж. Их насны морь ирэхийг хүлээн морьтой нь дөрөөн дээрээ, машинтай нь тэвшин дээрээ зогсож, явган нь өлмий дээрээ өндийх ажээ. «Эргэх яагаа ч үгүй» «энэ хөндий ч ёстой морины чадал шалгана даа!» «мөн ч олон газрын хурд цуглаж дээ» «эргээдэхвэл юу ч удах вэ дээ» гэх зэргээр хэсэг уяачид ярилцав.

Харин явган хүмүүсийн арын машины бүхээг түшсэн хэдэн залуугийн хараа өмнөхөн талд зогсож буй хүрэн пүүсүү дээлтэй хүүхэн дээр тусаж

- Энэ сүмбэ шиг нуруутай бүсгүй чинь хаанаас гараад ирэв ээ?

- Яагаав Улаанбаатараас яваа бүжигчин хүүхэн л байна.

- Мань эр бүр араас нь таньдаг болчихож,

- Манай мянгадын охин юм чинь.

- Үгүй мөн залаваа хөөе!

- Үнэн юм чинь дээ.

- Хэн гэдэг юм?

- Цэен гэдэг юм. Балчиндорж гуайн бага охин шүү дээ.

- За за, тийм болог. Маргахаа больё. Би ямар танай Мянгадаас хүн таних биш. Харин ясан савх шиг цэх хөлтэй хонгор байна даа.

- Чи үнэхээр таньдаг юм бол ногоон дурдан бүс шавхийтэл ороосон нарийхан бэлхүүсээр нь тэврээд нүүрийг нь нааш харуулаадах.

- Одоо л түлэх нь. Хөмсөг багатай хөнхөр бор хүүхэн дээ.

Араас нь хүн цоортол ширтэхийг мэдэрсэн бололтой эргэн харахдаа багын танилаа ойролцоох машин дээр зогсож буйг үзээд толгой дохин инээмсэглэв.

- Шүд нь гөлөгнийх шиг ямар цагаан юм бэ?

- Чимээгүй хүн дуулна.

Тэднийг ийнхүү ярилцаж байтал тасархай айсуй түрүү морины тоос зурайн харагдахад

хүмүүс шуугилдан бужигнаж эхлэв.

~ За «Согоо бор» минь ийшээ дөхье гэж нөгөө хүүхэнд нэгэн залуугийн хэлэхэд тэр юу ч дуугаралгүй түүнийг дагалдан олны дунд орон алга болов.

Нутгийн заншлаар хүмүүс гүүглэж морийг хөгжөөнө. Дун бүрүү хамартай цэнхэр морь түрүүлэн ирлээ.

«Энэ чинь манай Мянгадын морь гэнэлээ» хэмээн Цэен гүйлээ. Гэтэл түрүү морийг тойрон шавах хүмүүсийн дотор нөгөө хэдэн залуу бас л байлаа.

- Таминь бүү шаваач! Салхийг нь тавиад өгөөч! гэж уяачийн хэлэхэд наадамчид тал тал тийшээ боллоо.

Цэен хүүхэн эргэн явгал хэдэн залуу хойноос нь дагалдав.

Түүний өмнөөс хуучин цуваа товчлолгүй задгай орхисон өндөр хүн гүйн ирж мэхэсхийн мэндлэв. Дагзныхаа хавьцаа хэдэн сэвгэр үстэй мөлгөр халзан толгой нь тэр эрийн сүрийг дарах мэт үзэгдэнэ. Тэрбээр хүүхний сунгасан гарыг атгаж зүрхэн тус газар тавьж

- Мэдэгдэж байна уу? гэж асуув.

- Яагаад ингэж хүчтэй дэлсэнэ вэ? гүйгээ юу? гэж эргүүлэн асуув.

- Үгүй,

- Тэгээд?

- Чамайг хараад гээд халзан хүн уртаар санаа алдан хүүхний гарыг тавив.

- За, яршиг даа гэж хүүхэн сулхан өгүүлэв. Энэ хүнийг зураач Лодон гэнэ. Зураач бужигчнийг сугадан цааш одоход

- Нутгийн залуу гэхэд чи ч мөн больчихсон эр юм даа. Дөлсөөр яваад гуулин шанага шиг толгойтой амьтанд сэвгэрээ алдчих юм даа гэж нөгөө хэдийн нэг нь залууг цаашлуулав.

- Би өчигдөр уулзаж мэнд усаа мэдэлцсэн юм чинь. Ер тэгээд тэртээ нийслэл хотын хээнцэр бужигчнээр оролдоод яах ч юм билээ дээ гэв.

Эдний ийнхүү ярилцах үеэр Цэен Лодон хоёр тав гурван үг солиод амжжээ.

- Би чамайг энд явна чинээ санасангүй. Гэнэт учирчаад зүрх минь цээжиндээ багтахаа болих шахлаа.

- Сонин юм даа.

- Сонин ч гэж дээ. Миний зүрх ийм мөрөөдлийг тээж явж дээ.

- Энд хэлэх л гэж үү?

- Хэзээ нэгэн цагт илчлэх гэж тэр хэмээн бүжигчнийг налж эвхээстэй зурвасаа өвөрт нь сэмхэн шургуулав.

- За тэр ч яахав. Хаа хүрч явна?

- Алтайн хязгаарыг сонирхож явна.

- Удах уу?

- Эндээс ингээд нислээ. Ер нь буцах болоогүй.

- Зураг зурах нь уу?

- Яриа юу байх вэ? Хилийн цэргийн амьдралтай танилцах санаатай...

- Амжилт хүсье. Өөрийн чинь бүтээлийг үзэсгэлэнгээс л үзэх юмдаа. Өөрөөр яах вэ дээ? Сэтгэлд сайхан байдаг вэ?

- Миний зураг өөрийн чинь санаанд нийцдэг бол над түүнээс өөр жаргал алга.

- За яршиг даа. Ингэж хамаагүй ярьж болдог юмуу?

- Ярихгүй явж чадахаасаа нэгэнт өнгөрчээ.

- Сонин юм даа! гэж хэлээд Цэен санаа алдчихав. Гэтэл нисгэгч ирж Лодон гуай одоо хөдөлбө гэж хэлээд хүүхэн өөд уучлал гуйсан янзтай харав. Цэен зураачид нэг үг хэлье гэж бодсон боловч чухам юу хэлэх гээд байгаагаа өөрөө эс мэдэн

- Явах цаг чинь болчоо шивдээ. За яахав дараа уулзана биз баяртай гээд гараа сунгав.

Хүүхний энэ үг Лодонд ер бусын горьдлого төрүүлжээ. Зураач бүжигчин хоёр нийслэл хотноо ажилд ирэх очих замдаа дайралдсаар нэг л мэдэхэд хоорондоо мэндэлдэг болж, зарим үед саатан зогсож энэ тэрийг ярилцах удаа гарчээ. Тэгсээр танилцаж, бие биенийхээ сэтгэлийн гүн дэх нууцыг нүдний харцаар мэдрэх төдийхөн явсаар өдий хүрчээ.

«Түүний сөлөрдүүхэн боловч тунгалаг хар нүдэнд энхрийлэвч, эргэлзэх харц илрэх шиг санагдах юм. Үнэндээ тэр учир нь үл ойлгогдох харц миний сэтгэлд хоногшжээ. Энэ хүүхэн зүрх зүсэм ялдамхан аашилж, нүдээрээ инээвч тэрхэн дороо хөмсөг зангидан гөлрөх юм» гэж бодон Лодон онгоц тасрахыг мэдсэнгүй.

«Түүний зүрх намайг харах тоолондоо үргэлж ингэж цохилдог юм гэж үү? Өдий болтлоо эхнэр аваагүй явдаг нь хачин юм даа. Эр хүн гэдэг элдэвтэй дээ»

Цэен ийнхүү бодохын чацуу ширвээ хар сахалтай, ширүүн харцтай ганган залуу нүдэнд үзэгдэх шиг боллоо. «Тэр намайг хичнээн энхрийлж юутай уран үг хэлдэг байлаа. Эцэс сүүлд

нь зангаа хувилгаж бусдын үүрэнд өндгөө орхих хөхөө шиг гэнэт сураггүй алга болж билээ. Үсээ уртасгаж, өмдөө өргөсгөсөн тэр этгээд миний хүнд итгэх итгэлийг аваад явчихсан юмуу? Саяын уулздаг цайлган, хурц зантай эр дундын насны зураачийг цэвдэг сэтгэлт хуурамч залуутай адилтган бодож яахин болох билээ? Би түүнийг эс мөрөөдөвч, уулзах бүр сэтгэл сэргэж, агшин зуур бодол болон хувирах юм. Бусдыг өөртөө татаж аливааг бодуулах увдис түүнд байна уу? Би чинь хүн голохоор хүүхэн юм гэж үү? Тиймээ би эрийг голно ч, гологдоно ч. Аль нэг аян замын хүнтэй зэрвэсхэн уулзаад элдвийг бодож сэтгэлээ зовоогоод яах ч юм билээ!»

Цэен бөх гартал ийм л бодолд автагджээ.

Урлагийн бригадынхан, наадам тармагц аймгийн төв рүү хөдлөв. Бусад наадамчдын адил морь, бөхийн тухай ам хамхилгүй ярилцаж явав. Тэдний ярианд оролцохгүй яваа Цэенгийн нүдэнд ханилж яваад хаясан сахалт залуу, дөнгөж уулзаад ниссэн халзан зураач хоёр, ээлжлэн үзэгдэх мэт болж «Эр хүн элдэвтэй. Гэхдээ монголын бүх эрчүүдийн чанарыг тэр сониучхан этгээдийн араншингаар хэмжиж болохгүй. Тэгвэл насан туршдаа гон ганцаар явах болно. Юутай ч яаран итгэж болохгүй. Үгүй би чинь өөрөөсөө нэлээд ах халзан хүнд сэтгэлтэй болчлоо гэж үү? Ямар ч гэсэн түүнийг санагалзах болжээ. Хөөрхий минь зүрх нь тэгтлээ юунд цохилсон юм бол? Би чинь цохилсон зүрх бүхнийг тайтгаруулах «эм» биш дээ. Одоо тэр Алтайн нурууны дээгүүр нисэж байгалийн гоо сайханд сэтгэл нь дийлдэж, урлахын онгод нь орж намайг аль хэдүйн мартаад ирээдүйн уран бүтээлийнхээ тухай санааширсаар яваа биз.

Бид хоёр тэнцвэргүй хос юм даа. Гэтэл өнөөдөр тэр миний сэтгэлээс ер гарахгүй юм. Мөн ч сонин юм даа». Машины донсолгоонд сэгсрэгдэн явахдаа Цэен ийм л юм бодох ажээ. Аймгийн төвд ирж байрлах өрөөгөө заалгаж аваад гар нүүрээ угааж хоолонд ортол

«Яачдаг юм бол?» «Нисгэгч нь сүрхий чадмаг хүн гэнэ» «Тэр хавьдаа манан ихтэй байсан юм байх» «Өдий хүртэл сураггүйг бодоход өнгөрөө биз» «Төөрч өөр зүг рүү явчаагүй байгаа даа» гэж хүмүүс хоорондоо битүү хүтүү юм ярилцав.

Цэен гайхаж

- Юу болоов? гэж хажуу дахь хүнээсээ асуувал

- Баахан хүн суулгаж явсан онгоц хүрэх газраа цагтаа буусангүй гэнээ. Сураг, чимээ тасарчээ. Лав л хоёр зураач гуйсаар байгаад дайгдаж явсан гэнэ. Бодвол Лодон л байх. Энд явж байна гэж сонсогдсон шүү гэхэд Цэен «Юу?» гэж дуу алдаад халбагаа тавган дээрээ алдаж чив чимээгүй гөлрөнө. «Үнэн л байгаа даа таминь» гэж шивнэн өгүүлээд нимгэн уруулаа хазлан тунгалаг хар нүд нь нулимс бүрхэн бүрэлзэж, сууж буй сандал нь дайвалзан, өмнөх ширээ нь харагдахаа байж, хажуу дахь хүнээ үзэхээ болив. Дотор нь давчдан үс гээгээ зулгааж хувцсаа урж тастмаар санагдав. «Алдарт хүний нэрийг барьж, худал маяглаж байна гэж улс амьтан хэлэх вий» гэж санавч тэсч үл чадан хоолоо хаяж гарч өрөөндөө гүйн орж «Лодон! Лодон! Чи минь хаана байна? Амьд явна уу? Хэрэв чи ослоос мултарсан бол би чинийх. Би одоо л ухаарлаа. Үнэндээ чамд битүүхэн дасаж явжээ гэж түрүүлгээ харан ойчиж цурхиран уйлав. «Заяа байгаад амьд мэнд уулзвал!..» Хүүхний бодлыг дагалдан ухаалаг сэргэлэн нүдтэй,

өндөр гоолиг эр харагдах шиг санагдана. Түүний халзан толгой өргөн нүүрэнд нь онцгой зохисон мэт бодогдоно. «Согоо бор» гэж танайхан чамайг олж өхөөрджээ» гэж нэгэн удаа хэлж байсан нь хүртэл ив илхэн санагдана. Сая уулзахдаа «үнэн байвал сонсоход эвгүй биш юмсанж» гэж хэлэх гээд үгээ олсонгүй. Удаан хугацаагаар цээжиндээ хадгалж явсан зүйлээ уудлан илчлээд тодорхой хариу дуулалгүй явахдаа юу гэж бодоо бол? Хагацан ядан намайг эргэн эргэн харж онгоц зүглэхдээ амьд ахуйнхаа хамаг найдлагаа надад орхиод явсан хэрэг үү? Хэмээн нулимсаа арчихаар өврөө суйлтал эвхээстэй дөрвөлжин цаас гарт нь баригдав. Түүн дээр Цэенд гэж бичсэн нь зурайн үзэгдэв. Задалбал «Нуулгүй үнэнийг хэлэхэд би эрэлчин хүн. Уран бүтээлийн хайгуулын зэрэгцээ нэг л хүнийг эрэн явжээ. Тэгсээр би түүнийгээ олж үзлээ. Миний хайсаар явсан эмэгтэй маань чи байжээ. Чамайг анх харсан тэр нэг өдрөөс хойш миний зүрх баяраар бялхаж, бас сэтгэл минь гуниг мөрөөдлөөр дүүрчээ. Бийр, будаг барин зогсохдоо аливаа зүйлийн нодгыг олохоор оролдож цөхрөнгөө барах буюу алжаан ядрах үес чиний дүр сэтгэлд минь бууж урам зоригийг бадраана. Бүхнийг чиний төлөө хийж буй мэт надад санагдана. Нэгэнт эхэлсэн юмаа дуусгахын тулд «Үүнийг гүйцээлгүйгээр «Согоо бортой уулзаж яахин болно» гэж өөртөө тушаадаг билээ. Хэрэв зураг минь барагтай болбол» чиний хайнгуутаас болж «Согоо бор» ичнэ шүү» гэж уран бүтээлдээ тавих шаардлагаа чамтай холбож сэтгэлээ зогоодог билээ. Ийнхүү чи миний өдрийн бодол, шөнийн зүүд болсоор ихэд удлаа. Би энэ хэдэн үгийг чамд хэлэх гэж хичнээн зовбоо. Чи минийх байгаасай гэж үнэн голоосоо хүснэ. Хүсэл минь биелбэл би энэ ертөнц дээр хамгийн азтай хүн төдийгүй өдий хүртэл оролдсон зургийн өнгө будаг улам тодорч, хүн ардад улам ч ойлгомжтой болно гэж гүн итгэнэ. Чамайг өөрийнхөө эхнэр гэж хэлэх эрх олж авбал миний уран бүтээлд үл цуцах жигүүр ургана. Хэрэв чи намайг үнэн сэтгэлээсээ хайрлахгүй, хоромхон зуур уяран өрөвдөх аваас уйдахын цагт чинь тогтоох хүч надад байхгүй. Хэтэрхий нуршив бололтой. Хэлэх үг минь энэ дээ.

Танай бригадыг энд явна гэж сураг сонсоод энэ захидал мэтийг бичиж хоромхон зуур саатахыг нисгэгчээс гуйсан юм. «Согоо бор минь» аян замдаа сайн яваарай. Хэрэв та нар аймаг дээр хоёр хоног саатвал ахин уулзаж юу магад гэж горилно! Чамайг ямагт хүсэгч Лодон үнэн» гэжээ. Цэенгийн бариастай зурваснаас гал авалцах мэт гар нь халуу оргив.

«Нулимсны дусалд нэвтрэн халтардсан ам цаас зураачийн ариун хайрыг төлөөлөн хоцрох нь энэ, үү?» гэж бодоод бүжигчин хүүхэн бахардаж мөнөөх зурвасыг өр зүрхэндээ шингээх гэсэн юм шиг цээжиндээ наалдуулан хоёр гарынхаа алгаар дарлаа.

Үүд тогшивч хүн үл хариулахад бригадын ахлагч гайхан амьсгаа дарж чагнавал мэгшин уйлах чимээ сонсдов. Тэвдэн сандрахдаа хаалгыг угз татвал түгжээгүй, цовоо цолгин зантай Цэен нулимстайгаа хутгалдан уйтгарт дарагдан суугаа харагдлаа.

- Юу болох нь энэ вэ? хэмээн дэргэд нь очиж суун мөрөн дээр нь гараа тавин, «Цэен яагаав?» гэж аяархан асуув.

Хүүхэн нулимсаа арчиж, уртаар сүүрс алдан

- Би өнөөдөр тоглож чадахгүй шүү ! гээд гөлрөв.

- Тэр ч яана гэх вэ. Яаснаа надад хэлээч.

- Сураг байна уу?

- Юун сураг? гэж асууснаа гэнэт санаа авч «Өө хөөрхий надад яриад байдгаа хэлээд амжиж л дээ» гэж бодон хэлэх үгээ олж ядахдаа толгойгоо сэгсрэв. Бригадыг ахалж яваа Цэрэн Лодон хоёр урлагийн сургуульд нэг жил орж, дотно танилцаж ижилдэн үерхсээр илэн далангүй болсон хоёр юм.

«Танай «Согоо бор» хир хүүхэн бэ? Өдөр хоног өнгөрөх тутам түүнийг мөрөөдөх боллоо» гэх зэргээр Цэрэнтэй уулзах бүрдээ Лодон Цэенгийн тухай ярих болжээ. Улсын наадмын дараа дайралдахдаа «Сэтгэлээ зовоож явахын оронд үгээ хэлдэг ч юмуу? гэж бодовч нэг л зүрхлэхгүй юм даа» гэж уртаар санаа алдахад нь нэг ч үг дуугаралгүй дэмий инээжээ.

Түүнээс хойш уулзалдаагүй. Цэрэнгээр дамжуулан мэнд хүргэсэн ажээ. Цэрэн хэсэг дуугүй сууснаа

- Биеэ барьж уужуухан бодох хэрэгтэй. Юм заавал муугаар эргэх ёстой биш. Таван ханатай гэрийн буурийн чинээ газар буучихсан нисгэгч ч байдаг. Онгоцоо эвдрэхэд осолгүй газарддаг, бензинээ дуусахаар гулгуулж суулгадаг гэх зэргээр аль санаанд багтамгүй тохиолдлыг тоочиж барах вэ? Тэгээд энэ Самдан гэдэг чинь эндхийн газрыг таван хуруу шигээ мэддэг, жижиг онгоцоор нисэх албаа гүйцээгээд алсын тээврийн онгоцонд шилжих гэж яваа маш чадамгай эр дуулдана гэж Цэенг тайвшруулахыг оролдов.

«Гурав хоног агаар муудаад шуудан хуримтлагдаж ачаа нь хүндэрсэн юм гэх шив». «Арван хэдэн хүнтэй юм гэнэ шүү дээ» «Өлгийтэй хүүхэдтэй хүүхэн, наян хэдтэй өвгөн хүртэл сууж явсан юм гэнэ» «Туслах нисгэгчээ орхисон сурагтай». Иймэрхүү яриа хүн, хүний ам дамжина.

Лодонгийн бие нэг л хөнгөн, онгоцонд суугаад биш өөрөө жигүүрлэн нисэж яваа мэт баясал төрнө. Алтайн нурууны мөнх цаст уулыг цонхоор ажиглахад мөнгөн дуулгатай үлгэрийн баатар мэт санагдана.

Онгоцны далавч дайвалзан чимээ шуугиан улам ихсэнэ.

«Ботгон хоолой» хэмээх хавцал газрын цав шиг харагдана. Цааш жаахан явтал үргэлжлэх уулын дээгүүр манан татаж харанхуйлжээ.

Онгоц эргэлээ. Дахиад эргэлээ. Уулын хооронд давчуу учир ийнхүү өндөр авдаг ажээ. Нислэг үргэлжлэн онгоц улам дайвалзаж, нарны малгай шиг цагаан үүлсийг шүргэн алдана. Ахиулан ажихад мөсөн тэргүүн дээгүүр нь цас шуурах уул хангал цагаан азарга дэлээ хийсгэн салхи сөрөн довглох мэт харагдана. «Агаарт зогсож болдогсон бол энэ сүрт үзэгдлийг зурахсан!» Лодон ийнхүү тэр л зүг ширтэнэ.

Гэнэт аянга ниргэх мэт сүрт дуун гарч дотор бие дээшээ огшоод ирэх шиг болж сандлаасаа салан ойн буцаж суухдаа «Ээжээ яанаа!» гэж бүсгүй хүн чарлахыг сонсов.

«Өөр арга алга» гэж хэн нэг хүн хэлэх шиг болов. Түр, няр хийх чимээ сонсдов. Юу ч үл

үзэгдэнэ. «Согоо бор минь» гэж хашгирснаа ч Лодон өөрөө мэдсэнгүй. «Ингээд л өнгөрч дээ». Ийн бодохын чацуу анир чимээ эс сонсогдоно. Тэр аймшигт хормоос арваад мөч өнгөрчээ. Энэ завсар ямар учрал хэрхэн тохиолдсоныг Лодон яахан мэдэх билээ...

Нэг мэдэхнээ онгоц хөдлөхгүй байх шиг. Нүдэнд нь юу ч үл үзэгдэхэд орилохыг завдтал дуу гарч өгсөнгүй.

«Ингээд хэлгүй, нүдгүй болох минь энэ үү? хэмээн бодож биеэ тэмтрэхээр оролдвол гараас нь юм татаад байхад «бас юу дарчдаг билээ? Хугараагүй бололтой бусад маань цөмөөрөө үрэгдээд би ганцаараа эрэмдэг болж үлдээ юу? Эс бөгөөс чих минь бас дүлийрч аливааг сонсохоосоо өнгөрчихөв үү?» Лодонг хэсэг зуур ийм бодол эзлэв. Нэлээд удсаны дараа нүд нь онгойн манан, утаа аль нь мэдэгдэхгүй юм суунаглан орчин тойронд харагдах бараа алга.

Энэ ер нь онгоц шатаж таарваа даа?! Хэзээ дэлбэрдэг бол? Түрүүн цаашаа харчихсан бол аштай юу? Хоёр дахин үхэх үйлтэй байж дээ. Энэ муу халзан толгой юу! Өдий болтлоо ганцаар явсан атал үхлийнхээ өмнө хүний бүсгүй үрийн сэтгэлийг юунд хөндвөө. Лодон үүнийг бодон цухалдахдаа «Согоо бороо!» гэж хашгиран хэл оров.

Хүн тачигнатал инээж сонсдов. «За би солиорч байна уу даа? Ийм үед хэн инээх билээ» хэмээн бодтол:

- Та нар минь цөм мэнд шив дээ! гэж хэлээд нисгэгч өмнө нь зогсож харагдав.

- Мэнд, мэнд гэж энд тэндээс өгүүлэх сонсдов.

- Нисгэгчээ энэ юун утаа вэ? Онгоц шатаагүй биз гэвэл

- Бүү сандар! Би бүгдийг хийсэн одоо онгоцны аюул огт байхгүй. Харин та нүдээ арч гэхэд нь

- Миний гарыг юм дарчаад байна гэвэл Самдан, зураачийн нүдийг арчиж гар руу нь заав. Лодон сандлаас зуурсан ажээ.

- Онгоцны сүүлээр нь горхины эрэгт шааж тээглүүлэн зогсоочихсон. Ус нь их гүнзгий юм. Маш болгоомжлох хэрэгтэй. Холбоочин бид хоёр л урьтаж гарья.

Намайг дуудахаар цуварч буугаарай. Тэртэй тэргүй явгарсан улс яараад яах вэ? гэв.

Самдан Лодонг өрөөсөн гараас нь татан буулгаж

- Хүүхэдтэй хүүхнийг урьдаар буулга. Дараа нь өвгөнийг гарга гэж захирангуй өгүүлэв.

- Хүмүүс уван цуван бие биеэ дэмжсээр онгоцноос гарцгаав. Лодон хүүхний дэргэд очиж аг даггүй бархиран буй хүүхдийн дээрээс өнгийн

- Мээмээ нь өгөөд үз дүү минь! Гэхэд бүсгүй гэнэт санаа аван хөхөө гарган аманд нь хийхэд тэр нялх амьтан умар, умар хийн эхийн сүүг залгиж тайвшрав.

Самдан нисгэгч их биенээс бусад нь салам эвдэрсэн онгоцныхоо сэгийг хараад шүүрс алдаж

- Бид бүгдээрээ «ус уух хувьтай улс байж дээ» гэж өгүүлэв.

Асга хадаар дүүрэн явцуу хавцал дунд салхинд цохиулан агаарын цөмрөлтөнд орсон онгоц зориг самбаат нисгэгчийн гараар залуулан дэгдэж далавч, сэнсээ цувуулан гээсээр энд ирэн зогсжээ.

Самдан тамхиа гаргаж асаагаад

- Лодон гуай нэг цэцэг зурах гээд яваа хүн юмаа даа? гэв.

Лодон ихэд гайхан

- Яаж байна? хэмээн нүдээ том болгон асуув.

- Та «согоо бор минь!» гээд ухаан алдсан. Сэхэхдээ бас л «согоо бор минь!» гэж хашгирсан шүү дээ.

Зураач нэрэлхэхийн эрхэнд дуугүй суув.

- Согоо борыг чинь шарханд сайн гэдэг байхаа! гэж холбоочин өгүүлэв. За бүү мэд! Манай Лодонгийн шүтээн ч юм билүү хэн мэдлээ дээ.

- Хүүхээ чи согоо бор авч яваа бол надад өгөөч! Миний муу мойног хуруу шалбарчиж. Бариад боочих юмсан.

- Энд алга даа өвөө минь! гэж хариулав.

«Миний согоо бор» наддаа цэцэг, шүтээн дээ! Харин зүрхний шархыг эдгээх, сэдрүүлэхийг яахан таах билээ. Захидлыг минь уншаа бол уу? Одоо хаахна юу хийж яваа бол» хэмээн бодоод «Согоо бор!» гэж хад цуурайтгал хашгирмаар санагдав.

РЭНЖИНГИЙН САЙЖАА

Зохиолч Р.Сайжаа 1930 онд Завхан аймгийн Эрдэнэхайрхан суманд төржээ. 1963 онд Хууль цаазны дунд сургууль төгсжээ.

1954 оноос «Сахалт чөтгөр», «Нэргүй захидал», «Сэвлэг», «Далдын хар дээл» зэрэг өгүүлэг, туужийн ном, «Бага дарга» роман бичжээ.

ӨӨХӨН ЧУЛУУ

Шөнөжин орсон шиврээ бороо нар хөөрөх үед татарч газар суусан явган будан нарны гэрэлд өнгөтэйеэ цагааран хөвсийнө. Богдын голын билчирт зусаж байгаа мөнгөн аяга хөмөрсөн адил харагдах цагаан гэрээс сайхь эх Сайнсанаа гарч ирээд дөрвөн зүг найман зовхист хараа сунгахад ядарч туйлдсан хорголон бор нүдэнд нулимс цийлэгнэн хурж, зовхи нь цэврүүтэн цэлхийжээ. Тэрээр нулимсаа арчиж нүд хүрэх бүхнийг гүйлгэн харваас өөхөн чулуут хэмээх гэрийн чинээ толгой нүднээ тусахад хорин жилийн тэртээ тэнд балын амтыг амталсан «зөгий» болсноо санасан Сайнсанаагийн үргэлж харшилдаг таван махбодь амсхийх шиг болоход эвгүйхэн хөдөлбөл үеэр нахисхийдэг цэгц шулуун хөлөө аяархан зөөж гишгээд ямар нэгэн анир авсан согоо шиг зог тусан зогсож өөхөн чулуут толгойг ширтэн ингэж бодов.

Би хорин настай байжээ. Эр хүний өөдөөс эгц харж чадахгүй, харчуулыг сээтэн хаяхаар хамаг бие агзасхийж дургүй хүрдэг байсныг яана. Хүний ерөөл тавилан гэж хачин шүү! Өөхөн чулууны өврийн булгийн уснаас ус авч байтал Дүгэржав гэж зүс таних залуу хул морьтой давхин ирж билээ. Дүгэржав өтгөн хар хөмсөгтэй туранхай хөх царайтай, үг яриа гэж тун цэцэн цэлмэг. Түүний тас тас хөхрөх нь хичнээн хайр хүргэсэн гээ. Тэрбээр хавчиг хувинтай усыг минь өргөж өгөхдөө:

- Үгүй энэ чинь яасан хүнд юм бэ? гэв.

- Зүгээр зүгээр.

- Би дөрөөвчлөөд дөхүүлж өгье.

- Яах юм бэ? Би үүрээд л харьчихдаг юм чинь гэж намайг хэлэхэд Дүгэржав үг ч хэлсэнгүй хувинтай усыг мориныхоо буруу тал руу давуулж оосрыг зөв талын дөрөөнд дөрөөвчилж мордов.

- Хүн амьтан харвал муу хэлнэ байгаа гэж би дургүйцэх мөртөө дотроо дуртай, сайхан санагдав. Ээжий хонинд, аав хоршоонд ноос тушаах гээд явчихсан болохоор хувинтай усаа гэртээ хүргүүлсэн ч ичиж зовох юмгүй нүүр бардам байлаа. Гэсэн ч би байсхийгээд «Хүүе ээ, одоо би үүрээд харьчихъя» гэхэд Дүгэржав тоосон шинжгүй тас тас хөхөрч «Харин чи морин дээр морд. Би явган явья» гэж хэлэх нь сайхан санагдуулж хайр хүргэнэ. Хархүү гадаа хувинтай ус буулгаж өгөөд явахдаа:

- Сайнсанаа! Чи маргааш ус авах уу? Гэв.

- Авалгүй яахав.

- Хэдүйд авах вэ?

- Үдээс урагш.

- Би чам дээр очно шүү.

- За яршиг даа. Улс муу хэлнэ, хэрэггүй.

- Очихоо очино гэж Дүгэржав хэлээд Богдын гол чиглэн давхиж билээ. Тэр шөнө миний нойр ч хүрээгүй. Дүгэржавын тас тас хөхрөх дуун чихнээ сонсогдож сайхан инээмсэглэдэг царай нүднээ үзэгдэх шиг хонож билээ.

Намайг хувингаа дүүргээгүй байхад Дүгэржав ирж, бид хоёр толгойн өврийн өөхөн чулууны ёроолд очиж суусан. Хайрт минь толгойн оройн өөхөн чулууг ширтэн байснаа над руу нэг их сайхан инээмсэглэж миний царайг өөхөн чулуу гэж өхөөрдөж билээ. Түүнээс хойш хорин жил бид хоёрын амины ярианд өөхөн чулуу гэсэн үг зүрхний жигүүр, сэтгэлийн чимэг болсон юм. Дүгэржавтайгаа суусан жил олдсон банди минь энэ жил хорь хүрч хүний бага эмч болов.

Хүүгээ өчигдөр суух сум руугаа явахад үнсэхэд манцуйндаа байхын нь үнэр яг хэвээрээ байна лээ. Тийм нялх амьтан олонд оточ болж чаддаг юм байх даа! Ядаж сумдаа суулгая гэхээр аав нь сургасан газар нь ажиллах газрыг зааж өгдөг ёстой гээд хөдлөхгүй шүү! Бие муу байна. Миний хүү эмч болсон юм бол ээжийгээ эмчлэг гэхээр чамайг эмчлэх аавын хүү, ээжийн охин олон бий шүү дээ гэх юм. Манай Дүгэржав гэж энэ нэгдлийн хэдэн адуутай хөөцөлдөж байвал ганц болдог хүн... Үгүй ээ! Бас тийм биш. Ажил амьдралаа аль алинийг нь боддог хүн. Үүрээр босож надад хоол цай хийж өгөөд явна. Бас орой ирж хоол цай хийж өгнө. Үсийг минь хүртэл самнаж өгнө шүү! Хүний хань гэдэг юутай ч зүйрлэшгүй. Ямар сайндаа ч эр эм хоёр нэгнийгээ нэг бие гэж нэрлэх вэ? Өвгөн минь улсын аварга адуучин, би аймгийн аварга саальчин цол хүртлээ. Өмсөх хувцас, идэх хоол элбэг, нэр бүтэн айлын зэрэгтэй явах шиг жаргал хорвоо ертөнцөд яаж байх вэ? Эх хүнд төрүүлсэн үр шиг нь хайртай юм хаа байх вэ? Гэсэн ч монхор хамартай хар нүдэн бандиасаа илүү хорчгор хөх өвгөндөө хайртай гээч! Эм бүр ийм байдаг болов уу?!... Яаж бие даагдахгүй байхад өвгөнийгөө ирэх чимээнээр гарч хараад нэг хэсэгтээ ясанд янгинаж байсан өвчин эдгэрэх мэт болно.

Өвгөнөө морио шонгоос уяад гэр рүү явахад царайг нь хараад тэр өдрийн ажил төрөл хэрхэн амжсан, миний бие муу байгаад сэтгэл түгшиж эм тан хүртэл олоод ирснийг мэднэ. Эр эм хоёр гэдэг чинь нүдний харц, нүүрийн хөдөлгөөнөөр бодож сэтгэж байгаага мэддэг төдийгүй үл үзэгдэх утсаар холбогдсон хоёр зүрх бие биеэ мэдэлцдэг юм. Өвгөн бид хоёр хэлгүй, дүлий болчихсон ч дутаж гутахгүй. Хүн юу сурч мэдсэн, ямар ажил эрхэлдэг байна түүнээ магтаж, түүндээ дурладаг. Малчин хүний ажил өдөр шөнөгүй үргэлжилдэг мөртөө бас өдөр шөнөгүй үргэлжлэн амардаг нь сайхан. Өвгөн минь хар үүрээр адуундаа явсан. Одоо ирэх болж баймаар юмаа. Би гэж... Давааны араас өдөржин өвгөнтэйгөө нэрс түүж үдшийн бүрий болохоор майхандаа хавчиг хувин, хувин жимстэй ирсэн. Өвгөн гадаа галлаж, хоол цай хийх мөчид галын гэрэлд эргэн тойронд байсан мод бараантан данхайхад миний айдас хүрч өвгөнийхөө өвөр дээр суух шахам байж хоол цайгаа дутуу хагас идэж уусан болоод хэвтэж билээ. Шар шувуу дуугарч, ой тар няр гээд л би айхдаа өвгөнийхөө элгэнд, толгойгоо наалдуулаад хэвтчихсэн.

- Сайнсанаа! Чи юунаас айгаад байна? гэж өвгөнийг асуухад би:

- Өөрөө харанхуй шөнө модон дотор гал түлж хүн айлгачихаад гэж хорин жилийн тэртээ өөхөн чулуун толгойн өвөрт хушуу унжуулан айлгаж тунирхсантайгаа адил болж билээ.

Тэгэхэд өвгөн миний цээжээр чанга тэвэрч таг хэвтэв. Би зүүрмэглэж байснаа нам унтсан.

- Чөтгөр гээд босон харайж ирснээ ууц нуруугаа даран ёолж унасан гэдэг. Намайг хэдэн мөчийн хойно ухаан ороход үүр цайж байсан. Миний ууц нуруу лэнтийтэл хавдаж өвчин гэж ясандаа янгинаж яадаг аргаа барав. Өвгөн намайг дүүрсээр амны адгийн Жавьнд очсон. Жав гуай гай зовлон болно гэж бодсон юмуу?! Аа эсхүүл тэр нэгэн жил багийн дарга байхдаа манайд согтуу ирж өвгөнийг алгадаж, өвгөн хоёул муудалцаж сумын захиргаа хүрсэн хоёр. Тэр хэргээс болж Жав багийн даргаас мултарсан гэж нутгийн ах дүүс ярьдаг. Энэ үнэн ч юм билүү! Худлаа ч байж болох юм. Бүү мэд ээ, юу ч гэсэн энэ удаа Жавын цулцгар хүрэн царай бараантан барайж, араандаа нэгийг зуусан нь илэрхий.

- Та нар одоо түргэн явцгаа. Миний хүүгийнх нялх нойтон хүүхэдтэй... гэж хөөж билээ. Харин Жавын гээгтэй «могой» хатгаж гээд зусаг хонины сүүгээр угааж, надад сүү уулгасан. Орой нь өвгөн бид хоёр үлгэн салган гэртээ харив. Өвгөн маань цагаан цайлган юу бодсоноо хэлж байж санаа амардаг хүн болохоор байсхийгээд шүүрс алдаж толгой сэгсрэн:

- Дотуур тамиртай, хар буруу санаатай хүн хорт могой хоёр адил. Жав, гээгтэйгээ могой хатгажээ гэхэд «Үгүй, үгүй шумуул...» гээд хүргээгүй. Эхнэрээ сүү энэ тэрээр эмчлэх гэхэд хорьж, үүнд эмнэлэг мэмлэгийн хэрэг ч байхгүй гэж бүдүүн томоотой наана цааныг мэддэгээрээ биднийг тайвшруулан байж, эмнүүлээд эмнэлэг авахааргүй болгож хүүхнийг минь алсан хүн гэж өвгөний хэлдэг үнэн. Миний бие үнэхээр өөдлөхөө байлаа.

Дотуур тамиртай, хар буруу санаатай хүн хорт могой хоёр адил гэж өвгөний хэлдэг гэж бодох сацуу Сайнсанаагийн нүднээ Жавын заналт хар бараан царай аймшигтайяа үзэгдсэнээ, хар эрээн могой болон хувирахад саахь эхийн ухаан балартаж салхинд цохиулсан зул адил болжээ.

ЛУВСАНДАШИЙН СОДОВ

Зохилч Л. Содов 1929 онд Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт малчны гэрт төржээ. Офицерийн сургууль, цэргийн ерөнхий сургууль, 1961 онд Ленинградын улсын их сургуулийг тус тус төгсжээ.

1958 оноос уран бүтээлээ эхэлж Хаврын нар, Уул Алтаадын туужууд, Хоёр цагаан хусны домог зэрэг тууж, өгүүллэг Голын тэртээх манан, Сарны доорхи хорвоо роман бичжээ.

УУЛЫН НАРИЙН ХЭЖЛҮҮР

Зуны хурц наран тайгын цаагуур шаргал туяа цацруулан шингэх үед ойн зүгээс таатай сэрүү татдаг билээ. Ийм үед Сэлэнгэ мөрний Хувинтын тохойн ус чухам хаашаа урсаж буйг нь мэдэхэд бэрхтэй чимээгүйхэн мэлтэлзэх нь нуруугаа амрааж байгаа хүлэг морийг санагдуулам. Тэнгэр цахдах Чахтага уулын мушгиран урсдаг Сэлэнгэ Хувинтын энэ цагаан тохойд хэдэн салаа болон задарч намуухан урссанаа Алтаадын адгийн хадан гацаанд тулж очмогцоо ганц аварга цутгалан болж улам ч дошгирон шуугин цааш оддог байна. Хадан гацааны наад дэвсэг дээрхи жижиг цагаан байшингууд торлог бөөрөлзгөнө, битүү бүрхсэн цаад өөд нь олон гэр ярайн харагдах нь холоос тодорно.

Энэ бол Аржаргалантын модны үйлдвэрийн бяцхан суурин билээ. Замд яваа хүнд, буйд газар санагдах хэрнээ энд цэнгэл жаргал, уйтгар гуниг, сайхан сэтгэл, хайр дурлал ер нь хүний амьдралд тохиолддог ерөөл тавилан цөм бий. Энд ус модны ажилд гарамгай, ой мод шигээ эрс шулуун зантай эр чадалтай хүмүүс амьдарна. Анх газар газраас ирсэн модны дал холтос хуулан янз бүрийн оромж барин сууж байсан юм. Одоо модны үйлдвэрийнхэн нэртэй нэгэн өнөр ам бүл, ой мод шиг олуулаа болжээ. Сэлэнгэ мөрнөөр өдөр шөнөгүй урсан ирж байгаа салыг цагаан тохойн модны үйлдвэрээс эх орны хэрэгцээнд дөрвөн зүг, найман зовхист тээвэрлэдэг байна.

Ажлын өдөр машин трактор, салчин, усчдын дуу хадаж байдаг. Цагаан тохой өнөөдөр амралтын өдөр болохоор нам тайван байгаа нь энэ. Мөрний захаар хүн үзэгдэхгүй боловч өнжин хонон ухан байж дөнгөж сая ус шавраас татан гаргасан машин трактор бүдүүн бүдүүн гуалингуудаа дааж ядах мэт амьсгаадан гэлдэрч байгаа харагдана. Харин Сэлэнгийн арал тохойнуудад хайрдуулан орхисон салнууд бараантана. Тэнгэр дүнсгэр, анир чимээгүй бүгчим байвч алс тэнгэрийн хаяаг шүргэх шовх уулын оройгоор ганц нэг үүлс хуралдан их салхи дэгдэж аадар бороо цутгахыг зөгнөх амуй. Ойн ар хаяан дахь нөгөө олон гэрийн гадаа хүүхэд шуугилдан бужигнаж зарим томхон нь усанд очиж орохоор салчны хөл, машин тракторын дугуйд дагтаршсан шаргал замыг даган уралдаж яваа харагдана.

Сугар шилбэ рүү хатгах шивээ өвсийг эгдүүцэн авч хаяад,

- Хөлөө чулуунд урчихваа гэж охидууддаа анхаарууллаа. Үйлдвэрийн дарга Сугар эхнэр хүүхэдтэйгээ ойд зугаалж мөөг түүгээд сэрүүн оруулан буцаж яваа нь энэ юм. Сугар цэргийн инженерийн албаны дарга байсан боловч эрүүл мэндийн хувьд бэлтгэл офицерээр халагдан энд томилогджээ.

Сугар дарга халхгар эрээн өмд, богино ханцуйтай цамц, сийрсэн малгай өмсжээ. Эхнэр нь нарийхан шуумагтай тавьдаг өмд, бариу цамц өмсөж цэнхэр шүхэр барьсан байна. Хоёр охин нь ижилхэн одтой цоохор плать, өргөн хүрээтэй нарны малгай өмсөж, сагс барьсан явна. Тэдний инээд баясал тодорсон царай зүсийг харваас дутах юмгүй сэтгэл түвшин жаргалтай гэр бүл болох нь илт.

- Та хоёр цангаагүй биз! Наад шилтэй сүүнээсээ балга гэж хэлэх нь даргын гэргий үр хүүхэддээ, халамжтай зан сайтай хүн болох нь харагдана.

- Аав аа! Ээж ээ ~ Тэрнийг хараа гэж хоёр охин нь дуу алдав. Салчдын гэрүүдээс наашаа зам тосон гүйж яваа харагдана. Дарга маань ойд зугаалахаар эхнэр хүүхэдтэйгээ явж байна гэж томчуулын ярьж байхыг хүүхдүүд сонссон билээ. Салчдын гэрийн гадаа тоглож байгаа хүүхдүүд

- Манай дарга ухаантай, маш сайхан сэтгэлтэй гэж өөрсдийнхөө зохиосон дууг шуугилдан дуулж байгаа нь тодхон сонсогдоно. Долгор,

- Сугар! Хүүхдүүдийн дуулж байгааг сонсооч! Хүүхдүүд ийм л айхтар даа. Чамайг биш гэхэд нэгэн даргыг магтаад дуу зохиосон байна. Эцэг эхээ хэнд ямар байвал хүүхдүүд тийм байдаг юм. Салчид чамд сайн бололтой юм гэж хэлэхэд хоёр охин ч ааваараа бахархан инээж явлаа. Сугар энэ бүхнийг дуулаагүй юм шиг алхах боловч «Манай дарга амьдрал харж үзэх талаараа хосгүй хүн байсан даа» гэж сул цалинд гарч байгаа хуучин даргынхаа тухай салчдын ярьж байсныг санаж явлаа. Энэ үед нөгөө хүүхэд бүр дэргэд нь хүрч иржээ.

- Эвий гэж бондойсон улаан хацартай яасан хөөрхөн амьтан бэ? Гэж Долгор дуу алдав.

- Ээж ээ! Хэний хүүхэд юм бэ гэж охиноо асуухад нь

- Манай салчдын л хүүхэд байх даа. Та хоёр чихрээсээ байвал өгөөч гэжээ. Охид нэг нэг баавгайтай чихэр сарвайсан боловч бяцхан охин бишүүрхсэн юм шиг ширтсээр байна. Долгор,

- Заа! Ав, ав! Манай охидууд чамд чихэр өгч байна гэхэд бяцхан охин эргэлзсэн том алаг нүдээрээ ээж аав хоёрыг улнаас толгойг хүртэл ширтсээр байлаа. Бяцхан охин нүдээ ууртай гялалзуулан амаа жимийсэн байхыг Долгор сая ажиглажээ.

- Тун ширүүн харцтай охин юмаа. Чи биднийг яасан сүрхий харах юм бэ? Манай охидууд тоглоомыг чинь булааж аваагүй биз гэлээ. Бяцхан охин Сугар руу дөхөж очсоноо,

- Та миний аавыг талхны мөнгөнөөс салгасан уу? Муу хүн гэж хэлчихээд гэрийн зүг бөжин шиг дэгдэв. Аав, ээж, охид мэл гайхцгаан нэгэн мөч өөд өөдөөсөө харан таг дуугүй зогссоноо цаашаа яваа харагдавч ойн цоорхойн хад чулуун дороос ундарсан ботгоны нүд шиг булаг шанд, мөөг, чацаргана, жимс цэцэгний тухай хөгжөөнтэй яриа замхран дор бүхнээ бодолд дарагджээ. Гэнэт бага охиноо,

- Ээж ээ! Саяын хүүхдийн аав, ээж ямар хүн байдаг юм бол гэхэд,

- Ээж нь яаж танихав дээ. Нэг хүний л үр байх гэв. Сугар харин «Би ч танихгүй, ер нь салчид маань хэн нь хэдэн хүүхэдтэйг ч мэдэхгүй шүү дээ» гэж бодож явав. Энэ үе нөгөө бяцхан «элч» салчдын хорооллын наад жалга руу орж харагдана. Охиныг эрэг дороос нэг хүн тосон авч байна. Энэ бол Занаа байлаа.

- Даргад хэлэв үү? Юу гэж байна гэж охиноосоо яаран асуужээ. Охин,

- Таны зааж өгснийг хэлсэн. Юу ч хэлээгүй, намайг хараад л байсан гэв. Занаа их хэрэг

бүтээлээ гэсэн шиг санаа алдан,

- Болж! Хүн бүгдийг ингэж байхад бид тэгж хэлэлгүй яах юм бэ. Миний охин аавдаа хэлж болохгүй шүү! Гэж захилаа.

Сэлэнгэ нам дөлгөөхөн боловч юунд ч саатахгүй гэсэн шиг шуугин долгилно. Дээрээс нар төөнөн, хажуугаас сэрүү татсан ийм өдөр сал урсгах гэдэг ёстой эр хүний жаргал даа. Уснаа өнгийн тольдох гайхамшигтай цогцолсон нов ногоон уулс, зүрхэн шовх хадан хясааны хоорондуур их сал гарч ирлээ. Салны дунд хирд бяцхан майхан шааж өмнө нь угаа суунаглана. Хонхойж цонхойсон, тортог болсон зэс тогоог авч салны ирмэг дээрээс тонгойн ус утгаж гал дээр тавьж байгаа харагдана. Салны толгойд ганц хүн сэлүүр барин тамхи татаж сууна. Тэр наранд халахаас болгоомжлон цамцаа норгон толгой дээрээ тавьж үсэрхэг шилбээ өвдөгт, тултал усанд дүрэн, усан дээр бутарч байгаа нарны гэрлийг нүд онийлгон ширтэнэ. Нарны хурц гэрэлд усны толио шүр сувдын үртэс шиг гялбалзан нүд гялбуулахад нөгөөх хүн жирэлзэх давалгааг тасралтгүй ширтэн явлаа. Энэ хүн чухам юу бодож явааг хэн ч мэдэхгүй. Өвгөн салчин тэрэгч өөрөө өөртэйгөө ярин өнө эртний юм бодож явлаа. Сэлэнгэ, нарны гэрэлд гоо сайхан, солонгын цэнхэр өнгөтэй болж өөрөөсөө нэн гайхамшигтай гэрэл цацруулан байх нь энэ өвгөн салчин Дамдинд жаргалтай. Будан мананд орой нь бүүдгэрэх нь их тайгын хормойн идэрхэн ой найр, чуулга гэлтэй мөр мөрөө түшин найган шуугих нь уяралтай. Дамдинд, «хүмүүс ч гэсэн энэ ой мод шиг дэм дэмдээ амьдардаг ёстой. Миний ирэхэд энэ ой зулзаган төгөл байж дээ. Ой мод олон ч уул бараадаж ургах юм, би энэ модны үйлдвэрийг түшиж амьдарч яваа юм гэж бодов. Анх хэдэн онд ирж байсан юм бэ дээ?» гэж өөрөөсөө асуух мэт бодлогошрон, модны жижигхэн холтос хуу татан чулуудав. Цахлай хараацай далавчаараа ус шүргэн эргэлдэн хөөцөлдөж, энд тэнд ялаа шумуул шүүрч байгаа загас пол пул хийж байна. Өвгөн салчинд, анх ирж байснаа бодоход амттайхан байнам. Модны рам гэж юу байдгийг мэдэхгүй хирнээ л зориглосондоо идэр нас, эр зоригийн сайхан тэр дээ гэж шүүрс алдав.

Занаа зул дөнгөж жаргамагц боодолтой юмаа орны ширгүүгээс сэмхэн аваад гадаа гарахад тэнгэр үзэгдэхгүй анх сонссон хайр сэтгэлийн энхрий ялдам үгс шиг зөөлөн бүлээн бороо шивэрч байгаа нь таатай байлаа. Сэлэнгэ мөрний Түлбэрийн голын уулзварын бөөн бургасны чанх дээр хөөрдөг долоон бурхан үзэгдэхгүй байв. Занаа урсгалын чимээгээр чиг барин явсаар цагаан бургасны хаяанд ирж зогсов. Жигдхэн шаагих намираа борооны доогуур Сэлэнгийн лут их хүчтэй шуугин урсахуй нь сонстоно. Сэлэнгийн хүчит энэ урсгал хаман одох нь гэлтэй улам улам тодрон, ойртох сонсогдоно. Бороо цутгаж буй харанхуй тэнгэрийн доор ус улам ч сүртэй хүчтэй болдог байна. Занаа айдас бишрэл төрсөндөө «Ай бурхан минь! Яасан аймаар юм бэ? Яасан ирдэггүй юм бэ? Буцдаг юм билүү» гэж бодов. Занаа зангидсан алчуурынхаа үзүүрээр нүүрний усыг арчиж үс гэзгээ янзлан учрахад биеэ бэлтгэн хүлээв. Дамдинтай энд уулзахаар тохирон болзсон билээ. Их мөрөнд цутгах түмэн цутгалангийн нэг болох Түлбэрийн голын энэхэн билчрээс тэр хоёрын хамтын амьдралын урт зам эхлэх ёстой юм. Үзэсгэлэнт, хүчит Сэлэнгэ мөрөн өөртөө түмэн гол горхийг нэгтгэн цааш хаа хол одогийг мэддэггүйтэй адил ерөөлөөр учирсан хоёрын амьдрал юу туулж, хаана төгсөхийг одоо хир яахин төсөөлөх билээ. Дамдин,

- Их хүлээв үү? гэж хэлээд гарыг нь атгахдаа түүний үл мэдэг чичирч байгааг мэдэв. Занаа,

- Гайгүй ээ! Нэг их хүлээгээгүй! гэв. Дамдин,

- Гайгүй гэнэ шүү! Даарчихсан байна шүү дээ! Май миний дээлийг нөмөр гэж хэлээд тэрлэгээ толгой дээгүүр нь бороо халхлан барив. Занааг

- Чи өөрөө даарчихна шүү гэхэд нь,

- Би энэ байтугай харанхуй бороонд амьтан хүн ус гаргаж өгөх гэж хувцсаа тайчин, онгоцоо ус руу түлхэн ордог хүн шүү дээ. Энэхэнд ямар ч зүс бороонд дусаал дусдаггүй газар байдаг юм. Хоёул тэнд очъё хэмээн бөөн бургас руу хөтлөн явав. Бургасны гүн рүү явах тутам бороо холдож байх шиг дуу нь багасах ажээ. Мөчир, шилмүүс нь газар шүргэсэн саглагар бүдүүн бургасны ёроолд хүрч ирлээ.

- За энэ дээ! Ямар байна гэхэд Занаа,

- Гэр шиг хув хуурай, дулаахан юм гэв.

- Би чамайг дулаацуулъя гээд Дамдин хуурай мөчир авчирч бяцхан түүдэг асаалаа. Занаагийн хөл нүцгэн явааг мэджээ.

- Чи яагаад гуталгүй гараа вэ? Хөлөө галд ээ! Энд өглөө болгоод хоёулаа явна гэхэд нь Занаа,

- Аав чи бид хоёрыг сэжиг авсан байхаа. Наадмаар авч өгсөн гутлаа авдарт хийгээд цоожилчихсон. Хөл нүцгэн бол явж чадахгүй гэж санаж байгаа биз гэлээ. Дамдин Занаагийн мөрөөр тэврэн мөнгөн цагаан хүзүүгий нь илэн таалж,

- Гайгүй дээ! Намайг ядуу болохоор л тэгж байгаа юм. Би ажил хийгээд чамайг удахгүй гуталтай болгоно гэж хэлээд галын дөл ширтэн суув.

Тэр хоёрын хамтран асаасан бяцхан түүдэг мөчир нэмэх тоолон түмэн очис бутарган харанхуйг гэрэлтүүлэх гэсэн мэт тэнгэр өөд улам дүрэлзэн асаж байна. Занаа Дамдингийн дээлийг нөмрөн гал руу хөлөө жийж, норсон гэзгээ задлан хатааж самнаж суух бөгөөд нүд нь талимааран галын цог дээр тусжээ.

- Чи юу бодоо вэ гэхэд,

- Бодох юм байлгүй яахав гэж санаа алдав. Дамдин ч бас бодох юм байжээ. Хэсэг дуугүй байснаа

- Чи миний эхнэр үнэхээр болох уу гэлээ. Занаа,

- Болно! Чамд төрсөн биеэ тушаая! Чамайг дагаад хорвоогийн хаана ч хүрвэл хүрнэ гэжээ.

- Би юу ч үгүй гон бие хүн гэдгийг чи мэднэ.

- Тэр яахав! Сэтгэлтэй л бол болдог юм гэж ээж минь хэлдэг байсан.

- Амиа тэжээх гэж арван дөрөвтэйгөөсө усчин хийж Сэлэнгийн урд эргээс хойд эрэг, хойд эргээс урд эрэг рүү ховилт онгоцны өнцөг дээр зогсож алгаа эвэршгэл сэлүүрдлээ. Ус гатлуулчаад хүмүүс алган дээр хэдэн мөнгө тавих юм. Одоо усчин хийхгүй ээ гэв.

- Тэгээд яаж амьдрах вэ? чи бид хоёр гэх шиг Занаа Дамдины царай өөд харлаа.

- Аржаргалантад модны рам гээч юм бий болж, хөлсний ажилчид авч байна гэж загасчин оросуудтай яваа хүнээс дууллаа. Тэнд очиж салчин хийнэ дээ! Бид багадаа мод холбон урсгаж зөндөө тоглодог байсан юм гэлээ.

Үүр цайхын хирд бороо ч зогсож үүлс холдсон байв. Дамдин Занаа хоёр Сэлэнгийн эрэг дээр ирэв. Намуухан боловч хүчтэй хөөсрөн давалгаалах Сэлэнгэ рүү өнгийсөн хөгшин улиангар модноос нулимс адил ганц нэгээхэн навч эргэлдэн унаж холын замдаа чимээгүйхэн одох ажээ. Эрэг доор хооронд нь төмрөөр холбосон гуалингууд модноос бэхлээтэй байв. Дамдин,

- Чи бид хоёрын Аржаргалант орох унаа энэ дээ. Заа суу гэлээ. Занаа айж байгаа бололтой,

- Чиний холбоо онгоц яасан юм бэ?

- Бий нь бий л дээ! Түүнийг авч явж хүмүүсийг усны хоёр талд явгалчихаад яахав гэж бодсон юм. Онгоц байхад усчин олдох байлгүй гэв. Дээр нь гишгэтэл сал хотолзон ус дээгүүр нь цалгив. Дамдин Занааг голд нь суулгаж, хамаг хувцсаа тайлж, өмдөө шуугаад өөрөө цав цагаан хусан сэлүүр авч алгаа шилэмдэн эргийн ёроол руу нэгэнтээ хатгатал сал овсхийн хөнгөрч бөгс нь урсгал даган загасны сүүл шиг гялс хийв.

Дамдин сэлүүрээ суга татан авч хагас сууснаа дахин усны гүн рүү цул хийтэл хатгавал салны толгой давалгаан дээгүүр цоройн өндийж нар зөв даялан Сэлэнгийн гол руу сум адил харван одлоо. Занаа дасаагүй хүлгээс айсандаа нүдээ тас анин модны холбоос уяанаас бат зуурсан байв. Нүд нээвэл тавилангаас хэдэн бээр холдоод цагаан булангийн доор сайр тушаа яваа бололтой. Сал их мөрний дөлгөөн урсгалд намуухан хотолзон гулсана. Бага наснаас танил дасал болсон уул толгод холдон холдсоор. Дамдин,

- Айгаагүй биз! Айх юм байхгүй. Хатан Сэлэнгэ чи бид хоёрыг зорьсон газарт нь хүргээд өгнө гэж хэлээд сэлүүрээ татаж нэгэн мөч амарчээ.

Сэлэнгэ мөрнийг эмжсэн нов ногоон ой тайга шувтарч, орой нь үзэгдэхгүй барзгар хадан цохио элбэг дайралдах боллоо. Урагшлах тусам хадан цохио хоёр талаас түрж орж ирсэн учраас Сэлэнгэ нарийсан урсгал нь улам хүчтэй ширүүн болох ажээ. Баргар хадан уулнаас аандаа нурж байгаа асга чулууны их чимээ тэнгэрийн дуу шиг нижигнэх нь сүртэй сонсогдоно. Зам улам бартаатай болж сал амаа мэдэхгүй даага шиг цовхчин булгиж явсаар хоорондоо нийлсэн юмуу гэмээр нарийхан хадан хавцлын дундуур орж ирэв.

Дамдин салны урд үзүүрийн хоёр тал руу ээлжлэн хатгаж залах мөрт хөөсөрсөн их давалгаанд салны толгой, Занаа хоёр үзэгдэх болж байлаа. Хадан хошууны хоорондуур орж ирэх үед ус аймшигтай шуугин цалгин давалгаалж дээрээс аадар буух мэт санагдана. Дамдин Занаадаа одоо л салчин болж чадах залуу хүний ид хавыг үзүүлэх гэж тайван инээмсэглэн,

- Айх юм байхгүй, сайн барьж яваарай. Энэ хэсэг нугачааг өнгөрвөл зүгээр болно гэжээ. Занаа Дамдингийн тайван дууг сонсоод нэлээн тайвширлаа. Дамдин салны ташууран гуядагдаж байгаа сүүлийг залах мөртөө,

- Нүдээ эрээлжилбэл уулын орой хараад яваарай. Эцэг минь уулын орой ширтэхэд ухаан саруулжина. Ус газрын хэвгий даган урсдаг, эр хүн уул өгсөж даваа давж амьдардаг гэдэгсэн. Эцэг шигээ би нэг л юманд зүтгэвэл чигээрээ хүн байгаа юм даа гэлээ. Салчин болох гэж сэтгэл шулуудан анх ингэж л ирж дээ. Тэр цагаас хойш Сэлэнгэ голдиргоо өөрчилсөнгүй, татарсан ч үгүй, амсхийх завгүй урссаар байна. Анх ирэхэд энд хэдэн хар гэр ганц дүнзэн байшин л байсан даа. Занаа бид хоёр модны холтсоор чигжиж дулаалсан нийтийн байр гэгч навгар урцанд орж өвөл нь анхны минь хүү төрж билээ гэж бүүр түүрхэн бодож явжээ. Зарим нь майханд, зарим нь наранд шарахаар сал дээр гэдрэг, түрүү харан хэвтжээ. Шөнийн ус, бороонд норсон гутал, ороолтоо хатаахаар майхнаа тойруулан тавьсан байна. Сал урсгалын дагуу салхинд туугдан бүүвэйлэх адил намалзан аандаа хөвж яваа ийм үед зөвхөн толгойг залах төдийгөөс өөр ажил байдаггүй.

- Цай, хоол боллоо, босоорой гэж хашгирах дуунаар салчид цөм босож цалгин давалгаалж байгаа уснаас гар нүүрээ угаагаад майхны үүдэнд дэлгэж тавьсан ууттай боорцогыг тойрон суулаа.

- Дамдин гуай хоол, цайгаа уу гэж дуудахаар салны толгойд сууж яваа нөгөө хүн сэлүүрээ орхиж нааш явав. Дамдин уулын сонгино, хүнхээл ханхалсан хултай хоолыг модоор этэн шөлийг шоржигонотол сороод амаа алгаараа шувтран цай хийлгэлээ. Дамдин цай очиж тэнгэрийн хаяа ширтэн сууснаа

- Сэлэнгийн эх өөд хэд хоног айхтар хүчтэй бороо орох шиг боллоо. Үерийн түрүүч тун ойртсондоо. Өнөөдрөөс салхинаас шавар шороо их амтагдан, усан дээр бөөн бөөн хөөс гэнэт үзэгдэн усны шувууд уул хад өөд тэмцээд байх шиг гэв. Тийш харваас холын цэнхэр уулсын цаад руу тэнгэр нүргэлэн аадар бороо цутган байгаа бололтой, наран шингэх зүгийн тэнгэрийн хаяа хоосрон харанхуйлж тэр зүгээс гашуувтар салхи үлээж байлаа.

Сал урссаар Цагаан тохойн эх рүү орж ирлээ. Дамдин,

- Майхнаа буулгаад, салаа усныхаа голоос гаргаж зах руу нь зааж өгье. Усны хүч нэмээд байх шиг байна. Салаа хайрдуулаад орхиж болохгүйдэг шүү гэв. Хүмүүс Дамдин гуай мэдэж байгаа гэсэн шиг бээлий, хөшүүрэг мод, төмрөө авч эрэг дээр гаргахад бэлтгэжээ. Дамдингийн бригад гэж нэршсэн энэ 8 хүн нэг явахдаа тус бүр 12 ширхэгээс бүрдсэн 24 сал холбож ирдэг юмдаа.

Дамдин толгойд очин доогуур нь хөшин гэдрэг суутал салны толгой акулын ам шиг зай завсраараа ус садруулан хөөсрүүлсээр урсгалын хүчийг тас дайран эрэг рүү даялав. Урсгалын хүч их байснаас сал дундуураа могой шиг атиран гогцоорч дээр дээрээсээ цоройн гарчээ. Салны сүүлч үзэгдэхгүй байгаа нь түрүүчийнхээ салны доогуур шааж орсон хэрэг байв. Ийм үед ганц холбоос л тас үсэрвэл алдуурсан сал сум шиг харван замдаа тохиолдсон бүхнийг хаман оддог билээ. Дамдин толгойг урсгалын дагуу жаахан тавьж өгтөл сал хавиралдан нажигнасаар жаахан хэвдээ орлоо. Хоёр хоёроороо зай аван зогсож салыг эрэг рүү

хөндлөнгөөр нь аваачихаас мэхгүй боллоо. Салчид дуу нийлүүлэн зэрэг залсаар байтал сал эрэг рүү ойртон ирлээ...

Салчид өдрийн хүнд ажлыг ардаа хийгээд гэрийн зүг хөөрөлдөн явна. Дамдин урт түрийтэй усны гутал, юүдэн малгай өмсөж хусан сэлүүр мөрөн дээрээ тавьжээ. Дамдингийн өмнөөс сэгсгэр үстэй охин гүйж ирлээ. Дамдин Отгонжаргалыг үнсэж, мөрөн дээгүүрээ суулгахад охин эцгийн хүзүүгээр тэврэн,

- Аав аа! Талхны мөнгөнд яваад ирэв үү гэж асуулаа.

- Тэглээ гэх сонсогдоно. Энэ үгийг хэлэхэд Дамдинд сэтгэл нь нэг л жаргалтай уяхан болоод явчих шиг санагддаг билээ. Надаас хойш яанадаа гэж сэтгэл зовдоггүй ч хөлийг нь дөрөөнд хүргэх хүн нь би гэж бодоход ааг омог, баяр жаргал цээжинд багтаж ядах үе бий. Энэ бол Дамдинд хамгийн дээд жаргал юм. Үртэй хүнээс өөр баян хүн дэлхийд үгүй билээ. Отгонжаргал хамгийн бага нь болохоор эцэгэх хоёр нь энхрийлэн эрхлүүлчихсэн юм даа. Дамдинг өглөө цайгаа уугаад ажилдаа гарч явгал эхнэр нь,

- Хүүе! Наадах чинь дагаад байна шүү дээ гэж дуудлаа. Эргэж харвал Отгонжаргал хойноос нь гүйж явлаа. Дамдин эргэж очин охиноо аргадан үнсээд,

- Аавыгаа дагаж болохгүй! Ус их байгаа. Аав нь ажилдаа явъя, талхны мөнгөнд явъя гэлээ. Аав нь охиноо эрхлүүлж хэлжээ. Охин хэдий балчирхан ч ухаантай үр байлаа.

- Аав! Та надад талх чихэр авчрах гэж байгаа юм уу? Гээд өвөр дээрээс нь бууж дагасан ч үгүй, уйлсан ч үгүй хоцорсон билээ. Тэгээд сая асууж байгаа нь тэр юм. Дамдин эхнэрийн аягалсан өтгөн шаргал цайг тавтай уугаад ажлын ядаргаа арилаад дахиад л чадал тэнхээ барагдамгүй санагдав. Ер нь эцэг хүний үүрэг ёсоор ажил хийж хэдэн хүүхдээ тэжээж яваа шүү гэж бодоход сэтгэл санаа ямагт өег сайхан байдаг ажээ. Отгонжаргал дэргэд нь элдэв юм шулганан тоглож сууснаа,

- Аав аа! Та дахиж явахгүй, тиймээ гэв.

- Аав нь өнөөдөр явахгүй. Охиноо өвөртлөөд унтаж амарна гээд сэлүүрийн мод татуурга олсонд холгогдож эвэршсэн гараараа охиныхоо үсийг иллээ.

Дамдин шөнө дундын хирд машин, тракторын пижигнэх их чимээнээр сэрлээ. Салчид гол руу бушуухан очоорой, босоорой гэж бачимдан хашгиралдах сонсогдов. Дамдин босож хувцаслаад бушуухан гарвал бороо асган газар тэнгэрийн зааг ялгарахгүй бөгөөд уул ус, ой мод нэлдээ ганхан шуугиж байх шиг нүүгсэн их чимээ гарч байв. Дамдин Сэлэнгэ үерлэжээ гэж мэдэв. Ус шавар нэлийн урсах уулын хэжлүүрийг барин гэлдрэх зүтгүүрийн ганц тракторын гэрлээр чиг барин салчид гол руу явцгаалаа. Тэнгэр тас няс дуугаран үе үе гялбалзах цахилгаанд хар үүл мушгиралдан нүүгэлдэнэ. Хайрдуулан холбож орхисон салнууд усны хүч нэмэгдсэнээс нажигнан тар няр мөргөлдөж байгаа нь сонстоно. Дамдинд Сэлэнгийн дунд сайранд орхисон сал гэнэт санаанд оржээ.

- Үерийн гол хүч хараахан ирээгүй байгаа дээр юуны түрүүнд дунд сайрын их салыг тогтоож

авахыг бодъё хэмээн хашгиран холбоо сал дээр үсрэн гартал,

- Юуны өмнө энэ хэсэг салнуудаа татаж гарга! гэх шинэ даргын захирангуй мөртөө хүүхдэрхүү дуу сонсогдлоо. Дамдинг дагаж сал түрэн ус руу орох гэж байсан салчид цөм зогсов.

- Бушуу хөдөлцгөө! Та нар хайчив гэж даргын дахин бухимдан хашгирахад салчид арга буюу буцаж эрэгт хайрдуулсан салыг чирэн гаргахаар тракторын араас бэхлэн уяж зарим нь буй хүчээрээ татацгааж эхлэв. Дамдин даргын дэргэд гүйж хүрлээ.

- Дарга минь! Хүү минь үерт хэдэн зуун сал урсгана гэдгийг та юу гэж бодож байна. Үзсэн үү? Төмөр хоргоо зад татсан араатан л гэж мэд. Юун түрүүн дунд сайрт орхисон их салаа тогтоох арга бодох хэрэгтэй, тэгэхийн тулд хэсэг хүн нэг салаар урсан очиж сайтар бэхлэн холбох ёстой. Тэгвэл хоёр талын ууланд цахдаж зогсдог нэг ёс бий. Нөгөө арга бол урсаж очихоос нь өмнө буй бүх хүчээрээ хадан хясаанд боолт хийж тогтоох л байна. Өөр зам үгүй гэлээ. Сугар дарга салчны энэ үгэнд юу гэж хариу өгөхөө үнэндээ тунгаан бодсон нь үгүй. Гэсэн ч хэн нь дарга юм бэ гэсэн хачин жигтэй үг яг зүрхний тушаа хатгаад авах шиг болов. Агшин зуур «Би мэдэж байна, тушаал бол тушаал» гэсэн үг амнаас нисэн гардаг байна. Сугар салчдад хамгийн анх удаа шийдвэртэй өгсөн тушаал энэ байлаа. Дамдин гайхаш нь барагдан,

- Чи мэдэхгүй бол хэн мэдэхэв дээ гэж амандаа бувгнан арга буюу нөхдийн араас очив. Сугар ийм үед удирдлага шийдвэртэй хатуу чанга байх нь зөв гэж боджээ.

- Урсах нэг нь урсаж л байг, та нар олон таван үггүй энэ салнуудыг татаж гарга гээд өөрөө ч удирдан орох нь уу гэлтэй гүвэлзэх усны зах барин эрэг рүү гүйлээ.

Салчид шөнө турш элс шаварт дарагдан овоорсон холбоо салнуудыг ухаж чирч гаргасаар үүр цайлгалаа. Хөөсрөн хоормогтсон үерийн их усан замд тохиолдсон бүхнийг хуу хаман одно гэсэн мэт давалгаалан шуугиж байв. Салчдын нүд сал орхисон дунд сайр руу тусжээ. Сайрыг хэдийд ус авч хэдхэн бургасан толгой цухуйж харагдана. Сал үзэгдэх бараагүй болжээ. Аадар бороо жаахан татарч тэнгэрийн дуу холдож, ойр орчмын юм үзэгдэхийн үед л салчид амсхийн тамхи баагиулан сууцгаалаа. Сугар даргыг нэг харахад нь өвгөн салчин Дамдин ирж явна. Дэргэд нь ирээд өвгөн салч гашуудалтай тонгойн зогсжээ. Нүүр нь үерт идэгдсэн хөгшин уулын сархиаг шиг үрчлээтэн сүртэй бөгөөд ууртай догшин болсныг Сугар ажив.

- За дарга минь! Тусгүй юм болсон байгаа биз. Сал үерээс гаргах гэдэг шатар нүүхтэй адил шүү. Хөгшин салчны үгэнд орсон бол бид их салтайгаа байж мэдэх л шүү дээ гэлээ. Сугарт энэ үг тун ч зэвүүн ёжтой санагджээ. Гэсэн ч « Аргагүйдээ, нас өтлөхөөр хэн ч ажилдаа түүртдэг уур уцаартай ч болдог гэсэн, энэ өвгөн түүний нэг биз» гэж бодов. Тэгээд,

- Та ядраад байвал харихгүй юу даа. Бид тантай, тангүй хийчих байлгүй гэв.

Дамдин энэ үгийг гүйцэд ойлгосонгүй ээ!

- Юу гэнээ даргаа! Би энэ ус модтой өвгөртлөө ноцолдсон хүн Сэлэнгийн үертэй анх тулгарч байгаа минь энэ бишээ! Хүнд хөөгдөх болоогүй гэлээ. Сугар,

- Би таныг хөөгөөгүй! Юу юуны тухандгүй олон жил ажилласнаараа далайлгах хэрэггүй шүү дээ! Би тан шиг ажиллаагүй ч гэсэн зах зухыг нь мэднэ гэв.

- Ёстой л зах зухыг нь мэдэж байна даа! гэж эгдүүтэй хэлээд нойтон модны булан сандайлан, гүвэлзэн шуугих үерийг харан бодлогошров.

Тэртээ гүүрийн үзүүрээс наад хөтөл давтал машин, хөсөг тэрэг цувран зогссон харагдана. Сэлэнгэ нэг үерлэхээрээ хэдэн долоо хоног зам гүүр хааж, ажил алба тасалдуулдаг билээ. Ер нь арал дээр байсан их салыг өчигдөр нааш нь татуулахгүй яасан юм бэ? Салхины үнэр үер ойртож байгааг хэлээд байлаа шүү дээ. За түүнийг мэдэхгүй нь хир гэхэд мэдээд хэлж байгаа хүний үгэнд ордог байгаа даа. Татуургад байгаа хэдэн салд яараад байхдаа яадаг юм бэ? Урсаад хаа холдохов. Доод тохой хүрээд л зогсоно. Хайран мод гэж шүүрс алдан салчдын хоорондоо ярьж, гаслах сонсогдоно.

Дамдин хэдийгээр шинэ даргатай ажил төрлөөс болж ам мурийсан ч гэсэн ажлаа хийдгээрээ хийсээр л явжээ. Ажил дээрээс болж аль маргахыг тэр гэхэв. Дамдин бурууг хийчихвэл зэмлүүлэхдээ гомдож гонсойдоггүй, буруутныг нүүрэн дээр нь хэлэхдээ хулчийдаггүй зантай юм. Өвгөн салчин, дарга хүүг хүмүүсийн нүүрэн дээр арай ч хатуу хэлчихэв үү дээ. Цул эрдэм л хүн байх даа. Жаахан хар ухаан суугаад ажлын дөртэй болчихвол манай үйлдвэр байтугайг хөдөлгөнө дөө гэж бодож явсаар ажилдаа иртэл санхүү дээр хурдан ирүүл гэж тосгоны төвөөс дуудуулсан байлаа. Дамдин,

- Хүн нэмэгдвэл хүнс нэмэгдэнэ гэж ийм л сайхандаа.

Хэдэн хүүхдүүдийн минь мөнгий бодож олгох гэж буй хэрэг гэж бодсоор очжээ. Олон жил цалин хөлсийг нь бодож сохор зоос ч дутаалгүй олгож ижил дасал болсон хөгшин нягтлан Сампил нүднийхээ шилийг авч зовсон байртай хараад

- Бие тэнхээ сайн уу? хүүхдүүд зүгээр үү? гэж асуужээ

- Би ямар алзах биш дээ. Сампил аа! Дамдинг анхныхаа салыг урсгаж ирээд цалингаа бодуулж авч байсан шигээ л гэж бод! Одоо 10 жил сал татаж чамаар цалингаа бодуулсан ч эр чадал бай шүү! Усны шувуу усандаа гэсэн юм. Би ус мод хоёроос үхтлээ салахгүй гэж боддог шүү! Гэв.

Ингэх ярихдаа царай нь улам ч залуужин нүд нь цогтой гэрэлтэж байхыг Сампил ажиглажээ. Сэтгэл санаа баяртай урам зоригор бялхаж явахад хүний царайнаас гэрэл туяа цацардаг байнам. Дамдингийн ийм их сайхан юм бодож яваа нь Сампилын сэтгэлийг улам ч зовоожээ. Сампил хийх юм, хэлэх үгээ олохгүй бантаж хэсэн баахан үүлгэртэн сууснаа,

~Дамдин минь! Чи даргыг гахай хариулагчаар оч гэхэд нь юу гэж үгүй гэсэн юм бэ? Чамайг энэ 15-аар тасалбар болгоод оронд чинь нэг залуу авсан тушаал ирсэн байна. Харин сарын цалинг олгож тэтгэвэрт гаргалаа гэсэн байна гэлээ.

Өвс шарилж ургасан уулын хормойн нарийн хэжлүүр өгсөн Дамдин гэрийн зүг явж байна. Толгой эргэж нүд эрээлжилснээс орчин тойрон цар таваг шиг жирэлзэн далбилзана. Энэ

жимээр хичнээн удаа цалингаа өвөртлөн эхнэр хүүхэддээ өгснийг санаж чадахгүй явна. Өврөө байн байн дарж үзэхэд дөрвөлжин эвхсэн шинэхэн цас хуурай өвс шиг шажигнана. Энэ бол ажлаас халсан даргын тушаалын нэг хувь юм. Маргаашаас эхлээд салчин биш маргаашаас хэлээд энэ тосгонд ирэх хэрэгцээгүй болно гэж бодохоос нэгэн мөч бороотой өдрийн тэнгэр шиг бүүдгэрэн байв. Айл гэрийнхээ голомтыг асаасан ийм нутгаас сална гэхэд яс янгинах шиг болов. Зам яахин хороосныг анзаарсангүй нэг мэдэхэд эхнэр хүүхэд нь гэрийнхээ хаяанд харуулдан зогсож байв.

- Эдэндээ яаж хэлнэ дээ гэж нэл халгаснаа, жаргалаа ч зовлонгоо ч хуваалцах ерөөлтэй төрснөөс хойш үнэнээ л хэлье гэж шийдэв. Ингэж бодож явтал Отгонжаргал өмнөөс гүйн ирж,

- Аав аа, та талхны мөнгөнд яваад ирэв үү гэж томоогүй хөөрхөн ааль гарган асуугаад хүзүүгээр нь тэврэн авлаа.

Хоолой нь зангиран бөглөрч нүдээ тас анин зогсов. Энэ бол өөрийгөө өрөвдөж гутарсан нь огт биш байлаа. Охиноо өрөвдлөө. Аяган чинээ үр минь, алаг үр минь! Чи юу гэнээ гэж нүд хуурай мөрт гиншигнэн үглэв. Гэрийнхээ хаяанд ирлээ. Салчны сууринд Дамдинг танихгүй хэн байлаа. Миний ингэж ирж байгааг хөгшин залуугүй цөм гайхан харж байгаа гэж бодов. Занаа нөхрийн царайг хараад нэг л учир болж гэдгийг гадарлан усанд нэгийгээ алдчихсан юм биш байгаадаа хэмээн айдас төрөн, юу хэлэхийг нь битүүхэн хүлээжээ. Гал дээр яаравчлан цай үйх зуураа,

- Чамайг арай ирэх болоогүй гэж бодоод цайгүй сууж байлаа гэж юу гэхийг нь туршиж асуужээ. Дамдин дуугарсангүй. Тэгэхээр нь цай аягалж нэлээд харж байснаа

- Үерт алдсан нөгөө салнуудаа олоо юу? Гэж асуув. Дамдин,

- Сал над хамаагүй болсоон гэж түс тас үг хэлэв. Занаа чихэндээ итгэсэнгүй. Хоёр чих нь тугалга цутгасан юм шиг халуун дүүгэв. Харин аавынхаа өвөр дээр эрхэлж байсан Отгонжаргал охин энэ үгийг тун хурдан тусгаж авчээ

- Аав аа! Та дахин талхины мөнгөнд явахгүй юмуу? Гэж асуужээ

- Тийм ээ! Аав нь явахгүй гэж охиноо цаашлуулан хэлэв

- Аав аа! Та яагаад тэгж байгаа юм бэ?

- Яахав, аавыг чинь дарга ажлаас халчихсан гэжээ. Занаа уртаар санаа алдлаа. Сая л чихэндээ итгэжээ

- Одоо тэгвэл энэ хүүхдийг чинь яадаг байна даа. Даргынхаа сэтгэлд юу гэгч юм хийсэн юм бэ. Чи дэндүү чигээрээ шүү! Өөрт чинь л муу гэлээ. Дамдин эхнэрээ нүдний булангаар харвал нэг том нулимс хацрыг нь дагаад бөмбөрөн байв.

Энэ маань ч өтөлж аймхай туулай шиг болж дээ. Анх эх эцгээ Арилдий баяны хүүтэй суулгах

гэхэд нь тас зөрөөд намайг дагаад гарч байхдаа мөн ч зоригтой байсан даа гэж бодов. Тэгээд Занаа минь юун амархан нулимсав дээ. Ямар үр хүүхдээ алдчихсан биш гэлээ. Тэр нэг өдөр үйлдвэрийн дарга энхэр хүүхэдтэйгээ зугаалгаар буцаж явсан билээ. Үл таних бяцхан охиноос болж тэд бодолд дарагдан яваа шүү дээ. Охин нь,

- Манай аав хүнийг ажлаас нь халдаг юм байж дээ. Аав маань ажлаас халагдчихвал бидэнд яасан хэцүү байх бол гэж хүүхдийг өрөвчхөн сэтгэлээр бодож явжээ.

Сугар чухам юу гэж бодож явсныг хэн ч мэдэхгүй. Түүний өргөн саруул магнай улам ч цэлмэг болсон шиг. Хүн гэдэг барагдашгүй эрдэнэ хадгалсан уултай адил гүн гүнзгий юм. Сугар ямар ч гэсэн ертөнцийг хүнийг танин мэдэх хэрэгтэй юм гэж бодож эхэлсэн биз.

Долгор оройн хоолоо хийгээд яг л урьдын адил цонхны дэргэдэх эрээн бүтээлэгт ширээндээ тавьсан боловч хоёр охин дор бүрнээ шалтаг хэлээд идсэнгүй. Аав ээж хоёр бие биедээ нууцгайхан гэм үйлдсэн юм шиг гэх юмуу, аль эвсэл анх удаа уулзаж байгаа хүн шиг дуу шуугүй хоолложээ. Шөнө дөл болжээ. Охидууд унтсан эсэхийг бүү мэд Сугар, Долгор хоёр нэг ор дээр хэвтсэн боловч дундуур нь ямар нэг хүн ороод ирсэн шиг бие биеэсээ хөндий хөрвөн байв. Харин эхнэр нь

- Би чиний албан хэрэгт хуруу дүрэх гээгүй. Гэхдээ чамд хань түшиг болж яваагийн хувьд чи надад бас зарим юмыг дуулгаж зөвлөж болох шүү дээ. Дарга хүн хүнийг ажлаас халах, авах эрхтэй байлгүй яахав. Тэгэхдээ ажилчдынхаа ар гэрийг сайн судалж энэ хүнийг ажилд авснаараа би ямар сайн үйл хийж байна. Энийг халснаараа гэр бүлд нь ямар бэрхшээл тарих билээ гэдгийг сайн бодож үртэй хүн үрээрээ зүйрлэдэг байх хэрэгтэй шүү дээ. Хоёр охин чинь энэ байна. Чи эрдэмтэй чадалтай гээд юмыг хурдан хоомой шийдвэр буруу шүү гэлээ.

Ухаан санаа гэнэт цэлмэг адил үүр манхайн хаяарч уулын хярын модод сэрвийн орчлонгийн хол, ойрын юмс ялгарч байв.

Гараашийн жижүүрийн утас хангинав.

- Манай машиныг хурдын ирүүл гэх нь шинэ даргын дуу мөн байв. Машин ирлээ. Сугар,

- Салчны сууринд хурдан очоод Дамдин гуайг аваад ир гэлээ. 69 машин өглөө эрт довтолгон ирж явахыг хараад салчны нэг авгай гүйн ирж,

- Дамдин! Занаа та хоёрыг нүүхээ боль гэж дарга хүн ирүүлж байх шиг байна. Аштай байхав дээ! олон жил ижил дасал болсон айл эндээ байвал гэлээ. Занаа энэ үгэнд сэтгэл ихэд хөдөлсөндөө болоод ам алджээ.

- Эндээс холдох гэдэг надад ч үр хүүхдээсээ холдохоос ялгаагүй байна шүү! Ямар сайндаа би охиндоо үг зааж өгөөд дарга руу явуулж байхав гэчихлээ. Хүүхнүүд

- Ёстой ёстой, чиний зөв гэж ам амандаа шуугилдав. Харин Дамдин царайгаа түвшин болгож эхнэрээ сүрхий хараад,

- Занаа минь! Чи чинь юу болж байгаа чинь энэ вэ. Тэр хүн чинь чиний хэлсэн хэлээгүй, юу хийснээ одоо ойлгож байгаа. Тэр чинь энэ модны үйлдвэрт ирээдүйд надаас өчнөөн дахин хэрэгтэй хүн! Магадгүй миний явах тэр хүний ухаан суухад ч тус хүргэж мэднэ! Чи дуугүй л бай! Ажил хийж эхэлж байхад алддаг ч юм, онодог ч юм. Миний занг мэдэх мөртөө чи даан ч тийм булай юм хийх гэж байх уу?

- Түүний оронд чи гэрээ ачаалаагүй байхдаа даргыг гэр бүлтэй нь цай уулгачихья гэж санах байсан юм. Эр хүн хэрэлдэж уулзаад хэлцэж салдаг ч ёс бий гэв. Занаа,

- Мэдэхгүй, мэдэхгүй! Би ч бүр уймарч орхихдоо л тэгсэн юм гэж аргадангуй өчлөө.

Салчдын авгай нар зарим нь үдэлтийн цай уулгаж гаж Дамдин, Занаа хоёрыг урьж оруулан зарим нь халуун цай, тавагтай идээ барин гүйлдэж хүүхдүүдийнх нь өвөрт боов боорцог хийж үнсэж байлаа. Дамдин, Занаа хоёр айлаас гарч ирлээ.

Занаа минь сайн яваад хүрээрэй гэж салчны авай, хүүхнүүд ам амандаа шуугилдан зарим нь төрсөн охиноо алс хол сургуульд үдэж байгаа юм шиг нулимс мэлтэгнүүлж харагдана.

Занаа хамгийн бага Отгонжаргалыг аваад кабинд суув. Гэр бараагаа хэдийн ачаалчихсан байсан хэрэг. Жолооч Дамдингийн дэргэд ирж,

- Таныг дарга аваад ир гэж явууллаа гэв

- Дарга хүүд сайн сайхныг ерөөж байна гэж хэлээрэй. Ам алдвал барьж болдоггүй. Ах нь гүдэсхэн зантай хүн. Монгол орон уудам, хийх ажил зөндөөн байна. Хөгшин салчин Дамдин тэртээд цэнхэртэх уулын их царамд гарч мод бэлтгэхээр шийджээ гэж дарга хүүд хэлээрэй гээд Дамдин хүүхдүүд суусан чиргүүл дээр үсрэн гарлаа.

Машин уулын нарийхан хэжлүүрээр алгуурхан хөдлөхөд өмнөөс нь ургахын улаан нар уулын орой дээгүүр тосон мандаж байлаа.